



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГААНЫ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)



- ◇ **Хууль, эрхзүй**
- ◇ **Улстөрийн намын төлөвшил, сонгуулийн тогтолцоо**
- ◇ **Парламентын ажлын албаны чиг үүрэг, зохион байгуулалт**
- ◇ **Үндсэн хуулийн эрхзүй**
- ◇ **Илтгэл, өгүүлэл, нийтлэл ... бусад**

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

DDC
328015
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (XII боть, 2012)
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун, О. Нарантуяа

ISBN 978-99929-895-6-4

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

Судалгааны эмхтгэл - XII боть

УИХ -ЫН 2011 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

УДИРТГАЛ ХЭСЭГ

-	ӨМНӨХ ҮГ	7
-	Парламентын үйл ажиллагаанд Тамгын газрын үүрэг	9
	<i>Ц. Шаравдорж (УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга)</i>	

1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

1.1.	Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудлаархи бусад орны эрх зүйн зохицуулалт	18
	<i>Х. Тэмүүжин, Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр</i>	
1.2.	Монгол Улсын авилгын эсрэг хуулийн хэрэгжилт ба авилгатай тэмцэх орчны эрх зүйн чадамжийн талаархи тойм судалгаа	27
	<i>Р. Хатанбаатар, Б. Хатантуул, Б. Мөнхцэцэг, А. Пагма</i>	
1.3.	Парламентын гишүүний халдашгүй байдлыг цуцлах бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаархи гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт	44
	<i>Б. Буяндэлгэр, Г. Алтан - Оч (Ph.D), П. Амаржаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул, А. Пагма</i>	
1.4.	Гадаадын зарим орны парламентын шинжлэх ухааны шагналын талаархи товч мэдээлэл	59
	<i>А. Пагма, Г. Гэрлээ</i>	

2. УЛСТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ, СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.1.	Улстөрийн намын гишүүнчлэл, төлөвшил, нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль, парламент болон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь	64
	<i>Ч. Базар (Ph.D), П. Амаржаргал, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр</i>	

	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улстөрийн намын оролцоо, үүрэг, нөлөө, гишүүдийн орон нутгийн хуралд нэр дэвших эрх, улстөрийн намуудын гишүүнчлэлийн тухай харьцуулсан судалгаа	77
	<i>П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн</i>	
2.2	Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийг хамтад нь явуулах боломжтой эсэх асуудлаар харьцуулсан судалгаа болон лавлагаа мэдээлэл	92
	<i>Р. Хатанбаатар, Б. Цолмонбаяр, Б. Хатантуул</i>	
2.3	Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд	97
	<i>Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул</i>	
2.4	Унитар улсуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишиг (Харьцуулсан судалгаа)	102
	<i>Р. Хатанбаатар, А.Пагма, Б. Цолмонбаяр</i>	
2.5	Дэлхийн эмэгтэйчүүдийн улстөрийн оролцоо (Харьцуулсан судалгаа)	112
	<i>Ч. Базар (Ph.D), Т. Мягмаржав</i>	

3. ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

3.1	Дэлхийн зарим улсын парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа	132
	<i>Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, А. Пагма, Р. Хатанбаатар, П. Амаржаргал, Г. Билгээ, Ц. Болормаа, Б. Буяндэлгэр, Г. Гэрэл, Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр</i>	
3.2	Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актуудын талаархи лавлагаа мэдээлэл	220
	<i>Д. Жигваагүнсэл, О. Нарантуяа, Ө. Мөнхтунгалаг</i>	
3.3	Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажлын албанаас үзүүлж буй үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)	242
	<i>А. Пагма, Г. Гэрэл, Б. Мөнхцэцэг</i>	
3.4	Парламентаас төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ажлын албанаас үзүүлж буй үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)	273
	<i>К. Пүрэвсүрэн, Т. Мягмаржав</i>	

3.5	Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)	256
	<i>Ц. Мягмарцэрэн, П. Амаржаргал, Г. Билгээ, Б. Дуламсүрэн</i>	
3.6	Монголын парламент дахь иргэдийн оролцоо, цаашид сайжруулах арга зам	270
	<i>Ч. Базар (Ph.D)</i>	
3.7	Парламентад Ажлын албанаас үзүүлж буй судалгаа, архив, номын сангийн үйлчилгээ (Харьцуулсан судалгааны дүгнэлт)	279
	<i>Ц. Болормаа, Б. Хатантуул</i>	
3.8	Парламентын Тамгын газрын бүтэц дэх мэдээллийн технологийн албаны чиг үүрэг, түүний зохицуулалт (Харьцуулсан судалгааны дүгнэлт)	309
	<i>Г. Алтан - Оч (Ph. D), С. Дорждагва</i>	

4. ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

4.1	Үндсэн хуулиа дээдлэхүй	318
	<i>Ц. Товуусүрэн</i>	
4.2	Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, Япон улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийг үндсэн хуулийн эрхзүйн үүднээс харьцуулах нь	326
	<i>П. Амаржаргал</i>	
4.3	Монгол Улсын [шинэ] Үндсэн хууль (1992) -ийн төслийг хэлэлцэж баталсан БНМАУ -ын Ардын Их Хурлын хуралдааны үйл явцын чөлөөт [зарим] тэмдэглэл (Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойд зориулан бэлтгэв)	331
	<i>Г. Чулуун</i>	

4. ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад

3.1	Монголын эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага	348
	<i>Н. Лүндэндорж (Sc.D), П. Амаржаргал</i>	
3.2	Аюулгүй байдлын секторын шинэчлэл ба түүнд тавих парламентын хяналт	352
	<i>Г. Алтан - Оч (Ph. D)</i>	
3.3	“Улаан түүх” -ийн босгон дээрх Богдын хүрээ (Нийслэл Хүрээ – 100 жил” сэдэвт Эрдэм шинжилгээний хуралд зориулав)	359
	<i>Г. Чулуун</i>	

3.4	Мэдээллийн аюулгүй байдлын талаархи зарим орны эрх зүйн зохицуулалт	386
-----	--	-----

Ч. Базар (Ph.D)

• **ХАВСРАЛТ**

	УИХ -ын 2011 оны хаврын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа	254
--	--	-----

(XI ботид орсон бусад судалгааны жагсаалт)

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨМНӨХ ҮГ

Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд УИХ -ын Тамгын газраас үзүүлж буй судалгаа -шинжилгээ, мэдээлэл, лавлагааны үйлчилгээ нь УИХ-аар батлан гаргаж буй хууль тогтоомж, бодлогын шийдвэрүүдийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, хууль хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтээс үүдэн гарах эерэг, сөрөг үр дагаврыг бодитойгоор урьдчилан харж тооцоо судалгаатайгаар асуудлыг шийдвэрлэх, хууль тогтоомжийг нийгмийн эрэлт шаардлагад нийцүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2009 оноос хойш Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв нь ээлжит чуулган бүрийн төгсгөлд УИХ-ын гишүүдийн захиалгаар гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг эмхэтгэн цуврал боть болгон хэвлүүлж эрхэм гишүүдийн ажлын хэрэгцээнд хүргүүлдэг уламжлал тогтсон юм. 2009 оноос хойш тус төв нь нийтдээ 12 боть судалгааны эмхэтгэл номыг хэвлүүлэн гаргасан нь УИХ -ын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг болоод зогсохгүй төрийн бодлого боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэхэд нь төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачид, уншигчдад мэдээллийн эх сурвалж, гарын авлага болон ашиглагдаж байна.

Энэ удаад эрхэм гишүүд, уншигчид та бүхэнд УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эмхэтгэн гаргадаг “Бодлогын судалгаа, шинжилгээ” номын XI, XII дугаар эмхэтгэлийг толилуулж байна. Эдгээр эмхэтгэлд 2011 оны намрын чуулганы хугацаанд Судалгааны төвийн гүйцэтгэсэн 34 судалгааны тайлан, 9 эрдэм шинжилгээний илтгэл багтсан бөгөөд эдгээр нь Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн болон хэлэлцэхээр төлөвлөж буй асуудлууд, улс орны өмнө тулгамдсан чухал асуудлуудыг хөндсөн цаг үеийн ач холбогдол бүхий лавлагаа мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний ажлууд юм.

Улсын Их Хурал 2011 оны намрын чуулганы хугацаанд УИХ -ын сонгуулийн тухай хууль, Төрийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирголоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Компанийн тухай хууль, 2012 оны Монгол улсын төсөв, мөнгөний бодлого зэрэг 24 бие даасан хуулийг батлан гаргаж, 104 хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Мөн 48 тогтоолыг УИХ-аар батлан гаргасан байна.

Эдгээр хууль, тогтоомжид холбогдох асуудлаар УИХ -ын гишүүдийн захиалгаар болон Судалгааны төвийн санаачлагаар судалгаа, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгсөөр ирлээ. Цаг үеийн тулгамдсан асуудлууд, гишүүдийн сонирхсон танин мэдэхүйн болон хуулийн төсөл боловсруулахтай холбоотой судалгааны ажлуудыг ч мөн эдгээр эмхэтгэлд оруулав.

2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төв УИХ -ын гишүүдийн захиалгаар 22, төвийн санаачлагаар 28, УИХ -ын Тамгын газрын захиалгаар 3 судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Сүүлийн жилүүдэд Монгол улсад бодлого судлалын салбар улам бүр эрчтэй хөгжих шаардлага бий болж байна. Төрийн бодлого, шийдвэрийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, аливаа асуудалд судалгаа тооцоотой хандахыг хууль тогтоогчдоос ард түмэн улам их хүсэх боллоо.

Нэг талаас, мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа иргэдийн боловсрол мэдлэг, мэдээллийн хангамж нэмэгдсэнээр төр засгийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандах байдал нэмэгдэж байна. УИХ -аар батлагдан гарч буй хууль, тогтоомжууд нийгэм-эдийн засгийн харилцааг зөв зүйтэй зохицуулж чадаж байгаа эсэх, хууль батлагдан гарсанаар улсын төсөвт хэдийн хэмжээний ачаалал ирэх, төрийн санхүү, мөнгөний бодлого зөв явж

байгаа эсэх зэрэг тодорхой асуудлуудад иргэд шүүмжлэлтэй хандаж байна. Нөгөө талаас, улам бүр даяарчлагдаж байгаа дэлхийн эдийн засгийн орчил дунд олон улсын стандарт болон өөрийн орны өвөрмөц онцлогт тохирсон ухаалаг, уян хатан бодлого явуулахыг эрхэм түшээд маань хичээж, аливаа асуудалд мэдлэг, мэдээлэлтэй хандахыг хүсэж байна.

Эдгээр зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Тамгын газрын Судалгааны төв чухал үүрэг гүйцэтгэж, УИХ -ын гишүүдийг шуурхай мэдээлэл, судалгаагаар тогтмол хангаж байна. УИХ -ын гишүүдийг судалгаа, мэдээллээр хангах үйл ажиллагааг улам бүр боловсронгуй болгохын тулд УИХ -ын номын санг цахим хэлбэрт шилжүүлэх төслийг БНТУ -ын ТИКА олон улсын байгууллага, БНСУ -ын КОИКА олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн АНУ -ын Конгрессын Судалгааны алба, IRI, HDP зэрэг олон улсын байгууллага, бусад орнуудын ижил түвшний парламентын судалгааны албадтай хамтран ажиллаж судлаачдын ур чадварыг сайжруулах, мэргэшүүлэхэд анхаарч байна. Судалгааны төв нь зөвхөн судалгаа, мэдээллээр хангах төдийгүй эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, сургалт семинар зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг мэргэшсэн алба болон өргөжих учиртай юм.

УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргадаг эдгээр судалгааны эмхэтгэлүүд нь мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангасан системтэй, цэгцтэй мэдээлэл болохоос гадна бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, судлаачдын гарын авлага, ширээний ном болон ашиглагдана гэдэгт найдаж байна.

УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц. Шаравдорж



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАМГЫН ГАЗРЫН ҮҮРЭГ

*Ц. Шаравдорж (УИХ -ын Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга)*

1992 оны 7 сарын 20 -ны өдөр Монгол Улсын Их Хурлын Анхдугаар Чуулган хуралдсанаас хойш өдгөө ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан 5 дахь парламент бүрэн эрхээ хэрэгжүүлэн Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Парламентын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, УИХ -аар хууль, тогтоолын төслийг хэлэлцэн батлах, УИХ -ын гишүүд бүрэн эрхийнхээ дагуу хууль санаачлах бүхий л үйл ажиллагаанд УИХ -ын Тамгын газрын зүгээс Улсын Их Хурал болон УИХ -ын бүтцийн нэгжүүд /хуулийн ажлын хэсэг, намын бүлэг, байнгын хороод, нэгдсэн чуулган/ -д мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалт, мэдээлэл судалгааны үйлчилгээ үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, УИХ -ын Тамгын газар бол УИХ -ын “гал тогоо” буюу мэргэшсэн аппарат гэдгийг та бүхэн мэдэж байгаа. 20 жилийн өндөрлөгөөс харахад, УИХ -ын үйл ажиллагаа төлөвшин бэхжихийн хэрээр Тамгын газрын үйл ажиллагаа ч мөн боловсронгуй болж, ажилтнуудад тавигдах шаардлага, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна.

Тамгын газрын үйл ажиллагааг уян хатан, боловсронгуй болгох, дэлхийн бусад орнуудын парламентын Тамгын газрын жишигт нийцсэн ажил үйлчилгээний хэлбэрүүдийг нэвтрүүлэх, техник зохион байгуулалтын оновчтой бүтцийг бий болгох, мэдээллийн цахим байдлыг бий болгох, боловсон хүчний чадавхийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүд нь УИХ -ын Тамгын газрыг шуурхай, шинэлэг, өндөр үр чадвар бүхий мэргэшсэн алба болон төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэгдэж байна. УИХ-ын Тамгын газрын зүгээс УИХ -ын бүтцийн нэгжүүдтэй улам бүр ойртон нягтрах, Тамгын газрын аппаратыг чадваржуулах талаар шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Түүх сөхвөл, 1992 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Ардын Их Хурлын чуулганы хуралдаан дээр тухайн үеийн Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж өөрийн тавьсан “БНМАУ-ын Бага Хурлын үйл ажиллагааны тайлан, хууль тогтоох ажлыг сайжруулах зорилт” -ын тухай илтгэлдээ “...Улсын Бага Хурлын гишүүд мэргэжлийн туслалцаа, шаардлагатай мэдээллээр ихээхэн дутагдаж байна. Хууль боловсруулах, хэлэлцэх, батлахтай холбогдсон техник асуудлуудыг ч Улсын Бага Хурлын гишүүд хариуцан гүйцэтгэхэд хүрч байна. Үүнтэй холбогдуулан Улсын Бага Хурлын гишүүд, байнгын хороо, аппаратын зохион байгуулалт, уялдаа холбоо, харилцан хамаарлыг оновчтой болгох шаардлага байна.

Улсын Бага Хурлын гишүүд хууль зүйн зөвлөгөө, судалгаагаар дутагдаж байгааг дахин тэмдэглэе. Өөрөөр хэлбэл, аппарат нь Улсын Бага Хурал, түүний гишүүдэд шууд үйлчилж байхаар одоогийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх нь зүйтэй” гэсэн санал гаргасан байдаг. Энэ нь үнэхээр зүй ёсны шаардлага байсан билээ. Тухайн үед байнгын ажиллагаатай хууль тогтоох анхны дээд байгууллага болох Улсын Бага Хурлын Тамгын газар нь:

1. Зохион байгуулалтын хэлтэс
2. Зөвлөгчдийн товчоо
3. Орон нутгийн Ардын хурлын ажлын хэсэг гэсэн 3 нэгжтэйгээр нийт 56 ажилтан, албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байжээ.

Тамгын газрын энэ бүтэц нь хууль тогтоох байгууллагыг үндсэн эрх мэдлээ хэрэгжүүлэхэд

аль ч талаар хангалттай туслалцаа үзүүлэх боломжгүй байснаас 1991 оны 3 дугаар сард Тамгын газарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж Зохион байгуулалтын хэлтсийг дотор нь Дотоод ажлын болон Захидал харилцааны хэсэг хэмээн ангилж, Шинжилгээ-лавламжийн хэсэг, Гадаад харилцааны хэсэг гэсэн 3 нэгжтэйгээр өөрчлөн байгуулсан байна.

1992 онд бүх нийтийн сонгуулиар Улсын Их Хурлыг байгуулснаас хойш өнөөг хүртэл Улсын Их Хурлын Тамгын газар бүтэц, зохион байгуулалтын хувьд 6 удаа өөрчлөгдөн зохион байгуулагдсан түүхтэй. Эдгээр түүхэн өөрчлөлтүүдийг товчхон дурьдсан нь Тамгын газрын өнөөгийн бүтэц, бүрэлдэхүүн бий болсон шаардлага, парламентын үйл ажиллагаан дахь Тамгын газрын үүргийг тодруулах гэсэн хэрэг билээ.

Одоогийн Тамгын газрын бүтцийг 2008 онд Улсын Их Хурлын даргын захирамжаар баталж, шинэчлэн зохион байгуулсан бөгөөд энэ нь Улсын Их Хурлын эрхэм зорилго болон Парламентын ажлын мэргэшсэн алба болох Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах урт болон дунд хугацааны стратеги зорилтын хүрээнд хийгдсэн өөрчлөлт шинэчлэлт юм.

УИХ -ын 2002 оны 22-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө” -нд тусгасан үндсэн 5 зорилтын хүрээнд УИХ болон УИХ-ын Тамгын газраас дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүхий л талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд
 - Улсын Их Хурал бүрэн эрхээ Чуулган, Байнгын болон дэд, түр хороод, намын бүлэг болон зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлж байна. УИХ-ын анхдугаар чуулган, ээлжит чуулган, ээлжит бус чуулган, онцгой чуулган болон хүндэтгэлийн чуулган, Үндсэн 5 байнгын хороо, дэд болон түр хороод, намын бүлгүүд нь УИХ-ын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж байгаа бөгөөд эдгээр институциональ бүтцэд Тамгын газрын үндсэн хэлтэс албадууд үйлчилж байна. Гэвч УИХ-ын энэхүү бүтцийг улам боловсронгуй болгох, эрх үүрэг, үйл ажиллагааг нь нарийвчлан зохицуулах шаардлага байна гэж зарим улс төрчид, судлаачид үздэг юм.
 - 2002 онд батлагдсан дээрхи стратегийн төлөвлөгөөнд тусгасан “Парламентын ажлын мэргэшсэн алба болох УИХ -ын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах” стратеги зорилтын хүрээнд УИХ болон Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр /UNDP/ хамтран “Ардчилсан засаглалын парламентыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх, хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан юм. Эдгээр дүгнэлт зөвлөмжид тулгуурлан УИХ -ын хууль тогтоох, төлөөлөх, хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах УИХ -ын болон УИХ -ын Тамгын газрын иж бүрэн, оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох арга хэмжээ авч байна.
 - УИХ -аар хэлэлцэн баталж байгаа хууль, тогтоомжийн шинжлэх ухааны үндэслэл, тооцоог сайжруулах, нийгмийн эрэлт шаардлагад нийцсэн хууль тогтоомжуудыг батлан гаргах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлогын оновчтой хувилбарыг тодорхойлоход УИХ -д дэмжлэг болохуйц судалгаа шинжилгээ, мэдээлэл лавлагааны үйлчилгээ дутагдалтай байсан тул УИХ-ын Тамгын газрын бүтцэд Судалгааны албыг байгуулан ажиллуулсанаар УИХ -ын гишүүдийг бодлогын судалгаа, мэдээлэл лавлагаагаар шуурхай хангадаг болсон нь УИХ-ын Тамгын газрын бүтцэд гарсан томоохон дэвшил боллоо.
 - 1990 оноос хойш батлан гаргасан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн системчилсэн

ангилал тогтоох, хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, системчилсэн эмхэтгэл, CD гаргах, хууль тогтоомжийн албан ёсны орчуулгыг англи хэл дээр гаргах талаар Тамгын газар анхаарч байна. Одоогоор хуулийн мэдээллийн сан, ангилалыг бий болгоод байгаа бөгөөд цаашид хуулийн албан ёсны орчуулга хийх эрхтэй байгууллагыг томилох, эрх үүргийг тодорхой болгох, хуулийн мэргэшсэн орчуулагч ажиллуулах шаардлага бий эсэх талаар судалж шийдвэл зохих асуудлууд байна.

- Мөн өнгөрсөн хугацаанд УИХ-аар батлан гаргасан 450 орчим хууль тогтоомжийг эргэж нягтлах, хууль хоорондын уялдаа холбоог сайжруулах, Үндсэн хууль болон хууль хооронд зөрчилтэй асуудлуудыг УИХ -аар хэлэлцэхгүй байх үүднээс Эрх зүй хууль тогтоомжийн хэлтсийн ажилтнууд болон Судалгааны төвийн судлаач, шинжээч нар УИХ -д өргөн барьсан хуулийн төсөлд дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Мөн эдийн засгийн харилцааг зохицуулж буй 50 орчим хуулийн төслийн концепцэд дүн шинжилгээ хийх ажлыг УИХ -ын даргын захиалгаар Төвийн судлаачид гүйцэтгэлээ. Цаашид өргөн барьж буй хуулийн төсөлд бусад орнуудын туршлагаар төсөв, санхүүгийн дүн шинжилгээ хийж парламентад оруулж ирдэг жишгийг тогтоох талаар энэ онол практикийн хурлын хүрээнд асуудлыг хөндөж тавих нь зүйтэй гэж бодож байна.
 - УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд, төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачдын саналыг авах, олон нийтээр хэлэлцэх бололцоог өргөтгөх, УИХ -д өргөн барьсан хуулийн төслийг олон нийтэд танилцуулах, холбогдох санал дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэх, нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах талаар зарим нэгэн ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, 2009 оноос эхлэн Тамгын газрын Судалгааны төв болон Байнгын хороодоор дамжуулан УИХ -аар хэлэлцэж байгаа зарим тодорхой асуудлаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид ТББ -уудтай сэдэвчилсэн уулзалт ярилцага хийх, анкетын санал асуулга авах, хэвлэлийн нийтлэлд агуулгын дүн шинжилгээ хийх, бусад судалгааны байгууллагуудын хийсэн судалгааны дүнг харьцуулан судлах зэргээр судалгааны түвшинд нэлээд үндэслэл сайтай судалгаа, мэдээллийг гаргаж УИХ -ын эрхэм гишүүдэд хүргүүлж байна.
 - Цаашид Байнгын хороод, хуулийн ажлын хэсгүүд, УИХ -ын гишүүд эдгээр судалгааны мэдээлэлд анхаарлаа хандуулж, ач холбогдол өгч хэлэлцдэг системийг төлөвшүүлмээр байгаа юм. Мөн УИХ -ын вэб сайтаар болон холбогдох байнгын хороодоор дамжуулан иргэд, байгууллагуудаас хууль тогтоолын төсөлд өгч байгаа саналыг нэгтгэж боловсруулах, хуулийн төсөлд тусгах үндэслэл бий эсэх тал дээр мэргэжлийн судлаач, шинжээчид, хуулийн ажлын хэсгүүд нэлээд нухацтай ажиллаж, холбогдох байнгын хороодоор хэлэлцдэг байх, саналыг авсан эсэх, аваагүй бол ямар үндэслэлээр аваагүй талаар эргэх холбоо барьдаг ийм механизм бусад орнуудад байдгийг авч хэрэгжүүлэхийг иргэд олон нийт шаардаж байна гэдгийг анхаарах цаг болсон гэж бодож байна.
 - Чуулганы үйл ажиллагааг хэвийн явуулах, гишүүдийн ажлын нөхцөлийг сайжруулах талаар Тамгын газраас нөөц боломждоо тулгуурлан нэлээд ажил хийлээ. Чуулганы танхимын тохижилт, техник тоног төхөөрөмжийн чадавхийг сайжруулсанаар УИХ -ын чуулган болон Байнгын хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөл үндсэндээ бүрдсэн гэж үзэж байна. УИХ -ын гишүүдийг ажлын хэрэгцээний зөөврийн компьютерээр хангах, гишүүдийг чуулганы танхим, аль ч хурлын заалнаас цахим мэдээллийн баазад нэвтрэх боломжтой болгох үүднээс дотоод ажлын e-office программыг нэвтрүүлэх, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, УИХ -ын вэб сайтыг шинэчлэх зорилтыг ойрын үед хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Гэвч хөрөнгө санхүүгийн хувьд асуудал хүндрэлтэй байгаа учраас гадаад, дотоодын байгууллагад хандан хүсэлт уламжилж байгаа гэдгээ нуулгүй хэлье.
- Энэ онд бид Солонгос улсын KOICA Олон улсын байгууллагын тусламжаар УИХ-

ын архивыг цахим хэлбэрт оруулах төслийг амжилттай хэрэгжүүлээ. Маргааш цахим архивийн нээлтийг хийхээр төлөвлөж байна.

- Цаашид Улсын Их хурлын Номын сан, Судалгааны төвийн мэдээллийн баазыг цахим хэлбэрт шилжүүлэх, УИХ-ын Тамгын газрын хэлтэс, албад, төвүүдээс гаргаж байгаа дотоод ажлын мэдээллийг нээлттэй болгож, эрх бүхий хэрэглэгчдэд нээлттэй байлгах ажиллаж байна. Ингэснээр мэдээллийн шинэчлэлт, ажлын уялдаа холбоо улам бүр сайжрах юм.
- УИХ-ын материал, техникийн хангамжийг сайжруулах, Төрийн ордны өргөтгөлийг нэн яаралтай хийх, ингэснээр өрөө тасалгааны хүрэлцээг сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна. Одоогоор УИХ-ын Тамгын газрын ажилтнууд ажлын хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа олон жишээнүүд байна. Төрийн ордонд төрийн эрх барих 3 институци, ажлын албадтай шахцалдан ажиллаж байгаа энэ нөхцөл байдлыг өөрчлөх цаг болсон гэж үзэж байна.

2. УИХ -ын Хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд

- Парламентын хяналтыг Засгийн газрын үйл ажиллагаанд төвлөрүүлэх нийтлэг зарчмыг Улсын Их Хурал хяналтын гол чиг баримтлалаа болгож байгаа билээ. Одоогоор УИХ-ын гишүүд, Байнгын хороод, нам эвслийн бүлгээс Засгийг газрын гишүүд болон УИХ-аас байгуулагддаг байгууллагын эрх баригчдад асуулт, асуулга тавьж албан ёсны хариу авах, мөн Улсын төсвийн хуваарилалт, зарцуулалтанд хяналт тавих чиглэлийг УИХ -ын хяналтын үйл ажиллагааны үндсэн хэлбэр болгон зохион байгуулж байна. УИХ-ын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд УИХ-ын Тамгын газрын Байнгын хороодын Ажлын алба, холбогдох Байнгын хороодын ажилтнууд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, зохион байгуулж байна.
- Мөн УИХ -ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа одоогийн нэг механизм бол УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороодын тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгийн хэлбэр юм. Тамгын газрын Судалгааны төвийн хийсэн судалгаагаар, 1996 - 2009 онд УИХ -ын даргын захирамжаар - 31, УИХ-ын тогтоолоор - 2, Байнгын хороодын тогтоолоор - 211 ажлын хэсэг байгуулагдан ажилласан гэсэн тоо байна.

Тайлант хугацаанд эдгээр ажлын хэсгийн 70% орчим нь ямар нэгэн хэмжээгээр ажиллаж тогтоол шийдвэр гаргаж, шийдвэрийн биелэлтэндээ хяналт тавьсан бол 25% нь ажилласан эсэх нь тодорхойгүй, 5% нь огт ажиллаагүй гэсэн мэдээлэл байна. Иймд судлан танилцах, хууль, шийдвэрийн хэрэгжилтэнд гишүүд биечлэн хяналт тавьж байгаа одоогийн энэ механизмыг оновчтой болгох, ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, эрх зүйн байдлыг тодорхой болгох талаар сүүлийн үед улс төрчид, судлаачид нэлээд олон хувилбараар хэлэлцэж байна. Энэ асуудлаар та бүхнийг саналаа хэлэх байхаа гэж бодож байна.

- УИХ-ын хяналт шалгалтын бас нэг механизм бол Засгийн газрын мэдээллийг тогтмол сонсох хэлбэр юм. УИХ дахь цөөнхийн бүлгийн гишүүдээс амаар тавьсан асуултанд Ерөнхий сайд сар бүрийн 1 болон 3 дахь долоо хоногийн Баасан гаригийн нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийхээр Дэгийн тухай хуулиар зохицуулсан бөгөөд энэхүү ажлыг мөн Тамгын газрын Байнгын хороодын ажлын алба хариуцан зохион байгуулж байна.
- Мөн УИХ -ын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд Үндэсний аудитийн газар чухал үүрэгтэй боловч УИХ-ыг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардагдах дүн шинжилгээ, мэдээлэл, судалгаагаар шуурхай хангах ажиллагаа хангалтгүй байгаа тул холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, УИХ-тай ажлын уялдаа холбоог нь сайжруулах шаардлага байна.
- Мөн УИХ -аас байгуулагдаж, ажлаа тайлагнадаг байгууллагуудын ажлын тайланг

УИХ -ын Байнгын хороодоор хэлэлцдэг боловч тэдгээр байгууллагуудаас УИХ -д шаардлагатай мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний материалыг шуурхай гаргуулан авч УИХ -ын үйл ажиллагаанд ашиглах тал дээр анхаарах шаардлага байна.

3. УИХ нь ардчилсан зарчимд нийцүүлэн үйл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах зорилтын хүрээнд
 - УИХ -ын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах зорилгоор 21 аймаг, дүүргүүдэд УИХ -ын сурталчилгаа, мэдээллийн төвийг байгуулан ажиллуулж байна. Мөн энэ оноос эхлэн бүх аймаг, орон нутагт УИХ -ыг сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, тодорхой хуулийн төслүүдээр хэлэлцүүлэг хийх, иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулж эхэлж байгаа нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг ард түмэнд таниулах, зөв ойлголт, мэдлэг мэдээлэл өгөхөд чиглэгдэж байна.
 - 2008 оноос эхлэн УИХ -ын Тамгын газрын шинэ бүтэц зохион байгуулалтаар УИХ-ын Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны хэлтсийг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс болгон өөрчлөн зохион байгууллаа. Мөн www.open-parliament.mn вэб сайтыг шинээр ажиллуулж эхэллээ.
 - Улсын Их Хурлын www.parliament.mn болон www.open-parliament.mn вэб сайтуудаар дамжуулан УИХ, УИХ -ын Тамгын газрын мэдээллийг олон нийтэд хүргэх, иргэд олон нийтийн саналыг авах, өргөн баригдсан хуулийн төслийг танилцуулах, хуулийн төсөлд санал авах ажлыг зохион байгуулж байна
 - Мөн УИХ-ын он-лайн мэдээллийн өрөөг тохижуулж УИХ-ын гишүүд тойргийн сонгогчилтойгоо он-лайн мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүллээ. Энэ мэдээллийн төвөөр дамжуулан АНУ -ын Конгрессийн гишүүдийн туслахуудтай УИХ-ын гишүүдийн туслахууд онлайн ярилцлага хийж, мөн Орон нутгийн сурталчлах төвүүдтэй холбогдож сургалт, мэдээлэл хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.
 - Парламентын сэтгүүлчдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх техник, зохион байгуулалтын арга хэмжээ авч тусгай өрөө гарган, ажиллах нөхцөлөөр хангалаа.
 - УИХ-ын дэргэд теле студи байгуулан үйл явдлыг баримтжуулах, видео бичлэг, богино хэмжээний телевизийн нэвтрүүлэг хийх өрөө тасалгаа, техник хэрэгсэлээр хангалаа. Мөн Сансар кабелийн телевизтэй гэрээ байгуулан Парламентын сувгаар олон нийтэд мэдээлэл хүргэж байна.
 - УИХ-ын ээлжит чуулганы статистик мэдээлэл, УИХ-ын судалгааны төвөөс эмхэтгэн гаргасан судалгааны цуврал эмхэтгэл, УИХ-ын мэдээллийн бюллетень зэрэг УИХ болон УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой брошюр, ном товхимолуудыг тогтмол хэвлэж, хуулийн эмхэтгэл CD, гарын авлагуудыг иргэд, сонгогчид олон нийтэд зориулан гаргаж байна.
 - Парламентын 20 жилийн ойн хүрээнд парламентын түүхийн музейг байгуулж, төрийн ордонтой иргэд сонгогчдыг танилцуулах аялалыг зохион байгуулж байна.
4. УИХ-ын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд:
 - Монгол улсын олон тулгуурт нээлттэй , идэвхтэй гадаад бодлогын хүрээнд парламентын гадаад харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагаа шинэ агуулга, хэлбэрээр хөгжиж байна. УИХ-ын 2 талын хамтын ажиллагааны хүрээнд нийт 53 парламент хоорондын бүлгүүд ажиллаж байна. Монгол улсын Их Хурал Олон улсын парламентын холбоо болон бүс нутгийн парламентын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй орлцож олон улсын түвшинд нэр хүндээ өсгөж байна.

- Парламентын гадаад харилцаа, хамтын ажиллагааг Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс эрхлэн явуулж байна
- Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд УИХ-ын дарга, дэд дарга нар 40 гаруй удаа гадаад орнуудад албан ёсны айлчлал хийж, ОУПХ-ны хурал БНПХ-ны хуралд илтгэ тавьж хэлэлцүүлсэн ба гадаадаас 23 орны парламентын спикер, дэд дарга нар албан ёсны айлчлал хийсэн байна.
 - УИХ-ын Тамгын газрын ЕНБ дарга нь Олон улсын парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн хуралд оролцож 2009 онд Сөүл хотноо болсон АНДБН -ын Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын анхдугаар хурлаас тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдлоо.
 - Мөн УИХ-ын дарга Д. Дэмбэрэл 2010 онд Ази Номхон Далайн Парламентчдын формуын даргаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд 2011 онд Монгол улсад энэхүү бүсийн парламентчдын 19 дүгээр форумыг зохион байгуулах хариуцлагатай бөгөөд, нэр хүндтэй үүргийг Монгол улсын парламент хүлээж аваад байна.
 - Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс гадаад харилцааны асуудлын хүрээнд шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл хангах, гадаадын зочин төлөөлөгчдөд үйлчлэх болон Хууль, Улсын Их Хурлын шийдвэрээр даалгасан бусад бүх үүргийг биелүүлж байна.
 - УИХ-ын хүндэтгэлийн чуулган болон ээлжит чуулганы нээлтэнд гадаадын албан ёсны зочид, төлөөлөгчдөд синхрон орчуулга хийх кабин, төхөөрөмжийг чуулганы танхимд байрлууллаа.
5. Парламентын ажлын мэргэшсэн алба болох УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэрийг сайжруулах стратегийн зорилтын хүрээнд:
- УИХ -ын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг боловсронгуй болгох, ажилтнуудыг чадавхижуулах чиглэлээр УИХ болон Тамгын газраас тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.
 - УИХ-ын даргын 2008 оны 11 сарын 27ны өдрийн 147 тоот захирамжаар УИХ-ын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн тогтоолоо. НҮБХХ -ийн “Ардчилсан парламентын засаглалыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд гаргасан дүгнэлт зөвлөмж, УИХ -ын хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх функциональ бүтцийг бий болгох, УИХ болон УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааг уялдуулах, хэлтэс, албадын чиг үүргийг тодорхой болгож УИХ-д иж бүрэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Тамгын газрыг нийт 6 хэлтэс, 2 алба, 1 төвтэй байхаар шинэчлэн зохион байгууллаа.
 - Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн томоохон өөрчлөлт бол УИХ-ын дэргэд үйл ажиллагаа явуулж байсан Бодлогын шинжилгээний төвийг татан буулгаж Тамгын газрын бүтцэд ажиллах Судалгаа, шинжилгээний төвийг байгуулсан явдал юм. Өнгөрсөн хугацааны үр дүнгээс харахад УИХ-ыг мэдээлэл, лавлагаа, судалгаа шинжилгээгээр уян хатан шуурхай хангах ажиллагаа үнэхээр хэрэгцээтэй байжээ гэдэг нь харагдаж байна. Цаашид УИХ-ын Судалгааны төвийг Номын сангийн баазтай нэгтгэн бусад орнуудын парламентын судалгааны албадын жишгээр бэхжүүлэн хөгжүүлэх шаардлага байна гэж үзэж байна.
 - УИХ -ын Тамгын газар одоогоор УИХ -ын хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн хувьд шууд үйлчилгээ үзүүлдэг Эрх зүй хууль тогтоомжийн хэлтэс /редакцийн хэсэгтэй/, Байнгын хороодын ажлын алба болон хууль хэлэлцэх, хуулийн концепц боловсруулахад лавлагаа, мэдээлэл, судалгаагаар хангах үүрэг бүхий Судалгааны төв / УИХ-ын номын сан, Хөгжлийн мэдээллийн

төвтэй/, УИХ -ын үйл ажиллагааг хэвийн явуулахад техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Чуулган зохион байгуулах алба, Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс /хэвлэх цехтэй/ болон Захиргаа боловсон хүчний хэлтэс, Санхүү аж ахуй үйлчилгээний хэлтэс, Гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс гэсэн бүтэцтэй ажиллаж байна.

- Улсын Их Хурлын Тамгын газар техник, зохион байгуулалт, боловсон хүчний чадавхийн хувьд бэхжиж 2010 оны 10 дугаар сарын 1 -ний байдлаар нийт 196 ажилтантай байгаагаас эрх зүйч 69 /35.2%/, эдийн засагч 33 /16.8%/, бусад мэргэжлийн 94 /47%/ байна. Боловсролын зэргээр нь авч үзвэл, эрдэмтэн доктор /PhD/ - 7 /3.5%/, магистр 57 /29.1%/ байна. Тамгын газрын ажилтнуудын 41.8% нь эрэгтэй, 58.2% нь эмэгтэй, дундаж нас 40, төрд ажилласан дундаж жил 13.5 байна.

Цаашид Тамгын газрын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, материаллаг бааз, боловсон хүчний чадавхийг сайжруулах чиглэлээр идэвхитэй ажиллаж байна. Тамгын газрын үйл ажиллагааны урт болон, дунд хугацааны төлөвлөлтийн хүрээнд үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгох, мэргэшсэн чадварлаг аппарат болохын төлөө манай хамт олон ажиллаж байна.

Парламентын гишүүд УИХ -аар хэлэлцэж байгаа бүхий л асуудлаар мэргэшсэн байх албагүй бөгөөд харин Тамгын газар нь холбогдох судалгаа, шинжилгээ, дүгнэлт, зөвлөмж, мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлдэг нь дэлхий нийтийн жишиг билээ. Ийм ч учраас Тамгын газрын ажилтнуудыг экспертийн хэмжээнд дадлага туршлагатай болгож, УИХ-ын үйл ажиллагааг хэвийн явуулах нь бидний зорилго юм.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1

БҮЛЭГ

ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Б. Буяндэлгэр, Р. Хатанбаатар, П. Амаржаргал,
К. Пүрэвсүрэн, Б. Цолмонбаяр*

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 9 гишүүний санаачилсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн захиалгын дагуу “албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцыг бусад улс орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжинд хэрхэн тусгасныг харьцуулан судлав. Тус судалгаанд АНУ, ХБНГУ, Япон улс, ОХУ, БНХАУ, Пост коммунист орнуудыг хамруулсан болно.

АНУ

Америкийн эрүүгийн хууль тогтоомж нь холбооны хууль тогтоомжууд болон муж улсуудын эрүүгийн хуулиудаас бүрддэг онцлогтой. Холбооны хууль тогтоомжид авилгатай холбоотой эрүүгийн эрх зүйн нормууд нь үндсэндээ АНУ-ын Хуулийн Кодын 18 дугаар хэсэгт (United States Code: Title 18 – Crimes and criminal procedure) заагдсан байдаг. Гэхдээ энэ хэсэгт албан тушаалын гэмт хэргийн талаар тусгайлсан бүлэг байхгүй, харин 18 дугаар хэсгийн зарим бүлгүүдэд уг гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн талаар заасан байна.

АНУ -ын хуулийн Кодын 18 дугаар хэсгийн дараах дөрвөн бүлэгт албан тушаалын гэмт хэргийн шийтгэлийн талаар заасан:

1. 11 дүгээр бүлэг – Хээл хахууль, шударга бус орлого, нийтийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, сонирхлын зөрчил,
2. 93 дугаар бүлэг – Албан тушаалтан ба хөлсний ажилтан,
3. 41 дүгээр бүлэг - Дарамтлах ба сүрдүүлэх,
4. 29 дүгээр бүлэг - Сонгууль, улс төрийн үйл ажиллагаа.

АНУ-ын хувьд албан тушаалын гэмт хэргийн субъект нь зөвхөн нийтийн албан тушаалтнаас гадна нийтийн захиргааны байгууллага, нийтийн корпораци, улсын банкнуудын ердийн албан хаагчид, тэнд ажиллаж байгаа гэрээт ажилтнууд ч мөн албан тушаалын гэмт хэргийн субъект байж болдог онцлогтой. Мөн хээл хахууль өгсөн юмуу өгөхөөр санал болгосон этгээд албан тушаалын гэмт хэргийн субъект болдог.

1. АНУ-ын хуулийн Кодын 18 дугаар хэсгийн 11 дүгээр бүлгийн 201 дүгээр зүйлд хээл хахууль авагч гэж хэнийг хэлэхийг тодорхойлоод хуулиар оногдсон үүргээ зөрчин хээл хахууль авсан нийтийн албан тушаалтан болон хахууль өгөгчийг хоёуланг нь 10000 доллар хүртэл торгох юмуу 2 жил хүртэл хугацаагаар хорихоор заасан байна. Албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэрэгт мөн төрийн албан тушаалд томилоход нөлөөлөхөөр амлан бусдаас мөнгө, үнэт зүйлс авах ордог бөгөөд 1000 хүртэл доллараар торгох юмуу 1 жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог. Энэ тохиолдолд тодорхой үйлдэл үйлдсэнд нь бус ирээдүйд өөрийн нөлөөгөө ашиглан туслахаар амлан шан харамж авсанд нь шийтгэл оногдуулж байгаа юм. Энэ гэмт хэргийн субъект нь хувь хүнээс гадна пүүс, компани байж болно.

2. Албан тушаалаа урвуулан ашиглах. Төрийн албан хаагчийн үйлдэх албан тушаалын

гэмт хэрэгт албан тушаалын үндсэн үүрэгтэй нь зохицолдохгүй үйлдэл хийхийг оруулна. Захиргаа, эрүү, иргэний ямарваа хэрэгт хэргийн аль нэг тал нь АНУ байх юмуу уг хэрэгт улс материалын сонирхолтой байх тохиолдолд төрийн албан хаагч хэн нэгний сонирхолыг төлөөлж болохгүй. Энэ үйлдэл нь 10000 хүртэл доллараар торгох юмуу 2 жил хүртэл хорих ял оноох шийтгэлтэй.

Энэ төрлийн гэмт хэрэгт мөн албан тушаалтан улсын хөрөнгө, мэдээлэл ашиглан хөрөнгө мөнгөтэй болоход чиглэсэн үйлдэл хийх явдал орно. Тухайлбал, албан үүргээрээ орлого бүрдүүлэх юмуу хуваарилах үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч АНУ -ын юмуу аль нэг штатын хөрөнгө, эсвэл сангийн хөрөнгө ашиглан худалдаа болон бусад ашгийн үйл ажиллагаа хийсэн бол гэмт хэрэгт тооцогдоно. Мөн АНУ -ын төрийн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг этгээд албан үүргийн дагуу мэдэж буй АНУ-ын худалдаа, зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн дагуу уг мэдээллийг авах ёсгүй этгээдэд тараасан бол гэмт хэрэгт тооцогдоно. Эдгээр гэмт хэрэгт 10000 хүртэл доллараар торгох юмуу 10 хүртэл жил хорих ял оноодог (Зүйл 1902). Үүнээс гадна албан тушаалаа урвуулан ашиглаж шийтгэгдсэн этгээдийг уг албанаас нь хална.

Төрийн албан хаагч ямар нэгэн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хуулинд зааснаас илүү шан авсан бол 500 хүртэл доллараар торгуулах юмуу 6 сар хүртэл хугацаагаар хорих шийтгэл хүлээхээс гадна уг албан тушаалаа эрхлэх эрхээ хасуулна.

3. АНУ -ын хуулийн Кодын 18 дугаар хэсгийн 41 дүгээр бүлэгт дарамтлах тухай заасан байна: §872 ёсоор “АНУ -ын аль нэг департамент юмуу төлөөлөгчийн газрын албан хаагч эсвэл албан тушаалтан ямарваа зүйлийг олж авахаар дарамтласан, дарамтлахаар оролдсон бол 5000 хүртэл доллараар торгуулах эсвэл 3 хүртэл жил хорих ялаар шийтгэгдэнэ”.

4. Сонгууль ба улс төрийн үйл ажиллагаатай холбоотой албан тушаалын гэмт хэрэг. Энэ бүлэг хэрэгт дараах хэргүүд орно.

Ямар нэг сонгуульт албан тушаалд нэр дэвшигч өөрийг нь дэмжсэний төлөө хэн нэгэнд нийтийн буюу хувийн секторын албан тушаалд томилуулах эсвэл хөлсний ажилд оруулахаар амласан бол хариуцлага хүлээнэ. Улс төрийн үйл ажиллагаанд оролцох, ямарваа улс төрийн албан тушаал эзлэхийн төлөө сонгууль явагдах үеэр нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлсний төлөө юмуу ерөнхий болон тусгай сонгуулийн үеэр хэн нэгэнд ажилд оруулж өгөх болон бусад ашиг амласан этгээд хариуцлага хүлээнэ.

Сенатын гишүүд, Төлөөлөгчдийн танхимын гишүүд, АНУ-ын албан хаагчид болон АНУ-ын төрийн сангаас цалин, шагнал авдаг этгээдийн зүгээс шууд болон шууд бусаар улс төрийн хувьд хамтран ажиллахыг шахах, хандив нэхэх, хандив авах зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэгт бас орно.

Дээр дурдсан бүх гэмт хэрэгт 5000-10000 доллараар торгох юмуу хоёроос гурван жил хорих ял онооно. АНУ-д Төрийн албаны ёс зүйн хуульд (United States Code: Title 5a, Ethics in Government Act 1978) хөрөнгө орлогоо худал мэдээлсэн бол хэрхэн хариуцлага хүлээлгэхийг доорхи маягаар зохицуулсан байна.

104 дүгээр зүйл.

(a) Ерөнхий прокурорын газар дурын хүний эсрэг АНУ-ын дүүргийн шүүхэд иргэний хэрэг үүсгэх эрхтэй. (i) санаатайгаар зориуд хуурамч тайлан гаргасан

(b) байгууллагын дарга, холбогдох нарийн бичиг, төрийн байгууллагын ёс зүйн газрын захирал, Конгрессын ёс зүйн хороо, Шүүхийн конферэнс нь тухайн этгээд

санаатайгаар зориуд хуурамч тайлан гаргасан гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд хэргийг Ерөнхий прокурорт шилжүүлнэ. Шүүхийн конференс нь тухайн этгээдийн нэрийг ийнхүү Ерөнхий прокурорт шилжүүлэхдээ тойргийн шүүхийн зөвлөлд энэ тухай мэдэгдэнэ.

(с) Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, холбогдох нарийн бичгийн дарга, байгууллагын дарга, Боловсон хүчний менежментийн газар, Конгрессын ёс зүйн хороо, Шүүхийн конференс нь хуурамч тайлан гаргасан, мэдээлэх ёстой байсан мэдээллийг мэдүүлээгүй этгээдэд холбогдох хуулийн дагуу боловсон хүчний буюу бусад арга хэмжээг авч болно.

ХБНГУ

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 30 дугаар хэсгийн 331 – 358 дугаар зүйлүүдэд албан тушаалын гэмт хэргийн талаар заагдсан байна. Германы хуулиар хээл хахууль өгөх ба авах хэрэгт эрүүгийн хариуцлага ноогдуулахдаа тухайн албан тушаалтан өөрийн албан үүрэгт хамрагдах хууль ёсны үйлдэл хийгээд авсан уу, эсвэл албан үүрэгт нь хамаарахгүй хууль бус үйлдэл хийгээд авсан уу гэдгээр нь ангилан ханддаг байна.

§331 ёсоор албан тушаалтан ямар нэг үйлдэлийг тухайн хугацаанд хийх юмуу ирээдүйд хийхийн тулд бусдаас эд хөрөнгийн болон өөр ашиг нэхсэн, эсвэл авсан, эсвэл авахаар амлуулсан бол торгох юмуу хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэгдэнэ. Хэрэв дээрх хэргийг шүүгч үйлдсэн бол торгох юмуу гурав хүртэл жил хорих ялаар шийтгэгдэнэ. Гэхдээ энэ зүйлд албан тушаалтан этгээд нэхсэн ашигаа бодитоор авах юмуу амлалт авахдаа урьдчилан зохих эрх мэдэлтэнд мэдэгдэж зөвшөөрөл авсан, эсвэл авмагцаа уг хахуулийг өгсөн, авсан тухай мэдэгдвэл шийтгэл оноохгүй гэж заасан байна.

Харин 332 дугаар зүйлээр 331 дүгээр зүйлд дурдсан хэргийг үйлдэхдээ албан тушаалтан өөрийн албан үүргээ зөрчин хийсэн бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял онооно, хөнгөн тохиолдолд торгох юмуу гурав хүртэл жил хорих ял онооно гэж заажээ. Хэрэв энэ хэргийг шүүгч үйлдсэн бол нэг жилээс арван жил хүртэл хугацаагаар, хөнгөн тохиолдолд зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог байна.

333 дугаар зүйлд дээрх хоёр зүйлд заасан хээл хахуулийн хэргийн хахууль өгөгч этгээдэд оноох ял нь хахууль авагчийнхтай адил байхаар зохицуулжээ. 334 дүгээр зүйлээр хахууль өгөгч этгээд хахууль өгөх юмуу амлахдаа албан тушаалтан өөрийн үүргээ зөрчин хийхээр тохиолдолд түлхсэн бол хахууль авсан этгээдтэй адилаар 332 дугаар зүйлд заасантай адил ялаар шийтгэгдэхээр зохицуулжээ.

Ашигласан материал:

- <http://www.law.cornell.edu/uscode/>, Cornell University Cornell Law School, Legal Information Institute

Япон

Япон улсын тухайд тухайлан зохицуулсан Авлигын эсрэг хууль байхгүй бөгөөд өөр салбар хуулиудаар зохицуулсан байна. Үүнд: Япон Улсын Эрүүгийн хууль (Penal Code of Japan), “Япон Улсын Итгэлцлийн тухай хууль” (Trust Act of Japan), “Япон Улсын Шудрага бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” (Unfair Competition Prevention Act of Japan) зэрэг хуулиудаар зохицуулж байна.

Япон Улсын 1907 онд батлагдаж, 2007 онд нэмэлт, өөрчлөлт орсон Эрүүгийн хуулийн (Penal Code of Japan, Act No. 45 of April 24, 1907) Хорин тавдугаар бүлгийн 193-198 зүйлүүдэд уг үйл явцыг тодорхой заасан заалт харагдахгүй байна. Эрүүгийн хуульд авилгал гэдэг

нь гэмт үйлдлийн ангилал буюу үүнд: хээл хахууль авах, эрхээ урвуулан ашиглах, итгэл алдах, төрийн сан мөнгийг ашиглах гэсэн гэмт хэргийн төрлийг өөртөө багтаасан байна.

Парламентаар 2006 онд батлагдсан “Итгэлцлийн тухай хууль” (Trust Act of Japan, Act No. 108 of December 15, 2006) мөн 1993 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт орсон “Шудрага бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” (Unfair Competition Prevention Act. Act No. 47 of May 19, 1993) зэрэг хуулиудад дээрхи үйл явцыг зохицуулсан нарийн заалт алга байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын төрийн байгуулалтын өнөөгийн тогтолцоо, түүнийг цаашид төгөлдөржүүлэх боломж, арга зам. Онол практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Удирдлагын Академи 2011
2. Anthony Didrick Castberg /Professor of Political Science, University of Hawaii, USA/ “Corruption in Japan and the USA”
3. <http://video.news.mn/video/6075.shtml?catid=171> "Сонирхолын зөрчлийг зохицуулах хуулийн талаар" 2011.09.29 байдлаар
4. http://www.unafei.or.jp/english/pdf/PDF_rms/no56/56-33.pdf
5. <http://sonirhliin-zurchil.blogspot.com/p/blog-page.html>
6. Penal Code of Japan Act No. 45 of April 24, 1907 Amendment : Act No. 54 of 2007
7. Trust Act Act No. 108 of December 15, 2006
8. Unfair Competition Prevention Act, Act No. 47 of May 19, 1993

* * *

БНХАУ -ын Удирдах албан тушаалтнуудын хувийн асуудлыг өргөн мэдүүлэх тухай журам

БНХАУ-ын 2010 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн Хятадын Коммунист Намын төв хороо, Засгийн газрын Тамгын газраас гаргасан “Удирдах албан тушаалтнуудын хувийн асуудлыг өргөн мэдүүлэх тухай” /шинэчилсэн/ журмаар албан тушаалтнууд жилд нэг удаа журамд заасан хувийн хөрөнгө, орлогыг мэдүүлэх үүрэгтэй.

Журмын 2 дугаар зүйлд хувийн хөрөнгө, орлогоо мэдүүлэх албан тушаалтнууд, 3 дугаар зүйлд хувийн хөрөнгө, орлогоо мэдүүлэгчийн гэрлэлтийн байдлын өөрчлөлт, түүний үр хүүхдийн харьяалал, эрхэлж буй ажлын байдал, 4 дүгээр зүйлд хувийн хөрөнгө, орлого мэдүүлэгчийн орлого, үл хөдлөх хөрөнгийн байдлыг заасан байна.

Нэг.

Албан тушаалтнуудыг хянан удирдахын тулд “БНХАУ-ын коммунист намын зарчим” буюу намын дотоод зарчим, Хятадын холбогдох хууль тогтоомжуудад үндэслэнэ.

Хоёр.

- 2.1. Намын, Ардын Их Хурлын, хуулийн, хяналтын байгууллага болон ардчилсан намын төлөөлөл байгууллагын дэд даргаас дээш албан тушаалтнууд,
 - 2.2. Ардын төлөөлөл байгууллагад сумын дэд хэлтсийн албан тушаалтнаас дээш албан тушаалтан,
 - 2.3. томоохон хэмжээний улсын компани, хувьцаат компанийн дундаас дээш удирдах албан тушаалтан болон дунд зэрэглэлийн тусгай хөрөнгө оруулалттай ААН, улсын хөрөнгө оруулалттай ААН-ийн удирдах албан тушаалтнууд болно.
- Дэд зохицуулагчийн албан тушаалаас дээшхи удирдах албан тушаалын бус, тэтгэвэрт гарсан, тэтгэвэрээ тогтоолгоогүй байгаа удирдах албан тушаалтнууд

хувийн холбогдох мэдүүлгээ тодорхой дүрэм журмын дагуу гаргана.

Гурав.

Удирдах албан тушаалтнууд дараахи тохиолдолд хувийн гэрлэлтийн байдлын өөрчлөлт, түүний үр хүүхдийн гадаадад цагаачилсан байдал, эрхэлж буй ажлыг мэдүүлэх ёстой.

1. албан тушаалтны гэрлэлтийн өөрчлөлт
2. албан тушаалтны хувиараа гадаадад гарсан талаарх бичиг баримтын байдал
3. албан тушаалтны гадаадад зорчсон байдал
4. хүүхэд нь гадаадын иргэн болон харьяалалгүй иргэнтэй гэр бүл болсон байдал
5. хүүхэд нь Хонг Конг, Макао, Тайванийн иргэнтэй гэр бүл болсон байдал
6. гэр бүлийн хүн, хүүхэд нь цагаачилсан байдал
7. гэр бүлийн хүн, хүүхдийн ажлын байдал, үр хүүхдийн гадаадад ажиллаж буй байдал
8. гэр бүлийн хүн, хүүхэд нь хуулийн байгууллагаар мөрдөгдсөн байдал

Дөрөв. Удирдах албан тушаалтны нэр дээр байгаа олсон орлого, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт зэргийг мэдүүлэх

1. уг хүний цалин болон шагнал, тэтгэмж
2. уг хүний заасан хичээл, гаргасан нийтлэл, лавлагаа, ном, зураг зэргээс олсон орлого
3. уг хүн болон гэр бүлийн гишүүний мөн орлого

Хэрэв хувийн хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй тохиолдолд ажлаас чөлөөлөх арга хэмжээ авагдана. Хувийн хөрөнгө, орлогын асуудлыг Намын хяналтын хороо, Хянан шалгах яам хариуцна.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд албан тушаалтан журамд заагдсан хувийн хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу буруу мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах тухай заалт байхгүй.

ОХУ

ОХУ-ын 2008 онд батлагдсан “Авилгын эсрэг үйл ажиллагааны тухай хууль”-нд төрийн албан хаагч болон төрийн албанд шинээр орж буй этгээд нь өөрийн хөрөнгө орлогоо заавал мэдүүлэх бөгөөд энэ үүргийг биелүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн тохиолдолд төрийн албанаас халах, төрийн албанд авахгүй байх үндэслэл болдог.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн, үнэн зөв бөглөсөн эсэхийг байгууллагын удирдлага эсвэл эрх бүхий албан тушаалтнууд шалгах бөгөөд тэдний хөрөнгө орлогын талаарх лавлагааг хууль, хяналтын байгууллагаас гаргуулан авч болно./Федеральный закон от 25.12.2008 N 273-ФЗ “О противодействии коррупции”, Статья 8/

№	Пост коммунист орнууд	Зохицуулах хууль, тогтоомжийн нэр	Авилгал, сонирхлын зөрчлийн ерөнхий зохицуулалттай холбоотой заалтууд	“албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцтай холбоотой заалтууд
1	Латви	Төрийн албан тушаалтны үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль 2002.04.25 Сеймээр батлагдсан	<p>28 дугаар зүйл. Мэдүүлэг, баримт туг баталгаажуулах</p> <p>(5) Мэдүүлгийг хянах явцад төрийн албан тушаалтны мэдүүлэгт заасан орлого ба энэ хуульд зөвшөөрснөөс илүү хэмжээний орлого, санхүүгийн нөөц захиран зарцуулж байгааг илтгэсэн баримт илэрвэл эсвэл ийм байдлын талаар мэдээлэл хүлээн авбал, Авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх газар, Үндсэн хуулийн хамгаалалтын хороо, Ерөнхий сайд, тухайн баримтыг шалгах үүрэг хүлээнэ.</p> <p>Авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх газар, Үндсэн хуулийн хамгаалалтын хороо, Ерөнхий сайдын хяналтын ажиллагааны хүрээнд шаардлагатай бол төрийн албан тушаалтны хөрөнгө олж авсан хууль ёсны байдлын талаарх шалгалтыг Төрийн орлогын үйлчилгээний хороотой хамтран хийх, аливаа этгээдээс баримт мэдээлэл хүсэх, бичгэн тайлбар хүсэх эрхтэй.</p> <p>29 дүгээр зүйл. Мэдүүлэг, баримт, зөрчлийг хянахтай холбоотой төрийн албан тушаалтны үүрэг,</p> <p>(1) Хуульд заасан төрийн албан тушаалтан, удирдах байгууллагаас хүссэн мэдээллийг төрийн албан тушаалтан гаргаж өгөх үүрэг хүлээнэ</p> <p>(2) Төрийн албан тушаалтан нь хууль ёсны эх үүсвэрээс олох орлогоос өөрийн зарлага, санхүүгийн байдлаа хангаж байгаа болохыг хуульд заасан төрийн албан тушаалтан, удирдах байгууллагад харуулах үүрэгтэй.</p>	<p>28-р зүйлийн (3) Хуульд заасан төрийн албан тушаалтан, удирдах этгээдийн хүссэн хөрөнгө, санхүүгийн хөрөнгө олж авсан тухайн мэдээллийг гаргаж өгөөгүй, хууль ёсны эх үүсвэрээс орлого санхүүгийн нөөцөө гаргаж байгааг харуулж чадаагүй бол төрийн албан тушаалтныг энэ хуульд хориглосон өмч хөрөнгө, санхүүгийн нөөцийг олж авсан, төрөөс энэ баримтыг нуусан гэж үзнэ.</p> <p>30 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан, бусад этгээдийн хүлээх харууллага</p> <p>(2) төрөөс заасан хязгаарлалтыг зөрчиж, хууль бусаар олж авсан орлого, санхүүгийн ашиг олж авснаар төрийн албан тушаалтан нь санхүүгийн утгаар үнэлгээ хийсэн хэмжээгээр, хориглосон замаар олж авсан хөрөнгө орлого, санхүүгийн ашгийн өсөн нэмэгдсэн үнэ цэнэтэй дүйцэх хэмжээний хохирол төрд учруулсан хэмээн үзэж, энэ хуульд заасан хязгаарлалтыг зөрчсөнөөр олж авсан орлого, санхүүгийн ашиг, эсвэл дүйцэх өсөн нэмэгдэх хэмжээний үнийн дүнг төрд хураан авна.</p>
2	Монтегро	Сонирхлын зөрчлийн хууль	<p>11 дүгээр зүйл</p> <p>Төрийн албан тушаалтан төрийн алба эрхэлж байх үедээ өөрөө болон түүний эхнэр, нөхөр, гэрлэлтээс гадуур гэр бүлийн харилцаатай этгээд, хамт амьдардаг хүүхдийн олж авсан орлого, эд хөрөнгийг Хороонд мэдүүлээгүй эсвэл хууль ёсны үндэслэлээ байхгүй бол тэдгээр орлого, эд хөрөнгийг хууль бус гэж энэ хуулийн хүрээнд үзнэ. Хороо нь энэ тухай Бүгд найрамдах Монтегро улсын Прокурорт мэдэгдэнэ.</p>	<p>22 дугаар зүйл</p> <p>Хороо нь сонирхлын зөрчил байгааг тогтоовол, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдүүлгийг өгөөгүй бол, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан алдаагаа засаагүй бол эрх бүхий удирдлагад тухайн төрийн албан тушаалтныг ажлаас халахыг санал болгоно.</p> <p>Хэрвээ Хороо нь төрийн албан тушаалтныг эрүүгийн хэрэг үйлдсэн гэж үзвэл, холбогдох эрх бүхий прокурорт мэдэгдэнэ</p>

3	Гүрж улс	Төрийн албаны сонирхлын зөрчил, авилгын тухай хууль 2009 оны 6 сарын 1	20 дүгээр зүйл 1. Хуульд заасны дагуу хэргийн шалгах эрх бүхий байгууллага аль болох богино хугацаанд шалгах ёстой. Ийм журам байхгүй тохиолдолд Гүржийн Захиргааны хэргийн хуульд заасны дагуу энгийн захиргааны хэргийн журмын дагуу шалгах ажиллагааг гүйцэтгэнэ.	20-2. Хэрвээ, хэргийг шалгаж буй байгууллага ил гарсан этгээдийг зөрчил үйлдсэн болохыг тогтоовол иргэн, захиргаа, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэс болох ба хэргийг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.
4	Чех	Сонирхлын зөрчлийн тухай хууль 2006 он	19 дүгээр зүйл Аль ч шатны шүүхийн байгууллага Бүртгэлд архивлагдсан төрийн албан тушаалтны мэдүүлэг тодорхой, үнэн зөв, бүрэн эсэхийг шалгах эрхтэй. Үүнийг хийхийн тулд холбогдох төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, үйлдвэр аж ахуйн байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллах санал гаргах эрхтэй. Ялангуяа шаардлагатай бүх мэдээлэл, тайлбар асуух болон Бүртгэлд байгаа мэдүүлэг нь цаг хугацаандаа нийцсэн эсэхийг тогтоохын тулд холбогдох төрийн албан тушаалтнаас асуух эрхтэй. Дээр дурдсан бүх талууд шүүхээс бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хамтран ажиллах үүрэгтэй. Шаардлагатай бүх мэдээллийг ажлын 10 хоногт багтаан гаргаж өгөх ёстой. Хуулийн бусад заалтаар өөрөөр зохицуулагдаагүй бол бүх мэдээллийг үнэ төлбөргүй гаргаж өгнө.	22 дугаар зүйл Шийтгэл (1) 9 -11 дүгээр зүйлд заасан цаг хугацааг баримтлаагүй төрийн албан тушаалтанг шүүхийн шийдвэрийн дагуу 30,000.00 кронаар торгоно. Энэ торгуулийг хуулинд заасан холбогдох үүргээ хэрэгжүүлэх хүртэл давтан оногдуулж болно. (2) Дараах тохиолдолд төрийн албан тушаалтныг 100,000.00 хүртэл кронаар торгох эрхтэй: а) 9-11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу мэдүүлсэн мэдүүлэг нь үнэн зөв бус, бүрэн бус бол, б) хувийн сонирхол ялангуяа өөрийн ажил, мэргэжил, бизнесийн ажиллагаатай холбоотой хувийн ашиг сонирхолдоо эрхэлж буй төрийн албан тушаалаа хамааруулсан бол, с) хувийн сонирхлын мэдүүлгээ бүрэн гүйцэд мэдүүлээгүй бол (6 дугаар зүйл), (3) Дараах зөрчил гаргасан төрийн албан тушаалтныг 500,000.00 хүртэл кронаар торгох эрхтэй: а) өөрийн албан тушаал, гүйцэтгэх эрх мэдэл, хүлээсэн ажил үүрэгтэй холбоотойгоор олж авсан мэдээллээ ашиглан өөрийн болон өөр бусдад хууль бусаар, шударга бусаар давуу байдал эсвэл ашиг олсон бол, б) энэ хуульд заасан төрийн албан тушаалтны хувьд харшлах үйл ажиллагааг эрхэлсэн бол, с) өөрийн нэр, овог, өөрийн таних тэмдгээ эрхлэж буй төрийн албан тушаалын зэрэг дэвийн нэрийн хамтаар хариуд нь ашиг, төлбөр авахын тулд арилжаа сурталчилгааны зорилгоор хэрэглэхийг зөвшөөрсөн бол,

5	Бүгд Найрамдах Азербайжан улс	Төрийн албан тушаалтны үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль	<p>24.4. “Төрийн албан тушаалтан санхүүгийн мэдээлэл гаргах журам”-ын тухай хуулийн дагуу гаргасан мэдэгдлийг Хэрэгжүүлэгч агентлагийн хүсэлтээр энэ хууль, бусад хуулийн зөрчлийг тогтоохын тулд гаргаж өгнө.</p> <p>24.6. Төрийн албан тушаалтан нь Хэрэгжүүлэгч агентлагтай хамтарч ажиллана. Хэрэгжүүлэгч агентлагийн явуулж буй хянан шалгах ажиллагаанд саад болсон, хажуунаас оролцсон, бүрхэгдүүлсэн төрийн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>	<p>24.7. 23.2.4-т заасан тохиолдолд энэ хууль, бусад хуулийг төрийн албан тушаалтан зөрчсөн гэх үндэслэлийг хянан шалгах ажиллагаагаар тогтоовол, Хэрэгжүүлэгч агентлаг нь төрийн албан тушаалтанд бичгээр шийдвэрийг мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд Хэрэгжүүлэгч агентлагийн шийдвэрийн үндэслэл баримт, энэ хууль, бусад хуулийн зөрчигдсөн гэж үзэж буй заалтыг агуулсан байна. Мэдэгдэлд Хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааны журмыг тусгана. Төрийн албан тушаалтан нь 15 өдрийн дотор мэдэгдэлд амаар, бичгээр хариу илгээх ба төлөөний этгээдээр төлөөлүүлэх эрхтэй.</p> <p>24.8. Төрийн албан тушаалтнаас 15 өдрийн дотор хариу авсны дараа Хэрэгжүүлэгч агентлаг нь дараах арга хэмжээ авна:</p> <p>24.8.1. энэ хууль, бусад хуулийн зөрчил гарсан гэж үзэх үндэслэлтэй шалтгаан байхгүй гэж үзвэл хэргийг хэрэгсэхгүй болгож, төрийн албан тушаалтанд бичгээр шийдвэрээ мэдээлнэ,</p> <p>24.8.2. хэрвээ төрийн албан тушаалтны хариуг авч үзсэний дараа, энэ хууль, бусад хуулийг зөрчсөн гэх үндэслэлтэй шалтгаан байсан хэвээр байна гэж Хэрэгжүүлэгч агентлаг үзвэл төрийн албан тушаалтнаас байцаалт авч эхэлнэ.</p> <p>24.9. Хэрэгжүүлэгч агентлаг нь хянан шалгах ажиллагааны явцад төрийн албан тушаалтнаас олсон баримт, нэмэлт тайлбарт үндэслэн нэгдсэн нууц хавтас бүрдүүлнэ.</p> <p>24.10. Хэрвээ, хянан шалгах явцад эрүү, захиргааны зөрчлийн элемент илэрвэл Хэрэгжүүлэгч агентлаг нь холбогдох хууль хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэнэ. 28.1 Төрийн албан тушаалтан, хуучин албан тушаалтан байсан этгээд нь хууль бусаар олж авсан эд хөрөнгө, эрх дарх, давуу талын үнэ төлбөрийг сайн дураараа төрд хүлээлгэн өгнө. Төрийн албан тушаалтан, хуучин албан тушаалтан байсан этгээд нь хууль бусаар олж авсан эд хөрөнгө, эрх дарх, давуу талын үнэ төлбөрийг сайн дураараа төрд хүлээлгэн өгөхөөс татгалзсан бол хууль бусаар олж авсан эд хөрөнгө, эрх дарх, давуу талын үнэ төлбөрийг холбогдох төр, орон нутгийн байгууллагаас шүүхэд хандсаны үндсэн дээр хийгдсэн шүүхийн шийдвэрээр төрийн мэдэлд авна.</p>
---	-------------------------------	--	---	--

Ашигласан материал:

- http://km.undp.sk/uploads/public/File/AC_Practitioners_Network/Latvia_law_Prevention_Conflict_of_Interest.htm
- <http://www.gov.me/files/1187943961.pdf>
- http://www.janvalenta.cz/korpus/doku.php?id=act_on_conflict_of_interests
- <http://www.state.gov/>
- <http://politics.people.com.cn/GB/1026/12111916.html>

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан улсууд нийтийн албан тушаалтан нь заавал орлогын мэдүүлгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж өгөх ёстой, хөрөнгө орлогын мэдээлэл нь олон нийтэд ил байж түүнээс илүү эд хөрөнгө олж авсныг ихэвчлэн тодорхой мэдээлэгчийн хүсэлтээр аудит, шүүх, прокурор шалгах аар хуульчилсан байна. Санкцийн хувьд улс орнуудын хувьд харилцан адилгүй байна.

Латви улсын хувьд Төрийн албан тушаалтны үйл ажиллагааг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хуульд зааснаар орлогын мэдүүлгээс илүү гарсан хөрөнгийг хууль ёсны гэж харуулж чадахгүй бол улсад тэр хэмжээний хохирол учруулсан, төрөөс нуусан гэж үзэж төрд хурааж авдаг бол Монтенегро улсын хувьд Хороо нь ажлаас халах санал гаргаж, эрүүгийн гэмт хэрэг бол прокурорт шилжүүлдэг байна. Макаод төрийн албан хаагч жил бүр хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгөх бөгөөд албан хаагч төрөөс олгогдсон эрх мэдлийг ашиглаж илүү орлого яаж олсноо тайлбарлах үүрэгтэй, хэрэв тайлбар хангалтгүй бол хөрөнгийг хурааж, 3 жил хорих ялаар шийтгэнэ.

Эстонид хөрөнгө орлогын мэдээлэлдээ албан хаагч өмнөх 6 сарын цалингийн 10%-иас илүү хэмжээний орлогын талаар мэдээлэх бөгөөд хөрөнгө орлогоо худал мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин АНУ-д Төрийн албаны ёс зүйн хуульд хөрөнгө орлогоо худал мэдээлсэн бол Ерөнхий прокурорт шилжүүлж, боловсон хүчний буюу бусад арга хэмжээг авахаар зохицуулсан байна.

ОХУ-ын 2008 онд батлагдсан “Авилгын эсрэг үйл ажиллагааны тухай хууль”-нд төрийн албан хаагч болон төрийн албанд шинээр орж буй этгээд нь өөрийн хөрөнгө орлогоо заавал мэдүүлэх бөгөөд энэ үүргийг биелүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн тохиолдолд төрийн албанаас халах, төрийн албанд авахгүй байх үндэслэл болдог байна.

Япон, ХБНГУ, БНХАУ-ын хувьд хөрөнгө, орлогын мэдүүлгээс илүү гарсан хөрөнгийг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол гэсэн үйл явцыг нарийвчлан зохицуулсан заалтууд байхгүй бөгөөд Авилга, хээл хахуультай холбоотой гэмт хэргийг зохицуулсан хуулиудад ерөнхийд нь хэрхэн тусгасныг тус судалгаанд мэдээлэл өгөх үүднээс хөрөнгө орлогын мэдүүлэг, хугацаа, хариуцагч байгууллага зэрэг мэдээллээр харуулсан болно.

Судалгааны үндсэн дээр дүгнэхэд “албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцыг бусад улс орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжинд хэрхэн тусгасныг харьцуулахад

1. Пост коммунист орнууд сонирхлын зөрчилтэй холбоотой хэргийг шийдэхийн тулд Авилгатай тэмцэх хуулиа хүчингүй болгож тусгайлсан Сонирхлын зөрчлийн эсрэг хуулиудыг баталсан байна.
2. АНУ, ХБНГУ, БНХАУ зэрэг улсууд Авилгын эсрэг хуулиар болон бусад хуулиар зохицуулсан хоёр ерөнхий хандлагатай байна.

“Албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцтай холбоотой нийтлэг зохицуулалт бол

1. Илүү гарсан хөрөнгийг төрд хураан авах
2. Ажлаас халах, дахиж төрийн албанд ажиллахгүй байх
3. Хорих гэсэн зохицуулалттай байна.



МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ОРЧНЫ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖИЙН ТАЛААРХ ТОЙМ СУДАЛГАА

Р. Хатанбаатар, Б. Хатантуул, Б. Мөнхцэцэг, А. Пагма

УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн захиалгаар “Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт ба авлигатай тэмцэх орчны эрх зүйн чадамж” сэдвийн хүрээнд Монгол дахь авлигын төлөв байдал, Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, уг хуулийн авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах чадамжийн талаар тойм судалгааг гүйцэтгэв.

Судалгааг дараах эрх зүйн баримт бичгүүд болон Авлигатай тэмцэх газраас авсан мэдээлэл зэргийг авч ашигласан болно. Үүнд:

- НҮБ-ын Авилгын эсрэг конвенц 2006 он,
- Авилгын эсрэг хууль 2006 он ,
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2002-2010 он,
- АТГ-ын зохион байгуулалтын бүтэц орон тоо батлах /УИХ-ын 2007 оны 3 дугаар тогтоол/,
- Хөрөнгө орлогын мэдүүлэгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам /УИХ-ын 2007 оны 9 дүгээр тогтоол/,
- Авилгын индексийг тооцон гаргаж олон нийтэд зарлах тухай/УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол,
- Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол
- Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний тайлан,
- Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан,
- Туршилтын үнэлгээ хөтөлбөр,
- Авлигатай тэмцэх газрын 2007-2011 оны тайлан,
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны “Мянганы хөгжлийн 24 дүгээр зорилт: Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” тайлан.

Хээл хахууль авах гэмт хэргийн гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийхдээ “Транспэренси Интернэйшнл”-ээс гаргасан Авлигын нөхцөл байдлын индекс -2011 судалгааны дагуу авлига хамгийн их байгаа, хамгийн бага байгаа болон авлига дундаж байгаа орнуудаас сонгон 8 орны эрүүгийн хууль болон Авилгын эсрэг хуулинд хэрхэн зохицуулсныг хүснэгтээр харуулж захиалгыг гүйцэтгэв.

Хавсралт 1 болон 2-оор Авлигатай тэмцэх үндэсний стратегийг боловсруулахад анхаарах асуудал, мөн түүнчлэн Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хүрээнд хүлээсэн үүрэг, хэрэгжилтийн талаарх тайланг бүрэн эхээр нь хавсаргав.

Монгол дахь авлигын төлөв байдал

Авлигын асуудлыг дэлхий дахинаа судалж, улс нэг бүрээр авлигын түвшинг тодорхойлж байдаг “Транспэренси-Интернэйшнл” /**Transparency International**/ олон улсын байгууллагын судалгаагаар авлига хамгийн их цэцэглэсэн улсын тоонд буурай хөгжилтэй улсууд

төдийгүй АНУ, Итали, Франц зэрэг өндөр хөгжилтэй улс орсноос үзвэл энэхүү хорт үзэгдэл улс орны баян чинээлэг, хөгжилтэй эсэхээс төдийлөн үл хамаарч “даяарших” хандлагатай болж байна.

Монгол Улсад авлига улам бүр газар авч буйг тус улсын нийгэм-эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжих үйл явцыг дэмжиж хөрөнгө санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлж байсан донор улсууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагууд Улсын Их Хурал, Засгийн газарт удаа дараа анхааруулж байсан ч Монголын төр энэхүү үзэгдлийг уг үндсээр нь таслахад чиглэсэн бодитой ажил зохион явуулаагүйгээс эдүгээ манай улс авлигад гүнзгий идэгдсэн улсын тоонд орж байна. Тухайлбал, **Transparency International** байгууллагаас тогтмол гаргадаг **Corruption Perception Index** 2010 оны байдлаар Монгол Улсыг авлигын түвшингээр 178 улсаас 116-д оруулжээ.

- Монгол Улсыг 2009 оноос эхлэн Global Integrity буюу “Шударга, ил тод байдлын тайлан”-д хамааруулж эхэлсэн. Уг тайланд Монголын Улсын “шударга, ил тод байдал”-ыг Mongolia: Integrity Indicators Scorecard Overall Score: 57 (+/- 1.54) - Very Weak буюу “маш сул” гэж дүгнэжээ.
- Дэлхийн банкаас жил бүр гаргадаг “Сайн засаглалын индикатор”-т Монгол Улсын авлигад тавих хяналт /control of corruption/-ын үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтмол буурч 2009 онд 100 онооны үнэлгээнээс 24 оноогоор нилээд хойгуур жагсажээ.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, түүнчлэн АНУ-ын “Олон улсын хөгжлийн агентлаг”, “Муж улсуудын шүүхийн үндэсний төв” зэрэг судалгааны байгууллагаас санхүүжүүлж монголын иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор гүйцэтгэсэн судалгаанууд Монгол дахь авлигын төлөв байдал, авлигын тухай иргэдийн төсөөлөл, хандлагыг бодит байдлаар тодорхойлоход ач холбогдол бүхий хангалттай мэдээлэл агуулсан байна. Дээрх судалгааны тайлан, мэдээ мэдээллийг бүхэлд нь дүгнэж үзвэл эдүгээ Монгол Улсын авлигын талаар дараах төсөөлөл хийж болохоор байна²

Үүнд:

- Авлига төрийн албаны бүхий л салаа мөчирт өргөн тархсаны дотор улс төрийн хүрээнд, ялангуяа улс төрөөр дамжин төрийн өндөр албан тушаалд хүрэгсэд /судалгаанд “Өндөр түвшин”, “Элит” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна/-ийн дунд авлига илүү их байна.
- Улс төрийн хүрээнд дэх бизнесийн бүлэглэлийн сонирхлын зөрчил, сонгуулийн болон намын санхүүжилт, сонгуулийн тогтолцооны авлигад үзүүлэх нөлөө маш хүчтэй хэвээр байна.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал суларч, улс төрийн намуудаас ихээхэн хараат болсны гадна “төрийн аппарат данхайж”, улсын төсөвт эзлэх зардлын хэмжээ, хувийн жин өсөн нэмэгдсэн ч иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар улам муудаж байна.
- Улс төрийн намын дараа авлигад хамгийн ихээр автсан байгууллагаар цагдаа, газрын алба, шүүх, мэргэжлийн хяналт, татвар зэрэг байгууллагыг олон жил ээлжлэн нэрлэж байна.
- Авлига авах олон арга, хэлбэрийг судалгааны санал асуулгад дурдсан боловч эдгээрээс төрийн албанд ажилд орох, ямар нэг зөвшөөрөл олгох, тендерт оролцох буюу төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтыг онцлон нэрлэсэн байх ба сүүлийн үеийн судалгаагаар эрүүл мэнд, боловсролын салбарын эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой авилгыг олонтаа нэрлэх болжээ.
- Авлигыг “ажлаа хурдан бүтээх чухал хэрэгсэл”, “авлига нь нийгэмд байх зүйл,

заавал муу үр дагавартай байх ёсгүй”, “тийм ч гаж үзэгдэл биш” гэх зэргээр авлигад дасан зохицох хандлага нийгмийн зарим бүлэгт төлөвшиж буй нь ажиглагдаж байна.

Хамгийн сүүлийн үеийн тоон судалгаануудаас харахад хэдийгээр аргачлалын тухайд асуудалтай боловч авлигын нөхцөл байдал сайжрахгүй байгаа гэдэг нь илэрхий байна. Эдгээр асуудал 2009 оны 12 дугаар сард хийгдсэн Азийн Сангийн олон нийтийн авлигын төсөөллийн судалгаанаас¹ ч харагдаж байгаа бөгөөд уг судалгаа дараах гол дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

- Монгол улсад тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлын тоонд авлига тогтмол багтдаг боловч авлигын жагсаалтад эзлэх байр нь ерөнхийдөө доошилсон байна.
- Гэвч иргэдийн дийлэнх олонхи нь Монголд авлига нийтлэг үзэгдэл гэж үзсэн хэвээр байна.
- Дунджаар 5 өрх бүрийн нэг нь 3 сарын хугацаанд ямар нэгэн хахууль өгдөг.
- Өрхийн 1 жилд төлдөг нийт хахуулийн хэмжээ 2007 оноос хойш эрс нэмэгдсэн бөгөөд өрхийн төсөвт үзүүлэх дарамт ч тэр хэмжээгээр нэмэгдэж байна.
- Авлигын улс оронд тусч буй нийт өртөг сүүлийн 4 жилд ойролцоогоор \$337 сая ам. доллар байв.
- Хахууль өгөхгүй гэж хариулсан хүний тоо 2007 оноос эхлэн тогтмол нэмэгдсээр байна. Мөн авлигыг хүлээн зөвшөөрөх хүний тоо буурсаар байна.
- АТГ-т өгөх үнэлгээнд бага зэрэг өөрчлөлт гарсан хэдий ч тус байгууллагад итгэх олон нийтийн итгэл ихээхэн буурчээ.
- Нийт 4 жилийн ажиглалтаас харахад Газрын албыг авлигад хамгийн их автсан байгууллага гэж үзжээ.
- Багш, эмч, төрийн захиргааны албан хаагчид хахууль хамгийн их давтамжтай авсан байна. 2009 онд эмч нар хахууль хамгийн их авсан жагсаалтыг тэргүүлэх болов.

Хэрэв авлига үнэхээр асуудал мөн бол АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тайланд авлигатай тэмцэх гол анхаарал өндөр албан тушаалд сонгогдсон болон томилогдсон төрийн албан хаагчдыг хамарсан авлига руу чиглэх ёстой гэж үзжээ:

Захиргааны авлига нь төрийн үр ашгийг багасгаж, эдийн засгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг бууруулж байгаа ч Монголд оршиж байгаа хамгийн хүнд шинжийн авлига нь элитийн түвшний авлига юм. Үүний шалтгаан нь элитийн түвшинд захиргааны түвшний авлигаас илүү их хэмжээний мөнгө эргэлддэг болон илүү олон хэлцэл хийгддэгтэй л зөвхөн холбовол учир дутагдалтай. Эхний шалтгаан нь магадгүй үнэн байх, харин сүүлийн шалтгааныг батлахад хэцүү. Элит түвшний авлига Монголд нэн тулгамдсан асуудал болоод байгааг дараах шалтгаантай холбож үзэх нь зүйтэй.

- 1) энэ нь захиргааны авлигын өнгө, жишгийг тогтоодог бөгөөд одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр нь хадгалж үлдэх гүн сонирхлыг агуулж байдаг,
- 2) энэ нь бусад бүх сонирхлыг, түүнийг дотор ардчиллыг бэхжүүлж, өргөн хүрээтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих сонирхлыг шахах магадлал бүхий улс төр, эдийн засгийн тогтолцоог улам бэхжүүлж болзошгүй юм.²

¹ <http://report.globalintegrity.org/Mongolia/2009>

² <http://info.worldbank.org/governance/wgi/pdf/c147.pdf>

Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал

Монгол Улсын хэмжээнд дараах эрх зүйн баримт бичгүүд үйлчилж байна. Үүнд:

- НҮБ-ын Авилгын эсрэг конвенц 2006 он,
- Авилгын эсрэг хууль 2006 он ,
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2002-2010 он,
- АТГ-ын зохион байгуулалтын бүтэц орон тоо батлах /УИХ-ын 2007 оны 3 дугаар тогтоол/,
- Хөрөнгө орлогын мэдүүлэгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам/ УИХ-ын 2007 оны 9 дүгээр тогтоол/,
- Авилгын индексийг тооцон гаргаж олон нийтэд зарлах тухай/УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол,
- Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол зэрэг болно.

Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг гаргахдаа АТГ-ын 2007-2011 оны тайлан, НҮБ-ын Авлигалын эсрэг Конвенцийн хэрэгжилтийн тайлан, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны “Мянганы хөгжлийн 24 дүгээр зорилт: Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” тайлангаас авч ашигласан болно.

НҮБ-ын Авлигалын эсрэг конвенцийн хэрэгжилт^{3,4}

Монгол Улс 2005 оны 4 сарын 29-ний өдөр конвенцид гарын үсэг зурж, 2006 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр уг конвенцид нэгдэн орсон. Конвенцийн шаардлагын дагуу арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс Авлигын эсрэг хуулиа шинэчлэн баталсан бөгөөд 2006 оны 11 сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж Авлигатай Тэмцэх Газрыг байгуулсан. Эрүүгийн хуулийг 2002 онд хянан үзэж, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, АТГ-ын мөрдөн шалгах хүрээний хэргүүдийг тусгасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 2002 онд баталсан бөгөөд 2007 онд нэмэлт, өөрчлөлт оруулан, эрүүгийн хариуцлага ногдуулах гэмт хэргийн талаар АТГ-ын мөрдөн байцаах чиг үүргийг тодорхойлсон байна. Мөн АТГ-ын үйл ажиллагаа нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах, хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар хязгаарлагддаг, шүүн таслах эрх мэдэл байдаггүй.

Монгол Улс НҮБ-ын Авлигалын эсрэг конвенцийн 46 дахь зүйл (эрх зүйн харилцан тусалцаа), түүний 9, 13 дахь заалтын дагуух шаардлагатай бүх арга хэмжээг авчээ. Мөн Авлигын эсрэг конвенцийн 5 дахь зүйлийн (авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа) шаардлагыг байнга хангаж байх арга хэмжээ авч байна. Тус улс мөн конвенцийн 17-р зүйл (Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах), 52-р зүйлийн (Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх) хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулж байна.

Харин тус улс Авлигалын эсрэг конвенцийн 15-р зүйл (Үндэсний төрийн албан тушаалтныг хахуульдах), 25-р зүйл (Шүүн таслах ажиллагаанд саад учруулах), 53-р зүйлийн (Эд

³ Asia Foundation (2009). Mongolia Corruption Benchmarking Survey. Mongolia: Ulaanbaatar. p7.

⁴ USAID. (2005). Assessment of Corruption in Mongolia, *Final Report*. Mongolia: Ulaanbaatar. p3.

хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ) шаардлагыг хангах талаар зөвхөн зарим нэг арга хэмжээ л авсан байна. Монгол Улс Авлигалын эсрэг конвенцийн 16-р зүйлийн (Гадаадын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах) шаардлагыг хангах чиглэлээр арга хэмжээ аваагүй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

Улсын Их Хурлаас 2002 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь авлигаас урьдчилан сэргийлэх стратегийг агуулдаг бөгөөд 2004, 2006 онд тус тус нэмэлт, өөрчлөлт хийгджээ. 2006 оны нэмэлт, өөрчлөлтийг 2007 онд УИХ баталсан. Энэхүү хөтөлбөрийг 2002-2010 оны хооронд хоёр үе шаттай хэрэгжүүлсэн байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гурван бүлэгтэй, тодорхой зорилго, зорилт, зарчим, хэрэгжилтийн хугацааны хуваарь, хүлээгдэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан байдаг. Уг хөтөлбөр сонгуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, шүүхийн бие даасан байдлыг хангах, гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүг чөлөөлөх, авлигатай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэхийг зорьж байна. УИХ анх Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөлийг зохицуулах, удирдах чиг үүрэгтэй байгуулсан байна.

2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчилснээр НҮБ-ын Авлигалын эсрэг конвенцийг бүрэн хэрэгжүүлэх зорилттой нийцүүлсэн. Шинэчилсэн хуулиар Авлигатай Тэмцэх Газрыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг манлайлан хэрэгжүүлэх байгууллага байхаар зааж, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон байна. АТГ эдүгээ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2010 онд дуусаж байгаатай холбогдуулан Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх дунд хугацааны хөтөлбөрийг батлуулахаар холбогдох төслийг боловсруулж байна.

Авлигын эсрэг хуулийн авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах чадамжийн талаар

Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон эрхзүйн шинэ орчныг бүрдүүлэх зорилгоор авлигын эсрэг хуулийг 2006 онд УИХ-аас батлан гаргасан билээ. Энэхүү хуулиас үзэхэд авлигатай тэмцэх байгууллагын эрхзүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг түлхүү зохицуулжээ. Харин авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагааны зарчмын чухал ач холбогдолтой зохицуулалтууд төдийлөн бүрэн дүүрэн хуульчлагдаагүй байдал харагдаж байна. Тухайлбал, авлигалтай тэмцэхэд олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхойлсон авч урьдчилан сэргийлэхтэй холбоотой зохицуулалт нь учир дутагдалтай болсоныг дурьдаж болно.

Авлигалаас урьдчилан сэргийлэх нэг гол нөхцөл нь сонирхлын зөрчлийг хуулиар сайн тодорхойлж зохицуулах явдал юм. Хуульд сонирхлын зөрчлийн талаарх тодорхойлолт байхгүйн зэрэгцээ төслийн долдугаар зүйлд авлигалаас урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой албан тушаалтнуудын тодорхой үйлдэл хийхийг хориглохоор заасан нь хангалтгүй байсан юм.

Авлигалаас урьдчилан сэргийлэх өөр нэгэн чухал нөхцөл нь төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн сайн зохицуулалт юм. Иймээс бодитой, хэрэгжихүйц заалтыг энэ хуулийн оруулах нь нэн ач холбогдолтой. Одоо үйлчилж буй Авлигалын эсрэг хуулинд ийм заалт байдаг боловч хэрэгжилт болон хяналт нь төдийлэн хангалтгүй байдаг.

Улс орнууд албан тушаалтны жагсаалтыг авлигалын хуулиндаа заасан байдаг ба хөрөнгө орлогын мэдүүлгийн загварыг хуулиндаа оруулсан байдаг байна. Төрийн албан хаагчдын жагсаалтанд зөвхөн төрийн өндөр албан тушаалтанаас гадна, төрийн оролцоотой аж

ахуйн нэгж, үйлдвэрийн газрын захирал хүртэл хамаарагдах нь зүйтэй юм. Тус хуулинд авлигалын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигалаас урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн талаар заасан боловч Зөвлөлийн статус, харьяалагдах институтын талаар тун бүрхэг байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг уг хуулиар тодорхой заан, бүрэлдэхүүнд иргэний нийгэм буюу ТББ-ын төлөөлөгчдийг оруулах нь ач холбогдолтой юм.

Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр УИХ-аас баталсан ба Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд энэ хуулийг дагалдан батлагдсан юм.

Монгол улсад засаглалыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албыг нийтийн алба болгон зохион байгуулах, түүний ил тод, хариуцлагатай, шударга үйл ажиллагааг бэхжүүлэх, нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн сонирхлыг хувийн сонирхлоос дээгүүрт тавих зэрэг шаардлага байгааг үндэслэн Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага бий болсон аж.

Эдгээр хуулиуд энэ оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс үйлчилснээр одоогоор зохицуулалт, хяналтгүй хэрэгжиж буй нийтийн албан тушаалтны албан үүрэгтэй зөрчилдсөн хувийн сонирхлыг хориглох, хязгаарлах, зохицуулах эрх зүйн үндэс бүрдэх юм. Ингэснээр нэг талаас, нийтийн албан тушаалтныг тодорхой баримтгүй хардаж нийтийн албаны нэр хүндийг гутаах, нөгөө талаас нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн сонирхолдоо урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал олгох замаар авлигад холбогдохгүй байх урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болно.

Сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүргийг дээрх хуулиар тогтоосон бөгөөд төрийн байгууллагын удирдлага нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам бүхий ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх, хувийн сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хянан шалгах, сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах шалгалт хийх, хариуцлага тооцох, зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Сонирхлын зөрчлийг сайн тодорхойлж зохицуулснаар авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөл болдогийг бусад улсын туршлага харуулж байна. Ихэнх орнууд сонирхлын зөрчлийн асуудлыг тусгай хуулиар зохицуулдаг бөгөөд зарим орнууд авлигалын эсрэг хуулиндаа тусгай бүлэг болгон оруулсан байдаг. Жишээлбэл, манай улстай адил шилжилтийн улс орон болох Латви болон Литва нь сонирхлын зөрчлийн тухай тусгай хуультай. Түүнчлэн Эстони улс нь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хоёр бүлэг дүрмийг Авлигалтай тэмцэх тухай хуулинд тусгасан байдаг.

Авлигын эсрэг хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага, этгээдийг тодорхой болгох, албан тушаалтанд хориглох зүйлийг нарийвчлан хуульчилах, хөрөнгө, орлогын мэдүүлэг, түүнийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхой болгох, авилгын эсрэг хууль, тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг тодруулан, нарийвчлан хуульчилсан нь тухайн хуулийн авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоо хэрэгжүүлэх, түүний чадамжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Бүхэлдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдан, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд энэ хуулийг дагалдан

батлагдсанаар авлига, сонирхлын зөрчилтэй тэмцэх хуулийн бүрэн зохицуулалттай болсон ба одоо хуулийг амьдралд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх ажил хүлээгдэж байна.

Хээл хахууль авах гэмт хэргийн эрүүгийн хуулийн харьцуулалт, гадаад орны туршлага

“Транспэренси Интернэйшнл”-/Transparency International/-ээс жил бүр гаргадаг Авлигын индексн 2011 онд хийгдсэн судалгаагаар⁵ Авлигын нөхцөл байдлын индексийг нийт 178 орны хүрээнд гаргасанаас:

- авлига хамгийн бага буюу Дани, Шинэ Зеланд, Сингапур, Финланд улсууд байсан бол
- авлига хамгийн их байгаа орнуудад Афганистан, Ирак, Узбекистан зэрэг,
- дундаж үзүүлэлттэй Турк, Малайз, Бразил улсууд байна.

Азийн орнуудаас Сингапур, Хонг-Конг улсууд нь олон улсын хэмжээнд Авлига хамгийн багатай эхний 15 орны тоонд багтдаг. Эдгээр улсуудад авлигын эсрэг тэмцэж харьцангуй богино хугацаанд эерэг үр дүнд хүрсэн шалтгаан нь төстэй бөгөөд хоёуланд нь авилгын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус байгууллага байгуулагдсан явдал нь уг амжилтын үндэс болсон гэж олон улсын шинжээчид үздэг.

Хээл хахууль авах гэмт хэргийн гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийхдээ “Транспэренси Интернэйшнл”-ээс гаргасан Авлигын нөхцөл байдлын индекс - 2010 судалгааны дагуу Авлига хамгийн их байгаа, хамгийн бага байгаа болон авлига дундаж байгаа дээрхи орнуудаас сонгон судалсан болно. /Судалгааг бэлтгэх явцад дээрх улсуудын хүрээнд Эрүүгийн хуулийг хайсан боловч зарим улс орны хувьд Эрүүгийн хууль тогтоомж нь англи хэл дээр биш, тухайн орны өөрийн хэл дээр байсан учир Авлигын индексээс дараагийн орнуудын хуулийг авч үзсэн болно./

ХЭЭЛ ХАХУУЛЬ АВАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГАДААД ОРНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /ХҮСНЭГТЭЭР/

1 ШИНЭ ЗЕЛАНД	
Авлига хээл хахуулийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж	- Шинэ Зеландын Гэмт хэргийн Акт-1961 /New Zealand-Crimes Act-1961/ ¹

⁵ Дэлгэрэнгүй тайланг хавсралт-2-оор үзнэ үү.

<p>Хээл хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан байдал /зүйл заалт/</p>	<p>6 дугаар хэсэг Хээл хахууль болон авлигал</p> <p>99. Шууд эсвэл шууд бус аргаар бэлэн мөнгө, үнэ бүхий зүйл, албан тушаал эсвэл ажлын байр, тэтгэмж авахыг хээл хахууль гэнэ.</p> <p>100.1. Шүүхийн албан тушаалтан (бүх шатны шүүгч нар) хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс Шүүхийн байгууллагад ажилдаг боломжоо ашиглан гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 14 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>100.2. Аливаа Шүүхийн албан тушаалтан (бүх шатны шүүгч нар) болон Хуралдааны урьдчилсан үе шатны удирдагч эсхүл түүний орлогч хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 7 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>102. Хатан хааны сайд эсвэл Засгийн газрын сайд хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 14 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>103. Аливаа Парламентын гишүүн хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 7 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>104. Аливаа хууль сахин биелүүлэх албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 7 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>105. Аливаа албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө болон хэрэгжүүлэхийн тулд, урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах болон санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон тохиолдолд 7 жилээс ихгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр</p>	<p>Хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлсэний төлөө, эсхүл гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхийн тулд урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах, санал болгосон хээл хахуулийг авахыг зөвшөөрсөн, авахыг оролдсон²</p>
<p>Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх хүндрүүлэх үндэслэл</p>	<p>Шүүхийн шийдвэрт</p>
<p>Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл</p>	<p>Шүүхийн шийдвэрт</p>

Гэмт хэргийн субъект	-Шүүхийн албан тушаалтан (бүх шатны шүүгч нар) -Хууль сахин биелүүлэх албан тушаалтан -Хатан хааны сайд эсвэл Засгийн газрын сайд -Парламентын гишүүн -Албан тушаалтан (энэ ангилалд Шинэ Зеланд улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага болон гадны байгууллагад ажиллаж буй гадаад орны харьяат)
Оногдуулах ялын хэмжээ	- Шүүхийн албан тушаалтанд 14 жилээс ихгүй хорих ял, - Хууль сахин биелүүлэх албан тушаалтанд- - Хатан хааны сайд эсвэл Засгийн газрын сайд-14 жилээс ихгүй хорих ял, - Парламентын гишүүнд-7 жилээс ихгүй хорих ял, - Хууль сахин биелүүлэх албан тушаалтан-7 жилээс ихгүй хорих ял - Албан тушаалтан-7 жилээс ихгүй хорих ял
2 СИНГАПУР УЛС	
Авлига хээл хахуулийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж	-Сингапур улсын Авлигалаас урьдчилан сэргийлэх Акт-241/1960, 2011 хүртэлх нэмэлт өөрчлөлт орсон. /Prevention of Corruption Act-241/1960 amendments up to 2011 included / ³
Хээл хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан байдал /зүйл заалт/	5 дугаар хэсэг Албан тушаалтан албан тушаалаа ашиглан бусдаас хээл хахууль авахаар холбоо тогтоох, хээл хахууль өгөхийг нь хүлээн зөвшөөрөх, авах, бусдаар дамжуулан авах эсхүл гүйцэтгэх үйлдлийнхээ төлөө урьдчилан амлаж хээл хахууль авсан тохиолдолд 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих ял эсхүл 2 ялыг хамтад нь хэрэглэнэ. 10 дугаар хэсэг Төрийн албан хаагч албан тушаалаа ашиглан хээл хахууль авсан тохиолдолд 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох эсхүл 7 жил хүртэл хугацаагаар хорих ял эсхүл 2 ялыг хамтад нь хэрэглэнэ. 11дүгээр хэсэг Парламентын гишүүн албан тушаал боломжоо ашиглан хээл хахууль авсан тохиолдолд 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох эсхүл 7 жил хүртэл хугацаагаар хорих ял эсхүл 2 ялыг хамтад нь хэрэглэнэ.
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Албан тушаалаа ашиглан бусдаас хээл хахууль авахаар холбоо тогтоох, хээл хахууль өгөхийг нь хүлээн зөвшөөрөх, авах, бусдаар дамжуулан авах эсхүл гүйцэтгэх үйлдлийнхээ төлөө урьдчилан амлах.
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх үндэслэл	Хуульд тусгаагүй

Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	<p>7 дугаар хэсэг</p> <p>Албан тушаалтан 5 болон 6 дугаар хэсэгт заасан зөрчлөөр яллагдсан үндэслэл нь тухайн хээл хахууль өгөгчийг Засгийн газартай гэрээ хэлэлцээр байгуулахад тусалж шан харамж авсан тохиолдолд 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох эсхүл 7 жил хүртэл хугацаагаар хорих ял эсхүл 2 ялыг хамтад нь хэрэглэнэ.</p> <p>13 дугаар хэсэг</p> <p>Тухайн Албан тушаалтан, Парламентын гишүүн, Төрийн албан хаагч тус Актдад заасан зөрчлийг 2 болон түүнээс их зөрчсөн бол оногдох ялын хамт хахуульд авсан үнийн дүнг гаргуулах болон Шүүх шийдвэрлэнэ.</p>
Гэмт хэргийн субъект	<ul style="list-style-type: none"> • Албан тушаалтан • Парламентын гишүүн • Төрийн албан хаагч
Оногдуулах ялын хэмжээ	<p>Албан тушаалтанг</p> <ul style="list-style-type: none"> - 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох, - 5 жил хүртэл хугацаагаар хорих ял, - 2 ялыг хамтад нь хэрэглэх - Хүндрүүлэх нөхцөлд байдалд - 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох, - 7 жил хүртэл хугацаагаар хорих ял, - 2 ялыг хамтад нь хэрэглэх <p>Парламентын гишүүнг</p> <ul style="list-style-type: none"> - 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох, - 7 жил хүртэл хугацаагаар хорих ял, - 2 ялыг хамтад нь хэрэглэх <p>Төрийн албан хаагч</p> <ul style="list-style-type: none"> - 100,000 сингапур доллараас ихгүй сингапур доллароор торгох, - 7 жил хүртэл хугацаагаар хорих ял, - 2 ялыг хамтад нь хэрэглэх

3 ФИНЛАНД УЛС

Авлига хээл хахуулийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж	Финланд улсын Эрүүгийн хэргийн Кодекс-39/1889, 940/2008 хүртэлх нэмэлт өөрчлөлт орсон. /The Criminal Code of Finland-39/1998 amendments up to 940/2008 included /
--	---

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хээл хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан байдал /зүйл заалт/	<p>40 дүгээр бүлэг 1 дүгээр хэсэг-Хээл хахууль авах⁶</p> <p>Албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхийн тулд бусдаас бэлэг өгөхийг болон хууль бус тэтгэмж өгөхийг шаардах эсхүл тухайн тэтгэмж болон бэлгийг авахын тулд ажил үүргээ гүйцэтгэх, үйлдлийг хийхээр урьдчилан амалж шан харамж авах эсхүл хээл хахууль авахыг зөвшөөрсөн тохиолдолд торгох эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх эсхүл албан тушаалаас нь чөлөөлөх арга хэмжээ авна.</p> <p>40 дүгээр бүлэг 2 дугаар хэсэг-Хээл хахуулийн хүндрүүлсэн нөхцөл</p> <p>Энэ хэргийг хясан боогдуулж, аргагүй байдалд оруулах замаар авсан эсхүл онц их хэмжээний хээл хахууль авсан тохиолдолд албан үүргээс нь чөлөөлж, 4 сараас 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>40 дүгээр бүлэг 4 дүгээр хэсэг-Парламентын гишүүн хээл хахууль авах</p> <p>Парламентын гишүүн албан үүргээ хэрэгжүүлэхийн тулд бусдаас бэлэг өгөхийг болон хууль бус тэтгэмж өгөхийг шаардах эсхүл тухайн тэтгэмж болон бэлгийг авахын тулд ажил үүргээ гүйцэтгэх, үйлдлийг хийхээр урьдчилан амалж шан харамж авах, эсхүл хээл хахууль авахыг зөвшөөрсөн тохиолдолд торгох эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Албан үүргээ хэрэгжүүлэхийн тулд бусдаас хээл хахууль өгөхийг шаардах, эсхүл гүйцэтгэх үйлдлийнхээ төлөө урьдчилан амлах болон хээл хахууль өгөхийг нь хүлээн зөвшөөрөх замаар авсан.
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх үндэслэл	<p>40 дүгээр бүлэг 3 дугаар хэсэг-Хээл хахуулийн зөрчил</p> <p>Албан тушаалтан албан үүргээ хэрэгжүүлэхийн тулд бусдаас бэлэг өгөхийг болон хууль бус тэтгэмж өгөхийг шаардах эсхүл тухайн тэтгэмж болон бэлгийг авахын тулд ажил үүргээ гүйцэтгэх, үйлдлийг хийхээр урьдчилан амалж шан харамж авах эсхүл хээл хахууль авахыг зөвшөөрсөн үйлдэл нь удирдлагын шудрага байдалд итгэх итгэлийг сулруулах байдалд хүргэсэн тохиолдолд тухайн албан тушаалтныг торгох эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	<p>40 дүгээр бүлэг 2 дугаар хэсэг</p> <p>Энэ хэргийг хясан боогдуулж, аргагүй байдалд оруулах замаар авсан эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан</p>
Гэмт хэргийн субъект	<ul style="list-style-type: none"> Албан тушаалтан Парламентын гишүүн
Оногдуулах ялын хэмжээ	<p>Албан тушаалтанг</p> <ul style="list-style-type: none"> тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, торгох, 2 жил хүртэл хугацаагаар хорих ял <p>Хөнгөрүүлэх нөхцөлд байдалд</p> <ul style="list-style-type: none"> Торгох, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих <p>Хүндрүүлэх нөхцөлд байдалд</p> <ul style="list-style-type: none"> 4 сараас 4 жил хүртэл хугацаагаар хорих <p>Парламентын гишүүнг</p> <ul style="list-style-type: none"> 4 жил хүртэл хугацаагаар хорих

4 МАЛАЙЗ	
АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ /Анх 1997 онд баталж 2006-1-1нд нэмэлт өөрчлөлт оруулсан №575/ Anti-corruption act 1997	14 дүгээр зүйл. Төрийн байгууллагын албан хаагч хээл хахууль авах Аль ч төрийн байгууллаг ⁶ -ын албан хаагчид доорх үйлдлүүдийн хариуд шагнал урамшуулал санал болгосон аливаа этгээд болон бусдаас доорх үйлдлүүдийн хариуд шагнал урамшуулал шаардсан төрийн албан хаагчийг, дээрх үйлдлийг хийх чадвар чадамж, эрх, боломж байсан эсэх, дээрх урамшуулал, шагналыг авахаас татгалзсан, тэвчсэн эсэх мөн тухайн шагнал урамшуулал нь тухайн албан тушаалтай холбоотой байсан эсэхийг үл харгалзан гэм буруутайд тооцно. (a) Төрийн аливаа албан байгууллагад өргөн барьсан эсхүл танилцуулсан аливаа асуудал, шийдвэрийн хүрээнд тухайн байгууллагын хуралд ямар нэгэн арга хэмжээний эсрэг эсхүл тухайн арга хэмжээний төлөө санал өгөх, эсхүл санал өгөхөөс татгалзах, (b) албан хаагч нь аливаа хууль тогтоомж, дүрэм журмын гүйцэтгэлийг түргэтгэх, хойшлуулах, саатуулах зэрэгт өөрийн албан үүргийг гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхээс татгалзах хэлбэрээр оролцох, (c) албан хаагч нь аливаа саналыг дэмжигдэхээс сэргийлэх, аливаа гэрээ байгуулах эрх олгохын тулд эсхүл аль нэг хүний талд ашигтай хэлбэрээр ажиллах, (d) өөрийн эрх мэдлийн хүрээнд хэн нэгний ашиг сонирхолд нийцүүлэн ямар нэг тусламж дэмжлэг үзүүлсэн, эсхүл хор хохирол учруулсан бол
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	-өөрийн болон бусдын ашиг сонирхолын үүднээс хэн нэгэнд ашигтайгаар, эсвэл хохиролтойгоор албан үүргээ гүйцэтгэх, -эс гүйцэтгэх, - дээрх үйлдлийг үйлдэхээр болон эс үйлдэхээр завдах, -түүнийхээ төлөө шагнал урамшуулал шаардсан, -санал болгосон шагнал урамшуулал авсан, эзэмшсэн, авахыг зөвшөөрсөн, авахаар завдсан /Үйлдэл эс үйлдэхүйгээр илэрнэ/
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх хүндрүүлэх үндэслэл	-Хөнгөрүүлэх үндэслэл мөн хуулинд тусгайлан заагаагүй боловч эрүүгийн хуулийн ерөнхий анги дахь гэмт хэргийн хөнгөрүүлэх нөхцөл үйлчлэх байх
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	-хүндрүүлэх үндэслэл хуулийн тусгай ангид тусгайлан заагаагүй ч
Гэмт хэргийн субъект	-Засгийн газар -Парламент -Нутгийн удирдлагын байгууллага болон бусад хууль ёсны захиргааны байгууллага -Засгийн газрын яамд, агентлаг, Парламентын мэргэшсэн алба, Нутгийн захиргааны байгууллагад үйлчлэх албадууд, -Төрийн өмчит компанийн удирдлага болон хяналтын эрхийг эдлэгч, -Аль нэг нийгмийн байгууллага болон эвсэл холбоодын албан тушаалтан, албан хаагч
Оногдуулах ялын хэмжээ	-3 жил хүртэл хугацаагаар хорих -торгох Хорих болон торгох нэгэн зэрэг онооно.

5 ОХУ	
Авлига хээл хахуулийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж	ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8-р бүлгийн 290-291-р зүйлүүдэд хээл хахуулийн гэмт хэргийн талаар заасан байдаг. ⁷
Хээл хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан байдал /зүйл заалт/	<p>290.1 Албан тушаалтан нь өөрөө буюу бусдаар дамжуулан хээл хахуульд зуучлах, авахад бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө эсвэл ашиг сонирхлын үүднээс, өөрийн албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсвэл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу хийвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 700-1000 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох буюу 5 жил хүртэл хугацаагаар хорьж, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3-н жил хүртэл хугацаагаар хасна.</p> <p>290.2 Хууль бус үйлдлээр хээл хахууль авсан тохиолдолд 3-7 жилээр хорих буюу 3-н жил хүртэл хугацаагаар тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</p> <p>Дээр дурьдсан 2 заалтаар нь ОХУ-ын төрийн албан тушаалын субъект болж, энэ нь орон нутгийн захиргааны тэргүүнтэй тэнцдэг бөгөөд энэ тохиолдолд 5-10 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэхгүй байх ба үйл ажиллагааг 3 жил хүртэг хугацаагаар явуулахгүй.</p>
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Албан тушаалтан нь өөрөө буюу бусдаар дамжуулан хээл хахуульд зуучлах, авахад бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө эсвэл ашиг сонирхлын үүднээс, өөрийн албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсвэл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу хийвэл
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх үндэслэл	Хээл хахууль өгсөн этгээд сайн дураараа үйлдсэн хэргээ хууль хяналтын байгууллагад мэдэгдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. ⁸
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	<p>а. Тодорхой зөвшөөрлийн дагуу бүлэг хүмүүс аль эсвэл зохион байгуулалттайгаар хийсэн</p> <p>б. удаа дараа</p> <p>в. хээл хахуулийн зориулалтаар</p> <p>г. их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол</p>
Гэмт хэргийн субъект	төрийн гүйцэтгэх албан тушаалтан нь, ОХУ-ын төрийн дээд байгууллагад тодорхой албан тушаал эрхэлсэн этгээд
Оногдуулах ялын хэмжээ	<ul style="list-style-type: none"> - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 700-1000 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгох - 5 жил хүртэл хугацаагаар хорьж, - тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3-н жил хүртэл хугацаагаар хасна - Хүндрүүлэх нөхцөлд - Хорих 7-12 жил хүртэл хугацаагаар - Эд хөрөнгийг хураана.⁹

6 АФГАНИСТАН	
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /1976-10-07/ Serial №134	ХОЁРДУГААР ДЭВТЭР НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БҮЛЭГ 3: Хээл хахууль /254-267 дугаар зүйл/ 254 зүйл. Төрийн албанд ажилладаг ямар ч албан хаагч нь өөрийн үүрэгт ажлаа хийсэн түүнчлэн, хийхээс түдгэлзсэний төлөө эсвэл дээрх үүргээ зөрчсөний төлөө өөрийн болон бусдын нэрийн өмнөөс ямар нэгэн хэлбэрээр мөнгө, бараа болон бусад орлого нэхэмжилсэн мөн дээрх зорилгоор бэлэг, үнэ бүхий зүйл хүлээн авсан, авахаар тохиролцсон этгээдийг хээл хахууль авсанд тооцно. 255.1: Хээл хахууль авсан этгээдэд 2 жилээс доошгүй 10 жилээс дээшгүй хугацаагаар хорих, нэхэмжилсэн, хүлээж авсан, авахаар тохиролцсон мөнгө, үнэт зүйлсийн мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох ял онооно. 255.2: Хээл хахууль өгсөн болон өгөхөд зуучилсан этгээдэд дээрхтэй адил ял онооно. 256 зүйл: Хэрэв авсан хээл хахууль авсан нь тухайн хээл хахуульд оноох ялаас хэтэрсэн ял бүхий гэмт хэргийг хаацайлах зорилготой байвал хээл хахууль авагч, өгөгч болон зуучлагчид хээл хахуулийн гэмт хэрэгт оноогдох мөнгөн торгуулиас гадна тухайн гэмт хэрэгт оноогдох ялыг давхардуулан онооно.
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Өөрийн үүрэгт ажлаа хийсэн түүнчлэн, хийхээс түдгэлзсэний төлөө эсвэл дээрх үүргээ зөрчсөний төлөө өөрийн болон бусдын нэрийн өмнөөс ямар нэгэн хэлбэрээр мөнгө, бараа болон бусад орлого нэхэмжилсэн мөн дээрх зорилгоор бэлэг, үнэ бүхий зүйл хүлээн авсан, авахаар тохиролцсон
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх хүндрүүлэх үндэслэл	
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	
Гэмт хэргийн субъект	-Төрийн албанд ажилладаг ямар ч албан хаагч
Оногдуулах ялын хэмжээ	-2 жилээс доошгүй 10 жилээс дээшгүй хугацаагаар хорих, - нэхэмжилсэн, хүлээж авсан, авахаар тохиролцсон мөнгө, үнэт зүйлсийн мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох -Мөн хээл хахуулийн гэмт хэрэгт оноогдох мөнгөн торгуулиас гадна тухайн гэмт хэрэгт оноогдох ялыг давхардуулан онооно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

7 УЗБЕКСТАН	
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /1994-09-22 No. 2012-XII/ /Criminal code of the Republic of Uzbekistan/	ТАВДУГААР ХЭСЭГ. Захиргааны байгууллагууд, Олон нийтийн холбоод, төрийн эрх бүхий байгууллагын засаглалын журмын эсрэг гэмт хэрэг. БҮЛЭГ 15. Засаглалын журмын эсрэг гэмт хэрэг 210 зүйл. Хээл хахууль авах Хээл хахууль авах, Өөрөөр хэлбэл, аливаа албан хаагч өөрийн албан үүрэгтэй холбоотой тодорхой ажил үйлдэл гүйцэтгэсэнийхээ төлөө хууль бус замаар, өөрийн биеэр эсвэл ямар нэгэн зуучаар дамжуулан бодит үнэт зүйлс хүлээн авсан, эсхүл өөрийн албан үүрэгтэй холбоотой гүйцэтгэх ёстой ажил үүргээ гүйцэтгээгүйн төлөө мөнгө санхүүгийн ашиг олсон, эзэмшсэн, энэхүү үйлдэл нь дээрх зүйлсийг өгч буй этгээдийн сонирхолд нийцсэн үйлдлийг үйлдсэн бол - 150 сарын цалингийн доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгуулиас эхлэн 5 жил хүртэл хорих ял оноох мөн зарим эрхийг хасах хүртэл арга хэмжээ авна. Хээл хахууль авсан нь: а) Давтан, рецидив гэмт хэрэгтэн эсхүл урьд өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан этгээдээс удаа дараалан энэ хуулийн 211, 212-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. б) Их хэмжээгээр, в) Айлган сүрдүүлэх замаар, д) Хэсэг бүлэг албан хаагч нийлэн өмнө нь хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр авлига авсан бол, 5-10 жилийн хугацаагаар хорино. Хээл хахууль авсан нь: а) Онц их хэмжээгээр, б) Эрх мэдэл бүхий албан тушаалтан үйлдсэн, в) Зохион байгуулалттай бүлэглэлийн ашиг сонирхлын үүднээс авлига хүлээн авсан бол, 10-15 жилийн хорих ял тус тус онооно. /нэмэлт өөрчлөлт орсон 29.08.2001/
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Өөрийн албан үүрэгтэй холбоотой: -Тодорхой ажил үйлдэл гүйцэтгэсэн, түүнийхээ төлөө хууль бус замаар, өөрийн биеэр эсвэл ямар нэгэн зуучаар дамжуулан бодит үнэт зүйлс хүлээн авсан, -Хахуул өгөгчийн хүсэлд нийцүүлэн өөрийн албан үүрэгтэй холбоотой гүйцэтгэх ёстой ажил үүргээ гүйцэтгээгүйн төлөө /эс үйлдэл/ мөнгө санхүүгийн ашиг олсон, эзэмшсэн, /Үйлдэл эс үйлдэхүйгээр илэрнэ/
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх хүндрүүлэх үндэслэл	
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	а) Давтан, рецидив гэмт хэрэгтэн эсхүл урьд өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан этгээдээс удаа дараалан, б) Их хэмжээгээр, в) Айлган сүрдүүлэх замаар, д) Хэсэг бүлэг албан хаагч нийлэн өмнө нь хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр авлига авсан бол, Хээл хахууль авсан нь: а) Онц их хэмжээгээр, б) Эрх мэдэл бүхий албан тушаалтан үйлдсэн, в) Зохион байгуулалттай бүлэглэлийн ашиг сонирхлын үүднээс авлига хүлээн авсан бол,

Гэмт хэргийн субъект	-Захиргааны байгууллагууд -Олон нийтийн холбоод -Төрийн эрх бүхий байгууллагын албан тушаалтан
Оногдуулах ялын хэмжээ	-150 сарын цалингийн доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгуулиас эхлэн 5 жил хүртэл хорих ял оноох мөн зарим эрхийг хасах хүртэл арга хэмжээ авна. -5-10 жилийн хугацаагаар хорино. -10-15 жилийн хорих ял тус тус онооно.

8 БНХАУ	
Авлига хээл хахуулийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж	БНХАУ-ын Эрүүгийн хууль -Criminal Law of the People's Republic of China (1997) БНХАУ-ын эрүүгийн хуулийн 8-р бүлгийн 385-396-р зүйлүүдэд хээл хахуулийн гэмт хэргийн талаар заасан байдаг. ¹¹
Хээл хахууль авах гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан байдал /зүйл заалт/	Хээл хахууль авах гэмт хэргийг үйлдсэн бол 5 хүртэл хорино. Хэрэв төрийн ашиг сонирхолд харшаар нөлөөлж хүнд хор уршиг учруулсан бол 5-10 жил хүртэл хугацаагаар хорино. Хэрэв хэргийн нөхцөл байдал нь хүнд бол эд хөрөнгийг нь хураана Хэн нэгэн этгээд хууль бус аргаар ашиг хонжоо олохын тулд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, компани, олон нийтийн байгууллагад эдийн засгийн үйл ажиллагаагаар дарамт үзүүлсэн бол 3 жил хүртэлх хугацаагаар хорих буюу баривчлах ял шийтгэнэ. Төрийн бүх албан хаагч нь өөрийн явуулж буй хууль ёсны үйл ажиллагааныхаа орлогын талаар тайлан тавина. Тэгээгүй тохиолдолд орлогоо нуун дарагдуулсан гэж үзэн 5 жил хүртэл хугацаагаар хорьж, бүх орлогыг улсын мэдэлд шилжүүлнэ. Төрийн дээд байгууллага нь хувь хүний болон аж ахуйн нэгж, пүүс, компаний нууцыг бусдад задруулсан болон хувийн зориулалтаар ашигласан тохиолдолд 3 жил хүртэл хугацаагаар шоронд хорих буюу ногдуулсан торгууль төлнө. Мөн энэ үйлдэл дээр нөхцөл байдал нь хүндэрсэн тохиолдолд 3-7 жилийн хүртэл ял эдэлнэ.
Хээл хахууль авах гэмт хэргийн илрэх хэлбэр	Төрийн албан хаагч нь өөрийн эрх мэдлээ ашиглан хууль бус үйл ажиллагаанд оролцон хэн нэгнээс мөнгө авсан тохиолдолд түүнийг хахууль авсан гэж үзнэ.
Хээл хахууль авах гэмт хэргийг хөнгөрүүлэх үндэслэл	Хээл хахууль авсан этгээд нь гэмт хэрэг үйлдсэнээ сайн дураараа илчилж ирсэн бол ялын хэмжээг бууруулах буюу чөлөөлнө
Уг гэмт хэргийг хүндрүүлэх үндэслэл	
Гэмт хэргийн субъект	- Төрийн бүх албан хаагч

Оногдуулах ялын хэмжээ	<p>383-р заалтад Хээл хахуулийн хэрэгт оноох ял шийтгэлийн талаар хуульчилсан байдаг.¹²</p> <p>Хээл хахуулийн гэмт хэрэг үйлдсэн хүнд тухайн хэргийн хөнгөнөөс нь хамаарч доор заасан ял шийтгэлээр шийтгэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн хүний хээл хахуулийн хэмжээ ₮100000 –аас илүү гарвал, 10 жил шоронд хорих эсвэл бүх насаар нь шоронд хорих болон хөрөнгийг нь хураан авч улсын санд шилжүүлнэ. Хүндрүүлэх нөхцөл байдалд цаазаар авах ял оноох ба хөрөнгийг нь хураан авч улсын санд шилжүүлнэ. 2. Тухайн хүний хээл хахуулийн хэмжээ ₮50000-аас их ₮100000 –аас бага бол, тухайн хүнийг 5 жил шоронд хорих болон хөрөнгийг нь хураан авч улсын санд шилжүүлнэ. Хүндрүүлэх нөхцөл байдалд бүх насаар нь шоронд хорих болон хөрөнгийг нь хураан авч улсын санд шилжүүлнэ. 3. Тухайн хүний хээл хахуулийн хэмжээ ₮5000-аас их ₮50000 –аас бага бол, тухайн хүнийг 1 жилээс их 7 жилээс бага хугацаагаар шоронд хорино. Хүндрүүлэх нөхцөл байдалд 7 жилээс их 10 жилээс бага хугацаагаар шоронд хорино. Тухайн хүний хээл хахуулийн хэмжээ ₮5000-аас их ₮10000 –аас бага бөгөөд, гэмт хэрэг үйлдсэн сайн дураараа илчлэн ирсэн тохиолдолд ялыг хөнгөрүүлэн үзэх бөгөөд ялаас чөлөөлж болно. Гэхдээ тухайн хүний ажилладаг байгууллага эсвэл дээд шатны байгууллагаас захиргааны шийтгэл өгч болно. 4. Тухайн хүний хээл хахуулийн хэмжээ 5000–аас бага бол, байдал хүнд тохиолдолд, 2 жилээс доош хугацаагаар шоронд хорих эсвэл тухайн хүний ажилладаг байгууллага эсвэл дээд шатны байгууллагаас захиргааны шийтгэл өгч болно.
------------------------	---

(Footnotes)

1. <http://www.legislation.govt.nz/act>
2. <http://www.legislation.govt.nz/act/public/1961> http://www.aseanhrmech.org/downloads/singapore-Prevention_of_Corruption_Act.pdf
3. http://www.aseanhrmech.org/downloads/singapore-Prevention_of_Corruption_Act.pdf
4. <http://www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039.pdf>
5. <http://statutes.agc.gov.sg/aol>
6. Авилгын эсрэг хуулийн 2-р зүйлд заасан
7. <http://www.yandex.ru.com>
8. Criminal Law.Russian Article 291
9. http://www.consultant.ru/popular/ukrf/10_41.html#p4840
10. Узбекстан улс нь 2010 оны 9 сарл “Авлигатай тэмцэх Үндэсний Хөтөлбөр”-ийн төслийг эцэслэн Яамдууд болон Олон нийтийн байгууллагын саналыг авахаар явуулсан тухай мэдээлэл байна. <http://www.oecd.org/dataoecd/39/26/46822261.pdf>
11. <http://www.lehmanlaw.com/resource-centre/laws-and-regulations/criminal-law/criminal-law-of-the-peoples-republic-of-china-1997-page5.html>
12. <http://www.baliprocess.net/Files/Legislation/A-C/ChinaCriminalLaw.pdf>



ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫГ ЦУЦЛАХ, БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Б. Буяндэлгэр, Г. Алтан - Оч (Ph.D), П. Амаржаргал, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, О. Нарантуяа, Б. Хатантуул, А. Пагма

Парламентын гишүүдийн халдашгүй байдлыг цуцлах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудлыг гадаад орнуудын Үндсэн хууль, бусад хуулинд хэрхэн зохицуулсан талаарх харьцуулсан судалгааг УИХ-ын гишүүн Сундуйн Батболдын захиалгаар гүйцэтгэлээ.

Судалгаанд АНУ, Испани /судлаач Б.Хатантуул/, Австрали,Бельги /Ц.Болормаа /, Герман /Г.Алтан-Оч/, Дани, Хятад /Г.Гэрэл/, Ирланд, Франц /Г.Билгээ/, Литва, Эстони /А.Пагма/, ОХУ /Б.Буяндэлгэр/, Солонгос /О.Нарантуяа/, Япон /П.Амаржаргал/ зэрэг орнуудыг хамруулсан бөгөөд эдгээр орнуудын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалтыг эх хэлнээс нь албан бусаар орчуулж, зарим тодруулгын хамт хүснэгтээр харьцуулан үзүүллээ.

Парламентын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийг хөндөх асуудлаарх гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтын нийтлэг болон онцлог талууд

XVIII-XIX зуунд парламентат ёс нь хаант засаглалтай өрсөлдөн эмцэж байх үедээ парламентын гишүүдийн халдашгүй дархан эрхийг баталгаажуулсан билээ. Өнөөдөр дэлхийн ихэнх оронд парламентын гишүүнийг гэмт хэргийн газар дээр нь саатуулаагүй бол түүнийг баривчилж хорих эрх хэнд ч байдаггүй бөгөөд парламентын зөвшөөрөлгүйгээр тухайн гишүүний эсрэг хэрэг үүсгэхийг хориглодог. Өөрөөр хэлбэл, парламентын гишүүний халдашгүй байдал гэдэг нь улс орнуудын нийтлэг жишгээр парламентын зөвшөөрөлгүйгээр тухайн гишүүний эсрэг иргэний болон эрүүгийн, захиргааны хэрэг өдөөж болохгүй байх зарчмаар илэрхийлэгддэг бөгөөд энэ нь парламентын гишүүний халдашгүй эрхийн талаар дэлхийн улс орнуудад үйлчилдэг нийтлэг эрх зүйн ойлголт юм.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд иргэний “халдашгүй эрх чөлөөтэй байх” гэдэг нь өргөн хүрээгээр авч үзвэл хүний хувийн чөлөөт байдал, эд хөрөнгө, орон сууц, захидал харилцааны нууцад хуульд заасан журмаас гадуур хэн ч халдахгүй байхаар тайлбарладаг.

НҮБ-ын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 оны Эрүү шүүлт болон бусад харгис, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэлийн эсрэг олон улсын гэрээ, бичгүүд, 1966 оны Иргэний болон улс төрийн тухай Пакт зэрэгт хуульчлан заасны дагуу хууль бусаар нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглохыг ойлгодог. Энэ ойлголт нь ийнхүү олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн халдашгүй байдлын ойлголт болж байна. Парламентын гишүүний халдашгүй эрхийн баталгааг илэрхийлэх үндсэн хоёр ойлголт байдаг. Эдгээр ойлголт нь нэр томъёоны хувьд: Immunity болон Indemnity гэсэн хоёр үгээр илэрхийлэгднэ.

Нэгдүгээрт: Immunity нь нийтийн эрх зүйн хэм хэмжээний үйлчлэлээс эрх зүйн тодорхой хүрээний субъектийг чөлөөлөх агуулга бүхий ерөнхий нэр томъёо юм. “ИММУНИТЕТ” буюу Парламентын гишүүний халдашгүй эрхийн батлагааг илэрхийлэх дээрх ойлголтын хувьд дэлхийн улс орон харьцангуй ялгамжтай хэлбэрээр зохицуулдаг. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийг нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд иммунитет тогтоосон 42 улс байдаг

бөгөөд эдгээрийн тоонд Монгол Улс багтна. Монгол улсын Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгааг хуульчлан тогтоож, түүний халдашгүй байдал, нэр төр, алдар хүндийг хамгаалах эрх зүйн үндсийг тогтоожээ. Парламентын гишүүний халдашгүй эрхийн үргэлжлэх хугацаа, орон зай нь улс оронд харилцан адилгүй байна.

- ХБНГУ-д парламентын гишүүний халдашгүй эрх Бундестаг ба Бундесратын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох хүртэл үргэлжилж байхад Япон Улсад чуулганы үед, Норвеги Улсад парламентын танхимд байх үед гишүүний халдашгүй эрх хүчин төгөлдөр байх харилцан адилгүй зохицуулалттай байдаг.
- Японд гэмт хэрэгт сэжиглэгдэн цагдан хоригдож байгаа парламентын гишүүн чуулганы үед түр суллагдаж хуралдаандаа суудаг.
- Германд парламентын гишүүнийг гэмт хэргийн газарт болон гэмт хэрэг үйлдсэн өдрийн маргааш нь парламентын зөвшөөрөлгүйгээр баривчилж болно.
- АНУ-ын Үндсэн хуулиар конгрессийн гишүүнийг урван тэрслэх, хүнд гэмт хэрэг үйлдэх болон энх тайвны эсрэг үйлдлээс бусад тохиолдолд танхимынхаа чуулганд хуралдаж байх хугацаанд болон чуулганд ирэх, буцах үед баривчилж болохгүй.
- Англид парламентын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, баривчлахад зөвхөн Спикерийн зөвшөөрөл байхад хангалттай.
- Австралид парламентын гишүүн нь парламентын чуулганы хугацаанд болон уг хугацаа эхлэхээс 5 хоногийн өмнө, мөн дууссанаас хойш 5 хоногийн хугацаанд халдашгүй эрхтэй байдаг.
- Харин Энэтхэг, Канадад чуулганы үед болон түүний өмнө, хойнох 40 хоногийн хугацаанд парламентын гишүүний халдашгүй байдал хадгалагдана.
- Бельгийн Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд гишүүний халдашгүй байдлын гол агуулга болсон “flagrante delicto” буюу гэмт үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд эрүүгийн хэрэгт татагдахгүй байх тухай заалтыг Үндсэн хуулинд аа нилээд дэлгэрэнгүй хуульчилсан байна.
- Литва улсад Сеймийн гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах болон бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах тухай Ерөнхий прокурорын мэдээллийг сонссоны дараа Сеймийн хуралдаан 1-2 цаг завсарласны эцэст гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах, бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах зөвшөөрөл өгөх зорилгоор мөрдөн шалгах комисс байгуулах, эсхүл гишүүний бүрэн эрхийг нь зогсоох үйл явцад бэлтгэх гэсэн 2 шийдвэрийн аль нэгийг гаргадаг. Сеймийн гишүүний бүрэн эрхийг зогсоох асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэр гарсаны дараа Сеймээр хэлэлцдэг.
- Эстонид парламентын гишүүнийг зөвхөн хууль зүйн сайдын танилцуулгын дагуу Рийгикогугийн бүрэлдэхүүний дийлэнхи олонхийн саналаар эрүүгийн хариуцлагад татаж болно.

Хоёрдугаарт: “ИНДЕМНИТЕТ” хэмээх ойлголтын хувьд энэ нэр томъёо парламентын гишүүний эрх зүйн байдалд хоёр утгаар хэрэглэгдэнэ. Нэгдүгээрт: парламентын гишүүн бусдыг доромжлох гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, парламентын бусад шийдвэрийн төсөл, парламентаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй байх гэсэн утгаар, хоёрдугаарт: парламентын гишүүний үйл ажиллагааныхаа төлөө авах цалин хөлс, бусад хангамж (байр, орон сууц, захидал харилцаа, албан томилолтын зардал г.м)-ийг хэлэх бөгөөд тодруулбал парламентын гишүүний “шагналын сан” гэсэн утгаар хэрэглэнэ. Дэлхийн ихэнх орон парламентын гишүүний энэ бүрэн эрхийн баталгааг Үндсэн хуульдаа хуульчлан тогтоосон байдаг.

- АНУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 1 дүгээр заалтад “Сенатч болон төлөөлөгчдийн албан ажлын нөхвөрийг хуулиар тогтоож, Нэгдсэн улсын хөмрөгөөс олгоно. Урван тэрслэх, хүнд гэмт хэрэг үйлдэх болон энх тайвны эсрэг үйлдлээс бусад тохиолдолд танхимынхаа чуулганд хуралдаж байх хугацаанд болон чуулганд ирэх, буцах үед тэднийг баривчилж болохгүй. Тэд Танхимын хуралдаанд үг хэлж, санал шүүмжлэл гаргасныхаа төлөө хаана ч асуугдах /not be questioned in any other Place/ ёсгүй” гэж заажээ.
- Германы Үндсэн хуулийн 3-р бүлгийн 46-р зүйл 1 дэх хэсэгт зааснаар “Өгсөн санал, эсвэл парламент буюу түүний хорооны хуралдааны үеэр хэлсэн үгийнх нь төлөө депутатыг хэзээ ч шүүхийн буюу албаны шугамаар мөрдөж болохгүй, эсвэл гишүүн нь парламентын гадуурх алив нэг хариуцлага хүлээхгүй” ба ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар “Холбооны парламент, Холбооны их хурал буюу Улсын хууль тогтоох байгууллагын гишүүнийг хэзээ ч түүний өгсөн санал, эсвэл чуулганы хуралдаан буюу түүний хороонд хэлсэн үгийнх нь төлөө чуулганы хуралдаанаас гадуур хариуцлагад татахгүй”.
- Франц Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд: “Үндэсний ассамблейн гишүүн нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн болон бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн саналын төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй”,
- БНСУ-ын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд: “Үндэсний чуулганы гишүүн нь чуулганы хуралдаан дээр албан ёсоор хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй”.
- Япон Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд: “Парламентын гишүүн нь бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үгийнхээ төлөө парламентын гадна хариуцлага хүлээхгүй”,
- Чехын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд “Депутат болон Сенатчыг Депутатуудын танхим, Сенат, тэдгээрийн бүтцийн байгууллагуудын хуралдаан дээр хэлсэн үгийнх нь төлөө эрүүгийн хариуцлагад татаж болохгүй”,
- Румын улсын Үндсэн хуулийн 70 дугаар зүйлд “Бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа илэрхийлсэн улс төрийн мэдэгдэл, санал хураалтад өгсөн саналынх нь төлөө депутатууд болон сенатчдад шүүхийн хариуцлага хүлээлгэж болохгүй” гэж тус тус заасан байдаг ажээ.
- Монгол Улсын хувьд УИХ-ын тухай хуулийн 34.3-д “Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй” гэжээ.
- Австрали улс буюу Уэстминистрийн (англо-саксоны) систем бүхий орнуудын хувьд гишүүдийн онцгой эрх /Parliamentary privilege/ нь үг хэлэх эрх чөлөө буюу хэлсэн үгийнхээ төлөө хариуцлагад татагдахгүй байх хамгаалалтыг хуулиар тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, Парламентын болон байнгын хороодын хуралдааны үеэр чуулган дээр хэлсэн үг, өгсөн саналынхаа төлөө хариуцлага хүлээхгүй байх хуулийн хамгаалалт юм. Австралийн хувьд энэхүү онцгой эрх нь зөвхөн парламентын чуулганы үед хүчин төгөлдөр байдаг.

Дээрхээс харахад парламентын гишүүн улс төрийн байр суурь, үзэл баримтлал, сонгогчдын эрх ашиг, итгэл үнэмшил, улс орны хөгжил дэвшлийн төлөө өөрийн үзэл бодлоо илэрхийлж үг хэлэх нь зүй ёсны хэрэг бөгөөд энэ тохиолдолд парламентын гишүүн хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй байх тухай ойлголт буюу хуулийн хүрээнд хэрэгжих ёстой эрх юм.

Энэхүү эрх чөлөөг эдлэх явдал нь үүрэг хариуцлагатай хамтдаа хэрэгжих бөгөөд бусдын нэр төр болон эрхийг хамгаалах буюу нууц мэдээллийг задруулахаас сэргийлэх зэрэг зорилгоор гаргасан журам болон хязгаарлалтад захирагдана. Өөрийн үзэл бодолтой байх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарладаг. Хэрвээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг хэтрүүлэн хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох буюу гүтгэвэл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээх юм.

Эндээс харахад парламентын гишүүний индемнитет эрх нь бусдын нэр, төр, алдар хүндтэй байх эрхээр хязгаарлагддаг нэгэнт тогтсон ойлголт болох нь харагдаж байгаа бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нэр төрийг хамгаалах хэрэгцээ хоёр зохистой тэнцвэрт байдлаар хангагддаг буюу нэг эрх нөгөө эрхээр хязгаарлагддаг ажээ.

Эцэст нь аль ч орны парламентын гишүүн нь хууль тогтоомж болон олон улсын зарчмаар хүлээн зөвшөөрөгдсөн ардчилсан парламентын гол шинж болох халдашгүй байдал, бүрэн эрхийн баталгааг эдлэх боловч үндсэн эрхийн тодорхой хэм хэмжээ хязгаарлалт, хууль тогтоомжид захирагдах нь хүний эрх, хууль дээдэлсэн, ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийн зүй ёсны шаардлага юм.

ХҮСНЭГТ

Улсын болон эрх зүйн актын нэр, огноо, эх сурвалж	Тухайн асуудалд холбогдох зүйл, заалт /эх хэл дээр/	Зүйл, заалтын албан бус орчуулга	Тодруулга
---	---	----------------------------------	-----------

1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Үндсэн Хууль /1787-12-07/ The Constitution of the United States of America http://pdpa.georgetown.edu	Article I Section 6 Clause 1: The Senators and Representatives shall receive a Compensation for their Services, to be ascertained by Law, and paid out of the Treasury of the United States. They shall in all Cases, except Treason, Felony and Breach of the Peace, be privileged from Arrest during their Attendance at the Session of their respective Houses, and in going to and returning from the same; and for any Speech or Debate in either House, they shall not be questioned in any other Place.	1 дүгээр зүйл 6 дугаар хэсэг 1 дүгээр нөхцөл: Сенатч болон Төлөөлөгчдийн албан ажлын нөхвөрийг хуулиар тогтоож нэгдсэн Улсын хөмрөгөөс олгоно. Урван тэрслэх, хүнд гэмт хэрэг үйлдэх болон нийгмийн хэв журам зөрчсөнөөс өөр бусад тохиолдолд танхимынхаа чуулган хуралдаж байх хугацаанд болон Чуулганд ирэх, явах үед тэднийг баривчилж үл болно. Тэднийг Танхимын хуралдаанд үг хэлж, санал шүүмжлэл гаргасны төлөө хаана ч байцааж болохгүй.	
--	--	--	--

2. АВСТРАЛИ

<p>Австралийн хамтын нөхөрлөлийн Үндсэн хууль 1900-07-09</p> <p>/Commonwealth of Australia Constitution act /</p> <p>http://www.apf.gov.au/senate/general/constitution/index.htm</p>	<p>Privileges, &c. of Houses.</p> <p>49. The powers, privileges, and immunities of the Senate and of the House of Representatives, and of the members and the committees of each House, shall be such as are declared by the Parliament, and until declared shall be those of the Commons House of Parliament of the United Kingdom, and of its members and committees, at the establishment of the Commonwealth.</p>	<p>Танхимуудын гишүүдийн онцгой эрх</p> <p>49. Сенат болон Төлөөлөгчдийн танхим, Байнгын хороодын гишүүдийн бүрэн эрх, онцгой эрх, халдашгүй байдлыг Парламент тогтооно.</p> <p>Австралийн Парламентаас гишүүдийн онцгой эрх, халдашгүй байдлыг тогтоох хүртэл тус улсын парламентын гишүүд Их Британи улсын Төлөөлөгчдийн танхим, түүний байнгын хороодын гишүүдийн нэгэн адил онцгой эрх, халдашгүй байдалтай байна.</p>	<p>Австрали улс буюу Уэстминистрийн (англо-саксоны) систем бүхий орнуудын хувьд гишүүдийн онцгой эрх /Parliamentary privilege/ нь үг хэлэх эрх чөлөө буюу хэлсэн үгийгээ төлөө хариуцлагад татагдахгүй байх хамгаалалтыг хуулиар тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, Парламентын болон байнгын хороодын хуралдааны үеэр чуулган дээр хэлсэн үг, өгсөн саналынхаа төлөө хариуцлага хүлээхгүй байх хуулийн хамгаалалт юм. Австралийн хувьд энэхүү онцгой эрх нь зөвхөн парламентын чуулганы үед хүчин төгөлдөр байдаг. Харин parliamentary immunity буюу халдашгүй байдлын талаар Үндсэн хуульд тусгайлан зохицуулаагүй байна. Энэ 2 баримт бичгээс гадна 1988 оны 2 сарын 22нд Сенатаас "Парламентын гишүүний онцгой эрхийн тухай тогтоол" баталсан бөгөөд тус тогтоолоор гэрчийг хамгаалах талаар голчлон зохицуулсан байна.</p>
<p>Парламентын гишүүний онцгой эрхийн тухай хууль 1987</p> <p>/Parliamentary Privileges act 1987/</p> <p>http://www.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/ppa1987273.txt</p>	<p>Section 14 Immunities from arrest and attendance before courts</p> <p>(1) A member:</p> <p>(a) must not be required to attend before a court or tribunal, and</p> <p>(b) must not be arrested or detained in a civil cause, on any day on which a House or committee of which that member is a member meets or within a day which is 5 days before or after a day on which that House or Committee meets.</p>	<p>14-р хэсэг: Баривчлагдах болон шүүхэд дуудагдах, шүүх хуралд оролцохоос хамгаалуулах халдашгүй байдал</p> <p>1. Гишүүн нь парламентын чуулганы хугацаанд болон уг хугацаа эхлэхээс 5 хоногийн өмнө, түүнчлэн дууссанаас 5 хоногийн дараах хугацааны туршид дараах халдашгүй байдалтай байна. Үүнд:</p> <p>a) Тухайн гишүүнийг шүүхэд дуудахгүй байх, мэдүүлэг авахаар хуулийн байгууллагад дуудахгүй байх</p> <p>b) Иргэний хэрэгтэй холбогдуулан баривчлан саатуулахгүй байх халдашгүй байдалтай.</p>	

3. БЕЛЬГИ

<p>Үндсэн хууль, 1994-02-14, /Belgium Constitution/, 14 February 1994 http://home.scarlet.be/dirkvanheule/compos/ConstitutionBelgium/ConstitutionBelgium.htm</p>	<p>Article. 59 Except in the case of flagrante delicto, no member of any Chamber may, during a session, be directly remanded or summoned before a court or tribunal regarding repressive matters nor be arrested except with the authorisation of the Chamber of which he is a member. Except in the case of flagrante delicto, restraining measures requiring the intervention of a judge cannot be instituted against a member of any Chamber for the duration of a session, regarding repressive matters, except by the first President of the Court of Appeal at the demand of the competent judge. This decision is communicated to the President of the concerned Chamber. All searches or seizures executed by virtue of the clause above can be performed only in the presence of the President of the Chamber concerned or a member appointed by him. During the session, only the officers of the public prosecutor's department and competent officers may institute repressive proceedings against a member of any Chamber. The member of any Chamber in question may at all stages of the investigations regarding repressive measures, request for the duration of the session that the Chamber of whom he is a member suspend the proceedings. The Chamber in question must grant this request if supported by a majority of two-thirds of the votes given. Detention of a member of any Chamber or his investigation by a court or Tribunal is suspended for the duration of the session if the Chamber of whom he is a member so requests.</p>	<p>59-р зүйл Гэмт үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд чуулган үргэлжлэх хугацаанд Танхимын зөвшөөрөлгүйгээр Танхимын гишүүнийг шүүхэд дуудах, мэдүүлэг авахаар дуудах, хорих болон баривчилж болохгүй. Үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд чуулганы үеэр Танхимын гишүүний эсрэг ямар нэгэн шүүгчийн оролцоо шаардагдах аливаа хориг, хязгаар бүхий арга хэмжээ авч болохгүй. Ийм арга хэмжээг зөвхөн эрх бүхий шүүгчийн шаардлагыг үндэслэн Давж заалдах шатны шүүхийн тэргүүн авах эрхтэй. Энэ тухай холбогдох Танхимын ерөнхийлөгчид (парламентын дарга) мэдэгдэх ёстой. Дээрх арга хэмжээтэй холбогдуулан хийх бүх нэгжлэг, гишүүний эд зүйлсийг хураах бол зөвхөн Танхимын дарга буюу түүний томилсон хүнийг байлцуулан хийнэ. Чуулганы хугацаанд аль ч Танхимын гишүүний эсрэг арга хэмжээг зөвхөн Улсын прокурор буюу түүнтэй адилтгахуйц төрийн албан хаагч тогтоож болно. Чуулганы хугацаанд тухайн гишүүн нь дээрх арга хэмжээтэй холбоотой шалгалт, мөрдөн байцаалтын аль ч үе шатанд Танхимд хандан уг үйл ажиллагааг түр зогсоохыг хүссэн хүсэлт гаргаж болно. Гишүүдийн гуравны хоёрын /олонхийн/ дэмжлэгийг авбал дээрх хүсэлтийг Танхим хүлээн авна. Чуулганы хугацаанд хэрвээ тухайн гишүүн хүсэлт гаргавал түүнд холбогдох шүүхийн шалгалтыг түр зогсооно.</p>	<p>Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд "freedom of speech" буюу "үг хэлэх эрх чөлөө"-ний талаар зохицуулалт орсон байна. Харин 59 дүгээр зүйлд гишүүний халдашгүй байдлын /parliamentary immunity/ гол агуулга болсон "flagrante delicto" буюу гэмт үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд эрүүгийн хэрэгт татагдахгүй байх тухай заалтыг Үндсэн хуулиндаа нилээд дэлгэрэнгүй хуульчилсан бөгөөд Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг буюу "The Rules of the Procedure of the Belgian House of Representatives"-ийн 93 дугаар зүйлд Танхимын гишүүнийг хэрэгт холбогдсон талаар эрх бүхий этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд хэрхэн хэлэлцэх процедурыг тусгасан бөгөөд Сенатын хуралдааны дэгд ижил байдлаар тусгагдсан байдаг байна.</p>
--	---	--	---

4. GERMAN

<p>Үндсэн хууль, 3-р бүлэг. Бундестаг (Холбооны парламент), 46-р зүйл. http://bundesrecht.juris.de/gg/art_46.html</p>	<p>Art 46</p> <p>(1) Ein Abgeordneter darf zu keiner Zeit wegen seiner Abstimmung oder wegen einer DuЯerung, die er im Bundestage oder in einem seiner Ausschüsse getan hat, gerichtlich oder dienstlich verfolgt oder sonst außerhalb des Bundestages zur Verantwortung gezogen werden. Dies gilt nicht für verleumderische Beleidigungen.</p> <p>(2) Wegen einer mit Strafe bedrohten Handlung darf ein Abgeordneter nur mit Genehmigung des Bundestages zur Verantwortung gezogen oder verhaftet werden, es sei denn, daß er bei Begehung der Tat oder im Laufe des folgenden Tages festgenommen wird.</p> <p>(3) Die Genehmigung des Bundestages ist ferner bei jeder anderen Beschränkung der persönlichen Freiheit eines Abgeordneten oder zur Einleitung eines Verfahrens gegen einen Abgeordneten gemäß Artikel 18 erforderlich.</p> <p>(4) Jedes Strafverfahren und jedes Verfahren gemäß Artikel 18 gegen einen Abgeordneten, jede Haft und jede sonstige Beschränkung seiner persönlichen Freiheit sind auf Verlangen des Bundestages auszusetzen.</p>	<p>1 дэх хэсэг. Холбооны парламентын чуулган буюу түүний хорооны хуралдааны үеэр өгсөн санал, эсвэл хэлсэн үгийнх нь төлөө депутатыг хэзээ ч шүүхийн буюу албаны шугамаар мөрдөж болохгүй, мөн депутатад парламентын гадуурх алив нэг хариуцлага хүлээлгэхгүй. Энэ нь гүтгэн доромжлоход хамаарахгүй.</p> <p>2 дахь хэсэг. Гэмт хэргийн үйлдэл дээрээ буюу дараагийн өдрийн туршид баривчлагдсан байсан ч гэмт хэрэг хийсэнтэй нь холбогдуулан зөвхөн холбооны парламентын зөвшөөрөлтэйгээр депутатад хариуцлага тооцох буюу депутатыг хорьж болно.</p>	<p>Цаашилбал, “3 дахь хэсэгт, Түүнээс гадна депутатын хувийн эрх чөлөөг ямар нэгэн байдлаар хязгаарлах буюу депутатад хэрэг холбогдуулахад холбооны парламентын зөвшөөрлийг авна. 4 дэх хэсэгт, Депутатын эсрэг аливаа эрүүгийн болон иргэний хэрэг үүсгэх, аливаа эрхийг хорих, болон түүний хувийн эрх чөлөөг хязгаарлах аливаа үйлдлийг холбооны парламентын шаардсанаар гүйцэтгэнэ.” гэж парламентын гишүүний бүрэн эрхэд ямар тохиолдолд халдаж болохыг илүү нарийвчлан тодотгосон байна.</p>
<p>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2-р бүлэг. Үйлдэл. 5 дахь дэд бүлэг. Парламентэд хэлсэн үг болон парламентийн тайлан илтгэлд ял оноохгүй байх. 36-р зүйл. Парламентад хэлсэн үг.</p>	<p>§ 36 Parlamentarische DuЯerungen Mitglieder des Bundestages, der Bundesversammlung oder eines Gesetzgebungsorgans eines Landes dürfen zu keiner Zeit wegen ihrer Abstimmung oder wegen einer DuЯerung, die sie in der Körperschaft oder in einem ihrer Ausschüsse getan haben, außerhalb der Körperschaft zur Verantwortung gezogen werden. Dies gilt nicht für verleumderische Beleidigungen.</p> <p>http://bundesrecht.juris.de/stgb/_36.html</p>	<p>Бундестар (Холбооны парламент), Холбооны их хурал буюу Улсын хууль тогтоох байгууллагын гишүүнийг хэзээ ч чуулганы хуралдаан буюу түүний хороонд өгсөн санал, эсвэл хэлсэн үгийнх нь төлөө чуулганы хуралдаанаас гадуур хариуцлагад татахгүй. Энэ нь гүтгэн доромжлоход хамаарахгүй.</p>	<p>Улсын болон холбооны түвшний бүх хууль тогтоох байгууллагын гишүүнийг өгсөн санал, хэлсэн үгийнх нь төлөө хариуцлага тооцохгүйгээр халдашгүй эрх олгосон байна.</p>

5. ДАНИ

<p>Үндсэн хууль 1953-06-05 /The Constitutional Act of Denmark of June 5, 1953/ http://www.ft.dk/English/~media/Pdf_materiale/Pdf_publicationer/English/My%20Constitutional%20Act_with_explanations%20pdf.ashx</p>	<p>Section 57 Without the consent of Parliament, no Member can be charged or subjected to imprisonment of any kind unless he or she is caught red-handed. Without the consent of Parliament, no Member can be held responsible for his or her statements in Parliament outside Parliament.</p>	<p>57 дугаар зүйл Хэрэв гишүүнийг хэргийн газарт үйлдэл дээр нь бариагүй бол Парламентын зөвшөөрөлгүйгээр, гишүүнийг аль ч төрлийн шоронд хорих ялаар хариуцлагад татахгүй эсвэл мөрдөн шалгахгүй. Парламентын зөвшөөрөлгүйгээр, гишүүнийг хэлсэн үгээр нь хуулийн хариуцлага хүлээлгэхгүй.</p>	
<p>Фолкэтиний дэг, 2009 /Standing Orders of Folketing, 2009/ http://www.ft.dk/~media/Pdf_materiale/Pdf_publicationer/English/Standing_Orders_of_the_Folketing%20pdf.ashx</p>	<p>17(2) Recommendations made by committees concerning petitions, including petitions for consent in accordance with Section 57 of the Constitutional Act (cf. Section 25), are read once and the time limits are the same as for second readings of Bills. The same applies to recommendations which take the form of a report from the Scrutineers' Committee (cf. Section 8a (5)). The Ombudsman of the Folketing is appointed during a meeting without a debate. This meeting shall take place not earlier than two days after the recommendation on the appointment made by the Legal Affairs Committee has been published on one of the Folketing web sites.</p>	<p>17-2 дугаар зүйл Үндсэн хуулийн 57-р заалтанд заасан зөвшөөрөл авах хүсэлт зэрэг Хорооноос гаргасан санал хүсэлтийг Парламентаар нэг удаа хэлэлцэх ба хэлэлцэх хугацаа нь хуулийн төслийн хоёр дахь удаагийн хэлэлцүүлгийн хугацаатай ижил байна. Хяналтын хорооны /Scrutineers' Committee/ саналтай ижил хүсэлт гаргана. Фолкэтиний Омбудсманыг /The Ombudsman of the Folketing/ хуралд оролцуулна (хэлэлцүүлэгт оролцолгүйгээр). Энэхүү хурлын хугацааг товлохдоо Хуулийн хэргийн хорооноос /Legal Affairs Committee/ гаргасан хүсэлтийг Фолкэтиний аль нэг вэбсайт дээр хэвлэн гаргасан цагаас хойш хоёр өдрөөс эртгүй байна.</p>	

6. ИРЛАНД

<p>Үндсэн хууль 1937 он., 15-р зүйл., Constitution of Ireland</p>	<p>Article 15. 13. The members of each House of the Oireachtas shall, except in case of treason as defined in this Constitution, felony or breach of the peace, be privileged from arrest in going to and returning from, and while within the precincts of, either House, and shall not, in respect of any utterance in either House, be amenable to any court or any authority other than the House itself.</p>	<p>15-р зүйл. 13. Oireachtas-ийн аль ч Танхимын гишүүд энэхүү Үндсэн хуульд заасныг өөрчлөхөөс бусад тохиолдолд дараах онцгой эрхийг эдэлнэ: эрүүгийн хэрэг, эсхүл нийтийн хэв журмыг зөрчсөн тохиолдолд баривчлагдахгүй байх, түүнчлэн урьдчилан мэдэгдэлгүйгээр аль ч шүүх, эсхүл Танхимаас өөр эрх бүхий байгууллагын өмнө хуулийн хариуцлага хүлээлгэхгүй.</p>	
<p>Парламентын танхимуудын хороод (онцгой эрх, дэг)-ын тухай хууль, 1976 он. Committees Of The Houses Of The Oireachtas (Privilege And Procedure) Act, 1976 http://achtanna.oireachtas.ie</p>	<p>2. —(1) A member of either House of the Oireachtas shall not, in respect of any utterance in or before a committee, be amenable to any court or any authority other than the House or the Houses of the Oireachtas by which the committee was appointed.</p>	<p>Oireachtas-ийн аль ч Танхимын гишүүн нь урьдчилан мэдэгдэлгүйгээр Танхим эсвэл Oireachtas-ийн Танхимаас томилогдсон хорооноос бусад аливаа шүүх, эрх бүхий байгууллагын өмнө хуулийн хариуцлага хүлээхгүй.</p>	

7. ИСПАНИЙН ВАНТ УЛС

<p>Үндсэн Хууль8 /1978-12-29/ The Constitution of Spain http://www.servat.unibe.ch/</p>	<p>Title III Parliament Chapter I Chambers Article 71 [Indemnity, Immunity, Remuneration]</p> <p>(1) The Deputies and Senators enjoy indemnity for the opinions expressed during the exercise of their functions. (2) During the period of their mandate, the Deputies and Senators enjoy immunity and may only be arrested in case of flagrante delicto. They may not be indicted or tried without prior authorization of the respective Chamber. (3) In actions against Deputies and Senators, the Criminal Section of the Supreme Court shall be competent. (4) The Deputies and Senators shall receive a remuneration which shall be fixed by the respective Chamber.</p>	<p>Бүлэг III, 1 дүгээр хэсэг, 71 дүгээр зүйл /индемнитет, халдашгүй байдал, урамшуулал/</p> <p>1. Парламентын гишүүд нь бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа бусдыг доромжлох гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, парламентын бусад шийдвэрийн төсөл, парламентаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй байх, 2. Мандатын бүрэн эрхийн хугацаанд Парламентын гишүүн нь халдашгүй дархан эрх эдлэх бөгөөд зөвхөн хэргийн газар дээр баривчилж болно. Гишүүнийг Танхимаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд түүнд хэрэг тулгах болон гэм буруутай гэж мөрдөж болохгүй, 3. Аливаа гишүүний эсрэг үйл хэрэгт Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн хэсэг шаардлагатай арга хэмжээг авахад бэлэн байна, 4. Парламентын гишүүн нь тус тусынхаа Танхимын уламжлалт урамшуулалыг хүртэнэ.</p>	<p>Конгрессын гишүүнийг flagrante delicto буюу зөвхөн хэргийн газар дээр баривчилж болно. Гэхдээ тухайн гишүүнийг тухайн танхимаас урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд түүнд хэрэг тулгах болон гэм буруутай гэж мөрдөж болохгүй.</p>
<p>Конгрессын дотоод журам-20048 Standing order of the Congress-2004 www.congreso.es</p>	<p>Chapter II Parliamentary Privileges Section 11 During the period of their mandate Members shall also enjoy immunity and may only be arrested in cases of flagrante delicto. They may not be indicted or persecuted without previous leave of Congress.</p> <p>Chapter IV Section 21 Suspension and loss of Member status</p> <p>1) A member shall be suspended from his or her parliamentary rights and duties: -Where such suspension is appropriate by application of the rules on parliamentary discipline established herein, -Where the authorization requested by a judicial authority has been granted by the House, and on the basis of a firm order of indictment, the Member is put into preventive detention, such suspension continuing for the duration of the detention. 2) A member shall be suspended in his or her parliamentary rights, privileges and obligations if a judgment of conviction that is final so decrees, or if the execution of judgment entails the impossibility of discharging parliamentary duties.</p> <p>Section 22 A member shall lose his or her status as such owing to the following causes: -by a final judicial decision annulling his or her election or proclamation.</p>	<p>Бүлэг II. Парламентын онцгой эрх 11 дүгээр хэсэг</p> <p>Гишүүн мандатынхаа бүрэн эрхийнхээ хугацаанд халдашгүй дархан эрх эдлэх бөгөөд зөвхөн гэмт хэрэг үйлдэх буюу гэмт ажиллагаа үйлдэхэд бэлтгэх үед баривчилж болно. Конгрессын зөвшөөрөлгүйгээр хэрэг тулгах болон мөрдөж болохгүй.</p> <p>Бүлэг IV 21 дүгээр хэсэг. Гишүүний бүрэн эрхийг түтгэлзүүлэх болон Гишүүний статусаа алдах</p> <p>1. Гишүүнийг дараах тохиолдолд бүрэн эрхээс түтгэлзүүлнэ: -Парламентын дэг журамд хамааралтай үндэслэл, -Шүүх байгууллагын ялласан төлөвлөгөөг Конгресс хүлээн зөвшөөрч урьдчилан саатуулагдаж байгаа гишүүний бүрэн эрхийн саатуулагдаж буй хугацаанд, 2. Гишүүн нь парламентын эрх, онцгой эрх болон үүргээс шүүхийн эцсийн шийдвэр гарсан болон хэрэв шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл нь түүнийг парламентын үүргээс чөлөөлөгдөх нөхцөл үүсгэж байгаа тохиолдолд бүрэн эрхээс түтгэлзүүлнэ.</p> <p>22 дугаар хэсэг Гишүүн дараах тохиолдолд гишүүний статусаа алдана: -Гишүүний сонгуулийг хүчингүй болгосон Шүүхийн эцсийн шийдвэр.</p>	

8. ЛИТВА

Үндсэн хууль 1992.11.02. /Конституция Литовской Республики/	Статья 62 Член Сейма без согласия Сейма не может быть привлечен к уголовной ответственности, арестован, не может быть иным образом ограничена его свобода.	Сеймийн гишүүнийг Сеймийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах болон бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.	
Сеймийн тухай хууль 1994.02.14. /Статут Сейма Литовской республики/	Статья 22. Член Сейма без согласия Сейма не может быть привлечен к уголовной ответственности, подвергнут аресту, не может быть иным способом ограничена его свобода, за исключением случаев, когда его застанут на месте преступления (in flagranti). В таких случаях генеральный прокурор немедленно сообщает об этом Сейму.	Сеймийн гишүүнийг гэмт хэргийн газарт саатуулахаас бусад тохиолдолд Сеймийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах болон бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Гэмт хэргийн газарт саатуулсан тохиолдолд Ерөнхий прокурор нэн даруй Сеймд мэдэгдэнэ.	Сеймийн гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах болон бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах тухай Ерөнхий прокурорын мэдээллийг сонссоны дараа Сеймийн хуралдаан 1-2 цаг завсарласны эцэст гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, баривчлах, бусад байдлаар эрх чөлөөг нь хязгаарлах зөвшөөрөл өгөх зорилгоор мөрдөн шалгах комисс байгуулах, эсхүл гишүүний бүрэн эрхийг нь зогсоох үйл явцад бэлтгэх гэсэн 2 шийдвэрийн аль нэгийг гаргадаг. Сеймийн гишүүний бүрэн эрхийг зогсоох асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэр гарсаны дараа Сеймээр хэлэлцдэг.

9. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-ын Үндсэн хууль, 1993-12-12 /Конституция Российской Федерации 12 декабря 1993 г/	Статья 98 1. Члены Совета Федерации и депутаты Государственной Думы обладают неприкосновенностью в течение всего срока их полномочий. Они не могут быть задержаны, арестованы, подвергнуты обыску, кроме случаев задержания на месте преступления, а также подвергнуты личному досмотру, за исключением случаев, когда это предусмотрено федеральным законом для обеспечения безопасности других людей. 2. Вопрос о лишении неприкосновенности решается по представлению Генерального прокурора Российской Федерации соответствующей палатой Федерального Собрания.	98 дугаар зүйл 1. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатыг гэмт хэргийн газарт саатуулахаас бусад тохиолдолд баривчлах, саатуулах, нэгжих, бусдын аюулгүй байдлыг хангах зорилгоор батлан гаргасан хууль тогтоомжид зааснаас өөр шалтгаанаар биед нь үзлэг хийхийг хориглоно. 2. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатын халдашгүй байдлыг цуцлах асуудлыг ОХУ-ын Ерөнхий прокурорын саналаар холбогдох танхим хэлэлцэн шийдвэрлэнэ.
	ОХУ-д парламентын гишүүнийг хуультогтоомжийн дагуу баривчлах, нэгжих, албадан саатуулах, мөрдөн шалгахдаа зөвхөн түүний халдашгүй байдлыг цуцладаг бөгөөд гишүүний гэм буруутайг тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсны дараа бүрэн эрх нь зогсдог.	

<p>Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатын эрх зүйн байдлын тухай хууль 1994-5-08/О статусе члена Совета Федерации и статусе депутата Государственной Думы федеральный закон от 8 мая 1994 г./</p>	<p>Статья 19. Неприкосновенность члена Совета Федерации, депутата Государственной Думы</p> <p>1. Член Совета Федерации, депутат Государственной Думы обладают неприкосновенностью в течение всего срока своих полномочий</p> <p>2. Член Совета Федерации, депутат Государственной Думы без согласия соответствующей палаты Федерального Собрания Российской Федерации не могут быть:</p> <ul style="list-style-type: none"> • привлечены к уголовной или к административной ответственности, налагаемой в судебном порядке; • задержаны, арестованы, подвергнуты обыску (кроме случаев задержания на месте преступления) или допросу; • подвергнуты личному досмотру, за исключением случаев, когда это предусмотрено федеральным законом для обеспечения безопасности других людей. • 4.В случае возбуждения уголовного дела или начала производства по делу об административном правонарушении, предусматривающем административную ответственность, налагаемую в судебном порядке, в отношении действий члена Совета Федерации, депутата Государственной Думы, орган дознания или следователь в трехдневный срок сообщает об этом Генеральному прокурору Российской Федерации. • Если уголовное дело возбуждено или производство по делу об административном правонарушении, предусматривающем административную ответственность, налагаемую в судебном порядке, начато в отношении действий члена Совета Федерации, депутата Государственной Думы, связанных с осуществлением ими своих полномочий, Генеральный прокурор Российской Федерации в недельный срок после получения сообщения органа дознания или следователя обязан внести в соответствующую палату Федерального Собрания Российской Федерации представление о лишении члена Совета Федерации, депутата Государственной Думы неприкосновенности. • 5. После окончания дознания, предварительного следствия или производства по делу об административном правонарушении, предусматривающем административную ответственность, налагаемую в судебном порядке, дело не может быть передано в суд без согласия соответствующей палаты Федерального Собрания Российской Федерации. • 6. Член Совета Федерации, депутат Государственной Думы не могут быть привлечены к уголовной или административной ответственности за высказывание мнения или выражение позиции при голосовании в соответствующей палате Федерального Собрания Российской Федерации и другие действия, соответствующие статусу члена Совета Федерации и статусу депутата Государственной Думы, в том числе по истечении срока их полномочий. Если в связи с такими действиями член Совета Федерации, депутат Государственной Думы допустили публичные оскорбления, клевету или иные нарушения, ответственность за которые предусмотрена федеральным законом, возбуждение уголовного дела, производство дознания, предварительного следствия или начало производства по делу об административном правонарушении, предусматривающем административную ответственность, налагаемую в судебном порядке, осуществляется только в случае лишения члена Совета Федерации, депутата Государственной Думы неприкосновенности. 	<p>19 дүгээр зүйл Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатын халдашгүй байдал:</p> <p>1. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутат бүрэн эрхийнхээ хугацаанд халдашгүй дархан эрхтэй.</p> <p>2. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатыг:</p> <p>а/ шүүхийн журмаар захиргааны болон эрүүгийн хариуцлагад татах</p> <p>б/ гэмт хэргийн газарт саатуулахаас бусад тохиолдолд баривчлах, саатуулах, нэгжих, байцаах</p> <p>в/ бусдын аюулгүй байдлыг хангах зорилгоор батлан гаргасан хууль тогтоомжид зааснаас өөрөөр биед нь үзлэг хийхийг тус тус хориглоно.</p> <p>...4. Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатад эрүүгийн болон шүүхийн журмаар захиргааны хэрэг үүсгэх тохиолдолд хэрэг бүртгэх байгууллага, эсвэл мөрдөн байцаагч 3 хоногийн дотор ОХУ-ын Ерөнхий прокурорт мэдэгднэ.</p> <p>Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатад эрүүгийн болон шүүхийн журмаар захиргааны хэрэг үүсгэвэл ОХУ-ын Ерөнхий прокурор дээрх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор гишүүний /депутатын/ халдашгүй байдлыг цуцлах саналыг тухайн гишүүний харъяалагдах танхимд танилцуулна.</p> <p>5.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан боловч хэргийг ОХУ-ын Холбооны Хурлын холбогдох танхимын зөвшөөрөлгүйгээр шүүхэд шилжүүлж болохгүй.</p> <p>6. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын депутатыг бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа хэлсэн үг, санал хураалтад өгсөн санал, илэрхийлсэн байр суурь болон эрх хэмжээнийхээ хүрээнд хийсэн бусад үйлдлийнх нь төлөө бүрэн эрхийнх нь хугацаанд болон түүний дараа эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэж болохгүй.</p> <p>Харин бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа байхдаа бусдыг олон нийтийн өмнө доромжилсон, гүтгэсэн, эсвэл бусад хэлбэрээр хууль зөрчсөн тохиолдолд түүний халдашгүй байдлыг цуцалсан тохиолдолд эрүүгийн ба захиргааны хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт хийх, урьдчилсан мөрдөн байцаалт явуулахыг зөвшөөрнө.</p>
---	---	--

10. СОЛОНГОС

<p>БНСУ-ын Үндсэн хууль, 1987.10.29 (Constitution of Korea) http://korea.na.go.kr/res/low_01_read.jsp?boardid=10000000035</p>	<p>Article 44 [Immunity] (1) During the sessions of the National Assembly, no member of the National Assembly shall be arrested or detained without the consent of the National Assembly except in case of flagrante delicto. (2) In case of apprehension or detention of a member of the National Assembly prior to the opening of a session, such member shall be released during the session upon the request of the National Assembly, except in case of flagrante delicto. Article 45 [Indemnity] No member of the National Assembly shall be held responsible outside the National Assembly for opinions officially expressed or votes cast in the Assembly.</p>	<p>44 дүгээр зүйл. Халдашгүй байдал 1. Үндэсний Ассамблейн гишүүнийг гэмт үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд чуулганы хугацаанд ҮА зөвшөөрөлгүйгээр баривчлах болон цагдан хорихыг хориглоно. 2. Үндэсний Ассамблейн гишүүнийг чуулганаас бусад хугацаанд баривчилсан бол гэмт үйлдэл дээрээ баригдсан эсэхийг үл харгалзан чуулганы хугацаанд суллана. • 45 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн гишүүн нь чуулганы хуралдаан дээр албан ёсоор хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариуцлага хүлээхгүй.</p>	<p>Үндсэн хуулийн 65-р зүйлд төрийн түшээгийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх саналыг Үндэсний Ассамблейгаас гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гартал тухайн төрийн түшээгийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ" гэж заасан байна. Дээрх тохиолдолд ҮА гишүүдийн гуравны нэгээс дээш хувь нь чуулганд оролцсон байх ёстой бөгөөд оролцогч гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.</p>
<p>БНСУ-ын Үндэсний Ассамблейн хууль (National Assembly act) http://korea.na.go.kr/res/low_02_read.jsp?boardid=10000000036</p>	<p>Article 26 (Procedure of Request for Consent to Arrest) (1) If a judge of the competent court desires to obtain a consent of the National Assembly in order to arrest or detain a National Assembly member, he/she shall submit to the Government a request for consent to the arrest before issuing the warrant, and the Government shall, upon receiving it, make a request for consent to the arrest to the National Assembly with its copy without delay. (2) After receiving the request for consent to arrest under paragraph (1), the Speaker shall report it to the plenary session convened first, and it shall be voted 24 hours after and within 72 hours from the time when it is reported to the plenary session. <Newly Inserted by Act No. 7614, Jul. 28, 2005> Article 27 (Notification of Arrest of National Assembly Member) When a National Assembly member is arrested or detained, the Government shall, without delay, notify the Speaker of the arrest or detention with a copy of the warrant. The same shall apply in cases of an extension of the detention period.</p>	<p>26 дугаар зүйл. Баривчлах зөвшөөрөл авах хүсэлт гаргах процедур 1. Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчлах болон цагдан хорихдоо Үндэсний Ассамблейгаас зөвшөөрөл авна. Засгийн газар харьяалах шүүхийн шүүгчийн шийдвэрийг хүлээн авсны дараа нэн даруй шийдвэрийн хуулбарыг хавсарган Үндэсний Ассамблейд баривчлах зөвшөөрөл гаргуулахаар хүсэлт гаргана. 2. Үндэсний Ассамблейн дарга 1 дүгээр хэсэгт заасан баривчлах зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авсны дараа эхний нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж, чуулганаар хэлэлцсэнээс хойш 24 цагийн дараа 72 цагийн дотор шийдвэр гаргана. 27 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчилсан тухай мэдэгдэл. Засгийн газар баривчлах болон цагдан хоригдсон Үндэсний Ассамблейн гишүүний талаар нэн даруй Үндэсний Ассамблейн даргад шийдвэрийн хуулбарыг хавсарган энэ тухай мэдэгдэх ёстой. Цагдан хорих хугацааны шийдвэр байсан ч адилхан байна.</p>	

11. ФРАНЦ

<p>Үндсэн хууль, 1958 он., 4-р бүлэг, 26-р зүйл, Constitution, http://www.conseil-constitutionnel.fr/</p>	<p>Article 26. Aucun membre du Parlement ne peut être poursuivi, recherché, arrêté, détenu ou jugé à l'occasion des opinions ou votes émis par lui dans l'exercice de ses fonctions. Aucun membre du Parlement ne peut faire l'objet, en matière criminelle ou correctionnelle, d'une arrestation ou de toute autre mesure privative ou restrictive de liberté qu'avec l'autorisation du bureau de l'assemblée dont il fait partie. Cette autorisation n'est pas requise en cas de crime ou délit flagrant ou de condamnation définitive. La détention, les mesures privatives ou restrictives de liberté ou la poursuite d'un membre du Parlement sont suspendues pour la durée de la session si l'assemblée dont il fait partie le requiert. L'assemblée intéressée est réunie de plein droit pour des séances supplémentaires pour permettre, le cas échéant, l'application de l'alinéa ci-dessus.</p>	<p>26-р зүйл. Улсын Хурлын гишүүнийг үүргээ хэрэгжүүлэх хугацаандаа санал бодлоо илэрхийлсэн, саналаа өгсөнийх нь төлөө мөрдөн мөшгөх, эрэн сурвалжлах, баривчлах, саатуулах, эсхүл шүүхэд шилжүүлэхгүй. Улсын Хурлын гишүүнийг зөвхөн харьяалах танхимын Товчооны зөвшөөрлөөр эрүүгийн буюу цагдаагийн журмаар мөрдөн мөшгөж эрх чөлөөг нь хасах буюу хязгаарлах арга хэмжээг авна. Гэмт хэргийн газар дээр эд мөрийн баримттай баривчилсан, эсхүл эцэслэн шийтгэсэн тохиолдолд энэ зөвшөөрлийг шаардахгүй. Харьяалах танхимаас шаардсан тохиолдолд Улсын Хурлын гишүүнийг цагдан хорьсон, эрх чөлөөг нь хассан буюу хязгаарласан арга хэмжээ авах, мөрдөн мөшгөх үйл ажиллагааг чуулганы үеэр түр зогсооно. Дээрх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмээн үзвэл харьяалах танхим нь бүрэн эрхийнхээ дагуу нэмэлт чуулганыг чуулна. “V Бүгд Найрамдах Франц улсын Үндсэн хууль”, МУИС, 2005 он.</p>	<p>Гэмт хэргийн газар дээр цагдан хорьсон, эсхүл эцэслэн шийтгэгдээгүй бол ямар ч гишүүнийг харьяалах танхимын зөвшөөрлөөр баривчлах болон эрх чөлөөг нь хасах буюу хязгаарлах зэрэг бусад арга хэмжээг авна. Гишүүнийг цагдан хорьсон болон бусад үйл ажиллагааг чуулганы үеэр түр зогсоож болно.</p>
<p>Парламентын чуулгануудын үйл ажиллагааны харилцааны тухай №58-1100 тоот тогтоол, 1958.11.17, 9-р зүйл, http://www.assemblee-nationale.fr/</p>	<p>Art. 9 bis. L'arrestation ou toute autre mesure privative ou restrictive de liberté susceptible d'être décernée à l'encontre d'un membre du Parlement fait, à peine de nullité, l'objet d'une demande d'autorisation formulée par le procureur général près la cour d'appel compétente et transmise par le garde des sceaux, ministre de la justice, au président de l'assemblée intéressée. Cette demande indique précisément les mesures envisagées ainsi que les motifs invoqués. L'autorisation donnée par le Bureau de l'assemblée intéressée ne vaut que pour les faits mentionnés dans la demande prévue au premier alinéa.</p>	<p>9-р зүйл. Парламентын гишүүнийг эд мөрийн баримтгүй баривчлах, эсхүл эрх чөлөөг нь хасах, хязгаарлах зэрэг үйл ажиллагааг авах тухай зөвшөөрлийг Давж заалдах шатны шүүхийн ерөнхий прокурор боловсруулж, Хууль зүйн сайд харьяалах танхимын Ерөнхийлөгчид уламжлуулж өгнө. Харьяалах танхимын Товчооны зөвшөөрөл нь энэ зүйлийн эхний хэсэгт заасны дагуу зөвхөн ач холбогдол бүхий баримт болно.</p>	
<p>Үндэсний Ассамблейн дэгийн тухай дүрэм, 1958 он, 14-р бүлэг, 80-р зүйл, 5-р заалт, Règlement de L'Assemblée Nationale http://www.assemblee-nationale.fr/</p>	<p>Article 80 5. Conformément au dernier alinéa de l'article 26 de la Constitution, l'Assemblée se réunit de plein droit pour une séance supplémentaire pour examiner une demande de suspension de détention, de mesures privatives ou restrictives de liberté ou de poursuite ; cette séance ne peut se tenir plus d'une semaine après la distribution du rapport ou, si la commission n'a pas distribué son rapport, plus de quatre semaines après le dépôt de la demande.</p>	<p>80-р зүйл. Үндсэн хуулийн 26-д заасны дагуу танхим нь гишүүнийг баривчлахыг түтгэлзүүлэх, тэдэнд, эсхүл тэдний шүүх ажиллагаанд бүрэн, эсхүл хагас хамгаалах асуудлыг хэлэлцэх ээлжит бус чуулганыг хуралдуулах ёстой. Хороо хуралдах тухай зарласнаас хойш долоо хоногийн дараа, эсхүл зарлагдаагүй бол мэдэгдэл хийгдсэнээс хойш 4 долоо хоногийн дараа ээлжит бус чуулган хуралдах ёстой.</p>	

12. ХЯТАД

<p>Үндсэн хууль, 1982 -12 -04</p> <p>/ 1982年12月4日 /</p> <p>http://www.gov.cn/gongbao/ content/2004/content_62714. htm</p>	<p>第七十四条 全国人民代表大会代表, 在全国人民代表大会会 主席 可, 在全国人民 代表大会 期 非 全国人民代表大会常委 委 可, 不受逮捕或者刑事 判。</p> <p>第七十五条 全国人民代表大会代表在全国 人民代表大会各 上的 言和表决, 不受 法律追究。</p>	<p>74 дүгээр зүйл Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын тэргүүлэгчдийн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр, Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурал завсарласан үед бол Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны хурлын зөвшөөрөлгүйгээр, Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төлөөлөгчийг баривчилж эсвэл эрүүгийн хэргээр шүүж болохгүй.</p> <p>75 дугаар зүйл Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Төлөөлөгчийг Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төрөл бүрийн хуралдаан дээр хэлсэн үг, өгсөн саналд нь хуулийн хариуцлага хүлээлгэж болохгүй.</p>
<p>Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын тухай хууль 1982 - 12 -10</p> <p>/ , /</p> <p><a href="http://www.jincao.com/fa/01/
law01.22.htm#04">http://www.jincao.com/fa/01/ law01.22.htm#04</p>	<p>第四十三条 全国人民代表大会代表、全国人 民代表大会常委 的 成人, 在全国人民 代表大会和 全国人民代表大会常委 各 上的 言和表决, 不受法律追究。</p> <p>第四十四条 全国人民代表大会代表非 全国人民代表大会主席 可, 在全国人民代 表大会 期 非 全国人民代表大会常委 可, 不受逮捕或者刑事 判。</p> <p>全国人民代表大会代表如果因 是 行犯 被拘留, 行拘留的公安机 立即向全国人 民代表大会主席 或者全国人民代表大会常委 委 告。</p>	<p>43 дугаар зүйл Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын төлөөлөгчийг, Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны хурлын бүрэлдэхүүн гишүүнийг Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хуралд болон Бүх Ардын Төлөөлөгчдийн их хурлын Байнгын хорооны хурал дээр хэлсэн үг, өгсөн саналаар нь хуулийн хариуцлага хүлээлгэж болохгүй.</p> <p>44 дүгээр зүйл Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын тэргүүлэгчдийн зөвшөөрөлгүйгээр, Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурал завсарлаж байх үеэр Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны хурлын зөвшөөрөлгүйгээр, Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын төлөөлөгчийг баривчилж эсвэл түүний хэргийг шүүж болохгүй.</p> <p>Хэрэв Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын төлөөлөгчийг гэмт хэрэг үйлдсэн газар дээр нь баривчлан саатуулсан бол, баривчлан саатуулсан цагдаагийн байгууллага нь яаралтай Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын тэргүүлэгчид эсвэл Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны хуралд мэдэгдэх ёстой.</p>
<p>Бүх Ардын Төлөөлөгчдийн Их хурлын төлөөлөгч, Орон нутгийн Бүх Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын төлөөлөгчийн тухай хууль</p> <p>1992 -04 -03</p> <p>/中 人民共和国全国人民代表 大会和地方各 人民代表大会代 表法, 1992年4月3日/</p> <p><a href="http://www.gov.cn/jrzq/2010-
10/29/content_1732873_2.htm">http://www.gov.cn/jrzq/2010- 10/29/content_1732873_2.htm</p>	<p>48 дугаар зүйл</p> <p>Төлөөлөгч нь доор дурдсан аль нэг байдалтай бол, төлөөлөгчийн албан тушаалаа гүйцэтгэх эрхийг түр цуцлана. Төлөөлөгчийн эрхийг шалгах хорооноос тухайн төлөөлөгчийн харьяагдах Ардын Төлөөлөгчдийн Байнгын хорооны хурал эсвэл Муж тосгоны Ардын төлөөлөгчдийн хуралд мэдэгдэнэ.</p> <ol style="list-style-type: none">1. Гэмт хэргийн шалтгаанаар баривчлагдсан, шалгагдаж буй, шүүхэд хэрэг үүсгэгдэнэ, хянан шалгагдаж буй тохиолдолд.2. Хуулийн дагуу гэмт хэргээр баривчлагдсан, эсвэл хугацаатай шоронд хоригдсон, гэхдээ улс төрийн эрхийг нь хасаагүй, ял эдэлж буй тохиолдолд.3. Төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаанд өмнөх заалтуудын тохиолдол арилсны дараа, төлөөлөгчийн албан тушаалыг буцаан сэргээнэ. Гэхдээ төлөөлөгчийн эрхийг түдгэлзүүлснээс бусад тохиолдолд. <p>• 49 дүгээр зүйл. Дараах аль нэг тохиолдолд, төлөөлөгчийн эрхийг түдгэлзүүлнэ.</p> <ol style="list-style-type: none">1. Орон нутгийн Ардын Төлөөлөгчдийн Их хурлын төлөөлөгч нь өөр бүс нутаг руу нүүсэн бол.2. Ажлаас гарах өргөдлийг нь хүлээн авсан бол.3. Тухайн Ардын Төлөөлөгчдийн Их хурлыг зөвшөөрөл авалгүйгээр хоёр удаа тасалсан бол.4. Огцруулсан бол.5. БНХАУ-ын иргэний харьяаллаа алдсан бол.6. Хуулийн дагуу улс төрийн эрхийг нь түдгэлзүүлсэн бол.7. Хөдөлмөрийн чадвараа алдсан бол.	

13. ЭСТОНИ

<p>Үндсэн хууль 1992.06.28. /Конституция Эстонии/</p>	<p>Статья 76. Член Рийгикогу пользуется неприкосновенностью. Он может быть привлечен к уголовной ответственности только по представлению канцлера юстиции с согласия большинства состава Рийгикогу.</p>	<p>Рийгигогугийн гишүүн халдашгүй дархан байна. Түүнийг зөвхөн хууль зүйн сайдын танилцуулгын дагуу Рийгигогугийн бүрэлдэхүүний дийлэнхи олонхийн саналаар эрүүгийн хариуцлагад татаж болно.</p>
---	---	--

14. ЯПОН

<p>Үндсэн хууль 1946.11.03 The Constitution of Japan Япон Улсын Үндсэн хууль-П.Амаржаргал Адмон хэвлэл-2011</p>	<p>Article 50. Except in cases provided by law, members of both Houses shall be exempt from apprehension while the Diet is in session, and any members apprehended before the opening of the session shall be freed during the term of the session upon demand of the House.</p>	<p>50 дугаар зүйл. Хуульд зааснаас бусад тохиолдолд, хоёр танхимын гишүүдийг чуулганы үеэр баривчлах, хэн нэгэн гишүүнийг чуулган эхлэхээс өмнө болон чуулганы хугацаанд баривчилж болохгүй</p>
<p>Парламентын тухай хууль Diet law of Japan</p> <p>(Энэ хууль нь Япон Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж үйлчилнэ.)</p> <p>(This Law shall become effective on the day of enforcement of the Constitution of Japan.)</p> <p>http://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm</p>	<p>Article 33. During a session of the Diet, a Member of a House shall not be apprehended without the consent of his House, unless he is in the very act of committing a criminal offense outside the House.</p> <p>Article 34. With regard to the consent of a House to the apprehension of one of its Members, the Cabinet must ask for it, producing a copy of the request, upon receiving a written request sent by the competent court or judge prior to the issue of a warrant of apprehension.</p> <p>Article 34-II. If a Member has been apprehended prior to the opening of a session, the Cabinet must communicate the Member's name, together with a copy of the warrant of apprehension, to the presiding officer of his House at the beginning of the session. If a judge decides, during a session, to extend the detention period of a Member who has been apprehended prior to the opening of the session, the Cabinet must inform the presiding officer of his House to that effect.</p> <p>Article 34-III. To propose a request for the release of a Member apprehended prior to the opening of a session, a written request with an explanatory statement must be presented to the presiding officer of the House, under the joint names of twenty or more Members.</p>	<p>Гучин гуравдугаар зүйл. Гэмт хэргийн үйлдэл дээр нь танхимын гадна баривчилсанаас бусад тохиолдолд Парламентын чуулганы үед, танхимын гишүүдийг тухайн танхимын зөвшөөрөлгүйгээр баривчлахгүй. Гучин дөрөвдүгээр зүйл.</p> <p>1. Шүүгчийн /шүүх/ баривчлах тухай захирамж гаргахаасаа өмнө бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсанаар Засгийн газар нь уг хүсэлтийг хуулбарыг аль нэг гишүүнийг нь баривчлах зөвшөөрлийг өгөх тухай хүсэлтийг тухайн танхимд гаргана.</p> <p>2. Хэрэв чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан, гишүүний баривчилгааны хугацааг чуулганы үеэр үргэлжлүүлэн сунгахаар шүүх шийдвэрлэсэн бол Засгийн газар нь танхимын даргалагч /тэргүүлэгч/ албан тушаалтанд мэдэгдэх ёстой.</p> <p>3. Чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан гишүүнийг чөлөөлөх саналыг оруулахдаа 20 болон түүнээс дээш тооны гишүүдийн хамтдаа тайлбар бүхий хүсэлтийг танхимын даргалагч /тэргүүлэгч/ албан тушаалтанд гаргана.</p>
	<p>Япон Улсын Үндсэн хуулиар парламентын гишүүний халдашгүй байдлын үйлчлэх хугацааг багаар тогтоосон байдаг. Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу хуульд зааснаас бусад тохиолдолд танхимын гишүүнийг Парламентын үеэр баривчилж болохгүй. Чуулган эхлэхээс өмнө баривчиллагдсан гишүүнийг тухайн танхимын шаардсаны дагуу чуулганы хугацаанд баривчилгаанаас чөлөөлнө.</p>	



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ШАГНАЛЫН ТАЛААРХИ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

А. Пагма, Г. Гэрлээ

Австри улс

Маргарэта Лупак сан /Margaretha Lupac Foundation/ нь парламентын тогтолцоо, ардчилалд голчлон анхаардаг ба энэ сангаас хоёр жил тутамд эрдэмтэн судлаач нарт шинжлэх ухааны шагнал болон ардчиллын шагналыг олгодог. Маргарэта Лупак /Margaretha Lupac/ нь 1910 оны 4 сарын 28-нд Вень /Vienna/ хотод Вэнзэл Лупакын /Wenzel Lupač/ охин болж төрсөн. Тэрээр дэлхийн II-р дайны үед Улаан загалмайн нийгэмлэгийн зөвлөхөөр мөн улсын батлан хамгаалах эдийн засгийн ажилд албан хаагчаар тус тус ажиллаж байсан. Маргарэта Лупак нь гайхамшигтай эх оронч хүн байжээ. Маргарэта Лупак нь 1999 оны 2 сарын 17-нд нас барж, өөрийн бүх өв хөрөнгө болох 1,5 сая еврог Австри улсын парламентын төслүүдэд зориулуулахаар Бүгд Найрамдах Австри улсын парламентад гэрээслэн үлдээсэн байна.

2001 онд түүний дурсгалд зориулан Үндэсний Зөвлөлийн ерөнхийлөгч /President of the National Council/ Dr. Heinz Fischer болон Холбооны Зөвлөлийн ерөнхийлөгч /President of the Federal Council/ Ing. Gerd Klamt нарын шийдвэрээр энэхүү санг үүсгэн байгуулсан. Тус сангийн статутанд зааснаар Маргарэта Лупак сан нь Австри улсын парламентын тогтолцооны хөгжил болон түүхэнд зориулсан судалгааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой ажээ. Маргарэта Лупак сан нь ардчилал, парламентын тогтолцоонд голчлон анхаардаг ба сангаас зохион байгуулдаг үйл ажиллагаанд дараах ажлууд орно. Үүнд:

Парламентын тогтолцоо болон ардчилалд жинтэй хувь нэмэр оруулсан, өндөр ач холбогдолтой үйл ажиллагаанд зориулсан шагнал олгох,

- Австри улсын Парламентын тогтолцооны хөгжил, түүний түүхийн талаар хийсэн судалгааны ажлыг дэмжих,
- Уулзалт болон бусад арга хэмжээг зохион байгуулах,
- Нийгмийн чиг хандлагыг илэрхийлсэн урлагын чухал ач холбогдлыг онцлоход зориулж Австрийн уран бүтээлчдийн уран бүтээлийн ажлыг дэмжих зэрэг болно.

Сангийн зохион байгуулалтын бүтцэд Итгэмжит зөвлөл /Board of Trustees/ болон Сангийн менежер /Manager of the Foundation/ орно. Түүний гишүүдийг хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн хугацаанд томилно. Итгэмжит зөвлөлийн даргаар Үндэсний Зөвлөлийн ерөнхийлөгч, түүний дэд даргаар Холбооны Зөвлөлийн ерөнхийлөгч томилогдоно. Мөн Үндэсний Зөвлөлийн гол хороодоос тус бүр нэг төлөөлөгчийг зөвлөлд томилно. Одоогийн хууль тогтоох байгууллагын хугацаанд Итгэмжит зөвлөл нь 14 хүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөлийн менежерээр парламентын захиргааны /Parliamentary Administration/ дэд дарга ажилладаг байна.

Ардчиллын шагнал /The Democracy Award/

Маргарэта Лупак сангийн Ардчиллын шагналыг хоёр жил тутамд нэг удаа гардуулна. Анх шагналыг 2004 оноос олгож эхэлсэн. Шагналын мөнгөн дүнг Маргарэта Лупак сан тухайн үеийн санхүүгийн байдлаасаа хамааран тогтоох ба нийт 15000 евро байх ба, үүнийг 3 хүртэл ялагчид хуваан олгож болно. Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа парламентад зохион байгуулагдана.

Шагналын шалгуурын шаардлагыг хангасан хүн эсвэл байгууллага нь өдөр тутмын ажлаараа эсвэл амьдарлынхаа туршид хийсэн ажлаараа ардчилал, жэндэрийн тэгш эрх, цөөнхийн эрх зэрэгт дэмжлэг үзүүлж ардчилалд үнэтэй хувь нэмэр оруулсан байх ёстой.

Одоогийн байдлаар шагнал олгосон он:

- Ардчиллын шагнал 2010
- Ардчиллын шагнал 2008
- Ардчиллын шагнал 2006
- Ардчиллын шагнал 2004

Шинжлэх ухааны шагнал /The Science Award/

Сан нь мөн хоёр жил тутам шинжлэх ухааны шагналыг олгоно. Шагналын мөнгөн дүнг Маргарета Лупак сан тухайн үеийн санхүүгийн байдлаасаа хамааран тогтоох ба нийт 15000 евро байх ба, үүнийг 3 хүртэл ялагчид хуваан олгож болно. Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа парламентад зохион байгуулагдана. Анх энэ шагналыг 2005 оноос гардуулж эхэлсэн. Энэ шагналыг эрдэмтэн судлаачдын амьдралдаа гаргасан амжилт, шинжлэх ухааны бүтээл, эсвэл гүйцэтгэсэн болон үнэлэгдсэн докторын ажил зэргээр нь үнэлэн шагнана.

Одоогийн байдлаар шагнал олгосон он:

- Шинжлэх ухааны шагнал 2009
- Шинжлэх ухааны шагнал 2007
- Шинжлэх ухааны шагнал 2005

Хорват улс

Бүгд Найрамдах Хорват улсын Үндэсний шинжлэх ухааны шагналуудыг /National Science Awards/ шинжлэх ухааны судалгааны гүйцэтгэлийн үр дүнгээрээ албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, онцгой амжилтанд хүрсэн шинжлэх ухааны судалгаа, шинжлэх ухааны шинэ нээлтүүд, шинжлэх ухааны ололт амжилт зэргээрээ тэргүүлсэн эрдэмтэн, судлаач, залуу судлаач нарт олгодог. Хорватын Үндэсний шинжлэх ухааны шагналын хуулинд /The Act on Croatian National Science Awards/ зааснаар дөрвөн төрлийн Үндэсний шинжлэх ухааны шагналууд байдаг. Үүнд:

- Амьдарлын амжилтын шагнал /Lifetime Achievement Award/
- Оны шилдэг шинжлэх ухааны шагнал /Annual Science Award/
- Оны шилдэг шинжлэх ухааны дэмжлэгийн шагнал /Annual Award for Popularization and Promotion of Science/
- Оны шилдэг залуу судлаачдын шагнал /Annual Award for Junior Researchers/

Хорватын парламентаас Үндэсний шинжлэх ухааны шагналын хороог /The National Science Awards Committee/ байгуулсан. Энэ хороо нь шагналын ялагчдыг зарлана. Шагналыг жил бүр Хорватын парламентын ерөнхийлөгч /President of the Croatian Parliament/ нь Хорватын парламентыг төлөөлж ялагч нарт гардуулна. Энэ хороо нь дараахь гишүүдээс бүрдэнэ: хорооны даргаар Хорватын парламентын ерөнхийлөгч, Шинжлэх ухаан Боловсрол Спортын яамны сайд /Minister of Science, Education and Sports/, болон алдартай 12 эрдэмтдээс бүрдэнэ. Хорооны гишүүдийг дөрвөн жилийн хугацаатайгаар хороонд томилно.

Амьдарлын амжилтын шагнал

Шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаанд, шинжлэх ухааны мэдлэгийг өргөтгөхөд

хувь нэмрээ оруулсан болон шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн гүйцэтгэлээрээ албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаачдад энэхүү шагналыг олгодог. Амьдралын амжилтын шагналыг жил бүр 6 хүртэл эрдэмтэн судлаач нарт олгоно.

Оны шилдэг шинжлэх ухааны шагнал

Гайхамшигтай шинжлэх ухааны нээлт, шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн гүйцэтгэлээрээ албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаач нарт энэхүү шагналыг олгодог. Оны шилдэг шинжлэх ухааны шагналыг жил бүр шинжлэх ухааны салбар бүрт 3 хүртэл олгоно.

Оны шилдэг шинжлэх ухааны дэмжлэгийн шагнал

Шинжлэх ухааны хэвлэл болон албан ёсны алдартай илтгэл, эсвэл бусад хэлбэрийн илтгэлээрээ илэрхийлсэн шинжлэх ухааны мэдлэгийг өргөтгөхөд үнэтэй хувь нэмрээ оруулсан эрдэмтэн судлаачдад энэхүү шагналыг олгодог. Оны шилдэг шинжлэх ухааны дэмжлэгийн шагналыг жил бүр 3 хүртэл эрдэмтэн судлаачдад олгоно.

Оны шилдэг залуу судлаачдын шагнал

Шинжлэх ухааны ном хэвлүүлсэн эсвэл олон улсад танигдсан шинжлэх ухааны сэтгүүл эсвэл түүнтэй зэрэгцэх түвшиний сэтгүүлд бүтээл нь хэвлэгдэн сайн үнэлгээ авсан залуу эрдэмтэн судлаачдад энэхүү шагналыг олгоно. Оны шилдэг залуу судлаачдын шагналыг жил бүр 6 хүртэл эрдэмтэн судлаачдад олгоно. 2011 онд дөрвөн төрлийн Үндэсний шинжлэх ухааны шагналаар нийт 26 эрдэмтэн судлаачдыг шагнасан.

АНУ-ын Конгрессын Алтан Медаль (Congressional Gold Medal)

Энэхүү Алтан Медаль нь АНУ-ын түүх, соёлын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гарамгай ололт, амжилт гаргасан хүмүүст АНУ-ын Конгрессын нэрийн өмнөөс олгодог иргэний дээд шагнал юм.

Конгрессын Алтан Медаль нь 1776 оноос эхлэн олгогдож эхэлсэн бөгөөд хамгийн анх Жорж Вашингтон шагнагдаж байжээ. 1860 он хүртэл цэргийн гарамгай удирдагчид, дайны талбарт гавъяа байгуулсан цэрэг, офицерүүдийг шагнадаг цэргийн шагнал байсан ба Хүндэтгэлийн Медалиар (Medal of Honor) шагнаж эхэлсэнээс хойш Конгрессын Алтан Медалиар дайны баатруудын зэрэгцээ гарамгай судлаачид, эрдэмтэд, соёлын зүтгэлтэн, инженер, иргэний нисэх хүчин, сансрын нислэгийн анхдагчид, нэрт аялагчид, хүний эрхийн төлөө тэмцлийн идэвхтэн, шашны зүтгэлтнүүдийг шагнаж байна.

Конгрессын Алтан Медаль нь АНУ-ын хууль тогтоох дээд байгууллага болох Конгрессын нэрийн өмнөөс олгодог үндэсний иргэний дээд шагнал бөгөөд статутаараа АНУ-ын Засгийн газрын иргэний дээд шагнал болох Ерөнхийлөгчийн Эрх чөлөөний Медальтай (Presidential Medal of Freedom) ижил юм. Үүнээс гадна АНУ-д Ерөнхийлөгчийн гардуулдаг Үндэсний шинжлэх ухааны Медаль (National Medal of Science) бий.

Конгрессын Алтан Медалиар шагнах шалгуур, журам

Конгрессын Алтан Медаль нь АНУ-ын төрийн дээд шагнал мөн боловч түүний статут нь хуулиар зохицуулагддаггүй, шагнал нь Конгрессын тусгай хороодын тогтоосон дүрмийн дагуу явагддаг болно. Тус медалиар шагнах тухай шийдвэр нь олон шат дамжиж гардаг ба хамгийн түрүүнд энэ асуудал Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцэгдэн, Санхүүгийн үйлчилгээний Байнгын хорооны дүрмийн дагуу төлөөлөгчдийн танхимын гишүүдийн 2/3 буюу нийт 290 гишүүний саналыг авсан байх ёстой. Конгрессын Алтан Медалиар шагнах

тухай шийдвэр буюу хуулийн төсөл нь Конгрессын доод танхимын гишүүдийн олонхийн саналыг авсан тохиолдолд уг асуудлыг Санхүүгийн үйлчилгээний Байнгын хорооны бүрэлдэхүүнд багтдаг Мөнгөний дотоод бодлого, технологийн дэд хороогоор хэлэлцэнэ.

2011 онд хүчин төгөлдөр болсон Санхүүгийн үйлчилгээний Байнгын хорооны дүрмийн дагуу дэд хорооны гишүүд шагналын талаархи хуулийн төслийг хэлэлцэхдээ дараах шаардлагыг хангасан эсэхийг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Шагнагдах гэж байгаа хүн АНУ-ын түүх, соёлд онцгой амжилт гаргасан байх ёстой. Онцгой амжилт гэдэгт тухайн хүний бүхий л амьдралынхаа туршид эсхүл нэг удаа гаргасан, тухайн салбарын (шинжлэх ухаан, урлаг гэх мэт) мэргэжлийн нийгэмлэг нь тэр салбарын хамгийн дээд амжилт хэмээн хүлээн зөвшөөрсөн амжилтыг ойлгоно.
- Шагнагдах хүн үүнээс урд нь Конгрессын Алтан Медалиар нэгэн адил амжилтын төлөө шагнагдаж байгаагүй байх,
- Тус медалиар нэхэн шагнаж болно. Ингэхдээ шагнагдагч нас барсанаас хойш 5 жилээс багагүй, 25 жилээс ихгүй хугацаа өнгөрсөн байх,
- Доод танхимаас дэмжсэн шагнах тухай шийдвэр нь Сенатаар хэлэлцэгдэн 67-оос доошгүй тооны сенатчын саналыг авсан байх ёстой ба ингэсэн нөхцөлд Сенатын Банк, орон сууц, хотын асуудлын комисст шилжүүлнэ. Конгрессын хоёр танхимаар дэмжигдсэн биллийг мөн Ерөнхийлөгчид батлуулахаар шилжүүлнэ. Шагнах тухай зарлиг нь нийтлэг хуулийн (Public Law) статустай байдаг. АНУ-ын Конгрессын Алтан Медаль нь хийцийн хувьд 465 грамм цэвэр алтны орцтой, 76,2 мм хэмжээтэй байдаг.

* * *

Эх сурвалж:

- <http://www.parlament.gv.at/ENGL/WWER/MLST/WPR/>
- <http://public.mzos.hr/Default.aspx?sec=2492>
- www.ru.wikipedia.org



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2

БҮЛЭГ

УЛСТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ, СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ АСУУДЛААР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ТӨЛӨВШИЛ, НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ
БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛЬ, ПАРЛАМЕНТ БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙГ
ЗЭРЭГ ЯВУУЛАХ НЬ** /Лавлагаа, мэдээлэл/

*Ч. Базар (Ph.D), П. Амаржаргал, Б. Хатантуул,
Б. Цолмонбаяр*

1. Улс төрийн намын гишүүнчлэлийн талаар

“Орчин үеийн ардчилал нь намуудын ардчилал юм.”[1] Намын тухай онол, үзэл санаа хэлбэршин төлөвших хүртлээ хүнд хэцүү сорилтыг туулсан байна. Эхэн үедээ намыг нийгэмд ашиггүй, зөрчил хуйвалдааны эх сурвалж гэж үзэж хяхаж хавчсаар иржээ. Яваандаа нийгэмд намын гүйцэтгэх үүрэг өсөх болсонтой холбоотойгоор түүнийг эерэг талаас нь үнэлэх хандлага мэдэгдэхүйц нэмэгдсэн юм. Намын түүхэнд эзлэх байр суурийг зөв бодитой гаргаж тавих үйл хэрэгт сэтгэгч Н.Макиавелли, Ш.Л.Монтескье нар чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Францын улс төрийн философич Реймон Арон “... намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал юм” гэжээ. Эндээс үзвэл засаглалыг хэрэгжүүлэхэд намуудын хууль ёсны зохистой оролцоо нь ардчилсан нийгэм дэх хэвийн бөгөөд эрүүл үзэгдэл мөн ажээ.

Монголын ардчиллын төлөвшил нь намуудын төлөвшлөөс ихээхэн хамааралтай. Манай улсын хувьд улс төрийн намын эрх зүйн байдлыг “Монгол Улсын Үндсэн хууль”, “Улс төрийн намын тухай хууль”, сонгуулийн тухай хуулиудаар тодорхой зохицуулсан. Олон намын систем төлөвшөөд 20 жил болох хугацаанд нийт 26 улс төрийн нам байгуулагдсанаас 9 нь татан буугдаж өдгөө Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 18 нам байна.[2] Гэвч эдгээрээс орчин үеийн улс төрийн намын шалгуурыг хангах хэмжээнд төлөвшсөн нь цөөхөн юм. Харин намын хэв шинжийн хувьд МАН, АН -уудыг “кадрын нам”, “олон түмний нам”, “өргөн хүрээний нам”-ын завсрын хэв шинжтэй гэж үзэж болох бол зарим жижиг намууд нь кадрын, зарим нь зөвхөн эрх зүйн шалгуураар л нам гэж тооцож болохоор төвшинд байна.[3]

№		МАН	АН	Иргэний зориг,
1	Бүтцийн хэлбэр	Шууд бүтэц	Холимог	Шууд бүтэц
2	Бусад элементүүд ба нэгдсэн бүтцийн хамаарал	Босоо холбоос	Холимог	Босоо холбоос
3	Намын гишүүнчлэл	Хатуу	Хатуу	Хатуу
4	Нийгмийн төлөөлөл	Тогтсон дэмжигчидтэй	Тогтсон дэмжигчидтэй	Бага
5	Удирдлага	Төвлөрөл их	Төвлөрөл их	Лидер дагасан
6	УИХ дахь давамгайлал	Их	Их	-

7	Намын санхүүжилт	-Гишүүний татвар хандив -Төрийн санхүүжилт	Гишүүний татвар хандив -Төрийн санхүүжилт	Гишүүний татвар хандив -Төрийн санхүүжилт
8	Сонгуулийн компанийн хэв маяг	Уламжлал агуулсан модерн	Модерн агуулсан уламжлалт	Модерн агуулсан уламжлалт
9	Төлөвшиж буй хэв маяг	Олон түмний нам	Өргөн хүрээний зарим шинжийг агуулсан олон түмний нам	Кадрын намын зарим шинжийг агуулсан олон түмний нам

Монгол улсын Дээд шүүхэд улсын бүртгэлтэй улс төрийн намуудын мэдээлэл [4]

дд	Намын нэр	Анх байгуулагдсан он	Гишүүдийн тоо
1	Монгол Ардын нам /МАН	1921.03.01	161300
2	Ардчилсан нам	2000.12.25	150000
3	Монголын Ногоон нам /МНН/	1990.05.13	2100
4	Иргэний Зориг нам /ИЗН/	2000.03.09	35000
5	Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	1993.12.05	1503
6	Монголын Либерал Ардчилсан Нам /МЛАН/	1998.05.21	863
7	Эх Орон нам	1998.12.22	160.000
8	Монголын Либерал Нам /МЛН/	1999.12.17	1300
9	Бүгд Найрамдах Нам /БНН/	2004.03.15	50000
10	Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нэгдсэн Нам /МЭҮНН/	2004.4.12	1069
11	Монголын Социал Демократ Нам	2004.12.19	3000
12	Ард Түмний Нам /АТН/	2005.12.11	11859
13	Үндэсний Шинэ Нам	2006.05.19	2400
14	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам	2006.10.09	1600
15	Иргэний Хөдөлгөөн Нам /ИХ/	2007.08.17	815
16	Хөгжлийн Хөтөлбөр Нам	2007.10.28	933
17	Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам	2008.02.01	850
18	Монгол Ардын Хувьсгалт Нам	2011.06.24	

Зарим улс орны намуудын гишүүнчлэлийн тухайд

Дэлхийн улс орнууд улс төрийн намын гишүүнчлэлээрээ хатуу гишүүнчлэлтэй, сул гишүүнчлэлтэй, гишүүнчлэлгүй гэж хуваагддаг. Англи, Америкийн улс төрийн уламжлалтай улс орнуудын хувьд намыг Парламент дахь намын бүлгийн түвшинд их төлөв тайлбарлахаас гадна хатуу тогтсон бүтэц, зохион байгуулалтгүй, тодорхой гишүүнчлэлгүй, сонгуулийн үед идэвхждэг, мэргэжлийн цөөн хүмүүсийн бүлэглэл маягаар ойлгодог аж. Харин их газрын Европын болон аж үйдвэржихийн өмнөх хийгээд аж үйлдвэржиж буй орны улс төрийн системтэй улс орнуудын судлаачид намыг хатуу тогтсон үзэл санаа, зохион байгуулалттай, байнгын гишүүнчлэлтэй, тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, хяналтын нарийн механизмтай олон түмний бүлэглэл хэлбэрээр тайлбарладаг байна.

Эндээс үзвэл өнөө хэр улс төрийн намын талаар цэгцтэй нэгдмэл ойлголт бүрэлдэж хараахан чадаагүй нь харагдаж байна. Хэдий тийм боловч улс төрийн намыг авч үзэхдээ дараахи гол ерөнхий шинжийг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй байдаг. Нэгд, санаа бодол нэгдмэл буюу ойролцоо хүмүүсийн бүлэглэл, хоёрт, үйл ажиллагааны тодорхой зорилго, чиглэл, үзэл санаа, хөтөлбөртэй байх, гуравт, ямар нэг хэмжээгээр зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй байх, дөрөвт, засгийн эрхийг авах эрмэлзлэл, түүнийг хэрэгжүүлэх нөөц чадвартай байх. Энэхүү ерөнхий шаардлага шалгуурыг хангаж чадаж буй бүлэглэлийг нам гэж үзэж болох юм. [5]

Улс төрийн намыг заавал бүртгэж байх эрх зүйн акт бүхий тогтолцоотой орнууд байх бөгөөд Испани, Итали, Францад намыг Дотоод хэргийн яам нь, Бельги, Нидерландад (Голланд) Хууль зүйн яам нь, АНУ-ын Миссури мужид мужийн Төрийн нарийн бичгийн газар нь, Португали, Бразильд Дээд шүүх нь бүртгэдэг байна. Энэтхэг, Мексик, Швейцарьт сонгууль явуулахын тулд байгуулагдсан байгууллагууд бүртгэдэг байна.

Нам байгуулж, бүртгүүлэхэд аль ч улс оронд нэг голлодог зүйл нь тухайн намын гишүүд болон дэмжигчдийн тоо байдаг. Швейцарьт нам бүртгүүлэхэд сонгогчдын 1.5 мянгаас доошгүй гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг бол Португалид 5 мянган сонгогчийг төлөөлсөн байх үүрэгтэй. Эдгээр нь тухайн улсын сонгогчдын буюу сонгуульд оролцож санал өгөх насны нийт хүмүүсийн тоотой харьцуулсан хувь юм.

АНУ-ын 20-иод муж улсын хууль тогтоох байгууллага намуудаас сонгогчдын ерөнхий тооны хувиар илэрхийлсэн тодорхой тооны гарын үсгийг шаарддаг байна. Жишээ нь, Өмнөд Дакотад энэ тоо 10 хувь байдаг бол Миннесотад 5 хувь байдаг. Ингэхдээ муж улсын түвшинд тухайн намын гишүүн ямар нэг албан тушаалтан сүүлийн сонгуульд нэр дэвшиж ялсан, эсвэл бүх нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүмүүсийн хувиас хамааран бүртгэдэг байна. Анхаарах зүйл, дээрх зарчим нь сонгогчдын төлөөлөл болохоос биш манайх шиг хатуу гишүүнчлэлтэй улсынх шиг намын гишүүдийн тоог илэрхийлж байгаа асуудал биш юм. Барууны орнуудад намын гишүүнчлэл гэж бараг байдаггүй, зөвхөн дэмжигчид байдагтай энэ нь хамааралтай.

Намын хатуу гишүүнчлэлтэй орнуудын хувьд, тухайлбал:

- БНУУ-д нам бүртгүүлэхэд гишүүн үүсгэн байгуулагчдын тоо 1000 байх ёстой байдаг.
- Мексикт энэ тоо 65 мянгаар хэмжигддэг.
- Канад болон Мексик улсын хувьд сүүлийн сонгуульд оролцсон сонгуулийн насны иргэдийн Канадад 5,1 хувь [6]
- Мексикт 31,7 хувь [7] нь аль нэг намын гишүүнчлэлтэй байсан байна.

Улс төрийн намгүй орнуудын жагсаалт:

- Бахрейн
- Бутан
- Кристмасын арлууд
- Микронези
- Кувейт
- Ливи
- Мальдив
- Оман
- Палау
- Катар
- Саудын Араб
- Свазиланд
- Тонга
- Тувалу
- Арабын Нэгдсэн Эмират
- Ватикан

Улс төрийн нам хатуу гишүүнчлэлгүй тохиолдолд сонгуульд оролцоод санал авсан дэмжигчдийнхээ тоогоор “Манай нам, нийт ард түмний төдөн хувийн дэмжлэгийг авлаа” гэсэн үр дүнгээр тухайн орон эрх барих хүчнээ тодорхойлж, засаглалаа тогтоож болно. Олон орон ийм загвараар явж байна. Энэ нь тухайн орныхоо тусгаар тогтнол, эв нэгдлийн баталгааг нэмэгдүүлдэг сайн талтай ч гэж зарим судлаачид үздэг ажээ.

Намуудын төлөвшлийн тухайд

“Орчин үеийн ардчилал нь намуудын ардчилал юм.” гэсэн үзэл онолын хүрээнд Монголын намууд сонгуулийн хэв маягийн авсаархан бүтэцтэй, хатуу гишүүнчлэлгүй намын хэлбэрт аажмаар шилжих нь зүйтэй бөгөөд үүний тулд:

- Намууд юуны өмнө зорилго, бодлогын сонголтоо тодорхой болгох
- Намууд парламентын хүрээнд орж ирж, төлөвших улс төр, эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх,
- Парламент дахь намын бүлэгт хууль санаачлах эрх олгох,
- Намуудын дотоод ардчиллыг гүнзгийрүүлэх,
- Намын дотоод бүтэц, зохион байгуулалтын хүрээнд шинэчлэлт хийх,
- Намын санхүүжилтийн нээлттэй ил тод хэлбэрийг бий болгох, намд өгч буй элдэв хандивыг улсын бүртгэлтэй хандивын маягтаар тооцож байх
- Намуудын хүний нөөцийн боломжийг сайжруулан тэднийг чадавхжуулах
- Парламент дахь цөөнхийн оролцоо, үйл ажиллагааны эрх зүйн хангалттай орчин, механизмыг зоригтой бүрдүүлэх нь зэрэгт анхаарах чухал байна гэж судлаачид тэмдэглэжээ. [8]

Эх сурвалж:

1. Жозеф А.Шумпетер “Капитализм, социализм, ба ардчилал”, Р.Даль “Ардчилал ба түүний шүүмжлэл”
2. Улсын дээд шүүх <http://www.supremecourt.mn/>
- 3.Н.Пүрэвгарьд. “Монголын улс төрийн намуудын төлөвшлийн зарим асуудал”, 2011.04.20

4. Улсын дээд шүүх <http://www.supremecourt.mn/>
5. Улс төр судлаач Д.Болд-Эрдэнэ. “Монголд нам устаж олигарх ноёрхлоо”. “Өнөөдөр” сонин. 2007.07.24.
6. <http://www42.statcan.gc.ca>
7. <http://pdba.georgetown.edu/Parties/Mexico/desc.html>, <http://buscador.inegi.org.mx>
8. Д.Болд-Эрдэнэ. “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил, УБ., 2008

2. Хэт улс төржилт ямар, ямар хүчин зүйлүүдээс шалтгаалж буй талаар

Хэт улс төржилтийн талаархи энэхүү мэдээллийг зарим судлаач, мэргэжилтнүүд болон олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл дээр үндэслэн тоймлов.

Улс төржилт гэж юу вэ?

Улс төр судлалын хувьд улс төржилт (politicization, политизация) хэмээх ойлголт байдаг. Нийгэмд улс төрийн үүрэг нөлөө нэмэгдэх, олон түмний улс төрийн идэвхи өсөх, нийгмийн амьдралын ямар нэг асуудал улс төрийн хүрээний анхаарлын төвд тавигдах явдлыг улс төржилт хэмээн ойлгож болно.

Хэтийдсэн улс төржилт

Нэр томъёоны тухайд хэт улс төржилт бус хэтийдсэн гэвэл илүү оновчтой байж болно.

Хэрэгтэй улс төржилт

Улс төр судлалын хувьд улс төржилт (politicization, политизация) хэмээх ойлголт үнэхээр бий бөгөөд нийгэмд улс төрийн үүрэг нөлөө нэмэгдэх, олон түмний улс төрийн идэвхи өсөх, нийгмийн амьдралын ямар нэг асуудал улс төрийн хүрээний анхаарлын төвд тавигдах явдлыг улс төржилт хэмээн ойлгож болно.

1990-ээд оны ардчилсан хувьсгал нь тухайн үеийн нийгэм-эдийн засгийн хямрал, олон улсын харилцаанаас гадуурхагдсан байдал, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хязгаарласан байдал, улс төрийн зохисгүй удирдлага зэрэг асуудлаар өргөн хэлэлцүүлэг өрнөж, монголын нийгмийн хөгжлийн цаашдын хандлагыг хэрхэн тодорхойлох талаархи үндэсний дэвшилт сэхээтнүүдийн үзэл санааны өрсөлдөөн, товчхондоо маш том улс төржилтийн үр дүн болон гарч ирсэн билээ. Нийгмийн тодорхой үе, нөхцөл байдалд нийгмийг бүхэлд нь хамарсан улс төржилт явагдах зайлшгүй шаардлага үүсдэг. Тухайлбал, нийгмийн хувьсгал, системийн шинжтэй өөрчлөлт хийх үүднээс бүх нийтийн санал хураалт явуулах, сонгуулийн үед улс төржихөөс өөр аргагүй юм.

Нийгмийн тулгамдсан асуудал улс төрийн амьдралын чухал сэдэв болох нь тухайн асуудлыг эергээр шийдвэрлэх, улс орны хөгжлийг урагшлуулахад том хүчин зүйл болдог. Тухайлбал, хотын утаа, хүн амын орон сууцны дутагдал, хүн худалдаалах хэрэг, хар тамхины хэрэглээ өсөх, гэр бүлийн хүчирхийлэл, боловсролын чанар муудах, дээд боловсрол эзэмшигчдийн жендерийн зохисгүй харьцааны бий болох, хувь хүний виртуал мэдээллийн нууц алдагдах, инженер техникийн боловсон хүчний дутагдал, гаж төрөлт ихсэх, хорт хавдрын өсөлт, хүн амын шилжих хөдөлгөөн ихсэх зэрэг асуудлууд “улс төржсөн”-өөр шаардлагатай хөрөнгө санхүү босгох, нийгмийн ухамсар төлөвших, зохицуулалтын эрх зүйн болон ёс зүйн орчин бүрэлдэхэд чухал хөшүүрэг болдог юм.

Хэтийдсэн улс төржилт бий болдог шалтгаан

а/ Улс төрчид болон Иргэний хөдөлгөөний хүрээнд:

- Ээлжит сонгуулийн үеэр сонгогчдод бодлогогүй амлалт өгөх
- Янз бүрийн асуудал хөндөж, улс төрийн дуулиан тарих замаар ашиг хонжоо олох /Гэхдээ заримдаа хөндсөн сэдэв нийгмийн эрх ашигтай давхцах явдал гардаг ч энэ нь ховор/
- Нийгмийн захиалгаар биш хувийн эсвэл бусдын сэдэлтэй улс төржих хандлага
- Бодлогод биш өөрийн реклам сурталчилгаанд илүүтэй анхаарах
- Өөрийн нэр хүндэд сэвтэй үйл явдлаас олон түмний анхаарлыг холдуулах зорилгоор өөрийн олонд танигдсан байдлаа ашиглан үр ашиггүй сэдвээр яриа хэлэлцүүлэг өрнүүлэх
- Үнэн бодит байдлаас хол асуудлаар олон нийтийн толгойг эргүүлэх
- Намаар талцах, намчирхах
- Бусдын үзэл бодлыг үл тоох, үл хүндэтгэх
- Хөгжлийн төлөөхи бодлогыг улс төрийн зорилгоор гуйвуулах, шуугиан тарих
- Хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх

б/ Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүрээнд:

- Чөлөөт учраас хэн, юу хүссэнээ бичиж нийтэлж, үгээ чөлөөтэй хэлж байна гэсэн халхавч хийх
- Нийгмийн анхаарлыг тодорхой асуудалд татах чадвараа зарим тохиолдолд аар саархан ярианы сэдэв болгох
- Улс төрчдийн хуурмаг явууллагаар улс төржилтийг хөөрөгдөх
- Захиалгат, төлбөрт нийтлэл, нэвтрүүлэг нийтлэх, нэвтрүүлэх

в/Олон нийтийн дунд

- Намаар талцах, намчирхах
- Буруу ташаа мэдээлэлд үндэслэн үр дүнгүй улс төржиж, итгэл үнэмшлээрээ бус улс төрийн хүчин, хөдөлгөөнүүдийн гар, хөл болох
- Намуудад үл итгэх
- Ирээдүйдээ итгэх итгэлээ алдах
- Бүтээн босгох бус бэлэнчлэх
- Нийгмийн баялагийн шударга бус хувиарлалтын сөрөг үр дагавар

Хэтийдсэн улс төржилтын сөрөг үр дагавар:

- Үндэслэл муутай, бодит бус мэдээлэл нийгэмд тархана.
- Хийсвэр оновчгүй шийдвэр дүгнэлтүүд хийгдэнэ.
- Нийгмийн хүч нөөцийг дэмий зүйлд зарцуулахад хүргэнэ. /Хөгжлийг сааруулна/
- Аливаа сонголт буруу хийгдэнэ.
- Зарим тохиолдолд Үндэсний аюулгүй байдал, оршин тогтнолд аюул учруулахуйц байдалд ч хүргэж болно.

Хэтийдсэн улс төржилтийн дүнд хийгддэг үйлдлүүд:

Сайн засаглалын зарчмууд /ил тод байдал, хариуцлага, иргэдийн оролцоо/ үл хэрэгжих

- Жагсаал, цуглаан хийх / Ард түмэн бол агуу, бас хүчирхэг. Гэхдээ энэхүү хүч тооны олон цөөнөөр бус, эв нэгдлээр л илэрхийлэгддэг ажээ. Хэчнээн олон мянган хүн, хэчнээн зөв юмны төлөө жагссан ч, тэр нь хүчирхийлэл болбол уг тэмцлийн агуулга алдарч, нийгэмд хаос болж муу нэртэй үлддэг тухай судлаачдын бичсэн нь бий. Жишээ нь, долдугаар сарын 1-ний үйл явдал бол сонгуулийн луйврыг эсэргүүцсэн шударга тэмцэл байсан гэж олон хүн хэлдэг. Эцэстээ хүчэрхийлэл болсон учраас энэ үйл явдлыг өнөөдөр “хар өдөр”, “долдугаар сарын 1-ний үймээн” гэх зэргээр дандаа сөргөөр, сайны бус, саарын жишээнд оруулж ярьж бичдэг.
- Албан тушаал, боловсон хүчний томилгоо /Улс төрийн үзэл бодол, намын харьяалал, авлига, хээл хахууль, тухайн хүний чадвар чадавхи, ах дүү, төрөл садангийн холбоо/
- Улс төрийн хямралаас үүдсэн салбарын бодлого, үйл ажиллагааны уналт
- Зохиомол үнийн хөөрөгдөл
- Хувийн компаниудын шударга бус үйл ажиллагаа /Жишээ нь, дэлхийн зах зээл дээр буудайны үнэ бууж байхад манайд талхны үнэ өсч байх/
- Засгийн газрын бодлогыг гуйвуулах
- Хуулийг өөрийн бизнесийн эрх ашигт нийцүүлэн өөрчлөх, улмаар лобби аргаар батлуулах /Уршиг нь үнийн хөөрөгдлийг бий болгож, өрсөлдөөнийг бууруулдаг/
- Бодлогын буруу шийдвэр
- Бодлого, шийдвэрийн ил тод бус байдал
- Мэдээллийн ил тод бус байдал
- Хувийн ашиг сонирлын үүднээс асуудалд хандах, хамгаалах
- Ашигт малтмал юмуу ашигтай бизнес тойрсон шударга бус үйлдэл түүнийг тойрсон хардалт /Жишээ хавсаргав/

Хэтийдсэн улс төржилтийг өдөөдөг субъектүүд:

- Улс төрчид
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Иргэний хөдөлгөөн
- Үйлдвэрчний эвлэл /зарим асуудлаар/

Эх сурвалж: http://www.doldon.com/xel/index.php?document_srl

Хавсралт:

Уул уурхайг улстөржүүлэхээ больж, мэргэжлийн хүмүүс оръё,
2008 оны 4-р сарын 8

Эх сурвалж: www.mongolnews.mn

Уул уурхай нэгэнт тэргүүлэх салбар болсон учраас энэ асуудлаар ярихгүй улс төрийн нам хүчин, улстөрч ч гэж байхгүй болсон. Мөн сүүлийн үед иргэний болон төрийн бус байгууллагууд ч энэ талаар янз янзын байр суурь илэрхийлж буй. Халуун сэдэв болсон ашигт малтмалын асуудлаар “Өнөөдөр” сонин, “MN-25” дугаар суваг телевизийнхэн мэргэжлийн хүмүүсийг урьж ярилцлаа. Ярилцлагад Үйлдвэр, худалдааны дэд сайд Я.Содбаатар, АМГХЭГ-ын Кадастрын албаны дарга Т.Бат-Оргил, Монголын уул уурхайн ассоциацийн тэргүүн М.Ганболд, Дэлхийн банкны төслийн зөвлөх Энрике Ортега нар оролцлоо.

-Уул уурхайн салбарыг хэт улстөржүүлэх нь мэргэжлийн байгууллагад тухайлбал, танай Кадастрын албанд хэрхэн сөргөөр нөлөөлдөг вэ?

Т.Бат-Оргил: Аливаа шийдвэр судалгаан дээр үндэслэх ёстой. Гэтэл одоо ярьж байгаа хүмүүсийг ажиглахад судалгаа байтугай наад захын бидэнд байгаа мэдээллийг ч авч хэрэглэхгүй байна. Баримт аваад үзэхэд, нэг хувь хүрэхгүй газар нутагт ашиглалт явуулж байхад, нийт нутаг дэвсгэрийг ухаад онгичоод, зарчихлаа гээд яриад байна.

Манайх судалгааны зориулалттай Статистик, эдийн засгийн тасаг гэж байгуулж буй. Ер нь хэтэрхий улстөржүүлээд бодит тооцоо судалгаан дээр үндэслээгүй шийдвэрүүд гаргах юм бол энэ салбар унаж, Монголын эдийн засагт асар их хор хохирол учирна. Энэ талаар хаа хаанаа их л хариуцлагатай баймаар. Бүх хүн эх орондоо хайртай шүү дээ. Зөвхөн хөдөлгөөнийхөн хайртай, би болохоор харь орны хорлон сүйтгэгч ирчихээд байгаа юм биш. Уул уурхайг улстөржүүлэхээ больж, мэргэжлийн хүмүүс орж эхлэх хэрэгтэй байна.

М.Ганболд: - Уул уурхайн салбар олон улсын практикт яаж хөгжиж ирсэн түүхийг өнөөдрийн нөхцөл байдалтай нь уялдуулж авч үзэхийг хэзээ ч үгүйсгэхгүй. Улс төрийг л аваад хаячихвал энэ салбар эрүүл болох гээд байгаа. Уул уурхайн салбарыг ингэж хэлээд шүүмжилчихвал надад хэдэн санал ирчих болов уу. Ирэх сонгуульд энэ талаар яривал сонгогдчихно гэх явуургүй бодлоор уул уурхайн салбараар тоглоом хийгээд байж таарахгүй.

Я.Содбаатар: - Дотоод дахь ойлголцол маш чухал. Нэг үеэ бодоход ашигт малтмалын үнэ ханш өсөөд, хөрөнгө оруулагчид сонирхож, гадаад орчин таатай болж байна. Эхний ээлжинд улс төрийн намууд, нийгмийн харилцаанд орж байгаа субъектуудын хүрээнд дотоодын ойлголцлыг нэг цэгт хүргэмээр. Тэгэхгүйгээр томоохон орд газруудын шийдэл аль нэг тийш туйлширвал эдийн засагт маш их хохирол учирч болзошгүй.

М.Ганболд: - Мэргэжлийн хүмүүс нь салбараа ярихгүй бол, уул уурхайг эмч, багш, яриад эхлэхээр юу болох вэ. Хэрвээ намайг хүнд мэс засал хий гэвэл алж л таарна биз дээ, өөр яах юм. Бүгдийг хольж хутгаж ойлгож болохгүй. Юугаар тоглож болох, болохгүйгээ бас мэдэж баймаар. Аливаа юманд хэмжээ хязгаар гэж бий. Улс төр бол хэмжээ хязгааргүй болчихлоо л доо.

Энрике Ортега: - Бүх дэлхийн практикийг мэднэ гэж өөрийгөө хэлэхгүй. Гэхдээ 20 орчим орны кадастрын газарт удаан хугацаагаар ажилласан. Мөн тооны орны хууль тогтоомжийг нь бас мэднэ. Миний мэддэг 50-иад улсын хууль тогтоомжид стратегийн орд гэсэн ойлголт байдаггүй. Ази, Африк, АНУ-ын туршлагыг судалсан л даа. Зарим оронд стратегийн орд гэсэн ойлголт байдаг. Сүүлийн 10 гаруй жилд 30 гаруй орон Ашигт малтмалын тухай хуулиа шинэчилсэн. Тэд стратегийн орд биш, ашигт малтмалын минералиудыг хуулиасаа авч хаясан юм.

Я.Содбаатар: - Манай ашигт малтмалын салбарын нэр хүнд дотоод, гадаадад яагаад доошлоод байна вэ гэдэг дээр бодох асуудал нь хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал. Эрх зүйн орчны тодорхойгүй байдлыг цаг алдалгүй засахын төлөө манай яам ажиллаж байгаа. Аль болох олон нийтэд нээлттэй болгох, төр, засгаас хувь хүн болоод ямар нэгэн түшмэлийн оролцоогүй шийдвэр гаргах чиглэлд анхаарч буй. Тиймээс Дэлхийн банктай хамтраад кадастрын төсөл хэрэгжүүлж байгаа. Энэ бол тэнд буй хэн нэгэн түшмэл, аль нэгэн даргаас хамаардаг системийг аль болох багасгах бодлого юм. Эрх зүйн орчныг тогтвортой байлгах асуудал нэн чухал байгаа. Мөн сонгууль болох гэж буйтай холбоотойгоор уралдаад мөнгө амлаад эхэллээ. Амлаад буй тэр их мөнгөнийх нь эх үүсвэр хаана байна вэ гэхээр ашигт малтмалын салбараас хийнэ гээд байгаа. Хэрвээ үнэхээр үүнийг хэрэгжүүлэх гэж байгаа юм бол энэ Парламентаар хуулиа гаргаад, гэрээнүүдээ цаг алдалгүй байгуулах хэрэгтэй.

3. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг хэрхэн сонгодог талаар

Энэхүү мэдээллийг зарим улс орны Үндсэн хууль болон орон нутгийн сонгуулийн тухай хуулиудыг судалж үзсэний үндсэн дээр бэлтгэв. Хууль эрх зүйн хувьд улс бүр өөр өөрийн ялгагдах онцлогтой байна. Япон, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Польш, Бүгд Найрамдах Болгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнуудад орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь бие даан нэрээ дэвшүүлэх, тухайн улс төрийн намууд нэрийг нь дэвшүүлэх зарчмаар явагдаж байна.

Зарим нэг онцлогийг дурьдвал:

- Япон улс нь тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тоон хязгаарыг тогтоож өгдөг.
- БНУУ-д тухайн орон нутагт байнгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх, түүнчлэн Төрийн бус байгууллага нэр дэвшүүлэх эрхтэй.
- БНСУ-д бие даан нэр дэвшигч нь хичнээн хүний гарын үсэг авах болон мөнгөний барьцааг хуульд тодорхой заадаг.
- БНКазахстан улсад тухайн тойргийн сонгуульд өргөдөл гаргаж нэр дэвших, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах зэргийг орон нутгийн сонгуулийн тухай хуулинд зааж өгчээ.

Дээр дурьдсан орон тус бүрийн Үндсэн хуульд хэрхэн тогтоосныг орон тус бүрээр авч үзвэл:

1. Япон улсын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн өөрийн удирдлага/-ийн 92 дугаар зүйлд “Орон нутгийн нийтийн эрх зүйн этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох журмыг орон нутгийн хараат бус байдлын зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно”.

93 дугаар зүйлд “Нийтийн эрх зүйн этгээдийн хурлын гишүүдийг нийтийн, шууд сонгуулиар сонгоно” гэжээ.

Япон улсын Сонгуулийн тухай хуулийн 86 дугаар зүйлд “Парламентад 5-аас доошгүй гишүүнтэй улс төрийн нам, хамгийн сүүлийн сонгуулийн саналын 2-оос доошгүй хувийн саналыг авсан улс төрийн нам нэр дэвшигчийг зарлана. Гэхдээ бие даан нэр дэвшигч дэвшиж болно” гэжээ.

2. Бүгд Найрамдах Унгар Улсын Үндсэн хуулийн Есдүгээр бүлэг /Нутгийн удирдлага/-ийн 42 дугаар зүйлд “Нийслэл хот, коммун болон мужуудын сонгогчид нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох эрхтэй”. Мөн хуулийн 71 дүгээр зүйлд “Парламентын гишүүд нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүд, нийслэл бусад нэгжийн захирагчийг нийт ард түмнээс шууд, нууц, тэгш эрхийн үндсэн сонгоно” гэж заажээ.

БНУУ-ын Сонгуулийн процессийн тухай хуулийн 46 дугаар зүйлд “Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийг санал болгох хуудсаар дэвшүүлэх бөгөөд тухайн тойргийн байнга оршин суудаг сонгогч нь сонгууль болохоос 23 хоногийн өмнө нэрийг нь дэвшүүлнэ” гэжээ. Мөн байгууллагаас орон нутгийн сонгуулд нэр дэвшүүлж болно. Тухайлбал, уг хуулийн 51 дугаар зүйлд Унгар улсын шүүхэд бүртгэлтэй Төрийн бус байгууллага нь нэр дэвшүүлж болохоор заасан байна.

3. Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэг /Нутгийн өөрийн удирдлага/-ийн 59 дүгээр зүйлд “Бүгд найрамдах улсын захиргааны нэгж тус бүрт хуулийн дагуу сонгогдсон гишүүдээс бүрдсэн нутгийн өөрөө удирдах байгууллага байна” гэжээ.

4.Польш улсын Үндсэн хуулийн Долоодугаар бүлэг /Орон нутгийн өөрөө удирдах

байгууллага/-ийн 169 дүгээр зүйлд “Орон нутгийн сонгуулийг нийтээрээ, шууд, тэгш эрхтэй, нууцаар санал хурааж явуулна” гэжээ.

5.Бүгд Найрамдах Болгар улсын Үндсэн хуулийн 136 дугаар зүйлд “Иргэд удирдах үйл ажиллагаанд өөрсдийн сонгож байгуулсан нутгийн төлөөллийн байгууллагаараа уламжлан эсхүл бүх нийтийн санал хураалт болон нийт иргэдийн хурлаар дамжуулан оролцож болно” гэжээ.

6.Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуулийн Долоодугаар бүлэг /Нутгийн өөрийн удирдлага/-ийн 102 дугаар зүйлд “Нутгийн өөрийн удирдах байгууллагын төлөөлөгчдийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно” гэжээ.

7.БНСУ-ын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн засаг захиргаа/ийн 118 дугаар зүйлийн 2 хэсэгт “Орон нутгийн хурлын бүрэн эрх, орон нутгийн захирагч нарын бүрэн эрх, сонгох болон сонгогдох сонгуулийн үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулна” гэжээ.

БНСУ-ын “Орон нутгийн өөрөө удирдах хууль”/1949/-ийн 26, 32 дугаар зүйлд “Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвших гэсэн хоёр хэлбэртэй байна. Хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь 1000-2000 хүний, Иргэдийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь 100-200 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байх ёстой.

Өөрөө удирдах дүүрэг, хот гүний засаг даргад нэр дэвшигч нь 300-500, Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь 50-100 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байна. Нэр дэвшигчийг орон нутгийн сонгуулийн санал хураалтаас 15 хоногийн өмнө бүртгэж, барьцааны мөнгө авна. Хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь /50 сая won/, Иргэдийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч /3 сая won/, Өөрөө удирдах дүүрэг, хот гүний засаг даргад нэр дэвшигч нь /10 сая won/, Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь /2 сая won/ барьцааны мөнгийг төлж, сонгуульд ялбал суутгалаа төлөөд буцааж авах, ялагдвал тодорхой хувийг буцааж авах нөхцөлтэй байна” гэж заажээ.

8.Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн засаг захиргаа ба өөрөө удирдах/-ийн 86 дугаар зүйлд “Орон нутгийн төлөөллийн байгууллагыг Маслихат гэх бөгөөд тухайн орон нутагт хүн амыг төлөөлөх болон нийтийн эрх ашгийг хамгаална”, “Маслихат нь бүх нийтийн, тэгш, нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно” гэжээ.

Тус улсын “Сонгуулийн тухай хууль”-ийн 103 дугаар зүйлд тогтоогдсон журмын дагуу бүртгэгдсэн улсын болон орон нутгийн нэгдлүүд Маслихат нэр дэвшүүлнэ. Мөн иргэд бие даан нэр дэвшиж болно. Маслихатын депутатад иргэн бие даан нэр дэвших бол тойргийн сонгуулийн хороонд нэр дэвших өргөдөл өгнө. Бие даан нэр дэвшигч нэгээс илүү сонгуулийн тойрогт нэр дэвшиж болохгүй. Мөн нэр дэвшигч нь тойргийн сонгуулийн хорооны дансанд мөнгө байрлуулах, уг мөнгийг хэрхэн буцаан авах нөхцөл, нэр дэвшигч түүний эхнэр, нөхрийн хөрөнгө орлогын мэдүүлэг багтана гэж тус тус заажээ.

Эх сурвалж:

- Япон Улсын Үндсэн хууль. Орч П.Амаржаргал, “Адмон” хэвлэл, УБ., 2011
- “Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцох нь” Бодлогын судлагаа шинжилгээ. Х боть, 256-287 х, УБ., 2011

- www.freechoice.jp/electionsystem.pdf
- <http://www.legislationline.org/documents/action/popup/id/5326>
- <http://www.online.bg/law/const/const0.htm>
- http://www.servat.unibe.ch/icl/hu00000_.html
- <http://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm>
- <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/APCITY/UNPAN014593.pdf>
- http://en.wikipedia.org/wiki/Local_elections_in_Poland
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Hungary
- <http://wtd.vlada.cz/scripts/detail.php?id=8073>
- http://korea.assembly.go.kr/res/low_01_read.jsp?boardid=1000000035
- http://www.kazakhstan.orexca.com/kazakhstan_constitution.shtml


4.Орон нутгийн болон УИХ-ын сонгуулийг хамт явуулдаг орнуудын талаар

Парламентын болоод орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь эдийн засгийн үргүй зардлыг хэмнэдэг сайн талтай бөгөөд орчин үед нэлээд орон сонгуулийн энэхүү тогтолцоог сонирхон ярилцаж байна. Өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, Австрали, хөгжиж буй орнуудаас Болгар, Филиппин зэрэг улс сонгуулиудаа зэрэг явуулж эхэлжээ. 2020 гэхэд Европын Холбооны орнууд энэ замаар сонгуулиа зохион байгуулна гэж ажиглагчид үзэж байна. Бельги, ялангуяа Герман улс үүнд илүү анхаарлаа хандуулж байна. Энэхүү лавлагаанд Филиппин улсын туршлагыг дэлгэрэнгүй судалж, бусад орнуудын мэдээллийг нэмж тусгав.

Филиппин улсын туршлага: Тус улс нь сонгуулиа зэрэг явуулахдаа бүрэн автомажсан санал хураалтын технологийг хэрэглэж байгаа нь ардчилсан, шударга сонгуулийн загварыг Өмнөд Азид түгээсэн чухал алхам болжээ. Тус улсын Парламент нь 2 танхимтай бөгөөд Сенат нь 26, Конгресс нь 286 гишүүнтэй. Филиппиний Үндсэн хуулийн 18-р бүлгийн 1-р хэсэгт “Орон нутгийн сонгууль нь Конгрессийн гишүүдийн сонгуультай нэг зэрэг явагдах бөгөөд орон нутгийн сонгуульд хотын бүх гишүүд болон нийслэл Манила орчмын хотуудын захирагч нарын сонгууль багтана” гэж заажээ. Мөн хуулийн 8-р хэсэгт “Орон нутгийн сонгогддог албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа 3 жил бөгөөд 3 хүртэл удаагаар улиран сонгогдож болно” гэжээ.

Филиппин улс нь сонгууль явуулах арга технологиороо хөгжиж буй орнуудын хувьд туршлага өндөртэй орнуудын тоонд зүй ёсоор ордог. Сонгуулийн хороо /COMELEC/ нь санал хураалтын автоматжуулалт, санал хураах байрны зохион байгуулалтад анхаарч, гадаадад байгаа өөрийн улсын иргэдийг тус байгууллагын вэб сайтаар онлайн хэлбэрээр санал авах зэргээр сонгуулийг хүртээмжтэй, шударга, чөлөөтэй явуулж санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргадаг байна.

Сонгуулийн хороо нь Дарга, хоёр Гүйцэтгэх захирал, 16 орон нутгийн салбарын захирал, 79 зөвлөх менежер, 1609 ажилтантай. 1992 оноос эхлэн тус байгууллага нь санал хураах үйл явцыг автоматжуулж эхэлсэн бөгөөд Optical Mark Reader (OMR) технологийг 1996 оны сонгуульд анх удаа амжилттай туршжээ. 1996 оноос хойш гар аргаар болон автомат хосолсон замаар санал хурааж байсан бол 2010 оноос эхлэн бүрэн автомажсан технологи ашиглаж байна. Санал хураалт, тооллогын автомат машиныг доори зургаас харж болно.



Тус улсад сургуулийн бүх ангид санал хураах хэсгийн хороог ажиллуулж, модем бүхий машиныг мөн байрлуулсан байдаг. Нэг хэсэгт ойролцоогоор 200 сонгогчийн саналыг авна. Иймээс санал хураалт шуурхай болдог байна. Хэсгийн хорооны ажиглагчид дугаараа өгч, нэр хаяг мэдээллээ шалгуулж сонгуулийн хэсгийн ажилтан нь EDCVL системд мэдээлэл байгаа эсэхийг зураг, гарын үсэг, баримт бичгийг үзсэнээр баталгаажуулсаны дараа нэрийг нь чангаар дуудна. Хумсанд өмнө нь санал өгсөн тэмдэглэгээ байгаа эсэхийг нягталсаны дараа хэрхэн саналаа тэмдэглэхийг зааж өгнө. Хэсгийн хорооны дарга биечлэн саналын хуудсыг өгнө.

Сонгогч саналын хуудасны нууц дэвтэр, тэмдэглэх үзэг ашиглан зааврын дагуу өөрийн сонгох нэр дэвшигч ба намын нэрийг бүтэн тэмдэглэж саналын хуудсыг PCOS машинд оруулж уншуулахад дэлгэцэн дээр “ТАНЫ СОНГОЛТ БҮРТГЭГДЛЭЭ” гэсэн үг гарч ирнэ. Саналын нууц дэвтэр үзгийг даргад буцааж өгч, хумсан дээрээ тэмдэглэгээ хийлгэснээр санал өгөх процесс дуусна. Санал авч дууссаны дараа машины “Санал хураахыг дуусгах”

гэсэн цэсийг сонгож ДҮНГ ГАРГАХ гэсэн цэсийг идэвхижүүлж санал хураалтын дүнг нэр дэвшигчид, намын нэрсийг сонгогдох албан тушаалын нэрээр нь ангилж 8 хувь хэвлэж гаргаад, хэсгийн хорооны дарга, гишүүд гарын үсэг зурна. Дараа нь машины “Дүнг дамжуулах” цэсийг сонгож төв сонгуулийн хороо руу илгээнэ. Ийнхүү Филиппин улсад санал хураалт бүрэн автоматжсан аргаар явагдаж байгаа нь сонгуулийн зөрчил булхай гарах асуудлыг зогсоож чадсан байна.

Эх сурвалж: http://www.comelec.gov.ph/statistics/2010natl_local/toc.html

Парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг зарим орны мэдээлэл

Улс орон	Сонгуулиудаа зэрэг явуулдаг талаарх мэдээлэл
Болгар	7.2 сая хүн амтай Болгар улсын хувьд хамгийн сүүлд 2011 оны 10 дугаар сарын 23-нд Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулсан байна. 2011 оны 2-р сард сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулсан. Сонгуулийн хороо нь 5 жилийн хугацаатайгаар томилогдож 21 гишүүдээс бүрдсэн. Сонгуулийн хэсгийн хороо нь 1000 хүртэл сонгогчдыг авдаг. Эрүүгийн хуулиндаа 2011 оны 4-р сард өөрчлөлт оруулж, хэвлэл мэдээллийн байгууллагын сонгуулийн үед баримтлах зарчим, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлсэн байна. Эх сурвалж: http://www.osce.org/odihr/elections/83959
Индонез	2009 онд тус улс нь үндэсний, муж, дүүргийн сонгуулийг амжилттайгаар нэг зэрэг явуулсан нь Зүүн Өмнөд Азид ардчиллыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. 2008 оноос эхлэн эдгээр сонгуулийг зэрэг явуулах талаар парламентын гишүүд эсрэг байр суурьтай байсан ч сонгуулийг зэрэг явуулж чадсан байна. 2008 онд Сонгуулийн тухай хуулиндаа хагас нээлттэй пропорциональ систем, босгыг 2,5 гэж оруулсан зэрэг нь ардчилсан алхам болсон байна. Эх сурвалж: http://www.google.mn/#hl=mn&source=hp&q=Indonesia+simultaneous+election+law&btnG=Google+%D0%A5%D0%B0%D0%B9%D0%BB%D1%82&bav=cf.osb&fp=351315cd2d2e33d5&biw=1024&bih=636
Тайвань	Тус улс нь 2012 оны Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийг зэрэг явуулах болсон. Энэ нь улс төрийн зорилгогүй бөгөөд нийгмийн зардлыг багасгах, улс төрийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, мөн 500 сая тайвань долларыг хэмнэх бололцоотой гэж Сонгуулийн төв хорооны дарга Чанг мэдэгдсэн байна. Эх сурвалж: http://www.taipeitimes.com/News/front/archives/2011/04/20/2003501206
АНУ	Холбооны болон муж улсын сонгуулиудыг 1975 оноос хойш зэрэг явуулдаг болсон нь эдийн засгийн асар их хэмнэлтийг авчирсан. Муж улсууд нэг л удаа сонгуулийг явуулдаг. Эх сурвалж: The Truth of the Matter, By Gough Whitlam http://books.google.mn/books?id=bQTtYL3KKgcC&pg=PR26&lpg=PR26&dq=simultaneous+elections+in+USA&source=bl&ots=MrBroGpywT&sig=EITkpvsWifFOQIzeMhdgqAuzyI&hl=mn&ei=-8etTvWSAYqqiALQ5PivCw&sa=X&oi=book_result&ct=result&resnum=3&ved=0CCYQ6AEwAg#v=onepage&q=simultaneous%20elections%20in%20USA&f=false
Австрали	Сонгуулиудыг нэг өдөр явуулах Америкийн загварыг Австрали улс дагаж Сенат болон Төлөөлөгчдийн хоёр танхимын сонгуулийг зэрэг явуулдаг болжээ. Бүх нийтийн санал асуулгаар хэд хэдэн удаа энэ асуудлыг эсэргүүцэж байсан байна.



**НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН
ОРОЛЦОО, ҮҮРЭГ, НӨЛӨӨ, ГИШҮҮДИЙН ОРОН НУТГИЙН ХУРАЛД НЭР ДЭВШИХ ЭРХ, УЛС
ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТУХАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

П. Амаржаргал, К. Пүрэвсүрэн

Гарчиг

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх тухай
2. Зарим орнуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн тухай
3. Орон нутгийн сонгууль болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намуудын оролцоо
4. Улс төрийн намуудын гишүүнчлэл
5. Ашигласан материал

* * *

Улсын Их Хурлын дэд дарга Г. Батхүүгийн захиалгаар “Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намын оролцоо, үүрэг, нөлөө, улс төрийн намуудын гишүүнчлэл, гишүүдийн орон нутгийн хуралд нэр дэвших эрхийн тухай” харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ. Уг судалгааг Австри, Австрали, АНУ, Герман, Дани, Ирланд, Испани, Их Британи, Казахстан, Канад, Мексик, Молдов, Нидерланд, ОХУ, Польш, Словени, Солонгос, Унгар, Франц, Чили, Швед, Швейцарь, Эстони, Япон зэрэг улсуудын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, мэдээлэл, судалгааны материалд үндэслэн хийсэн болно. Хэрэв шаардлагатай гэж үзвэл бусад нэмэлт мэдээллийг өмнө хийгдсэн судалгааны эмхтгэлүүдээс авч үзэж болно.

Нэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх тухай

Нэгдүгээр хэсгийг орон нутгийн сонгуулийн тогтолцоонд улс төрийн намууд хэрхэн оролцох оролцоо, орон нутгийн хурлын үйл ажиллагаанд нэр дэвших эрх, улс төрийн намаас нэр дэвшүүлэх эрх зэрэг асуудлаар судалгаанд хамрагдсан улс орнуудыг харьцуулан үзүүлэв.

Холбогдох хууль тогтоомжийг судлан үзэхэд орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх ажиллагааг, тухайлбал, Япон, Унгар, Бангладеш, Польш, Болгар, Чех, Казахстан, Бүгд Найрамдах Солонгос зэрэг улсуудад бие даан нэр дэвшүүлэх, улс төрийн намуудаас нэр дэвшүүлэх болон тодорхой тооны сонгогчдоос нэр дэвшүүлэх зарчмаар явагдаж байна.

Зарим нэг улсын онцлог зохицуулалтыг дурьдвал:

- Япон Улсад тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тоон хязгаарыг тогтоож өгдөг.
- БНУУ -д тухайн орон нутагт байнгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх, түүнчлэн Төрийн бус байгууллага нэр дэвшүүлэх эрхтэй.
- БНСУ -д бие даан нэр дэвшигч нь хичнээн хүний гарын үсэг авах болон мөнгөний барьцааг хуульд тодорхой заасан байдаг.
- БНКазахстан Улсад тухайн тойргийн сонгуульд өргөдөл гаргаж нэр дэвших, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах зэрэг асуудлыг Орон нутгийн сонгуулийн тухай хуульд зааж өгчээ.

Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх хэлбэрүүд:

Улсын нэр	Намаас	Сонгогчдоос	Олон нийтийн байгууллагаас	Бие даан
Австрали		+		
Австри	+			
АНУ	+	+		
Герман	+	+		
Испани	+			
Казахстан	+			+
Канад	+	+		
Словени	+			+
Солонгос	+			+
Унгар	+	+	+	+
Франц	+			
Чили	+			+
Швейцарь	+			
Япон	+			+

Эндээс үзвэл сонгуульд нэр дэвшүүлэх хэд хэдэн аргыг улс орнуудад хэрэглэж байна:

- зөвхөн улс төрийн намууд нэр дэвшүүлэх,
- зөвхөн тодорхой тооноос доошгүй бүртгэгдсэн сонгогчид нэр дэвшүүлэх,
- улс төрийн намууд ба тодорхой тооны бүртгэгдсэн сонгогчид хамтран нэр дэвшүүлэх.

Тухайлбал, Канадад нэр дэвшүүлэх баримт бичигт зөвхөн сонгогчдийн нэрсийн жагсаалтад бүртгэлтэй хоёр сонгогчийн гарын үсэг байхад хангалттай байдаг бол, Австралид нэр дэвшүүлэх өргөдөлд сонгогчдийн нэрсийн жагсаалтад бүртгэлтэй арван сонгогч гарын үсэг зурсан байх хэрэгтэй бөгөөд эдгээрийн нэг нь нэр дэвшүүлэгч, нэг нь нэр дэвшүүлэгчийн саналыг дэмжигч, үлдсэн найм нь нэр дэвшигчийг дэмжихийг зөвшөөрсөн мөн жагсаалтад бүртгэлтэй сонгогч байна.

АНУ-д улс төрийн намууд нэр дэвшүүлэхийн тулд тодорхой тооноос доошгүй бүртгэгдсэн сонгогчдын гарын үсэг цуглуулсан байх хэрэгтэй (Иллинойст 25 мянга, Нью-Йоркт 20 мянга, Охайо, Алабамад 5 мянга г.м.). Гэхдээ АНУ-д ихэнх орон нутгийн сонгууль улс төрийн намуудын оролцоогүй явагддагийг санах хэрэгтэй.

ХБНГУ-д Бундестагт суудалгүй боловч аль нэг муж улсын Ландтагт сүүлийн сонгуулиар таваас доошгүй суудал авсан улс төрийн нам сонгуулийн кампанид оролцох хүсэлтээ сонгуулийн удирдагчид мэдэгдэж, үүнийг нь үндэслэн холбооны сонгуулийн хороо уг байгууллагыг улс төрийн намын шинжтэй гэж үзсэн тохиолдолд уг нам сонгуульд нэр дэвшүүлж болно. Үүнээс гадна парламентад суудалгүй нам өөрийн нэр дэвшигчээ нэр дэвшүүлж буй тойрог бүрт 200-гаас доошгүй, нэр дэвшигчдийн жагсаалтаа дэвшүүлж буй

муж улс бүрт 1000-аас доошгүй сонгогчдын гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг байна.

Хоёр. Зарим орнуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн тухай

Канад Улс

Канад Улс нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс. Канадын нутаг дэвсгэр том боловч Канадын Сонгуулийн байгууллага бүхэлдээ төвлөрсөн шинжтэй байдаг бөгөөд алба салбарууд нь нийслэл Оттава хотдоо байрладаг. Бүтцийн хувьд 308 тойргоос бүрддэг. Сонгуулийн тойргуудыг арван жил тутам явагддаг хүн амын тооллогын дүнг үндэслэн өөрчлөн шинэчилдэг байна.

Намууд нь төв, орон нутгийн салбаруудад хуваагддаг. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлдэг байна. Канадын Сонгуулийн хуулийн 6-р бүлгийн 65, 66 дугаар зүйлд нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын талаар заасан байна. 1970 оны өөрчлөлтөөр сонгуулийн сонгох эрхийг 21 нас хүрсэн иргэд эдэлдэг байсныг 18 нас болгосон байна.

Намаас тойрог бүрт зөвхөн нэг нэр дэвшигчийг батлан гарын үсэг зурж болно. (*Сонгуулийн хуулийн 68 дугаар зүйл*) Тухайн сонгуулийн тойрогт эвсэл, намаас дэвшигч нас барсан эсвэл нэрийг татан авсан бол 74.1-т заасны дагуу өөр нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх өдөр дуусахаас өмнө нэр дэвшүүлж болно. (*Сонгуулийн хуулийн 68-2 дугаар зүйл*)

Олон намын тогтолцоонд суурилсан Сонгуулийн менежментийн байгууллагын гишүүд улс төрийн намуудын төлөөлөгчдийн үүрэг гүйцэтгэхийнхээ зэрэгцээ сонгуулийн үйл явцыг төвийг сахих зарчмын дагуу явуулж, өөрийг нь томилсон намын эрх ашгийг хамгаална. Тэд өөрсдийг нь томилсон намын эрх ашгийг хамгаалахаас гадна өөрийнхөөсөө бусад намын эрх ашгийг давуу байлгахгүйн төлөө ажиллана.

Чили Улс

Чили нь 15 регион, 51 провинц, 346 муниципалитет, коммунаас бүрдсэн унитар улс юм. Чили Улсын Үндсэн Хууль, Сонгуулийн тогтолцооны органик хууль-18.556 (1986), Орон нутгийн органик хууль-18.695 (2006), Улс төрийн намуудын тухай хууль-18.603 /1987/ зэрэг хуулиудаар орон нутгийн сонгуулийн процедурыг зохицуулна.

Парламентын болон орон нутгийн аль алиных нь сонгуульд нам, эвсэл, бие даагчдын зүгээс тойрог бүрт дээд тал нь хоёр хүний нэр дэвшүүлсэн жагсаалтыг гаргаж өгдөг байна. Сонгогчид өөрсдийн шилж сонгосон нэр дэвшигчийнхээ төлөө санал өгдөг. Эхний суудлыг нийт дүнгээр хамгийн олон санал авсан жагсаалтад багтсан нэр дэвшигчдэд өгдөг. Нэг тойргийн хоёр суудлын хоёуланг авахын тулд хамгийн амжилттай өрсөлдөгчдийн санал нь хоёр дахь жагсаалтад өгсөн саналаас хоёр дахин их байх ёстой. Энэ тогтолцоонд тавьдаг босго маш өндөр учраас намууд сонгуульд эвсэл болон оролцох шаардлагатай болдог байна. Тухайн жагсаалтаар нэг суудал авахын тулд нийт саналын 33,4 хувийн санал авсан байх шаардлагатай. Харин хоёр суудлын хоёуланг баталгаатай авахын тулд нийт саналын 66,7 хувийг авсан байх хэрэгтэй.

Сонгуулийн бином (binomial) тогтолцооны үр дүнд бараг бүх дүүргээс Концертационы нэг төлөөлөгч, Чилийн Альянсаас нэг төлөөлөгч сонгогддог байна. Энэ тогтолцоонд нэг жагсаалтаас нэг суудлын төлөө өрсөлдөж байгаа хоёр нэр дэвшигчийн хооронд өрсөлдөөн явагдах боломжтой ч практик дээр аль аль эвсэлд байгаа элитүүдийн байр сууринаас болж энэ байдал ихээхэн хязгаарлагддаг.

Энэ тогтолцооны давтагдашгүй онцлог бол практик дээр хамгийн том олонхийг бус хамгийн том цөөнхийг дэмждэг явдал юм. Энэ бол мажоритар буюу олонхийн тогтолцоо биш. Харин нийт саналын 34 хувийг авсан сонгуулийн жагсаалт нийт суудлын тал хувийг авах боломж олгодог учраас хувь тэнцүүлэх механизм ашигладаг боловч пропорциональ бус үр дүн гаргадаг тогтолцоо юм. Яагаад ийм гажуудал гараад байгаагийн гол шалтгаан нь сонгуулийн өрсөлдөөнд тавьдаг хязгаарлалтуудтай холбоотой. Энэхүү сонгуулийн тогтолцоо нь хэд хэдэн үндэслэлээр шүүмжлэл өртөж ирсэн. Нэгдүгээрт, намууд нэг суудал авахын тулд маш өндөр босго давах ёстой болдог учраас сонгуульд заавал эвсэж орохыг хүчээр шаарддаг.

Хоёрдугаарт, ихэвчлэн эвсэл бүр нэг суудал авдаг учраас жинхэнэ өрсөлдөөн хоёр сөргөлдөгч эвсэл ба тэдний намуудын хооронд явагдахын оронд нэг эвслийн гишүүн намуудын хооронд явагддаг байна. Энэхүү маргаан нь эвслийн эв нэгдэл, тогтвортой байдалд эрсдэл учруулж байдаг. Дөрөвдүгээрт, энэ тогтолцоо нь намын удирдлагуудад асар их эрх мэдэл олгосноос тэд бараг жагсаалт хийж байх явцдаа л ялагчдыг сонгочихдог байна. Олон тойрогт жинхэнэ өрсөлдөөн явагддаггүй учраас сонгогчид сонгуульд оролцох сонирхол муутай байгаад зогсохгүй өөрийнх нь дэмждэг намаас нэр дэвшигч байхгүй бол бүр ч сонирхолгүй болдог ажээ.

Одоогийн сонгуулийн тогтолцоотой холбоотой өөр нэг асуудал бол сонгогчоор бүртгүүлэх эсэх нь сайн дурын боловч саналаа заавал өгөх шаардлага тавьдаг явдал юм.

Франц Улс

Франц Улс нь засаг захиргааны нэгжийн хувьд 22 муж, 96 департамент, 342 дүүрэг, 3,883 кантон, 36,686 коммунд тус тус хуваагддаг байна. Францын улс төрийн намууд нь зохион байгуулалтын үндэсний хэмжээний буюу төв, орон нутгийн хэмжээний буюу салбаруудад хуваагдана. Намын салбар хорооны гишүүд тухайн орон нутгийн зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлнэ.

Муж зөвлөл, департамент болон кантоны Ерөнхий зөвлөлийн сонгуульд нэр дэвшигчид тавигдах дараах шаардлагуудыг хуульд заасан байна:

- 18 ба түүнээс дээш настай,
- франц үндэстэн,
- мужийн сонгуулийн бүртгэлд бүртгэлтэй,
- хамгийн багадаа сүүлийн таван жил татвар төлсөн.

Эдгээрээс гадна сонгуульд нэр дэвшиж болохгүй тохиолдолыг Сонгуулийн тухай хуульд тодорхой заасан байна. Тухайлбал, төрийн зарим албан тушаалтан, тухайлбал, мужид Засгийн газрыг төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтан сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хориглосон байна.

Франц Улс бол улс төрд жендерийн тэгш байдлыг хангах талаар хуульчилсан анхны улс. Жендерийн тэгш байдлыг хангах харилцааг хангах үүднээс 2000 онд баталсан Жендерийн тэгш байдлын тухай хуульд дараах гол нөхцөлийг тусгасан байна. Энэ нь бүх сонгуулийг үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг заавал хангах тухай зарчим бөгөөд үүнийг тухайн сонгуулиас хамаарч янз бүрээр хэрэгжүүлнэ. Тухайлбал, 3500-аас дээш оршин суугчидтай коммуны ба мужийн зөвлөлийн сонгууль, Корсикагийн Ассамблейн сонгуульд нэр дэвшигчдийн тал хувь нь заавал эмэгтэй байх ёстой.

Испани Улс

Испанийн Үндсэн хуулийн 13.2, 23, 140.1 болон 141 дүгээр зүйл; Сонгуулийн ерөнхий тогтолцоо органик хууль 5/1985; Улс төрийн намуудийн санхүүжилт Органик хууль 3/1987; Орон нутгийн бүтцийг зохицуулсан хууль 7/1985; Улс төрийн намуудын тухай Органик хууль 6/2002 зэрэг эдгээр хуулиудаар орон нутгийн сонгууль түүний процедурийг зохицуулдаг байна. Үндсэн хуулийн 13.2 болон 23 дугаар зүйлээр сонгох болон сонгогдох эрхийн үндсийг заасан.

Испани бол нутаг дэвсгэрийн зарчмын үндсэн дээр эрх мэдэл хуваарилан төвлөрлийг сааруулсан, бие даасан засаг захиргааны тогтолцоотой улс юм. *3 түвшний сонгуультай:*

- Үндэсний түвшний сонгууль (Конгресс),
- Өөртөө засах орны сонгууль (17 өөртөө засах коммунийн хууль тогтоох байгууллагыг сонгох),
- Орон нутгийн түвшний сонгууль

Сонгууль, санал асуулгыг Сонгуулийн тухай хуулийн дагуу бүх түвшний сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Сонгуулийн төв зөвлөлийн хяналтын дор өөртөө засах орон, орон нутаг, бүсийн сонгуулийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулдаг.

Испани улсын орон нутгийн сонгууль нь сонгуулийн хувь тэнцүүлсэн системн дагуу явагддаг. Сонгууль 4 жил тутамд болдог ба ойролцоогоор 66,000 орчим төлөөлөгчид орон нутагт сонгогддог байна. Улс төрийн намууд, Холбоо эвсэлүүд орон нутгийн сонгуульд оролцохоор бол Сонгуулийн Зөвлөлд сонгууль зарласанаас хойшхи 9 дэх өдрөөс өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, 15-20 хоногт нэр дэвшигчдийг танилцуулна. Улс төрийн нам нь дангаараа болон бусад улс төрийн намуудтай эвсэл байгуулан оролцож болно.

Тухайн улс төрийн нам, намуудын эвсэл болон холбоодоос ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалт дахь нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан байх ёстой (40 дүгээр зүйл-Сонгуулийн Ерөнхий тогтолцооны Органик хууль) бөгөөд энэ нь 3000-аас доош хүн амтай орон нутагт хамаардаггүй. Тус улсын иргэд, тухайн орон нутагт амьдарч буй Европын Холбооны иргэд болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн иргэд сонгууль өгөх эрхтэй. Тус улс дахь улс төрийн намууд төвийг сахих зарчим, мэргэжлийн ур чадварын өндөр стандартыг хангах зорилгоор Сонгуулийн менежментын байгууллагад өндөр нэр хүндтэй хүмүүсийг томилдог бөгөөд ийм тохиолдолд гишүүд намуудын төлөөлөгч маягаар ажилладаггүй. Мөн түүнчлэн улс төрийн намуудтай харилцах харилцаагаа хялбаршуулахын тулд сонгуулийн эхний үеэс улс төрийн нам бүрээс Сонгуулийн төв зөвлөл, доод шатны сонгуулийн зөвлөлтэй харилцах ерөнхий төлөөлөгчийг томилуулж, улс төрийн намууд болон Сонгуулийн зөвлөлийн хооронд холбоо барих үүрэгтэйгээр ажиллуулдаг байна.

Хэрэв сонгогдсон төлөөлөгч нас барсан болон бүрэн эрхээ алдсан тохиолдолд жагсаалтад дараагийн өндөр санал авсан нэр дэвшигч төлөөлөгч болно. Сонгуулийн кампанит ажил сонгууль зарласны 38 дахь хоногт эхэлж 15 хоног үргэлжилнэ.

Словени Улс

Бүгд Найрамдах Словени Улсын нутгийн удирдлагын эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хууль, Орон нутгийн сонгуулийн тухай хууль зэрэг холбогдох бусад хууль тогтоомжоор (*Сонгуулийн хууль болон Улс төрийн намын тухай хууль гэх мэт 10 орчим*) зохицуулагддаг байна.

Орон нутгийн сонгуулийг Орон нутгийн сонгуулийн тухай хууль болон Орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулиар зохицуулна. Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар “Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал”, засаг дарга, бүсийн зөвлөл болон хотын зөвлөлүүд, тосгон болон дүүргийн коммуныг сонгох сонгуулийн үйл явцыг зохицуулна. Ерөнхий орон нутгийн зөвлөлийн сонгууль нь 4 жил тутамд явагдах ба шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө зарлан явуулж болно. Орон нутгийн ердийн сонгуулийг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч, харин эрт (*early*) буюу хуулийн хугацаанаас өмнө явуулах дахин болон нөхөн сонгуулийг хотын захирагч зарлана.

Тухайн орон нутагт оршин суугч Словени улсын насанд хүрсэн бүх иргэн сонгуульд саналаа өгөх эрхтэй. Орон нутгийн сонгуулийн хуулийн дагуу 12-оос бага гишүүн бүхий “Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал”-ын (*Төлөөлөгчдийн хурал гэх*) мажоритар системээр, харин 12-оос олон гишүүн бүхий Төлөөлөгчдийн хуралд пропорциональ системээр сонгууль явагдана. Түүнчлэн, иргэд нь бие даан нэр дэвшигчдийг мажоритар системээр сонгох бөгөөд харин нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох тохиолдолд пропорциональ системээр сонгуулийг явуулна.

Хэрэв нэр дэвшигчдийн аль аль нь шаардлагатай олонхийн саналыг авч чадаагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг 2 дугаар шатанд өрсөлдүүлнэ. Нэр дэвшигчид болон нэр дэвшигчдийн жагсаалтад улс төрийн намууд, эсвэл сонгуулийн нэгж дэх сонгогчид гарын үсэг зурснаар тухайн нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх боломжтой болно.

Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогчид нь санал асуулгаар болон сонгогчдын хурлаар нэр дэвшигчдийг нэрлэж болно. Сонгогчдын хурлаар нэрлэж байгаа тохиолдолд сонгогчид тухайн хүнийг нэр дэвшигчид өрсөлдүүлэхээр санал оруулж, хурлаар хэлэлцэн сонгогдсон тохиолдолд нэр дэвшинэ. Сонгогч тус бүр хамгийн дээд тал нь Төлөөлөгчдийн хурал дахь суудлын тоогоор нэр дэвшигч санал болгох эрхтэй. Бие даан нэр дэвшигч нь хамгийн багадаа 30 санал, хэрэв сонгуулийн нэгж нь 500-аас бага оршин суугчидтай бол хамгийн багадаа 50 (оршин суугчийн) санал авснаар нэр дэвшигчийн эрхтэй болно.

БНСловени Улсын орон нутгийн сонгууль нь Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар зохицуулагдана.

Мажоритар системээр явагдах сонгуульд нэр дэвших.

Мажоритар зарчмын дагуу Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчдийг аймаг, нийслэлд улс төрийн намууд, харин сонгуулийн нэгжид сонгогчид нэр дэвшүүлнэ. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал дахь Итали, Унгар үндэстний төлөөллийг тухайн коммуны төлөөлөл болох 15-аас доошгүй хүний гарын үсэгтэйгээр санал болгосноор сонгогчид нэр дэвшүүлнэ. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурал дахь Цыган үндэстний төлөөллийг тухайн коммуны сонгогчид нэр дэвшүүлнэ.

Сонгуулийн нэгж тус бүр дээр улс төрийн намууд өөрийн нэр дэвшигчдийг Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлж болно. Улс төрийн намууд нэр дэвшигчийг сонгохдоо өөрсдийн тогтоосон дүрмийн дагуу сонгоно. Зөвхөн тухайн сонгуулийн нэгжид оршин суугч сонгуулийн эрх бүхий намын гишүүд нэр дэвшигчийг тодруулахад оролцоно. Нэр дэвшигчийг нууц санал хураалтаар сонгоно. Сонгогчид нэр дэвшигчийг гарын үсэг цуглуулж, эсвэл сонгогчдын хурлаар тодруулна. Сонгуулийн нэгж тус бүр дээр Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвших хүмүүсийг тухайн нэгжид байнга оршин суух 15-аас доошгүй сонгогчийн гарын үсэгтэйгээр тодруулна.

Пропорциональ системээр явагдах сонгуульд нэр дэвших.

Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвших хүмүүсийн нэрсийн жагсаалтыг аймаг, нийслэлд улс төрийн нам, сонгуулийн нэгжид сонгогчид гаргана. Жагсаалт тус бүр дэх нэр дэвшигчдийн тоо нь хамгийн ихдээ тухайн нэгжид оногдох Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн хурлын суудлын тоотой тэнцүү байна. Улс төрийн намууд сонгуулийн нэгж болгон дээр нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж болно. Сонгуулийн нэгж тус бүр дээр сонгогчид Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн 54-р зүйлд заасан тооны сонгогчийн гарын үсэгтэйгээр нэр дэвшигчдийн жагсаалт гаргаж болно. Нэг сонгогчийн групп нь зөвхөн нэг жагсаалт гаргах эрхтэй байна.

БНСУ

Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь нам эвслээс, бие даан гэсэн хоёр хэлбэрээр нэр дэвшинэ. Өргөтгөсөн хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь 1000-2000 хүн, ИТХ-д нэр дэвшигч нь 100-200 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байх ёстой. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний засаг даргад нэр дэвшигч нь 300-500, ИТХ-д нэр дэвшиж байгаа бол 50-100 хүний дэмжлэгийг авна. Нэр дэвшигчдийг санал хураалт болохоос 15 хоногийн өмнө хоёр хоног, өглөө 9-17 цагийн хооронд бүртгэнэ. Орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэхдээ дараах хэмжээний барьцааны мөнгийг авдаг.

Сонгуулийн төрөл	Барьцааны мөнгө /вон/
Өргөтгөсөн хот, мужийн захирагч	50 сая
Өргөтгөсөн хот, мужийн ИТХ	3 сая
Өөртөө засах дүүрэг, хот, гүний ЗД	10 сая
Өөртөө засах дүүрэг, хот, гүний ИТХ	2 сая

Дээрхи барьцааны мөнгийг сонгуульд сонгогдсон тохиолдолд суутгалаа төлөөд буцааж авах, сонгогдоогүй тохиолдолд тодорхой хувийг буцааж авах нөхцөлтэй байдаг. Хэрэв нэр дэвшигч сонгогдох, нас нөгчих, хүчинтэй саналын хуудас 100-ны 15 хувиас дээш байвал үндсэн зардлыг нь хасаад эргүүлж өгнө. Харин хүчинтэй саналын хуудасны тоо 100-ны 10 хувиас дээш, 15 хувиас доош байвал барьцааны мөнгөний 50 хувийг буцааж олгоно.

Орон нутгийн сонгуульд албаны бүрэн эрхийн хугацаа 4 жил. Хуульд заасны дагуу шинэ захирагчийн бүрэн эрхийн хугацаа 7 сарын 1-ээс эхэлдэг. Сонгуулийн санал хураах өдрийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, лхагва гарагт байхаар тохируулна. Сонгуулийн сурталчилгаа 14 хоног байна.

Сонгуульд ялагчийг дараах зарчмаар тодруулна.

1. Өргөтгөсөн хот, мужийн захирагч болон өөрөө удирдах дүүрэг, хот, гүний засаг даргын сонгуульд олонхийн санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Хэрэв 2 ба түүнээс дээш нэр дэвшигчийн саналын тоо тэнцвэл насны эрэмбээр шийдвэрлэнэ. Санал хураах цаг дуустал ганц нэр дэвшигч байвал нийт сонгогчдын 1/3 хувийн санал авч байж сонгогдсонд тооцогдоно.
2. Өөрөө удирдах дүүрэг, хот, гүний ИТХ-д нэр дэвшигчдээс олонхийн санал авсан эрэмбээр нийт ИТХ-ын тоонд нийцүүлэн сонгоно.
3. Орон нутгийн ИТХ-ын пропорциональ төлөөллийн сонгуульд 100-ны 5-аас дээш хувийн санал авсан нам суудал хуваарилуулж авах эрхтэй. Гэхдээ нийт суудлын 2/3-оос илүүг хуваарилахгүй.

Унгар Улс

Энэ 2010 онд БНУУ-ын Улсын хурал “Орон нутгийн хурлын төлөөлөгчид ба засаг даргыг сонгох тухай” 1990 оны LXIV (64 дүгээр) хуулиа Европын холбооноос гишүүн орнууддаа гаргасан зөвлөмжийг харгалзан шинэчлэн баталжээ. Ингэснээр 15 бүлэг, 63 зүйл, 5 хавсралт бүхий хуулиа 6 бүлэг, 25 зүйлтэй болгон өөрчилжээ. Орон нутгийн хурлын төлөөлөгчдийн тоог цөөрүүлж, сонгуулийн компанийн хугацааг багасгасан байна. Сонгуулийн кампанийн үргэлжлэх хугацааг 60 хоногоор тогтоожээ.

Нутгийн хурлын төлөөлөгчдийн тоо нь оршин суугчдын тооноос хамаарна. 10 мянга хүртэл оршин суугчидтай хот, тосгон хүн амаасаа хамаарч 2-8 төлөөлөгчийг шууд нэрсээр сонгох бол 10 мянгаас дээш хүн амтай хот, суурин газрууд хүн амынхаа тооноос хамааран тодорхой тооны төлөөлөгчдийг шууд нэрсээр сонгохоос гадна нэр дэвшээд сонгогдоогүй хүмүүсийн авсан саналын тоотой пропорционалиар саналын компенсацийн жагсаалтаар сонгоно. Гэхдээ энэ компенсацийн жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчдийн тоо нь шууд сонгогдсон төлөөлөгчдийн тооны 50 хувиас хэтрэхгүй.

БНУУ-ын Сонгуулийн процессийн тухай хуулийн 46 дугаар зүйлд “Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийг санал болгох хуудсаар нэр дэвшүүлэх бөгөөд тухайн тойргийн байнга оршин суудаг сонгогч нь сонгууль болохоос 23 хоногийн өмнө нэрийг нь дэвшүүлнэ” гэжээ. Мөн байгууллагаас орон нутгийн сонгуулд нэр дэвшүүлж болно. Тухайлбал, уг хуулийн 51 дүгээр зүйлд Унгар Улсын шүүхэд бүртгэлтэй Төрийн бус байгууллага нь нэр дэвшүүлж болохоор заасан байна.

Нэрсийн ба компенсацийн жагсаалт

Мужаас дооших нутаг дэвсгэрийн нэгжид мажоритараар сонгууль явуулах үед гишүүн сонгох болон засаг дарга сонгох нэр дэвшигчдийн нэг нэг жагсаалт байх бөгөөд нэр дэвшигч зөвхөн аль нэгд нь нэрээ дэвшүүлнэ.

Холимог системээр явагдах сонгуульд мужаас дооших нутаг дэвсгэрийн нэгж болон муж, мужийн эрхтэй хот, нийслэлд тус бүрт нь хурлын төлөөлөгчид нэр дэвшигчдийн 1 нэрсийн жагсаалт, 1 компенсацийн жагсаалт байна. Нэр дэвшигчид тухайн сонгуулийн тойрогтоо энэ 2 жагсаалтын аль алинд нь нэрээ дэвшүүлж болно. Хэрэв жагсаалтаар хоёулангаар нь сонгогдсон бол 30 хоногийн дотор сонголтоо хийж аль нэг жагсаалтаас нэрээ хасуулна. Холимог системээр засаг даргыг сонгох үед нэр дэвшигч мөн хурлын төлөөлөгчийг сонгох нэрсийн ба компенсацийн жагсаалтад аль алинд нь нэрээ дэвшүүлж болно. Нийслэлийн засаг даргад нэр дэвшигч зөвхөн нийслэлийн жагсаалтанд нэрээ дэвшүүлнэ. Нийслэл болон мужид, муж болон мужийн эрхтэй хотод зэрэг нэр дэвшүүлж болохгүй.

Нэр дэвшигч ба нэр дэвшүүлж буй намд тавих шаардлага

Мажоритараар сонгууль явуулж буй тойрогт нэр дэвшигч тухайн тойргийн сонгогчдын дор хаяж 1%-ийн дэмжлэг авч байж нэр дэвшинэ. Холимог системээр сонгууль явуулах тойрогт нэр дэвшүүлэх нам тухайн тойргийн сонгогчдын дор хаяж 1%-ийн дэмжлэг авсан байх ёстой.

Нэр дэвшүүлэх намын хувьд:

- а. 10000-аас дээш оршин суугчтай тойрогт улс төрийн нам компенсацийн жагсаалт гаргахын тулд уг нутаг дэвсгэр дэхь мажоритараар сонгох тойргуудын дор хаяж талаас илүүд нь нэр дэвшигчтэй байх ёстой.
- б. Нийслэлийн дүүргүүдийн талаас илүүд нь компенсацийн жагсаалт гаргасан нам нийслэлийн хуралд нэр дэвшүүлэх эрхтэй.

- в. Аль нэг тойрогт нэр дэвшсэн байсан хүн нэрээ татснаар намынх нь нэр дэвшүүлэх эрх хүчингүй болохгүй.

Намууд хамтарсан жагсаалт гаргах

- а. Мажоритараар шууд сонгох тойргуудын талаас илүүд хамтран нэр дэвшүүлсэн намууд хамтарсан компенсацийн жагсаалт гаргаж болно.
- б. Нийслэлийн дүүргүүдийн талаас илүүд нь хамтарсан компенсацийн жагсаалт гаргасан намууд нийслэлийн шууд сонгох тойрогт хамтран нэр дэвшүүлж болно.
- в. Намууд мужийн сонгогчдийн 1% буюу дор хаяж 2000-аас доошгүй сонгогчийн дэмжлэгийг хамтран авсан бол мужийн шууд сонгох тойрогт хамтран нэр дэвшүүлж болно.

Казахстан Улс

Казахстан Улсад сонгууль явуулах журам, процедур, үндсэн зарчмуудыг “Бүгд Найрамдах Казахстан Улсын сонгуулийн тухай” гэсэн Үндсэн хуульчилсан хуулиар тогтооно. Уг хуулиар Ерөнхийлөгч, Парламентын доод танхим Мажилисийн депутат, мужуудын хурал – Маслихатын депутат, нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүдийг сонгох сонгуулийг бүгдийг нь зохицуулна.

Сонгуулийн хуулийн 13 дугаар бүлэгт Маслихатын депутатуудыг сонгох талаар заасан. 101, 102 дугаар зүйлүүдэд Маслихатын депутатын сонгуулийг зарлах, нэр дэвшигчдэд тавигдах шаардлагын талаар заажээ.

Зүйл 103. Маслихатын депутатад нэр дэвшүүлэх

1. Тогтоогдсон журмын дагуу бүртгэгдсэн улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд болон тэдний бүтцийн салбарууд маслихатын депутатад нэр дэвшүүлнэ. Мөн иргэд бие даан нэр дэвшиж болно.
2. Улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд болон тэдний бүтцийн салбарууд маслихатын депутатад нэр дэвшүүлэх үйл ажиллагааг уг нэгдлийн дээд байгууллагаас нэр дэвшигч бүрийн дэвших сонгуулийн тойргийг заан мэдүүлж гүйцэтгэнэ. Олон нийтийн нэгдлүүд өөрийн гишүүн бус хүнийг депутатад нэр дэвшүүлэх эрхгүй. Олон нийтийн нэгдлүүд маслихатын сонгуулийн тойрог бүрт зөвхөн нэг нэр дэвшигчийн нэр дэвшүүлнэ. Маслихатын депутатад нэр дэвшүүлэх шийдвэрийг улсын болон орон нутгийн олон нийтийн нэгдлүүд, тэдний бүтцийн салбаруудын дээд байгууллагын нийт гишүүдийн олонхийн саналаар гаргаж, хуралдааны протоколоор баталгаажуулсан байна.
3. Олон нийтийн нэгдлийн дээд байгууллагын шийдвэрийг 1) нэр дэвшигчид танилцуулна, 2) нэр дэвшигчийн дэвших зөвшөөрөл бүхий өргөдлийн хамт харгалзах тойргийн сонгуулийн комисст хүргүүлнэ.
4. Маслихатын депутатад иргэн бие даан нэр дэвшихдээ харгалзах тойргийн сонгуулийн хороонд маслихатын депутатад нэр дэвших сонирхлоо илэрхийлсэн өргөдөл өгнө.
5. Хэн ч нэгээс илүү сонгуулийн тойрогт нэр дэвшиж болохгүй.
6. Хэрэв сонгууль зарлах үед өөрөөр заагаагүй бол депутатад нэр дэвшүүлэх ажил санал хураалтын өдрөөс хоёр сарын өмнө эхэлж, нэг сарын өмнө дуусна.
7. Хэрэв тухайн сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийг бүртгэж дуусах өдөр хоёроос доош тооны нэр дэвшигч бүртгэгдсэн байвал тойргийн сонгуулийн хорооны өргөн мэдүүлснээр нутаг дэвсгэрийн сонгуулийн хороо нэр дэвшүүлэх хугацааг хориос илүүгүй хоногоор сунгана.

8. Тойргийн сонгуулийн хороо гурав хоногийн хугацаанд нэр дэвшигч Үндсэн хууль болон үндсэн хуулийн эрхтэй энэхүү хуулийн шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.

Хуулийн энэ бүлгийн дараах зүйлүүдэд маслихатын сонгууль явуулахтай холбоотой бусад заалтууд орсон байна. Тухайлбал, нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигч тойргийн сонгуулийн хорооны дансанд депозит болгон мөнгө байрлуулах, уг мөнгийг буцаах болон буцаахгүй байх нөхцөл, нэр дэвшигч болон эхнэр (нөхөр) хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах журам, олон нийтийн нэгдлээс нэр дэвшигчдийн бүртгүүлэхэд шаардагдах бичиг баримт, тойргийн комиссоос тавах хяналт, бүртгэхээс татгалзах нөхцлүүд, нэр дэвшигчийг буцаан татах, нөхөн нэр дэвшүүлэх, саналын хуудас тоолох, дахин сонгууль явуулах, сонгуулийн үр дүнг гаргах, мэдээлэх зэргийг нарийвчлан заасан байна. Эдгээр заалтуудад улс төрийн намын үйл ажиллагаа, оролцооны талаар дурдагдаагүй болно.

Япон Улс

Япон Улсын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн өөрийн удирдлага/-ийн 92 дугаар зүйлд “Орон нутгийн нийтийн эрх зүйн этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох журмыг орон нутгийн хараат бус байдлын зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно”, 93 дугаар зүйлд “Нийтийн эрх зүйн этгээдийн хурлын гишүүдийг нийтийн, шууд сонгуулиар сонгоно” гэжээ.

Япон Улсын Сонгуулийн тухай хуулийн 86 дугаар зүйлд “Парламентад 5-аас доошгүй гишүүнтэй улс төрийн нам, хамгийн сүүлийн сонгуулийн саналын 2-оос доошгүй хувийн саналыг авсан улс төрийн нам нэр дэвшигчийг зарлана. Гэхдээ бие даан нэр дэвшигч дэвшиж болно” гэжээ.

Гурав. Орон нутгийн сонгууль болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намуудын оролцоо

	Үзүүлэлт	Испани	Герман	Их Британи	Ирланд	Дани
1.	Хуулийн нэр	“Орон нутгийн засаг захиргааны үндсэн хууль”. 1979 онд энэ хуулиар орон нутгийн ардчилсан сонгуулийг явуулсан.	Дэлхийн 2 дугаар дайны дараагаас орон нутгийн сонгуулиа “Орон нутгийн засаг захиргааны хууль”-иар явуулдаг болсон.	2000 онд парламентаар батлагдсан “Орон нутгийн засаг захиргааны акт”-аар орон нутгийн сонгуулийг зохицуулдаг.	1898 онд “Орон нутгийн захиргааны Ирландын акт”-ыг батлан гаргасан.	1953 оны “Үндсэн хуулийн акт”-аар орон нутгийн сонгуулийг зохицуулдаг.

2.	Орон нутгийн сонгууль дахь улс төрийн намуудын оролцооны эрх зүйн зохицуулалт	Орон нутгийн зөвлөлтэй ¹ . Зөвлөлийн гишүүдийг улс төрийн нам санал болгож, иргэдээс сонгодог. Гишүүн нас барсан тохиолдолд сонгууль явуулахгүй сонгуульд орсон санал авсан нэрсийн жагсаалтаар дараагийн хүнийг шууд сонгодог. Олонхи суудал авсан намын гишүүдээс зөвлөлийн даргыг томилдог.	Улс төрийн намаас нэр дэвшсэн гишүүдтэй зөвлөл орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлдэг.	Улс төрийн намын харьяалалтай гишүүдээр дамжуулан тухайн орон нутгийн зөвлөлд намын бодлогоо хэрэгжүүлдэг.	Орон нутгийн зөвлөлтэй байна. Зөвлөл нь пропорциональ системээр бүрддэг. Зөвлөл нь гол улс төрийн намаас хамааралтай.	Орон нутгийн зөвлөл нь улс төрийн намуудаас нэр дэвшүүлж, сонгогдсон төлөөллөөс бүрдэнэ.
3.	Орон нутгийн хурлын байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намуудын оролцоо	Олонхи болсон намын санал болгож томилуулсан Зөвлөлийн дарга нь орон нутгийн захирагааны бүх томилгоог хийдэг. Энэхүү томилгоогоороо дамжуулан нам нь улс төрийн бодлогоо хэрэгжүүлдэг.	Мужын орон нутгийн зөвлөлийн гишүүдийн дундаас захирагчийг сонгодог.	Мужын зөвлөлийг иргэдээс шууд сонгогдсон захирагч удирддаг.	Орон нутгийн зөвлөлийг гол улс төрийн намаас нэр дэвшүүлж, сонгогдсон захирагч удирдана.	

Дөрөв. Улс төрийн намуудын гишүүнчлэл

Гадаадын зарим орны улс төрийн нам бүртгэх үйл явц

Монгол Улсад улс төрийн намыг Дээд шүүхэд бүртгэдэг. Харин Герман, Итали, Франц, Грек, Испани, Португал, Бразил зэрэг улсад Намын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай хуулийн дагуу, Австри, Швейцарь, Финланд, Японд Сонгуулийн тухай хуулийн хүрээнд, АНУ, Мексикт манайх шиг шүүхийн шийдвэрээр буюу Дээд шүүх нь бүртгэж зөвшөөрөл олгосноор статусыг нь баталгаажуулдаг байна. Энэ бүх үйл ажиллагаа мэдээж тухайн улс бүрийн Үндсэн хуулийн хүрээнд явагддаг.

Бүртгэл: Намыг бүртгэхдээ заавал буюу албан ёсоор, эсвэл сайн дурын буюу чөлөөт байдлаар “шийддэг” байна. Жишээ нь, Их Британи болон Шинэ Зеландад улс төрийн намыг заавал бүртгэдэггүй. Үүнийг иргэдийн хувийн үйл хэрэг хэмээн ойлгож, чөлөөт нэгдлийн үндсэн дээр хэрэгжиг, нам өөрийнхөө дүр төрхийг тунхаглаж түүгээрээ оршин тогтног гэж үздэг байна. Гэхдээ чөлөөт байдлыг эрхэмлэсэн энэ либерал үзэл эдүгээ цагт хуучин уламжлалтайгаа хамт хумигдсаар байна. Үүний оронд улс төрийн намыг заавал бүртгэж байх эрх зүйн акт бүхий тогтолцоо ноёлох болжээ.

Энэ нь дотроо бас янз бүр. Испани, Итали, Францад намыг Дотоод хэргийн яам нь, Бельги, Нидерландад Хууль зүйн яам нь, АНУ-ын Миссури мужид мужийн Төрийн нарийн бичгийн газар бүртгэдэг бол Португали, Бразилд манайх шиг шүүхийн шийдвэрээр Дээд шүүх нь бүртгэдэг байна. Энэхг, Мексик, Швейцарьт сонгууль явуулахын тулд байгуулагдсан байгууллагууд бүртгэдэг байна. Харин намыг татан буулгахад Герман, Франц, Португалид шүүхийн шийдвэрээр, Унгарт Үндсэн хуулийн хүрээнд, Германд Хууль зүйн яам, Швейцарьт тусгай бүртгэлээс хасагдсан нөхцөлд тухайн улс төрийн намын статусыг цуцалж хүчингүй болгодог байна.

Шаардлага: Никарагуа Улсыг эс тооцвол дэлхийн ихэнх улс оронд улс төрийн нам байгуулахад урьдчилсан зөвшөөрөл аваад байдаггүй, шаарддаг ч үгүй байна. Хууль ёсны зөвшөөрөл бүхий статус авахын тулд албан ёсоор бичсэн материал шаардлагатай нь мэдээж. Энд тухайн намын нэр, бэлэг тэмдэг багтдаг. Ингэхдээ тэдгээр нь тухайн орны төр, шашны бэлэгдэлтэй адил бус байхыг урьдчилан сануулдаг байна.

Нам байгуулж, бүртгүүлэхэд аль ч улс оронд нэг голлодог зүйл нь тухайн намын гишүүд болон дэмжигчдийн тоо байдаг. Ихэнх улс оронд үүнийг харгалзан бүртгэдэг. Үүгээр үзэх юм бол Швейцарьт сонгогчдын 1,5 мянгаас доошгүй гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг бол Португалид 5 мянган сонгогчийг төлөөлсөн байх үүрэгтэй. Эдгээр нь тухайн улсын сонгогчдын буюу сонгуульд оролцож санал өгөх насны нийт хүмүүсийн тоотой харьцуулсан хувь юм. Тухайлал, АНУ-ын 20-иод муж улсын хууль тогтоох байгууллага намуудаас сонгогчдын ерөнхий тооны хувиар илэрхийлсэн тодорхой тооны гарын үсгийг шаарддаг байна.

Жишээ нь, Өмнөд Дакотад энэ тоо 10 хувь байдаг бол Миннесотад 5 хувь байдаг. Ингэхдээ муж улсын түвшинд тухайн намын гишүүн ямар нэг албан тушаалтан сүүлийн сонгуульд нэр дэвшиж ялсан, эсвэл бүх нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүмүүсийн хувиас хамааран бүртгэдэг байна. Эдгээр нь сонгогчдын төлөөлөл болохоос биш манайх шиг хатуу гишүүнчлэлтэй улсынх шиг намын гишүүдийн тоог хэлж байгаа юм биш. Учир нь барууны орнуудад намын гишүүнчлэл гэж бараг байдаггүй, зөвхөн дэмжигчид байдаг. Тиймээс тэнд намын гишүүдийн тоог харгалздаггүй. Харин хатуу гишүүнчлэлтэй орнуудын хувьд, жишээлбэл, Унгарт нам бүртгүүлэхэд гишүүн-үүсгэн байгуулагчдын тоо 1000 байх ёстой байдаг аж. Мексикт энэ тоо 65 мянгаар хэмжигддэг байна.

Энэтхэгт бүр хэцүү, шат дараалсан том шаардлагатай. Энд нам бүртгүүлэхэд эхлээд бүс нутгийн статус авдаг. Дараа нь нийт үндэсний хэмжээнд зөвшөөрөгдөхөд нийт сонгогчдын 4 хувийн саналыг авсан байх ёстой. Ингэхдээ 5-аас доошгүй жил улс төрийн үйл ажиллагаа явуулсан байх гэх мэт хэрэгтэй. Ингэж байж тухайн нам Энэтхэгийн 4 муж, бүс нутгийн бүртгэлтэй болж байж нийт Энэтхэгийн хэмжээнд намын статусаа авдаг байна. Герман, Португал, Бразил зэрэг оронд нам бүртгүүлэхэд маш их баримт материал гаргаж өгөх ёстой. Үүнд намын дүрэм, мөрийн хөтөлбөр, өргөдөл, санхүүгийн болон хөрөнгийн зарцуулалт, намын бүрэлдэхүүн зэрэг ордог байна.

Улс төрийн намуудын гишүүнчлэлийн талаарх зохицуулалт

Дэлхийн улс орнуудад улс төрийн намуудыг гишүүнчлэлээр нь хатуу гишүүнчлэлтэй, сул гишүүнчлэлтэй, гишүүнчлэлгүй гэж хуваагддаг. Англи, Америкийн улс төрийн уламжлалтай улс орнуудын хувьд намыг Парламент дахь намын бүлгийн түвшинд их төлөв тайлбарлахаас гадна хатуу тогтсон бүтэц, зохион байгуулалтгүй, тодорхой гишүүнчлэлгүй, сонгуулийн үед идэвхждэг, мэргэжлийн цөөн хүмүүсийн бүлэглэл маягаар ойлгодог аж. Харин их газрын эрх зүйн системтэй орнуудад судлаачид намыг хатуу тогтсон үзэл санаа, зохион байгуулалттай, байнгын гишүүнчлэлтэй, тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, хяналтын нарийн механизмтай олон түмний бүлэглэл хэлбэрээр тайлбарладаг байна.

Эндээс үзвэл өнөө хэр улс төрийн намын талаар цэгцтэй нэгдмэл ойлголт бүрэлдэж хараахан чадаагүй нь харагдаж байна. Хэдий тийм боловч улс төрийн намыг авч үзэхдээ дараахи гол ерөнхий шинжийг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй байдаг. Нэгд, санаа бодол нэгдмэл буюу ойролцоо хүмүүсийн бүлэглэл, хоёрт, үйл ажиллагааны тодорхой зорилго, чиглэл, үзэл санаа, хөтөлбөртэй байх, гуравт, ямар нэг хэмжээгээр зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй байх, дөрөвт, засгийн эрхийг авах эрмэлзлэл, түүнийг хэрэгжүүлэх нөөц чадвартай байх. Энэхүү ерөнхий шаардлага шалгуурыг хангаж чадаж буй бүлэглэлийг нам гэж үзэж болох юм.

Улс төрийн нам хатуу гишүүнчлэлгүй тохиолдолд сонгуульд оролцоод санал авсан дэмжигчдийнхээ тоогоор “Манай нам, нийт ард түмний төдөн хувийн дэмжлэгийг авлаа” гэсэн үр дүнгээр тухайн орон эрх барих хүчнээ тодорхойлж, засаглалаа тогтоож болно. Олон орон ийм загвараар явж байна. Энэ нь тухайн орныхоо тусгаар тогтнол, эв нэгдлийн баталгааг нэмэгдүүлдэг сайн талтай ч гэж зарим судлаачид үздэг ажээ.

Улс төрийн намын гишүүнчлэл:

Улс	Улс төрийн намын гишүүнчлэл	Тайлбар
АНУ	Гишүүнчлэлгүй “Federal Election Campaign Law” 1971, “Сонгуулийн компани ажлын тухай хууль”	
Герман	Гишүүнчлэлтэй “Political Parties Act” 1967, (Parteiengesetz, ParteienG) “Улс төрийн намын тухай хууль”	
Испани	Гишүүнчлэлтэй Улс төрийн намын тухай хууль 2002,	
Их Британи	Гишүүнчлэлгүй	
Мексик	Хатуу гишүүнчлэлтэй	
Молдов	Гишүүнчлэлтэй “Act of Political Parties” 2007, “Улс төрийн намын тухай хууль”	
Нидерланд	Гишүүнчлэлтэй	
ОХУ	Хатуу гишүүнчлэлтэй “Federal Law on Political Parties” 2001 “Улс төрийн намын тухай хууль”	
Польш	Гишүүнчлэлтэй “Act of Political Parties” 1997, “Улс төрийн намын тухай хууль”	
Унгар	Хатуу гишүүнчлэлтэй	
Швед	Гишүүнчлэлтэй	Намын хууль байхгүй, дүрмээр зохицуулна
Эстони	Гишүүнчлэлтэй “Act of Political Parties”, “Улс төрийн намын тухай хууль”	
Япон	Гишүүнчлэлтэй “Улс төрийн намын санхүүжилтын тухай хууль” 1996 /政党助成法/	

Намын гишүүнчлэлийн талаар жишээ дурьдвал:

➤ Оросын Холбооны Улс

ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль” 2001 онд батлагдсан. 2002-2010 онд жил бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан. ОХУ-д улс төрийн намуудыг тус улсын Хууль зүйн яам бүртгэдэг. Улсын бүртгэлд бүртгэлтэй 7 намтай. Улс төрийн нам нь 45 мянгаас доошгүй гишүүнтэй, ОХУ-ын нийт субъектын талаас илүүд нь салбартай, салбар тус бүр нь 450-аас доошгүй гишүүнтэй байна. Нутаг дэвсгэрийн бусад нэгжүүд дэх салбар нь 200-аас доошгүй гишүүнтэй байна.

- Нам нь нэг ижил мэргэжлийн хүмүүсээс бүрдэж болохгүй.
- 18 насанд хүрсэн ОХУ-ын иргэн улс төрийн намын гишүүн байж болно.
- Гадаадын харъяат болон харъяалалгүй этгээд, эрх зүйн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон ОХУ-ын иргэн улс төрийн намын гишүүн байж болохгүй.
- Иргэдийг намд элсүүлэхдээ тухайн намын дүрэмд заасан журмын дагуу бичгээр гаргасан өргөдлийг үндэслэнэ. (ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 2,3 дугаар заалт)
- Нам нь жил бүр гишүүдийнхээ тоог орон нутгийн салбар тус бүрээр гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. (ОХУ-ын “Улс төрийн намын тухай хууль”-ийн 27 дугаар зүйл)

➤ *Нидерландын Вант Улс*

Нидерландийн улс төрийн намын тухай хууль олдоогүй ч Нидерландын <http://www.organgesmile.com> сайтад мэдээлснээр Нидерландийн улс төрийн намууд гишүүнчлэлтэй бөгөөд намуудын санхүүжилтийг тухайн нам өөрөө хангах үүрэгтэй байна.

➤ *Холбооны Бүгд Найрамдах Герман Улс*

10 дугаар зүйлд гишүүний эрхийн талаар:

- Шинээр гишүүн элсүүлэх асуудал түр болон бүр хориглох эрх байхгүй. Гишүүнээр элсэх өргөдөлд татгалзсан хариу өгөхдөө тайлбар гаргах албагүй. Шүүхийн шийдвэрээр сонгох, сонгогдох эрх нь хасагдсан иргэд намын гишүүн байж болохгүй.
- Хуулиар намын гишүүд, төлөөлөгчид санал өгөх ижил эрхтэй боловч намын дүрмээр гишүүний хандиваас шалтгаалан саналын эрхтэй болохоор зааж болно.

➤ *Америкийн Нэгдсэн Улс*

Гишүүнчлэлгүй, дэмжигчидэд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг.

* * *

Ашигласан материал:

Ном зүй

Монгол хэл дээр

1. Дэлхийн улс орнуудын парламент, Улаанбаатар, 2010
2. Монгол улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл, Ред. Ж.Ядамсүрэн 2002 он
3. Япон Улсын Үндсэн хууль. Орч П.Амаржаргал, “Адмон” хэвлэл, УБ., 2011
4. “Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцох нь” Бодлогын судлагаа шинжилгээ. Х боть, 256-287 х, УБ., 2011

Англи хэл дээр

1. Johnson, M. 2005 Political Parties and Democracy in Theoretical and Practical Perspectives. National Democratic Institute for International Affairs.
2. Pierre, J. Svasand, L. & Widfeldt, A. (2000) "State Subsidies to Political Parties: Confronting Rhetoric With Reality in West European Politics. Frank Cass & Company Ltd.
3. Pildat Background Paper: Selected Case Studies of Public Funding of Political Parties, 2005.
4. Policy Brief, Centre for Governance and Development, 2005 March, Nairobi, Kenya
5. Shively, W.Ph. 2003, Power and Choice: An Introduction to Political Science, Eight edition,
6. The International IDEA Handbook series: Funding of Political Parties and Election Campaigns, 2003, ed. By Austin, R. and Tjernstrom, M.

Цахим хуудас

1. <http://www.legislationline.org/documents/action/popup/id/5326>
2. <http://www.online.bg/law/const/const0.htm>
3. http://www.servat.unibe.ch/icl/hu00000_.html
4. <http://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm>
5. <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/APCITY/UNPAN014593.pdf>
6. http://en.wikipedia.org/wiki/Local_elections_in_Poland
7. http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Hungary
8. <http://wtd.vlada.cz/scripts/detail.php?id=8073>
9. http://korea.assembly.go.kr/res/low_01_read.jsp?boardid=1000000035
10. http://www.kazakhstan.orexca.com/kazakhstan_constitution.shtml
11. www.ipu.org
12. Constitution of Estonia 2013. <http://estonia.eu/about-estonia/country/estonia-at-a-glance.html>
13. http://lgi.osi.hu/country_dasheet.php?id=11
14. <http://www.belarus.by/en/government/belarus-elections/elections-to-local-councils-of-deputies-belarus>
15. <http://lgi.osi.hu/publications/2001/84/Ch5-Georgia.pdf>
16. http://www.kl.dk/ImageVault/Images/id_38221/ImageVaultHandler.aspx
17. <http://www.cfr.org/indonesia/indonesia-local-elections/p8247#p2>
18. <http://www.state.gov/r/pa/ei/bgn/358-76.htm>



УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙГ ХАМТАД НЬ ЯВУУЛАХ БОЛОМЖТОЙ ЭСЭХ АСУУДЛААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА БОЛОН ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Р. Хатанбаатар, Б. Цолмонбаяр, Б. Хатантуул

УИХ-ын гишүүн, Төрийн Байгуулалтын Байнгын Хорооны дарга Ж.Сүхбаатарын захиалгаар “Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийг хамтад нь явуулах боломжтой эсэх” сэдвийн хүрээнд парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг зарим орны мэдээлэл, манай улстай хүн амын хувьд ойролцоо унитар тогтолцоотой улс орнуудын жишиг, мөн түүнчлэн сонгуулийг хамт явуулахын эерэг болон сөрөг үр дагаварын талаар судалгаа хийхийг хүссэн захиалгыг хүлээн авч сонгуулийг хамтад нь явуулдаг 6 орон мөн түүнчлэн манай улстай адил төстэй 20 унитар улс орны жишээг хамруулан Судалгааны төвийн судлаачдын баг захиалгыг гүйцэтгэв.

1.Орон нутгийн болон парламентын сонгуулийг хамт явуулдаг орнуудын талаарх мэдээлэл

Парламентын болоод орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь эдийн засгийн үргүй зардлыг хэмнэдэг сайн талтай гэдэг үүднээс нэлээд орон сонгуулийн энэхүү тогтолцоог хэрэглэдэг. Өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, Австрали, хөгжиж буй орнуудаас Болгар, Филиппин зэрэг улс сонгуулиудаа зэрэг явуулж эхэлжээ. 2020 гэхэд Европын Холбооны орнууд энэ замаар сонгуулиа зохион байгуулна гэж ажиглагчид үзэж байна. Бельги, ялангуяа Герман улс үүнд илүү анхаарлаа хандуулж байна. Хэдийгээр эдгээр өндөр хөгжилтэй орнууд сонгуулийг зэрэг явуулж байгаа ч Монгол улстай тогтолцооны хувьд ижил төстэй унитар улсуудаас Болгараас бусад нь сонгуулийг тус тусад нь зохион байгуулдаг байна.

1. Парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг зарим орны мэдээлэл

Улс орон	Парламент болон Орон нутгийн хурлын сонгуулийг хамтатган явуулдаг туршлага , мэдээлэл
Филиппин	<p>Тус улс нь сонгуулиа зэрэг явуулахдаа бүрэн автоматжсан санал хураалтын технологийг хэрэглэж байгаа нь ардчилсан, шударга сонгуулийн загварыг Өмнөд Азид түгээсэн чухал алхам болжээ.</p> <p>Тус улсын Парламент нь 2 танхимтай бөгөөд Сенат нь 26, Конгресс нь 286 гишүүнтэй. Филиппиний Үндсэн хуулийн 18-р бүлгийн 1-р хэсэгт “Орон нутгийн сонгууль нь Конгрессийн гишүүдийн сонгуультай нэг зэрэг явагдах бөгөөд орон нутгийн сонгуульд хотын бүх гишүүд болон нийслэл Манила орчмын хотуудын захирагч нарын сонгууль багтана” гэж заажээ. Мөн хуулийн 8-р хэсэгт “Орон нутгийн сонгогддог албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа 3 жил бөгөөд 3 хүртэл удаагаар улиран сонгогдож болно” гэжээ.</p> <p>Филиппин улс нь сонгууль явуулах арга технологиороо хөгжиж буй орнуудын хувьд туршлага өндөртэй орнуудын тоонд зүй ёсоор ордог.</p> <p>http://www.comelec.gov.ph/statistics/2010natl_local/toc.html</p>

Болгар	<p>7.2 сая хүн амтай Болгар улсын хувьд хамгийн сүүлд 2011 оны 10 дугаар сарын 23-нд Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулсан байна. 2011 оны 2-р сард сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулсан. Сонгуулийн хороо нь 5 жилийн хугацаатайгаар томилогдож 21 гишүүдээс бүрдсэн. Сонгуулийн хэсгийн хороо нь 1000 хүртэл сонгогчдыг авдаг. Эрүүгийн хуулиндаа 2011 оны 4-р сард өөрчлөлт оруулж, хэвлэл мэдээллийн байгууллагын сонгуулийн үед баримтлах зарчим, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлсэн байна.</p> <p>Эх сурвалж: http://www.osce.org/odihr/elections/83959</p>
Индонез	<p>2009 онд тус улс нь үндэсний, муж, дүүргийн сонгуулийг амжилттайгаар нэг зэрэг явуулсан нь Зүүн Өмнөд Азид ардчиллыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. 2008 оноос эхлэн эдгээр сонгуулийг зэрэг явуулах талаар парламентын гишүүд эсрэг байр суурьтай байсан ч сонгуулийг зэрэг явуулж чадсан байна. 2008 онд Сонгуулийн тухай хуулиндаа хагас нээлттэй пропорциональ систем, босгыг 2,5 гэж оруулсан зэрэг нь ардчилсан алхам болсон байна.</p> <p>Эх сурвалж: http://www.google.mn/#hl=mn&source=hp&q=Indonesia+simultaneous+election+law&btnG=Google+%D0%A5%D0%B0%D0%B9%D0%BB%D1%82&bav=cf.osb&fp=351315cd2d2e33d5&biw=1024&bih=636</p>
Тайвань	<p>Тус улс нь 2012 оны Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийг зэрэг явуулав. Энэ нь улс төрийн зорилгогүй бөгөөд нийгмийн зардлыг багасгах, улс төрийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, мөн 500 сая тайвань долларыг хэмнэх бололцоо олгосон гэж Сонгуулийн төв хорооны дарга Чанг мэдэгдсэн байна.</p> <p>Эх сурвалж: http://www.taipeitimes.com/News/front/archives/2011/04/20/2003501206</p>
АНУ	<p>Холбооны болон муж улсын сонгуулиудыг 1975 оноос хойш зэрэг явуулдаг болсон нь эдийн засгийн асар их хэмнэлтийг авчирсан. Муж улсуудад нэг л удаа сонгуулийг явуулдаг.</p> <p>Эх сурвалж: The Truth of the Matter, By Gough Whitlam</p> <p>http://books.google.mn/books?id=bQTtYL3KKgcC&pg=PR26&lpg=PR26&dq=simultaneous+elections+in+USA&source=bl&ots=MrBroGpywT&sig=EITkpvksWlffOQIzeMhdgqAuzyl&hl=mn&ei=-8etTvW-SAYqqiALQ5PivCw&sa=X&oi=book_result&ct=result&resnum=3&ved=0CCYQ6AEwAg#v=onepage&q=simultaneous%20elections%20in%20USA&f=false</p>
Австрали	<p>Сонгуулиудыг нэг өдөр явуулах Америкийн загварыг Австрали улс дагаж Сенат болон Төлөөлөгчдийн хоёр танхимын сонгуулийг зэрэг явуулдаг болжээ. Бүх нийтийн санал асуулгаар хэд хэдэн удаа энэ асуудлыг эсэргүүцэж байсан байна.</p>

2. Манай улстай адил төстэй тогтолцоотой унитар улс орнуудаас Болгараас бусад орнуудад парламентын болон орон нутгийн сонгууль тусдаа явагддаг байна.

№	Унитар тогтолцоотой улсууд	Хүн ам	Парламентын сонгогдох хугацаа	Парламентын гишүүдийн тоо	Орон нутгийн сонгуулийн хугацаа, парламентын сонгуультай хамтдаа явагддаг эсэх
---	----------------------------	--------	-------------------------------	---------------------------	--

1	Болгар	7.2 сая	4 жил	240	4 жил тутамд орон нутаг, парламентын сонгууль нэг өдөр явагддаг /Үндсэн хууль. 64-1/
2	Латви	2.2 сая	4 жил	100	4 жил тутамд парламентын сонгууль явагддаг /Үндсэн хууль 4-р зүйл/ Орон нутгийн сонгууль нь тусдаа явагддаг
3	Унгар	10 сая	4 жил	386	4 жил, тусдаа явагддаг
4	Эстони	1.3 сая	4 жил	101	4 жилийн хугацаатайгаар орон нутгийн сонгуулийг тусдаа явуулдаг
5	Өмнөд Солонгос	48.9 сая	4 жил	299	4 жилийн хугацаатайгаар орон нутгийн сонгуулийг тусдаа явуулдаг
6	Азербайжан	9 сая	5 жил	125	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг.
7	Беларусь	9 сая	4 жил	110	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
8	Гүрж	4.6 сая	4 жил	150	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
9	Дани	5.5 сая	4 жил	179	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
10	Израйль	7.2 сая	4 жил	120	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
11	Кувейт	3.5 сая	4 жил	65	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
12	Кыргызстан	5.4 сая	5 жил	120	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг
13	Люксембург	502,2 мянга	5 жил	60	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг
14	Македон	2 сая	4 жил	120	4 жилийн хугацаатай
15	Норвеги	4,9 сая	4 жил	169	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
16	Португал	11.3 сая	4 жил	230	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
17	Финланд	5.4 сая	4 жил	200	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг
18	Шинэ Зеланд	4.2 сая	3 жил	120	Орон нутгийн сонгууль нь 3 жилийн хугацаатай тусдаа явагддаг
19	Молдав	3.5 сая	4 жил	101	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг

2. Сонгуулийг хамтатган явуулсаны эерэг болон сөрөг үр дагавар

- Эерэг тал нь:

1. Сонгуулийн үйл ажиллагаа улс орны хэмжээнд нэгэн зэрэг явагдах учраас цаг хугацаа хэмнэнэ.
2. Сонгуулийн компанит ажлыг шат шатны сонгуулийн үед дахин дахин явуулах нь ажил цалгардах, улсын болон орон нутгийн ажил саатах нөхцөлийг үүсгэдэг. Хамтатган явуулсанаар энэ байдал арилна.
3. Улс төрийн намууд бүх шатны сонгуульд дээрээсээ доошоо хэт гүнзгий хутгалдан оролцож улс орон даяар улс төржсөн байдал удаан үргэлжилдэг явдал багасна. Олонхи болсон нам орон нутгийн сонгуульд өөрийн намыг ялуулахын төлөө идэвхийлэн оролцох, орон нутагт өөрийн намын төлөөллөө засаглалын эрхийн бүх шатанд хэрэгжүүлэх гэсэн санаа оролдлогыг тодорхой

хэмжээнд хаана.

4. Сонгогчдод парламент болон орон нутгийн хуралд аль нам, хэн гэдэг нэр дэвшигчид саналаа өгөх сонголт хийх боломжийг нэг дор бүрдүүлж өгнө.
5. Дээд, доод шатны нэр дэвшигчдийн санал худалдан авах буруу үйлдэл багасч мөнгөний сонгууль хязгаарлагдана.
6. Сонгуультай холбоотой зардал хэмнэгдэх учраас эдийн засгийн хувьд үр ашигтай.
7. Ойр ойрхон олон сонгуулийг явуулах нь улс орон даяар хэт улс төржих, сонгогчдыг залхаах, үргүй зардал их гарах нөхцөлийг бүрдүүлнэ. Монгол улсад 4 жилд 3 удаа явагдаж байгаа сонгуулийг ядаж 2 болгох нь эдийн засгийн хэмнэлт, засаглалын тэнцвэртэй хуваарилалт болон хяналт, сонгогчдын хүсэл сонирхол болон цаг хугацаа хэмнэх, хэт улс төржилтийг багасгах талаасаа ач холбогдолтой байж болох юм.

• Сөрөг тал нь:

1. УИХ-ын болон Орон нутгийн сонгуулийн тогтолцоо ижил биш. Өөрөөр хэлбэл УИХ-ын сонгууль холимог, Орон нутгийн сонгууль олон мандаттай мажоритари тогтолцоогоор явуулдаг учраас зөрчил үүснэ.
2. Бүх шатны сонгуулийн хуулийн зохицуулалт өөр өөр зохион байгуулалтыг шаарддаг учраас тэдгээр ялгаатай үйл ажиллагааг зохион байгуулах техник ажиллагаанд хүндрэл үүсч болзошгүй. Сонгуулийн хороо, хэсгийн хороодын ачаалал нэмэгдэнэ.
3. Орон нутгийн сонгуулийн үр дүнг гаргахад УИХ-ын сонгуулийнхтай нэг адил техник хэрэгслэлийг (автоматжуулсан) ашиглаж болох эсэх нь эргэлзээтэй.
4. 2012 онд УИХ-ын болон Орон нутгийн сонгуулийг хамт явуулах тохиолдолд одоо сонгогдсон ИТХ-ын бүрэн эрхийн 4 жилийн хугацаа наашилж 3,8 жилээр дуусгавар болох тул Монгол Улсын Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай зөрчилдөх нөхцөл үүснэ. (Орон нутгийн сонгуулийн тухай хуульд 2008 онд оруулсан нэмэлт өөрчлөлт)
5. Сонгууль хамт явагдах үед бүх аймаг, сум, орон нутгийн удирдлагууд нэр дэвшигч төрийн удирдлага болон хяналт хэсэг хугацаанд алдагдаж болзошгүй.
6. Саналын хайрцаг, компьютер техник хэрэгсэл, хүн хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага гарна.
7. Сонгогчдын боловсролыг сайжруулах бэлтгэл хугацаа шаардлагатай ба сонгогчид төөрөлдөх, будлих байдал гарч сонгууль дахин явагдах нөхцөл үүсч болзошгүй.
8. Сонгуулийн хууль болон техник ажиллагааны талаар арга зүйн сургалт зохион байгуулах, сурталчлах нэмэлт ажиллагаа шаардагдана.
9. Сонгогчдын санал тоолох автоматжуулсан техник, программ хангамжийн асуудал шийдэгдээгүй байгаа тул энэ удаадаа хамтатган явуулах бодит боломж байхгүй гэсэн дүгнэлтийг СЕХ-ны зүгээс хийж байгаа.
10. Сонгуулийн автоматжуулсан техник, программ хангамжийн чиглэлээ мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдээгүй. Сургалт зохион байгуулах хугацаа байхгүй тул хүндрэл гарна гэж холбогдох байгууллагууд үзэж байгаа.

3. Монгол Улсад сонгууль хамт явуулж байсан тухай мэдээлэл

1990 оны “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Депутатуудын сонгуулийн тухай” хуулийн

- 12.2-т Аймгийн төвийн болон улсын харьяалалтай хотод 10000 хүн ам тутамд АИХ-ын депутатуудын сонгуулийн нэг тойрог байгуулна. Харин тойрогтой

адилгах засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бүрийг АИХ-ын депутатуудын сонгуулийн нэг тойрогт тооцно.

- 12.3 -т Орон нутгийн АИХ-ын депутатуудын сонгуулийн тойргийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 2-т заасны дагуу тогтоосон АИХ-ын депутатуудын тоонд нийт хүн амыг хувааж байгуулна гэж заасан байдаг.

Уг хуулийн хүрээнд 1990 оны 7 дугаар сарын 22-нд сонгуулийг хамт явуулсан бөгөөд үүнээс хойш дахин сонгууль хамт явагдаагүй байна. Энэхүү сонгуулийн эерэг сөрөг үр дагаврын талаархи мэдээлэл байхгүй байна.

* * *

Ашигласан материал:

- Дэлхийн улс орнуудын парламент, Улаанбаатар, 2010
- Пятрас Гражулис Предложено наполовину сократить число парламентариев. [www. p-w-w-. ru](http://www.p-w-w.ru)
- Устанавливается порядок определения численности региональных парламентариев. regnum.ru
- www.ipu.org
- The Election Law On City and Town Councils, District Councils and Pagasts* Councils [http:// web.cvk.lv/pub/public/28157.html](http://web.cvk.lv/pub/public/28157.html)
- Constitution of Estonia 2013. <http://estonia.eu/about-estonia/country/estonia-at-a-glance.html>
- http://lgi.osi.hu/country_datasheet.php?id=11
- <http://www.belarus.by/en/government/belarus-elections/elections-to-local-councils-of-deputies-belarus>
- <http://lgi.osi.hu/publications/2001/84/Ch5-Georgia.pdf>
- http://www.kl.dk/ImageVault/Images/id_38221/ImageVaultHandler.aspx
- http://books.google.mn/books?id=iVJR9UZnTVAC&pg=PA373&lpg=PA373&dq=elect+local+councils++in+Israel&source=bl&ots=5E40tqn_qh&sig=gGR5NXCCd8zltKX_ffafqFtaK4&hl=mn&ei=LhumTvG8GsaliALZtLHMDQ&sa=X&oi=book_result&ct=result&resnum=4&ved=0CCoQ6AEwAw#v=onepage&q&f=false
- <http://www.cfr.org/indonesia/indonesia-local-elections/p8247#p2>
- <http://www.state.gov/r/pa/ei/bgn/358-76.htm>
- <http://www.electionguide.org/country-news.php?ID=128>
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Norway#Local_elections
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Portugal
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Finland
- <http://electionresults24.com/2011-moldovan-local-municipal-election-results.html>



СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООТ УЛС ОРНУУДЫН СОНГОГЧДЫН САНАЛ ГАРГАХ ХУВИЛБАРУУД (Харьцуулсан судалгаа)

*Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Г. Гэрэл,
О. Нарантуяа, Б. Хатантуул*

Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд

Сонгуулийн холимог тогтолцоо: нь олонхийг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Сонгуулийн холимог тогтолцооны хувилбарыг дэлхийн 30 шахам орнуудад ашигладаг⁶. Ер нь холимог тогтолцоог ихэнх тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэстний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнууд сонгосон байдаг.

Энэхүү тогтолцоог холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ (паралель) гэж ангилж болно.

- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо: -нд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм.
- Зэрэгцээ (паралель): саналын арга нь сонгогч олонхийг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдгөөрөө ялгаатай.

Судалгаанд сонгуулийн холимог тогтолцоо бүхий 24 орныг хамруулсан бөгөөд сонгогчдын санал гаргах субъектээр нь дараах байдлаар ангилж үзлээ. Үүнд:

- 1) Нэр дэвшигчид санал гаргах
- 2) Намаас нэр дэвшигчдийн жагсаалтад санал гаргах
- 3) Намд санал гаргах

Дээрх 24 орноос:

- ХБНГУ, Шинэ Зеланд, Болгар, Шотланд, Тайланд, Мавритан, Судан зэрэг 7 орон намд болон нэр дэвшигчдэд^{*} санал өгөх журмаар,
- Япон, Филиппин, Камерун, Конго зэрэг 4 орон нэр дэвшигчид болон намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад^{**} сонгогч саналаа гаргах журмаар,
- Сенегал намд болон намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас^{***} сонгон санал өгөх журмаар,
- Румын, Сейшелийн арлууд, Норвеги зэрэг 3 орон сонгогчид зөвхөн нэр дэвшигчидэд санал өгөх журмаар,
- Литва, Лесото, Мексик, БНСУ, Тайван, Венесуэл, Руанда зэрэг 7 орон сонгогчид зөвхөн намд санал өгөх журмаар санал хураалт явуулдаг,
- Унгар улс зөвхөн намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас сонгогч саналаа гаргах журмаар сонгуулийн санал хураалтыг явуулж байна.

Судалгаанд хамруулсан 24 орноос сонгогчид санал өгөх субъектээр нь ангилсан

⁶ Ц.Товуусүрэн. "Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол, арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим" судалгааны тайлан, 2010 он

санал хураалтын арга зам бүхий 3 хүснэгтийг тойргийн хэлбэр болон хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал зэрэг мэдээллийг багтаан доор хавсаргав.

* * *

**Сонгуулийн холимог тогтолцоотой бөгөөд нэр дэвшигчид санал гаргах
зохицуулалт бүхий улс орнууд**

Хүснэгт 1

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Тойргийн хэлбэр	Бүх суудал (Хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал)
1.	Боливи -дээд -доод	-Нэр дэвшигчид	Олон мандаттай 9 тойрог 1 мандаттай 70 тойрогт нэр дэвшигчийн төлөө, олон мандаттай 9 тойрогт намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын төлөө саналаа өгнө. 60 суудал хуваарилна.	130/60 36/36
2.	БНА Конго** -доод	-Нэр дэвшигчид -Нэр дэвшигчидийн нэрсийн жагсаалт	60 нэг мандаттай тойрогт нэр дэвшигчийн төлөө 109 олон мандаттай тойрогт нэрсийн жагсаалтын төлөө Муж бүр 1 тойрогт шууд бусаар пропорциональ системээр	500/440
3.	ХБНГУ* -доод	-Нэр дэвшигчид,	Мажоритар 299 тойрогт нэр дэвшигчийн төлөө, Олон мандаттай 16 тойрог намын нэрийн төлөө саналаа өгнө. Мажоритар суудал нь пропорционалиар хуваарилагдсан суудлаас олон байвал нэмэлт суудал тэргүүн ээлжинд авдаг.	598/299
4.	Шинэ Зеланд*	-Намд, -Нэр дэвшигчид	70 тойргоос мажоритар системээр, Үндэсний 50 мандаттай 1 тойрогт намын нэрийн төлөө саналаа өгнө	120/50
5.	Румын -дээд -доод	-Нэр дэвшигчид	1 мандаттай тойрогт эхний шатанд тооцогдоогүй саналыг үндэсний хэмжээнд нэгтгэж, намуудад хувь тэнцүүлэн хуваарилдаг.	1 мандаттай 315 тойргоос 50%+1 санал авсан нь шууд сонгогдсонд тооцож, үлдсэнийг нь үндэсний хэмжээнд нэгтгэж 10%-ийн босго давсан намд хувь тэнцүүлэн хуваарилна.
6	Норвеги	-Нэр дэвшигчид	19 тойргоос тус бүр 1 нь шууд сонгогдсонд тооцогдож, 150 нь хувь тэнцүүлэн хуваарилагдана.	19/150
7.	Болгар*	-Намд, -Нэр дэвшигчид	31 нь олонхийг төлөөлөх тогтолцоогоор нэр дэвшигчийн төлөө, 209 нь олон мандаттай 31 тойргоос намын төлөө санааа өгнө.	240/209

Судалгааны эмхтгэл, XII боть

8.	Шотланд*	-Намд-1санал, -Нэр дэвшигчид нэмэлт 1 санал	Олон мандаттай 8 тойрог	129/56
9	Тайланд*	-Нэр дэвшигчид-1 санал, -Намд-1 санал	1 мандаттай 375 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 125 мандаттай үндэсний хэмжээний 1 тойрогт намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын төлөө саналаа өгнө.	375/125
10	Филиппин**	-Намын нэр дэвшигчдийн жагсаалтад-1 санал, -Нэр дэвшигчид-1 санал	1 мандат бүхий 228 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 52 мандат бүхий үндэсний 1 тойрогт намын нэр дэвшигчдийн жагсаалтын төлөө санал өгнө.	228 /52/
11	Камерун**	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн жагсаалтад-1 санал	58 тойрог Туйлын олонхи /50%+1/ санал аваагүй ч хамгийн олон суудал авсан намд бүх суудлын 50%-ийг үлдсэн суудлыг намуудын авсан саналд хувь тэнцүүлэн хуваарилна.	180/122
12	Мавритан* -доод танхим	-Нэр дэвшигчид-1 санал	1-2 мандаттай 4 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 3-аас дээш болон 14 мандаттай үндэсний 1 тойрогт хаалттай жагсаалтаар санал хурааж, намуудад их үлдэгдлийн аргаар суудал хуваарилна.	95/14-өөс дээш тодорхойгүй.
13	Сейшел арлууд	-Нэр дэвшигчид	1 мандаттай 25 тойрог Можаритар системээр 10%-аас дээш санал авсан намд 9 суудлыг хувь тэнцүүлэн хуваарилна.	34/9
14	Сенегал** -доод танхим	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	5 хүртэл мандаттай /бүгд 90/ 35 тойрогт намын жагсаалтаас энгийн олонхийн саналаар, 60 мандаттай үндэсний 1 тойрогт намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас сонгоно.	150/60
15	Судан** -доод танхим	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	270 мандат бүхий тойргуудаас нэр дэвшигчийн төлөө, 180 мандтай тойргоос тнамд санал өгнө	450/180

* * *

**Сонгуулийн холимог тогтолцоотой бөгөөд намаас нэр дэвшигчдийн нэрсийн
жагсаалтад санал гаргах зохицуулалт бүхий улс орнууд**

Хүснэгт 2

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Тойргийн хэлбэр	Бүх суудал (Хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал)
1	Япон ^{**} -доод -дээд	-Намын нэр дэвшигчдийн жагсаалтад -Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	-1 мандаттай 300 тойрогт нэр дэвшигчийн төлөө, Олон /6-29/ бүгд 180 мандаттай 11 тойрогт намын нэр дэвшигчдийн жагсаалтын төлөө санал өгнө. Мажаритор системийн сонгуульд нэр дэвшигч нь пропорциональ системийн нэрсийн жагсаалтад орж болно. Сонгогдсон тохиолдолд жагсаалтаас хасагдана -Үндэсний 1 тойрог 96 мандаттай тойрогт нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын төлөө, 2-10(бүгд 146) мандаттай 47 тойрогт нэр дэвшигчдийн төлөө саналаа өгнө. Нэр дэвшигч аль нэгэнд нь нэрээ дэвшүүлэх эрх эдэлнэ	480/180 42/96
2	Унгар	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	64 мандаттай 1 тойрог, олон мандаттай 20 тойрог	386/210
3	Филиппин ^{**}	-Намын нэр дэвшигчдийн жагсаалтад-1 санал, -Нэр дэвшигчид-1 санал	1 мандат бүхий 228 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 52 мандат бүхий үндэсний 1 тойрогт намын нэр дэвшигчдийн жагсаалтын төлөө санал өгнө.	228 /52/
4	Камерун ^{**}	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн жагсаалтад-1 санал	58 тойрог Туйлын олонхи /50%+1/ санал аваагүй ч хамгийн олон суудал авсан намд бүх суудлын 50%-ийг үлдсэн суудлыг намуудын авсан саналд хувь тэнцүүлэн хуваарилна.	180/122
5	Сенегал ^{**} -доод танхим	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	5 хүртэл мандаттай /бүгд 90/ 35 тойрогт намын жагсаалтаас энгийн олонхийн саналаар, 60 мандаттай үндэсний 1 тойрогт намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас сонгоно.	150/60
6	Судан ^{**} -доод танхим	-Нэр дэвшигчид-1 санал, -Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	270 мандат бүхий тойргуудаас нэр дэвшигчийн төлөө, 180 мандтай тойргоос тнамд санал өгнө	450/180

* * *

**Сонгуулийн холимог тогтолцоотой бөгөөд намд санал гаргах з
охицуулалт бүхий улс орнууд**

Хүснэгт 3

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Тойргийн хэлбэр	Бүх суудал (Хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал)
1	Литва	Намд	71 тойрогт нэр дэвшигчийн төлөө санал өгөх ба Үндэсний 1 тойрогтнамын нэрийн төлөө санал өгнө.	141/70
2	Тайланд*	Намд	10 мандаттай 8 тойрог	480/80
3	Лесото	Намд	40 мандаттай үндэсний 1 тойрог	120/40
4	Мексик	Намд	200 мандаттай үндэсний 1 тойрог, 32 мандаттай үндэсний 1 тойрог	500/200, 128/32
5	БНСУ	Намд	1 мандаттай 245 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 54 мандаттай 1 тойрогт намын төлөө саналаа өгнө	299(54)
6	Тайван	Намд	1 мандаттай 176 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 49 мандаттай 1 тойрогт намын төлөө саналаа өгнө	225(49)
7	Венесуэл	Намд	3 хүртэл мандаттай 87 тойргоос 110 гишүүнийг нэр дэвшигчийн төлөө, 2-3 мандаттай 24 тойргоос намын төлөө санал өгнө.	162/52
8	Шинэ Зеланд* -танхимын 50 суудлыг	Намд	70 тойргоос мажоритар системээр, Үндэсний 50 мандаттай 1 тойрогт намын нэрийн төлөө саналаа өгнө	120/50
9	Болгар*	Намд	31 нь олонхийг төлөөлөх тогтолцоогоор 209 нь олон мандаттай 31 тойргоос	240/209
10	ХБНГУ* -доод	Намд	Олон мандаттай 16 тойрог	598/299
11	Мавритан* -дээд	Намд 1санал	1-2 мандаттай 4 тойрогт нэр дэвшигчийн төлөө, 3-аас дээш болон 14 мандаттай үндэсний 1 тойрогт хаалттай жагсаалтаар санал хурааж, намуудад их үлдэгдлийн аргаар суудал хуваарилна.	95/14-өөс дээш тодорхойгүй.
12	Шотланд*	Намд 1санал	1 мандаттай 73 тойрогт нэр дэвшигчийн төлөө, Олон /бүгд 56/ мандаттай 8 тойрогт Намд-1санал, Нэр дэвшигчид нэмэлт 1 санал өгнө	129/56
14	Руанда	Намд	53 мандат бүхий үндэсний 1 тойрогт намд санал өгнө., 27 суудалд шууд бусаар сонгогддог.	80/53

* * *

УНИТАР УЛСУУДЫН ПАРЛАМЕНТЫН БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА, ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООГ ТОГТООХ ЖИШИГ

(Харьцуулсан судалгаа)

*Р. Хатанбаатар, А.Пагма, Б. Цолмонбаяр***УДИРТГАЛ**

УИХ -ын гишүүн Н.Батбаярын захиалгаар “Унитар улсуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишиг” сэдэвт судалгааны ажлыг тус Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Унитар улс орнуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаа, парламентын гишүүдийн тоог тогтоох жишгийг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим унитар орны парламентын бүрэн эрхийн хугацаа, гишүүдийн тоог харьцуулан судлах,
- Нэгээс таван сая хүн амтай унитар улсуудын хүн амын тоо, парламентын гишүүдийн тоог, парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоогоор харьцуулан судлах
- Унитар тогтолцоотой зарим орнуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн талаар харьцуулсан судалгаа хийх
- Дээрх орнуудын парламентын гишүүдийн тоог тогтоодог жишгийг харьцуулан дүгнэлт гаргах зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Судалгаанд хамрагдсан гадаадын зарим орнуудын Үндсэн хуулийн болон хууль тогтоох байгууллага, орон нутгийн сонгуулийн тухай хуулийн холбогдох бүлэг заалт,
 - Гадаадын зарим орны парламентын тухай болон хүн амын статистик мэдээллийг харьцуулах
 - Судалгааны материалыг харьцуулан нэгтгэн дүгнэх

Хамрах хүрээ:

1. Дэлхийн унитар зарим орнуудын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, статистик мэдээлэл, нийт 70 улс,
2. Нэгээс таван сая хүн амтай унитар нийт 20 улсын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, статистик мэдээлэл
3. Унитар тогтолцоотой зарим орнуудын парламентын болон орон нутгийн сонгуулийн хуулийн судалгаа, нийт 20 улс зэрэг болно.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн

- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн ахлах референт Р.Хатанбаатар ахалж, шинжээч А. Пагма, судлаач Б. Цолмонбаяр нар хийж гүйцэтгэв. Бид энэ судалгаандаа дэлхийн унитар тогтолцоотой орнуудад парламентын гишүүдийнхээ тоог хэрхэн тогтоосныг харьцуулан үзлээ. Гэхдээ Австрали, далайн орнууд, Карибийн сав газрын хэт цөөн хүн амтай арлын улсууд болон Африк тивийн төрийн байгуулалт нь тогтворжоогүй орнуудыг судалгаанд аваагүй болно.

Улс орнууд парламентын гишүүдийнхээ тоог тогтоохдоо хүн ам, янз бүрийн нийгмийн бүлгүүдийн эрх ашиг, сонирхлыг бүрэн дүүрэн илэрхийлэх, төлөөлөх боломжтой, оновчтой тоог тодорхойлохын тулд гол төлөв хүн амын тоо, нягтшрал, газар нутгийн байдал, уламжлал, парламент хэрхэн ажилладаг, өөрөөр хэлбэл, байнгын эсхүл байнгын бус ажиллагаатай парламенттай зэргээ харгалздаг байна. Гэхдээ бидний харьцуулалт болон судлаач эрдэмтдийн судалгааны материалаас үзэхэд гишүүдийн тоог тогтооход хамгийн гол хүчин зүйл нь тухайн орны хүн амын тоо байгаа нь харагдаж байна. Ингээд судалгаанд хамрагдсан 70 орныг хүн амын тоогоор нь ангилан авч үзвэл:

1. 800 мянгаас доош хүн амтай 4 орон. Энд парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь 1400 – 9975 байна.
2. 1 саяас 5 сая хүртэл хүн амтай 20 орон. Энд парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь 22000 - 51000 байна. Харин Босни-Герцоговинд 109 мянга, Эстонид 12871 байгаа бусдаасаа нилээн ялгаатай.
3. 5 – 10 сая хүн амтай 15 орон. Энд парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь 26000 -86000 байна. Тажикистаны парламент байнгын ажиллагаатай биш.
4. 10 – 21 сая хүн амтай 11 орон. Энд парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь 49000 - 150000 байна.
5. 26 саяас дээш хүн амтай 19 орон. Энд парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь 82000 – 524000 байна.
6. 1,3 тэрбум хүн амтай Хятад улсын хувьд байнгын бус ажиллагаатай парламентад нь нэг парламентын гишүүний төлөөлж буй хүн амын тоо нь 433333 байна. /Хүснэгт 1/

Эндээс үзэхэд зарим нэг хэлбэлзлийг эс тооцвол улсын хүн амын тоо ихсэх тусам парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо нь ихэсч байна.

Парламентын гишүүдын хүн ам, сонгогчдыг төлөөлөх тооны талаар улс орнуудад өрнөдөг бүтээлч маргаан, мэтгэлцээнээс үзэхэд нэг талаас, парламентын гишүүдийн тоо хэт олон байвал татвар төлөгчдөд болон улсын төсөвт ачаалал нэмэгдэж, дарамт болно, нөгөө талаас, энэхүү тоо цөөн байгаа тохиолдолд парламентын төлөөлөх чадварт сөргөөр нөлөөлж, гишүүдийн ачаалал нэмэгдэх, иргэд, сонгогчдоос холдож хөндийрөх байдал бий болно гэсэн болгоомжлолыг илэрхийлж байна.

Хүснэгт 2 -д Монгол улстай хүн амын тоогоороо ойролцоо, унитар тогтолцоотой, 1-5 сая хүн амтай 20 орныг сонгож авч судлахад,

- 4,6 сая хүн амтай, парламент нь 2 танхимтай Босни – Герцеговин улсын парламентын доод танхимын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо 109 мянга,
- 1,3 сая хүн амтай Эстони улсад парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо 12871,
- 2 сая хүн амтай Македони улсад 16 мянга байгаа нь ерөнхий дундажаас нилээд

зөрж байна.

- Бусад 17 орны хувьд энэ тоо **22000 – 73000** байна.

Судалгаанд хамрагдсан унитар тогтолцоотой улс орнуудын хувьд парламентын болон орон нутгийн сонгуулийн хугацаа нь ижил хугацаатай байдаг бөгөөд ихэвчлэн парламентын сонгуулийн дараа орон нутгийн сонгууль тусдаа явагддаг байна. /Хүснэгт 3/

Хүснэгт1.Унитар тогтолцоотой зарим улс орнуудын парламентын талаархи мэдээлэл

№	Улсын нэр	Хүн амын тоо	Танхимын тоо	Бүрэн эрхийн хугацаа (жилээр)	Танхимын нэр (гишүүдийн тоо)	Парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо
1	2	3	4	5	6	7
1	Азербайжан	9 сая	1	5	Үндэсний Ассамблей (125)	72000
2	Албани	3,2 сая	1	4	Парламент (140)	22857
3	Алжир	34,9 сая	2	Үндэсний Зөвлөл-6 Үндэсний Ардын Ассамблей-5	Үндэсний Зөвлөл (144), Үндэсний Ардын Ассамблей (389)	89717 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
4	Ангол	8,5 сая	1	4	Үндэсний Ассамблей (220)	38636
5	Армен	3 сая	1	5	Үндэсний Ассамблей (131)	22900
6	Беларусь	9 сая	2	4	Төлөөлөгчдийн танхим (110), Бүгд найрамдах Зөвлөл (64)	81818 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
7	Бельги	10,8 сая	2	4	Сенат (71), Төлөөлөгчдийн танхим (150)	72000 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
8	Босни Герцеговин	4,6 сая	2	4	Ардын танхим (15), Төлөөлөгчдийн танхим (42)	109523 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
9	Болгар	7,2 сая	1	4	Үндэсний Ассамблей(240)	30000
10	Венесуэл	26,8 сая	1	5	Үндэсний Ассамблей (167)	160479
11	Вьетнам	85,8 сая	1	5	Үндэсний Ассамблей (493)	174036
12	Грек	11,2 сая	1	4	Парламент (300)	37333
13	Гүрж	4,6 сая	1	4	Парламент (150)	30666
14	Дани	5,5 сая	1	4	Парламент (179)	30726

Судалгааны эмхтгэл, XII боть

15	Израиль	7,2 сая	1	4	Кнессет (120)	60000
16	Индонези	229 сая	1	5	Төлөөлөгчдийн Зөвлөл (560)	408928
17	Ирланд	4,5 сая	2	5	Сенат (60), Төлөөлөгчдийн танхим (166)	27108/зөвхөн доод танхимын төлөөлөл/
18	Исланд	317 мянга	1	4	Парламент (63)	5031
19	Испани	46,0 сая	2	4	Сенат (264), Төлөөлөгчдийн танхим (350)	131428 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
20	Итали	60,4 сая	2	5	Сенат (322), Төлөөлөгчдийн танхим (630)	95873 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
21	Их Британи Вант Улс	62,0 сая	2	Лордууд танхим-байнгын Нийтийн танхим-5	Лордууд танхим (733), Нийтийн танхим (650)	95384 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
22	Казакстан	16,1 сая	2	Сенат-6 Мажилис-5	Сенат (47), Мажилис (107)	150467 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
23	Камбож	13,3 сая	2	Сенат-6 Үндэсний Ассамблей-5	Сенат (61), Үндэсний Ассамблей (123)	108130 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
24	Камерун	18,9 сая	1	5	Үндэсний Ассамблей (180)	105000
25	Кипр	798,0 мянга	1	5	Төлөөлөгчдийн танхим (80)	9975
26	Колумби	45,3 сая	2	4	Бүгд Найрамдах Улсын Сенат (102) Төлөөлөгчдийн танхим (166)	272891 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
27	Коста-Рика	4,2 сая	1	4	Хууль тогтоох Ассамблей (57)	73684
28	Кувейт	3,5 сая	1	4	Үндэсний Ассамблей (65)	49230
29	Кыргызстан	5,4 сая	1	5	Жогорку Кенеш (120)	45000
30	Лаос	6,8 сая	1	5	Үндэсний Ассамблей (115)	59130
31	Латви	2,2 сая	1	4	Парламент (100)	22000
32	Ливан	4 сая гаруй	1	4	Үндэсний Ассамблей (128)	31250

33	Литва	3,3 сая	1	4	Парламент (141)	23404
34	Лихтенштейн	35 мянга	1	4	Диет (25)	1400
35	Люксембург	502,2 мянга	1	5	Төлөөлөгчдийн танхим (60)	8370
36	Македони	2 сая	1	4	Бүгд Найрамдах Ассамблей (120)	16666
37	Молдав	3,5 сая	1	4	Парламент (101)	34653
38	Монгол	2,7 сая	1	4	Улсын Их Хурал(76)	35526
39	Нидерланд	16,5 сая	2	4	Сенат (75) Төлөөлөгчдийн танхим (150)	110000 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
40	Норвеги	4,9 сая	1	4	Парламент (169)	28994
41	Пакистан	166,5 сая	2	Сенат-6 Үндэсний Ассамблей-5	Сенат (100), Үндэсний Ассамблей (342)	486842 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
42	Панам	3,1 сая	1	5	Үндэсний Ассамблей (71)	43661
43	Парагвай	6,9 сая	2	5	Сенаторын танхим (45) Депутатуудын танхим (80)	86250
44	Перу	29,1 сая	1	5	Бүгд Найрамдах Улсын Ассамблей (120)	242500 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
45	Польш	38 сая	2	4	Сенат (100), Сежм (460)	82608 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
46	Португали	11,3 сая	1	4	Бүгд Найрамдах Ассамблей (230)	49130
47	Румын	21 сая	2	4	Сенат (137), Төлөөлөгчдийн танхим (334)	62874 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
48	Серби	7,3 сая	1	4	Үндэсний Ассамблей (250)	29200
49	Сингапур	4,8 сая	1	5	Парламент (94)	51063
50	Словак	5,3 сая	1	4	Үндэсний Зөвлөл (150)	35333
51	Словени	2 сая	2	Үндэсний Зөвлөл-5 Үндэсний Ассамблей-4	Үндэсний Зөвлөл (40), Үндэсний Ассамблей (90)	22222
52	Солонгос (БНСУ)	48,9 сая	1	4	Үндэсний Ассамблей (299)	163545

Судалгааны эмхтгэл, XII боть

53	Тажикистан	7,3 сая	2	5	Үндэсний Ассамблей (34), Төлөөлөгчдийн танхим (63)	115873 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
54	Тайланд	65,9 сая	2	Сенат-6 Төлөөлөгчдийн танхим-4	Сенат (150), Төлөөлөгчдийн танхим (480)	137291
55	Турк	72,5 сая	1	4	Турк Улсын Үндэсний Их Хурал (550)	131818
56	Узбекистан	28,1 сая	2	5	Сенат (100), Хууль тогтоох танхим (150)	187333
57	Украйн	45,9 сая	1	5	Парламент (450)	102000
58	Унгар	10 сая	1	4	Үндэсний Ассамблей (386)	25906
59	Филиппин	88,5 сая	2	Сенат-6 Төлөөлөгчдийн танхим-3	Сенат (24), Төлөөлөгчдийн танхим (250- аас ихгүй гэхдээ хуулиар олон байхаар зохицуулж болно)	354000 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
60	Финланд	5,4 сая	1	4	Парламент (200)	27000
61	Франц	64,5 сая	2	Сенат-6 Үндэсний Ассамблей-5	Сенат (343), Үндэсний Ассамблей (577)	111785
62	Хорват	4,4 сая	1	4	Парламент (153)	28758
63	Хятад	1,3 тэрбум	1	5	Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал (3000)	433333
64	Чех	10,4 сая	2	Сенат-6 Төлөөлөгчдийн танхим-4	Сенат (81), Төлөөлөгчдийн танхим (200)	52000
65	Чили	17 сая	2	Сенат-8 Төлөөлөгчдийн танхим-4	Сенат (38) Төлөөлөгчдийн танхим (120)	141666
66	Швед	9,2 сая	1	4	Парламент (349)	26361
67	Шинэ Зеланд	4,2 сая	1	3	Төлөөлөгчдийн танхим (120)	35000
68	Шри-ланк	21,3 сая	1	6	Үндэсний Ассамблей (225)	94666
69	Эстони	1,3 сая	1	4	Парламент (101)	12871

70	Япон	127 сая	2	Төлөөлөгчдийн танхим-4 Зөвлөхүүдийн танхим-6	Төлөөлөгчдийн танхим (480), Зөвлөхүүдийн танхим (242)	524793
----	------	---------	---	---	--	--------

* * *

Нэгээс таван сая хүн амтай унитар улс орнуудын парламентын гишүүдийн тоо

Хүснэгт 2.

№	Улсын нэр	Хүн амын тоо	Танхимын тоо	Бүрэн эрхийн хугацаа (жилээр)	Танхимын нэр (гишүүдийн тоо)	Парламентын нэг гишүүний төлөөлж байгаа хүн амын тоо
1	2	3	4	5	6	7
1	Албани	3,2 сая	1	4	Парламент (140)	22857
2	Армен	3 сая	1	5	Үндэсний Ассамблей (131)	22900
3	Босни Герцеговин	4,6 сая	2	4	Ардын танхим (15), Төлөөлөгчдийн танхим (42)	109523 /зөвхөн доод танхимын төлөөлөл/
4	Гүрж	4,6 сая	1	4	Парламент (150)	30666
5	Ирланд	4,5 сая	2	5	Сенат (60), Төлөөлөгчдийн танхим (166)	27108/зөвхөн доод танхимын төлөөлөл/
6	Коста-Рика	4,2 сая	1	4	Хууль тогтоох Ассамблей (57)	73684
7	Кувейт	3,5 сая	1	4	Үндэсний Ассамблей (65)	49230
8	Латви	2,2 сая	1	4	Парламент (100)	22000
9	Ливан	4 сая гаруй	1	4	Үндэсний Ассамблей (128)	31250
10	Литва	3,3 сая	1	4	Парламент (141)	23404
11	Македони	2 сая	1	4	Бүгд Найрамдах Ассамблей (120)	16666
12	Молдав	3,5 сая	1	4	Парламент (101)	34653
13	Монгол	2,7 сая	1	4	Улсын Их Хурал(76)	35526
14	Норвеги	4,9 сая	1	4	Парламент (169)	28994
15	Панам	3,1 сая	1	5	Үндэсний Ассамблей (71)	43661

16	Сингапур	4,8 сая	1	5	Парламент (94)	51063
17	Словени	2 сая	2	Үндэсний Зөвлөл-5 Үндэсний Ассамблей-4	Үндэсний Зөвлөл (40), Үндэсний Ассамблей (90)	22222
18	Хорват	4,4 сая	1	4	Парламент (153)	28758
19	Шинэ Зеланд	4,2 сая	1	3	Төлөөлөгчдийн танхим (120)	35000
20	Эстони	1,3 сая	1	4	Парламент (101)	12871

**Унитар тогтолцоотой зарим улс орнуудын парламентын
болон орон нутгийн сонгуулийн талаарх харьцуулалт**

Хүснэгт 3.

Унитар тогтолцоотой улсууд	Хүн ам	Парламентын сонгогдох хугацаа	Парламентын тоо гишүүдийн тоо	Орон нутгийн сонгуулийн хугацаа, парламентын сонгуультай хамтдаа явагддаг эсэх	Тайлбар
1. Болгар	7.2 сая	4 жил	240	4 жил тутамд орон нутаг, парламентын сонгууль нэг өдөр явагддаг /Үндсэн хууль. 64-1/	Үндэсний Ассамблейн гишүүдийг сонгох тухай хуульд 1-р зүйл. Энэхүү акт нь үндэсний ассамблейн гишүүд, орон нутгийн захирагч, дарга нарыг сонгох харилцааг зохицуулна. 4-р зүйл. Сонгогч нэг саналыг Үндэсний ассамблейн гишүүнд, нэг саналыг орон нутгийн захиргааны зөвлөлийн гишүүнд, нэг саналыг орон нутгийн захирагчид, нэг саналыг дүүргийн захирагчид өгнө гэж заажээ. Сонгуулийн холимог тогтолцоотой.
2. Латви	2.2 сая	4 жил	100	4 жил тутамд парламентын сонгууль явагддаг /Үндсэн хууль 4-р зүйл/ Орон нутгийн сонгууль нь тусдаа явагддаг	Хот, тосгоны зөвлөл болон орон нутгийн /Pagasts/ Зөвлөлийн сонгуулийн тухай хуулийн 1-р бүлгийн 1-р зүйлд Хот, тосгон, дүүрэг, орон нутгийн зөвлөлийг 4 жил тутамд ардчилсан, тэгш, шууд, нууц зарчмаар хувь тэнцүүлэх сонгуулийн аргаар сонгоно гэж заажээ.
3. Унгар	10 сая	4 жил	386	4 жил, тусдаа явагддаг	Холимог системээр явагдана.
4. Эстони	1.3 сая	4 жил	101	4 жилийн хугацаатайгаар орон нутгийн сонгуулийг тусдаа явуулдаг	
5. Өмнөд Солонгос	48.9 сая	4 жил	299	4 жилийн хугацаатайгаар орон нутгийн сонгуулийг тусдаа явуулдаг	Холимог тогтолцоогоор явагддаг.

6. Азербайжан	9 сая	5 жил	125	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг.	Орон нутгийн удирдлагын статус, сонгуулийн тухай хуульд зааснаар орон нутгийн зөвлөл нь хүн амын тооноосоо хамааран 5-19 гишүүнтэй байна.
7. Беларусь	9 сая	4 жил	110	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
8. Гүрж	4.6 сая	4 жил	150	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	2009 онд Сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулсан.
9. Дани	5.5 сая	4 жил	179	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Хатуу пропорциональ системээр явагддаг
10. Израйль	7.2 сая	4 жил	120	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Пропорциональ системтэй.
11. Индонези	229 сая	5 жил	560	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
12. Кувейт	3.5 сая	4 жил	65	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
13. Кыргызстан	5.4 сая	5 жил	120	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
14. Люксенбург	502,2 мянга	5 жил	60	5 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
15. Македон	2 сая	4 жил	120	4 жилийн хугацаатай	
16. Норвеги	4,9 сая	4 жил	169	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Орон нутгийн сонгууль нь нэг зэрэг 2 өөр сонгуулиар явагддаг. 1. Мужийн зөвлөлийн сонгууль 2. Хотын зөвлөлийн сонгууль
17. Португал	11.3 сая	4 жил	230	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Хотын болон орон нутгийн сонгууль нь нэг өдөр нэг зэрэг явагддаг
18. Финланд	5.4 сая	4 жил	200	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Эланд мужийн орон нутгийн сонгууль нь парламентийн сонгуультайгаа зэрэг явагддаг.
19. Шинэ Зеланд	4.2 сая	3 жил	120	Орон нутгийн сонгууль нь 3 жилийн хугацаатай тусдаа явагддаг	
20. Молдав	3.5 сая	4 жил	101	4 жилийн хугацаатай тусдаа явагддаг	Пропорциональ системтэй

* * *

Ашигласан материал:

- Дэлхийн улс орнуудын парламент, Улаанбаатар, 2010

- Пятрас Гражулис Предложено наполовину сократить число парламентариев. [www. p-w-w-.ru](http://www.p-w-w.ru)
- Устанавливается порядок определения численности региональных парламентариев. regnum.ru
- www.ipu.org
- The Election Law On City and Town Councils, District Councils and Pagasts* Councils <http://web.cvk.lv/pub/public/28157.html>
- Constitution of Estonia 2013. <http://estonia.eu/about-estonia/country/estonia-at-a-glance.html>
- http://lgi.osi.hu/country_datasheet.php?id=11
- <http://www.belarus.by/en/government/belarus-elections/elections-to-local-councils-of-deputies-belarus>
- <http://lgi.osi.hu/publications/2001/84/Ch5-Georgia.pdf>
- http://www.kl.dk/ImageVault/Images/id_38221/ImageVaultHandler.aspx
- http://books.google.mn/books?id=iVJR9UZnTVAC&pg=PA373&lpg=PA373&dq=elect+local+councils++in+Israel&source=bl&ots=5E40tqn_qh&sig=gGR5NXCCd8zltKX_ffafqFtaK4&hl=mn&ei=LhumTvG8GsaliALZtLHMDQ&sa=X&oi=book_result&ct=result&resnum=4&ved=0CCoQ6AEwAw#v=onepage&q&f=false
- <http://www.cfr.org/indonesia/indonesia-local-elections/p8247#p2>
- <http://www.state.gov/r/pa/ei/bgn/358-76.htm>
- <http://www.electionguide.org/country-news.php?ID=128>
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Norway#Local_elections
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Portugal
- http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Finland
- <http://electionresults24.com/2011-moldovan-local-municipal-election-results.html>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДЭЛХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

(Харьцуулсан судалгаа)

Ч. Базар (Ph.D), Т. Мягмаржав

Судалгааны ажлын агуулга:

Нэгдүгээр бүлэг: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих арга механизм

- Квот гэж юу болох?
- Квотын төрөл
- Квотын ач холбогдол
- Квотыг хэрэгжүүлэх нь чухал
- Квот ямар үр дүнд хүрэх вэ
- Квотын давуу болон сул талууд
- Квотын өнөөгийн байдал

Хоёрдугаар бүлэг: Квотыг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлага

- Өмнөд Азийн орнууд
- Өмнөд Африк болон бусад орнууд
- Арабын орнууд
- Үндсэн хуулиар зохицуулалт хийсэн орны сайн жишээ
- Сонгуулийн хуулиар зохицуулалт хийсэн орны сайн жишээ

Гуравдугаар бүлэг: Дэлхийн удирдагч эмэгтэйчүүдийн товч мэдээлэл

- Төрийн нарийн бичгийн даргаас дээш алба хашсан эмэгтэйчүүд
- Эмэгтэйчүүд өндөр албан тушаалд сонгогдоход учирч буй саад бэрхшээлүүд
- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл
- Хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл
- Хөрөнгө санхүүгийн хүндрэл
- Өндөр албан тушаалд сонгогдон хийсэн өөрчлөлтүүд, ололт амжилт болон улс төрийн зоримог алхмууд
- Өндөр албан тушаалтай эмэгтэйчүүд авилгалд буруутгагдаж байсан эсэх, учир шалтгаан

Судалгааны ажлын удиртгал

2012 онд УИХ-ын сонгуулийн жил болж байгаатай холбогдуулан УИХ-ын Тамгын газрын судалгааны төвийн санаачлагаар “Дэлхийн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо” сэдэвт энэхүү харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв. Тус судалгааны ажилд эмэгтэйчүүдийн квотын тухай ерөнхий ойлголт, хэрэгжилт, үр дүн болон дэлхийн хичнээн орны хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаархи ерөнхий мэдээлэл болон квотыг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлага, түүнчлэн амжилтанд хүрсэн дэлхийн эмэгтэй улс төрчдийн улс төрийн амьдралд учирч байсан саад бэрхшээл, ололт амжилт, улс төрийн зоримог

шийдлүүдийн талаархи харьцуулсан мэдээлэл багтсан болно. Түүнчлэн 80 орны холбогдох хууль тогтоомж дахь квотын талаархи мэдээллийг түүвэрлэн оруулав

Нэг. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих арга механизм

Квот гэж юу вэ?

Хүйсийн төлөөллийн доод хязгаарын хэмжээ буюу квот нь сонгуульт болон томилгоот албан тушаалын бүх түвшинд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувийн доод хязгаарыг тогтоосон тэгш оролцоог ханган баталгаажуулах аргачлал юм. Удирдах, шийдвэр гаргах түвшинд ихэнхдээ эмэгтэйчүүд доогуур байр эзэлдэг тул эмэгтэйчүүдийн квот гэж нэрлэх нь ч бий. Засгийн газар, парламент болон орон нутгийн зөвлөл гэх зэрэг сонгогдох болон томилогдон ажилладаг байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийг квот нь гол зорилгоо болгодог.

Жендэрийн квот нь улс төрийн намууд болон улс төрийн институцийн практикт өргөн тохиолддог эмэгтэйчүүдийг ялгаварлах, улс төрийн өрсөлдөөнд оруулахгүй байх явдлын эсрэг хийж буй хууль зүйн тэмцэл юм.

Квотын төрөл

Квотын хоёр гол төрөл өнөөдөр дэлхий нийтэд өргөн хэрэглэгдэж байна. Үүнд, нэр дэвшигчийн тоонд квот тавих болон тодорхой тооны суудлыг эмэгтэйчүүдэд зориулан хуваах гэсэн хоёр төрөл хамаарна.

Нэр дэвшигчийн квот нь тодорхой нэгэн сонгуульд оролцож байгаа нэр дэвшигчийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн доод хэмжээг тогтоож, улс төрийн намуудаас гарах нэр дэвшигчийн жагсаалтад үйлчилдэг. Хууль ёсны нэр дэвшигчийн квот нь Үндсэн хууль, сонгуулийн хууль болон улс төрийн намуудын хууль зэрэг хуулиудаар дамжин хэрэгжинэ. Хуулиар тогтоосон ийм квотыг бүх улс төрийн намууд даган мөрдөж, шаардагдаж байгаа хувь хэмжээний эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх үүрэгтэй. Харин улс төрийн намын сайн дурын квот нь улс төрийн намууд өөрсдөө тогтоодог квот бөгөөд ихэнхдээ төвийг сахисан зүүний чиглэлийн намууд энэ талаар санаачилгатай, харин либерал болон консерватив намууд нь квотыг хүчтэй эсэргүүцдэг аж.

Эмэгтэйчүүдэд зориулсан суудал гэдэг нь хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдэд зориулсан тодорхой хэмжээний суудал шууд хуваарилан өгөхийг хэлнэ. Үүнийг мөн л Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна. Суудал хувиарлах квот нь дотроо сонгуульгүй шууд томилох, эмэгтэйчүүдийг өрсөлдүүлэн сонгох зэрэг олон янзаар хэрэгждэг. Тухайлбал,

- Уганда улсад сонгуулийн тойрог бүрийн нэг суудал буюу нийт 56 суудал эмэгтэйчүүдэд хувиарлагдсан байдаг.
- Руанда улсад нийт суудлын 30%-д эмэгтэйчүүд тусгай үйл явцын дагуу сонгогддог бөгөөд энэхүү суудлыг зөвхөн эмэгтэйчүүдэд зориулан хадгална гэж Үндсэн хуулиндаа тусгажээ.
- Танзани улсад нийт суудлын 20% эмэгтэйчүүдэд шууд хувиарлагддаг ба үүнийг дараагаар нь улс төрийн намуудад авсан саналынх нь хэмжээгээр хуваарилан өгдөг байна.
- Кени болон Арабын зарим улсууд энэхүү суудал дээр сонгохгүйгээр шууд томилдог.

Жендэр заагаагүй квот нь аль нэг хүйсийн нэр дэвшигч нийт нэр дэвшигчийн тодорхой хувиас хэтэрч болохгүй хэмээн заагддаг. Энэхүү квот нь заримдаа эсэргүүцэгчдийн зүгээс

эрэгтэйчүүдийг ялгаварлаж байна гэсэн гомдол гарсан үед ашиглагдах стратегийн сонголт болж болдог.

Сонгуулийн систем ба квот:

Жендэрийн квотыг пропорциональ тогтолцоон дээр хэрэглэхэд илүү хялбар байдаг. Харин нэг намаас нэг тойрог, нэг нэр дэвшигч гаргадаг мажоритар системд тохиромжгүй хэмээн үздэг.

Квотын ач холбогдол:

Өнөөдөр сонгуулийн квот нь эмэгтэйчүүдийн нэр дэвших доод хэмжээг хамгийн бага 30-40%-д хүргэх эсвэл олон тооны олон улсын гэрээ болон тунхагаар баталгаажсан жендэрийн тэгш байдлын хэмжээнд хүргэх зорилготой. Квотыг заримдаа түр зуурын арга хэмжээ гэж үздэг ч эмэгтэйчүүдэд сонгогдоход тулгарч байгаа бүх саад бэрхшээл арилсан хойно л хэрэглэхгүй болох билээ. Квот нь төлөөллийн ардчиллыг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилготой. Ихэнх улсад хүн амын 50%-иас дээш эмэгтэйчүүд эзэлдэг боловч дэлхий даяар парламентын суудлын 16% орчим нь эмэгтэйчүүд байдаг байна. Ийм тохиолдолд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж байгаад квотын ач холбогдол оршино.

Квотыг хэрэгжүүлэх нь чухал

Шууд хувиарласан квот бол хэрэгжих бүрэн үндэслэлтэй. Нэр дэвшигчийн квот хэрэгжихгүй байх тохиолдол их байдаг. Шалтгаан нь:

- Хэдийн хэмжээний квот тавина төдий тооны эмэгтэй сонгогдоно гэсэн үг биш.
- Хэрэгжүүлэх арга зам /дүрэм журмыг боловсруулан мөрддөггүй/-ыг тодорхой боловсруулаагүй.
- Нэрсийн жагсаалтын доогуур буюу ялах магадлалгүй газар тэдний нэрийг байрлуулдаг.

Квот ямар үед үр дүнд хүрэх вэ?

Жендэрийн квот нь эмэгтэйчүүдэд улс төрд орох эхлэл цэг болдог. Үүнийг өмнө нь улс төрөөс бүрэн хаалттай байсан Иордан болон Афганистан зэрэг орны жишээн дээрээс харж болно. Түүнчлэн квотыг эмэгтэйчүүдийн байр суурийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, эсвэл буцаж муудахаас сэргийлэхийн тулд хийдэг. Скандинавын орнууд эмэгтэйчүүдийн төлөөллийн хувьд байнгын тогтвортой өсөлтийг харуулж байгаа бол Аргентин, Коста Рика, Өмнөд Африк болон Руанда улсууд нь үр дүнд түргэн хүрэх загвар болж байна.

Квотын системийг хэрэгжүүлснээр эмэгтэйчүүдэд тулгараад байгаа асуудлуудыг дангаар шийдэж чадахгүй. Улс төрийн намууд, боловсролын систем, ТББ-ууд, ҮЭ, сүм хийд гээд бүгд байгууллага дотор хариуцлагаа ухамсарлан доод түвшнээс дээд хүртэл эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих шаардлагатай. Тухайлбал, Шведэд квотын системээс эмэгтэйчүүдийн оролцоог эхлээгүй. Танд эхлээд эмэгтэйчүүдийг бэлтгэн, тэд улс төрд орох боломж, чадвартай гэдгийг итгүүлж, түүнчлэн системийг бэлтгэж эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ялагдахад ичихгүй байх нөхцлийг хангажээ. Дараа нь квотыг ашиглан өөрчлөлт хийж эхэлсэн байна. /Бригитта Даль, Шведийн парламентын дарга асан/

Квотын давуу болон сул талууд

Сул талууд:

- Эмэгтэйчүүдэд давуу тал олгодог учраас бүгд тэгш байх зарчимд харшилдаг.\

- Улс төрийн төлөөлөл нь санал бодол болон улс төрийн намын үйл ажиллгааны сонголт байхаас хүйс зэрэг нийгмийн категорийн сонголт биш.
- Квот бол ардчилал бус, учир нь хэн сонгогдохыг сонгогч нар л мэдэх учиртай.
- Квотоос болоод улстөрчид зөвхөн хүйсээсээ хамааран сонгогддог, харин мэдлэг чадвараасаа хамааран сонгогдохгүй учраас илүү чадвартай нэр дэвшигч нар ялагддаг.
- Олон тооны эмэгтэйчүүд зөвхөн эмэгтэй хүнийхээ хувьд сонгогдохыг хүсэхгүй байгаа.
- Квот тогтоох нь намын байгууллагын дунд ихээхэн зөрчилдөөнийг үүсгэнэ.
- Эмэгтэйчүүдэд квот тогтоосноор удахгүй бусад бүлгийнхэнд квот тогтоох хэрэгтэй болно, ингэснээрээ улс төрийн тогтворгүй санамсаргүй бүлэг үүсэх ба тохиолдлын бүлгийн сонирхлыг л хамгаална.

Давуу талууд:

- Эмэгтэйчүүдийн квот нь ялгаварлан гадуурхдаг, эмэгтэйчүүдэд эдлэх ёстой эрхийг нь эдлүүлэхгүй байгаа саад бэрхшээлүүдийн нөхөн төлбөр болдог.
- Хууль тогтоох байгууллага болон байнгын хороонд хэд хэдэн эмэгтэй байхыг квот бий болгодог бөгөөд ингэснээр тэд цөөн тооны эмэгтэйгээс хавьгүй илүү чадалтай болдог.
- Эмэгтэйчүүд иргэн болохын хувьд тэгш төлөөлөлтэй байх эрхтэй.
- Улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн туршлага, мэдлэг боловсрол хэрэгтэй.
- Эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдийн сонирхлыг төлөөлж чадахгүй. Харин олон тооны эмэгтэйчүүд байваас сонирхлоо зэрэг илэрхийлж чадна.
- Сонгууль бол төлөөллийн үйл явц болохоос боловсролын чанарын шалгалт биш.
- Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй эн зэрэгцэх боломжтой, харин эрчүүд давамгайлсан улс төрийн системд эмэгтэйчүүдийн чадавхийг бууруулж тооцож ирсэн.
- Квот нь эрэгтэй хүнийг хувь хүнийх нь хувьд ялгаварлан гадуурхдаггүй. Харин улс төрийн намыг зөвхөн эрэгтэйчүүдийг дэвшүүлэхийг л хязгаарладаг. Сонгогчдын хувьд эмэгтэй нэр дэвшигчид нар байгаа болохоор санал өгөх боломжууд нь өргөждөг.
- Квот тогтоох нь зөрчилдөөн үүсгэж болох ч энэ нь түр зуурын л үзэгдэл юм.

Квотын өнөөгийн байдал

Эмэгтэйчүүдийн квотын системийг 90 гаруй орон, үүнээс 40 гаруй нь Үндсэн хуулиар, 50 гаруй нь Сонгуулийн хуулиараа хуульчлан хэрэгжүүлж байгаа аж. Үүний дотор Соц-интерний 62 орон сонгуулийн квоттой байдаг байна.

Үндсэн хуулиар болон сонгуулийн хуулиар квотыг зохицуулсан орнууд

Улс орон	Квотын төрөл	Эхэлсэн жил	Одоогийн квотын хувь	Парламент дахь эмэгтэйчүүдийн хувь
Америк тив				
Аргентин	Үндсэн хууль, хууль	1991	30	34.1 /2003/

Боливи	Хууль	1997	30	18.5 /2002/
Бразил	Хууль	1997	30	8.2 /2002/
Коста Рика	Хууль	1996	40	35.1 /2002/
Доминикан	Хууль	1997	25	17.3 /2002/
Эквадор	Хууль	1997	20	16.0 /2002/
Гуйана	Үндсэн хууль	-	33	20.0 /2001/
Гондурас	Хууль	2000	30	5.5 /2001/
Мексик	Хууль	2002	30	22.6 /2003/
Панам	Хууль	1997	30	9.9 /1999/
Парагвай	Хууль	1996	20	10.0 /2003/
Перу	Хууль	1997	30	17.5 /2001/
Европ тив				
Бельги	Хууль	1994	33	35.3 /2003/
Босни Герцеговина	Хууль	2001	33	16.7 /2002/
Франц	Үндсэн хууль, Хууль	1999, 2000	50	12.1 /2002/
Македон	Хууль	2002	20	17.5 /2002/
Серби	Хууль	2002	30	7.9 /2003/
Африк, Ойрхи Дорнод				
Жибути	Хууль	2002	10	10.8 /2003/
Эритрей	Үндсэн хууль	-	30	/2001/
Иордан	Хууль	2003	6 суудал	5.5 /2003/
Кени	Үндсэн хууль	1997	6 суудал	6.7 /2002/
Марокко	Хууль	2002	30 суудал	10.8 /2002/
Руанда	Үндсэн хууль, Хууль	2003	30	48.8 /2003/
Судан	Хууль		10	9.7 /2000/
Танзани	Үндсэн хууль, Хууль	2000	20-30	22.3 /2000/
Уганда	Үндсэн хууль, Хууль	1995, 1989	56 суудал	24.7 /2001/
Ази				
Афганистан	Үндсэн хууль	2004	25	25.0 /2004/
Армени	Хууль	1999	5	4.6 /2003/

Бангладеш	Үндсэн хууль	2004	45 суудал	2.0 /2001/
Индонези	Хууль	2003	30	11.0 /2004/
Ардчилсан Солонгос	Хууль	-	20	-/2003/
Балба /Нерал/		1990	5	5.9 /1999/
Пакистан	Хууль	2002	60 суудал	21.6 /2002/
Филиппин	Үндсэн хууль, Хууль	1995, 1995	20	17.8 /2001/
Тайвань	Үндсэн хууль	1997	10-25	22.2 /2001/

Тайлбар:

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд парламент дахь эмэгтэй гишүүдийн тогтвортой харьцаа /30 болон түүнээс дээш хувь/ гурав дахин нэмэгдсэн бол эмэгтэйчүүдийн эзлэх хувь 10% -иас бага байдаг парламентын хувь бараг 2 дахин багассан байна. Квотыг хэрэгжүүлснээр Руанда, Коста Рика, Аргентин, Мозамбик, Өмнөд Африк зэрэг улсууд ОУПХ-ны улсууд дотор маш дээгүүр жагсах болжээ. Өмнө нь Дани, Финлянд, Исланд, Норвеги, Швед зэрэг 5 улс олон жилийн турш тэргүүн байрыг эзэлж байсан ч өнөөдөр эдгээр нь ихээхэн сорилттой тулаад байна.

Хоёр. Квотыг хэрэгжүүлж буй орнуудын туршлага**Ирак:**

2004 онд гарсан Сонгуулийн хуулийн заалтын дагуу улс төрийн намууд нь эмэгтэй нэр дэвшигчдийг жагсаалт дээрээ дараалсан гурван байрлал болгоны нэгд байрлуулах ёстой буюу “Жашсаалт дээр байгаа эхний цувраа 3 нэр дэвшигчийн нэгээс доошгүй нь эмэгтэй, эхний цувраа зургаан нэр дэвшигчийн хоёроос доошгүй нь эмэгтэй ...байх ёстой” гэх мэтчилэн хуулиндаа зааж, дүрэм, журмыг мөрдсөнөөр сонгогдсон төлөөлөгч нарын 31%-ийг эмэгтэйчүүд эзлэх болжээ.

Аргентин:

1991 онд батлагдсан квотын хуулиар намын нэр дэвшигчдийн жагсаалтын 30%-иас доошгүй нь эмэгтэйчүүд байх ёстой гэж заажээ. Түүнчлэн “боломжит 2-4 дүгээр байрлалын хооронд нэг эмэгтэй, 5-9 дүгээр байрлал дээр хоёр эмэгтэй, 9-11 дүгээр байрлал дээр 3 эмэгтэй” гэх мэтээр зааж өгсөн байна. Үүний үр дүнд эмэгтэйчүүд нийт сонгогдсон төлөөлөгчдийн 34% болжээ.

Швед:

Социал демократууд болон зүүний намыг оролцуулаад хэд хэдэн улс төрийн намууд эмэгтэйчүүдийн нэрсийг байрлуулахдаа сөөлжсөн жагсаалт буй нэг эрэгтэй-нэг эмэгтэй-нэг эрэгтэй-нэг эмэгтэй гэсэн зарчмаар явагдана гэдгийг дүрэм, журамдаа оруулж мөрдсөн байна.

Скандинавын орнууд:

Үзүүлэлт: 2005 оны статистикаар Шведийн парламентын 45%, Финляндын 38%, Данийн 37%, Норвегийн 36% болон Исландын 30%-ийг эзэлж байжээ.

Тайлбар:

Эдгээр оронд квотыг баталгаажуулсан Үндсэн хуулийн болон бусад хуулийн заалт байхгүй. Өндөр өсөлтөд хүрсэн шалтгаан нь эмэгтэйчүүдийн

бүлэг, байгууллагуудын тогтвортой үзүүлсэн шахалт, шаардлагууд болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үр дүн аж. Эмэгтэйчүүд улс төрийн намуудад эмэгтэй гишүүдийнхээ нэр дэвшилтийг өсгөх шахалтуудыг тасралтгүй хийжээ. Үр дүн нь намууд ялангуяа төвийн болон зүүний хүчний намууд нь /1970, 1980, 1990-ээд онуудад/ сайн дураараа намын дотор квот тогтоосноор тэрхүү шаардлага биелж эхэлсэн байна.

Өмнөд Азийн орнууд:

Улс	Доод танхимын эмэгтэй гишүүд	Квотын заалт		Сонгуулийн тогтолцоо
		Үндэсний	Орон нутгийн	
Бангладеш	2.0 /2001 оны сонгууль/	345 суудлын 45 дээр нь эмэгтэйчүүд сонгогдох заалттай. /2004 оны Үндсэн хуулийн өөрчлөлт/	Дор хаяад 25 хувь нь эмэгтэйчүүдэд ноогдоно.	Олонхийн систем
Энэтхэг	8.3		Эмэгтэйчүүд болон бусад хязгаарлагдмал бүлгээс дор хаяад 33% /1992 оны Үндсэн хуулийн өөрчлөлт/	Олонхийн систем
Пакистан	21.1	342 суудлын 60 нь эмэгтэйчүүдэд шууд олгогдсон	Дүүргийн хэмжээнд нийт суудлын 33% нь эмэгтэйчүүдэд оногдсон.	Хосолсон /Олонхийн тогтолцоог жагсаалттай хослуулсан/

Тайлбар:

3 улсад оршин буй систем өөр өөр байна. Пакистан, Бангладешт Үндэсний болон орон нутгийн төвшинд квотын систем нэвтэрсэн бол Энэтхэгт зөвхөн орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байна. Энэтхэгт төлөөллийн суудлыг ээлжлэн авах систем байдаг. Төлөөллийн сонголтыг шазар зүйн хувьд сольж байхын тулд эмэгтэйчүүдэд олгогдсон тойргуудыг сонгууль бүрт сольж байдаг. Ингэснээр эмэгтэй төлөөллийн заламж чанар алдагдахад хүрдэг.

Бангладешт эмэгтэйчүүдийг сонгох тойрог нь шууд сонгуулийн тойргоос 3 дахин том байдаг. Ийм жишиг нөгөө 2 улсад байдаггүй.

Пакистанд холбоо нь нөгөө хоёр улсад байдаг шиг өөр өөр тойрогт хуваагддаггүй боловч бүх нэр дэвшигчдийн хувьд нэг тойргийн үүрэг гүйцэтгэдэг.

Эдгээр оронд квотын ижил төстэй зүйлүүд бий. Энэ нь сонгуулийн мажоритар систем, намд сууриалсан улс төрийн систем зэрэг болно.

Өмнөд Африк болон бусад орон:

Өмнөд Африк болон Мозамбикт улс төрийн намууд квотын механизмыг нэвтрүүлсэн. Өмнөд Африкийн хөгжлийн холбооны гишүүн орнууд 2005 он гэхэд парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30%-д хүргэх зорилт тавин ажилласны дүнд Өмнөд Африк, Мозамбик, Намиби, Уганда, Эритриа зэрэг орнуудын парламентад эмэгтэйчүүд 22-30%-ийг эзэлж байна.\

Америк тив:

Сүүлийн 10 гаруй жилд энэ тивийн парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 5.5%-иар нэмэгдсэн байна. Одоогоор Америк тивийн 11 оронд төрөл бүрээр хуульчилсан квотыг

хэрэгжүүлж, Аргентин, Коста Рика, Мексик зэрэг орнуудын парламентад эмэгтэйчүүдэд 20-иос дээш хувийг эзэлж байна. Түүнчлэн хэд хэдэн улс төрийн намууд чөлөөт квоттой болжээ.

Латин Америк

Эквадорын жишээн дээр: 1980-аад оны эхэн үеэр Эквадор улсад өрнөсөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн гарал үүсэл болон соёлын нөхцөл байдлын ялгааг үл хамааран, эмэгтэйчүүдэд ээлтэй хууль тогтоомжууд батлан гаргахыг шаардаж жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулжээ.

1998 онд 5.5% байсан эмэгтэйчүүдийн оролцоо 2000 онд 24.8%-д хүрч өсчээ. Түүнчлэн 1998-2000 оны хугацаанд нутгийн уугуул эмэгтэй Конгрессын Дэд ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан байна. 2002 оны сонгуулиар байнгын 100 суудлын 17 суудалд эмэгтэйчүүд сонгогдсон бол түр суудлын 19-д эмэгтэйчүүд ялжээ.

Тайлбар:

1997 онд баталсан Квотын хуулиар улс өрийн нам, эвслүүдээс нэр дэвшигчдийн жагсаалтад нэгээс илүү нэр дэвшигч бүхий сонгуулийн тойргуудын нэр дэвшигчдийн жагсаалтад 20%-иас доошгүй нь эмэгтэйчүүд байхаар заасан бөгөөд энэхүү заалт 1998 оны сонгуульд анх хэрэглэгдсэн байна.

1998 онд хийсэн Үндсэн хуулийн өөрчлөлт нь сонгуульд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд тэгш эрхтэйгээр оролцох эрхийг баталгаажуулсан.

2000 онд хийсэн Сонгуулийн хуулийн болон Улс төрийн оролцооны хуулийн шинэчлэлээр улс төрийн намууд нэр дэвшүүлэхдээ баримтлах эмэгтэй нэр дэвшигчийн квотыг заан өгчээ. Энэхүү квот нь одоогоор тогтоосон 30%-иас сонгууль болгоны дараа 5%-иар нэмэгдэх ёстой бөгөөд энэхүү тоо нь сонгууль бүрээр явсаар байгаад 50% хүртэл нэмэгдэхээр хуульчилжээ. Сонгуулийн хуулийн 59 дүгээр зүйлд "Гурван төлөөлөгч сонгодог тойргуудад дор хаяад нэг эмэгтэй нэр дэвшигч байх бөгөөд дахин нэгийг сонголтот байдлаар байлгана..." хэмээн заажээ.

Арабын орнууд:

Үзүүлэлт: Арабын ертөнцийн /Номхон далайн бүс нугийг оруулахгүйгээр/ орнуудын парламент дахь эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлт 6.5 хувь / Иракт 31%, Тунист 22.8%, Сири 12%, Жибути 10.8%/-тай байна. Дэлхийн бусад бүс нутагтай харьцуулахад Араб эмэгтэйчүүд парламентын дээд танхимд илүү их төлөөлөлтэй байгаа нь дээд танхимыг шууд томилдогтой холбоотой байж болно гэж судлаачид үздэг.

Бодит байдал:

Нэгдүгээрт, олон оронд хууль зүйн эерэг өөрчлөлт хийгдсэн ч эмэгтэйчүүдэд тулгарч байгаа гол асуудлын тоонд хууль эрх зүйн ялгавартай байдал багтсан хэвээр байна. Нийгмийн хамгаалал, тэтгэвэр, орлогын албан татвар, өв залгамжлах, эрүүгийн гэмт хэргийн шийдвэрлэлт зэрэгт эмэгтэйчүүдэд тэгш ханддаггүй хэвээр байна.

Хоёрдугаарт, Сонгуулийн үйл явцтай холбоотой. Сонгууль явагддаг нөхцөл байдал нь олон улсын болон бүс нутгийн хэмжээний хөгжлөөс шалтгаалаад үргэлж өөрчлөгдөж байдаг. Үүн дээр нэмээд сонгуулийн хуулийг зөвхөн түр хэрэгжих хууль байдлаар баталсан тохиолдол байдаг тул энэхүү хуулийн талаар парламент болон олон нийтийн түвшинд хэлэлцүүлэг явуулах боломж хаагдмал байдаг байна. Энэ байдлаас үүдээд ялгаварлан гадуурхах үйл явцыг өөрчлөх талаар төлөвлөх болон лобби явуулах боломжууд хаагддаг ажээ.

Үндсэн хуулиар зохицуулалт хийсэн орны сайн жишээ**Руанда улс**

Хуулийн зохицуулалт:

2003 онд баталсан Үндсэн хуулиндаа “Жеэджрийн тэгш эрхийн зарчмыг онцгойлон авч үзэлгүйгээр Руандачуудын хоорондын тэгш эрх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын тэгш эрхийг үндэсний хөгжлийн заавал мөрдөх зарчим болгон баталгаажуулна” хэмээн заажээ. Нэгдүгээр бүлэгт “Руандачуудын тэгш байдал бол Үндсэн хуулийн нэг “тулгуур зарчим” мөн” гэж заасан байна. Түүнчлэн “...Тэгш байдлыг бий болгох нэг хөшүүрэг нь “шийдвэр гаргах түвшний” албан тушаалын 30-оос доошгүй хувийг эмэгтэйчүүд эзэлнэ” хэмээн заасан байна.

Бодит байдал:

2 танхимт парламенттай. Үндсэн хуулийн дагуу Сенатын гишүүдийн 30 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг. Төлөөлөгчийн танхимын 80 гишүүний 53-ыг нь пропорцианал төлөөллийн системээр шууд сонгодог. Бусад суудлыг дараахи байдлаар буюу 30 хувь /24 суудал/-ийг муж бүрийн болон нийслэл хот Кигалигийн эмэгтэйчүүдээс, 2 суудлыг Үндэсний залуучуудын зөвлөлөөс, 1-ийг Тахир дутуу хүмүүсийн нийгэмлэгүүдийн холбооноос сонгодог байна.

Эмэгтэйчүүд эзлэх ёстой 24 төлөөллийг зөвхөн эмэгтэйчүүд оролцсон сонгуулиас сонгох ба үүнд зөвхөн эмэгтэй хүн сонгож, эмэгтэй хүн сонгогддог. Эмэгтэйчүүдийн суудлын төлөөх сонгуулийг эмэгтэйчүүдийн зөвлөлүүд зохицуулдаг. Энэхүү зөвлөлүүдийн тогтолцоог тус улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн яамнаас зохицуулан бий болгож, бэхжүүлжээ. Төлөөллийн танхимын эмэгтэйчүүд сонгогдох 24 суудлаас гадна чөлөөт өрсөлдөөнөөр сонгогдох суудалд дахин 15 эмэгтэй сонгогдож, 2003 оны сонгуулиар нийт 80 суудлын 39 буюу 48,8%-ийг эмэгтэйчүүд эзэлжээ.

Сонгуулийн хуулиар зохицуулалт хийсэн орны сайн жишээ**Аргентин улс**

Хуулийн зохицуулалт:

Үндэсний сонгуулийн тухай хууль ба 24012 тоот хуульд “нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь болон сонгогдох боломжтой жагсаалтад эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлээгүй бол тухайн намын нэр дэвшигчийн жагсаалтыг бүртгэхгүй” гэж заасан байдаг. Түүнчлэн “боломжит 2-4 дүгээр байрлалын хооронд нэг эмэгтэй, 5-9 дүгээр байрлал дээр хоёр эмэгтэй, 9-11 дүгээр байрлал дээр 3 эмэгтэй” гэх мэтээр зааж өгсөн байна.

Бодит байдал:

Эмэгтэйчүүд нийт сонгогдсон төлөөлөгчдийн 34% болжээ. Сонгуулийн энэхүү систем нь Конгресс дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэх явцыг баталгаажуулж өгчээ. Квотыг хүлээн зөвшөөрөх бодит түлхэц нь түүний төлөө олон улс төрийн хүчний төлөөлөл болсон эмэгтэйчүүд нэгдэн нийлж чадсан байна. Эмэгтэйчүүдийн эв санааны нэгдэл бол намын эвслээс хавьгүй хүчтэй, чухал зүйл байжээ.

Монгол Улс

Манай УИХ-д 1992 онд эмэгтэйчүүд 7,7% нэр дэвшиж байсан бол 2008 онд 19% болж өссөн байна. 2000 онд парламентад хамгийн олон буюу 9 эмэгтэй /12%/ төлөөлөл байсан бол 2008-2012 оны Их хуралд 3 эмэгтэй буюу 3,9% болон буурчээ. Дэлхийд хамгийн бага

хувьтай 20 орны тоонд Тонго, Иемен, Оман зэрэг оронтой хамт Монгол явж байна. Түүнчлэн Жендэр хөгжлийн индексээр Монгол улс 2011 онд дэлхийн 140 орноос 94-т оржээ.

Гурав. Дэлхийн удирдагч эмэгтэйчүүдийн товч мэдээлэл

Судалгааны гуравдугаар бүлэг болох энэ хэсэгт дэлхийн хэмжээнд өндөр албан тушаалд томилогдож байсан зарим эмэгтэйчүүдийн тухайн албан тушаалд сонгогдон ажиллахад тулгарч байсан саад бэрхшээл, ололт амжилт, сонгогдсоноор хийсэн өөрчлөлт шинэчлэлт, авилгалд буруутгагдаж байсан эсэх, улс төрийн ямар зоримог шийдлүүд гаргасан болон дэлхийн бусад улс оронд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг хэрхэн дэмжиж байгаа талаарх тойм мэдээллийг тусгасан болно.

Дэлхий дахинаа улс төрд эмэгтэйчүүдийн нөлөө, оролцоо өсөж байхад манай оронд л эсрэгээрээ байна гэх гомдол улс төрд идэвхтэй оролцдог эмэгтэйчүүдээс маань нэг бус удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байсан. Үнэхээр ч эмэгтэйчүүдийн мэдээллийн сайтаас гаргасан эмэгтэй удирдагчдийн жагсаалтаас харвал дэлхийн түүхийн бүхий л хугацаанд гарын таван хуруунд багтахуйц эмэгтэйчүүд төр засгийн эрх барьж байсан бол зуунаас зуунд дамжих бүрт эмэгтэй удирдагчдын тоо, томилогдох давтамж тун хурдтай өсч байгаа нь анзаарагдана. Тодруулбал, түүхийн эртний үеэс XXI зуун хүртэл нийт 85 эмэгтэйчүүд улс орны удирдах албан тушаалд ажиллаж байсан тухай тоо баримт байна.

Эдгээрээс доорх 18 эмэгтэй улс төрчийн улс төр дахь түүхэн замналаас багцлан, тэдэнд тулгарч байсан саад бэрхшээл, ололт амжилт болон улс төрийн зоримог шийдвэрүүдийн талаар багцлан хүргэж байна. Үүнд:

Төрийн нарийн бичгийн даргаас дээш алба хашсан эмэгтэйчүүд

1. Мадлен Олбрайт / АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан 1997-2001 он /
2. Кондолиза Райс /АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан 2005-2009 он/
3. Хиллари Родэм Клинтон / АНУ-ын 67 дахь Төрийн нарийн бичгийн дарга 2009 оны 1-р сараас эдүгээ хүртэл ажиллаж байгаа/
4. Ангела Меркел /Германы Холбооны Канцлер 2005 оноос эдүгээ хүртэл /
5. Индра Ганди /Энэтхэг улсын Ерөнхий сайд байсан 1966-1977, 1980-1984 он/
6. Пратибха Девисингх Патил /Энэтхэг Улсын Ерөнхийлөгч 2007 оны 7-р сараас эдүгээ хүртэл ажиллаж байгаа/
7. Юлия Тимошенко /Украин улсын Ерөнхий сайд асан 2005, 2007-2009 он/
8. Далиа Грайбоскайте /Литва улсын Ерөнхийлөгч 2009 он/
9. Таря Халонен /Финлянд Улсын Ерөнхийлөгч 2000 он/
10. Лаура Чинчилла /Коста Рика Улсын Ерөнхийлөгч 2010 он/
11. Жоханна Сигурдартоттир /Исланд Улсын Ерөнхий сайд 2008 он/
12. Шейк Хасина Важед /Бангладеш Улсын Ерөнхий сайд 1996-2001, 2009 он/
13. Эллен Жонсон /Либер Улсын Ерөнхийлөгч 2005 он/
14. Жулиа Гиллард /Австрали улсын Ерөнхий сайд 2010 он/
15. Дилма Русеф /Бразил улсын Ерөнхийлөгч 2008 он/
16. Кристина Фернандез де Кирчнер /Аргентин улсын Ерөнхийлөгч 2011 он/
17. Беназир Бхутто /Пакистаны ерөнхий сайд байсан 1988-1990, 1993-1996/
18. Глория Макапал Аройо /Филлиппин улсын Ерөнхийлөгч 2004-2007 он/

Нэр бүхий эдгээр 18 эмэгтэй удирдагчдын талаар дараахи асуудлуудаар багцлан тодорхой

мэдээлэл хүргэхийг зорив. Үүнд:

1. Эмэгтэйчүүд өндөр албан тушаалд сонгогдоход учирч буй саад бэрхшээл
2. Өндөр албан тушаалд сонгогдон хийсэн өөрчлөлтүүд, ололт амжилт болон улс төрийн зоримог алхамууд
3. Өндөр албан тушаалтай эмэгтэйчүүд авилгалд буруутгагдаж байсан эсэх, учир шалтгаан

1. Эмэгтэйчүүд өндөр албан тушаалд сонгогдоход учирч буй саад бэрхшээл

Дэлхийн нэр хүндтэй улс төрч эмэгтэйчүүд өндөр албан тушаалд хүрэхийн тулд дараахи бэрхшээлүүд тохиолдож байсан нь тэдний түүхээс харагдаж байна. Тухайлбал:

- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл

Тухайлбал, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Кондолиза Райсын хувьд хамгийн том саад бэрхшээл бол арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл байсан нь түүний намтараас тод харагдаж байдаг. Энэхүү арьс өнгөөр ялгаварлах үзэл түүнийг бага настай байхаас эхлэн оюутан болон төрийн өндөр албанд очих хүртэл нь байсан байдаг. Энэ бэрхшээл ганц Кондолиза Райсд байгаагүй бөгөөд бусад хар арьст эмэгтэй улс төрчдөд ч мөн адил тулгарч байсан бэрхшээл байдаг.

- Хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл

Хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл бол аль ч улсын эмэгтэй улс төрчдийн хувьд тулгардаг нийтлэг бөгөөд томоохон саад бэрхшээлийн нэг юм. Тухайлбал, АНУ-ын нэртэй улс төрчдийн нэг болох Хиллари Клинтон Төрийн нарийн бичгийн дарга асан Мадлен Олбрайт, Австралийн Конгрессийн гишүүн асан өдгөөгийн Ерөнхий сайд Жулиа Гиллард, Либерийн ерөнхийлөгч Эллен Жонсон, Литвийн ерөнхийлөгч Далиа Грайбоскайте, Украины ерөнхий сайд асан Юлия Тимошенко гэх мэт дэлхийн улс орнуудын бүхий л эмэгтэй улс төрчдөд хүйсийн байдал нь давуу эрх олгох биш харин ч улс төрийн замналд нилээд хэмжээгээр бэрхшээл учруулдаг байсан нь тэдний намтар түүхээс тод харагддаг.

Тухайлбал, 2008 оны АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд Хатагтай Клинтон бараг 2003 оноос эхлэн бэлтгэсэн ба 2007 оны 1 сарын 20-ны өдөр өөрийн веб сайтаар дамжуулж Хиллари АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх тухайгаа анх "... Миний нэр, нэр дэвшигчдийн дунд байх болно, би ялах болно" гэж мэдээлсэн байдаг. Үүнээс өмнө Нэгдсэн улсын ерөнхийлөгчийн сонгуульд эмэгтэй хүн нэр дэвшиж байсан түүх байдаггүй нь 200 гаруй жилийн ардчилалын түүхтэй улсад эмэгтэй улс төрчийн хувьд ямар өндөр шалгууртай болох нь харагдаж байна. Энэ байдал бусад улс орны эмэгтэй улс төрчдийг тойрч гараагүй байна.

Түүнчлэн, Либерийн Ерөнхийлөгч Эллен Жонсон Африкийн анхны эмэгтэй Ерөнхийлөгч Тэрбээр 1970-аад оны сүүлчээр Либерийн Сангийн сайдаар ажиллаж байж. Гэвч 1980 онд Самуэль До цэргийн хүчийг булаах үед Жонсон Кени улс руу дүрвэж, "Сити" банкны захирал болжээ. Тэрбээр 1996 онд эх орондоо эргэн ирж, 2005 онд улс орноо олон жилийн иргэний дайнаас чөлөөлөх, иргэддээ хайр халамж үзүүлэхээр амлаж, сонгуульд дахин өрсөлдөн ялалт байгуулжээ.

Түүнчлэн 2012 онд тэрээр Либерийн улсын ерөнхийлөгчөөр хоёр дахь удаагаа улиран сонгогдсон бөгөөд түүний улс төрийн гол өрсөлдөгч америк гаралтай улс төрч Винстон Табман ялагдлаа хүлээж хүндэт зочдын суудалд уригдсан байна. Винстон Табманыг дэмжигчид Эллен Жонсон-Сирлийфийн ялалтыг хүлээн зөвшөөрөхгүй дахин эмх замбараагүй байдал, нийгмийн хуваагдал үүсэх вий гэж Либерчүүд санаа зовж байсан юм.

Харамсалтай нь Винстон Табман улс орныхоо эв нэгдэл, улс төрийн тогтвортой байдлыг бодож Эллен Жонсон-Сирлийфийг хүлээн зөвшөөрснийхөө шанд өөрийн толгойлдог байсан “Ардчилсан Өөрчлөлтийн Конгресс нам”-аасаа хөөгдсөн юм. Энэ нь эмэгтэй улс төрч хүйсийнхээ хувьд хэрхэн ялгаварлан гадуурхагдаж байгааг хамгийн тод жишээ юм.

Австралийн Ерөнхий сайд Жулиа Гиллард 48 насандаа Австралийн анхны эмэгтэй Ерөнхий сайд болов. Харин “Би эцэг эхчүүдэд, охиддоо тэдний нүд рүү нь харж байгаад тийм ээ, эмэгтэй хүн хийж чадна гэж хэлж байхыг хүсч байна” хэмээн Дилма Русеф Бразилийн сонгуульд ялалт байгуулсныхаа дараа хэлсэн байдаг юм. Дэлхийн дөрөв дэх том ардчилсан улсад ялалт байгуулсан Русеф Өмнөд Америкийн орнуудын анхны эмэгтэй Ерөнхийлөгч билээ. Түүний амжилт дэлхийн хаана ч гарч ирэх эмэгтэй удирдагчдын ялалт болсон.

Германы Канцеллор Ангела Меркель бол дэлхийн хамгийн нөлөө бүхий удирдагчдын нэг. Тэрбээр улс төр рүү орохоосоо өмнө Баруун Германд физикээр докторын зэрэг хамгаалсан байна. Хоёр Герман нэгдсэний дараа 1990 оны 12 дугаар сард Бундестагт суудал эзэлсэн юм. Канцеллор Хелмут Коль түүнийг жилийн дараа л Кабинетын сайдаар томилжээ. 2010 онд “TIME” сэтгүүлд өгсөн ярилцлагадаа “Намайг өөрийгөө хэзээ ч доогуур үнэлж байгаагүй гэж та хэлж болно. Нэр төрд дуртай байхад муу зүйл огт байхгүй” хэмээсэн байдаг. Энэ мэтчилэн тухайн улс орон бүрийн өндөр албан тушаалд анх хүрч чадсан эмэгтэйчүүд бүгд хүйсийн ялгаварлан гадуурхах үзэлд тодорхой хэмжээгээр өртөж байсан байдаг.

Аргентины Ерөнхийлөгч Кристина Фернандез де Кирчнер 2007 оны 11 дүгээр сард Ерөнхийлөгчөөр сонгогдсон Фернандез өөрийгөө мэддэг эмэгтэй гэдгээ нотолсон. Улс төрийн өрсөлдөгч намын зарим элитүүд түүнийг үл тоомсорлодгийг харгалзахгүйгээр тэрбээр улсынхаа хөдөө аж ахуйн хамгийн том хуйвалдаан, сонгуулийн хууль бус сурталчилгаанаас үүдэн АНУ -тай зөрчилдсөн зөрчилдөөн, Аргентины Төв банкны захирагчийг ажлаас нь огцруулсан эдийн засгийн цуврал хэрүүл шуугиан гэх мэтээс эсэн мэнд гарч чадсан. Түүний гайхалтай төрх, чадварлаг илтгэх урлаг зэрэг нь өмнөх тэргүүн хатагтай Эва Перонтэй жишихэд хүргэдэг юм.

Пакистан улсын ерөнхий сайд асан Беназир Бухато 1988 оны 12 дугаар сарын 1-нээс Пакистаны ерөнхий сайдаар ажиллах болжээ. Лалын шашинтай орнуудаас хамгийн анх эмэгтэй ерөнхий сайдтай /Пакистаны түүхэнд хамгийн залуу/ болсон орон Пакистан байлаа. Гэвч түүний улс төрийн амьдрал дардан байгаагүй бөгөөд улс орны шашин шүтлэг болоод уламжлалт соёлоос шалтгаалан түүний баримталж байсан хөгжлийн бодлого, өөрчлөлт шинэчлэлт нь түүнд маш аюултай эрсдлийг авчирч байсан юм. Тодруулбал, Беназир Бхутто хоёр дахь удаагаа ерөнхий сайд болоод улс орондоо зоримог шинэчлэл хийсэн ч 1996 оны сүүлээр Беназир Бхуттогийн засгийн газар огцорчээ. Энэ үед Аль Кайда алан хядах байгууллагын толгойлогч Усама Бен Ладен Беназир Бхуттогийн толгойг авч ирсэн хүнд 10 сая америк доллар амлаж байлаа.

1996 онд Беназир Бхутто дэлхийн нөлөө бүхий улс төрчийн тоонд оржээ. Оксфордын их сургуулийн хүндэт доктор цол хүртэж, Геннесийн номонд нэр нь бичигдсэн байна. Беназир Бхутто хоёр дахь удаагаа ерөнхий сайдаар ажиллахдаа амжилтанд хүрсэн ч 1998 оны эхээр түүний ээж, нөхөр нь авилагийн хэргээр шүүхэд дуудагдан нөхөр нь 54 жилийн ял сонсож, Беназир Бхутто гурван хүүхдийн хамт Арабын Нэгдсэн Эмират, дараа нь Их Британи руу цагаачилсан байна. Нөхөр нь шоронгоос суллагдаад эхнэр хүүхдүүдийнхээ араас очиж, Беназир Бхуттогийн гэр бүлийнхэн 2007 оны 10 сарын 18-нд Пакистанд эргэн иржээ.

Хэрвээ Пакистанд ардчилсан сонгууль явуулах юм бол Беназир Бхуттогийн талынхан

ялалт байгуулах магадлалтай байв. Иймээс 2001 онд Пакистаны ерөнхийлөгч Первез нэг хүн хоёроос дээш удаа ерөнхий сайдаар томилогдож болохгүй гэж хуулийн заалт оруулжээ. 2008 оны 12 сарын 27-нд Беназир Бхутто Равалпинди хотод цуглаанд оролцож байхдаа алан хядах ажиллагааны золиос болж амь насаа алдсан юм.

- Хөрөнгө санхүүгийн хүндрэл

Судалгаанд хамрагдсан 18 улс төрч эмэгтэйчүүдийн түүхээс харахад ихэнх хэсэг нь буюу 11 эмэгтэй дундаж орлого бүхий энгийн ажилчны гэр бүлээс гаралтай байна. Тухайлбал, ХБНГУ-ын канцлер Ангела Меркелийн ээж Хатагтай Казнер багшийн мэргэжилтэй бөгөөд нөхөр нь шашны байгууллагад ажилладаг дундаж гэр бүлээс гаралтай ажээ. Мөн Украины ерөнхий сайд асан Юлия Тимошенко багадаа эцгийн хайрыг амсаагүй бөгөөд Юлияг ээж нь ганцаараа өсгөсөн хэмээн түүний намтарт бичигдэн үлдсэн байдаг. Түүнчлэн эх нь түүнийг тэжээхийн тулд хэд хэдэн ажил зэрэг хийдэг байсан ч амьдралаа арай ядан залгуулж байжээ. Тимошенко тэр үеийг дурсах дургүй бөгөөд нэг удаа ярилцлага өгөхдөө л “Би ядуу айлд төрсөн. Маш ядуу гэж хэлэх нь зөв юм байна. Цагтаа би сайн эзэгтэй байсан. Ингэхээс өөр арга байгаагүй. Байнга л юм оёж, нөхөж, нэхдэг байсан” гэж ярьсан байдаг.

Гэвч тэрээр ерөнхийлөгч асан Л.Кучмагийн хүргэн Виктор Пинчукийн дэмжлэгтэйгээр газрын тосны салбарт ажиллах болсон байна. Днепрепетровск хязгаарыг нефтийн бүтээгдэхүүнээр хангадаг байсан “Украинский бензин” корпорацийн ерөнхий захирлаар томилогдсоноор танилынхаа хүрээг улам өргөжүүлж удалгүй үйлдвэрлэл санхүүгийн “ЕЭС Украина” корпорацийн тэргүүнээр томилогджээ. Мөнгө улс төр хоёр үргэлж холбоотой байдаг болохоор улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг корпорацийг тэргүүлж байхдаа парламентын сонгуульд нэр дэвшиж, ялалт байгуулсан юм.

Литвийн ерөнхийлөгч Грайбоскайте худалдааны төлөөлөгч болон цахилгаанчны гэр бүлээс гаралтай бөгөөд тэрээр эдийн засгийн сэдвээр доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалж байх үедээ үйлдвэрт цагаар ажиллаж байсан түүхтэй юм.

Финлянд Улсын ерөнхийлөгч Хельсинкийн ажилчин гэр бүлд өссөн Таря Халонен үйлдвэрчний эвлэл болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласнаар улс төрийн амжилттай, өндөр карьерт хүрч чадсан талаар түүний намтарч бичсэн байдаг.

АНУ -ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон 2008 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихдээ гэр бүлийн санхүүгийн тухай 2000 оноос хойш тэд 100 сая долларыг ерөнхийлөгчийн сонгуульд бэлтгэж цуглуулсан ба үүний ихэнх нь Ерөнхийлөгч асан Клинтонь ном бичсэн, илтгэл тавьсан, бусад идэвхитэй үйл ажиллагааны хүрээнд босгож чадсан гэж мэдээлсэн байдаг.

2. Өндөр албан тушаалд сонгогдон хийсэн өөрчлөлтүүд, ололт амжилт болон улс төрийн зоримог алхамууд

Эмэгтэй улс төрчид өндөр албан тушаалд хүрснээр улс төрийн бодлогын хувьд зөвхөн нийгмийн салбарт бус эдийн засаг болон батлан хамгаалах, гадаад харилцааны салбарт эрс шийдэмгий алхамууд хийсэн түүхэн өөрчлөлтүүдийг хүн төрөлхтөн мэднэ. Тухайлбал:

- АНУ-ын төрийн нарийн бичиг хатагтай Мадлен Олбрайт Сенатын эрхэм гишүүн Эдмундын хууль зүйн асуудал эрхэлсэн туслахаар 1976-1978 онд ажиллаж, АНУ-ын Ерөнхийлөгч асан Жимми Картерын үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн болсон түүхтэй. Тэрбээр Ерөнхийлөгч асан Билл Клинтонь зөвлөхөөр 1992 онд ажиллаж, хойтон жил нь НҮБ-д АНУ-ыг төлөөлөх болсон юм.

- Тухайн үед “Дэлхийн Засгийн газар”-ыг тэргүүлж байсан Бутрос Гали ч түүний чадварыг үнэлж, чухал албаа хариуцуулж байлаа. Ирак улс Хатагтай Мадленд улстөрчийн хувьд зоримог шийдвэр гаргах цаг ирсэн юм. АНУ Иракийн эсрэг цэргийн ажиллагаа явуулах эсэхэд түүний үг чухал байлаа. Тэрбээр энэ тухай утгал бодсоны эцэст “Тийм” хэмээн толгой дохисон юм.
- Түүний шийдвэр ёсоор болж, цэргийн ажиллагааны үр дүнд Саддам Хуссейны дэглэмийг түлхэн унагасан ч Мадленыг дэлхий нийт улстөрч биш, бүсгүй хүнийх нь хувьд шүүмжлэлийн бай болгосон удаатай. CBS телевизийн “60 хором” нэвтрүүлгийн хөтлөгч Лесли Шталь 1996 онд түүнээс ингэж асууж л дээ. “Иракийн дайны үеэр хагас сая хүүхэд амь үрэгдсэн гэж бид сонссон. Хатагтай, энэ юу болж байна вэ. Хирошимад атомын бөмбөг хаяхад амиа алдсан хүүхдүүдийн тооноос хавьгүй их биш үү. Та ийм зүйл болохыг мэдэж байсан биз дээ” гэж. Харин Мадлен “Тийм ээ, энэ тухай олонтаа бодсон. Миний хувьд, маш хүнд сонголт байсан нь үнэн. Бид тийм л үнэ цэнээр Саддамын дэглэмийг түлхэн унагасан юм шүү дээ” хэмээн хариулжээ.

Гэхдээ дарангуйлагч Саддам Хуссейн мятаршгүй Мадленыг хүндэлдэг байсан. Тагнуулч В.Путин ч түүний өмнө мэхийн ёсолдог. Америкчуудад үнэн голоосоо дургүй Ким Чен Ир Мадленыг 2000 онд Хойд Солонгост айлчлахад амтат дарсаар дайлж байсан удаатай. М.Каддафи, Б.Нетаньяху, Хосни Мубарак арьс өнгө, үзэл бодол өөр ч дэлхийн лидерүүд Мадленыг “Хатагтай Төрийн нарийн бичгийн дарга” хэмээн хүндэлдэг билээ.

- АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон хувьд 2000 оны 11 сарын 7-нд болсон хууль тогтоох байгууллагын сонгуульд Хиллари Клинтон өрсөлдөж ялалт байгуулжээ. АНУ-ын тэргүүн хатагтай байсан эмэгтэйчүүдээс хууль тогтоох байгууллагад ялалт байгуулсан хүн огт байгаагүй юм. 2006 оны 11 сарын 7-нд Хиллари Клинтон сенатын танхимд дахин улиран сонгогджээ.
- 2008 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэг намаас нэр дэвшигч хоёрын рейтинг тун ойролцоо явсан ч Хатагтай Хиллари Клинтон “бидний сонгогчдын байдал их давалгаалж байна, харин Барак Обамаг дэмжигчид хатуу тангараг бүхий сонгогчид байна иймд АН-ын ялалтыг баталгаажуулахын тулд “Бид зогсох хэрэгтэй” гэсэн шийдвэр гаргасан байна.
- Хамгийн сүүлд 2008 оны 6 сарын 3-ны өдөр болсон АН-ын дээд чуулган дээр Хиллари “Барак Обама бид 2-ын хоорондын тулаан үүгээр дуусгавар боллоо. Одоо бидний хийж чадах зүйл бол Барак Обамаг дэмжих үлдлээ” гэж албан ёсоор мэдэгджээ. Гэхдээ тэдний санал тун ойрхон байсныг АН –ны гишүүд бүгд мэддэг ба манайхаар өөрийнх нь төлөө баттай санал өгөхөө амласан төлөөлөгчдийн тоогоороо Хиллари 1640, Обама 1763 байсан юм.
- Тэрбээр Клинтон эрүүл мэндийг хамгаалах төлөвлөгөөг сенатаар батлуулахад хамгийн гол үүрэг гүйцэтгэж, Гэр бүлийн аюулгүй байдлын тухай хууль, Зар сурталчилгааны бие даасан байдлыг хангах тухай хууль, Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын тухай хууль зэргийг батлуулахад гол үүрэг гүйцэтгэсэн ба Сенатын гишүүний 8 жилийн хугацаанд төсөв, цэрэг арми, байгаль хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн байнгын хороо, насжилтийн тусгай хороо, Батлан хамгаалах ба Европтой хамтрах хорооны зэрэг 5 байнгын хороонд ажилласан байна.
- 2001 оны 9 сарын 11 аймшигт халдлагын дараа Хиллари Нью Йорк мужийн аюулгүй байдлыг хангах төсөл өргөн барьсан ба ахмад сенатч Charles Schumerийн

хамт Дэлхийн Худалдааны төвийг дахин сэргээн босгох санд 21 тэрбум долларын хөрөнгө босгож оруулсан байдаг. Сенатын гишүүний хувь хатагтай Клинтон Афганистанд явуулсан АНУ-ын цэргийн бодлогыг хүчтэй дэмжиж, Иракт явуулсан Бушийн дайны бодлогын төлөө сенатад санал Афган, Ирак зэрэг орнуудад өөрийн биеэр очиж байсан.

ХБНГУ-ын канцлер Ангела Меркелийн хувьд тэрээр 1990 оноос Ардын төлөөлөгчдийн сонгуулиар CDU -гийн албан ёсны төлөөлөгчөөр, мөн тэр жилдээ ХБНГУ-ын Бундестагт сонгогджээ. 1991 - 1994 онуудад Канцлер Хелмут Кёлын үед Меркел хүүхэд эмэгтэйчүүд болон байгаль хамгаалал цөмийн аюулгүй байдал хариуцсан шадар туслахаар ажиллажээ. Үүний хажуугаар намынхаа Мекленбург Форпоммерн дэх удирдах зөвлөлийн үүрэгт ажлыг давхар гүйцэтгэж байлаа. 1998 онд хатагтай Меркел CDU-гийн ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдож түүний улс төрийн карьер нь эргэлт буцалтгүй өсөх замдаа орсныг батлан харуулсан байна.

2000 онд намынхаа дарга болж, 2002 онд канцлерийн сонгуульд нэлээд шуугиан тарьж өрсөлдөөд ялагдах хүлээжээ. Гэвч 2005 оны сонгуульд дахин нэр дэвшиж өрсөлдсөнөөр Германы түүхэнд анхны эмэгтэй Канцлераар сонгогдсон байна. Меркелийн өмнө Европын холбооны өрийн асуудлыг тогтворжуулах мөн Евро бүсийн эв нэгдлийг хамгаалах үүрэг тулаад байна. Тэрээр Францын ерөнхийлөгч Саркозийн хамт Евро бүсийн улс төр, эдийн засгийн илүү нягтралыг уриалж байна.

Канцлерин Меркел ажилгүйдлыг бууруулах, эдийн засгийн хямралаас сэргийлэн банкны ажилтнуудан бонуст тавих хяналтын бодлого нь тун амжилттай байгаа юм. Ялангуяа хямралд томоохон худалдааны болон хүнд үйлдвэрийн салбарууд эрсдэлтэй, ажилчдынхаа тоог хязгаарлах болсон ч Меркелийн засгийн газар энэ асуудлыг гэрээт болон богино хугацааны ажлын байраар нөхөх бодлого хэрэгжүүлснээр олон нийтэд сайшаагдсан. Мөн байгаль орчны салбарт ихээхэн хөрөнгө оруулснаар байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үүнийг дагаад ажлын байрыг нэмэгдүүлжээ.

Боловсролын салбар, тэр дундаа байгалийн шинжлэх ухааныг түлхүү хөгжүүлэх нь байгалийн баялаг багатай Герман улсын хувьд ирээдүйн хөгжил дэвшилд хүрэх хамгийн зөв зам гэж Меркел үздэг байна.

Энэтхэг улсын Ерөнхий сайд асан Индра Ганди 1966-1977 онд Засгийн газрыг тэргүүлж байгаад 1980 онд дахин Ерөнхий сайдаар томилогдсон юм. Харамсалтай нь, 1984 онд бие хамгаалагчдаа буудуулан хорвоогийн мөнх бусыг үзүүлжээ. Индра Гандийг амь үрэгдсэний дараа түүний хүү Раджив Ганди ерөнхий сайд болж, 1989 он хүртэл таван жил Засгийн газрыг тэргүүлжээ.

Юлия Тимошенко Украин улсын Ерөнхий сайдаар хоёр удаа ажиллаж, дөрвөн удаа Ардын депутатаар сонгогдсон нэртэй улстөрч. Дэлхий дахинаа нэр хүндтэй “Форбс” сэтгүүлээс 2005 онд шалгаруулсан дэлхийн хамгийн нэр нөлөө бүхий эмэгтэйчүүдийн гуравдугаарт бичигдэж байлаа. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж, одоогийн Ерөнхийлөгч В.Януковичид гуравхан хувийн цөөн саналаар ялагдсан, “хийн гүнж”, “төмөр хатагтай”, “славян хатагтай”, “гээгтэй хатан”, “Украины улс төр дэх цор ганц эрэгтэй” гэх мэтээр нэрлэгдэж байв.

2009 онд Литва улс эдийн засгийн хямралд орох үед Грайбоскайте Ерөнхийлөгчийн компани ахлаараа хамгийн доод орлоготой иргэд болон бараг 16%-д хүрээд байсан ажилгүйдэлд анхаарлаа хандуулсан байна. Бие дааж нэр дэвшсэн тэрбээр Литва Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн түүхэн дэх хамгийн их санал авсан ялалт буюу 68 хувийн саналаар тус улсын Ерөнхийлөгч болжээ.

Финлянд Улсын Ерөнхийлөгч Таря Халонен 2000 оноос Ерөнхийлөгчийн албанд зүтгэж тэрбээр улс орныхоо цэргийн тэргүүн командлагчийн үүргийг гуйвшгүйгээр хамгаалж байгаа бөгөөд НАТО-д элсэх Финляндын гишүүнчлэлийг эсэргүүцдэг.

Коста Рикагийн Ерөнхийлөгч Лаура Чинчилла 2010 оны хоёрдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар Чинчилла 47 хувийн саналаар ялалт байгуулсан. Тус орны гэмт хэргийн гаралт өсч байгаа санаа зовоосон асуудлыг зохицуулахад түүний өмнө нь хашиж байсан Батлан хамгаалах болон Хууль зүйн сайдаар ажиллаж байсан туршлага нь их хэрэг болдог байна. Уламжлалт үзлийг баримтлагч тэрээр ижил хүйстэнтэйгээ гэрлэх, үр хөндүүлэлт, жирэмслэлтээс хамгаалах эмийг хуульчлах зэрэгт эсрэг байр суурьтай байдаг. Өмнөх удирдагчдынхаа про-бизнесийн бодлого буюу олон улсын хөрөнгө оруулалт болон чөлөөт худалдааг өртгөтгөх бодлого баримталж байна.

Исландын Ерөнхий сайд Жоханна Сигурдартоттир 2008 оны аравдугаар сард Исландын эдийн засаг сүйрсний дараа Сигурдартоттир дургүйцэл бухимдлын дундуур өндөрлөгт хүрэх замаа зассан. Өмнө нь нислэгийн багийн бүрэлдэхүүнд байсан тэрээр 1978 оноос хойш парламентад 8 дахь удаагаа дараалан сонгогдож улс орныхоо хамгийн урт хугацаанд зүтгэсэн парламентын гишүүн болоод алдартай улс төрчдийн нэг болсон. Нэмж хэлэхэд 67 настай, Исландын анхны эмэгтэй Ерөнхий сайд Сигурдартоттир хамгийн эхний ижил хүйстэн төрийн тэргүүн гэдгээ зарласан. 2010 оны зургаадугаар сард Исланд улс ижил хүйстний гэрлэлтийг хуульчлахад тэрээр урт хугацааны хамтрагчтайгаа гэр бүл болжээ.

Эллен Жонсон-Сирлийф Либерт олон жил үргэлжилсэн иргэний дайныг бүрэн эцэс болгож, 9 жил тогтоод байгаа энх тайвныг бэхжүүлж, ардчиллыг сэргээнэ гэж мэдэгдсэн байна. Нобелийн Энх тайвны шагналт хатагтай Либерийн ардчилалыг бэхжүүлж, ард иргэдэд итгэл найдварыг эргэн төрүүлж, гадны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар залуучуудыг ажлын байраар хангах, ялангуяа иргэний дайны үед хүүхэд-цэрэг байсан залуучуудын боловсрол, эрүүл мэнд, ажил олоход нь анхаарч ажиллахаа амласан байна. Эллен Жонсон-Сирлийфийн хувьд 14 жил үргэлжилсэн иргэний дайны ул мөрийг бүрэн арилгаж, ардчиллыг бэхжүүлэх хүнд сорилттой тулгараад байгаа юм. Иргэний дайны үед 250 мянган хүн амь үрэгдэж, эдийн засаг нь үндсэндээ авах юмгүй болтлоо сүйрсэн юм.

Анх удаагаа Бразилийг эмэгтэй хүн тэргүүлж байна. Жилийн дотор түүний чансаа 95 дугаар байрнаас 3-т орж иржээ. Шинэчлэгч ерөнхийлөгч Лула де Сильва 2005 онд энэ эмэгтэйг өөрийн аппаратын тэргүүнээр тавьсан юм. Ийм тушаалд өмнө нь эмэгтэй хүн байсангүй учраас Дилма ерөнхийлөгчийн залгамжлагч болно гэж бүгд л хүлээж байсан билээ. Тэрээр ажилчны хэт радикал хөдөлгөөний гишүүн тэрээр хоёр жил шоронд суужээ. Эрчим хүчний сайдаар 2001 онд томилогдсоноос хойш Русеф илүү прагматик “капиталист” тал руу хувирч эхэлжээ.

Аргентин улсын Ерөнхийлөгч Кристина Фернандез де Кирчнер инфляц, ангийн хямрал, төрийн эргэлт гээд Аргентины 1970-1980-аад оны үеийн саад бэрхшээл эргээд ирэв. Хотын гудамж талбай, хурдны замууд эсэргүүцэл тэмцлийн талбар болно гэж Кристинаг тангараг өргөхөд хэн ч санаагүй. Түүнд төрийн тэргүүний суудлыг шилжүүлэн өгсөн өмнөх Ерөнхийлөгч Нестор Кирчнерийн засаглалын үеийн амар тайван байдал үргэлжилнэ гэдэгт ард нийт итгэлтэй байв. Н.Кирчнерийг Аргентины түүхэн дэх хамгийн сайн удирдагчдын нэг гэлцдэг. Тиймээс ч 2001 оны санхүүгийн хямралын дараахан улс орноо амар жимир болгосон Ерөнхийлөгчийг тэргүүн хатагтайдаа суудлаа шилжүүлэхэд гайхах хүн байсангүй.

3. Өндөр албан тушаалтай эмэгтэйчүүд авилгалд буруутгагдаж байсан эсэх, учир шалтгаан

Судалгаанд хамрагдсан 18 улс төрч эмэгтэйчүүдээс авилгын хэрэгт холбогдсон болон

холбогдуулан шалгагдаж байсан 5 эмэгтэй байна. Үүнд:

- Юлия Тимошенко /Украин улсын ерөнхий сайд асан/
- Шейк Хасина Важед /Бангладеш Улсын Ерөнхий сайд/
- Кристина Фернандез де Кирчнер /Аргентин улсын Ерөнхийлөгч/
- Беназир Бхуттогийн гэр бүл /Пакистаны ерөнхий сайд асан/
- Глория Макапагал Аройо /Филлиппин улсын ерөнхийлөгч асан/ нар юм.

Эдний дундаас шүүхээс гэм буруутай хэмээн нотлогдож хорих ялаар шийтгүүлсэн нь Юлия Тимошенко юм. Түүнийг 2001 оны нэгдүгээр сарын 5-ны өдөр Украины Ерөнхий прокурорын газраас Ю.Тимошенкогийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн. Түүнд Оросын хийг идэж завшсан, татвар төлөхөөс зайлсхийсэн хэрэгт буруутгаж Ерөнхий сайдын орлогчоос чөлөөлж, баривчилсан. Гэвч дараа нь Украины Дээд шүүхээс үүнийг хууль бус үйлдэл гэсэн дүгнэлт гаргасан байна. 2001 оны зун ОХУ-ын Ерөнхий прокурорын газраас ОХУ-ын БХЯ-ны хариуцлагатай албан тушаалтнуудад хахууль өгсөн хэргээр буруутгасан байна.

Шүүхээс түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэн 7 жилийн хорих ялаар шийтгэсэн ч тэрээр өөрийгөө энэ хэрэгт гэм буруугүй гэдгээ хэлж “Манайд шударга шүүх алга” хэмээн шүүхийн танхимаас мэдэгдэл хийсэн байдаг. Харин Бангладеш улсын ерөнхий сайд зүүний төвийг баримтлагч Авами Лигийн удирдагч Хасина мөн л авилгын хэрэгт буруутгагдаж байсан ба гэм буруутай нь шүүхээр нотлогдоогүй байна. 2001 онд “Transparency International” олон улсын байгууллагаас Бангладешыг дэлхийн хамгийн их авлигатай улсаар тодруулсны дараа Хасина албан тушаалаасаа буусан ч 2009 оны нэгдүгээр сард Авами Лиг дахин Ерөнхий сайд болжээ.

Мөн, Аргентины ерөнхийлөгчөөр сонгогдсон Фернандез өөрийгөө мэддэг эмэгтэй гэдгээ нотолсон. Улс төрийн өрсөлдөгч намын зарим элитүүд түүнийг үл тоомсорлодгийг харгалзахгүйгээр тэрбээр улсынхаа хөдөө аж ахуйн хамгийн том хуйвалдаан, сонгуулийн хууль бус сурталчилгаанаас үүдэн АНУ-тай зөрчилдсөн зөрчилдөөн, Аргентины Төв банкны захирагчийг ажлаас нь огцруулсан эдийн засгийн цуврал хэрүүл шуугиан гэх мэтээс эсэн мэнд гарч чадсан.

Пакистаны ерөнхий сайд асан Беназир Бухатто өөрөө авилгын хэрэгт буруутгагдаагүй ч түүний ээж болон нөхрийг нь авилгын хэргээр буруутган түүний нөхөрт 54 жилийн ял сонгосон 8 жил хоригдон суллагдсан байна. Харин Филлиппины ерөнхийлөгч асан Глория Макапагал Аройог тус улсын Хууль зүйн яамнаас “2007 оны сенатын сонгуулийн үр дүнг луйвардсан гэж албан ёсоор буруутган баривчлах ял хүлээлгээд байгаа юм. Энэ нь “4 жилийн өмнө болсон сонгуулийн үеэр санал хураалтын явцад нөлөөлсөн гэх олон баримт байгаа” хэмээн тус улсын Сонгуулийн хорооноос мэдэгдсэнтэй холбоотой ажээ. Хэрвээ үнэн гэдэг нь нотлогдвол тус улсын хуулиар барьцаа мөнгө төлөн чөлөөлөгдөх боломжгүй бөгөөд бүх насаар нь хорих ял тулгаж магадгүй юм байна.

Эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших хувь эрчүүдийнхээс давуу байгаа ч албан тушаал ахих, нийгэмд дуу хоолойгоо хүргэх нь учир дутагдалтай байсаар л байна. Тодруулбал, 2000 онд УИХ-ын гишүүдийн 11.8 хувь, Засгийн газрын гишүүдийн 4.5 хувь нь эмэгтэйчүүд байсан бол 2004 онд УИХ-ын гишүүдийн 6.5 хувь нь, 2008 онд 3.9 хувь нь эмэгтэйчүүд байсан тоон мэдээлэл байна. Энэ үзүүлэлтээс харахад сонгуулиас сонгуулийн явцад эмэгтэйчүүдийн төлөөлөл багассан байна.

Ашигласан материал:

- Парламент дахь эмэгтэйчүүд тоо ба агуулга Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон

улсын институтын гарын авлага

- Парламент ба эмэгтэйчүүд 2010 он
- www.lexadin.nl
- http://en.wikipedia.org/wiki/Election_lawv
- <http://www.law.cornell.edu/wex/elections>



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3

БҮЛЭГ

ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**
(ТУСГАЙ ЗАХИАЛГАТ СУДАЛГАА)

Захиалагч:

Улсын Их Хурлын Тамгын газар (Ерөнхий нарийн бичгийн даргын 251 дүгээр захирамж)

Гүйцэтгэсэн:

Судалгааны төвийн судлаачдын баг

“Дэлхийн зарим улсын парламентын ажлын албадын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа” судалгааны ажлыг гүйцэтгэсэн судлаачид:

Ц.Норовдондог	Судалгааны удирдагч, багийн ахлагч
Ц.Товуусүрэн	Багийн ахлах судлаач
Р.Хатанбаатар	Багийн ахлах судлаач
П.Амаржаргал	Багийн судлаач
Г.Билгээ	Багийн судлаач
Ц.Болормаа	Багийн судлаач
Б.Буяндэлгэр	Багийн судлаач
Г.Гэрэл	Багийн судлаач
Б.Дуламсүрэн	Багийн судлаач
Б.Мөнхцэцэг	Багийн судлаач
А.Пагма	Багийн судлаач
Б.Хатантуул	Багийн судлаач
Б.Цолмонбаяр	Багийн судлаач

Судалгааг нэгтгэн редакторласан судлаачид:

Ц.Товуусүрэн	Ахлах судлаач
Р.Хатанбаатар	Ахлах судлаач
К.Пүрэвсүрэн	Референт-судлаач

* * *

Гарчиг

Удиртгал

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Парламентын ажлын албаны тухай нийтлэг ойлголт
Судалгааны явцад анхаарал татсан зарим асуудал
Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Дэлхийн зарим улсын парламентын ажлын алба
Австрали, далайн улс орнууд

- Австрали

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Ази тивийн улс орнууд

- Турк
- Энэтхэг

Америк тивийн улс орнууд

- Америкийн Нэгдсэн Улс
- Канад

Африк тивийн улс орнууд

- Кабо-Верде

Европ тивийн улс орнууд

- Австри
- Норвеги
- Серби

* * *

Дэлхийн зарим улсын парламентын ажлын албадын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа (Товчлон авав.)

Удиртгал

Улсын Их Хурлын Тамгын газрын 2010 оны ажлын тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар хэлэлцэж, Тамгын газрын ажлын үр дүнг цаашид улам боловсронгуй болгох талаар гаргасан шийдвэрийн дагуу Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2011 оны 251 дугаар захирамжаар байгуулагдсан судлаачдын баг “Дэлхийн зарим улс орны парламентын ажлын албадын талаарх тусгай захиалгат судалгаа”-г гүйцэтгэв.

Судалгааны ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжийн дагуу хийж гүйцэтгэв. Судалгаанд дэлхийн бусад орнуудын парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, бүтцийн нэгжүүдийн чиг үүргийн талаар тив бүрээс сонгосон дэлхийн 50 орчим орныг сонгон авсан болно.

Судалгааны эхний хэсгийг ахлах судлаач Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, Б.Буяндэлгэр нар боловсруулсан бөгөөд энэ хэсэгт бусад орнуудын Парламентын Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн нийтлэг тогтолцоо, парламентын ажлын албыг байгуулах, чиг үүргийг нь тогтоох эрх зүйн актуудын онцлог, бусад орнуудын парламентын ажлын албаны ялгагдах хэлбэр, зарим орнуудын парламентын ажлын албаны бүтцийн онцлог зэргийг тусгасан болно. Түүнчлэн Монгол Улсын парламентын ажлын албаны үүсэл, хөгжил, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг судлаач Ц.Болормаа боловсруулан бэлтгэв.

Хоёрдугаар хэсэгт дэлхийн бусад орнуудын парламентын Тамгын газрын талаарх мэдээллийг оруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан орнуудын мэдээлэлд зарим нэг онцгой тохиолдлыг эс тооцвол улс бүрийн үндэсний парламентын онцлогт тохируулан манайд хэвшсэн хэллэг, нэр томъёог түлхүү хэрэглэв. Орнуудыг тив тус бүрээр нь, монгол цагаан толгойн үсгийн дарааллаар байршуулав.

Австрали, далайн зарим орнуудын Парламентын Ажлын албаны талаарх мэдээллийг ахлах судлаач Р.Хатанбаатар, Америк тивийн орнуудыг судлаач Б. Хатантуул, Б. Дуламсүрэн, Африк тивийн орнуудыг ахлах судлаач Ц.Товуусүрэн, Ази тивийн зарим орнуудыг судлаач А. Пагма, Б. Мөнхцэцэг, П. Амаржаргал, Европ тивийн орнуудыг ахлах судлаач Р. Хатанбаатар, Б. Буяндэлгэр, судлаач А. Пагма, Г. Билгээ, Ц.Болормаа, Г. Гэрэл нар боловсруулсан болно.

Дэлхийн бусад орнуудын парламентын ажлын албаны талаархи товч мэдээлэлд парламентын ажлын албаны чиг үүрэг, бүтцийн схем, газар хэлтэс, албадын чиг үүргийн талаар тусгахыг зорьсон болно. Мэдээллийг боловсруулахдаа энэ талаархи ном, товхимол, холбогдох улсуудын Үндсэн хууль, Олон улсын парламентын холбоо, олон улсын бусад байгууллага болон тухайн улсын парламентын болон хууль, эрх зүйн цахим хуудсуудыг ашигласан болно.

* * *

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Парламентын ажлын албаны тухай нийтлэг ойлголт

Парламентын Ажлын алба нь парламентад бүхэлд нь болон Парламентын танхимууд, Байнгын болон бусад хороод /комисс/, парламентын гишүүдэд хууль тогтоох болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх болон шинжлэх ухаан, техник-зохион байгуулалтын талаар туслах өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн албан хаагчдын байгууллага юм.

Парламентын ажлын алба нь хууль тогтоох (legislative) үйл ажиллагаанд туслах, захиргааны (Administrative) удирдлагаар дэмжих болон нарийн бичгийн дарга нарын газрын (Secretariat) үйлчилгээг дор дурдсан чиг үүргийн дагуу хэрэгжүүлнэ:

- Парламент, Парламентын танхимууд, Байнгын хороод, төслийн ажлын хэсгүүдэд төслийг хэлэлцүүлж, батлуулах, хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхлэх хүртэлх бүх үе шатанд мэргэжил, арга зүй, техник-зохион байгуулалт, судалгаа шинжилгээний болон архив, номын сангийн үйлчилгээ дэмжлэг үзүүлэх чиглэлээр:
 - Төслийг хэлэлцүүлж, батлуулах, хүчин төгөлдөр болж мөрдөгдөх хүртэлх бүх үе шатанд дэмжлэг үзүүлэх албад нь өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн бүрдлийг хянах, хэлэлцэх, хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэх, уялдуулах, хэлэлцүүлэгт бэлтгэх, парламентын үйл ажиллагааны албан ёсны тайлан гаргах, парламентын бүх үйл ажиллагааны бичлэгийг үйлдэх, хууль тогтоомжийг хэлэлцэхэд процедурын тусламж үзүүлэх, баталсан шийдвэрийн эцсийн найруулгыг бэлтгэж парламентад танилцуулах, ёсчлуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - Парламентын судалгаа шинжилгээний алба, номын сан, архив нь дэлхийн улс орнуудад парламентын маш чухал албанд тооцогдох бөгөөд парламент түүний хороод, гишүүдийг тэнцвэртэй, үнэн зөв мэдээлэл, лавлагаагаар хангах, тодорхой чиглэлээр шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаагаар хангах, парламентын үйл ажиллагааны баримт бичгийг зохих журмын дагуу архивлах, архивын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ажиллана.
- Парламентын боловсон хүчин, хүний нөөц, захиргаа, санхүү, төсөв зардал, материал техникийн хангамж, техникийн үйлчилгээ, харуул хамгаалалт зэрэг асуудлыг хариуцах парламентын ажлын албаны чиг үүргийг захиргаа санхүү, хүний нөөц, техник зохион байгуулалтын алба хэрэгжүүлнэ.
- Парламентын удирдлага, гишүүдийн ажлын алба /зөвлөх, туслах, нарийн бичгийн дарга;
 - Парламентын дарга, дэд дарга, гишүүдийн ажлын алба нь тэдгээрийг хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэх чиглэлээр судалгаа хийх, төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхэд туслах, тэдгээрийн хэлэх үгийн төслийг бэлтгэх болон гишүүд сонгогчид, ашиг сонирхлын бүлгүүдтэй харилцаа тогтоох, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоо тогтоох, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, олон

нийттэй харилцах асуудалд туслах чиг үүрэг бүхий нарийн бичгийн дарга нарын газар юм.

Парламентын ажлын алба бол түүний хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зарим тохиолдолд /ихэвчлэн 2 танхимтай бол/ төлөөллийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь чиглэгдсэн бүтэц, зохион байгуулалттай байдаг.

Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудад парламентын ажлын албаны бүтэц, албан хаагчдын тоо хангалттай байхыг эрхэмлэдэг байна. Тухайлбал, АНУ-д конгрессын 535 гишүүнд 20000 орчим албан хаагчдаас бүрдсэн ажлын алба үйлчилж байхад, пост коммунист орон болох Украинд 450 парламентын гишүүнд 10 гаруй Ерөнхий газар, 50 гаруй газар, хэлтэс, алба үйлчилж байна.

Гадаадын улс орнуудад парламентын ажлын албаны бүтэц, чиг үүргийг ихэвчлэн хууль тогтоомжийн актуудаар тогтоодог байна. Жишээ нь: АНУ-ын 1946 оны /1970 онд шинэчлэн найруулсан/ өөрчлөн байгуулалтын тухай хууль нь парламентын ажлын албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулж байгаа үндсэн хэм хэмжээний акт болдог. Шведэд 1974 оны Риксдаг/парламент/-ын тухай хуулиар, Их Британид 1978 оны Нийтийн танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын тухай хуулиар энэ асуудлыг зохицуулдаг байна. Зарим нэг улс оронд, тухайлбал, Австрийн холбооны 1920 оны Үндсэн хуулийн 30 дугаар зүйл, Грекийн 1975 оны Үндсэн хуулийн 65 дугаар зүйл, Испанийн Үндсэн хуулийн 72 дугаар зүйлээр парламентын ажлын албыг байгуулах асуудлыг зохицуулсан байна.

1. Парламентын Тамгын газруудын зохион байгуулалтын зарим өвөрмөц хэлбэрүүд:
 - Австралийн Сенат - Сенатын департамент ба Клеркийн газар, Парламентын үйлчилгээний Департаменттай.
 - Шведийн Риксдаг – Захиргааны департамент ба Нарийн бичгийн даргын газартай.
 - Шинэ Зеланд – Төлөөлөгчдийн танхимын Клеркийн газар, Парламентын үйлчилгээний алба, Парламентын зөвлөхүүдийн офистой байна.
2. Хоёр танхимтай парламенттай улсуудад ихэнх тохиолдолд танхим тус бүр нь бүрэн бие даасан Тамгын газартай байх боловч Их Британи зэрэг зарим улсад Танхим тус бүрийн департаментаас гадна хоёр танхимд хоёуланд нь үйлчилдэг дундын Департаментууд байдаг.

Австралийн парламентын хоёр танхимын Тамгын газрууд нь ажлын арга барилын хувьд ялгаатай онцлогтой байна. Тухайлбал, Сенатын Тамгын газар нь сонгодог хэлбэрээр зохион байгуулагдсан байдаг бол Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар нь үр дүнгийн бүлгүүдийн хэлбэрээр ажиллаж, гэрээний дагуу бүтээгдэхүүн нийлүүлдэг.

3. Парламентын Тамгын газрууд үйл ажиллагаагаа хариуцан тайлагнах хоёр хэлбэр ажиглагдаж байна: а) парламентын спикер Тамгын газраа шууд хариуцаж парламентын өмнө үүрэг хүлээнэ, б) парламентын удирдлагын зөвлөл юмуу спикерийн зөвлөл гэх мэт хамтын удирдлагын байгууллагууд тамгын газраа ерөнхийд нь удирдаж, үйл ажиллагааг нь парламентын өмнө хариуцна.
4. Парламентын тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга буюу Клеркийг томилох дараах үндсэн 3 хэлбэр байна:
 - парламентаас шууд томилох
 - парламентын удирдлагын зөвлөлөөс томилох
 - спикер шууд томилох.

Мөн олон орны хувьд Ерөнхий нарийн бичгийн дарга буюу Клеркийг парламентын үндсэн, байнгын, хамгийн ахлах ажилтан гэж үзэж төрийн тэргүүн болох хаан эсхүл Генерал-губернатор томилдог. Тухайлбал, Их Британийн парламентын Нийтийн танхимын Клеркийг Хатан хаан, Шинэ Зеландын парламентын Төлөөлөгчдийн танхимын Клеркийг Генерал-губернатор тус тус томилдог.

5. Парламентын Тамгын газруудын нэг гол үүрэг нь парламентын бүх үйл ажиллагааны бичлэгийг үйлдэх, парламентын албан ёсны тайлан гаргах, парламентын баримт бичгийг хадгалах ажлыг зохион байгуулах явдал юм. Энэ үйлчилгээний нэг гол үр дүн нь Хансард буюу парламентын хэлэлцүүлгийн бичлэг юм. Жишээлбэл, Шинэ Зеландын парламентын Тамгын газрын хансардын ажилтнууд нь гишүүдийн хэлсэн үгийг бичиж авах, хэлэлцэж буй хуулийн төсөлд оруулах засварын тухай гишүүдийн саналын төслийг тараах, тэдгээрийг хэлэлцүүлгийн өдөр тутмын бичлэгт тусгах үүрэгтэй. Хуралдаан бүрийн аман асуулт, хариултын засварлаагүй стенограмм болон өдрийн бүх хэлэлцүүлгийн бичлэгийг парламентын веб сайтад тухай бүр байрлуулах ба дараа нь хэвлэн нийтлэх хувилбарыг бэлтгэнэ. Хансардыг долоо хоног, сараар хэвлэх ба долоо хоног, жил, парламентын чуулган бүрээр индексжүүлнэ.
6. Парламентын хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд төсвийн тухай хууль, төсвийн гүйцэтгэлийг батлах тухай хуулийг тусгай дэгийн дагуу баталдаг нь уг асуудалд улс орнуудын парламент тусгайлан ач холбогдол өгдгийн илрэл юм. Ийм ч учраас АНУ, БНСУ, Украин зэрэг зарим улс орнуудад ажлын албаны бүтцэд болон гадна талд нь төсвийн асуудал хариуцсан нэгж алба байгуулж, төсвийн хүрээний мэдэгдлээс эхлэн төсвийн хэлэлцүүлгийн бүх шатанд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй ажилладаг байна.

АНУ-ын Конгрессийн төсвийн газар (СВО) нь Конгрессийн төсөв ба зарцуулалтыг нарийвчлан, олон талаас нь судлан хянаж, холбооны төсөвтэй холбоотой бүх мэдээлэл, шинжилгээ, шийдвэрийг гаргах суурь мэдээллээр хангах үүрэгтэй. Төлөөлөгчдийн танхим болон Сенатын хорооны саналыг үндэслэн жил бүрийн эдийн засаг ба төсвийн тайлан мэдээг гаргадаг Конгрессийн төсвийн газар нь 8 хэлтэст хуваагддаг. 2010 оны байдлаар гэхэд холбооны зардал тооцох 650 удаагийн, хуулийн хэрэгжилтийн 475 үнэлгээ зэргийг хийж Конгресст танилцуулсан байна.

7. Парламентын боловсрол олгох тухай асуудал нь парламентын Тамгын газруудын чухал үүргийн нэг юм. Иймд олон орны парламентын Тамгын газар нь Парламентын боловсролын газартай байна. Энэ газрууд нь парламент, парламентат ёсны түүх болон Үндсэн хуулийн агуулгатай асуудлаар судалгаа хийж, парламентын тухай мэдээллийг ном, товхимол болон электрон хэлбэрээр гаргана.

АНУ-ын Конгрессийн сургалтын агентлаг нь бие даасан, улс төрийн хараат бус агентлаг бөгөөд Конгрессийн гишүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд ёс зүйн харилцаа, эрүүл мэнд, аюулгүй байдал, дипломат ёс гэх мэт улс төр, олон улсын түвшинд Конгрессийн гишүүдэд тавигдах шаардлагын талаар сургалтыг зохион байгуулдаг байна. Мөн Конгрессийн гишүүд, албан хаагчдад тэдгээрийн эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгөх сургалт явуулдаг. Дараах үндсэн гурван чиглэлээр боловсролын үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Дунд сургуулийн сурагчдад парламентын үүрэг, ролийг ойлгуулах сургалтуудыг зохион байгуулдаг. АНУ-ын конгрессын Пэйж хөтөлбөр нь дунд сургуулийн сурагчдад бүтэн жилийн хугацаанд эсхүл 1-2 улирлын туршид АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд туслах ажилтнаар ажиллах боломжийг олгодог. 180 жилийн түүхтэй уг хөтөлбөрт хамрагдахын тулд өндөр шалгуур хангасан байх

ба уг хөтөлбөрт хамрагдах хугацаанд нь Төлөөлөгчдийн танхимын гишүүн уг суралцагчийн бүх зардлыг хариуцна. Сенатад ажиллаж буй бүх “пэйж” сурагчдад зориулсан тусгайлсан хөтөлбөр бас байдаг.

- Парламентын гишүүдэд зориулан парламентын үйл ажиллагаанд оролцогчийнх нь үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг бэлтгэн, тэдэнд хүргүүлэх, танхимын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олж авахад туслах үйлчилгээ байна. Парламентын процессын асуудлаар парламентын гишүүд, тэдний туслахууд болон парламент, гүйцэтгэх засаглалын албан хаагчдад зориулсан семинар зохион байгуулна. Төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийнхэн зэрэг бүлгүүдэд зориулсан парламентын үйл ажиллагааны талаар ойлголт өгөх семинар зохион байгуулж, танилцуулга хийнэ.
- Мөн насанд хүрэгчдэд зориулсан парламентын боловсролын үйлчилгээ үзүүлж, парламентын үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулан дэмжүүлэх зорилгоор боловсролын байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулах ба лекц уншиж, үзэсгэлэн зохион байгуулна. Энэ үйл ажиллагааны үр дүнд олон нийт, нийгмийн бүлгүүд парламентын талаарх мэдлэгээ дээшлүүлж, Танхим, байнгын хороодын үйл ажиллагааг сонирхох, оролцох тэмүүлэлтэй болсон байх ёстой.

Сүүлийн жилүүдэд парламентын тамгын газруудын бүтцэд шинжлэх ухаан, технологийн бодлогын асуудлаар бие даасан, бусдаас хамааралгүй, хүртээмжтэй анализ хийх үүрэгтэй парламентын дотоод эх сурвалж болох байгууллагыг нилээд олон оронд бий болгож байна. Жишээлбэл, Их Британийн парламентын Лордуудын танхим болон Нийтийн танхимын дундын Парламентын шинжлэх ухаан, технологийн оффис ийм чиг үүрэгтэй ажилладаг байна.

Парламентын ажлын албадын зохион байгуулагдах хэлбэр

Судалгаанд хамрагдсан улс орнуудыг тоймлон үзвэл нэг танхим бүхий парламенттай 25 улсаас 23 нь нэгдмэл бүтэц бүхий ажлын албатай байхад, 2 улс нь Захиргааны болон Хууль тогтоох үйл ажиллагааны департаменттай байна. Харин хоёр танхим бүхий парламенттай 21 улсаас танхимууд нь тусдаа бие даасан ажлын албатай 10 улс, Танхимууд нь дундын болон тусдаа ажлын албатай 5 улс, нэгдсэн нэг ажлын албатай 5 улс байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Дэлхийн зарим улсын парламентын ажлын албадын бүтцийн ялгаа

Хоёр танхимтай парламент			Нэг танхимтай парламент		
Танхимууд тусдаа ажлын албатай	Танхимууд дундын болон тусдаа ажлын албатай	Танхимууд нэгдсэн нэг ажлын албатай	Нэгдмэл бүтэц бүхий ажлын албатай	Захиргааны болон хууль тогтоох үйл ажиллагааны ажлын алба нь тусдаа	Ажлын албаны зэрэгцээ Хуулийн бодлого, төсвийн шинжилгээний хүрээлэн, Зөвлөхийн товчоотой
Шинэ Зеланд Узбекстан Энэтхэг Япон Аргентин Мексик Герман Нидерланд ОХУ Румын	Австрали АНУ Канад Тринадад-Тобаго Египет	Чили Австри Босни-Герцеговин ИБУИНВУ Швейцари	Самао Вьетнам Киргиз Саудын Араб Сингапур БНСУ Турк БНХАУ Ботсван Габон Жибути Кабо-Верде Марокко Намиби Армян Гүрж Молдов Монтенегро Норвеги Серби Украин Финланд Эстони Монгол	Словени Швед	Вьетнам Шинэ Зеланд БНСУ АНУ (2 танхимтай)

* * *

Судалгааны явцад анхаарал татсан зарим асуудал

Монгол Улсын анхны байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурлын Нарийн бичгийн даргын 1990 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот захирамжаар УБХ-ын Тамгын газрыг Зохион байгуулалтын хэлтэс, Зөвлөгчийн товчоо, Орон нутгийн ажлын хэсэг гэсэн 3 хэлтэс, 22 ажилтантайгаар анх байгуулснаар шинэ үеийн парламентын ажлын албаны үндэс суурь тавигдсан билээ.

1992 онд Улсын Их Хурлын Тамгын газрыг эмхлэн байгуулснаас хойш Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтад 6 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд УИХ-ын 2002 оны 22 дугаар тогтоолоор баталсан Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын дагуу 2008 онд УИХ-ын даргын захирамжаар Тамгын газрын одоогийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоожээ.

УИХ-ын Тамгын газрын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудын парламентын ажлын албадынхтай ойролцоо түвшинд байна гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж үзэхэд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чиг үүргийг тодруулах, бүтцэд зарим өөрчлөлт оруулах зэрэг шаардлага байна гэж үзэж байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хурлаас жил бүр батлах тухай заасан байдаг. Энэ асуудал нь дэлхийн улс орнуудын парламентын онцгой бүрэн эрхэд хамаарах

бөгөөд ихэнх улс орнуудад төсвийн хүрээний мэдэгдлээс эхлээд төсөв батлагдаж, мөрдөгдөх бүх үе шатанд дүн шинжилгээ хийх, хяналт тавих чиг үүрэг бүхий төсвийн шинжилгээний нэгжийг парламентын ажлын албаны бүтцэд болон ажлын албатай зэрэгцээ байгуулсан байна. Төсөв түүний гүйцэтгэлийг батлах асуудал нь жил бүр давтагддаг, жил жилийн онцлог бодлоготойгоор төлөвлөгдөж байх шаардлагатай учир одоогийн хэлбэрээр баталдаг байдлыг цаашид үргэлжлүүлэх нь УИХ-ын төсвийн талаарх бүрэн эрхийг улам бүдэгрүүлэх урсигтай юм.

Ийм учраас төсвийн бодлого, төсвийн төсөл, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, хяналт тавих, мөрдөн шалгахад оролцох, туслах чиг үүрэг бүхий нэгжийг Тамгын газрын бүтцэд бий болгож, эрх зүйн үндсийг нь хуулиар тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх асуудал хангалтгүй байгаа талаар иргэд, сонгогчид болон УИХ-ын гишүүдийн зүгээс ч байнга шүүмжлэл гарч байдаг. Дэлхийн улс орнуудын парламентууд хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шалгах болон мөрдөн шалгах гэсэн хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгжийг Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд байгуулж, УИХ-ын дэгийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулан, энэхүү нэгжийн чиг үүргийг тодорхойлох нь зүйтэй.

3. Дэлхийн улс орнуудад парламентын ажлын албаны хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах талаар парламентын үйл ажиллагааг сонгогч олон нийтэд нээлттэй, шуурхай, үнэн зөв, хүргэх нийтлэг чиг үүрэгтэй байна. Улс орнуудын, түүний дотор Монгол Улсын Үндсэн хуулиар хууль тогтоох бүрэн эрхийг парламент, хууль хэрэгжүүлэх, сурталчлах бүрэн эрхийг Засгийн газар хэрэгжүүлэхээр тогтоосон байдаг. Иймд манай Тамгын газарт байгуулсан Хууль сурталчлах алба нь гүйцэтгэж байгаа үүргийнхээ хувьд парламентын үйл ажиллагааг сурталчилж байгаа боловч нэрийн хувьд “Хууль сурталчлах алба” бус “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах алба” гэх нь Монгол Улсын Үндсэн хууль (Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-ын 4 дэх заалт)-д нийцнэ.

Парламентын байнгын хороо, комисс, намын бүлэг, депутатуудын бүлгийн хуралдааны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нээлттэй эсвэл хаалттай байх талаар Судалгааны төвөөс гаргасан “Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай холбоотой гадаад орнуудын харьцуулсан судалгаа”-наас үзвэл ХБНГУ-ын Бундестаг, Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхим, Турк Улсын Үндэсний Их Хурлын байнгын хороо хаалттай хуралддаг, Австралид хаалттай хуралдах тохиолдлыг заасан байдаг бол ОХУ, АНУ-д хорооны хуралдааныг нээлттэй байхаар заасан байдаг ч хэлэлцэх асуудлаас хамааран хаалттай хуралдах шийдвэрийг тухайн үед нь гаргадаг байна.

Конгресс дэргэдээ нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг бүхэлд нь бичлэг хийх телестуди ажиллуулж, тусгай кабелийн телевизээр 24 цагийн турш ямар нэг засваргүйгээр нэвтрүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн Конгрессын телестудийн бичлэгийг авч нэвтрүүлэгтээ ашиглахыг зөвшөөрдөг байна.

Банк, санхүү, төрийн мөнгөний бодлого, даатгал, татвар, гааль, нийгмийн халамжийн болон төсвийн төслийн талаар хэлэлцэгдэж буй хууль тогтоомжийн төслийн зарим зүйл, заалт, тоо баримтыг олон нийтэд хэвлэл мэдээллээр дамжуулан хүргэх нь нийгэмд

хүлээлт үүсгэх, бараа, үйлчилгээний үнэ хөөрөгдөх, банк санхүүгийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй тул эдгээр асуудлуудын эцсийн хэлэлцүүлгээс өмнөх шатны хэлэлцүүлгүүдийг хаалттай хуралдаанаар хийх нь зохимжтой.

4. Зарим улс орнуудын хувьд судалгааны захиалга хүлээн авах, судалгааны ажлыг хийж гүйцэтгэх журамтай байна. Эдгээр журамд дараах нийтлэг зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

а/ Судалгааны ажлыг парламентын гишүүд, парламентын Байнгын болон Дэд, Түр хороод, Тамгын газрын удирдлагын захиалгаар гүйцэтгэнэ.

б/ Цаг үеийн тулгамдсан асуудал, бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудлаар судлаач болон судалгааны төвийн санаачлагаар судалгааны ажлыг гүйцэтгэж болно.

в/ Судалгааны захиалгыг албан бичгээр авна. Лавлагаа, мэдээллийн шинжтэй болон хөдөө орон нутаг, гадаадад ажиллаж байгаа гишүүдийн захиалгыг утсаар буюу цахим шуудангаар авч болох бөгөөд Судалгааны төвийн бичиг хэрэг хариуцсан ажилтан захиалагчийн нэр, захиалга өгсөн утасны дугаар, цаг, огноо, цахим хаягийг бүртгэлд тэмдэглэнэ.

г/ "Нууц"-тай холбоотой захиалгыг энэ талаар гарсан хууль тогтоомж, холбогдох журам, зааврын дагуу шийдвэрлэнэ.

Түүнчлэн судлаачид гишүүдэд хувийн зөвлөгөө өгөх, сонгуулийн тойрогт нь ажиллах, хуулийн төсөл боловсруулах, боловсруулахад оролцох, улс төрийн үзэл бодлоо судалгааны бүтээлдээ илэрхийлэх, захиалагчын зөвшөөрөлгүйгээр судалгааны бүтээлийн талаар бусдад мэдээлэхийг хориглодог. Ажил үүрэгт нь хамааралгүй эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй болон хүний хувийн нууцад хамаарах захиалгыг гүйцэтгэхээс татгалзах эрхийг судлаачид эдэлдэг байна.

5. Зарим улс орнуудын парламентын ажлын албаны бүтцэд иргэд, сонгогчдод парламентын түүх, чиг үүрэг, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх, тэдний асуултад телефон утас, факс, цахим шуудан болон бусад хэлбэрээр хариулт өгөх үүрэг бүхий мэдээллийн төв ажилладаг байна. Мөн мэдээллийн төвийн байранд иргэд зочилж, парламент болон төрийн бусад байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авах, телевизийн дотоод сүлжээгээр парламентын хуралдааныг сонирхох, парламентаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хууль тогтоомжын төсөл зэрэгтэй танилцах, хуулбарлаж авах, парламентаас хэвлэн гаргасан тогтмол хэвлэл, ном товхимол бусад материалыг уншиж, хуулбарлан авч болдог. Мөн парламентын ордон, парламентын үйл ажиллагаатай танилцахыг хүссэн иргэн Мэдээллийн төвд ханддаг байна.

6. Судалгаанд хамрагдсан зарим улс орнуудын парламентын ажлын албатай зэрэгцэн хуулийн бодлогын судалгаа хийх, хуулийн төсөл бэлтгэх чиг үүрэг бүхий хуулийн хүрээлэн, Хуулийн зөвлөхүүдийн товчоо, офис ажилладаг байна.

7. Судалгаанд хамрагдсан ихэнх улс орнуудын парламентын ажлын албаны бүтцэд иргэдэд парламентын боловсрол олгох нэгж ажилладаг байна.

8. Шинэ Зеландын парламентын Тусгай хороод нь парламентын хууль тогтоох, санхүүгийн, хяналт шалгалтын болон мөрдөн шалгах үүрэгтэй холбоотой хамгийн шуурхай ажлыг гүйцэтгэдэг нь анхаарал татаж байна. Танхим дахь хэлэлцүүлэг зөвхөн парламентын гишүүдээр хязгаарлагддаг бол тусгай хороод өөрийн үйл ажиллагаандаа олон нийтийг татан оролцуулж болдог. Хууль тогтоох процесст

парламентын гишүүд ийнхүү олон нийттэй харилцан ажилладаг нь Шинэ Зеландын парламентын онцлог юм. Тусгай хороодод уг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах үүрэгтэй ажлын алба байна.

Даширамд дурдахад, Үндсэн хуулиар тодорхойлсон УИХ-ын онцгой бүрэн эрхэд хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийг хамааруулж, төлөөлөх бүрэн эрхийг хамааруулаагүй билээ. Гэтэл Улсын Их Хурал төлөөлөх бүрэн эрхтэй гэж зарим эрдэмтэн, судлаачид тодорхойлдог. Тухайлбал, Улсын Их Хурал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлсэн “Ардчилсан засаглалын парламентыг бэхжүүлэх” төслийн хүрээнд монголын парламентын үйл ажиллагаанд хийсэн судалгааны нэгдсэн тайлан, санал, зөвлөмжид “Монгол Улсын Их Хурал нь дэлхийн ардчилсан улс орнуудын парламентын жишгээр, өөрийн бүрэн эрхийн хүрээнд,

- хууль тогтоох;
- хянан шалгах;
- төлөөлөх;

гэсэн 3 үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна” гэж үзсэн нь тэмдэглэгджээ.

Дээр дурдсан судалгаанд төлөөлөх бүрэн эрхийг тайлбарлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн заалтуудыг иш үндэс болгосон байна. Эдгээр заалтууд УИХ-ын төлөөлөх бүрэн эрхийг илэрхийлэх шинжтэй байгаа боловч онцгой бүрэн эрхэд хамааруулах зохицуулалт биш юм. Бидний судалснаар ихэвчлэн хоёр танхим бүхий парламенттай орнуудын дээд танхим нь парламентын төлөөлөх бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа дүр зураг харагдаж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

Тамгын газар нь төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлаас хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь иж бүрэн зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх өндөр чадавхи бүхий бие даасан мэргэшсэн төрийн захиргааны байгууллага юм.

Монгол Улсын Парламентын мэргэшсэн албадын түүхэн товчоон

Монгол улс орчин үеийн хууль тогтоох, төрийн дээд эрх барих байнгын ажиллагаа бүхий парламенттай болсон нь 1990 оны Улсын Бага Хурлаас эхлэлтэй бөгөөд өнөөг хүртэл парламентад хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь иж бүрэн зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болох “Тамгын газар”-ыг үе үеийн парламент 7 удаа шинэчлэн зохион байгуулсан түүхтэй. Үүнд:

1) Монгол Улсын Бага Хурлын Тамгын газар. /1990-1992 он/

Улсын Бага Хурлын Тамгын газар нь байнгын ажиллагаатай парламентын анхны мэргэшсэн алба юм. Тус албаны эрх зүйн үндсийг хуулиар тогтоосон⁷ бөгөөд Улсын Бага Хурлын

⁷ Улсын Бага Хурлын тухай хууль, 27 дугаар зүйл.

даргын 1990 оны есдүгээр сарын 24-ний өдрийн 04 тоот захирамжаар “Тамгын газар” нэртэйгээр анх байгуулж байжээ. Ийнхүү байгуулахдаа Тамгын газрыг дараах бүтэцтэй байхаар зохион байгуулсан байна. Үүнд:

- Зохион байгуулалтын хэлтэс
- Зөвлөгчдийн товчоо
- Орон нутгийн Ардын хурлын ажлын хэсэг гэсэн үндсэн гурван нэгжтэй байсан байна.

Улсын Бага Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтад Улсын Бага Хурлын даргын захирамжаар 1991 оны гуравдугаар сард хоёр ч удаа өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр Зөвлөгчдийн товчоог татан буулгаж Төрийн байгуулалтын байнгын хороо байгуулсан бөгөөд Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга нь Улсын Бага Хурлын Тамгын газрын дарга байхаар баталсан байна.⁸

1992 оны хоёрдугаар сарын 3-ны өдөр Улсын Бага Хурал “Тамгын газар”-ыг аж ахуй, санхүү, боловсон хүчний асуудлаа бие даан шийдвэрлэх хуулийн этгээд болгох тухай тогтоол гаргажээ. Үүнээс хойш өнөөдрийг хүртэл Монгол Улсын Их Хурлын Тамгын газар нийт 6 удаа өөрчлөгдөн зохион байгуулагдаж байсныг дор товчхон танилцуулж байна.

2) Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. /1995-1996 он/

1992 оны сонгуулийн дараа УИХ-ын Тамгын газар үйл ажиллагаагаа Улсын Бага Хурлын Тамгын газрын бүтэц бүрэлдэхүүнээр хэрэгжүүлж байсан байна. Харин 1995 онд Тамгын газрыг дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй өөрчлөн байгуулсан байна. Үүнд:


- УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний орлогч-2
- Зохион байгуулалтын хэлтэс
- Санхүү үйлчилгээний хэлтэс
- Хууль тогтоомжийн шинжилгээ-лавламжийн хэлтэс
- Парламентын номын сан
- Байнгын хороодын зөвлөгчид
- Гадаад харилцааны хэлтэс
- Хэвлэл мэдээллийн алба
- УИХ-ын даргын ажлын хэсэг гэсэн үндсэн бүтэцтэй байна. Эдгээр бүтцийн нэгжийг дараах байдлаар зохион байгуулсан байна. Тухайлбал, Гадаад харилцааны хэлтэс, Хэвлэл мэдээллийн алба, УИХ-ын даргын ажлын хэсэг нь Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад харъяалагдахаас гадна УИХ-ын даргад давхар харъяалагдана.

Зохион байгуулалтын хэлтэс болон Санхүү үйлчилгээний хэлтсийг Ерөнхий нарийн бичгийн даргын нэг орлогчоор дамжуулан Ерөнхий нарийн бичгийн дарга удирдахаар бол Хууль тогтоомжийн шинжилгээ - лавламжийн хэлтэс, Номын сан болон Байнгын хорооны зөвлөгчдийг Ерөнхий нарийн бичгийн даргын хоёр дахь орлогчоор дамжуулан Ерөнхий нарийн бичгийн дарга удирдахаар зохион байгуулсан байна. 1995 онд УИХ -ын Тамгын газрын бүтцийн зураглал⁹ дараах байдалтай байжээ.

⁸ “Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент” Улсын Их Хурлын Тамгын газар. УБ хот, 2010 он. 27 тал.

⁹ УИХ-ын Тамгын газрын Захиргаа, боловсон хүчний хэлтсээс гаргасан зураглал


Зураг 1



3) Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. /1996 - 2000 он/

1996 - 2000 оны УИХ-ын Тамгын газар бүтэц, зохион байгуулалтын хувьд томоохон хэмжээний өөрчлөлт хийсэн байдаг.

Зураг 2



1996 оноос 2000 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан УИХ-д үйлчлэх Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдаж ба Ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч бөгөөд Хуулийн хэлтсийн дарга, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Санхүү, зохион байгуулалтын хэлтсийн дарга гэсэн хоёр орлогчтой байжээ. Бүтэц, зохион байгуулалт нь:

- Хуулийн хэлтэс
 - Санхүү, зохион байгуулалтын хэлтэс
 - Парламент хоорондын харилцааны хэлтэс
- гэсэн 3 хэлтэс байна. Мөн дараах алба, хэсгүүдтэй.

- Байнгын хороодын ажлын алба
- Судалгаа мэдээлэл, лавламжийн алба
- Хэвлэлийн алба
- Санхүү үйлчилгээний алба

гэсэн 4 алба байсан бөгөөд ЕНБД-ын орлогч бөгөөд Санхүү, зохион байгуулалтын хэлтсийн даргын шууд удирдлага дор:

- Хяналт шалгалтын хэсэг
- Олон нийттэй харилцах хэсэг
- Хуралдаан зохион байгуулах хэсэг

гэсэн 3 хэсэг тус тус ажиллаж байсан байна.

Түүнчлэн Санхүү, зохион байгуулалтын хэлтэс болон Судалгаа мэдээлэл, лавламжийн алба нь зохион байгуулалтын хувьд тус тус дараах нэгжүүдтэй байна. Үүнд:

Санхүү, зохион байгуулалтын хэлтэс нь:

- Санхүү, үйлчилгээний алба
- Боловсон хүчний хэсэг
- Бичиг хэрэг, бичээчийн хэсэг
- Олшруулах хэсэг гэсэн нэгжтэйгээр,

Судалгаа мэдээлэл, лавламжийн алба нь:

- Шинжилгээ, судалгааны хэсэг
- Номын сан
- Сүлжээ, програмын хэсэг
- Архив гэсэн нэгжтэйгээр тус тус ажиллаж байжээ.

Мөн зохион байгуулалтын хувьд Парламент хоорондын харилцааны хэлтэс болон Хэвлэлийн алба нь УИХ-ын даргад давхар харъяалагдаж байсан байна.

4) Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. /2000-2001 он/


2000-2004 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан УИХ өөрийн Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтад 2001, 2003 онд тус тус өөрчлөлт оруулж байсан байна. Үүнээс 2001 оны бүтцийн өөрчлөлтөөр УИХ-ын Тамгын газрын бүтцийн нэгжүүдийг нилээд системчилж 3 хэлтэс, 4 алба, 1 хэсэгтэй байхаар зохион байгуулсан байна. Үүнд:

- Хуулийн хэлтэс
- Гадаад харилцааны хэлтэс
- Санхүү, үйлчилгээний хэлтэс

- Чуулган, байнгын хороодын ажлын алба
- Судалгаа, лавламжийн алба
- Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба
- Техникийн алба
- Захиргаа, дотоод хяналтын хэсэг.

Тамгын газрын бүтцийн дээрх нэгжүүд зохион байгуулалтын хувьд Хуулийн хэлтэс, Чуулган, байнгын хороодын ажлын алба, Судалгаа, лавламжийн алба нь ЕНБД-ын нэгдүгээр орлогч бөгөөд хуулийн хэлтсийн даргын шууд удирдлага дор, Санхүү, үйлчилгээний хэлтэс болон Техникийн алба нь ЕНБД -ын орлогч бөгөөд Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын шууд удирдлагад ажиллана. Харин Гадаад харилцааны хэлтэс, Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба болон Захиргаа, дотоод хяналтын хэсэг нь ЕНБД-ын шууд удирдлагад ажиллах бөгөөд УИХ-ын даргад давхар харъяалагдана.

Зураг 3



5) Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. /2001 - 2003 он/

2001-2003 онд үйл ажиллагаа явуулж байсан Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг гурван орлогчтой (Хуулийн асуудал эрхэлсэн нэгдүгээр нарийн бичгийн дарга, Зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга, Санхүү, техникийн ашиглалт эрхэлсэн нарийн бичгийн дарга) болгосон бөгөөд Тамгын газрын нэгжийг бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах байдлаар өөрчлөн байгуулсан байна. Үүнд:

Ерөнхий нарийн бичгийн дарга нь:

- Хэвлэлийн алба
- Гадаад харилцааны хэлтсийг шууд удирдаж, Тамгын газрын бусад нэгжийг асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга нараар дамжуулан удирдан зохион байгуулна.

Түүнчлэн, Хэвлэлийн алба, Гадаад харилцааны хэлтэс нь УИХ-ын даргад давхар харъяалагдана.

Хуулийн асуудал эрхэлсэн нэгдүгээр нарийн бичгийн дарга нь:

- Хуулийн хэлтэс
- Мэдээлэл, судалгааны хэлтэс
- Хяналт, шалгалтын хэлтсийг харъяалан удирдахаар,


Зохион байгуулалтын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга нь:

- Захиргаа, дотоод хяналтын хэлтэс
- Зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтэс
- Чуулган, хуралдааны ажлын албыг харъяалан удирдахаар,

Санхүү, техникийн ашиглалт эрхэлсэн нарийн бичгийн дарга нь:

- Санхүү, үйлчилгээний хэлтэс
- Техник ашиглалтын алба, Хэвлэх тасгийг харъяалан удирдахаар тус тус зохион байгуулжээ.

Зураг 4



6) *Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. /2003-2008 он/*


УИХ-ын Тамгын газрын 2003 онд хийсэн бүтцийн өөрчлөлтөөр Ерөнхий нарийн бичгийн даргын орлогчыг хоёр болгон бууруулсан бөгөөд бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтын өөрчлөлтөд голлон анхаарсан байдаг. Үүнд:

Ерөнхий нарийн бичгийн даргын шууд удирдлагад:

- Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэс
 - Номын сан
- Гадаад харилцааны хэлтэс
- Хэвлэл мэдээллийн алба байх бол,
- Хуулийн хэлтэс

- Хуралдаан зохион байгуулах алба
- Хяналт шалгалтын хэлтсийг Нэгдүгээр нарийн бичгийн дарга бөгөөд Хуулийн хэлтсийн даргаар дамжуулан,
- Санхүү, үйлчилгээний хэлтэс
- Техник ашиглалтын албыг Нарийн бичгийн дарга бөгөөд Санхүү, үйлчилгээний хэлтсийн даргаар дамжуулан тус тус удирдахаар зохион байгуулжээ. Түүнчлэн Гадаад харилцааны хэлтэс болон Хэвлэл мэдээллийн алба нь УИХ-ын даргад давхар харъяалагдана.

Зураг 5




7) Улсын Их Хурлын Тамгын газар /2008 оноос хойш/

Улсын Их Хурлын даргын 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 147 дугаар захирамжаар одоогийн УИХ-ын Тамгын газрыг зохион байгуулсан байна. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын эрх зүйн үндсийг хуулиар тогтоосон бөгөөд энэ нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурал нь өөрийн гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх болон ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна” гэж заажээ.

Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд Улсын Их Хурлын чуулган бэлтгэн явуулах, түүний өдөр тутмын ажлыг зохицуулахад Улсын Их хурлын даргад туслах, Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдах үндсэн үүрэг бүхий Ерөнхий нарийн бичгийн даргыг Улсын Их Хурлаас томилно. Ерөнхий нарийн бичгийн дарга нам бус байна. Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг нь Ерөнхий нарийн бичгийн даргын шууд удирдлага дор Тамгын газрын бүтцэд багтаж, Улсын Их Хурлын даргад үйлчилнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч

Зураг 6



Тамгын газар нь дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон бусад хороодын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн туслалцаа болон бусад ажиллах нөхцөлөөр хангах;
- 2) Улсын Их Хурлын аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, түүний төсвийг зохих журмын дагуу зарцуулах;
- 3) Улсын Их Хурлын чуулганы бэлтгэл, хуралдааны хэвийн ажиллах нөхцөлийг хангах;
- 4) Чуулганы болон хороо, ажлын хэсгийн хуралдааны танхим, шаардлагатай техник хэрэгслийг бэлэн байлгах, танхимд журам сахиулах;
- 5) Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, баримт бичгийг нийтлүүлэх, тараах ажлыг зохион байгуулах. Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- 6) Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
- 7) Улсын Их Хурлын бичиг хэрэг, архивын үйл ажиллагааг хөтлөн явуулах;
- 8) Улсын Их Хурал, Тамгын газар, түүний харьяа байгууллагын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл хангах, гадаадын зочин төлөөлөгчдөд үйлчлэх;
- 9) Хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

Тамгын газрын хэлтэс, алба, төв, тэдгээрийн чиг үүрэг

Дээрх бүдүүвчид үзүүлсний дагуу УИХ-ын Тамгын газар нь бүтцийн хувьд дараах нэгжтэй байна. Үүнд:

1. Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс
 2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс
 3. Захиргаа, боловсон хүчний хэлтэс
 4. Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс
 5. Санхүү, аж ахуй үйлчилгээний хэлтэс
 6. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
 7. Судалгааны төв
 8. Байнгын хороодын ажлын алба
 9. Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба
- гэсэн зохион байгуулалтын нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс дэргэдээ Редакцийн хэсэгтэй, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс дэргэдээ “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн редакцийн хэсэгтэй, Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс дэргэдээ Хэвлэх цехтэй, Судалгааны төв дэргэдээ Номын сантайгаар тус тус ажиллаж байна.

1. Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс

Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль, тогтоолын төслийн бүрдлийг хянах, Улсын Их Хурлын гишүүдээс хууль санаачлахад нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль, тогтоолын төслийг Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэх, уялдуулах, энэ асуудлаар Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороо, Улсын Их Хурлын удирдлага, гишүүд, ажлын хэсгээс өгсөн үүрэг, тавьсан саналыг хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд төслийн хэлэлцүүлэгтэй холбогдсон асуудлаар тайлбар өгөх, баталсан шийдвэрийн эцсийн найруулгыг бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлуулах, хууль тогтоомжийг системчлэх, ангилах, эрх зүйн актын лавлагаа, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурлын гишүүдэд хууль, тогтоолын төсөл боловсруулахад нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
- 2) Хууль санаачлагчийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль, тогтоолын төслийн бүрдлийг хянаж, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан шаардлага хангасан төслийг зохих журмын дагуу өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Нарийн бичгийн даргад мэдэгдэх;
- 3) Шаардлагатай тохиолдолд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуультай нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн дүгнэлт бичиж, Байнгын хорооны дарга болон ажлын хэсгийн ахлагчид танилцуулан холбогдох тайлбар, лавлагааг өгөх;
- 4) Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар гаргах Улсын Их Хурлын даргын захирамжийн төсөл боловсруулах;
- 5) Хууль, тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хууль зүйн нэр томъёо, хэл зүйн шаардлагад нийцүүлэн томъёолон бэлтгэх;
- 6) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу төслийн анхны хэлэлцүүлгийн шатанд гарсан саналын дагуу холбогдох Байнгын

- хорооноос санаачлан боловсруулах, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;
- 7) Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан удирдах дараалал бэлтгэх;
 - 8) Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд нэмж тусган, эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх;
 - 9) Эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж, хууль зүйн бичлэгийн техникт нийцүүлэн томъёолол, үг хэллэгийг жигдэлж Редакцийн хэсгээр хянуулан төслийн эцсийн найруулгыг бэлтгэх, Улсын Их Хуралд танилцуулах ажлыг зохион байгуулах;
 - 10) Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар эцсийн найруулгыг танилцуулах явцад гарсан найруулгын болон техникийн шинжтэй засварыг тусган хууль, тогтоолыг ёсчлуулах ажлыг зохион байгуулах;
 - 11) Батлагдсан хууль, тогтоолыг Ерөнхийлөгчийн хориг тавих хугацаа дуусмагц холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
 - 12) Батлагдсан хууль, тогтоолын танилцуулга бэлтгэх;
 - 13) Ерөнхийлөгчийн хоригийн талаар хууль зүйн дүгнэлт боловсруулах, Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчид холбогдох асуудлаар Цэцэд өгөх тайлбар бичихэд нь туслалцаа үзүүлэх;
 - 14) Ерөнхийлөгчийн хориг болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан гарах Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулах;
 - 15) Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх бусад эрх зүйн актаар хууль тогтоомжийн сан бүрдүүлж, тэдгээрийг ангилах, системчлэх, нэмэлт, өөрчлөлтийг тусгах ажлыг тухай бүр хийж, эрх зүйн актын лавлагаа, мэдээллээр үйлчлэх;
 - 16) Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэн баталсан хууль, тогтоолын талаарх статистик дүн мэдээ гаргах.

2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс нь Монгол Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэм /цаашид “МПБ” гэх/ болон Улсын Их Хурлын Тамгын газраас гадаад орнуудын хууль тогтоох дээд байгууллага, тэдгээрийн олон улсын парламентын холбоотой хамтран ажиллах бүлгэм, Олон улсын парламентын холбоо /цаашид “ОУПХ” гэх/, тус холбооны дэргэдэх Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэг, хууль тогтоох байгууллагуудын Тамгын газар, олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагууд, олон улсын бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллах асуудлыг холбогдох хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээр, тохиролцооны үндсэн дээр зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурал, түүний Тамгын газраас гадаад орнуудын парламент, тэдгээрийн Тамгын газар, олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагуудтай харилцах бодлогыг боловсруулах, тэдгээрийн өмнө Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын зүгээс хүлээсэн үүргийг биелүүлэх, харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;
- 2) Улсын Их Хурал, МПБ-ийн Гүйцэтгэх хорооноос ОУПХ-той харилцах, хамтран ажиллах бодлогыг боловсруулах, ОУПХ-ны өмнө Монгол Улсын Их Хурал, МПБ-ийн зүгээс хүлээсэн үүргийг биелүүлэх, ОУПХ-ноос батлагдаж буй тогтоолуудыг МПБ-ийн Гүйцэтгэх хорооны дарга, гишүүдэд орчуулж танилцуулах, тогтоолуудын хэрэгжилтийн тайланг тухай бүр ОУПХ-нд хүргүүлэх, ОУПХ-той идэвхтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх;

- 3) Улсын Их Хурал, МПБ, Тамгын газрын нэрийн өмнөөс зохих журмын дагуу Гадаад харилцааны яам, Монгол Улсаас гадаад улс орнуудад суугаа Элчин сайдын яамдууд болон холбогдох бусад байгууллагатай харилцах, үйл ажиллагаагаа уялдуулан явуулах;
- 4) гадаад орнуудын парламент, тэдгээрийн Тамгын газартай байгуулах хамтын ажиллагааны протокол, санамж бичиг зэрэг баримт бичгийг боловсруулах, орчуулах, биелэлтэд нь хяналт тавих;
- 5) Улсын Их Хурал, МПБ-ийн Гүйцэтгэх хорооноос гадаад бодлого, олон улсын харилцааны асуудлаар гаргах баримт бичгийг боловсруулах, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд, МПБ-ийн Гүйцэтгэх хорооны дарга, Тамгын газрын удирдлагаас бусад орны парламентын удирдлага, гишүүд, ОУПХ-ны удирдлага, нарийн бичгийн дарга нарт парламентын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар хүргүүлэх захидал, урилга, илгээлт болон бусад баримт бичгийг боловсруулах, орчуулах;
- 6) Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүд, МПБ-ийн Гүйцэтгэх хорооны удирдлагад гадаад бодлого, парламент хоорондын харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, шаардлагатай лавлагаа, мэдээлэл, танилцуулгаар хангах;
- 7) гадаад орнуудын парламент, тэдгээрийн ажлын алба, холбогдох олон улсын байгууллагын тухай болон тэдгээртэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх боломж, гадаад орнуудын парламентуудтай харилцаа, хамтын ажиллагаа шинээр эхлүүлэх боломж, арга хэлбэрийн талаар судлах, санал боловсруулж удирдлагад танилцуулах;
- 8) Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэмийн гадаад бодлого, үйл ажиллагаа, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн талаар шаардлагатай тохиолдолд тус улсад суугаа гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газруудад мэдээлэх;
- 9) Улсын Их Хурал, МПБ, Тамгын газрын төлөөлөгчдийг гадаад орнуудад айлчлуулах, олон улсын хурал, семинар, симпозиум, сургалтад оролцуулах, Улсын Их Хурал, МПБ, Тамгын газрын урилгаар гадаад орнуудаас ирэх зочид, төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг хариуцан зохион байгуулах;
- 10) Улсын Их Хурал, МПБ, Тамгын газрын гадаад арга хэмжээний жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 11) Улсын Их Хурал, МПБ-ийн гадаад бодлого, үйл ажиллагааны талаар Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй хамтран мэдээлэл хийх;
- 12) Улсын Их Хурлын дарга, дэд дарга нар, Улсын Их Хурлын гишүүд, МПБ-ийн Гүйцэтгэх хороо, Тамгын газрын удирдлагууд парламентын харилцааны асуудлаар гадаадын зочин, төлөөлөгчид, Монгол Улсад суугаа гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, дипломат ажилтнуудыг хүлээн авч уулзахад оролцож уулзалт, ярилцлагын тэмдэглэл хийх, шаардлагатай тохиолдолд хэлмэрчлэх;
- 13) Парламентын гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гадаад орнуудын парламент, Монгол Улсад суугаа гадаад орнуудын дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газартай уулзалт зохион байгуулах, санал, мэдээлэл солилцох, яриа хэлэлцээр хийх, захидал бичгээр харилцах;
- 14) Улсын Их Хурлын веб хуудсанд оруулах шаардлагатай мэдээ, материалыг орчуулах.

3. Захиргаа, боловсон хүчний хэлтэс

Захиргаа, боловсон хүчний хэлтэс нь Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүдийн туслах, бие төлөөлөгч-туслахын хөдөлмөрийн харилцаатай холбогдон гарах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдээс иргэдийн өргөдөл, санал, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэхэд нь тусалцаа үзүүлэх, Улсын Их Хурал, Тамгын газрын бичиг хэрэг, архивын үйл ажиллагааг хөтлөн явуулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнес төлөвлөгөө боловсруулж, түүний биелэлтийг тооцож ажиллах, Тамгын газрын хагас, бүтэн жилийн ажлын тайланг нэгтгэн дүгнэх;
- 2) Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт болон Тамгын газрын дүрэм, дотоод журам, хэлтэс, алба, төв /цаашид “бүтцийн нэгжүүд” гэх/-ийн ажлын чиг үүргийг боловсронгуй болгох асуудлаар санал, дүгнэлт боловсруулж шийдвэрлүүлэх;
- 3) Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандартын дагуу Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг мөрдүүлэх;
- 4) Төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг Тамгын газрын бүтцийн нэгжүүдийн саналын дагуу бэлтгэж батлуулах;
- 5) Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүдийн туслах, бие төлөөлөгч-туслахуудын болон Улсын Их Хурлаас томилогддог удирдах ажилтнуудын хувийн хэргийг стандартын дагуу бүрдүүлж, хадгалах, хүний нөөцийн холбогдолтой мэдээ, судалгаа, тайланг гаргах, тэдний албаны үнэмлэх олголт, бүртгэл, шинэчлэлтийг хариуцан гүйцэтгэх;
- 6) Тамгын газрын ажилтнууд болон Улсын Их Хурлын гишүүдийн туслахууд, бие төлөөлөгч-туслахуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, давтан сургах, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, Олон улсын байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран гадаад, дотоод сургалтууд зохион байгуулах;
- 7) Ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, цалин хөлс, нөхөх олговор олгох, тэдний ажил мэргэжлийн түвшинг үнэлэх, албан хаагчдад зэрэг дэв олгох, ур чадварын нэмэгдэл, шагнал урамшил олгох, шагналд тодорхойлох зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 8) Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмж, буцалтгүй тусламж, хөнгөлөлт, эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй холбогдсон асуудлыг хариуцан шийдвэрлүүлэх;
- 9) Улсын Их Хурлын дарга, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдуулж Улсын Их Хурал, Байнгын хороодоос гаргасан шийдвэр болон Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад шийдвэрийг бүтцийн нэгжүүд, холбогдох албан тушаалтанд шуурхай хүргэх, биелэлтэд нь хяналт тавих, Тамгын газрын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Тамгын газрын удирдлагаас бүтцийн нэгжүүд болон ажилтнуудад өгсөн үүргийн биелэлтийг тухай бүр нь тооцож ажиллах;
- 10) Ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулах, түүний биелэлтийг тооцон дүгнэх ажлыг зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид ерөнхий менежерээс нийлүүлэх тусгай захиалгат бүтээгдэхүүнийг төлөвлөх, тооцох ажлыг зохион байгуулах, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавих;
- 11) Тамгын газрын нэрэмжит шагнал, тэдгээрийн төрөл, хэмжээ болон олгох журам

- боловсруулж батлуулах, нөөцийн болон олголтын асуудалд хяналт тавих;
- 12) Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүдийн туслахууд, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнуудын Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, тайлан гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
 - 13) Улсын Их Хурлын вэб хуудсанд байршуулах хүний нөөцийн холбогдолтой мэдээллийг байршуулах, Улсын Их Хурал, Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн хэмжээнд зохион байгуулагдах нийтлэг арга хэмжээний мэдээллийг долоо хоногоор боловсруулж, холбогдох ажилтнуудад хүргүүлэх;
 - 14) Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар танилцуулга бэлтгэн хэвлүүлэх, олон нийтийн хүртээл болгох;
 - 15) Тамгын газрын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж, жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийн сан байгуулж хөтлөх;
 - 16) Байгууллага, хамт олны баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах;
 - 17) Улсын Их Хурлын гишүүдийн туслахууд, бие төлөөлөгч-туслахуудын ажил хэргийн чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт семинар, ярилцлага зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, тэдний ажлын тайланг нэгтгэн, дүгнэх;
 - 18) Тамгын газраас Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын алба, Төрийн ёслолын алба зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулж, Улсын Их Хурлын ахмадын хорооны үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;
 - 19) Парламентын музей, иргэдийг хүлээн авах байр ажиллуулан иргэд, сонгогчдын санал, хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагад мэдээлэх ажлыг зохион байгуулах;
 - 20) Улсын Их Хурал, түүний Тамгын газрын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагааг стандартын дагуу зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын бүтцийн нэгжүүдийг архивын лавлагаа, мэдээллээр хангах, архив, бичиг хэргийн ажлын мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
 - 21) Улсын Их Хурал, Тамгын газрын бичиг хэргийг хөтөлж, байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, баримт материал, иргэдийн захидал, Улсын Их Хурлын вэб хуудсаар дамжуулан ирүүлсэн болон амаар тавьсан санал хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэх, тэдгээрийг Улсын Их Хурлын болон Тамгын газрын удирдлага, Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулж, хариутай бичиг, өргөдөл, санал, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, дүн мэдээг сар тутам гаргах, нэгдсэн танилцуулга бэлтгэж, Улсын Их Хурал, Байнгын хороо, Тамгын газрын удирдлагад хүргүүлэх;
 - 22) Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бүтцийн нэгжид ажиллагсдын албан тасалгааны хуваарийг оновчтой зохион байгуулах, засвар, үйлчилгээ хийх төлөвлөгөө, хуваарийн талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавих;
 - 23) Тамгын газрын ажилтнуудын цаг бүртгэлийн цахим системийг боловсронгуй болгох асуудлыг Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэстэй хамтран хийж, цаг бүртгэлд хяналт тавьж ажиллах;
 - 24) Улсын Их Хурлын гишүүдийн тойрогтоо ажилласан тухай тайлан, мэдээг авч нэгтгэх, гишүүдийн орон нутагт ажиллах үед иргэд, сонгогчдоос гаргасан саналыг нэгтгэж, холбогдох Байнгын хороо, бусад шаардлагатай газарт хүргүүлэх;

- 25) Ерөнхий нарийн бичгийн даргын өдөр тутмын үйл ажиллагаанд зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.

4. Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс

Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс нь Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдал болон техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллахад чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурлын Тамгын газарт баримтлах мэдээллийн технологи, мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдал болон техникийн нэгдсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;
- 2) Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааны танхимын микрофон, санал хураалтын системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, аудио болон видео бичлэг хийх, техникийн болон програм хангамжийн өргөтгөл, шинэчлэлтийг хариуцан ажиллах;
- 3) Интернэт болон Интранэтийн үйлчилгээ, сервер компьютерийн ашиглалт, тохируулгыг хариуцаж, сүлжээний аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг зохих түвшинд хангаж, энэ чиглэлээр шаардлагатай бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- 4) Улсын Их Хурлын интернэтийн болон интранэтийн вэб хуудас, тэдгээрийн дизайн, бүтэц, мэдээллийн агуулга, програмчлалын технологи, шинэчлэлт, баяжуулалт, тавигдах мэдээллүүдийн стандарт, хариуцаж оруулах хуваарийг тогтоон мөрдүүлж, Тамгын газрын бүтцийн нэгжүүдээс оруулах мэдээллүүдэд цаг хугацаа, стандарт, форматын талаас нь хяналт тавих;
- 5) Компьютерийн техник болон програм хангамжийн үйлчилгээг хариуцан гүйцэтгэх;
- 6) Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд тараах материалыг хувиалан олшруулах, хувилах, олшруулах машины засвар, үйлчилгээг хариуцан гүйцэтгэх;
- 7) Улсын Их Хурлын телесүлжээ, компьютерийн сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, сүлжээний зохион байгуулалт, өргөтгөл шинэчлэлтийг хариуцан ажиллах;
- 8) Улсын Их Хурал, түүний Тамгын газар, нам, эвслийн бүлгийн ажлын алба, Улсын Их Хурлын гишүүд, туслахуудад ашиглагдаж байгаа техник, хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай засвар, үйлчилгээг хариуцан гүйцэтгэх;
- 9) Принтер, тог баригч, телевизор, факсын аппарат, диктофон, аудио болон видео техник хэрэгсэл, проектор зэрэг Тамгын газрын хэмжээнд ашиглагдаж байгаа бусад техник хэрэгслийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцаж, энэ чиглэлээр шаардлагатай мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- 10) Хэвлэх цехийн өдөр тутмын үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж, уг цехэд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцаж, хөдөлмөрийн болон галын аюулгүй ажиллагаанд холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хяналт тавьж ажиллах;
- 11) Хэвлэлийн эх бэлтгэх, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг хэвлэх, бусад нэр төрлийн хэвлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэвлэх.
- 12) Техник хэрэгслийн хуваарилалт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, ашиглалтын байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлын шаардлага хангахгүй болсон техник хэрэгслийг сэлбэн засварлах, шилжүүлэх, ашиглалтаас хасах, техник хэрэгсэл, сэлбэг, материалын хангалт хийх, норм тогтоож мөрдөх асуудлыг Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэстэй

хамтран зохион байгуулах;

- 13) Мэдээллийн технологи, техникийн шинэчлэлийн чиглэлээр нэгдсэн төлөвлөгөө, төсөл боловсруулж хэрэгжүүлэх, зохих журмын дагуу гадаад орны байгууллагатай харилцах, гэрээ, хэлцэл байгуулах замаар хамтран ажиллах;
- 14) Улсын Их Хурал, түүний Тамгын газарт ашиглагдаж байгаа мэдээллийн системүүдийг нэгдсэн стандарт, удирдлагаар хангах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх, мэдээллийн урсгал / орц, гарц / -д хяналт тавьж дүгнэх, боловсронгуй болгох;
- 15) Вэб хуудсанд мэдээлэл оруулах асуудлаар Тамгын газрын ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
- 16) Тамгын газарт шаардлагатай програм хангамжийн хэрэгцээг тодорхойлж, стандарт боловсруулан мөрдүүлэх, шинэчлэх, өргөтгөх.

5. Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэс

Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэс нь Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн санхүү, аж ахуй, үйлчилгээг хариуцан явуулах хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурал, түүний Тамгын газрын төсөв зохиож батлуулах, захиран зарцуулахтай холбогдсон үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн гүйцэтгэх;
- 2) Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, санхүү, төсвийн норм, хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 3) Төлбөр тооцооны ажлыг хөнгөвчлөх, түүний үнэн зөв, шуурхай байдлыг хангахад чиглэсэн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, тэдгээрт үндэслэн санхүүгийн тайлан баланс гаргаж, зохих газарт нь хугацаанд нь хүргүүлэх, санхүүгийн тайлан, гүйцэтгэлийн аудитыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэж дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- 4) Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлж, иж бүрэн програмчлах ажлыг зохион байгуулах;
- 5) Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, өмчийн асуудал эрхэлсэн орон тооны бус комиссын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, эд хөрөнгийн тооллого, тооцоог тухай бүр хийж, хөрөнгийн ашиглалтад хийх үзлэг шалгалтыг зохион байгуулах, хөдөлгөөн өөрчлөлтийг баланс бүртгэлд тусгах;
- 6) Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бүтцийн нэгжид ажиллагсдын хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай эд хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хангамжийг бэлтгэх, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, тайлан гаргах;
- 7) Тамгын газраас Улсын Их Хурлын төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэх бүтээгдэхүүний өртөг зардлыг тооцох, тэдгээрийн үр дүнгийн тайланг нэгтгэн гаргаж танилцуулах;
- 8) Улсын Их Хурал, түүний Тамгын газарт ажиллагсдын цалин, нэмэгдлийг зохих журмын дагуу тооцон батлуулж, батлагдсан цалингийн санд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих;
- 9) Ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтын дагуу хууль тогтоомжоор тогтоогдсон хэмжээнд унаа, холбоо, шуудан, хэвлэл захиалга, албан тасалгааны засвар, үйлчилгээг холбогдох газруудтай гэрээ байгуулан гүйцэтгэлийг шуурхай

- хангах, биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах;
- 10) Улсын Их Хурал болон Тамгын газарт урилгаар ирсэн дотоод, гадаадын зочид төлөөлөгчдөд гардуулах бэлэг, дурсгалын зүйлийн нөөцийг бүрдүүлж, зохих журмын дагуу зарцуулах, тайлан мэдээ гаргах;
 - 11) Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал дахь Нам, эвслийн бүлэгт ногдох төсвийг зохих журмын дагуу хуваарилж, тухайн төсвийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр зарцуулах, гүйцэтгэлийг хангах, тайлагнахтай холбоотой мэдээлэл, аргачлал зөвлөмжөөр хангах.

6. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь Улсын Их Хурал болон Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд хүргэж мэдээлэх, сурталчлах үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ: Үүнд:

- 1) Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлах бодлого, чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 2) Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны явц, дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааны тухай танилцуулга, сурталчилгааны бусад материал бэлтгэн нийтлүүлэх, эмхтгэж хэвлүүлэх;
- 3) Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох болон цаг үеийн асуудлаар мэдээлэл, мэдэгдэл, тайлбар хийх зэргээр Улсын Их Хурлын албан ёсны байр суурийг удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу илэрхийлэх;
- 4) Улсын Их Хурал, Байнгын хороо, Тамгын газрын удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу батлагдсан хууль тогтоомж болон Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороо, Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн бага хурал хийлгэх, төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүд, холбогдох бусад хүмүүсийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгүүлэх ажлыг зохион байгуулах;
- 5) Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийг олон улсын болон өөрийн оронд болж буй үйл явдлын тухай хэвлэлийн мэдээллээр хангах;
- 6) МПБ-ийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах;
- 7) Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон гэрэл зургийн архив бүрдүүлэх, видео сан байгуулах;
- 8) “Төрийн мэдээлэл” эмхтгэлийг эрхлэн гаргах. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг хэвлэхийн өмнө уг шийдвэрийн ёсчилсон хувьтай нь тулган хянаж, алдаагүй хэвлүүлэх асуудлыг хариуцна;
- 9) Парламентын сэтгүүлчдэд сурвалжлах эрхийн үнэмлэх олгох, мэдээллээр хангах асуудлыг хариуцан, бүртгэл судалгаа хөтлөх, гэрээ, журам зөрчсөн сэтгүүлчийн сурвалжлах эрхийн үнэмлэхийг хураах;
- 10) Парламентын сэтгүүлчдийн бичсэн нийтлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой алдаатай нийтлэл, нэвтрүүлэгт няцаалт өгөх, мэдэгдэл, тайлбар гаргах зэргээр мэдээллийн бодит байдлыг хангах ажлыг хариуцаж зохион байгуулах;
- 11) Улсын Их Хурлын гишүүдийг сонгогдсон тойрогтой нь холбож, хууль сурталчлах, иргэдийн санал бодлыг сонсох телевизийн цуврал нээлттэй ярилцлага /“Теле-мост”/ явуулах ажлыг хариуцаж зохион байгуулах;
- 12) Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж

сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллах гэрээ байгуулж ажиллах, гэрээний биелэлтэд хяналт тавих;

- 13) Улсын Их Хурлын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах төвүүдийг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлага, холбогдох мэдээллээр хангах;
- 14) Байнгын хорооны хуралдааныг нээлттэй явуулах, олон нийтийн саналыг хууль болон бодлогын шийдвэрийн төсөлд тусгах үүднээс хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан санал авах ажлыг Тамгын газрын бүтцийн холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;
- 15) Иргэдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Монгол Улсын Төрийн ордонтой танилцуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах;
- 16) Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах ажлыг хариуцаж ажиллах.

7. Судалгааны төв

Судалгааны төв нь Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд ирүүлсэн захиалга, чиглэлийн дагуу болон Төвийн санаачлагаар цаг үеийн тулгамдсан асуудлууд, бодлогын чанартай асуудлуудаар судалгаа хийх, бодлогын шинжилгээний дүгнэлт, зөвлөмж гаргах, цаг үеийн шуурхай мэдээлэл, судалгааны мэдээллээр хангах, судалгааны мэдээллийн бааз бүрдүүлэх, хууль, тогтоолын төсөл болон бодлого боловсруулах шатанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, экспертүүдийн саналыг авах, хэлэлцүүлэг хийхтэй холбогдуулан олон нийттэй харилцах үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

- 1) Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд хийх судалгааны ажлын захиалгыг Байнгын хороодын ажлын албаар дамжуулан авах, Улсын Их Хурлын болон Тамгын газрын удирдлага, Байнгын хороодын удирдлагаас өгсөн захиалгын дагуу судалгааны ажлыг зохион байгуулах;
- 2) Цаг үеийн тулгамдсан асуудал болон бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудлаар Төвийн санаачлагаар судалгааны сэдэв гаргаж, судалгааны ажлыг зохион байгуулах;
- 3) Судалгааны сэдвийн хүрээнд тухайн асуудлаар статистик мэдээлэл, судалгааны материал, зах зээлийн мэдээлэл, бусад орны туршлагыг судалж судалгааны мэдээллийн бааз бүрдүүлэх, мэдээллээр хангах;
- 4) Судалгааны сэдвийн хүрээнд тухайн салбарын хууль, эрх зүйн болон төрийн зохицуулалтын бодлого, чиглэл, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээллийн бааз бүрдүүлж мэдээллээр хангах;
- 5) Судалгааны сэдвийн хүрээнд бодлогын судалгаа хийж төлөв байдал, хандлагад дүн шинжилгээ хийх, нөлөөллийн хүчин зүйлийг тодорхойлох, бодлогын шинжилгээний дүгнэлт гаргаж, тухайн асуудлыг шийдвэрлэх бодлогын альтернатив хувилбаруудыг боловсруулах, санал, зөвлөмж гаргах;
- 6) Шаардлагатай хууль, тогтоолын төсөл болон бодлогын шийдвэрийн төсөлд олон нийтийн саналыг тусгах үүднээс санал авах, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдыг оролцуулан хэлэлцүүлэг, онол практикийн хурлыг Тамгын газрын бүтцийн холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;
- 7) Засгийн газар, яам, агентлаг, судалгаа шинжилгээ, мэдээллийн болон бусад холбогдох байгууллага, Тамгын газрын бүтцийн нэгжүүдээс мэдээлэл авах, хамтран ажиллах;
- 8) Судалгааны явцад шаардлагатай асуудлаар мэргэжлийн эксперт, зөвлөхийг гэрээгээр ажиллуулах, судлаачдын түвшинд уулзалт, ярилцлага, төрөлжсөн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах;

- 9) Судалгааны чиглэлээр олон нийтийн хэлэлцүүлэг хийх, санал авах ажлыг зохион байгуулах;
- 10) Веб хуудсаар дамжуулан хуулийн төсөл болон бодлогын асуудлаар хэлэлцүүлэг хийх, олон нийтийн санал авах ажлыг тогтмол зохион байгуулах;
- 11) Дотоодын болон гадаад орнуудын парламент болон парламентын дэргэдэх бодлогын судалгаа, шинжилгээний байгууллагын талаар судалгаа хийх, парламентын түүхийн эмхтгэл гаргах;
- 12) Судалгааны материалыг эмхтгэн номын санд шилжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийг судалгааны дэлгэрэнгүй тайлантай танилцах нөхцөлийг бүрдүүлэх;
- 13) Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын удирдлагыг улс орны дотоод мэдээлэл болон дэлхийн улс төр, эдийн засаг, санхүүгийн байдлын талаархи тойм мэдээллээр шуурхай хангах;
- 14) Судалгааны мэдээллийн нэгдсэн бааз бүрдүүлэх, мэдээллийг ангилан дэлгэрэнгүй болон хураангуй хэлбэрээр хадгалах, судалгааны лавлагаа, цахим мэдээллийн сан бүрдүүлэх;
- 15) Улсын Их Хурлын дотоод сүлжээнд судалгааны мэдээллийн материалыг байршуулах;
- 16) Судалгааны ажлын тайлан, судалгааны материалаар болон шаардлагатай зарим асуудлаар гарын авлага, ном товхимол эмхтгэн гаргах;
- 17) Төвийн болон Тамгын газрын хэмжээнд бусад хэлтэс, албатай хамтран сургалт зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 18) Улсын Их Хурлын номын санг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, олон нийтэд номын сангаар үйлчлэх.

8. Байнгын хороодын ажлын алба

Байнгын хороодын ажлын алба нь Улсын Их Хурлын Байнгын, дэд, түр хороо /цаашид “Хороо” гэх/-ны хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх, дотоод ажлын зохион байгуулалтыг хангаж, Хорооны дарга, гишүүдэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, ажлын алба, ажилтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, шуурхай удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Хорооны ажлын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж, Тамгын газрын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллах;
- 2) Хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдаанаас гарах тогтоол, шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, түүний хэрэгжилтийг хангах;
- 3) Улсын Их Хурлын гишүүдээс хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхэд нь Хорооны эрхлэх асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- 4) Хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах ажлыг төлөвлөж, гүйцэтгэлийг хангах;
- 5) Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаар мэргэжлийн дүгнэлт гарган Хорооны дарга, гишүүдэд төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх шатнаас өмнө танилцуулах;
- 6) Хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх болон анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаархи болон албан тушаалтныг томилох, чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах, түүнчлэн Байнгын хороо санаачлах төслийн талаар Хорооноос гаргах санал, дүгнэлтийг зохих журмын дагуу бэлтгэх, албажуулах;
- 7) Хорооны эрхлэх асуудлын хүрээнд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний

- болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд /Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, Улсын Их Хуралд үйл ажиллагааныхаа тайланг мэдээлдэг, сонсгодог/-ын тайланд үнэлэлт өгөх, уг тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, холбогдох шийдвэр гаргуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 8) Хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай зохих журмын дагуу харилцах, хяналт тавьж ажиллах;
 - 9) Улсын Их Хурлын даргын захирамж болон Хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөн албажуулах, ажлын хэсгийн танилцуулга бэлтгэх;
 - 10) Хорооны долоо хоногийн, чуулганы болон түүний завсарлагааны хугацаанд хийх ажлын төлөвлөгөө, график боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
 - 11) Тухайн долоо хоногт Байнгын хороо, ажлын хэсэг болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуваарийн төслийг бэлтгэн Тамгын газрын Нарийн бичгийн даргад хүргүүлэх;
 - 12) Хорооны даргад “Хуралдаан удирдах дараалал” бэлтгэж танилцуулах, уг дараалалтай холбоотой асуудлаар Хорооны хуралдаанд тайлбар, зөвлөгөө өгөх;
 - 13) Хорооны хуралдааныг нээлттэй явуулах, төслийн талаар олон нийтээс санал авах ажлыг Тамгын газрын бүтцийн холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулж, саналыг нэгтгэн танилцуулах;
 - 14) Улсын Их Хурлын гишүүнээс Засгийн газар, бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтанд асуулт, асуулга тавих ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хариуг сонсох асуудлыг зохих журмын дагуу зохион байгуулах;
 - 15) Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хуралд сонсох ажлыг хариуцан зохион байгуулах;
 - 16) Улсын Их Хурлаас Засгийн газарт болон бусад байгууллагад тогтоолоор өгөгдсөн үүргийн биелэлтэд хяналт тавих, шийдвэрийн хэрэгжилтийг улирал тутам гаргаж, холбогдох судалгаа, дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын болон Тамгын газрын удирдлагад танилцуулах;
 - 17) Хорооны эрхлэх асуудал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийж, уг асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад өгөх чиглэл, санал, дүгнэлт, зөвлөмжийн төслийг боловсруулж албажуулах;
 - 18) Хорооны үйл ажиллагааны тайлан, танилцуулга, статистик мэдээг бэлтгэх, зохих журмын дагуу албажуулж холбогдох газруудад хүргэх;
 - 19) Улсын Их Хурлаар хэлэлцэх төслийг чуулганы танхимд тараахаас бусад үед зохих журмын дагуу Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараах, түүнчлэн гишүүдэд ирсэн материалыг шуурхай хүргэх;
 - 20) Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хорооны хурлаар хэлэлцсэн асуудал, төслийн хувийн хэргийг зохих журмын дагуу бүрдүүлж, архивт шилжүүлэх;
 - 21) Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хороо, ажлын хэсгийн хуралдаанд байлцвал зохих хүмүүс, албан тушаалтныг бэлэн байлгах, шаардлагатай мэдээ, мэдээллийг бүрэн авчруулах арга хэмжээ авах;
 - 22) Хороонд ирсэн, явсан албан бичиг, иргэдийн санал, өргөдөл, гомдлыг бүртгэн авч, зохих албан тушаалтанд танилцуулан холбогдох газарт шилжүүлэх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тооцох, уг материалыг архивт шилжүүлэх;
 - 23) Хорооны даргад ирсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, хариу бэлтгэн явуулах;

- 24) Улсын Их Хурлын болон Хороод, Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдож гарсан шийдвэр, удирдлагаас өгсөн үүргийг тухай бүр тооцож, биелэлтийг хангаж ажиллах;
- 25) Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт, дараалалд орсон болон шинээр өргөн мэдүүлсэн төслүүдэд бодлогын шинжилгээ хийлгэх, бусад орнуудын хууль тогтоомжийн зохицуулалтын талаар судалгаа хийлгэх саналыг тогтоосон журмын дагуу Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвд тавьж, холбогдох мэдээллээр хангах;
- 26) Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга болон ёсчлуулах хувийг нягталж, Байнгын хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулахад бэлтгэх;
- 27) Хорооноос зохион байгуулсан ажлын талаар олон нийтэд мэдээлэх, хэвлэлийн бага хурал хийх ажлыг Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй хамтран зохион байгуулах;
- 28) Байнгын хорооны дарга 7-оос дээш хоног түр эзгүйд үүргийг нь аль нэг гишүүнээр орлуулж гүйцэтгүүлэх, Үндсэн хуулийн цэцэд үүссэн маргаантай асуудлаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох зэрэг Байнгын хорооны эрхлэх асуудал, дотоод зохион байгуулалтын асуудалтай холбогдон гарах Улсын Их Хурлын даргын захирамжийн төсөл болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах;
- 29) Хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын холбогдолтой судалгаа, лавлагааны сан бүрдүүлэх;
- 30) Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод сүлжээнд холбогдох материалыг цаг тухайд нь оруулах;
- 31) Хорооноос зохион байгуулах хурал, зөвлөгөөний бэлтгэлийг хангах, илтгэл, танилцуулга, шийдвэрийн төсөл боловсруулах.

9. Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба

Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба нь Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлж, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааны товыг зөвлөлийн гишүүдэд зарлаж, хуралдааны тэмдэглэл хөтлөх;
- 2) Улсын Их Хурлын анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой чуулганы болон хүндэтгэлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны үйл ажиллагаа, дүнгийн талаар холбогдох мэдээ, тайлан, танилцуулга гаргах;
- 3) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны хуваарь, хэлэлцэх асуудлын дарааллыг олшруулж, батлагдсан хуваарийн дагуу Улсын Их Хурлын гишүүд, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар, Төрийн ордны хамгаалалтын алба, Төрийн холбооны газрын холбогдох хүмүүст тараах;
- 4) Хуралдаанаар хэлэлцэх хууль, тогтоолын төсөл, Хорооны болон Улсын Их Хурал дахь Нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт, танилцуулга, саналын томъёоллыг тараах ажиллагаанд хяналт тавьж, зохих хувийг Улсын Их Хурал, Тамгын газрын удирдлага, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын холбогдох албан тушаалтан, хуралдааны тэмдэглэл хөтлөгч нарт шуурхай хүргэх;
- 5) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны ирц хүчинтэй байх нөхцөлийг бүрдүүлж, ирцийн мэдээ гаргах;

- 6) Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар асуудал хэлэлцэхэд зайлшгүй байх шаардлагатай хууль санаачлагч, ажлын хэсгийн гишүүд болон холбогдох бусад хүмүүсийн нэрсийг тухайн Байнгын хорооноос гаргуулан авч, хуралдаан даргалагчид танилцуулах;
- 7) Хуралдааны танхимд дэг сахиулах;
- 8) Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэхээр чуулганы танхимд тараах хууль, тогтоолын төсөл, түүнд холбогдох баримт бичгийг гишүүдэд тараах ажлыг зохион байгуулах, энэ тухай бүртгэл хөтлөх;
- 9) Хуралдааны танхимын цэвэрлэгээ, үйлчилгээ, гэрэлтүүлэг, дулаан, чийгшилт, агааржуулалт болон холбоо, санал хураалтын системийн техник хэрэгслийн ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих;
- 10) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны явцын товч тэмдэглэлийг хөтөлж, дэлгэрэнгүй тэмдэглэлийг соронзон хальснаас бичиж буулгах, хэвлэн гаргах;
- 11) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны аудио болон видео бичлэгийг CD, DVD-д буулгаж, шаардлагатай тоогоор хувилах ажлыг зохион байгуулах;
- 12) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг Улсын Их Хурлын веб хуудас болон дотоод сүлжээнд тухай бүр нь байрлуулж байх;
- 13) Улсын Их Хурлын нэгдсэн болон Хорооны хуралдааны товч болон дэлгэрэнгүй тэмдэглэлийг уншиж нийлэх, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, зохих хугацаанд архивт шилжүүлэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

* * *

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ДЭЛХИЙН БУСАД ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБА

1. Австрали, Далайн орнууд

АВСТРАЛИ

Австралийн Хамтын нөхөрлөл (*Commonwealth of Australia*)

Сенатын Департамент

Сенатын Департамент нь Сенат, түүний байнгын хороод, сенатын ерөнхийлөгч, сенатын гишүүдэд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөх болон туслах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Департаментын парламентын удирдлага нь Сенатын ерөнхийлөгч байх ба департаментыг Сенатын Клерк (Clerk) толгойлно. Австралийн парламентад Сенатын Департаментаас гадна Төлөөлөгчдийн танхимын Департамент, Парламентын үйлчилгээний Департамент байна. Сенатын департамент нь:

- Сенатын Клеркийн газар
- Баримт бичгийн газар (Table office)
- Процедурын газар
- Байнгын хороодын газар
- Блейк Родын газар (Black Rod's office). гэсэн 5 газартай.

Клеркийн газар

Клеркийн газар нь:

- Сенат болон түүний байнгын хороодын үйл ажиллагаатай холбоотой процедурын болон Үндсэн хуулийн зөвлөгөөгөөр сенатчдыг хангах
- Процедурын хороо болон Эрх ямбын байнгын хороо (Committee of Privileges)-г зөвлөх болон захиргааны дэмжлэгээр хангах
- Сенат болон түүний байнгын хороодын үйл ажиллагаатай холбоотой материалыг нийтийн хэрэгцээнд зориулж бэлтгэх, тараах
- Сенатын департментын ерөнхий удирдлагыг хэрэгжүүлэх
- Олон улсын парламентын холбоотой харилцах нарийн бичгийн даргын газрын зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Мөн Департментын бүх процедурын болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой хариуцлага, хяналтыг хэрэгжүүлнэ.

Баримт бичгийн газар

Энэ газар нь Сенатын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад шаардлагатай процедурын болон захиргааны дэмжлэгийг үзүүлнэ. Тухайлбал:

- Процедурын болон хөтөлбөрийн зөвлөгөө, баримт бичгээр хангах
- Сенатын үйл ажиллагааны албан ёсны тайлан гаргах
- Сенатын үйл ажиллагааны бичлэгийг үйлдэх
- Өдөр тутмын ажлын хуваарь (Order of Business) гаргах
- Сенатаар хэлэлцэх хууль тогтоомжийн бүрдлийг хянах, бусад хуультай нийцүүлэх, уялдуулах, хэлэлцүүлэгт бэлтгэх
- Сенатын үйл ажиллагаа, баримт бичигтэй холбоотой үйлчилгээг зохион байгуулах, хянах
- Сенатын баримт бичгийн хадгалалтыг хариуцах
- Сенатын үйл ажиллагааны талаарх статистик мэдээг бэлтгэх
- Хуулийн болон Төлөвлөлтийн байнгын хороодын ажлын албаны үүрэг гүйцэтгэнэ. Хуулийн төсөл нягтлах байнгын хороонд захиргааны асуудлаар тусламж үзүүлнэ.

Процедурын газар

Энэхүү газар нь сенатын гишүүд ба департментын ажилтнуудад үйлчилгээ үзүүлдэг. Газрын дарга нь Сенатын Клеркийн процедур хариуцсан ассистент байх бөгөөд процедурын асуудлаар аман болон бичгийн хэлбэрээр зөвлөгөө өгөхөөс гадна хууль тогтоомжийг хэлэлцэхэд процедурын тусламж үзүүлнэ. Мөн хууль тогтоомжийн төсөл хэлэлцэх байнгын хороод болох Хуулийн зохицуулалт, хууль тогтоомжийн болон Хуулийн төсөл нягтлах байнгын хорооны ажлын албаны үүрэг гүйцэтгэнэ.

Процедурын газрын Судалгааны хэсэг нь парламент, парламентын түүх болон Үндсэн хуулийн асуудлаар судалгаа хийх, сенатын талаарх мэдээллийг ном, товхимол болон электрон хэлбэрээр бэлтгэх, парламентын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар сенатын гишүүд, тэдний туслахууд болон парламент, гүйцэтгэх засаглалын албан хаагчдад зориулан семинар зохион байгуулах, процедурын мэдээллийн ресурсийн төвийг ажиллуулах, парламентын гишүүд ба парламентын албан тушаалтнуудын хамрагдах хөтөлбөр, парламентын асуудлаар нийтэд зориулсан лекц, үзэсгэлэн зэргийг зохион

байгуулна.

Мөн Процедурын газрын харьяанд Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын департментуудын хамтран байгуулсан Парламентын боловсролын газар байна. Энэхүү газар нь дунд сургуулийн сурагчдад зориулан парламентын чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулах сургалтуудыг зохион байгуулна.

Байнгын хороодын газар

Энэ газар нь парламентын байнгын хороод, тусгай хороод болон хоёр танхимын хамтарсан хороодод зориулан судалгаа хийх, захиргааны болон нарийн бичгийн даргын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Газрын дарга нь Сенатын Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент байх бөгөөд мөн Баримт бичгийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэж, байнгын хороод болон хороодын ажлын албадад процедурын холбоотой зөвлөгөө, удирдамж өгнө.

Байнгын хороодын газар нь хууль тогтоох найман хороо, Ерөнхий үүргийн байнгын хороо, хамтарсан дүрмийн гурван хороо болон Сенатаас байгуулсан тусгай хороодод үйлчилнэ. Хууль тогтоох болон Ерөнхий үүргийн байнгын хороодын ажлын алба нь байнгын хороодын газрын ажилтнуудаас бүрдэнэ. Ажлын алба нь Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент, байнгын хорооны нарийн бичгийн дарга болон судалгааны асуудал хариуцсан ажилтнуудаас бүрдэнэ. Судлаачдын тоог хариуцах ажлаас хамааран тогтооно.

Блейк Родын газар

Энэ газар нь сенатын гишүүд болон департаментад дараах үйлчилгээг үзүүлнэ. Тухайлбал, парламентын ордон дахь албан тасалгаанууд болон бусад хавсарсан өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, мэдээллийн систем, тээвэр, дэлгүүр, хоолны газар, электрон хэвлэл, хэвлэл, шуудангийн үйлчилгээ зэргийг хариуцна. Үүнээс гадна Сенат болон түүний албадын аюулгүй байдал, Сенатын хуралдаантай холбоотой ёслол, Сенатын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зэрэг ажлыг зохицуулах үүрэгтэй.

Блейк Родын газар нь дотроо алба, хэлтсүүдтэй ба Хүний нөөцийн хэлтэс нь сенатын гишүүд, Департментын ажилтнуудын цалин хөлс олгох, ажилтнуудын орон тоог бүрдүүлэх, департментын баримт бичгийг хөтлөх, департментын албан үйл ажиллагааг явуулахтай холбоотой тусламж, зөвлөгөө өгөх, ариун цэвэр, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, тэдний тэтгэмж, сургалт, хөгжлийн асуудал зэргийг хариуцна.

Санхүүгийн удирдлагын хэлтэс нь санхүүгийн бодлогын асуудлаар зөвлөгөө өгөх, департментын төсвийг бэлтгэх асуудлыг зохицуулах, жилийн санхүүгийн тайлан гаргах, худалдан авалт, нягтлан бодох бүртгэлийн асуудлыг хариуцах, Санхүүгийн удирдлага, тайлангийн хуулийг дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийн ашиглалтын тайлан гаргах, сенатын гишүүд, албан тушаалтнуудын шуудангийн зардлыг зохицуулах зэрэг үүрэгтэй.

Төлөөлөгчдийн танхимын департмент

Төлөөлөгчдийн танхимын Департмент нь Төлөөлөгчдийн танхим, байнгын хороод болон зарим хамтарсан хороодын үр дүнтэй үйл ажиллагаа явуулах болон танхимын гишүүд парламентад хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй. Департмент нь Танхимын үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулан дэмжүүлэх ажил зохион байгуулах, парламентын олон улсын болон бүс нутгийн харилцааг хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Танхимын Спикер парламентын өмнө Департментын үйл ажиллагааг хариуцна. Төлөөлөгчдийн танхимын

Клерк департментын үйл ажиллагааг удирдана.

Департментын үйл ажиллагааны үр дүн нь Төлөөлөгчдийн танхим өөрийн төлөөлөх болон хууль тогтоох үүргээ бүрэн гүйцэд биелүүлсэн байх явдал юм. Иймээс Департментын 5 албадыг Үр дүнгийн бүлэг (Output group) гэж нэрлэнэ. Эдгээр нь:

- Output group 1.1 – Танхим ба Ерөнхий байнгын хороо
- Output group 1.2 – Олон нийтийн ойлголт (Community Awareness)
- Output group 1.3 – Байнгын хороодын үйлчилгээ
- Output group 1.4 – Парламент хоорондын харилцаа
- Output group 1.5 – Гишүүдийн үйлчилгээ

Output group 1.1 – Танхим ба Ерөнхий байнгын хороо

Бүлгийг Клеркийн баримт бичиг хариуцсан ассистент толгойлно. Хариуцах асуудал нь:

- Танхим ба Ерөнхий байнгын хороо
- Танхим ба Ерөнхий байнгын хорооны ажлын графикийг хэлэлцэхэд зөвлөх болон бусад үйлчилгээгээр хангах
- Хууль тогтоомжийн төсөлд редакци хийх, Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай нийцүүлэх, хэлэлцүүлэгт бэлтгэх
- Парламентын хуралдааны бичлэг хийх
- Процедурын болон статистик мэдээллийг нэгтгэх, анализ хийх, хэвлэх

Бүлгээс бэлтгэн гаргасан материалыг Клеркийн офис, Баримт бичгийн болон Танхимын судалгааны газарт тус тус хүргүүлнэ. Департментын бусад ажлын бүлэг, хэлтсүүдэд шаардлагатай тохиолдолд хүргүүлнэ. Бүлгийн гол үүрэг нь:

- Спикер болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдэд зөвлөгөө өгөх
- Хөтөлбөр, процедурын асуудлаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх
- Хууль тогтоомжийн төслийг хянах, нийцүүлэх, уялдуулах, хэлэлцүүлэгт бэлтгэх
- Танхимын үйл ажиллагааны тайлан бэлтгэх
- Танхимд өргөн баригдсан баримт бичгийг боловсруулах, хадгалах, уг баримт бичгийг хэрэглэх, үзэх нөхцөлийг бий болгох
- Процедурын болон парламентын үйл ажиллагаанд шаардлагатай судалгаа, статистикийн үйлчилгээгээр хангах

Output group 1.2 – Олон нийтийн ойлголт (Community Awareness)

Бүлгийг Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент толгойлох ба Төлөөлөгчдийн танхим ба парламентын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд танилцуулна.

Бүлгийн үйл ажиллагааны үр дүнд олон нийт, нийгмийн бүлгүүд Төлөөлөгчдийн танхимын талаарх мэдлэгээ дээшлүүлж, Танхим, байнгын хороодын үйл ажиллагааг сонирхох, оролцох тэмүүлэлтэй болсон байх ёстой. Департментын Харилцаа, төслийн офис бусад газар, хэлтсүүдтэй хамтран мэдээллийн бүтээгдэхүүн бэлтгэх ба семинар, танилцуулга зохион байгуулснаар олон нийтэд Танхимын тухай мэдээлэл хүргэнэ.

Output group 1.3 – Байнгын хороодын үйлчилгээ

Бүлгийг Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент толгойлно. Байнгын хороод үйл

ажиллагаагаа явуулахад нь процедур, судалгаа, анализын болон захиргааны дэмжлэг үзүүлэх, эцсийн үр дүнг хэвлэн нийтлэх үүрэгтэй. Бүлгийн үйл ажиллагааг Байнгын хороодын газар гүйцэтгэнэ. Байнгын хороодын газар нь хороодоос хууль тогтоомж, бодлогын асуудал хэлэлцэх, Засгийн газрыг хянах үүргээ гүйцэтгэхэд нь туслана.

Output group 1.4 – Парламент хоорондын харилцаа

Бүлгийг Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент толгойлно. Парламентын олон улсын ба бүс нутгийн харилцааг хэрэгжүүлэхэд нь зөвлөх, туслах үүрэгтэй. Бүлгийн ажил үүрэг, үйлчилгээг тэргүүн ээлжинд Парламентын харилцааны газарт хүргэх ба энэ газрыг Төлөөлөгчдийн танхим ба Сенат хамтран санхүүжүүлэх бөгөөд Төлөөлөгчдийн танхимын Департментын харъяанд байна.

Output group 1.5 – Гишүүдийн үйлчилгээ

Бүлгийг Парламентын Гүйцэтгэгч (Serjeant-at-Arms, Парламентский пристав, Serviens –латин) толгойлно. Гол үүрэг нь Төлөөлөгчдийн танхимын гишүүдэд зөвлөх, туслах, үйлчлэхэд чиглэнэ. Гишүүдийг парламентын ордонд байршуулах, офисийн, холбоо харилцаа болон бичиг хэргийн хэрэгслээр хангах, цалин хөлс олгох зэрэг үүрэгтэй. Эдгээр үүргийг Парламентын Гүйцэтгэгчийн газар, Хүний нөөцийн газар, Мэдээллийн систем, хэвлэн нийтлэх газар, Санхүүгийн газрууд тус тус хариуцна.

Департмент нь дээр дурдсан үүргүүдийг хэрэгжүүлэхдээ Парламентын үйлчилгээний департменттай нягт хамтран ажиллана. Парламентын үйлчилгээний департмент нь парламентын барилга байгууламж, барилгын нэгдсэн мэдээлэл-технологийн үйлчилгээний асуудлыг хариуцдаг бол Төлөөлөгчдийн танхимын департмент нь парламентын гишүүдэд голлон үйлчилгээ үзүүлдэг.

Парламентын Гүйцэтгэгч (Serjeant-at-Arms)

Уламжлал, түүхийн үүднээс Парламентын гүйцэтгэгчийн гол үүрэг нь парламентын танхимын ёслол, аюулгүй байдал болон аж ахуйн асуудлыг хариуцдаг байсан бол одоо үед үүрэг нь илүү өргөн болж Төлөөлөгчдийн танхимын бүх хэрэгцээг хангах орчин үеийн ажлын аппарат болон хөгжсөн байна.

Парламентын гүйцэтгэгчийн гол үүрэг нь парламентын хуралдааны үед эмх журам сахиулах, Дэгийн хуулийг мөрдүүлэхэд спикерт туслах юм. Гүйцэтгэгч ба түүний ажилтнууд нь эмх замбараагүй байдал үүсгэсэн хүмүүсийг танхимаас гаргах, хуралдааны танхимд байх албаны хүмүүс болон хэвлэл мэдээллийнхнийг зохицуулах үүрэгтэй. Түүнчлэн Гүйцэтгэгч нь гишүүдийг бүртгэх, танхим дотор гишүүдэд суудал хуваарилах, Төлөөлөгчдийн танхимаас Сенатад албан мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Гишүүд, ажилтнуудад мэдээлэл, зөвлөгөө өгөх болон шаардлагатай бусад тусалцаа үзүүлнэ. Тухайлбал, гишүүд ба гишүүн байсан хүмүүсийн талаарх мэдээллийн санг бий болгох, хадгалах, тодорхой мэдээллийг хэвлэн нийтлэх, автомашины үйлчилгээг хариуцах, нарийн бичгийн даргын үйлчилгээ, хурдан бичлэгийн үйлчилгээ зэрэг болно.

Гүйцэтгэгч нь Спикерт радио, телевизийн нэвтрүүлгийн талаар барих бодлогоор зөвлөгөө өгөхөөс гадна, парламентын танхимд кино, фото зураг авахыг зохицуулж, парламент, гишүүдийн үйл ажиллагааны талаар радио, телевизийн сурвалжлага, нэвтрүүлэгт хяналт тавина.



2. Ази тивийн улсууд

ТУРК (Бүгд Найрамдах Турк Улс) (Republic of Turkey)

Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоох байгууллага буюу парламент нь Турк Улсын Үндэсний Их Хурал /The Turkish Grand National Assembly/ байна. Үндэсний Их Хурал нь даргын зөвлөлтэй байх ба Даргын зөвлөлийг парламент дахь улс төрийн намын бүлгүүдийн эзэлсэн суудлын тоотой хувь тэнцүүлэх хэлбэрээр байгуулдаг.

Ерөнхий нарийн бичгийн даргын газар (Administrative and service units)

Үндэсний Их Хурлын ажлын алба нь Ерөнхий нарийн бичгийн даргын газар байх ба түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдана. Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Үндэсний Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаа, парламентын гишүүдийн санхүү, захиргаа, нийгмийн үйлчилгээ, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь хууль тогтоох, захиргаа, техникийн асуудал хариуцсан гурван орлогчтой байна. Түүнчлэн цагдаа ба цэргийн албан хаагчид Үндэсний Их Хурлын аюулгүй байдлыг хангана. Үндэсний Их Хурлын даргын болон Ерөнхий нарийн бичгийн даргын газрын зөвлөхүүд нь хууль, эдийн засаг, гадаад харилцаа, соёл урлаг гэх мэт шаардлагатай асуудлуудаар судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, санал бэлтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь парламентын хууль боловсруулах үйл ажиллагаа болон хуулийн хэрэгжилтийн хяналт, шалгалтын явцад шаардагдах ажлыг гүйцэтгэх, хороодын үйл ажиллагааны тайлан, протокол хөтлөх, шаардлагатай мэдээ мэдээлэл,

баримт бичгийг гарган өгөх, номын сан, баримт бичиг, архив, хэвлэн нийтлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах болон эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, харилцаа холбоо, тээвэр, ордны барилга байгууламж, түүний засвар арчлалт, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт зэрэг ажил үйлчилгээг хариуцна. Тус газар нь 5000 гаруй ажилтантай.

Ерөнхий нарийн бичгийн даргын газрын чиг үүрэг:

- Үндэсний Их Хурал Үндсэн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай захиргааны туслалцааг Даргын зөвлөл, хороод, гишүүдэд үзүүлэх,
- Хуулийн төсөл бэлтгэх, боловсруулах, гишүүдээс гаргасан саналыг томъёолох, хороодын тайлан бэлтгэх зэрэг ажилд туслалцаа үзүүлэх,
- Баримт бичгийг бүртгэх, хувилах, мэдээлэх үйлчилгээг үзүүлэх,
- Аюулгүй байдлыг хангах, засвар үйлчилгээг хариуцах, хэрэгцээтэй тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах,
- Парламентын гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргын газрын ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний асуудлыг хариуцах,
- Төсөв, санхүүг хариуцах,
- Бичиг хэрэг, архивын асуудлыг хариуцах,
- Үндэсний Их Хурлын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудлыг хариуцан зохион байгуулах,
- Үндэсний Их Хурлын барилга, бүтээн байгуулалтын удирдлага, засвар үйлчилгээний асуудлыг хариуцах,
- Үндэсний Их Хурлын даргаас өгсөн бусад үүрэг даалгаврыг гүйцэтгэх зэрэг болно.

Ерөнхий нарийн бичгийн даргын газрын бүтэц, зохион байгуулалт

Ерөнхий нарийн бичгийн дарга

Ерөнхий нарийн бичгийн даргын удирдлагад харъяалах хэлтэс, албад:

- Хуулийн зөвлөхүүдийн алба /Office of the Legal Advisors/
- Захиргааны хэлтэс /Directorate of Administrative Branch/
- Гадаад харилцаа, протоколын газар /Directorate of External Affairs and Protocol/
- Санхүүгийн үйлчилгээний газар
- Худалдан авалтын зөвлөл /Head of Purchase Board/
- Иргэний хамгаалалт алба /Expertise of Civil Defense/
- Дотоод хяналтын алба
- Чанарын ерөнхий зохицуулах газар
- Зөвлөхүүд

Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч (Хууль тогтоох) (Deputy secretary general / legislative/)

Хууль тогтоомжийн газар (Head of Laws and Resolutions Department)

- Захиргааны хэлтэс /Directorate of Administrative Branch/
- Хууль тогтоомжийн хэлтэс /Directorate of Laws and Resolutions/
- Төсвийн хэлтэс /Directorate of Budget/

- Протоколын хэлтэс /Directorate of Minutes/
- Номын сан, баримт бичиг, орчуулгын хэлтэс /Directorate of Library- Documentation and Translation/
- Судалгааны төв
- Хэвлэх үйлдвэр /Directorate of Printing House/

Олон нийттэй харилцах газар (Head Of Public Relations Department)

- Баримт бичиг, архивын хэлтэс /Directorate of Documents and Archives/
- Хэвлэл мэдээлэл-олон нийттэй харилцах хэлтэс /Directorate of Press and Public Relations/
- Парламентын үйлчилгээний хэлтэс /Directorate of Services/
- Турк Улсын Үндэсний Их Хурлын Телевизийн хэлтэс /Department of TGNA Television/

Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч (Захиргааны) (Deputy secretary general / administrative/)

Хүний нөөц, нягтлан бодох бүртгэлийн газар (Head of Personnel and Accountancy Department)

- Захиргааны хэлтэс /Directorate of Administrative Branch/
- Хүний нөөцийн судалгааны хэлтэс /Directorate of Personnel and Staff Rights/
- Боловсон хүчний сургалтын хэлтэс /Directorate of Training of the Staff/
- Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс /Directorate of Accountancy/
- Төсөв, санхүүгийн хэлтэс

Туслах үйлчилгээний газар (Head of Auxiliary Services Department)

- Дотоод үйлчилгээний хэлтэс /Directorate of Internal Services/
- Нийгмийн үйлчилгээний хэлтэс /Directorate of Social Services/
- Их эмчийн алба /Office of the Doctor in Chief/
- Сувилагчийн газар /Department of Nursery/
- Тээврийн хэлтэс /Directorate of Transportation Branch/

Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч (Техник асуудлын) (deputy secretary general /technical/)

- Барилга, байгууламжийн нэгжийн удирдлага /Directorate of Management and Construction/

Техник асуудал хариуцсан газар (Head of Technical Department)

- Удирдлага, бүтээн байгуулалтын хэлтэс
- Парк, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс /Directorate of Parks and Gardens/
- Мэдээллийн хэлтэс

Үндэсний ордны газар (Head of National Palaces Department)

- **Турк Улсын Үндэсний Их Хурлын номын сан, баримт бичгийн төв**

Номын сан, баримт бичгийн төвийн зорилго нь парламентын гишүүдэд хууль тогтоох,

Судалгааны эмхтгэл, XII боть

төлөөлөх зэрэг Үндсэн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээ, материалаар хангах явдал юм. Энэхүү төв нь номын санч, баримт бичгийн ажилтан, судлаач зэрэг 60 гаруй ажилтантай.

Номын сангийн үйлчилгээ

Номын сангийн үйлчилгээний тасаг нь хэрэглэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хурдан шуурхай үйлчилнэ. Уншлагын үйлчилгээний тасаг нь гар дээр ном олгох, хувилахаас гадна номын сангийн мэргэжилтнүүд нь гишүүдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл бэлтгэх зэрэг үйлчилгээг тус тус үзүүлнэ.

Баримт бичгийн үйлчилгээ

Номын сан, баримт бичгийн төвд дараах үндэсний мэдээллийн баазуудыг ашиглах боломжтой. Үүнд:

- DOKBAN (Newspaper and Journal Data Bank)
- TUTBAN (Official Debates Data Bank)
- MILBAN (Biographical Data Bank of the Members of Parliament)
- KABBAN (Cabinets Data Bank)
- LIDBAN (Leaders Data Bank)
- PARBAN (Political Parties Data Bank)
- BIYBAN (Biographical Data Bank)

Судалгааны үйлчилгээ

Тус тасагт эдийн засаг, олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухаан, төрийн захиргаа зэрэг мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүд ажиллана. Судалгааны тасгийн ажилтнууд гишүүдээс ирүүлсэн захиалгын дагуу судалгаа хийж хариуг амаар болон бичгээр өгч болно. Судалгааны тасгаас хийсэн судалгааны ажил, тайлангаар улирал тутам “Bilgi” сэтгүүл, ном зэргийг хэвлэн гаргана.

ЭНЭТХЭГ - Бүгд Найрамдах Энэтхэг Улс (Republic of India)

Энэтхэгийн парламентын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт

Энэтхэг Улсын парламент нь доод танхим буюу Ардын танхим (House of People/ Лок сабха), дээд танхим буюу Муж улсуудын зөвлөл (Council of State/ Rajya Sabha) гэсэн хоёр танхимтай. Үндсэн хуулийн 98 дүгээр зүйлийн 1-д зааснаар парламентын танхим тус бүр орон тооны Тамгын газартай байна гэж заажээ. Уг зүйлд зааснаар парламентын танхим тус бүрийн тамгын газрын ерөнхий бүтэц, түүний нэр адил байх боловч дотоод бүтэц (харьяалагдах хороо, хэлтэс, ажлын алба, хэсэг, нэгж, жигүүр) болон гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны чиглэлээрээ ялгаатай байна.

Үндсэн хуулийн 98 дугаар зүйлийн 2 -т, “... парламентын танхим бүрийн тамгын газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үүрэг, хариуцлагын асуудал болон ажиллах нөхцөлийг парламент хуулиар зохицуулна” гэжээ.

Парламентын дээд, доод танхимын Тамгын газруудын чиг үүрэг:

- Парламентын дээд, доод танхим үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх
- Танхим тус бүрийн хороодод шаардлагатай үйлчилгээг үзүүлэх

- Дээд болон доод танхимын гишүүдийг цалин, хангамж, тэтгэмж зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн бусад нөхцөлөөр хангах
- Төрөл бүрийн хэвлэл болон бусад эх сурвалжаас лавлагаа, судалгаа бэлтгэж боловсруулалт хийх
- Парламентын дээд, доод танхимын Тамгын газрын шаардлагыг хангахуйц боловсон хүчнээр хангах
- Парламентын дээд, доод танхим болон тэдгээрийн харъяа хороодын чиг үүрэгт зайлшгүй хамааралтай баримт бичиг болон өдөр тутмын хуралдааны тэмдэглэлийн бичлэгийг боловсруулж хэвлэх

Парламентын танхим тус бүрийн тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах ба Үндсэн хууль болон Парламентын дээд, доод танхимын даргаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд ажиллана. Ерөнхий нарийн бичгийн даргын эрх мэдэл нь Энэтхэгийн Засгийн газрын тэргүүний эрх мэдэлтэй адил байна.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь бусад бүх нарийн бичгийн дарга, хороодын нарийн бичгийн дарга нар болон Тамгын газрын нийт ажилтнуудыг удирдлагаар хангана. Парламентын хоёр танхимын Тамгын газар нь нийт 1240 гаруй ажилтантай, бүтэц зохион байгуулалтын хувьд дотроо хороо, салбар, ажлын алба, хэсэг, нэгж, жигүүр гэсэн нэгжүүдтэй.

Парламентын Цалин хөлсний хорооноос санал болгосны дагуу 1974 оноос эхлэн Тамгын газрын үндсэн чиг үүрэгт өөрчлөлт оруулснаар дараах бүтэц, зохион байгуулалтаар ажиллах болжээ.

Салбар

- Захиргааны салбар - I, II
- Хороод хариуцсан салбар - I, II
- Хууль зүйн салбар – I, II
- Хуралдааны салбар – I, II, III
- Онцгой давуу эрх болон ёс зүйн салбар
- Асуулга, асуултын салбар
- Төлбөр, тооцооны салбар
- Компьютер, хангамжийн салбар
- Хуваарилалт, хүргэлтийн салбар
- Ерөнхий хангалт, нийлүүлэлтийн салбар
- Парламентын ордон, түүний эд хөрөнгийн хадгалалт, ашиглалтын салбар
- Нийтлэг үйлчилгээний салбар
- Гишүүний үйлчилгээний салбар
- Худалдан авалт, нийлүүлэлтийн салбар
- Нийгэм хангамжийн салбар

Ажлын албад

- Хуулийн төслийн алба
- Парламентын албан бичиг баримтын ажлын алба
- Төлбөр, тооцоо, бүртгэлийн ажлын алба
- Батлагдсан хууль тогтоомжийн редакцийн алба

ШИН МН
СУДАЛГААНЫ САН

- Парламентын хамгаалалтын алба

Хэсэг

- Өргөдөл, гомдлын хорооны хэсэг
- Засгийн газрын баталгааны хорооны хэсэг
- Нягтлан бодох бүртгэлийн хэсэг
- Аудитын хэсэг
- Англи хэлний редакцийн хэсэг
- Хинди хэлний редакцийн хэсэг
- Хэвлэх хэсэг -1, 2
- Орчуулгын хэсэг-1, 2
- Судалгаа, номын сангийн хэсэг
- Харъяа хорооны хууль зүйн хэсэг
- Сурвалжлагч, мэдээлэгчдийн хэсэг
- Товчлол, тэмдэглэлийн хэсэг
- Парламентын хуралдааны тэмдэглэлийн англи хувилбарын хэсэг

Нэгж

- Сахилгын асуудал болон шүүх, гэмт хэргийн нэгж
- Нэгдсэн санхүүгийн нэгж
- Сансрын телевизийн сувгийн нэгж
- Хэвлэл мэдээллийн нэгж

Парламентын хоёр танхимын Тамгын газрын хороо, салбар, ажлын алба, хэсэг, нэгжүүд нь дараах 10 төрлийн үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

Хууль, санхүү, захиргаа, зохион байгуулалтын үйлчилгээ (354 ажилтантай)

Энэ нь Төрийн зөвлөл болон түүний хороодод чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ба салбар чиглэлийнхээ дагуу үйлчилгээ үзүүлэх нэгжүүдтэй байна. Захиргааны, гишүүдийн цалин, ахуй хангамжийн, хурал болон протоколын, хууль зүйн, хороод хариуцсан хэлтсүүд, асуулт, асуулга хариуцсан салбар болон сонирхлын бүлгийн, мэдээ мэдээллийн, албан баримт бичгийн, батлагдсан ба өргөн баригдсан хуулийн жагсаалт гаргах албадын ажилтнууд тус үйлчилгээг гүйцэтгэнэ.

Хууль тогтоомжийн жигүүрийн ажлын ихэнх хэсэг нь асуулт, асуулгын салбар, хууль тогтоомжийн салбар, Парламентын баримт бичгийн алба зэргээр Танхимын үйл ажиллагаатай уялдаатай байдаг. Харин *Парламентын хорооны салбарын* ихэнх ажил нь Үнэлгээний хороо, Улсын төсвийн хороо, Улсын үйлдвэрийн газрын хороодын ажилтай уялдаатай байна. *Захиргаа, зохион байгуулалтын жигүүр нь* гишүүдийн цалин, нэмэгдэл хөлс, гишүүдийн үйлчилгээ, төлбөр тооцооны алба, төсөв, данс бүртгэлийн салбар, нийтлэг ажил үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг эрхэлнэ.

Хорооны салбарын ажилтнууд нь парламентын байнгын болон бусад хороодод зөвлөн туслах үүрэгтэй. Протоколын салбарын ажилтнууд нь Энэтхэгийн болон гадаад орны удирдлагуудын оролцсон айлчлал, хурал, цуглааныг зохион байгуулахтай холбоотой ажлыг гүйцэтгэнэ. Захиргаа, санхүү, зохион байгуулалт, хууль тогтоомжийн үйлчилгээ хариуцсан ажилтнууд нь парламентын захиргааны эрэлт хэрэгцээнд нийцүүлж аль ч салбар хооронд шилжин хариуцлагатай ажиллах үүрэгтэй.

Парламентын Номын сан, судалгаа, лавлагаа, мэдээлэл, баримтжуулах болон мэдээлэх үйлчилгээ (90 ажилтантай)

Бүх салбар чиглэлээр судалгаа, лавлагаа, мэдээлэл бэлтгэх, тэдгээрийг эмхтгэхээс гадна Тамгын газраас эрхлэн гаргадаг тогтмол хэвлэмэл материалыг бэлтгэн гаргах ажлыг хариуцна. Энэ үйлчилгээ нь парламентын гишүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, Энэтхэг болон гадаад орнуудын хөгжлийн талаарх өдөр тутмын мэдээлэл, номын сангийн эх сурвалжаас бэлтгэгдсэн сүүлийн үеийн, бодит мэдээ мэдээлэл, судалгаагаар хангахад чиглэнэ.

Парламентын гишүүдэд чуулганаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, Танхимын өмнө тулгамдсан асуудлаар гарын авлага болохуйц судалгаа, лавлагааны материал бэлдэх, мөн Энэтхэгийн Парламентын холбооны их, бага хурлын төлөөлөгчдөд зориулан судалгаа, зөвлөмж, мэдээлэл, тоо баримтыг бэлтгэнэ. Мөн парламентат ёсны талаар ном болон бусад хэвлэлийн материалд гарсан сонирхолтой товчлол, тэмдэглэл, гадаад улс орнуудын талаарх цаг үеийн мэдээллээр хангана. Энэ үйлчилгээ нь 5 хэлтэст хуваагдана. Үүнд: номын сан, судалгаа, лавлагаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, парламентын музей.

Протокол, тэмдэглэл хөтлөх үйлчилгээ (40 ажилтантай)

Парламентын дээд, доод танхим болон түүнд хамаарах парламентын хороодын хурал чуулганы бэлтгэл хангах, хурлын тэмдэглэлийг үгчлэн буулгаж, хэвлэн нийтлэх ажлыг хариуцна. Энэтхэгийн Парламентын бүлэг болон парламентын хоёр танхим хооронд зохион байгуулсан уулзалт, ярилцлагын болон парламентын дээд, доод танхим түүний хороодын хуралдааны тэмдэглэлийг үгчлэн буулгаж тайлагнах үүрэгтэй.

Зэрэгцсэн орчуулгын тайлбар хийх үйлчилгээ (25 ажилтантай)

Парламентын танхим, түүний байнгын хороод болон бусад хороодын хурлын ажиллагаа, гадаад орны парламентын төлөөлөгчдийн уулзалт ярилцлага, хурал зөвлөгөөний үйл ажиллагааг Хинди хэлнээс англи хэл рүү, англиас хинди хэл рүү зэрэгцсэн орчуулга хийнэ. Мөн англи, хинди хэл төдийгүй Танхимд гишүүдийн ярьж болох орон нутгийн бусад 11 хэлнээс зэрэгцсэн орчуулга хийх үйлчилгээ үзүүлнэ.

Редакцийн болон орчуулгын үйлчилгээ (95 ажилтантай)

Парламентын дээд Танхимын болон түүний Тамгын газрын үйл ажиллагаанд шаардлагатай орчуулга болон Танхимын өдөр тутмын хурлын англи, хинди хэл дээрх хуралдааны тэмдэглэл, тогтоол, шийдвэр, санал асуулга, албан ёсны мэдэгдэл, хэлэлцэх асуудлын дараалал, хороодын дүгнэлт, албан бичиг зэргийг хинди хэлнээс англи, англиас хинди хэл рүү орчуулж, хянан засварлана.

Энэ үйлчилгээний салбарын ажилтнууд нь Танхимын болон хорооны хуралдааны хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөх, бэлтгэх, редакторлох, орчуулах зэрэг тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Энэ нь дотроо Редакцийн салбар, Товчлол, тэмдэглэлийн салбар, Парламентын орчуулгын салбар, Байнгын хороодын орчуулгын салбар гэсэн нэгжүүдтэй.

Нарийн бичиг болон хурдан бичлэгийн үйлчилгээ (98 ажилтантай)

Протокол хөтлөгч нь парламентын дарга, гишүүд болон Хороодын дарга, Тамгын газрын удирдлагуудын албан ажилд зориулж хуралдааны бүрэн тэмдэглэл хөтлөнө. Энэ үйлчилгээний ажилчид нь бичлэгийн бүх төрлөөр буюу хуулах, галиглах, найруулан

бичих, машинаар бичихээс гадна гадаад орны зочид, төлөөлөгчдийн аман болон телефон ярианы тэмдэглэлийг хөтөлнө. Эдгээр албан хаагчид нь мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

Хэвлэх үйлчилгээ (47 ажилтантай)

Парламентын албан бичгийн хэвлэмэл хуудсууд, тухайлбал, гишүүний нэртэй албан хуудас, албан хэвлэлийн хуудас - I, II, хорооны тогтоолын албан хуудас, чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх индекстэй хуудас, түүний хавсралт, Тамгын газрын бусад хэвлэмэл албан баримтыг хэвлэх үйлчилгээг хариуцна. Түүнчлэн Тамгын газраас эрхлэн гаргадаг ном, бусад хэвлэмэл материалыг нэг бүрчлэн унших, хэвлэх, үдэх хавтаслах зэрэг бүх техник үйл ажиллагааг хариуцна.

Харуул хамгаалалт, ариун цэврийн үйлчилгээ (207 ажилтантай)

Энэ үйлчилгээ нь хоёр танхимын хамтарсан хорооны нарийн бичгийн даргын нэгдсэн удирдлага, хяналтын дор парламентын ордны бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудлыг хариуцна. Цэвэрлэгээ, ариун цэврийн үйлчилгээний ажилчид нь ордны өрөө тасалгааны цэвэрлэгээ, агааржуулалт зэрэг ая тухтай байдлыг хангах үүрэгтэй.

Жолооч болон хүргэлтийн үйлчилгээ (43 ажилтантай)

Жолооч нар болон хүргэлтийн үйлчилгээний ажилчдаас бүрдэнэ. Жолооч нар нь Парламентын гишүүд болон Тамгын газрын удирдлагуудад машинаар үйлчилнэ. Хүргэлтийн үйлчилгээ буюу шууданч нь ихэвчлэн парламентын албан бичгүүдийг гишүүд болон Засгийн газрын байгууллагуудад түргэн шуурхай, саадгүй хүргэх ажлыг хариуцна.

Бие төлөөлөгч, туслах болон зарлагын үйлчилгээ (238 ажилтантай)

Удирдлагууд нь бараа бологч болон туслах, зарлагын үйлчилгээ авна.

3. Америк тивийн улс орнууд

АМЕРИК (Америкийн Нэгдсэн Улс)

(United States of America)

Америкийн Нэгдсэн Улсын хууль тогтоох байгууллага нь Конгресс байна. Дээд танхим буюу Сенатын танхим 100-н гишүүнтэй, доод танхим буюу Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн тоо муж улсуудын хүн амын тооноос хамаарах ба одоогоор 435 гишүүнтэй. Конгрессийн ажлын албанаас гадна Сенат болон Төлөөлөгчдийн танхим нь тус тусдаа ажлын албадтай байна.

УН.МН
СУДАЛГААНЫ САН

1. Конгрессийн ажлын алба

Зураг

**Капитолын архитекторын газар**

1793 онд Жорж Вашингтон анх Капитолын суурийг тавьснаас хойш АНУ-ын Капитолын Архитектор нь Капитолын ордны үйлчилгээ, бүтээн байгуулалтыг хариуцаар ирсэн. Архитекторын удирдлага дор 2600 албан хаагчид Капитолын орчинд байрлах түүхийн дурсгалт зүйлс ба орчин үеийн үйлчилгээний барилга, байшингуудыг хариуцан хамгаалж байна. Капитолын архитекторын алба нь АНУ-ын Конгрессийн өмнө 1.530.000м² барилга байшин, 1,8км² газар нутгийн үйлчилгээ, үйл ажиллагаа, хөгжүүлэлт, хадгалалтыг хариуцан ажилладаг. Мөн тэмдэглэлт баяр, ёслолын үйл ажиллагааг хариуцна.

Капитолын Архитектор нь Капитолын цагдаагийн газар, Капитолын жуулчдад үйлчлэх албыг удирдлагаар хангана. 1989 он хүртэл АНУ-ын Ерөнхийлөгч дүрмийн дагуу Архитекторыг томилдог байсан. 1990 оноос хойш томилох үйл ажиллагааг албан ёсоор хуульчилснаар АНУ-ын Ерөнхийлөгч уг албан тушаалтныг Конгрессийн хорооноос санал болгосон гурван хүнээс сонгож, Сенаттай зөвшилцөн 10 жилийн хугацаагаар томилно. Архитектор нь өөрийн хүсэлтээр дахин сонгогдох эрхтэй.

Капитолын цагдаагийн газар

АНУ-ын Капитолын цагдаагийн газар нь Капитолын нутаг дэвсгэрт онцгой эрхтэй байх ба АНУ-ын нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэхдээ холбооны цагдаагийн албаны адил эрхтэй байна. 2010 оны байдлаар уг агентлаг нь 1800 ажилтантай. Конгрессийн гишүүн, тэдгээрийн гэр бүл, конгрессийн албан хаагчдыг АНУ-ын газар нутагт хамгаалах үүрэг гүйцэтгэнэ.

Ерөнхий мөрдөн байцаагчийн алба

Тус алба нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу 2005 онд АНУ-ын Конгрессийн шийдвэрээр байгуулагдсан. Ерөнхий мөрдөн байцаагчийн алба нь АНУ-ын Капитолын цагдаагийн газрын чиг үүргийн дагуу Конгрессийн ажлын албад болон гишүүд, албан хаагчдын талаар ирүүлсэн аливаа санал, гомдол зэрэг асуудлаар мөрдөн байцаах, шалган

тогтоох ажиллагаа явуулах үүрэгтэй. Ерөнхий мөрдөн байцаагч нь АНУ-ын Капитолын Цагдаагийн газрын Удирдах зөвлөлд ажлаа шууд тайлагнана.

Аудитын алба

Ерөнхий мөрдөн байцаагчийн албаны үйл ажиллагааны үед илэрсэн эдийн засгийн, үнэлгээний, бие хүний талаарх асуудалд аудит хийнэ.

АНУ-ын Капитолын цагдаагийн газрын удирдлага, тус газрын үнэлгээ, аудитын үйл ажиллагааг Ерөнхий мөрдөн байцаах газар удирдан зохион байгуулж, хамтран гүйцэтгэнэ.

Хяналтын алба

Тус алба нь дотоод болон гадны эх үүсвэрийг үндэслэн АНУ-ын Капитолын цагдаагийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, ажилчдын ёсзүйг сахиулах, АНУ-ын Капитолын цагдаагийн албаны албан хаагчдын холбогдсон хэргийг хянан шалгах үүрэг хүлээнэ. АНУ-ын Капитолын Цагдаагийн албаны албан хаагч нь өндөр ёс суртахуунтай, мэргэжлийн хувьд өндөр мэргэшсэн байх нь энэ албаны тэргүүн зорилго болно.

Капитолын жуулчдад үйлчлэх алба

АНУ байгуулагдсны 100 жилийн ойн баярт зориулж 1876 онд анх энэхүү үйлчилгээг үндэслэн байгуулсан. Энэхүү үйлчилгээ нь Капитолын жуулчны үйлчилгээний зөвлөлийн шууд удирдлага дор ажилладаг. Тус үйлчилгээ нь АНУ-ын Капитолын Зочдын төвд байрладаг. Энэхүү үйлчилгээ нь ямарваа нэгэн төлбөрийг үйлчлүүлэгчдээс авдаггүй бөгөөд Конгрессоос санхүүжүүлдэг. Капитолын Зочдын төв нь үзэсгэлэн, бэлэг дурсгалын дэлгүүр, театр зэргийг агуулсан иж бүрэн цогцолбор байгууламж юм.

Конгрессийн санхүү бүртгэлийн газар

Конгрессийн нягтлан бодох бүртгэлийн газар (GAO) нь АНУ-ын Конгрессийн шууд удирдлага дор ажилладаг аудит, үнэлгээ ба судалгааны агентлаг юм. Тус байгууллага нь 1921 онд байгуулагдсан. Энэхүү газар нь АНУ-ын Засгийн газрын цахим мэдээ бэлтгэх ба эдгээр мэдээнд үндэсний аюулгүй байдал, улсын нууцаас бусад санхүүгийн мэдээлэл хамаарна. Тухайлбал, Холбооны төсөв, санхүүгийн удирдлага, боловсрол, батлан хамгаалах, худалдаа, олон улсын харилцаа, хүний нөөцтэй холбоотой бусад мэдээлэл байна. Мэдээ, тайлангийн ихэнх хувийг Конгрессийн гишүүдийн хүсэлтийн дагуу бэлтгэдэг. Жилд ойролцоогоор 900 тайлан мэдээг бэлтгэдэг. Санхүү бүртгэлийн газрын бүтэц:

- Ерөнхий аудитор
- Комптроллер /Comptroller/
- Ерөнхий байцаагч
- Аудит
- Аудитын захирал
- Эрдэнэсийн сангийн нярав
- Корпорацийн асуудал хариуцсан ажилтан

Конгрессийн сургалтын алба

Конгрессийн сургалтын алба нь 1995 оны Конгрессийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан холбооны агентлаг юм. Тус алба нь бие даасан, улс төрийн хараат бус агентлаг бөгөөд Конгрессийн гишүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд зориулсан эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулдаг. Уг сургалтаар ёс зүйн харилцаа, эрүүл мэнд,

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

аюулгүй байдал, дипломат ёс гэх мэт улс төр, олон улсын түвшинд Конгрессийн гишүүдэд тавигдах шаардлагын талаарх мэдээллийг өгнө. Мөн Конгрессийн гишүүд, албан хаагчдад тэдгээрийн эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилготой.

Уг албаны зөвлөлийн даргаар Конгрессийн олонх ба цөөнхийн бүлгийн хамтран нэр дэвшүүлсэн хүнийг томилох бөгөөд бүлэг тус бүрээс тэнцүү төлөөлөлтэй байхаар 4 хүнийг гүйцэтгэх албанд томилно.

Тус алба нь сургалтад оролцогчдын харилцаа холбоо, хувийн нууцыг чанд хадгалан ажиллана.

Конгрессийн төсвийн газар

Конгрессийн төсвийн газар (СВО) нь холбооны агентлаг бөгөөд Конгрессийг эдийн засгийн мэдээллээр хангах үүрэг хүлээнэ. 1974 оны Конгрессийн төсөв ба зарцуулалтыг хянах актын дагуу байгуулагдсан. Тус газар нь холбооны төсөвтэй холбоотой шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, шинжилгээ, суурь мэдээллээр хангах үүрэгтэй. Агентлаг нь Төсвийн хуулийн 202-ийн Е хэсэгт заасны дагуу жил бүрийн эдийн засаг, төсвийн тайлан, мэдээг гаргаж Төлөөлөгчдийн танхим болон Сенатад хүргэнэ.

Мөн Конгрессийн гишүүдийн захиалгаар төсөвтэй холбоотой тайлан, мэдээг боловсруулна. Тухайлбал, Конгрессийн төсвийн агентлаг нь 2010 онд 33 судалгаа, тайлан, 12 товчоо, сар тутмын төсвийн дүгнэлт, 35 захидал, 14 илтгэл, 2 суурь баримт бичиг боловсруулжээ. Эдгээр нь Конгрессийн танхимуудын хурлаар хэлэлцэгдсэн байна. Мөн 2010 оны холбооны зардал тооцох 650, хуулийн хэрэгжилтийн 475 үнэлгээ зэргийг тус тус хийж Конгресст танилцуулжээ.

Конгрессийн төсвийн хоёр хорооны саналыг үндэслэн Төлөөлөгчдийн танхимын дарга/ Спикер/ болон Сенатын дэд ерөнхийлөгч нар зөвшилцөн уг газрын даргыг томилно. Газрын даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

Конгрессийн төсвийн газар нь 8 хэлтэст хуваагдана. Үүнд:

- Төсвийн анализийн хэлтэс
- Эдийн засгийн анализийн хэлтэс
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэлтэс
- Макро эдийн засгийн хэлтэс
- Менежмент, бизнес, мэдээллийн үйлчилгээний хэлтэс
- Микро эдийн засгийн судалгааны хэлтэс
- Үндэсний аюулгүй байдлын хэлтэс
- Татварын анализийн хэлтэс

Засгийн газрын хэвлэлийн газар

Тус газар нь Конгрессийн хоёр танхимын хамтарсан шийдвэрээр 1860 онд байгуулагдсан. АНУ-ын Засгийн газрын хэвлэлийн газар нь Холбооны засгийн газрын гишүүдийн болон дээд шүүх, Ерөнхийлөгчийн тамгын газар, Конгрессийн хэвлэлийн асуудлыг хариуцдаг. Хуулийн дагуу Төрийн хэвлэн нийтлэгч энэхүү байгууллагыг удирддаг. Одоогийн байдлаар тус байгууллага доорх баримт бичгүүдийг албан ёсоор хэвлэдэг байна. Үүнд:

- Холбооны зохицуулалтын код
- Нийтийн болон хувийн асуудлын талаарх хууль
- Конгрессийн тайлан

Судалгааны эмхтгэл, XII боть

- АНУ-ын код
- Төлөөлөгчдийн танхимын хэвлэл
- Сенатын хэвлэл

Мөн тус газар нь 1920 оноос хойш АНУ-ын паспортыг хэвлэж байна.

Конгрессийн номын сан

1800 онд ерөнхийлөгч Жон Адамс АНУ-ын Засгийн газрыг Филадельфи хотоос одоогийн нийслэл болох Вашингтон хот руу шилжүүлэх тухай хуульд гарын үсэг зурснаар Конгрессын номын сан байгуулагдсан гэж үздэг. Тухайн үеийн номын сангийн фондыг бий болгох үүднээс Конгресс 5000 ам.долларын төсвийг баталж 740 боть ном, 3 ширхэг газрын зургийг худалдан авчээ.

Их Британийн цэргүүд дайрч номын санг галдан шатаах хүртэл буюу 1814 оны 8 дугаар сар хүртэл Капитолд байрлаж байсан байна. Тухайн үед ерөнхийлөгчийн суудлаас буугаад байсан Томас Жефферсон өөрийн 50 жил цуглуулсан номын фондоо Конгрессийн номын санд хандивласан байна. Түүний цуглуулгад Америкийн Нэгдсэн Улсын түүхтэй холбогдсон ном бүтээлүүд, гадаад хэл, шинжлэх ухааны ховор номууд байсан. 1815 оны нэгдүгээр сард Конгресс Жефферсоны цуглуулгыг хүлээн авсан бөгөөд түүний хандивласан номын фонд нь 23950 ам.долларын үнэ бүхий 6487 ширхэг ном байжээ.

АНУ-ын нутаг дэвсгэр дээр хэвлэгдсэн аливаа ном хэвлэлийн нэг хувийг Конгрессийн номын санд өгч байх, ном бүтээлийг хүлээн авах, улсын төсвөөс санхүүжүүлэх, урамшуулах үйл ажиллагааг хуульчилж өгсөний үр дүнд 1850-иад онд Конгрессийн номын сангийн сан хөмрөг 55000 гаруй номтой болжээ.

Конгрессийн номын сан нь АНУ-ын хууль тогтоох дээд байгууллага болох Конгресст үйлчлэхээс гадна Засгийн газрын агентлаг, бусад номын сангууд, эрдэмтэд, судлаачдаас гадна олон нийтэд үйлчилдэг. Одоогоор Конгрессийн номын сан нь дэлхий дээрх хамгийн том номын сангуудын нэг бөгөөд 130 сая гаруй хэвлэмэл бүтээгдэхүүн байгаагаас 460 хэл дээр 29 сая ном болон товхимол, 58 сая гар бичмэл байна. Мөн ховор номын цуглуулгаараа Хойд Америкт томоохонд орох ба хуульзүйн чиглэлийн материал, кино, газрын зураг, хөгжмийн болон дууны цуглуулгаараа дэлхийд хамгийн томд тооцогддог. Конгрессийн номын сан нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна.

Номын сангийн удирдах газар

Номын сангийн удирдах газар нь номын сангийн бодлогыг тодорхойлох, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг зохион байгуулах үүрэгтэй.

Захиргаа, санхүүгийн алба

Номын сангийн харъяа газруудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдгээр газруудын үйл ажиллагааг дэмжих зорилготой. Захиргааны газарт хүний нөөц, санхүү, аюулгүй байдлын албад харьяалагдана.

Конгрессийн судалгааны алба

Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, мэдээллээр хангана.

Зохиогчийн эрхийн алба

Үндэсний зохиогчийн эрхийн системийн дагуу зохиогчийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулна.

Хуулийн номын сан

Конгресс 1832 онд хуулийн номын санг байгуулсан бөгөөд одоогоор 3 сая гаруй хууль, эрх зүйн акт, баримт бичгүүдийг агуулсан дэлхийн хамгийн том хуулийн номын сан юм.

Номын сангийн алба

Энэ алба нь Америкийн ард түмний бүтээсэн түүхэн ном сурвалж болон дэлхийн түүхэн баримт бичгүүдээс бүрдсэн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, зохион байгуулах, кодчилох зэргийг асуудлыг хариуцна.

Стратеги төлөвлөлтийн газар

Энэ газар нь стратеги төлөвлөгөөний дагуу номын сангийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, үндэсний хэмжээнд удаан хугацааны дижитал хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

Конгрессийн судалгааны алба

Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 1914 онд Конгрессийн номын сангийн бүтцэд Хууль зүйн лавлагааны албыг байгуулжээ. 1970 оны Бүтэц, зохион байгуулалтын тухай хуулиар Хууль зүйн лавлагааны албаны нэрийг өөрчилж Конгрессийн судалгааны алба болгосон байна. Конгрессийн судалгааны алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах дэлхийн хамгийн том судалгааны төв юм. Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод мэдээлэл, судалгааны үйлчилгээ үзүүлнэ. Шинжээчид нь хуулийн төслийг Байнгын хороодоор хэлэлцүүлэхээс хууль батлагдах хүртэлх бүх шатанд мэдээлэл, судалгааг бэлтгэхдээ цаг үеийн, бодитой, нам бус, төвийг сахисан, нууцыг хадгалах зарчмаар ажиллана.

Гүйцэтгэх засаглал ба хууль тогтоох байгууллагын судалгааны чадавхийг тэнцвэржүүлэх зорилгоор тус албыг 1970-аад онд өргөтгөн бэхжүүлсэн. Эрх зүйн зохицуулалтын хувьд тус албаны үйл ажиллагааг АНУ-ын Конгрессийн хууль тогтоох үйл явцтай нягт уялдуулж өгсөн ба Конгресст бодлогын альтернатив хувилбарууд ба тэдгээрээс гарах үр дагаварыг тооцсон санал боловсруулан толилуулах үүрэгтэй.

Конгрессийн судалгааны алба нь гүйцэтгэх засаглалын байгууллага болон олон нийтийн судалгааны хэрэгцээг хангах үүрэг хүлээдэггүй. Конгрессийн судалгааны алба нь нийт 700 гаруй ажилтантайгаас 450 гаруй нь бодлогын шинжээч, хуульч, мэдээллийн мэргэжилтэн, эдийн засагч, гадаад хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, цагаачлал, эрчим хүч, байгаль орчин болон шинжлэх ухаан, технологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, шинжээчид байна.

Судалгааны албанаас тайлан, мэдээлэл, семинар, илтгэл, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд үзүүлдэг.

Конгрессийн судалгааны албанаас үзүүлэх үйлчилгээ болон бүтээгдэхүүнүүд:

- Тойм мэдээлэл, зөвлөгөө
- Тухайн үед хэлэлцэж буй хуулийн асуудлаарх тайлан, мэдээг цахим хуудсаар 7 хоногийн 24 цагийн турш мэдээлэх

Судалгааны эмхтгэл, XII боть

- Хууль зүйн мэдээллийн систем (LIS)
- Семинар, уулзалт зохион байгуулах, Холбооны хуулийн шинэчлэлийн талаар жилд 2 удаа хэлэлцүүлэг хийх
- Конгрессийн ажилтнуудад хууль тогтоох болон төсөв хэлэлцэх журмын талаар сургалт зохион байгуулах
- Хуульд дүн шинжилгээ, анализ, тайлбар хийх

Судалгааны албаны бүтэц:



Америкийн хуулийн салбар

Энэ салбар нь хуулийн чиглэлийн бүхий л асуултуудад хариулт өгдөг. Ингэхдээ тухайн асуудал Үндсэн хуулийн зарчим, холбогдох хууль, холбооны улсын зарчим, худалдаа, иргэний эрхтэй нийцсэн эсэх талаас авч үзнэ. Түүнчлэн бизнес, гэмт хэрэг, байгаль орчин, иргэний эрх, олон улсын эрх зүйн зэрэг салбарын хууль, асуудалд дүн шинжилгээ хийнэ. Энэ салбар нь дотроо таван хэсэгтэй ба хэсэг тус бүр удирдагчтай байна. Үүнд:

- Захиргааны хууль
- Бизнес
- Конгресс
- Шүүх ба олон улс
- Үндэсний баялаг

Нийгмийн бодлого

Энэ салбар нь дотоодын нийгмийн бодлогын хөтөлбөрийн асуудлуудад дүн шинжилгээ хийдэг. Энэ салбарын хамрах асуудлын хүрээнд боловсрол, ажиллах хүч, түүний аюулгүй байдал, эрүүл мэндийн даатгал ба санхүүжилт, эрүүл мэндийн үйлчилгээ, насжилт, нийгмийн даатгал, тэтгэвэр, иргэдийн шилжилт хөдөлгөөн, эрүүгийн шүүх, нийгмийн хангамж, хүнс ба орон сууцжуулах хөтөлбөрүүд багтана.

Энэ салбар нь дотроо зургаан хэсэгтэй ба хэсэг тус бүр судалгааны удирдагчтай байна.

- *Хүүхэд ба гэр бүл* – жирэмслэлт, хүүхэд ба үрчлэлт, бага орлоготой иргэд, орон гэргүйчүүд болон орон гэрээсээ дайжсан өсвөр насныхан, орон сууцны хөтөлбөр,
- *Аюулгүй байдал ба шилжилт хөдөлгөөн* – Эрүүгийн гэмт хэрэг, мансууруулах бодисын хэрэглээ, архи тамхи, галт зэвсгийн хяналт, хилийн аюулгүй байдал, шилжилт хөдөлгөөн,
- *Боловсрол ба ажиллах хүч* – анхан болон дунд боловсрол, мэргэжлийн сургалт, ажиллах хүчний асуудлууд,
- *Эрүүл мэндийн үйлчилгээ ба санхүүжилт* – эмнэлгийн үнэгүй тусламж, ядуу иргэдэд зориулсан үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ ба хүүхдийн эрүүл мэндийн даатгалын асуудлууд,
- *Эрүүл мэндийн үйлчилгээ ба судалгаа* – эрүүл мэндийн судалгаа, эрүүл

мэндийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд, ахмад дайчдын эрүүл мэндийн халамж,

- *Нийгмийн даатгал* – нийгмийн даатгал, ажилгүйдлийн нөхөн төлбөр, тэтгэвэр, тэтгэмж

зэрэг асуудал тус тус хамаарна.

Гадаад хэрэг, батлан хамгаалах, худалдаа

Энэ салбарт дэлхийн улс төр, эдийн засгийн хөгжлийн асуудал, АНУ ба бусад улс хоорондын улс төр, эдийн засгийн харилцаа, улс хоорондын асуудал болох терроризм, цагаачлалын асуудлаар шинжээчид ажилладаг. Үндэсний аюулгүй байдлын судалгаанд зэвсэгт хүчний стратеги, АНУ-ын батлан хамгаалахын төсөв, зэвсгийн систем, зэвсэгт хүчний баазын нөхөн төлбөр зэрэг асуудлууд хамаарна. Худалдааны шинжээчид нь эдийн засгийн асуудлуудад дүгнэлт өгөх ба худалдааны тариф, экспорт, импортын асуудлуудыг авч үзнэ. Тус салбар дотроо долоон хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

- Ази
- Батлан хамгаалах ба зэвсгийн хяналт
- Батлан хамгаалахын төсөв, удирдлага, зохион байгуулалт
- Европ ба Америк тив
- Гадаад бодлогын менежмент, олон улсын асуудал
- Олон улсын худалдаа ба санхүү
- Ойрхи дорнод ба Африк

Засгийн газар ба санхүү

Тус салбар нь зургаан хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

- Банк, даатгал, үнэт цаас ба макро эдийн засгийн бодлого
- Конгресс ба шүүх засаглал
- Гүйцэтгэх засаглалын салбарын үйл ажиллагаа – Ерөнхийлөгчийн алба ба эрх мэдэл, ерөнхийлөгчид нэр дэвшигчид, холбооны ажиллах хүч, Нэгдсэн улсын шуудан, дүрэм журмын удирдлага, спорт гэсэн асуудлуудыг хамаарна.
- Холбооны улсын зарчим, сонгууль ба онцгой байдлын удирдлага
- Засгийн газрын санхүү ба татвар
- Хууль тогтоох ба төсвийн батлагдах үе шат

Санхүүгийн асуудлын хүрээнд банк, санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, татвар, төрийн санхүү, төсвийн болон мөнгөний бодлого, улсын зээл, эдийн засгийн зээлийн үзүүлэлтүүдийг судалдаг.

Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нөөц

Тус салбар нь байгалийн нөөц, шинжлэх ухааны дэвшил, технологийн хөгжил, бизнесийн гол салбаруудын зохицуулалтуудыг судална. Нөөцийн асуудлын хүрээнд байгалийн баялаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, хүнс ба загас агнуур, эрчим хүч ба ашигт малтмал зэрэг хамаарна. Шинжлэх ухааны салбарын асуудалд иргэний болон зэвсэгт хүчний судалгаа хөгжлийн асуудлууд, мэдээлэл технологи, сансар судлал, бусад шинжлэх ухааны салбарууд хамаарна. Үйлдвэрлэлийн асуудалд тээврийн хяналт, тээврийн дэд бүтцийн асуудал, үйлдвэрлэлийн зах зээл ба зохицуулалтын талаар шинжилгээ, судалгааны ажлууд багтана.

- Хөдөө аж ахуй ба хүнсний хангамж

- Эрчим хүч ба ашигт малтмал
- Байгаль орчны бодлого
- Байгалийн нөөц судлал
- Шинжлэх ухаан ба технологийн бодлого
- Тээвэр ба үйлдвэрлэлийн шинжилгээ

Мэдлэгийн мэдээллийн хэсэг

Энэ нь дээрх судалгааны салбаруудын бодлогын судлаачдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, туслах хэлбэрээр хамтран ажиллана.

2. Сенатын ажлын алба

Ерөнхий нарийн бичгийн дарга

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Сенатын ажлын албыг удирдана. Сенатаас батлагдан гарч буй хууль тогтоомжуудыг хянаж, гарын үсэг зурна. Хуульд заагдсан тодорхой нөхцөлүүдэд Ерөнхий нарийн бичгийн дарга Сенатын хуралдааныг удирдаж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь 1789 оноос Сенатын танхимд уншлага хийх, удирдлага зохион байгуулалтын ажлыг зохицуулах зэрэг үүрэг бүхий туслах нарийн бичгийн даргатай болсон.

Бичиг хэрэг, хангамжийн хэлтэс

Сенатын албан хэрэгцээнд шаардлагатай байгаа бичиг хэргийн материал, хангамжийг хариуцах ашгийн бус байгууллага юм.

Төрийн албан хэргийн бүртгэлийн алба

Холбооны засгийн газар болон сенатаас гаргасан дүрэм, журмуудыг хэрэгжүүлэх чиглэлээр гарч буй баримт бичгүүдийг боловсруулах үүргийг хүлээнэ.

Боловсон хүчний хөгжлийн хэлтэс

Хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, ажил эрхлэлтийн асуудлыг засгийн газрын өмнөөс төлөөлж оролцоно. Хэлтэс нь ажил эрхлэлт, ажилтан, ажил олгогчийн харилцааг зохицуулсан “Конгрессийн нягтлан бодох бүртгэлийн тухай акт” болон холбогдох бусад хуулийг баримталж ажиллана.

Сенатын номын сан

Хууль, эрх зүйн үндсэн номын сангийн үйлчилгээг уламжлалт ба цахим хэлбэрээр үзүүлнэ. Сенатын үйл ажиллагаанд шаардлагатай хууль эрх зүйн мэдээллийг холбогдох байгууллага болон бусад эх сурвалжаас авч үйлчилнэ.

Санхүүгийн алба

Сенатад төсөвлөгдсөн хөрөнгийг захиран зарцуулна. Сенатын төсвийн тооцоог нэгтгэн, Төсвийн зарлагын хороонд тайлагнана.

Баримт бичиг, хэвлэх үйлчилгээний алба

Сенатын албан ёсны баримт бичиг, хэвлэмэл бусад зүйлсийг хэвлэх болон хүргэлтийн

үйлчилгээг үзүүлнэ.

Сенатын аюулгүй байдлын алба

Тус алба нь тагнуул, цэрэг, цагдаагийн байгууллагуудтай хамтран Сенатын офисууд болон хороод, гишүүд, албан хаагчдад байгаа үндэсний аюулгүй байдалтай холбоотой нууцын зэрэгтэй мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Мөн харилцаа холбоо, компьютерийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Сенатын пэйж сургууль

Сенатад ажиллаж буй бүх “пэйж” сурагчдад зориулсан тусгай хуваарьт хөтөлбөр юм.

Сенатын бэлгийн дэлгүүр

Сенатын бэлэг дурсгалын эд зүйлсийг ажилтан, албан хаагчид болон олон нийтэд зориулан худалдаална.

Сенатын гадаад харилцааны алба

Сенатын гадаад харилцаа, парламент хоорондын харилцааг хариуцна.

Архив

Сенатын үйл ажиллагааны баримт бичгийг хадгалан хамгаалах талаар хөтөлбөр хэрэгжүүлж, зохион байгуулна. Архив нь цаасан хэлбэрээр байгаа ном, баримт бичгийн хадгалах хугацааг уртасгах, нөхөн сэргээх, гамшгийн үед хамгаалах зэрэг үүрэгтэй.


Сенатын куратор

Сенатын урлаг, соёлын хорооны шууд удирдлага дор Капитол ба Сенатын харъяа барилгууд, музейн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Куратор түүний ажилтнууд нь үзэсгэлэнгийн загвар гаргах асуудлыг хариуцна. Мөн Сенатын цуглуулгад байх түүхийн дурсгалт уран зураг, баримал, тавилга зэрэг эд өлгийн зүйлсийг судлан тодорхойлж, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулж, бүртгэл хөтөлнө.

Сенатын түүхийн алба

Түүхэн чухал үйл явдлын баримт мэдээлэл, статистик, Сенатын үе үеийн гишүүдийн фото зураг, намтрын товчоон зэрэг мэдээллийг хадгална. Эдгээр мэдээлэл нь түүхэн баримт бичиг болохын хувьд түүнийг бэлтгэхдээ эрдэм шинжилгээний ажилтнуудын зөвлөгөөг авч хамтран ажиллана. Алба нь сенаторууд, ажилтан албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний ажил хийж буй хүмүүс, төрийн албан хаагчдад нээлттэй үйлчилдэг.

Зураг



Парламентын гадаад харилцааны газар

Тус газар нь АНУ -ын Төлөөлөгчдийн танхимын гишүүд, ажилтнуудын гадаад харилцаа, парламент хоорондын харилцааны асуудлыг хариуцна. Тухайлбал, гадаадын зочид, төлөөлөгчдийг хүлээн авч уулзах, албан ёсны айлчлалын бэлтгэл хангах, зохион байгуулах, албан ёсны айлчлалын үеийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах зэрэг болно. 2003 оны актын дагуу байгуулагдсан тус газрын захирлыг Төлөөлөгчдийн танхимийн дарга / Спикер/ шүүд томилно.

Тус газар нь АНУ-ын Үндсэн хууль болон суурь хуулийн системчлэл, ангилал, кодчиллын

асуудлыг хариуцна. 1974 онд АНУ -ын конгрессийн 988 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан. Газрын даргыг Төлөөлөгчдийн танхимийн дарга /Спикер/ санал болгон Шүүх эрх мэдлийн хороонд хэлэлцүүлж томилно.

Онцгой байдлын газар

Тус газар нь 2001 оны 9 сарын 11 -ний өдрийн террорист халдлагын дараа 2002 онд байгуулагдсан. Төлөөлөгчийн танхимын онцгой нөхцөл байдалд ажиллах зарчим, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хариу арга хэмжээ авах, гамшгийн менежмент, гамшгийн дараах нөхөн сэргээлт зэрэг асуудлыг хариуцна. Онцгой байдлын газрын захирлыг Төлөөлөгчдийн танхимийн дарга /Спикер/ цөөнхийн бүлгийн даргатай хамтран томилно. Газар нь холбооны тагнуул, цэрэг, цагдаагийн байгууллагаас тодорхой хязгаартай мэдээллийг гаргуулах эрхтэй бөгөөд өөрийн үйл ажиллагааг олон нийтэд нэгбүрчлэн мэдээлэх үүрэг хүлээхгүй.

Конгрессийн ёс зүйн газар

Төлөөлөгчдийн танхимын саналаар Конгрессийн ёс зүйн газрыг 2008 оны 03 сард байгуулсан. Тус газар нь Төлөөлөгчдийн танхим ба түүний ажилтан албан хаагчдын ёс зүйн талаар санал дэвшүүлж, Төлөөлөгчийн танхимын ёс зүйн хороогоор хэлэлцүүлэх эрхтэй. Тус газрыг найман гишүүний бүрэлдэхүүнтэй захирлын зөвлөл удирдах ба тэдгээр нь төрийн албан хаагч бус энгийн иргэн байна. Ёс зүйн талаарх аливаа хэргийг гурван сарын дотор шийдэх буюу холбогдох байгууллагад хүргүүлэх, шийдвэр гаргуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

- *Төлөөлөгчдийн танхимын дарга /Спикер/ ажил үүргийнхээ хүрээнд дараах газруудыг шууд хамаарна.*

Төлөөлөгчдийн танхимын парламентч /зөвлөх/

Парламентчийг Төлөөлөгчдийн танхимын дарга /спикер/ түүний улс төрийн байр сууринаас бус хууль, эрх зүйн салбарт мэргэшсэн, Төлөөлөгчдийн танхимын дарга /спикер/-д шууд зөвлөх ур чадварыг нь харгалзан томилно.

Ахлах мэргэжилтэн

АНУ -ын 104 дүгээр Конгрессийн үеэс эхлэн Төлөөлөгчдийн танхимын дотоод захиргааны асуудал эрхэлсэн албан тушаалтны орон тоо бий болжээ. Энэхүү албан тушаалтан нь захиргааны удирдлагын бүх асуудлыг хариуцах бөгөөд Ардчилсан нам, Бүгд Найрамдах нам тус бүр нэг хүнийг уг албан тушаалд дэвшүүлэн Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцүүлж, санал хураан томилно. Уг албан тушаалтны эрхлэх ажлын хүрээнд хүний нөөцийн менежмент, дотоод мэдээлэл, санхүү, нягтлан бодох бүртгэл, тендер зарлах, худалдан авалтыг гүйцэтгэх зэрэг ажил хамаарна.

Төлөөлөгчдийн танхимын Түүхч

Уг албан тушаалыг Төлөөлөгчдийн танхимын түүхийг судлах, олон нийтэд сурталчлан таниулах үүрэгтэйгээр 1983 онд бий болгосон ба түүнийг олонхийн бүлгээс томилно.

Санваартан

1789 онд анхны Конгресс хуралдсанаас хойш одоог хүртэл Төлөөлөгчдийн танхимын хурал нь залбирлаар эхэлдэг ёс заншлыг хадгалж иржээ. Уг заншлыг гүйцэтгэх болон шашны бусад асуудлыг эрхлэх албан тушаалтан болох Санваартанг Төлөөлөгчдийн

танхимын нэгдсэн хуралдаанаар томилно.

Төлөөлөгчдийн танхимын гүйцэтгэгчийн (serjeant-at-arms) алба

Гүйцэтгэгчийн ажлын алба нь дэг сахиулах, протокол, зохион байгуулалтын ажил, үүрэг гүйцэтгэнэ. Төлөөлөгчдийн танхимын ахлах албан тушаалтны хувьд Төлөөлөгчдийн танхимын даргын /спикер/ шууд зааварчилгааны дагуу ажиллана. Уг алба нь Капитолын цагдаагийн газрын бүтцэд хамаарна.

Төлөөлөгчдийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга

Хоёр жил тутмын завсрын сонгуулиар бүрдсэн Төлөөлөгчдийн танхимын Спикерийг сонгосны дараа олонх, цөөнхөөс нэр дэвшүүлэн Танхимын Ерөнхий нарийн бичгийн даргыг /Клерк/ хоёр жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дараах газар, хэлтсийг удирдлагаар хангана.

Капитолын үйлчилгээний групп

Капитолын үйлчилгээний групп нь Гишүүд болон гэр бүлийн хорооны өрөө, Lindy Claiborne Boggs -ийн нэрэмжит Конгрессын эмэгтэйчүүдийн уншлагын танхим, Капитол ордны залбирлын зэрэг өрөө тасалгааны үйлчилгээг хариуцна.

Танхимын ажил эрхлэлтийн зөвлөлийн офис (OHEC)

Төлөөлөгчдийн танхимын ажлын албадын ажил үүргийн хуваарь, ажил эрхлэх практикийн талаар зөвлөгөө өгөх үүрэгтэй.

- ***Эрх зүйн мэдээллийн төв (LRC)***

Уг төв нь дараах дөрвөн албаараа дамжуулан Танхим болон олон нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Олон нийтийн мэдээллийн алба
- Бүртгэл, бичлэгийн алба
- Номын сангийн үйлчилгээ
- Хэвлэн нийтлэх алба

Урлаг, архивын офис, Түүхчийн офис

Эдгээр офис нь 200 жилийн түүхтэй Төлөөлөгчдийн танхимын түүхэн баримт бичиг, дурсгалт зүйлс, судалгаа болон Төлөөлөгчдийн танхимын бүртгэл, тайланг хадгална. Түүнчлэн АНУ-ын конгрессийн үйл ажиллагаатай холбоотой хувь хүмүүсийн намтрын архивыг хөтлөх ба холбогдох баримт бичгийн эх хувийг хадгална. 2000 гаруй зүйлийн урлаг, түүхийн дурсгалуудыг хадгалан хамгаалж, үзэсгэлэн зохион байгуулах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

Төлөөлөгчдийн танхимын Пэйж хөтөлбөр

Пэйж хөтөлбөр нь дунд сургуулийн сурагчдад бүтэн жилийн хугацаанд эсвэл 1-2 улирлын туршид АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд туслах ажилтанаар ажиллах боломжийг олгодог. 180 жилийн түүхтэй уг хөтөлбөрт хамрагдах шалгуур өндөр байх ба хөтөлбөрийн хугацаанд Төлөөлөгчдийн танхимын гишүүн уг суралцагчийн бүх зардлыг хариуцна.

Компьютер системийн хэлтэс (LCS)

Тус газар нь Төлөөлөгчдийн танхимын хороодоос тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн боловсруулах, электрон санал авах системийн аюулгүй байдал, тогтвортой ажиллагааг хангах, саналыг тоолох, нэгтгэн боловсруулж мэдээлэх зэрэг үүргийг хүлээнэ.

Хэвлэлийн үйлчилгээний алба (OPS)

Тус алба нь албан бичгийн хэвлэмэл хуудас, дугтуй, алба ёсны бичиг баримт зэргийг хэвлэнэ.

Эрх зүйн хэлтэс

Тус хэлтэс нь албан баримт бичгийг хүлээн авч боловсруулах, нэгтгэх, Төлөөлөгчдийн танхимын өдөр тутмын үйл ажиллагааны бичлэгийг бэлтгэх, хэвлэх, электрон санал хураах системийг хариуцан ажиллах зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Мөн хуулийн төсөл, Ерөнхийлөгчийн мэдэгдэл, шийдвэр, хуулийн нэмэлт, санал зэргийг Төлөөлөгчдийн танхимд уншиж сонсгох үүргийг хүлээнэ.

Эдгээр асуудлыг Хуулийн төсөл хариуцсан Клерк, Хэвлэлийн Клерк, Талли (Tally) Клерк, Танхим хоорондын харилцааны Клерк, Уншигч Клерк зэрэг албан тушаалтнууд хариуцна.

Хуулийн төслийн Клерк

Төсөв, тушаал, тогтоол, нэмэлт баримт, материалуудыг хүлээн авч боловсруулан Төлөөлөгчдийн танхимын хуралд танилцуулна.

Хэвлэлийн Клерк

Төлөөлөгчдийн танхимын албан ёсны сэтгүүлийг эрхлэн гаргах ба түүний өдөр тутмын үйл ажиллагааны тайланг бэлтгэн олон нийтэд мэдээлнэ.

Танхим хоорондын харилцааны Клерк

Төлөөлөгчдийн танхимаас Сенатад хандсан мэдэгдэл, хууль тогтоомжийг бэлтгэн хүргүүлэх үүргийг хүлээнэ.

Уншигч Клерк

Хуулийн төслүүд, шийдвэр, нэмэлт, санал болон ерөнхийлөгчийн мэдэгдлийг Танхимд уншиж сонсгох үүрэгтэй. Мөн Төлөөлөгчдийн танхимаас гаргасан эрх зүйн актуудыг Сенатад мэдээлнэ.

Талли Клерк

Талли Клерк нь электрон санал хураалтын системийг хариуцан ажиллуулах ба танхимд явагдсан санал хураалтын бичлэгийг үйлдэж, хороодын тайланг хүлээж авна. Мөн “Төлөөлөгчдийн танхимын хуанли”, “Хууль тогтоох үйл ажиллагааны түүх”-ийг бэлтгэнэ.

КАНАД (Канад Улс, *Canada*)

Канад нь Үндсэн хуульт хаант улс бөгөөд Хатан хаан II Элизабет төрийн тэргүүн, Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн байна. Тус улс нь парламентын засаглалтай, холбооны улс юм. Холбооны парламент нь Хатан хаан (Амбан захирагчаар төлөөлүүлсэн) болон хоёр танхимаас бүрддэг. Нийтийн танхим /House of Commons/ нь сонгуулиар байгуулагддаг

бол Канадын Сенатын танхимын /Senate/ гишүүд нь томилогддог юм.


Зураг



Парламентын бүтэц

Канадын Парламентын ажлын алба

Канадын парламентын ажлын алба нь Нийтийн танхимын болон Сенатын ажлын албадаас бүрдэнэ. Танхимуудын ажлын албадыг Клеркүүд толгойлно. Парламентын ажлын албаны Клерк нь Сенатын ажлын албаны Клерк байна.



Канадын парламентын ажлын алба нь Парламентад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Сенатын танхимын Клерк

Сенатын Клерк нь Сенат, түүний байнгын хороод, сенатын ерөнхийлөгч, сенатын гишүүдэд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөх болон туслах өргөн хүрээтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. “Төрийн албаны хууль”-ийн 130 дугаар зүйлд заасны дагуу Сенатын Клеркийг Губернаторын саналыг үндэслэн зөвлөл 7 жилийн хугацаагаар томилно. “Сенатын Захиргааны дүрэм”-ийн дагуу Клерк нь Сенатын захиргааны тэргүүн байх бөгөөд Сенатын Дотоод эдийн засаг, төсөв, захиргааны байнгын хороогоор дамжуулан Сенатын өмнө ажлаа хариуцна. Сенатын Клерк нь танхимын Баримт бичгийн офисын дарга бөгөөд танхимын даргын процедурын зөвлөх байна.

Сенатын Клерк нь Сенатын захиргааны тэргүүний хувьд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- а/ Хамтын удирдлагын асуудал, түүний дотор захиргаа, санхүүгийн төлөвлөлт, удирдлагын хэтийн төлөвийн асуудлаар зөвлөх;
- б/ Захиргаа, санхүүгийн асуудлыг зохион байгуулах;
- в/ Сенатын захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх;
- г/ Сенатын захиргааны чиг үүргийн хяналт шалгалтыг явуулах;
- д/ Дотоод эдийн засгийн хороогоор дамжуулан Сенатад ажлаа тайлагнах;

Сенатын Клерк нь Сенатын нарийн бичгийн даргын хувьд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- а/ Парламентын үйл ажиллагааны бичлэгийг үйлдэж, хадгалж хамгаалах;
- б/ Хууль болон практикт шаардлагатай бичлэгүүдийг ашиглах болон хувилах боломжийг бүрдүүлэх;

Сенатын Клерк чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Хуулийн болон Ёс зүйн Клерк, Сенатын Ушер тусална.

Хуулийн Клерк нь гишүүдэд хууль тогтоох болон хянан шалгах үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй.

Сенатын ёс зүйн Клерк нь Сенатын танхим ба тэдгээрийн ажилтан албан хаагчдын ёс зүйн талаар санал дэвшүүлж, Сенатын танхимын ёс зүйн хороогоор хэлэлцүүлэх эрхтэй.

Сенатын Ушерийн гол үүрэг нь парламентын хуралдааны үед эмх журам сахиулах ба Дэгийн хуулийг мөрдүүлэхэд хуралдаан даргалагчид туслана.

Нийтийн танхимын Клерк

Төрийн албаны тухай хуульд зааснаар 2005 он хүртэл Нийтийн танхимын Клеркийг Губернатор томилдог байсан бол Клеркийг хамгийн сүүлд буюу 2009 онд Танхим, дэгийн асуудал хариуцсан байнгын хорооны санал оруулснаар Танхим томилсон байна.

Нийтийн танхимын Клерк нь Нийтийн танхим, түүний байнгын хороод, хамтарсан хороод болон гишүүд хууль тогтоох эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх үйлчилгээ үзүүлнэ. Мөн Танхимын үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулан дэмжүүлэх ажил зохион байгуулна. Клерк нь Нийтийн танхимын санхүү, захиргааны асуудлыг хариуцах чиг үүрэг бүхий Дотоод эдийн засгийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэж, Нийтийн танхимын парламент хоорондын харилцааны асуудлыг хариуцан ажиллана.

Танхимын захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий гүйцэтгэх байгууллага болох Клеркийн удирдлагын бүлэг (CBG)-ийг Клерк тэргүүлнэ. Тус бүлэг нь Нийтийн танхимын

дарга, Дотоод эдийн засгийн зөвлөлд Нийтийн танхимын захиргааны асуудлаар санал зөвлөмж гаргана.

Клеркийн удирдлагын бүлэгт:

1. Нарийн бичгийн даргын орлогч (Дэгийн алба)
2. Хуулийн Клерк бөгөөд парламентын Зөвлөх (хуулийн Клерк бөгөөд парламентын Зөвлөхийн офис)
3. Парламентын Гүйцэтгэгч (Serjeant at-arms)
4. Мэдээллийн албаны дарга (Мэдээллийн алба)
5. Санхүүгийн албаны дарга (Санхүүгийн алба)
6. Хүний нөөцийн албаны дарга (Хүний нөөц, нэгдсэн төлөвлөлт, харилцаа холбооны алба)

нар байна.

Нарийн бичгийн даргын орлогч нь Нийтийн танхимын хоёр дахь үндсэн, байнгын ажилтан бөгөөд Клеркийн удирдлагын бүлгийн хүрээнд хийгдэж буй ажлын үр дүн, тэргүүн ээлжийн болон стратегийн чиглэлийг тодорхойлох үүрэгтэйгээс гадна Дэгийн албыг ерөнхий удирдлагаар хангаж, парламент хоорондын харилцааны асуудлыг хариуцна.

Хуулийн клерк бөгөөд парламентын Зөвлөх нь гишүүдийг хууль тогтоох болон хянан шалгах үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй. Нийтийн танхимд өргөн баригдсан баримт бичгийн төслийг хэвлэж, тараана.

Парламентын гүйцэтгэгчийн (Serjeant-at-Arms) гол үүрэг нь парламентын хуралдааны үед эмх журам сахиулах ба Дэгийн хуулийг мөрдүүлэхэд спикерт туслана.

Клеркийн удирдлагын бүлэг нь:

1. Нийтийн танхимын захиргааны стратегийн чиглэлийг тодорхойлох, ажлын төлөвлөгөөг боловсруулах, гарах үр дүнг тооцох;
2. Нийтийн танхимын захиргааг эрх үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай хүний нөөц, санхүүгийн эх үүсвэрээр хангах;
3. Нийтийн танхимын хэтийн хөгжилд хамааралтай асуудлыг хэлэлцүүлэх, батлуулахын өмнө Дотоод эдийн засгийн зөвлөлд танилцуулах, эсхүл түүгээр батлуулах;
4. Батлагдсан бодлого, удирдамжид Нийтийн танхимын захиргааны удирдлагыг нийцүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Парламентын номын сан

Парламентын номын сан нь Холбооны нэгдлийн дараа Канадын парламентын актын 73-79 дүгээр зүйлийн дагуу байгуулагдсан. Сенатын болон Нийтийн танхимын Спикерүүд хамтран тус номын сангийн удирдлага, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ. Одоогоор 600,000 орчим ном, баримт бичгийн фондтой. Номын сангийн мэдээлэл, судалгааны материалуудыг парламентын гишүүд, ажилтнууд, парламентын хороод, холбогдох бусад байгууллага ашиглана. Номын санд голчлон Канадын улс төр, парламентын үйл ажиллагаа, Засгийн газар, эдийн засаг, хууль, парламентын түүх, дэг, улс төрийн шинжлэх ухаан, олон улсын байдалтай холбоотой материалууд байдаг. Тус номын сан нь 300 орчим ажилтантай.

4. Африк тивийн улс орнууд

КАБО - ВЕРДЕ

Бүгд Найрамдах Кабо-Верде Улс (*Republic of Cape-Verde*)

Парламентын Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Үндэсний ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь:

- Хууль тогтоомжид заасны дагуу Үндэсний ассамблей, хороод, парламентын бүлгүүдэд захиргаа, техник үйлчилгээ үзүүлэх;
- Үндэсний ассамблейн даргын эрх хэмжээний хүрээнд хурал, бусад арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;
- Байнгын болон тусгай хороод, парламентын бүлгүүдэд Үндэсний ассамблейн төв байранд ажиллах нөхцөлийг хангаж, өрөө, танхимын хуваарилалтыг хариуцах;
- Үндэсний ассамблейн жил бүрийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, төсвийг боловсруулж, энэ тухай мэдээллээр хангах;
- Байнгын хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Бүтцийн схем

Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрх:

- Ерөнхий нарийн бичгийн даргын газрын үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Үндэсний ассамблейн даргын үйл ажиллагаанд туслах үйлчилгээг сайжруулах, боловсронгуй болгох;
- Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хийгдэж байгаа зохион байгуулалтын болон техникийн үйл ажиллагааны талаар боловсруулагдсан баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах;
- Ерөнхий нарийн бичгийн даргын газраас төрийн бусад байгууллагатай харилцах ажлын уялдаа, холбоог хангах;
- Үндэсний ассамблейн дарга болон даргын товчоо шаардлагатай гэж үзвэл

Ерөнхий нарийн бичгийн дарга:

- Үндэсний ассамблейн төсвийг Даргын товчоо, зөвлөлөөс тогтоосон зарчимд нийцүүлэн бэлтгэж, хэлэлцүүлэхээр өргөн барих;
- Үндэсний ассамблейн тайлан тэнцлийг гаргах ажлыг зохион байгуулж, Зөвлөлд өргөн мэдүүлэх;
- Үндэсний ассамблейн албадын дотоод зохион байгуулалт, чиг үүргийн талаарх дүрэм, журмыг өөрчлөх санал оруулах асуудлыг тус тус шийдвэрлэнэ.

Үндэсний ассамблейн даргын тушаалаар өгөгдсөн Ерөнхий нарийн бичгийн даргын газрын удирдлагын түвшний бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

Парламентын үйлчилгээний газар

Үндэсний ассамблейн гишүүдийн хууль тогтоох болон парламентын үйл ажиллагаанд захиргааны болон техник үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх үндсэн нэгж юм.

Чиг үүрэг:

- Үндэсний ассамблейн хууль боловсруулах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах;
- гишүүд, Байнгын хороодын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Үндэсний ассамблейн нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаанд захиргааны болон техник үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх;
- Нэгдсэн хуралдааны протокол, парламентаас гаргасан бусад баримт бичгийг нийтлүүлэхэд бэлтгэх;
- Парламентын мэдээлэл, баримт бичгийн үйлчилгээний газар болон бусад албадтай баримт бичиг, мэдээллийн талаар хамтран ажиллах;
- “Албан ёсны хэвлэл”-д хууль тогтоомжийг хэвлүүлэхээр бэлтгэх;

- ***Хуралдаан зохион байгуулах хэлтэс***

- Нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, товчооны хуралдаанд захиргааны болон техник үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх;
- Нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлыг боловсруулах, мэдээлэх;
- Чуулганаар хэлэлцэх асуудлын хуваарь гаргах;
- Нэгдсэн хуралдааны ирцийн бүртгэл хөтлөх;
- Хууль бусад шийдвэрийн төсөл, хууль батлахтай холбогдон гишүүдийн гаргасан санал, санал хураалтын дүн, Засгийн газарт тавьсан асуулга, түүнд тавигдсан асуулт, тайлбар болон парламентын бусад баримт бичгийн файлуудыг бүртгэж, ангилах;
- Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалуудыг гишүүдэд тараах;
- Дэгд заасны дагуу хэвлэх баримт бичгийг Редакцийн хэлтэст шилжүүлэх;
- Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдсэн хууль тогтоомжийн төсөл, гарсан саналыг эцсийн найруулгад бэлтгэхэд Байнгын хороодод туслах;
- Батлагдан гарсан хууль, Зөвлөлийн шийдвэрийн бичлэгийг үйлдэж албан ёсны хэвлэлд нийтлэхэд бэлтгэх;
- Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн Үндэсний ассамблейн баримт бичигт засвар оруулахад туслах;
- Хууль тогтоох үйл ажиллагааны процесс болон Байнгын хороодын хянан шалгах ажилд Хороодын үйл ажиллагааг дэмжих хэлтэстэй хамтрах;
- Үндэсний ассамблей, түүний бүтцийн байгууллагуудын хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Батлагдан гарсан хууль тогтоомжийг Ерөнхийлөгчөөр гарын үсэг зуруулахад бэлтгэх, хүргүүлэх;
- Парламентын бүлгүүдийн төлөөлөгчдийн хуралдааныг зохион байгуулахад техникийн дэмжлэг үзүүлэх;
- Хууль санаачлах үйл ажиллагаа хэвийн явагдахад шаардагдах техникийн зөвлөгөө, мэдээллээр хангах;
- Хууль санаачлах үйл ажиллагаа Үндсэн хууль болон процедурын шаардлагатай нийцэж буй эсэхэд хяналт тавих;

- ***Хороод, Нарийн бичгийн даргын газрын үйл ажиллагааг дэмжих хэлтэс***

- Байнгын хороод, дарга нарт тэдгээрийн үйл ажиллагаатай холбоо бүхий техникийн мэдээллийг системтэй өгөх үйлчилгээ үзүүлэх;

- Байнгын хороодод хамаарах асуудлаар тайлбар, мэдээлэл боловсруулах;
- Үндэсний ассамблейн дарга нараас шүүхэд өгөх тайлбарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Байнгын хороодын дарга нарын хүсэлтээр хороодын хуралдааны протоколыг бэлтгэх, боловсруулах, шинжилгээ хийх;
- Байнгын хороодын дарга нараас гаргах тусгай мэдээллийг бэлтгэх;
- Техникийн үйлчилгээний програм хангамж боловсруулах үйл ажиллагаанд оролцох;
- Байнгын хороодын дарга нарт шаардагдах бусад дэмжлэг үзүүлэх;

Редакцийн хэлтэс

- Нэгдсэн хуралдааны протокол хөтлөх;
- Нэгдсэн хуралдаан дээр тавигдсан илтгэл, мэдэгдлийн нэгдсэн тайланг зохих техник хэрэгслийн тусламжтайгаар бэлтгэх;
- Өмнөх хэсэгт заасан текстийг шаардлагатай тохиолдолд найруулж боловсруулах;
- Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хэвлэлтэд бэлтгэх, бүрдлийг хянах;
- Нийтлүүлэхэд бэлэн болсон парламентын баримт бичгийг шалгаж зөвшөөрөл өгөх;
- Үндэсний ассамблейн баримт бичгийг тогтоосон хугацаанд нийтлүүлэх;

Парламентын мэдээлэл, баримт бичгийн үйлчилгээний газар

Тус газар нь Үндэсний ассамблейн баталсан болон үйл ажиллагааны мэдээлэл, баримт бичгүүдийг шуурхай тараах, хураан авах, хадгалах, системчлэх үүрэгтэй.

Чиг үүрэг:

- Үндэсний ассамблейн үйл ажиллагааг номын сангийн болон баримт бичгийн үйлчилгээгээр дэмжих;
- Үндэсний ассамблейн түвшинд номын сан, баримт бичиг, дүрэм заавар, хууль эрх зүй, захиргаа, шинжлэх ухаан, техникийн мэдээллээр дэмжих, тэдгээрийг цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үндэсний болон олон улсын мэдээллийн шинэчилсэн файлуудыг бий болгох;
- Үндэсний ассамблейн үйл ажиллагаанд холбогдох үндэсний болон гадаад улс орнуудын хууль тогтоох үйл ажиллагааны мэдээлүүдийг цуглуулах, шинжилгээ хийх, архивлахад туслалцаа үзүүлэх;
- Номын санг удирдлагаар хангах;
- Үндэсний ассамблейн баримт бичиг болон Үндэсний ассамблейд хамаарах баримт бичгүүдийг нийтлүүлэхэд оролцох;
- Үндэсний түүхийн архивтай хамтран парламентын түүхийн сан үүсгэхэд оролцох;

Парламентын мэдээлэл, баримт бичгийн хэлтэс

- Үндэсний ассамблейд зохион байгуулагдаж буй арга хэмжээтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актууд, захиргааны болон шинжлэх ухаан техникийн мэдээлэл бүхий баримт бичгүүдийг номын сангийн фондод авах үйл ажиллагааг зохион байгуулах;

- Үндэсний ассамблейн үйл ажиллагаанд хамаарах үндэсний болон гадаад улс орнуудын хууль эрх зүйн мэдээллээр хангах, тэдгээрийг цуглуулах, архивлах, дүн шинжилгээ, боловсруулалт хийх;
- Хууль тогтоомжийн сан үүсгэх;
- Номын сангийн фондоос каталоги, эмхтгэлийн хэлбэрээр хэвлэмэл баримт бичгийн үйлчилгээ үзүүлэх;
- Үндэсний ассамблейн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хэвлэн нийтлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Номын сан

- Үндэсний ассамблей түүний байгууллагуудын чиг үүргээ биелүүлэхэд шаардлагатай шинжлэх ухаан, эдийн засаг, нийгэм, статистикийн мэдээллээр хангах, тэдгээрийг хадгалах, индексчлэх, каталогжуулах;
- Шинэ ном, урсгал мэдээлэл, баримтат мэдээллийн санг баяжуулах;
- Номын сангийн мэдээллийн эх үүсвэрийг бүхэлд нь каталогжуулах, индексчлэх ажиллагааг зохион байгуулах;
- Олон нийтэд үйлчлэх;
- Гар дээр өгөх үйлчилгээ үзүүлэх;
- Сургалт явуулах;
- Шинэ номын танилцуулгыг тогтмол нийтлүүлэх;
- Үйл ажиллагааны дүрмээ боловсруулж, батлуулах;

Архив

- Үндэсний ассамблейн түүхэн уламжлалыг агуулсан сан бүрдүүлэх;
- Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг цуглуулж хадгалах, индексжүүлэх, каталогжуулах;
- Соронзон хальсанд буулгасан бичлэгийн мэдээллийг хадгалах, боловсруулах, цуглуулах;
- Үндэсний ассамблейн фото зургийн санг бүрдүүлж хадгалах;
- Хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг ашиглуулах
- Үндэсний болон гадаад улсуудын архивтай хамтран ажиллах;

Захиргаа, санхүүгийн үйлчилгээний газар

Үндэсний ассамблейн удирдах байгууллагын шийдвэр, шаардлагад нийцүүлэн санхүү, хөрөнгө, хүний нөөцийн болон бусад захиргааны үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий зохион байгуулалтын нэгж мөн.

- Үндэсний ассамблейн удирдлагын зардлын тайлан, төсвийн төслийг боловсруулах, түүний талаарх мэдээллийг танилцуулах;
- Өргөдөл хүлээн авах;
- Урсгал болон их засварын ажлыг гүйцэтгэх;
- Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Нийгмийн хангамж, нийгмийн бусад үйл ажиллагааны системийг тогтоох;
- Парламентын үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, ажлын чанарыг сайжруулах талаар арга хэмжээ авах;
- Үндэсний ассамблейн активын удирдлагыг хэрэгжүүлэх, шаардлага хангахуйц техникийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Түүнчлэн дор дурдсан үйлчилгээг хариуцан хэрэгжүүлнэ:

- Үндэсний ассамблейн захиргаа, санхүүгийн удирдлагын үйлчилгээг зохицуулах;
- Үндэсний ассамблейн бие даасан төсвийг тогтоосон журмын дагуу боловсруулах, системчлэх, танилцуулах ба түүний тайлан, танилцуулга, тайлбарыг гаргах;
- Үндэсний ассамблейн орлого бүрдүүлэх, хяналт тавих журам тогтоох;
- Бүх үнэт цаасны зарлагыг төсвийн хуулийн дагуу гүйцэтгэх;
- Төсвийн тооцоотой холбогдох хавсралт баримт бичгийг олшруулж хүргүүлэх;
- Цалин урамшуулал, бусад зардалтай холбоотой бүх хавсралт тооцоонд шаардагдах мөнгөн эх үүсвэрийн талаарх мэдээллийг танилцуулах;
- Ажилтнуудын бүртгэл, хувийн хэргийг тогтоосон журмын дагуу тухай бүр шинэчлэх;
- Ажилтнуудыг сургах, давтан сургахад дэмжлэг үзүүлэх;

Хүний нөөцийн хэлтэс

- Үндэсний ассамблейн ажилтнуудын талаарх мэдээллийг шинэчлэх, хүний нөөцийн ашиглалтыг сайжруулах механизмын талаар санал дэвшүүлэх;
- Хөдөлмөрийн эрх зүйн харилцааны зохицуулалтын дагуу ажилтнуудыг сонгох, томилох, дэвшүүлэх, хөдөлмөрийн харилцааг хуулийн дагуу зогсоох;
- Ажлын үр дүнг үнэлэх ажлыг зохицуулж, шагнаж урамшуулах;
- Үндэсний ассамблейн ажлын албаны боловсон хүчний стандартын дагуу ажилтнуудын ажлыг дүгнэх системийг тогтоох, дүн шинжилгээ хийх;
- Ажилтнуудын чадавхийг сайжруулах зорилгоор гадаад, дотоодын мэргэжлийн сургалтад хамруулах;
- Ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- Үндэсний ассамблейн ажилтнууд болон намын бүлгийн ажилтнуудын бүртгэл, ажлын ирц, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээтэй холбоотой баримт бичгийг хариуцах;
- Хуралдаан зохион байгуулах хэлтэстэй хамтран парламентын гишүүдийн нийгмийн хамгааллын асуудлаарх бүртгэл, зохицуулалтыг хариуцах;
- Бусад албадтай хамтран ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэн ажиллах;
- Цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг Санхүүгийн хэлтэстэй хамтран шийдвэрлэх;
- Эрхлэх асуудлын хүрээнд магадлагаа гаргах;
- Парламентын ажилтнуудад ажлын үнэмлэх олгох, ажлын өрөө хуваарилах;
- Үндэсний ассамблейн захидал, бичиг харилцааг хариуцах,
- Үндэсний ассамблейн бүртгэлийн файлын системийн удирдлагад оролцох, гарах шуудангийн бүртгэлийг хөтлөх;
- Дотоод дүрэм журмыг мөрдүүлэх, мэдээллийг ажилтнуудад хүргэх;
- Бусад

Санхүүгийн удирдлагын хэлтэс

- Үндэсний ассамблейн үндсэн болон нэмэлт төсвийн төслийг боловсруулж бэлтгэх;
- Төсвийг хуулийн дагуу зарцуулах;
- Хууль тогтоомжид заасны дагуу тайлан бүртгэлийг хөтлөх;

- Санхүүгийн баримт бичиг, гүйлгээний үр ашигтай байдал болон үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд явагдаж буй эсэхэд хяналт тавих;
- Төсвийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх, төсвийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, төсвийн гүйцэтгэлийн тайлан, картуудыг гаргах;
- Эрх зүйн баримт бичигт заасан эрх хэмжээний хүрээнд төсвийн орлого, зарлагыг гүйцэтгэх;
- Батлагдсан байнгын фондуудын удирдлагыг хэрэгжүүлэх, түүний төслийн саналыг боловсруулах;
- Удирдлагын зардлын тооцоо, тайланг гаргах;
- Төсвийн хүрээнд Үндэсний ассамблейн гишүүд, ажилтнуудын цалин бусад нэмэгдэл олгох асуудлаар журам тогтоох;
- Төсвийн санхүүжилтээр Үндэсний ассамблейн үйлчилгээнд зориулан худалдан авах ажил үйлчилгээ, материалын талаар санал дэвшүүлэх;
- Гадаад валютын гүйлгээг хариуцах;
- Улсын төсвөөс хөрөнгө зарцуулах, мөнгөн шилжүүлгийн гүйлгээний бичилтийг гүйцэтгэх;
- Сар бүрийн балансаар хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих;
- Удирдлага солигдоход гарын үсгийн эрхийг хүчингүй болгох;
- Тодорхой хугацаанд нэмэгдэл олгох болзол, журам гаргах;
- Банктай байнгын холбоотой ажиллах;
- Үндэсний ассамблейн шугамаар өөртөө засах мужуудад хөрөнгө шилжүүлэх;
- Үндэсний ассамблейн санхүүгийн бодлогыг тодорхойлох, судалгаа хийх;

Хөрөнгө, хангамжийн хэлтэс

- Үндэсний ассамблейн хэрэгцээнд материал, үйлчилгээг худалдан авах, хадгалах, нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авах барааны үнийн зохистой хязгаарыг тогтоох, бараа материалыг хадгалах, чанарыг шалгах арга, журмыг судлах;
- Хөрөнгө оруулалтаар авах бараа, материалын захиалгыг хүлээн авч тогтоосон загварын дагуу нийлүүлэх;
- Үндэсний ассамблейн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Хэрэгцээгүй бараа, акталсан болон гэмтсэн барааг худалдах санал гаргах;
- Эд хөрөнгийн тооллого, тооцоог хийх, зохион байгуулах;
- Ажил гүйцэтгэгчийн хийсэн ажлын гүйцэтгэлийг шалгах;
- Утсан харилцаа, аж ахуйн үйлчилгээ, гэрэлтүүлэг, дуу хураагуур, ногоон байгууламж, цэвэрлэгээ, халаалт, хөргөлт, цахилгаан шат, галын дохиолол, харуул хамгаалалтын үйлчилгээний чанарын асуудлыг хариуцах;
- Хүний нөөцийн хэлтэстэй хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах;
- Олон нийтийн болон гадаад харилцааны газартай хамтран ордон танилцуулах хяналтыг хэрэгжүүлэх;

Олон нийтийн болон гадаад харилцааны газар

Олон нийтийн болон гадаад харилцааны газар нь Үндэсний ассамблейн гадаад харилцааг

хэрэгжүүлэх, идэвхижүүлэх, гишүүдийн гадаад арга хэмжээний протоколын арга хэмжээг зохион байгуулах, өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх үүрэг бүхий нэгж юм.

1. Олон нийттэй харилцах хүрээнд:

- Үндэсний ассамблейн гишүүдийн болон парламентын байгууллагуудын дотоод, гадаад протоколын арга хэмжээг зохион байгуулах;
- Нэгдсэн хуралдааны талаар “Social Communication”-д мэдээлэл өгөх;
- Парламентын байгууллагуудын дотоод, гадаад арга хэмжээний талаар мэдээлэх;
- Парламентын үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдээлийн хэрэгслээр нийтэлсэн мэдээллийг цуглуулах, ангилах, дүн шинжилгээ хийх;

2. Олон улсын харилцааны хүрээнд:

- Үндэсний ассамблейн дарга, бусад албаныханд дипломат ёсны талаар зөвлөгөө өгөх;
- Муж улсуудаас гадаад улс орнуудад өөрийн төлөөлөгчийн газрыг байгуулахад бэлтгэх, үйл ажиллагаагаа явуулахад нь тусламж үзүүлэх;
- Үндэсний ассамблейд гадаадын төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулах, хяналт тавих;
- Эх орондоо олон улсын парламентын хуралдаан зохион байгуулах үеэр зохиогдох нийгэм, соёлын арга хэмжээний хөтөлбөрийг зохиох;
- Үндэсний ассамблейн байгууллагаас өгсөн үүргийн дагуу олон улсын парламентын хуралдааны шийдвэр, зөвлөмжийг судлах;
- Гадаад, дотоод арга хэмжээний хүрээнд найрамдлын бүлгийн үйл ажиллагааг дэмжих;
- гадаадын болон олон улсын парламентын үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг цуглуулах, боловсруулах, гишүүдэд хүргэх;
- Олон улсын болон парламентын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг цуглуулах, боловсруулах, гишүүдэд хүргэх;

Мэдээллийн технологийн хэлтэс

Парламентын ажлын албадын нэг болох Мэдээллийн технологийн хэлтэс нь Үндэсний ассамблейн даргын шууд удирдлагад ажиллана. Мэдээллийн технологийн хэлтэс нь Үндэсний ассамблейн компьютерийн системийн үйл ажиллагааг хариуцан зохицуулах тусгай үйлчилгээний алба мөн.

- Үндэсний ассамблейн компьютерийн системийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, техникийн үйлчилгээ хийх;
- Нэвтрүүлсэн компьютерийн сүлжээний удирдлагыг хэрэгжүүлэх;
- Үндэсний ассамблейн тооцоолон бодох техник, холбооны системийн иж бүрэн удирдлага, техникийн үйлчилгээг хариуцах;
- Захиргаа, санхүүгийн удирдлагын газартай хамтран шаардлагатай компьютерийн тоног төхөөрөмжийг худалдан авах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- Үндэсний ассамблейн холбогдох этгээдтэй хамтран удирдлагын чиг үүргийн өгөгдлийг боловсруулах;
- Үндэсний ассамблейн товчоотой хамтран мэдээллийн автомат боловсруулалтын системийг боловсруулж хэрэгжүүлэх;

- Үндэсний ассамблейн компьютерийн системийн үйлчилгээний чиглэлийг тогтоох;
- Програм хангамжийн болон технологийн тоног төхөөрөмжийн талаарх мэдээлийг цуглуулах, сонголт хийх;
- Үндэсний ассамблейн мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх бодлогыг Захиргаа, санхүүгийн удирдах газартай хамтран хэрэгжүүлэх;
- Компьютер, тоног төхөөрөмж ашиглагчидтай нягт хамтран ажиллаж, тэдгээрийг үр ашигтай ашиглуулах;

* * *


5. Европ тивийн улсууд

АВСТРИ - Бүгд Найрамдах Австри Улс (*Republic of Austria*)

Австрийн Холбооны хурал буюу парламент нь хоёр танхимтай бөгөөд тэдгээр нь Холбооны зөвлөл, Үндэсний зөвлөл юм. Австрийн Холбооны Үндсэн хуульд зааснаар тус улсын парламент болон Европын холбооны парламентын гишүүдэд туслалцаа үзүүлэх ажлын алба нь Парламентын Тамгын газар бөгөөд Холбооны зөвлөлийн ерөнхийлөгч удирдана. Парламентын Тамгын газар 380 албан хаагчтай бөгөөд тэдний гол үүрэг нь байнгын хороо болон нэгдсэн чуулганд шаардагдах үйлчилгээ үзүүлэх, баримт бичиг боловсруулах зэрэг асуудлаар туслалцаа үзүүлэх юм.

Австрийн Парламентын Тамгын газар¹⁰

Зураг



¹⁰ <http://www.parlinkom.qv.at/>

Австрийн парламентын Тамгын газрын газар, албадын ажил үүргийн хуваарь

Хуулийн газар (L)

Үндэсний Зөвлөлийн ажлын алба (L1)

Ерөнхийлөгчийн ажлын алба (L1.1)

- Үндэсний Зөвлөл ба Үндэсний Зөвлөлийн ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд туслах;
- Үндэсний Зөвлөл, байнгын хороодын ажлын хөтөлбөрийг бэлтгэх;
- Холбогдох журмын дагуу явагдах үйл ажиллагаа, хэлэлцэх асуудлуудаар хууль, эрх зүйн болон бусад үйлчилгээ үзүүлэх;
- Ажлын төлөвлөгөө боловсруулах.

Хуралдаан зохион байгуулах хэлтэс (L1.2)

- Санал хураалтад бэлтгэх;
- Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг Дэгийн хуулийн дагуу явуулахад туслах, асуулгын цагт бэлтгэх;
- Хуралдаан зохион байгуулах, үг хэлэх хугацааг сахиулах, хуралдааны албан ёсны протокол хөтлөх, Үндэсний Зөвлөлийн тогтоолын хуулбарыг гаргах;
- Мэдээлэл, лавлагаагаар хангах.

Хороодын ажлын алба (L1.3)

- Хорооны даргын үйл ажиллагааг Дэгийн хуулийн дагуу нарийн зохион байгуулалттай хэрэгжүүлэхэд туслах, хуралдаанд бэлтгэх болон холбогдох баримт бичгийг хариуцах;
- Хорооны шийдвэрүүд, тайлан болон бусад баримт бичгийн найруулга зэргийг хариуцах.

Стенограф, протоколын хэлтэс (L1.4)

- Үндэсний Зөвлөл болон Холбооны Зөвлөлийн хуралдааны стенограф бичлэгийг хариуцах;
- Үндэсний Зөвлөл болон Холбооны Зөвлөлийн хуралдааны протоколоос лавлагаа авах, түүнчлэн Хороодын үйл ажиллагааны судалгаанд баримт болгон хэсэгчлэн авах;
- Стенографийн бичлэгийг протоколд буулгах.

Хууль тогтоох цахим процессын төв (E-Legislation) (L1.5)

- Хууль тогтоох процессыг цахим хэлбэрээр явуулах, үйл ажиллагааны явцад холбооны агентлаг болон бусад байгууллагатай он-лайн холбогдон ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тухайн өдрийн батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ажлын төлөвлөгөө хянах, хуулийн тайлбар хянах, ачаалалтай ажилд тусалцаа үзүүлэх, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх.

Парламентын баримт бичиг, архив, статистикийн хэлтэс (L1.6)

- Үндэсний Зөвлөл болон Холбооны Зөвлөлийн стенограф бичлэг болон стенограф бичлэгийн индексийг баримтжуулах, хуулийн төслүүд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг баримтжуулах;
- Архив болон статистик мэдээллийг хөтлөх;

- “Power point” дээрх илтгэл зэрэг техник мэдээллийг бэлтгэх;
- Ардчилал, эрх зүйн салбарын мэдээллийн тойм

Үндэсний Зөвлөлийн ажлын албаны хэрэг эрхлэх газар

- Хууль тогтоох процессийг цахим хэлбэрээр явуулах техникийн хангамж, тухайн өдрийн ажил хэргийн хуваарийг гаргах;
- Хороодын хуралдаан, илтгэлүүдтэй холбогдох баримт ба судалгаа, шинжилгээ зэргээр Үндэсний Зөвлөл, түүний хороодын ажлын явцад туслах;
- Үндэсний Зөвлөлд нэр дэвшүүлэх болон мандатаас татгалзахтай холбоотой асуудлын баримт бичгийн техник үйл ажиллагаанд туслах;
- Протокол хөтлөх, шивэх, компьютерт өгөгдөл оруулах
- Хэвлэх.

Холбооны Зөвлөлийн ажлын алба (L2)

Ерөнхийлөгчийн ажлын алба (L2.1)

- Холбооны Зөвлөл ба Холбооны Зөвлөлийн ерөнхийлөгчийн өдөр тутмын ажилд туслах;
- Холбооны Зөвлөл, байнгын хороодын ажлын хөтөлбөрийг бэлтгэх;
- Холбогдох журмын дагуу явагдах үйл ажиллагаа, хэлэлцэх асуудлуудаар хууль, эрх зүйн болон бусад үйлчилгээ үзүүлэх;

Хуралдаан зохион байгуулах хэлтэс (L2.2)

- Санал хураалтад бэлтгэх;
- Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг Дэгийн тухай хуулийн дагуу явуулах, үг хэлэх хугацааг сахиулах, үг хэлэгчдийн жагсаалтыг асуулгын цагт бэлтгэх,
- Үг хэлэгчдийн жагсаалт гаргах, хуралдааны албан ёсны протокол хөтлөх, Холбооны зөвлөлийн тогтоолын хуулбарыг гаргах;

Хороодын ажлын алба (L2.3)

- Хорооны даргын үйл ажиллагааг Процедурын хуулийн дагуу нарийн зохион байгуулалттай хэрэгжүүлэхэд туслах, хуралдаанд бэлтгэх болон холбогдох баримт бичгийг хариуцах;
- Хорооны шийдвэрүүд, тайлан болон бусад баримт бичгийн найруулга зэргийг хариуцах.
- Мэдээлэл, лавлагаагаар хангах.

Стенограф, протоколын хэлтэс (L2.4)

- Холбооны Зөвлөлийн хуралдааны стенограф бичлэгийг хариуцах;
- Стенографийн бичлэгийг протоколд буулгах.

Парламентын баримт бичиг, архив, статистикийн хэлтэс (L2.5)

- Үндэсний Зөвлөл болон Холбооны Зөвлөлийн стенограф бичлэг хийх болон стенограф бичлэгийг индексжүүлэх, хуулийн төслүүд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг баримтжуулах;
- Архив болон статистик мэдээллийг хөтлөх;
- “Power point” дээрх илтгэл зэрэг техник мэдээллийг бэлтгэх;

- Ардчилал, эрх зүйн салбарын мэдээллийн тойм;
- Парламентын мэдээллийн сангийн техникийг хариуцах;

Эрх зүй, хууль тогтоомж, судалгааны алба (L3)

Үндсэн хуулийн асуудлын хэлтэс (L3.1)

- Үндсэн хуулийн асуудлууд, захиргааны процессийн асуудлууд, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлууд, Үндсэн хуулийн шүүхийн өмнө парламентыг төлөөлөх болон Захиргааны Зөвлөлтэй холбоотой асуудлууд, Европын холбооны хууль зүйн асуудлыг хариуцах;
- Европын интеграцитай холбоотой хууль, эрх зүйн асуудлыг зохицуулах;
- Архив болон статистик мэдээллийг хөтлөх.

Парламент судлалын хэлтэс (L3.2)

- Парламентын асуудлаар шинжлэх ухааны судалгаа хийх;
- Австрийн Үндсэн хууль болон ардчилалын шинэчлэлийн процессийг баримтжуулах;
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, парламентын Тамгын газрын албадын мэдээлэл солилцоог хариуцах (L1 болон L4);
- Эрдэм шинжилгээний төслийн хүрээнд их дээд сургууль, сургалтын байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

Дэг, процедурын хэлтэс (L3.3)

- Захиргааны ажил үүргийг зохион байгуулах;
- Дэг сахиулах журам (Rules of Evidence cases) боловсруулах;
- Процедурын журам,

Парламентын ажлын албаны эрх зүйн асуудлын хэлтэс (L3.4)

- Парламентын Тамгын газраас төрийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой иргэний болон хууль зүйн асуудлууд, нууцтай холбоотой асуудлууд, парламентын Тамгын газрын бусад хэлтсүүдээс хүлээн зөвшөөрөөгүй зохиогчийн эрх болон эрх зүйн бусад асуудлыг хариуцах;

Номын сан (L3.5)

- Тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээлийн (хэвлэмэл, электрон хэлбэр, CD-ROM болон сүлжээний мэдээллийн зэрэг) сан бүрдүүлэх, контент анализ хийх, түгээх;
- Хууль, улс төрийн сэдэвтэй электрон номын сангийн систем бүрдүүлэх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Парламентын мэдээллийн солилцоо хийх;

Мэдээллийн хэлтэс (L3.6)

- Үндэсний болон Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгчдөд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Парламентын бүлгүүд болон парламентын Тамгын газарт мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Тухайн цаг үеийн мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл, судалгаа шинжилгээнд анализ хийх;

Мэдээлэл, олон нийттэй харилцах алба (L4)**Дижитал хэвлэл мэдээлэл, хамтарсан төслийн алба (L4.1)** (*Digital media and corporate design*)

- Парламентын удирдах газрын онлайн үйлчилгээ
- “New Media” зочдын төв
- фото зураг зохион байгуулах
- урлаг, соёл, уран зураг
- хамтарсан төслийн алба /Corporate Design/

Харилцаа холбооны хэлтэс (L4.2)

- иргэдэд үйлчлэх
- хэвлэл мэдээлэлтэй харилцах
- хэвлэн нийтлэх
- олон улсын соёлын уулзалт

Ардчилалыг дэмжих алба (L4.3)

- ардчилалыг дэмжигчид болон залуу парламентчдыг дэмжих

Хэвлэл мэдээллийн хэлтэс (L4.4)

- Парламентын сурвалжлагчдын үйл ажиллагааг зохицуулах;
- Парламентын хуралдааны явцын талаарх мэдээллийг түгээх;
- Хэвлэлд зориулсан парламентын мэдээлэл;
- албан ёсны мэдээлэл;
- хэвлэл мэдээлэлтэй харилцах;

Арга хэмжээ, зочдыг зохицуулах алба (L4.5)

- арга хэмжээ зохион байгуулах;
- зочдод үйлчлэх ажиллагааг зохион байгуулах;

Захиргааны газар (A)Захиргааны алба (A1)**Хүний нөөцийн хэлтэс (A1.1)**

- хүний нөөцийн асуудлууд, шагнал, A1.2b-тэй хамтарч ажиллах;
- боловсон хүчний хуваарилалт;
- мэргэжлийн зааварчилгаа өгөх, үнэмлэх олгох, ажилчдын зэрэг, дэвийн асуудал хариуцах;

Ерөнхий зохицуулалтын хэлтэс (A1.2)**Зохион байгуулалт (A1.2a)**

- бүтэц, процессын зохион байгуулалт
- байгууллагын хөгжил, захиргааны шинэчлэл
- ажил үүргийн хуваарилалт, хуваарь

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

- жендерийн асуудал
- хяналт
- ерөнхий зохион байгуулалт ба удирдлагын асуудал
- ажлын байрны асуудал
- хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа
- эрүүл мэнд, түргэн тусламж
- автомашины зөвшөөрөл, машины зогсоолын асуудал
- дипломат паспорт
- орчуулга

Боловсон хүчний сургалт (A1.2b)

- боловсон хүчний чадавхийг сайжруулах сургалт

Гишүүд, туслахуудын асуудал хариуцсан хэлтэс (A1.3)

- Үндэсний зөвлөл болон Холбооны зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, нөхөн олговор, тэтгэвэр, одон медаль
- Гишүүдийн туслахуудын цалин, урамшуулал, нөхөн олговор, тэтгэвэр, одон медаль

Төсвийн удирдлагын хэлтэс (A1.4)

- санхүү, зээлийн удирдлага
- төлбөр, тооцоо, шилжүүлэг хийх
- нягтлан бодох бүртгэл

Мэдээллийн технологийн хэлтэс (A1.5)

- төлөвлөлт, худалдан авалт, боловсруулалт, суурилуулалт
- Парламентын мэдээлэл, харилцааны систем (PARLINKOM)-ын техникийн үйлчилгээ, түүнд тавигдах шаардлагыг боловсруулах
- Мэдээллийн техниктэй холбоотой бусад асуудал

Үйлчилгээний алба (A2)**Ордны зохион байгуулалт, объектын удирдлага ба тусгай төслийн хэлтэс (A2.1)**

- барилга байгууламж, түүний аюулгүй байдал болон монтаж угсралт
- барилга байгууламжтай холбоотой бусад асуудал

Хамгаалалтын алба (A2.2)

- хамгаалалтын асуудал, хамгаалалтын үйлчилгээ
- дотоод зохион байгуулалтын журмыг боловсруулах
- нэвтрэх үнэмлэх
- хамгаалалтын удирдах төв
- объектын аюулгүй байдлыг хангах болон гал түймэртэй тэмцэх хамгаалалтын болон шуурхай зохион байгуулалттай баг

Байгууламжийн техник удирдлагын хэлтэс (A2.3)

- байгууламж, цахилгаан, халаалт, агааржуулалт, хөргөх төхөөрөмж, сантехник, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, хамгаалалтын технологи, төмрийн ажил, цахилгаан шат, галын дохио, аман орчуулгын хэрэгсэл, түгжээ, түлхүүр зэрэг байгууламжийн техник асуудлын удирдлага, зохион байгуулалт

Аж ахуйн хэлтэс (А2.4)

- техник хэрэгсэл, тавилга, машин болон бусад бараа худалдан авах, засвар үйлчилгээ хийх
- данс бүртгэл
- цэвэрлэгээний үйлчилгээ, гэрийн үйлчилгээ
- мужаан болон засал чимэглэлийн үйлчилгээ
- электрон галерей

Европын холбоо, олон улстай харилцах газар (А3)

Европын холбооны асуудал хариуцсан хэлтэс (А3.1)

- Европын холбооны мэдээллийн бааз;
- Үндэсний зөвлөл, түүний Европын холбооны асуудал хариуцсан байнгын дэд хороо, мөн Холбооны зөвлөлийн Европын холбооны асуудал хариуцсан хороонд дэмжлэг үзүүлэх;
- Европын холбооны төслийг боловсруулах;
- Европын холбооноос хэрэгжүүлж буй төслийн явцыг мэдээлэх, төслийн явцын талаарх тайлан гаргах;
- Европын холбооны улсуудын парламент хоорондын мэдээлэл солилцох;

Европын харилцааны хэлтэс (А3.2)

- Европын нэгдэлийн асуудлаар Парламент хоорондын харилцаа;
- Европын улсуудын үндэсний парламент, хороодын хамтын ажиллагаа;

Олон улсын харилцааны хэлтэс (А3.3)

- Холбооны зөвлөл ба Үндэсний зөвлөлийн ерөнхийлөгч, хороо болон парламентын бүлгүүдийн түвшний харилцаа;
- олон улсын парламент хоорондын харилцаа;
- дээд хэмжээний уулзалтын протокол хөтлөх;


Бага хурал зохион байгуулах, зочид, төлөөлөгчдийг хүлээн авах хэлтэс (А3.4)

- Парламентын Тамгын газрын албадад туслалцаа үзүүлэх;
- хоёр талт, олон талт болон Европын түвшний арга хэмжээг зохион байгуулах;

Олон талт хамтын ажиллагааны хөгжлийн хэлтэс (А3.5)

- Умард-Өмнөд (хөгжингүй болон хөгжиж буй орнууд)-ийн харилцаа;
- хөгжлийн хамтын ажиллагаа;
- олон улсын эмэгтэйчүүдийн асуудал;
- хүний эрхийн асуудал.


АВСТРИЙН ПАРЛАМЕНТЫН УДИРДАХ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



НОРВЕГ**Норвегийн Вант Улс (Kingdom of Norway)**

Парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг Норвег Улсын парламентын үйл ажиллагааг Үндсэн хууль болон парламентын Дэгээр /Stortinget the Norwegian Parliament Rules of Procedure/, парламентын Ажлын албаны үйл ажиллагааг зөвхөн парламентын Дэгээр зохицуулна.

Зураг

**Парламентын ажлын алба**

Стортинг /Норвегийн парламент/-ын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт:

- Стортингийн ажлын алба нь нийт таван газартай ба ойролцоогоор 400 ажилтантай.

Стортингийн Ерөнхий нарийн бичгийн дарга (Secretary General of the Storting)

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Стортингийн ажлын албыг бүхэлд нь удирдан явуулж, Стортингийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэх нарийн бичгийн даргын газар (Executive Secretariat)

Тус газар нь Тэргүүлэгчдэд албан үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Тэргүүлэгчид болон Ерөнхий нарийн бичгийн даргад шаардлагатай хэвлэл мэдээллийн лавлах, хүлээн авах үйлчилгээ, жолоочийн үйлчилгээ зэргийг хариуцан гүйцэтгэнэ.

Үндсэн бүтцийн газар (Constitutional Department)

Тус газар нь Стортингийн процедур, хороодын үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй.

Танхимын ажлын алба (Chamber Secretariat)

Танхимын ажлын алба нь парламентын үйл ажиллагаа, өдөр тутмын ажлыг удирдан зохион байгуулна. Түүнчлэн хороодын зөвлөмжүүдийг бэлтгэх, хэвлэх ажлыг хариуцна.

Байнгын хороодын ажлын алба (Standing Committees Secretariat)

Тус албаны бүтцэд Байнгын хороодын нарийн бичгийн дарга нарын газар ба Байнгын хороодын архив байна. *Байнгын хороодын нарийн бичгийн даргын газар* нь хороодын хурал, сонсгол зэргийг зохион байгуулах, хэвлэл, олон нийтэд зориулсан мэдээллийг бэлтгэх, хороодын өдөр тутмын ажилд бодитой туслалцааг үзүүлэх үүрэгтэй. *Байнгын хорооны архив* нь хороодын үйл ажиллагааны тайлан мэдээг хадгалах, хороодын архивыг Стортингийн архив руу явуулахад бэлтгэх ажлыг хариуцна.

Хороодын ажлын алба (Committee Secretaries)

Хороодоор хуулийн төсөл хэлэлцүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах ба үйл ажиллагаанд нь мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

Ажлын хуваарь, баримт бичгийн алба (Tabling Office)

Стортингийн ажлын хуваарийг зохицуулна. Санал, асуулт, лавлагаа, Стортингийн хэлэлцэх асуудлуудын долоо хоногийн хуваарийг бэлтгэнэ. Мөн Стортингийн хуралдааны үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг бэлтгэнэ.

Баримт бичгийг хянан тохиолдуулах төв (The Word Processing Centre)

Хорооны зөвлөмжид хэвлэхийн өмнө шаардлагатай үг, үсгийн алдаа, дүрэм, техникийн засварыг хийж гүйцэтгэнэ.

Ерөнхий үйлчилгээний газар (General Services Department)

Тус газар нь Стортингийн аюулгүйн алба, техникийн үйлчилгээ, систем, техник технологийн шинэчлэл зэрэг ажилд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

ICT хэлтэс (ICT Section)

ICT хэлтэс нь Стортингийн ажилтнуудад компьютерын суурь мэдээлэл, системийн талаарх сургалт зохион байгуулах ажлыг хариуцна. Мөн хэрэглэгчдэд шаардлагатай компьютерын туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

Аж ахуйн үйлчилгээний хэлтэс (Housekeeping Services Section)

Аж ахуйн үйлчилгээний хэлтэс нь цэвэрлэгээ, цэцэрлэгжүүлэлт, тохижуулалт, хурлын өрөөний үйлчилгээ, зочид буудлын үйлчилгээ зэргийг хариуцна.

Аюулгүйн албаны хэлтэс (Security Section)

Аюулгүйн алба нь барилга, байгууламжийн аюулгүй байдал, хүлээн авалтын аюулгүй байдал, машины зогсоол, орох, гарах зөвшөөрөл, гэнэтийн аюул, дохиоллын хэрэгсэлтэй холбоотой асуудлыг хариуцна.

Техникийн хэлтэс (Technical Section)

Техникийн хэлтэс нь техник, харилцаа холбооны тоног төхөөрөмжийг суурилуулан ажиллуулах, барилга байгууламжийг шинэчлэх зэрэг ажлыг хариуцна. Түүнчлэн шаардлагатай тавилга хэрэгслийг худалдан авах зэрэг тохижилтын асуудлыг хариуцна.

Захиргааны газар (Administrative Affairs Department)

Захиргааны газар нь Стортингийн захиргааны менежментэд туслалцаа үзүүлэх, ажилтнуудын үүрэг, хүний нөөц, санхүү, ерөнхий захиргааны зэрэг асуудлыг хариуцна. Түүнчлэн Стортингийн гишүүдийн цалин, нөхөн төлбөр, албан томилолт, орон байр, тэтгэвэр, тэтгэмж, даатгал, ажиллах нөхцөл зэрэг асуудлыг хариуцна.

Эрүүл мэндийн алба (Occupational Health Services)

Эрүүл мэндийн алба нь Стортингийн гишүүд, ажилтнууд, Төрийн захиргааны Стортингийн Омбудсмэны албан хаагчид, парламентын Төрийн мөрдөн шалгалтын ерөнхий захирал болон түүний офисийн албан хаагчдад холбогдох дүрэм, журмын дагуу эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Үүнд, эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээ, вакцинжуулалт, ажлын байрны эрүүл ахуйн зэрэг үйлчилгээ хамаарна.

Хүнсний хангамжийн үйлчилгээний хэлтэс (Catering Services Section)

Уулзалт, арга хэмжээ болон өдөр тутмын хоолны үйлчилгээ үзүүлнэ.

Хүний нөөцийн хэлтэс (Human Resources Section)

Хүний нөөцийн хэлтэс нь хүний нөөц, захиргаа, цалин тооцоо, ажлын орчин нөхцөл, сургалтын асуудлыг хариуцна.

Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс (Accounting Section)

Тус хэлтэс нь нягтлан бодох бүртгэл, цалин тооцоо, бэлэн мөнгөний үйлчилгээ (зарлага, нөхөн төлбөр, томилолтын зардал) зэрэг асуудлыг хариуцна.

Албан томилолт хариуцсан алба (Travel Office)

Тус алба нь тийз болон зочид буудлын урьдчилсан захиалга хийх, даатгал, гадаад валютын зэрэг асуудлыг хариуцна.

Санхүү, захиргааны хэлтэс (Finance & Administration Section)

Санхүү, захиргааны хэлтэс нь Стортингийн захиргааны төсөв, санхүү, худалдан авалттай холбоотой асуудлыг хариуцна. Гишүүдэд захиргааны туслалцаа үзүүлэх, ерөнхий захиргааны үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн гишүүдийн орон сууц, ахуйн үйлчилгээний комиссын ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

Мэдээлэл, баримт бичгийн газар (Information and Documentation Department)

Тус газар нь Стортингийн үйл ажиллагааны тэмдэглэлийг хөтлөх, бэлтгэх, хадгалах үүрэгтэй. Түүнчлэн Стортингийн ажилд туслалцаа үзүүлэхээр Үндэсний ассамблейд гадаад, дотоод мэдээллийг гарган өгөх үүрэгтэй.

Хүргэлт, хүлээн авалтын хэлтэс (Messenger and Reception Services Section)

Тус хэлтсийн гүйцэтгэх ажилд хүлээн авах, захидал, хүргэлт, телефоны үйлчилгээ хамаарна.

Хэвлэлийн алба (Printing Services)

Хэвлэлийн алба нь график дизайн, хэвлэх, хувилах, олшруулах үйлчилгээ, протокол бэлтгэх зэрэг асуудлыг хариуцна. Мөн офиссын тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зэрэг үйлчилгээг үзүүлнэ.

Албан ёсны тайлан, мэдээний хэлтэс (Official Reporters' Section)

Стортинг, Гадаад хэрэг, батлан хамгаалахын өргөтгөсөн Байнгын хороо, Нордикийн зөвлөлийн хуралдааны протоколыг хөтлөх, редакторлах, баримт бичгийн боловсруулалт хийх, нягтлах үүрэгтэй.

Мэдээллийн хэлтэс (Information Section)

Ерөнхий мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, зочдод ордон танилцуулах ажлыг хариуцна. Түүнчлэн мэдээлэл, сургалтын материал бэлтгэх, Стортингийн вэб хуудас, дотоод сүлжээний асуудлыг хариуцна.

Стортингийн архив (Archives of the Storting)

Энэ нь Стортингийн гол архив бөгөөд парламентын үйл ажиллагаанд баримт бичгийн болон архивын үйлчилгээ үзүүлнэ. Мөн Стортингийн уран зураг, хөрөг зургийн галерейн ажлыг хариуцна.

Стортингийн номын сан (Library of the Storting)

Номын сангийн үйлчилгээнээс гадна ном, тайлан, тогтмол хэвлэл, сонинг фондод авах, гадны мэдээллийн сангуудаас хайлт хийх, радио, телевизийн бичлэг үзэх, хуулж авах зэрэг үйлчилгээний ажлыг хариуцна.

Судалгааны хэлтэс (Research Section)

Гишүүд, байнгын хороод, намын ажлын албадад экспертийн туслалцаа үзүүлнэ.

Олон улсын харилцааны газар (International Department)

Тус газар нь Стортингийн олон улсын харилцаатай холбоотой ажлыг хариуцна.

Олон улсын харилцааны асуудлаарх нарийн бичгийн даргын газар (The International Secretariat)

Тус ажлын алба нь гишүүдэд олон улсын харилцааны асуудлаар экспертийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэхээс гадна парламентын төлөөлөгчдийн айлчлал, олон улсын байгууллагууд дахь байнгын төлөөлөгчидтэй харилцах асуудлыг хариуцна.

Нордикийн зөвлөлийн нарийн бичгийн даргын газар (Nordic Council Secretariat)

Нордикийн зөвлөлд суугаа Стортингийн төлөөлөгчдийн газрын ажлын албаны үүргийг гүйцэтгэж, үйл ажиллагааны болон экспертийн туслалцаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ.

СЕРБИ - Бүгд Найрамдах Серби Улс (Republic of Serbia)**Үндэсний Ассамблейн Ажлын алба (National Assembly Support Service)**

Бүгд Найрамдах Серб Улсын Үндэсний ассамблейд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага нь Үндэсний ассамблейн Ажлын алба байна.

Ажлын албаны эрх зүйн үндэс нь холбогдох хууль, журам, шийдвэрээр тогтоогдсон байна. Тухайлбал, “Үндэсний ассамблейн тухай хууль”-ийн 20-р бүлгийн 292-р зүйл болон “Үндэсний ассамблейн үйл ажиллагааны журам”-ын 3-р бүлгийн 35-р зүйлд зааснаар Үндэсний ассамблейд үйлчлэх байгууллагыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах ба Үндэсний ассамблей болон Үндэсний ассамблейн даргын өмнө ажлаа хариуцна. Ерөнхий нарийн бичгийн дарга нь хоёр орлогчтой байна. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дээрх хууль, журам болон Үндэсний ассамблейн бусад хууль тогтоомжид заасан дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн дарга болон дэд даргад чуулганд бэлтгэхэд туслах
- Үндэсний ассамблейн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд анхаарч ажиллах
- Үндэсний ассамблейн Ажлын албыг удирдах
- Хууль болон журмаар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэсний ассамблейн Ажлын албаны үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, ажилтан ажиллагсдын албан тушаал болон ажлын чиг үүрэг, тус байгууллагын үйл ажиллагааг хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай бусад асуудлуудыг “Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр”¹¹ хэмээх баримт бичгээр зохицуулсан байна.

Үндэсний ассамблейн Ажлын алба нь Үндэсний ассамблей, түүний Байнгын хороод, парламентын гишүүд, Ассамблейн дарга, дэд дарга нар болон парламент дахь бүлгүүдэд мэргэжлийн болон шинжээчийн зөвлөгөө өгөх үүрэгтэйгээс гадна Бүгд Найрамдах Улсын сонгуулийн хороонд тодорхой үйлчилгээнүүдийг үзүүлнэ.


Ажлын албаны ажилтнуудын эрх, үүргийг төрийн албан хаагчдын тухай хууль, хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, төрийн байгууллагын ажилтан албан хаагчидтай байгуулдаг улсын эрх бүхий байгууллагуудын тусгай гэрээгээр зохицуулна. Ерөнхий нарийн бичгийн дарга Ажлын албаны дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг батална. Мөн Үндэсний ассамблейн төсвийн төсөл боловсруулах ба Үндэсний ассамблей болон Ажлын албаны санхүү, материаллаг баазын удирдлагын үйл ажиллагааг эрхэлнэ.

*Үндэсний ассамблейн Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт*¹²

Зураг

¹¹ The Decision on the Organisation and Operation of the National Assembly Support Service (Official Gazette of RS No. 62/06)

¹² Схемд адил статустай нэгжийг нэг өнгөөр тэмдэглэв.



Ажлын алба нь:

- Үндэсний ассамблейн Тамгын газар
- Үндэсний ассамблейн даргын Кабинет
- Байнгын хороодын асуудал хариуцсан сектор
- Олон улсын харилцааны сектор
- Үндэсний ассамблейн Чуулган зохион байгуулах сектор
- Зохион байгуулалт, Клеркийн сектор
- Санхүү, материал хангамжийн сектор
- Хөрөнгө оруулалт, техник ашиглалтын сектор
- Парламентын бүлгүүдийн ажлын алба

гэсэн зохион байгуулалтын нэгжтэй байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газар

Үндэсний ассамблейн Тамгын газар нь Ажлын албаны захиргаа, олон нийттэй харилцах, хүний нөөц болон протокол үйлчилгээний зэрэг чиг үүргийн нэгдмэл цогц үйл ажиллагааг хангаж ажиллана. Үндэсний ассамблейн Тамгын газар нь дараах бүтцийн нэгжүүдтэй.

Үүнд:

- Хүний нөөцийн хэлтэс
- Олон нийттэй харилцах хэлтэс
- Ёслолын хэлтэс
- Дотоод аудит

гэсэн 4 хэлтэс байна.

Хүний нөөцийн хэлтэс нь “Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр”-т зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хэлтсийн ажилтнууд болон захиргааны үйл ажиллагааг хөтлөн явуулахаас гадна Үндэсний ассамблейн Ажлын алба, түүний үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, хэрэгжүүлэх;
- Ажлын албаны ерөнхий баримт бичиг, Үндэсний ассамблейн байгуулсан гэрээний санал болон ажилтнуудын ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулах;
- Ажилтнуудын ур чадвар, багаар ажиллах чадвар зэргийг хянах;
- Ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхтэй холбоотой сургалт, семинар зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, ажилтнуудын ажил эрхлэлттэй холбоотой баримт бичгүүдийг боловсруулах;
- Ажиллагсдын эрүүл мэнд, тэтгэвэр, тэтгэмж болон хөдөлмөрийн чадвар алдсаны даатгал

зэрэг асуудлыг хариуцан ажиллана. Тус хэлтсийн бүтцэд Эрсдэлийн удирдлагын хэсэг ажиллана.

Олон нийттэй харилцах хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх;
- Дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрийн мэдээ, мэдээлэлд мониторинг хийх;
- Үндэсний ассамблейн үйл ажиллагаа, ордонтой иргэд, олон нийтэд танилцуулах зэрэг үйл ажиллагааг хариуцна.

Ёслолын хэлтэс нь Үндэсний ассамблейн ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа болон уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, Ассамблейн дарга, дэд дарга, гишүүд болон бусад албан хаагчдын дотоод, гадаад айлчлалын төлөвлөгөөг бэлтгэн зохион байгуулах ба бусад улс орны дипломат төлөөлөгчид, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчидтэй харилцах, орчуулгын үйлчилгээ үзүүлэх зэрэг дүрэм, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэсний ассамблейн даргын кабинет

Үндэсний ассамблейн даргын зөвлөл нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний Ассамблейгаар хэлэлцэгдэж буй болон Хурлын дарга, дэд дарга нарт өргөн барьсан бусад хууль тогтоомжийн төсөлд боловсруулалт, анализ хийх;
- Үндэсний Ассамблейн дарга болон төрийн байгууллагууд, олон улсын байгууллага, хүрээлэнгүүдийн хоорондын хамтын ажиллагааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үндэсний Ассамблейн дарга, дэд дарга нарын албаны айлчлал, олон нийттэй уулзах уулзалт зохион байгуулах талаар зөвлөгөө өгөх болон аналитик үйлчилгээ үзүүлэх;
- Дарга, дэд дарга, парламентын гишүүд, гадаадын зочид, төлөөлөгчдийн хурал цуглааны материал, санамж бичиг зэргийг бэлтгэх, хариуцан зохион байгуулах;
- Үндэсний Ассамблей болон Ажлын албанаас гадаад, дотоодын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаатай холбогдуулан явуулж буй үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үндэсний Ассамблейн дарга, дэд дарга нарт шаардлагатай мэдээлэл, бусад материалуудыг түүвэрлэх, эмхтгэх, Үндэсний Ассамблей дахь парламентын бүлгүүдэд хандсан зөвлөгөө болон албаны үйлчилгээ үзүүлэх;
- Иргэдтэй харилцах, иргэд парламентад зочлох үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох.

Үндэсний ассамблейн Чуулган зохион байгуулах сектор

Чуулган зохион байгуулах сектор нь Үндэсний ассамблейн чуулганы хуралдааны бэлтгэл болон явцын ажлыг гүйцэтгэхээс гадна чуулганаар батлагдсан олон улсын гэрээг хэвлэлд бэлтгэх, хууль зүйн нэр томъёоны болон бичвэрийн засвар хийх, Үндэсний ассамблейгаас баталсан хуулиудыг хянан тохиолдуулах, хуралдааны товч тэмдэглэлүүдийг редакторлох, хэвлэх; парламентын асуулгуудыг томъёолох зэрэг албаны болон мэргэжлийн бусад үүргийг гүйцэтгэнэ.

Тус сектор нь хоёр хэлтэстэй. Үүнд:

- *Үндэсний ассамблейн Чуулганы зохион байгуулах хэлтэс*
- *Хуралдааны тэмдэглэл хөтлөх хэлтэс*

байна.

Үндэсний ассамблейн Чуулган зохион байгуулах хэлтэс нь “Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр”-т зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн чуулганы хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах, хуралдаанд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг цуглуулах, бэлтгэх;
- Үндэсний ассамблейн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- Үндэсний ассамблейн чуулганаар батлагдсан хууль тогтоомжуудыг “Бүгд

- Найрамдах Серби Улсын Төрийн сонин”-д хэвлүүлэхэд бэлтгэх;
- Үндэсний ассамблейгаас баталсан хуулиудын эх хувийг бэлтгэх;
- Үндэсний ассамблейн хуралдааны хөтөлбөр, цагийн хуваарийг боловсруулах, хуралдааны товын талаар гишүүдэд мэдээлэл өгөх;
- Хуралдаанаар батлагдсан олон улсын гэрээг хэвлэлд бэлтгэх;
- Үндэсний ассамблейн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай албаны болон мэргэжлийн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Хуралдааны тэмдэглэл хөтлөх хэлтэс нь “Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр”-т зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн хуралдааны хэлэлцүүлгийн бүх тэмдэглэлийг “Хуралдааны тэмдэглэл” цуврал хэвлэлд хэвлэхээр хянах;
- Зөвшөөрөгдөөгүй тэмдэглэлүүдийн үг үсэг, найрлагыг дахин боловсруулж, зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулах;
- Хууль зүйн болон бичвэрийн хяналт хийх;
- Парламентын асуулгын төсөлд хууль зүйн болон бичгийн томъёололын хяналт хийх;
- Хуралдааны тэмдэглэлүүдээр ном товхимол бэлдэж гаргах;
- Хянан зөвшөөрөгдсөн тэмдэглэлүүдийг хэвлэхэд бэлтгэх;
- Агуулгын график дизайн, агуулга болон илтгэгчдийн бүртгэлийг бэлтгэх;
- Үндэсний ассамблейн удирдлагын хорооноос зөвшөөрсний дагуу хэвлэгдэн гарсан хуралдааны бичлэгийн товхимолыг хэрэглэгчдийн хаягийн бүртгэлийг гаргах;
- Хуралдааны тэмдэглэлийн архив, мэдээллийн санг үүсгэж хадгалах зэрэг үндсэн үүрэг болон холбогдох дүрэм, журамд заасан бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Байнгын хороодын асуудал хариуцсан сектор

Тус сектор нь холбогдох шийдвэрт заасан дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Байнгын хороодын хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах;
- Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэгдсэн асуудлуудтай холбоотой баримт бичиг, мэдээ бэлтгэх, тайлан бичих;
- Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж буй асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг томъёолон бэлтгэх;
- Байнгын хороодоос гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Иргэд, байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авах;
- Үндэсний ассамблейгаас баталсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын танилцуулга, тайлан бичих;
- Санаачилсан хууль тогтоомжийн төсөл Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргахад зориулан санал, тайлбар бэлтгэх, холбогдох мэдээллийг харьцуулах;
- Иргэд, байгууллагуудаас гаргасан өргөдөл, санал, хүсэлтэд хариу өгөхөд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- Хууль тогтоомж болон хуулийн төсөлд анализ хийх;
- Үндэсний ассамблей, түүний байнгын хороод болон гишүүдэд шаардлагатай бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Байнгын хороодын асуудал хариуцсан сектор нь дараах 4 хэлтэстэй байна. Үүнд:

- *Хууль зүйн хэлтэс*
- *Эдийн засгийн харилцаа, санхүүгийн хэлтэс*
- *Батлан хамгаалах, Үндэстний асуудлын хэлтэс*
- *Нийгмийн бодлогын хэлтэс*

Хууль зүйн хэлтэс нь Үндсэн хуулийн байнгын хороо, Хууль тогтоомжийн хороо, Захиргааны хороо, Эрх зүй, захиргааны хороо, Нутгийн өөрөө удирдах байгууллагын хороо болон Өргөдөл, саналын хорооны эрх мэдлийн хүрээн дэх үүргийг гүйцэтгэнэ.

Эдийн засгийн харилцаа, санхүүгийн хэлтэс нь Санхүүгийн хороо, Өмч хувьчлалын хороо, Аж үйлдвэрийн хороо, Хөдөө аж ахуйн хороо, Худалдаа, аялал жуулчлалын хороо, Тээвэр, харилцаа холбооны хороо болон Хот төлөвлөлт, барилга, эдийн засгийн шинэчлэлийн хороодын эрх мэдлийн хүрээн дэх асуудлуудыг хариуцан ажиллана.

Батлан хамгаалах, Үндэстний асуудлын хэлтэс нь Батлан хамгаалах, аюулгүй байдлын хороо, Үндэстэн хоорондын харилцааны хороо, Косово-Метохияагийн асуудал хариуцсан хороо, Гадаадад оршин сууж буй сербүүдийн асуудал хариуцах хороо болон Аюулгүй байдлын албадын хяналтын хороодын эрх мэдлийн хүрээн дэх асуудлуудыг хариуцан ажиллах үүрэгтэй.

Нийгмийн бодлогын хэлтэс нь Эрүүл мэнд, гэр бүлийн хороо, Ядуурлыг бууруулах хороо, Соёл, мэдээллийн хороо, Боловсролын хороо, Шинжлэх ухаан технологийн хөгжлийн хороо, Хөдөлмөр, цэргийн алба хаагсад болон нийгмийн асуудлын хороо, Байгаль орчны хороо, Залуучууд, спортын хороо болон Жендерийн эрх тэгш байдлын хороодын эрх мэдлийн хүрээний асуудлуудыг хариуцаж ажиллана.

Парламентын бүлгүүдийн ажлын алба

Парламентын бүлгийн ажлын алба нь дүрэм, журамд заасан заасан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хууль болон хуулийн төслүүдэд анализ хийх;
- Парламентын бүлгүүдээс Үндэсний ассамблейд уламжилсан хуулийн төсөл, тогтоол, шийдвэр, тунхаглал, зөвлөмж зэрэг эрх зүйн актуудын талаар санал боловсруулах;
- “Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны журам”-д зааснаар парламентын гишүүдэд хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт болон бусад хууль эрх зүйн актын талаар санал боловсруулахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх, саналыг бэлтгэх;
- Иргэд байгууллагуудаас парламентын бүлэгт хандан гаргасан өргөдөл, санал, хүсэлтийг хариуцах;
- Парламентын гишүүдээс иргэд, байгууллагын төлөөлөгчидтэй хийх уулзалтыг зохион байгуулах;
- Парламентын бүлэг болон гишүүдэд шаардлагатай бусад мэргэжлийн болон захиргааны асуудлыг хариуцна.

Олон улсын харилцааны сектор

Олон улсын харилцааны сектор нь холбогдох дүрэм, журамд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай харилцахтай холбоотой баримт бичгийг бэлтгэх, үйл ажиллагааг зохион байгуулах;
- Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд Үндэсний ассамблейн төлөөлөгчид оролцох ажлыг зохион байгуулах, туршлага судлах судалгааны багийн айлчлалыг зохион байгуулах болон гадаадын төлөөлөгчдийн айлчлал, судалгааны багийг хүлээн авах;
- Үндэсний ассамблей, түүний байнгын хороодод айлчилж буй гадаадын болон олон улс, бүс нутгийн байгууллагын зочид төлөөлөгчдөд зориулан танилцуулгын материал бэлдэх гэх мэт үүрэг гүйцэтгэхээс гадна гадаад харилцааны бодлогын эрх зүйн орчинтой холбоотой аливаа асуудлыг европын холбооны хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс хууль тогтоомж болон бусад эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах, хяналт тавих үүрэгтэй.

Олон улсын харилцааны сектор нь дараах хоёр хэлтэстэй байна. Үүнд:

- *Гадаад харилцааны хэлтэс*
- *Европын интеграцийн хэлтэс*

Гадаад харилцааны хэлтэс нь Гадаад харилцааны байнгын хороо, Олон улсын эдийн засгийн харилцаа, хөгжлийн хороо, Найрамдлын бүлгүүд болон байнгын ба бусад төлөөлөгчдийн асуудал хариуцсан бүлгийн эрх мэдлийн хүрээн дэх асуудлуудыг хариуцаж ажиллана.

Европын интеграцийн хэлтэс нь Европын интеграцийн байнгын хорооны эрх мэдлийн хүрээний асуудлыг хариуцан ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

Зохион байгуулалт, Клеркийн сектор

Тус сектор нь Клеркийн албаны ерөнхий үүргийг хэрэгжүүлэхээс гадна бараа, бүтээгдэхүүн худалдан авах болон мэдээлэл, судалгаа, номын сангийн үйлчилгээ, Үндэсний ассамблей дахь цахим санал хураалтын систем, компьютерийн сүлжээ, цахилгаан холбооны системийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг хариуцан ажиллана. Дараах 4 хэлтэстэй. Үүнд:

- *Ерөнхий ажлын хэлтэс*
- *Бараа, үйлчилгээ худалдан авах хэлтэс*
- *Мэдээлэл, судалгаа, номын сангийн хэлтэс*
- *Мэдээллийн технологийн хэлтэс*

Ерөнхий ажлын хэлтэс нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: Үндэсний ассамблейн ажил үүрэгтэй холбоотой бичиг баримтуудыг хүлээж авах, илгээх, архивлах, зарлага, бичээч, тэмдэглэл хөтлөгч, шаардлагатай бичиг баримт материалыг бэлдэх, хэвлэх, олшруулах болон тээвэр үйлчилгээний зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Тус хэлтэс нь дараах 5 албатай байна. Үүнд:

- *Клеркийн офис, хүргэлт*
- *Бичлэгийн хэлтэс*
- *Түргэн бичлэг*
- *Захиргаа*
- *Тээвэр үйлчилгээ*

Бараа, үйлчилгээ худалдан авах хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн хэрэгцээт ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Өмчийн худалдааг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийг бэлтгэх, улсаас зарласан бусад худалдан авалтыг удирдан явуулах,
- Эрх бүхий байгууллагуудад худалдан авалттай холбоотой тайлан бэлтгэж хүргүүлэх, улсын бараа, үйлчилгээ худалдан авах гэрээнүүдийн бүртгэлийг хөтлөх, бараа үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлтэнд хяналт тавих, үнэлгээ хийх зэрэг болно.

Мэдээлэл, судалгаа, номын сангийн хэлтэс нь “Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр”-т зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаатай холбогдуулан мэргэжлийн болон шинжээчийн судалгаа, мэдээллээр хангах;
- Үндэсний ассамблейн хуралдаанаар хэлэлцэгдэж буй асуудлаар парламентын гишүүд болон байнгын хороодод мэргэжлийн харьцуулсан судалгааны үйлчилгээ үзүүлнэ.

Мэдээлэл судалгаа, номын сангийн хэлтэс нь дараах 2 албатай. Үүнд:

- *Мэдээлэл судалгааны алба*
- *Номын сан*

Мэдээллийн технологийн хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Харилцаа холбооны систем, бусад цахим системийг боловсронгуй болгох, сайжруулах програмуудыг бэлтгэх, утсан харилцаа, хурлын хэлэлцүүлгийн систем, дотоод телевизийн ажиллах горимыг тохируулах, тэдгээрийн засвар үйлчилгээг хариуцах;
- Хуралдааны танхимын дуу авианы системийг хянах, хуралдааны явцыг бичих,
- Үндэсний ассамблейн компьютерийн сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, Үндэсний ассамблейн веб хуудас ашиглалт, засвар үйлчилгээ, веб хуудсыг хөгжүүлэх, сайжруулахтай холбоотой үйл ажиллагааг хариуцан ажиллах;
- Үндэсний ассамблейг цахим шуудангийн систем болон бусад програмаар хангах, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах болон эдгээртэй холбоотой бусад үүргийг гүйцэтгэнэ.

Мэдээллийн технологийн хэлтэс нь дараах 2 албатай байна. Үүнд:

- *Цахим системийн алба*
- *Компьютерийн сүлжээ, интернэт, харилцаа холбооны алба*

тус тус ажиллана. Цахим системийн алба нь дотроо Зохион байгуулалт, хөгжлийн бүлэгтэй байна.

Санхүү, материал хангамжийн сектор

Санхүү, материал хангамжийн сектор нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Материалын хэрэгцээг төлөвлөх;
- Яаралтай өр төлбөрийн бүртгэлийг хөтөлж, төлж барагдуулах,
- Жилийн эцсийн болон улирлын зарлагын тайлан гаргах, санхүүгийн тайлан

бүртгэл, тайлагнах эд хөрөнгө, жижиг бараа материал зэргийн бүртгэлийг хөтлөх, ажилчдын цалин болон бусад төлбөрийг тооцох, төлөх;

- Шаардлагатай бараа материалыг худалдан авах, хадгалах, нөөцлөх болон тэдгээрийн бүртгэлийг хөтлөх, санхүүгийн болон бараа материалын шилжүүлгийн тайлан мэдээг бэлтгэх, дүгнэх зэрэг холбогдох дүрэм, журмаар тогтоосон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тус сектор нь дотроо Төсөв, төлөвлөлт, шинжилгээний бүлэгтэй.

Хөрөнгө оруулалт, техник ашиглалтын сектор

Хөрөнгө оруулалт, техник ашиглалтын сектор нь Үндэсний ассамблейн ашиглаж буй барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээ, барилгын болон өргөтгөлийн ажил үйлчилгээ, сэргээн засах, шинэ технологи нэвтрүүлэх, нөхөн сэргээлт хийх гэх мэт ажлыг гүйцэтгэхээс гадна эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллах үндсэн чиг үүрэгтэй. Тус сектор нь дараах 2 хэлтэстэй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын хэлтэс
- Техник ашиглалтын хэлтэс

Хөрөнгө оруулалтын хэлтэс нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үндэсний ассамблейн техник, технологийн одоогийн байдлыг дүгнэх;
- Урт болон богино хугацааны техникийн төлөв байдлыг тодорхойлох, төлөвлөх;
- Урт болон богино хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;
- Урт болон богино хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, тендер зарлах, улсын соёлын өвийг ашиглах, хамгаалахтай холбоотой асуудлууд болон барилгын гадаад, дотоод дизайн, шинээр барилга, өргөтгөл барих, тоног төхөөрөмж, бусад үл хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээний зэрэг асуудлыг хариуцна.

Техник ашиглалтын хэлтэс нь холбогдох дүрэм, журамд заасан дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд: үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмж, барилгын агааржуулалтын болон ус зайлуулах систем зэргийн техникийн болон урсгал засвар үйлчилгээг явуулах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах зэрэг үйлчилгээг хариуцна. Тус хэлтэс нь дотроо эрүүл ахуйн албатай байна.

Ашигласан материал, мэдээллийн эх сурвалжийн жагсаалт:

Нэг. Судалгааны ном, товхимол

А. монгол хэл дээр:

1. Дэлхийн улс гүрний товч лавлах. УБ., 2006 он
2. Монгол Улсын Парламент. 1 -р боть УБ., 2005 он
3. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2009 он /Ханс-Зайделийн сан, Эрх зүйн боловсролын академи/
4. Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлал. 1, 2, 3 -р дэвтэр УБ., 2004 он
5. Дэлхийн улс орнуудын парламент. Улсын Их Хурлын Судалгааны төв, УБ., 2010 он
6. Бүгд Найрамдах Франц Улсын Парламентын үйл ажиллагааны туршлага /Мэдээлэл, лавлагаа/ Ю.Эрдэнэтуяа, Д.Мягмарцэрэн, А.Пагма. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ.

7. Австрали улсын парламентын тамгын газрын үйл ажиллагааны туршлага (Мэдээлэл, лавлагаа) Ц.Норовдондог, Ц.Болормаа, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ.
8. Хууль тогтоох чиглэлийн судалгаа ба дүн шинжилгээ (АНУ-ын Конгрессийн судалгааны албаны туршлага) Ц.Норовдондог, Ц. Батбаяр, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ.
9. Турк улсын Парламентын Тамгын газрын үйл ажиллагааны туршлага Д.Ариунаа, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ.
10. Япон Улсын Үндсэн хууль. Орчуулсан П.Амаржаргал, УБ., 2011 он
11. Парламентын тухай хууль /The Diet Law/

Б. гадаад хэл дээр

12. Amarsanaa J. Contitutionalism and Constitutional review in Mongolia, Ulaanbaatar, 2009
13. THE GERMAN BUNDESTAG, – FUNCTIONS AND PROCEDURES , Organisation and working methods, The legislation of the Federation, By Susanne Linn and Frank Sobolewski, 2010, Edition, NDV

Хоёр. Судалгааны өгүүлэл

1. Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн төсөлд холбогдох судалгаа, бусад орны туршлага. Бодлогын судалгаа, шинжилгээ судалгааны эмхтгэл, IV боть, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ., 2010, 155-182 дахь тал
2. Г.Чулуун, Ю.Эрдэнэтуяа. Парламентын хяналт ба шалгалт. Бодлогын судалгаа, шинжилгээ, судалгааны эмхтгэл, IV боть, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ., 2010, 182-197 дахь тал
3. Ц.Товуусүрэн. Сонгуулийн эрх зүйн тогтолцооны онол, арга зүйн үндэслэл, зохистой хувилбарыг сонгох зарчим. Бодлогын судалгаа, шинжилгээ, судалгааны эмхтгэл, V боть, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв, УБ., 2010, 90-108 дахь тал

Гурав. Цахим мэдээллийн эх сурвалж, хаяг:

1. <http://www.diputados.gob.mx/inicio.htm>
2. <http://www.senado.gob.mx/>
3. <http://www.diputados.gov.ar/>
4. <http://www.senado.gov.ar/>
5. <http://www.parl.gc.ca/>
6. <http://pdba.georgetown.edu/Constitutions/constudies.html>
7. <http://web.eduskunta.fi>
8. <http://www.shura.gov.sa/>
9. <http://www.stortinget.no/>
10. <http://www.stortinget.no/Global/pdf/>
11. http://www.tbmm.gov.tr/english/about_tgna.htm
12. <http://www.parliament.gov.sg/parliament-secretariat>
13. <http://www.ipu.org>
14. <http://www.pdba.georgetown.edu>
15. <http://www.constitution.garant.ru>
16. <http://www.servat.unibe.ch>
17. <http://www.imf.org>
18. <http://www.state.org>
19. <http://www.infoplease.com>
20. <http://www.mapsofworld.com>
21. <http://www.countrystudies.us>
22. <http://www.constitution.org>

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

23. <http://www.cia.gov>
24. <http://confinder.richmond.edu>
25. <http://www.lexadin.nl>
26. <http://www.europarl.europa.eu>
27. <http://www.african-ipu.org>
28. <http://www.arab-ipu.org>
29. <http://www.appf.org.pe>
30. <http://www.parlacen.org.gt>
31. <http://www.cpahq.org>
32. <http://www.solon.org>
33. <http://www.bundestag.de>
34. <http://www.parliament.gov.sg/parliament-secretariat>
35. http://korea.assembly.go.kr/int/org_01.jsp?leftid=AA#skipNavigation
36. <http://korea.assembly.go.kr/int/sup.jsp?leftid=DA>
37. http://www.npc.gov.cn/englishnpc/Organization/node_2850.htm
38. <http://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm>
39. http://www.shugiin.go.jp/index.nsf/html/index_e_guide.htm
40. Lok Sabha Secretariat (Recruitment and Conditions of Service) Rules, 1955



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Д. Жигваагүнсэл, О. Нарантуяа, Ө. Мөнхтунгалаа

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актуудын талаарх лавлагаа мэдээллийг Судалгааны төвийн референт - судлаач Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа, Ө.Мөнхтунгалаа нар хийж гүйцэтгэв.

Судалгаа мэдээллийн зорилго нь Улсын Их Хурлын Тамгын газрын статус, чиг үүргийг тодорхойлсон Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа төрийн албаны үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн актуудын талаарх мэдээллийг бэлтгэх. /Хавсралт1,2/

Судалгааны мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлсэн байдал: Лавлагаа мэдээллийг УИХ-ын Тамгын газрын статус, чиг үүргийг тодорхойлсон Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, сайд, агентлагын даргын тушаал зэрэг эрх зүй актууд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, УИХ-ын гишүүд, зөвлөх, туслах болон бие төлөөлөгч-туслахуудын зайлшгүй судлах зүйлсийн жагсаалт 2011, төрийн албаны тухай эрх зүйн баримт бичгийн эмхтгэл зэрэг материалуудаас ашиглав.

УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгүүд: Монгол Улсын Их Хурлын 2002 оны тогтоолоор Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах Стратеги төлөвлөгөөг баталсан. Энэхүү стратеги төлөвлөгөөний хүрээнд УИХ-ын Тамгын газрын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бүтэц, зохион байгуулалт, үндсэн чиг үүргийг боловсронгуй болгох дүрмийг баталснаар УИХ-ын Тамгын газрын статусыг тодорхойлжээ.

УИХ-ын Тамгын газар нь төрийн албаны үйл ажиллагааг зохицуулсан нийтлэг үйлчлэл бүхий 17 хууль, /Хүснэгт1/ тэдгээрийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн УИХ-ын тогтоол болон УИХ-ын даргын 9 захирамж, /Хүснэгт 2.1./ Засгийн газрын 9 тогтоол, /Хүснэгт 2.2./ Төрийн албаны зөвлөлийн 3 тогтоол, /Хүснэгт 2.3/ УИХ-ын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 19 захирамж, /Хүснэгт 2.4./ сайд, агентлагын даргын баталсан 17 тушаал /Хүснэгт 2.5./ буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 74 эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. /Хүснэгт 1-6/

Хүснэгт 1. Хууль эрх зүйн актын лавлагаа

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
	Монгол Улсын Их Хурлын тухай хууль	2006-01-26
	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	2007-10-11
	Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль	2001-11-08

Үндэсний Аюулгүй байдлын тухай хууль	2001-12-27
Төрийн албаны тухай хууль	2002-06-28
Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль	2002-06-27
Төрийн нууцын тухай хууль	1995-04-18
Төрийн нууцын жагсаалт батлах тухай	2004-01-02
Байгууллагын нууцын тухай хууль	1995-05-16
Хувь хүний нууцын тухай хууль	1995-04-21
Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	1995-04-17
Төрийн албан ёсны хэлний тухай хууль	2003-05-15
Хөдөлмөрийн тухай хууль	1999-05-14
Архивын тухай хууль	1998-01-02
Захиргааны хариуцлагын тухай хууль	1992-11-27
Авлигын эсрэг хууль	2006-07-06
Монгол улсын төрийн ордны тухай хууль	2001-02-01

* * *

Хүснэгт 2. Бусад эрх зүйн актуудын лавлагаа

2.1.УИХ-ын тогтоол болон УИХ-ын даргын захирамжаар

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
	Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө	УИХ-ын тогтоол, 2002.05.24-ний өдөр № 22
	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм	УИХ-ын тогтоол, 2006.06.22-ний №62
	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам	УИХ-ын тогтоол, 1995.10.17-ний №73/1998, 2000 онд нэмэлт, өөрчлөлт орсон/
	Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай	УИХ-ын тогтоол, 2009.01.16-ны №06
	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	УИХ-ын тогтоол, 2008-12-19-ний №43
	Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай	УИХ-ын тогтоол, 2007-01-31-ний №09

	Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, зааг тогтоох тухай	УИХ-ын тогтоол, 2001-02-01-ний №16
	Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай	УИХ-ын даргын захирамж, 2008.02.12-ний №23
	Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай	УИХ-ын даргын захирамж, 2008.11.27-ны №147

* * *

Хүснэгт 2.2

2.2. ЗГ-ын тогтоолоор

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь, үнэлгээний тухай	Засгийн газрын тогтоол, 1994.01.12-ны №8
	1.Ажлын цагийг нэгтгэн бодох журам 2.Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм 3.Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм 4.Нийгмийн хамгааллын улсын хяналтын дүрэм	Засгийн газрын тогтоол, 1999.08.11-ний №122
	Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлох журам Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам	Засгийн газрын тогтоол, 1994.12.21-ний №212
	Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам	Засгийн газрын тогтоол, 2004.05.05-ны №112
	Монгол улсын Үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам	Засгийн газрын тогтоол, 2006.07.26-ны №184
	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм	Засгийн газрын тогтоол, 2010.11.10-ны өдрийн №288
	Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам	Засгийн газрын тогтоол, 2011.03.02-ны өдрийн №62
	Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай	Засгийн газрын тогтоол, 2002 оны 06 сарын №120
	Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай	Засгийн газрын тогтоол, 2003 оны 11 сарын №233

* * *

Хүснэгт 2.3.

2.3. Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
---	--------------------	------------------

	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам	Төрийн албаны зөвлөлийн тогтоол, 2004.06.15-ны №18
	Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар	Төрийн албаны зөвлөлийн тогтоол, 2007.08.13-ны №48
	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам	Төрийн албаны зөвлөлийн тогтоол, 2010.12.01-ний №129

* * *

Хүснэгт 2.4.

2.4.УИХТГ-ын ЕНБД-ын захирамжаар

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
	Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2008.03.12-ний №77 тоот
	УИХТГ-ын нарийн бичгийн даргын эрхлэх ажлын чиглэл болон тамгын газрын хэлтэс, алба, төвийн чиг үүрэг	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2009.02.05-ний №73 тоот
	УИХ-ын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2009.03.20-ны №130
	УИХТГ-ын ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2008.03.31-ний №94
	Төрийн албан хаагчид нэг удаагийн тусламж олгох нөхцөл, журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2008.10.02-ны өдрийн №261 тоот
	Номын сангийн дотоод журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжгүй 2009.11.05
	УИХТГ-ын ажилтнуудыг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх сургалтад оролцуулах журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2009.10.26-ний №479 /2010.11.02-ний №524 нэмэлт өөрчлөлт орсон/
	УИХТГ-т Их дээд сургууль, коллежийн оюутныг дадлага хийлгэх журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2009.10.26-ний №478
	Төрийн мэдээлэл эмхэтгэлийг хэвлэн нийтлэх үйл ажиллагааны журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2009.04.24-ний №212
	Чуулган байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны ажилтнуудын дүрэмт хувцсыг хэрэглэх журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2010.12.29-ний №617

Улсын Их Хурлын Тамгын Газрын ажилтнуудын ажил хүлээлцэх журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2010.02.08-ны №73
УИХ-ын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийг эмхэтгэх, хэвлэн нийтлэх тухай журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2011.06.24-ний №247
Судалгааны захиалга хүлээн авах, гүйцэтгэх журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2011.12.16-ны №506
Мурparliament программыг ажиллуулах журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2011.06.23-ны №245
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанд Тамгын газрын ажилтнууд оролцох журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжгүй
УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар зөвлөхийн дүгнэлт гаргах журам	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2010.10.07-ны №4571
Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2003.10.02-ны №232 тоот
Монгол улсын Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам	Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, МУЕТГ-ын дарга, УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ТЕГ-ын даргын хамтарсан 2008.09.17-ны өдрийн №140, 3/720, 38, 466, 245 тоот тушаал
Журам тогтоох тухай	УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2005.02.01-ний №39 тоот

* * *

Хүснэгт 2.5.

2.5. Сайд, агентлагын даргын тушаал

№	Эрх зүйн актын нэр	Батлагдсан огноо
	Өдрийн ба цагийн хөдөлмөрийн хөлсийг тооцох тухай	Хөдөлмөрийн сайдын тушаал, 1993.03.25-ны №56
	Ээлжийн амралт олгох заавар батлах тухай Ээлжийн амралтын олговор тооцох журам	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын тушаал, 2000.06.14-ны №166
	Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар	Сангийн сайдын тушаал, 2002.12.22-ны №116
	Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам	Санхүү, эдийн засгийн сайдын тушаал, 2002.9.17-ны №258

Монгол Улсын Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан гадаад зээл, Засгийн газрын санхүүжилтийн хүрээнд хэрэгжих төслийн санхүүгийн тайлан гаргах журам	Санхүү, эдийн засгийн сайдын тушаал, 2002.4.26-ний №114
Төсөвт байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлан гаргах хугацааг тогтоох тухай	Санхүү, эдийн засгийн сайдын тушаал, 2004.01.26-ний №28
Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Валютын ханшийн өөрчлөлтийн бүртгэлийн зааврыг	Санхүү, эдийн засгийн сайдын тушаал, 2001.12 сарын №401
Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам	Сангийн сайдын тушаал, 2006.09 сарын №292
Журам батлах тухай Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам Төрийн сангийн төлбөр тооцооны журам Төсвийн зарцуулалтын эрхийн тухай журам Төрийн сангийн бэлэн мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх журам	Сангийн сайдын тушаал, 2005.05 сарын №123
Албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Сангийн сайдын тушаал, 2006.02 сарын №64
Гадаад оронд болох хурал, зөвлөлгөөн, уулзалт яармагторолцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын нийт хэмжээг шинэчлэх тухай	Сангийн сайдын тушаал, 2006.04 сарын №124
Түр журам батлах тухай Төсвийн байгууллагын өөрийн орлого төлөвлөхөд баримтлах түр журам	Сангийн сайдын тушаал, 2006.06 сарын №196
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай	Сангийн сайдын тушаал, 2007.01 сарын №04
Төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам	Сангийн сайдын тушаал, 2007.01 сарын №11
Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын журам Нэмэгдсэн өртгийн албан татварыг нягтлан бодох бүртгэлд тусгах журам	Сангийн сайдын тушаал, 2007.01 сарын №18
Амлалтын бүртгэлийн үйл ажиллагааны тухай журам	Сангийн сайдын тушаал, 2005.12 сарын №351

Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар	Архивын ерөнхий газрын даргын тушаал, 2009.07.07-ны №68
--------------------------------------	---

* * *

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТУУД, ТЭДГЭЭРЭЭР ЗОХИЦУУЛСАН ХАРИЛЦАА

Хавсралт 1

№ Эрх зүйн актын нэр Батлагдсан огноо	Агуулга, холбогдох зүйл заалт	Үндэслэсэн хууль	Холбогдох заалт	Тайлбар
---	----------------------------------	---------------------	-----------------	---------

Улсын Их Хурлын тогтоол

1. Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө УИХ-ын тогтоол. 2002.05.24-ний өдөр № 22	Стратеги төлөвлөгөө нь Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулахад чиглэгдсэн.	Улсын Их Хурлын тухай хуулийн 3.1-ийг үндэслэн	3.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.	УИХ-ын ТГ-ын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах төлөвлөгөө
2. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм УИХ-ын тогтоол. 2006.06.22-ний №62	Монгол Улсын Их Хурлын ажлын алба нь Тамгын газар байна. Тамгын газрын дүрмээр УИХ-ын Тамгын эрх үүрэг, удирдлагын зохион байгуулалт, бусад ажлын хэсгүүдтэй хэрхэн харилцах харилцааг зохицуулсан.	Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-ыг үндэслэн	39.2 Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг УИХ батална.	УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөнө.
3. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам УИХ-ын тогтоол. 1995.10.17-ний №73 /1998, 2000 онд нэмэлт өөрчлөлт орсон/	Төрийн албаны тухай хуулинд заасны дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгохдоо энэхүү журмыг баримтлана.	Төрийн албаны тухай хуулийн 7, 20 дугаар зүйлд заасныг үндэслэн	7.Төрийн захиргааны албан тушаал, түүний ангилал, 20.Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв гэсэн зүйлд заасны дагуу	Төрийн албанд нийтлэг хамааралтай.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Судалгааны эмхтгэл, XII боть

4. Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай УИХ-ын тогтоол. 2009.01.16-ны № 06	УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, УДШ, Үндсэн хуулийн цэц, УЕПГ, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоохдоо энэхүү хавсралтыг баримтлана. УИХ-ын тамгын газар нь УИХ-ын ажлын алба учир тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс түшмэл гэсэн ангилалд хамаарагддаг бөгөөд АА-1-ээс АА-11 хүртэлх зэрэглэлээр цалинждаг байна.	Төрийн албаны тухай хуулийн 7.9 дэх хэсгийг үндэслэн	7.9. УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, УДШ, Үндсэн хуулийн цэц, УЕПГ, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг УИХ тогтооно. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. /Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай УИХ-ын тогтоол. 2008-12-19 № 43	“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн	12.1. Аппаратыг чадваржуулан хямдруулж боловсронгуй болгох шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.	Төрийн албанд нийтлэг хэрэглэгддэг.
6. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай УИХ-ын тогтоол. 2007-01-31 № 09	Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг маягтаар бөглөж 2 дугаар сарын 15-ны дотор харьяа байгууллагын хариуцсан албан тушаалтанд өгөх үүрэгтэй.	Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн	10.3. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурал батална.	Төрийн албанд нийтлэг хэрэглэгддэг.
7. Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, зааг тогтоох тухай УИХ-ын тогтоол. 2001-02-01 № 16	Монгол Улсын Төрийн ордны тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг тогтоосон.	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн	-	Төрийн ордонд үйл ажиллагаа явуулж буй байгууллага албан тушаалтанд хамааралтай.

Улсын Их Хурлын даргын захирамж

1. Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын даргын захирамж 2008.02.12-ний №23	Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг төрийн зарим байгууллагын удирдлагын зэрэг зиндаа, нийтлэг жишгийг харгалзан “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг энэхүү хавсралтаар баталсан.	Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 11.1.7, 11.1.12, 11.2-дахь хэсэг, Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн тухай Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг үндэслэн	11.1.6. Улсын Их Хуралд шууд ажиллаа хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах 11.1.7. Улсын Их Хурлын Төсвийн тухайд төсвийн ерөнхийлөн захирагчид хуулиар олгосон бүрэн эрх хэрэгжүүлэх 12.1.5. эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;	Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг төрийн зарим байгууллага, албан тушаалтанд хамааралтай.
--	--	---	---	--

2. УИХ-ын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай УИХ-ын даргын захирамж 2008.11.27-ны №147	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын санал болгосны дагуу 2008 онд Тамгын газрын бүтцийг энэхүү захирамжаар шинэчлэн баталжээ. Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоосны дагуу хэлтэс, албад, төвийн чиг үүргийг тодорхойлсон.	Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12, 11.2-д заасныг үндэслэн	11.1. Улсын Их Хурлын дарга нь гишүүнд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.2. Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 11.1-д заасан эрх хэмжээний асуудлаар захирамж гаргана. 12 дугаар зүйл. Улсын Их Хурлын дэд дарга, түүний чиг үүрэг	УИХ-ын Тамгын газрын нийт ажилтнуудад хамааралтай.
---	---	---	--	--

* * *

Засгийн газрын тогтоол

1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь, үнэлгээний тухай Засгийн газрын тогтоол 1994.01.12-ны № 8	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн эдийн засгийн үндэслэлийг сайжруулж аж ахуйн нэгж, байгууллагад нөхөн үйлдвэрлэл явуулах, техник, технологио шинэчлэх санхүүгийн нөхцөл бүрдүүлэхэд оршино.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5.1.1 заасныг үндэслэн		Төрийн албанд нийтлэг хамааралтай.
2. Ажлын цагийг нэгтгэн бодох журам 2. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм 3. Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм 4. Нийгмийн хамгааллын улсын хяналтын дүрэм Засгийн газрын тогтоол. 1999.08.11-ний № 122	1. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны ажлын цагийг нэгтгэн бодоход энэ журмын баримтлана. 2. Монгол Улсын хуульд шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах орон тооны бус комиссоор хянан шийдвэрлэхэд энэ дүрмийг баримтлана. 3. Хөдөлмөрийн улсын хяналтын зорилго нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн стандартын биелэлтийг хангуулахад энэх дүрмийг баримтлана. 4. Нийгмийн хамгааллын улсын хяналтын зорилт нь нийгмийн халамжийн багц хууль, нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нийгмийн хамгааллын бүх төрлийн арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулсан төсөв, зээл, тусламж, төслийн хөрөнгийн зарцуулалтын байдалд хөндлөнгийн хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийг баримтлана.	Хөдөлмөрийн тухай хуулийн 73.3, 126.2, 140.3, Нийгмийн халамжийн тухай хуулийн 35 зүйлийг үндэслэн		Төрийн албанд нийтлэг хамааралтай.

3. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлох журам Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам Засгийн газрын тогтоол 1994.12.21-ний № 212	Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлоход энэхүү журмыг баримтлана.	Нийгмийн даатгалын тухай хуулийн 32, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3.3, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 зүйлийг үндэслэн		Төрийн албанд нийтлэг хамааралтай.
4. Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам Засгийн газрын тогтоол 2004.05.05-ны № 112	Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан тусламж олгоход энэхүү журмыг мөрдөнө.	Төрийн албаны тухай хуулийн 30.5-ыг үндэслэн	30.5 "Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам"-ыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
5. Монгол улсын Үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам Засгийн газрын тогтоол. 2006.07.26-ны №184	Монгол улсын үндэсний гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эзэмших, хадгалахад энэхүү журмыг баримтлана.	Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 8.7, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 23.5-ыг тус тус үндэслэн	8.7. Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмыг Засгийн газар тогтооно. 23.5. Үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмыг Монгол Улсын Засгийн газар тогтооно.	Монгол улсын иргэнд хамааралтай.
6. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм Засгийн газрын тогтоол 2010.11.10-ны №288	Төрийн захиргааны албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.	Төрийн албаны тухай хуулийн 10.4-т заасныг үндэслэн	10.4. энэ хуулийн 5.1.2-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.

7. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам Засгийн газрын тогтоол. 2011.03.02-ны №62	Төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцлийг хангах зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.	Төрийн албаны тухай хуулийн 21.2-т заасныг үндэслэн	21.2 Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг Засгийн газар тогтооно.	Төрийн албанд нийтлэг хамааралтай
8. Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай Засгийн газрын тогтоол. 2002 оны 06 сарын №120	Монгол Улсын Засгийн газраас Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг болон нутгийн удирдлагын хувьсах зардлын хэмжээг тооцох аргачлалыг баталсан.			Төрийн албанд нийтлэг хамааралтай
9. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай Засгийн газрын тогтоол. 2003.11 сарын №233	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албыг боловсронгуй болгох, төсвийн зардлыг хямдруулах ажлын хүрээнд төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрт шилжүүлэн гэрээгээр гүйцэтгүүлэхдээ энэхүү журмыг баримтлана.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолыг үндэслэн		Төрийн албанд нийтлэг хамааралтай

* * *

УИХ-ын ТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж

1. Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2008.03.12-ний өдрийн №77 тоот	УИХ-ын даргын 2008.02.12-ний №23 тоот захирамжийг үндэслэн Тамгын газрын хэлтэс, албадын ажлын өдөрт хэрэглэх дуудлагын автомашины лимитийг тогтоосон.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3, ЗГ-ын 2007 оны №349 тоот, УИХ-ын даргын захирамж 2008.02.12-ний №23 тоотыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана. ЗГ-ын № 349.Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын даргын захирамж 2008 оны №23. Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай	УИХ-ын Тамгын газрын нийт ажилтнуудад хамааралтай.
2. УИХТГ-ын нарийн бичгийн даргын эрхлэх ажлын чиглэл болон тамгын газрын хэлтэс, алба, төвийн чиг үүрэг УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2009.02.05-ний өдрийн №73 тоот	2008 онд УИХ-ын Тамгын газрын хэлтэс, албадын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсны дагуу тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг шинэчлэн тодорхойлсон байна.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь хэсгийг үндэслэн	40.3. Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	

Судалгааны эмхтгэл, XII боть

3. УИХ-ын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2009.03.20-ны № 130	Дотоод журмын зорилго нь Тамгын газрын жигд үйл ажиллагааг хангах, захиргаа, ажилтны эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, ажилтныг албан тушаалд томилох, албан тушаалаас түр чөлөөлөх, чөлөөлөх, халах, тэдний хөдөлмөрийг оновчтой оновчтой зохион байгуулах, урамшуулах, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, үйл ажиллагааны мэргэжлийн төлөвлөлт, тайлагнах, үнэлэх, мэдээлэх, түүнчлэн ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах, байгууллага, иргэдтэй харилцах, хөдөлмөрийн дэг журмыг тогтоох, түүнийг сахихтай холбогдсон харилцааг зохицуулна.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь хэсгийг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	Холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
4. УИХТГ-ын ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2008.03.31ний өдрийн №94 тоот захирамж	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд, тэдэнд орон сууцны дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын нийт ажилтнуудад хамааралтай.
5. Төрийн албан хаагчид нэг удаагийн тусламж олгох нөхцөл, журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2008.10.02-ны өдрийн №261 тоот	Засгийн газраас баталсан Төрийн албан хаагчид нэг удаагийн тусламж олгох журмыг үндэслэн Тамгын газрын ажилтнуудад нэг удаагийн тусламж, дэмжлэг олгох нөхцлийг тогтоосон.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын нийт ажилтнуудад хамааралтай.
6. Номын сангийн дотоод журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжгүй 2009.11.05	УИХ-ын Номын сан нь УИХ-ын гишүүд, УИХ-ын ТГ-ын ажилтнууд болон бусад ажилтнуудад ном хэвлэл, сонин холбогдох материалаар үйлчлэхдээ энэхүү журмыг баримтлана.	-	-	УИХ-ын Тамгын газрын номын сангаар үйлчлүүлэгчидэд хамааралтай.
7. УИХ-ын Тамгын газрын ажилтнуудыг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх сургалтад оролцуулах журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009.10.26-ний өдрийн №479 тоот захирамж /2010.11.02-нд нэмэлт өөрчлөлт орсон.№254	Төрийн албаны тухай хуулийг үндэслэн Тамгын газрын ажилтнуудын мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалтанд оролцуулах нөхцлийг тогтоосон.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь хэсгийг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын нийт ажилтнуудад хамааралтай.
8. УИХТГ-т Их дээд сургууль, коллежийн оюутныг дадлага хийлгэх журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009.10.26-ний өдрийн №478 тоот захирамж	УИХ түүний Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох, их дээд сургууль, коллежийн оюутнуудад ажлын дадлага, мэргэжлийн дагуу ажиллах чадвар, дадал, арга барил эзэмшүүлэх зорилгоор оюутныг УИХ-ын Тамгын газарт дадлага хийлгэх журам, нөхцлийг тогтоосон.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь хэсгийг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газарт дадлага хийж буй оюутнууд болон хариуцсан албан тушаалтанд хамааралтай.

9. Төрийн мэдээлэл эмхэтгэлийг хэвлэн нийтлэх үйл ажиллагааны журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009.04.24-ний өдрийн №212 тоот	Энэхүү журмаар "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн ажилтнуудын гүйцэтгэх үүрэг, эмхэтгэлийн дизайн, гарах хугацаа, эх материал нийлүүлэх, хэвлэх, захиалгаа авах, тараах үйл ажиллагааг зохицуулна.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	Төрийн мэдээлэл эмхэтгэлийг хэвлэн нийтлэхэд энэхүү журмыг баримтлана.
10. Чуулган байнгын хорооны хуралдаан хорооны байгуулах зохион байгуулах албаны ажилтнуудын дүрэмт хувцсыг хэрэглэх журам УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2010.12.29 №617	Чуулган байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны ажилтнууд УИХ-ын нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаанд энгэрийн тэмдэг зүүж, албаны дүрэмт хувцсыг заавал өмссөн байна.	УИХТГ-ын ЕНБД-ын захирамж Ажлын чиг үүрэг шинэчлэн батлах тухай 2009.02.05 №73	Ажлын чиг үүрэг шинэчлэн батлах тухай 2009.02.05 №73 8.Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба: Чуулган байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба нь УИХ-ын нэгдсэн болон Хорооны хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлж, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй.	Чуулган байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны ажилтнууд, холбогдох албан тушаалтнуудад хамааралтай.
11. Улсын Их Хурлын Тамгын Газрын ажилтнуудын ажил хүлээлцэх журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2010.02.08-ны өдрийн №73 тоот захирамж	Ажилтан нь Төрийн албаны хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Тамгын газрын дотоод журам зэрэг эрх зүйн баримт бичигт заасны дагуу холбогдох шийдвэр гарч ажлаас өөрчлөгдөх, түр чөлөөлөгдөх, чөлөөлөгдөх, халагдах, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болох, хөдөлмөрийн гэрээ цуцлагдах тохиолдолд үүрэгт ажлаа энэхүү журамд заасны дагуу хүлээлгэн өгнө.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.
12. УИХ-ын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийг эмхэтгэх, хэвлэн нийтлэх тухай журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2011.06.24 №247	Энэхүү журмаар "Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны талаархи нэгдсэн танилцуулга" /цаашид "Эмхэтгэл" гэх/-ийг эмхэтгэн гаргахтай холбогдуулан Тамгын газрын хэлтэс, алба, төвөөс мэдээлэл гаргах, мэдээллийг хянан баталгаажуулах, нэгтгэн боловсруулах, хэвлэн нийтлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.	УИХ-ын тухай хуулийн 39.1.7	39.1.7. батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх;	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.

13. Судалгааны захиалга хүлээн авах, гүйцэтгэх журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2011.12.16 № 506	УИХ-ын Тамгын Газрын Судалгааны төвөөс УИХ-ын гишүүд болон холбогдох нэгж, албан тушаалтнуудыг чанар, үр нөлөө бүхий судалгаа мэдээллээр хангах, судалгааны захиалга хүлээн авах, гүйцэтгэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.	УИХ-ын тогтоол. 2002.05.24-ний өдөр № 22 Монгол Улсын Их хурлын стратеги төлөвлөгөө батлах тухай: 1.9. УИХТГ-ын ЕНБД-ын захирамж Ажлын чиг үүрэг шинэчлэн батлах тухай 2009.02.05 №73 9.1	УИХ-ын ТГ-ын стратеги төлөвлөгөө батлах тухай: 1.9.Төрийн байгуулалт, эрх зүй, улс төр судлал, социологи, эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар судалгаа явуулах, хууль тогтоомжийн төслийн онолын үндэслэлийг боловсруулахад оролцох, үйлчилж буй хууль тогтоомжийн үр нөлөөг судлах, шинжлэх ухааны тайлбар бэлтгэх, дэлхийн улс орнуудын парламентат ёсны чиг хандлагыг судлах үүрэг бүхий эрдэм шинжилгээ, судалгааны төвийг Улсын Их Хурлын дэргэд байгуулах асуудлыг судлан боловсруулах. Ажлын чиг үүрэг шинэчлэн батлах тухай 2009.02.05 №73 9.1 УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд хийх судалгааны ажлын захиалгыг байнгын хороодын ажлын албаар дамжуулан авах, УИХ-ын болон ТГ-ын удирдлага, байнгын хороодын удирдлагаас өгсөн захиалгын дагуу судалгааны ажлыг зохион байгуулна.	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.
14. MyParliament программыг ажиллуулах журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж 2011.06.23 №245	Энэхүү журмаар Улсын Их Хурлын гишүүдийн албан хэрэгцээнд ашиглах iPad төхөөрөмжид зориулсан MyParliament програмыг ажиллуулах болон түүний мэдээллийн санг шинэчлэх, мэдээлэл оруулах, түүний хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн харилцааг зохицуулна.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь хэсгийг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.
15. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанд Тамгын газрын ажилтнууд оролцох журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжгүй	Энэхүү журмаар УИХ-ын чуулганы нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанд Тамгын газрын ажилтнууд оролцох ажиллагааг зохицуулж, эдгээр хуралдааныг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу цэгцтэй зохион байгуулахыг журамласан.	УИХ-ын тухай хууль: 19 дүгээр зүйл.	19.1. Байнгын хороо нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана. 29.10. Нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд Тамгын газрын ажилтнууд байлцаж хуралдааны бэлтгэл хангах, үйл явцын тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийн танилцуулга, томъёоллын эх бэлтгэх зэргээр чуулганы ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.

16. УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар зөвлөхийн дүгнэлт гаргах журам УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж, 2010.10.07-ны №457i	Энэхүү журмаар Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн ахлах зөвлөх, зөвлөх нь УИХ, Байнгын болон бусад хороо, УИХ-ын удирдлага, гишүүд, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар хууль зүйн дүгнэлт гаргах харилцааг зохицуулсан.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана	УИХ-ын Тамгын газрын хэлтэс, албадын зөвлөхүүдэд хамааралтай.
17. Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2003.10.02-ны өдрийн №232 тоот	Энэхүү заавар нь УИХ түүний Тамгын газрын баримт бичгийг зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, тараах, илгээх, тэдгээрийн шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг нэгдсэн арга зүйгээр явуулах зорилготой.	УИХ-ын тухай хуулийн 40-р зүйлийн 40.3 дахь заалтыг үндэслэн	40.3.Ерөнхий нарийн бичгийн дарга эрхлэх асуудлаар захирамж гаргана.	УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад хамааралтай.
18 Монгол улсын Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, МУЕТГ-ын дарга, УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ТЕГ-ын даргын хамтарсан 2008.09.17-ны өдрийн №140, 3/720, 38, 466, 245 тоот тушаал	МУ-ын Төрийн ордны тухай болон Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх, Төрийн ордонд байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтнууд ажил үүргээ хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, Төрийн ордон, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөний хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг энэхүү түр журмаар зохицуулна.	Төрийн ордны тухай хуулийн 5.2, 8.5, 9.2-т заасныг үндэслэн	5.2. Төрийн ордны халдашгүй дархан байдлыг энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хамгаалалт, үйлчилгээний тусгай журмын дагуу хангана. 8.5. Албан ажлын шаардлагаар ажлын бус цагт Төрийн ордонд нэвтрэх журмыг ордны хамгаалалтын алба УИХТГ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ-аас өгсөн зөвшөөрлийг үндэслэн тогтооно. 9.2. Төрийн ордонд үйлчилгээ явуулах болон засвар хийх журмыг Төрийн ордны үйлчилгээ хариуцсан байгууллага УИХ-ын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ болон Төрийн ордны хамгаалалтын албатай зөвшилцөн тогтоож, мөрдөнө.	Төрийн ордонд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, албан тушаалтанд хамааралтай.
19 Журам тогтоох тухай УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2005.02.01-ны №39 тоот	Тамгын газраас тэтгэвэрт гарсан ахмад настнуудыг бүртгэж, халамж үйлчилгээ үзүүлэх тухай энэхүү захирамжаар журамласан байна.	УИХ-ын тухай хуулийн 33.3 дахь хэсэг, Тамгын газрын ахмадын хорооны саналыг үндэслэн	33.3. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө.	УИХ-ын Тамгын газрын асуудал хариуцсан албан тушаалтанд хамааралтай.

Төрийн албаны зөвлөлийн тогтоол

16 Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам Төрийн албаны зөвлөлийн тогтоол. 2004.06.15-ны №18	Төрийн албаны хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөхдөө энэхүү журмыг баримтлана.	Төрийн албаны тухай хуулийн 37.4-т заасныг үндэслэн	37.4. Хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
--	--	---	---	------------------------------------

Судалгааны эмхтгэл, XII боть

2. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар Төрийн албаны зөвлөлийн тогтоол. 2007.08.13-ны №48	Энэхүү заавар нь төрийн албаны хэмжээнд төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулахад нэгдсэн стандарт мөрдүүлэх, улмаар тухайн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төрийн албан хаагч бүрийн жилийн ажлаа оновчтой төлөвлөхөд оршино.	Төрийн албаны тухай хуулийн 19.3 болон 35.1.9, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47.1-д заасныг үндэслэн	19.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага тогтооно. 35.1.9.төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах; 47.1. Төрийн албаны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох удирдах албан тушаалтантай, ерөнхий менежер төсвийн байгууллагын албан хаагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг дүгнэх заавар, журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавина.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
3. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам 2010.12.01-ний №129	Энэхүү журам нь төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагчийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 44.1.1, Төрийн албаны тухай хуулийн 35.1.7, УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн 2.1 заалт/	35.1.7.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах; 44.1.1. улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явцад хяналт тавих;	Төрийн албанд нийтлэг хамааралтай.

* * *

Сайд, агентлагын даргын тушаал

1. Өдрийн ба цагийн хөдөлмөрийн хөлсийг тооцох тухай Хөдөлмөрийн сайдын 1993.03.25-ны №56	Хөдөлмөрийн хуульд заасны дагуу ажилтны ажилласан өдөр, цаг, хөдөлмөрийн хөлсийг тооцох аргачлалыг боловсруулсан.	Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн 1993.03.11-ний 2 дугаар протоколыг үндэслэн	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
2. Ээлжийн амралт олгох заавар батлах тухай Ээлжийн амралтын олговор тооцох журам Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын тушаал 2000.06.14-ны №166	Ажил олгогч нь ажилтанд ээлжийн амралт олгохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 79 зүйл, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү зааврыг удирдлага болгоно. Ажилтны ээлжийн амралтын олговрын хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлоход энэ журмыг баримтлана.	Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2, 79 дүгээр зүйлийг үндэслэн		Төрийн албанд нийтлэг хамааралтай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар Санхүү, эдийн засгийн сайдын тушаал 2002.12.22-ны өдөр №116	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа банкнаас бусад бүх аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү дансны үлгэрчилсэн зааврыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэнэ.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
4. Мэргэшсэн нягтлан бодогчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам Санхүү, эдийн засгийн сайдын тушаал 2002.09.17-ны № 258	Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан нарт мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдөнө.	Монгол Улсын Засгийн газрын "Нэмэгдэл олгох тухай" 2002 оны 174 дүгээр тогтоолыг үндэслэн	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
5. Монгол Улсын Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан гадаад зээл, Засгийн газрын санхүүжилтийн хүрээнд хэрэгжих төслийн санхүүгийн тайлан гаргах журам Санхүү, эдийн засгийн сайдын тушаал 2002.04.26-ний № 114	Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан гадаад зээл, Засгийн газрын санхүүжилтийн хүрээнд хэрэгжиж буй төслийн санхүүгийн тайланг гаргах зарчим, бүтэц, зохион байгуулалт, хяналт тавих, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.	Засгийн газрын тухай хуулийн 20.5.2 дахь хэсгийг үндэслэн	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
6. Төсөвт байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлан гаргах хугацааг тогтоох тухай Санхүү, эдийн засгийн сайдын тушаал 2004.01.26-ний № 28	Төсөвт байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагчдын улирлын болон жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан гаргах хугацааг зохицуулна.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлийн 6 заалтыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүүгийн албан тушаалтнуудад хамааралтай.
7. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Валютын ханшийн өөрчлөлтийн бүртгэлийн зааврыг Санхүү, эдийн засгийн сайдын тушаал 2001.12 сарын № 401	Энэхүү зааврыг 2002 оны 01 дүгээр сарын 1-нээс эхлэн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх, энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллах.	Нягтлан бодох бүртгэлийн хууль-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Гадаад валютын ханшийн өөрчлөлт НББОУС-21-ийг хэрэгжүүлэх зорилгоор	Төрийн албанд нийтлэг хамааралтай
8. Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныгшагнаж журам Сангийн сайдын тушаал 2006.09 сарын № 292	Төрийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж, шагнаж урамшуулахад энэ журмыг мөрдлөг болгоно.	Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүү харуусан албан тушаалтнуудад хамааралтай.
9. Журам батлах тухай Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам Төрийн сангийн төлбөр тооцооны журам Төсвийн зарцуулалтын эрхийн тухай журам Төрийн сангийн бэлэн мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх журам Сангийн сайдын тушаал 2005. 05 сарын №123	Төсвийн байгууллагын бэлэн мөнгөөр орлого хүлээн авах, Төрийн сангийн бүртгэлийн данснаас бэлэн мөнгөний зузаатгал авах, төлбөр тооцоо хийх, бэлэн мөнгө, үнэт цаасны мөнгөн кассын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дэх заалтыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүү харуусан албан тушаалтнуудад хамааралтай.

Судалгааны эмхтгэл, XII боть

10. Албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай Сангийн сайдын тушаал 2006.02 сарын №64	Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлттэй уялдуулан улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг тогтоосон.		Төрийн албанд нийтлэг хамааралтай.
11. Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын нийт хэмжээг шинэчлэх тухай Сангийн сайдын тушаал, 2006.04 сарын №124	Дурьдсан албан ажлаар гадаад оронд явагчдын албан томилолтын зардлын нийт хэмжээг шинэчлэн тогтоосон.	Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлтийг харгалзан гадаад томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай	- Төрийн албанд нийтлэг хамааралтай.
12. Түр журам батлах тухай Төсвийн байгууллагын өөрийн орлого төлөвлөхөд баримтлах түр журам Сангийн сайдын тушаал, 2006.06 сарын №196	Холбогдох хуулийн хүрээнд төсөвт байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэх явцад бий болсон өөрийн үйл ажиллагаа(Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаа)-ны орлогыг төлөвлөхөд энэхүү түр журмыг мөрдөнө.	Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүү хариуцсан албан тушаалтнуудад хамааралтай.
13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Сангийн сайдын тушаал, 2007.01 сарын №04	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Монгол Улсын хуулийн хүрээнд тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцыг захиалагч байгууллага цаг хугацаа алдалгүй, шуурхай, үр ашигтай зохион байгуулахад шаардлагатай зохицуулалтаар хангахад энэхүү журмыг баримтлана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.6 дахь заалтыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүү хариуцсан албан тушаалтнуудад хамааралтай.
14. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам Сангийн сайдын тушаал, 2007.01 сарын №11	Төсвийн байгууллагуудын төсвийн зарлагыг хэмнэх, нэмэлт орлого олох боломжийг бүрэн ашиглах сонирхлыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн эцсийн үр дүнтэй төсвийн санхүүжилтийг уялдуулахад энэ журмыг баримтлана.	Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 6.1.3, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн, мөн хуулийн 13.3, 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор	Төсөвт байгууллагын санхүү хариуцсан албан тушаалтнуудад хамааралтай.
15. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын журам Нэмэгдсэн өртгийн албан татварыг нягтлан бодох бүртгэлд тусгах журам Сангийн сайдын тушаал 2007.01 сарын № 18	НӨАТ төлөгчийн төсөвт илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шалгаж баталгаажуулах, түүнийг татвар төлөгчид буцаан олгох, бусад татварын өрөнд шилжүүлэн тооцоход энэхүү журмыг мөрдөнө. Нэмэгдсэн өртгийн албан татвар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний Төсөвт байгууллагын санхүү хариуцсан албан тушаалтнуудад хамааралтай. борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлогод ногдуулан хэрэглэгчдээс нэхэмжлэн авсан болон үйлдвэрлэл, үйлчилгээний ба худалдан борлуулах зориулалтаар импортолсон буюу дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчдөөс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-тай холбогдсон ажил, гүйлгээг анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, санхүү, татварын тайланд тусгахад энэхүү журмыг мөрдөнө.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15.2, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 15.2.3-ыг үндэслэн	Төсөвт байгууллагын санхүү хариуцсан албан тушаалтнуудад хамааралтай.

16. Амлалтын бүртгэлийн үйл ажиллагааны тухай журам Сангийн сайдын тушаал, 2005.12 сарын №351	Төсвийн байгууллагуудад "Амлалтын бүртгэлийн үйл ажиллагаа"-г хэрэгжүүлэн батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх орчныг бүрдүүлэхэд оршино.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай "хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн	
---	--	--	--

17. Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар Архивын ерөнхий газрын даргын тушаал 2009.07.07-ны №68	МУ-ын төр, захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд үүсч хөтлөгдөж буй албан баримт бичгийн агуулга, бүтэц, хэв загварыг ижилтгэх, баримт бичигтэй ажиллах ажлын арга, хэлбэрийг боловсронгуй болгох, албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулахад оршино.	Архивын тухай хуулийн 11.1.1, Засгийн газрын 2009 оны 189-р тогтоолыг үндэслэн	11.1.1. Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын талаар арга зүйн нэгдсэн зарчим, хэм хэмжээ тогтоож мөрдүүлэх;	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
---	---	--	--	------------------------------------

* * *

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АКТУУД, ТЭДГЭЭРЭЭР ЗОХИЦУУЛСАН ХАРИЛЦАА

Хавсралт 2

№ Эрх зүйн актын нэр Батлагдсан огноо	УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагаанд хамаарах зохицуулалт	Холбогдох зүйл заалтууд	Тайлбар
1. Монгол Улсын Их Хурлын тухай хууль 2006-01-26	Энэ хуулиар Тамгын газрын эрх зүйн үндсийг тогтоож өгсөн бөгөөд УИХ-ын Тамгын газар нь УИХ-ын ажлын алба бөгөөд УИХ-ыг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүргийг тодорхойлж түүний эрхлэх ажил болон удирдлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон.	38.2. Улсын Их Хурал нь гишүүд, Байнгын, дэд, түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна. 39.2. Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг Улсын Их Хурал батална.	УИХ-ын Тамгын газрын статусыг тодорхойлсон гол хууль.
2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 2007-10-11	Энэхүү хуулиар УИХ-ын хуралдааны дэгийг тогтоосон бөгөөд Тамгын газрын гүйцэтгэх ажлыг нарийн тодорхойлон заагаагүй ч УИХ-ын тухай хуулийн 39.1.3-д заасанчлан нэгдсэн, байнгын, дэд, түр хороод, нам эвслийн бүлгийн хуралдааны техникийн бэлтгэлийг хангах үүргийнхээ дагуу хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохион байгуулна.	53 ¹ .1. Улсын Их Хурлын үйл ажиллагааг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх болон телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулна. 54.1. Нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсэг, нам, эвслийн бүлгийн хуралдааны явцыг бичгээр болон соронзон хальсанд нэгэн зэрэг, шаардлагатай бол дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан тэмдэглэж хадгална.	УИХ-ын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс, Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны үндсэн чиг үүрэгт хамааралтай.

Судалгааны эмхтгэл, XII боть

3. Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль 2001-11-08	Энэхүү хуулиар хууль санаачлагч хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан бөгөөд УИХ-ын Тамгын газар нь хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах ажлыг эрхлэн гүйцэтгэх чиг үүргийн харилцааг зохицуулсан.	Хуулийн 20.1-д Хууль санаачлагч хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээс өмнө холбогдох бичиг баримтын хамт Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлэх бөгөөд ЕНБД 72 цагийн дотор хуулийн төсөл, холбогдох бичиг баримтыг хянаж, шаардлага хангасан гэж үзвэл төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлон хууль санаачлагчид мэдэгдэх ба төсөл нь дээрх шаардлагыг хангаагүй байвал түүнийг хангуулах арга хэмжээ авна.	УИХ-ын Тамгын газрын хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах ажлыг эрхлэн гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд хамааралтай.
4. Үндэсний Аюулгүй байдлын тухай хууль 2001-12-27	Энэ хуулиар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим, үндэсний аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.	Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
5. Төрийн албаны тухай хууль 2002-06-28	Энэ хуулиар Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн алба хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
6. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2002-06-27	2012 оны 2 дугаар сарын 1-ээс хүчингүй болсон бөгөөд зарим зүйл хэсэг 2013 оны 01 дүгээр сарын 01-ээс хүчингүй болсонд тооцно.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
7. Төрийн нууцын тухай хууль 1995-04-18	Энэхүү хуулиар төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.	-	Энэхүү хууль нь УИХ болоод Тамгын газрын нууц хариуцсан ажилтнууд болон бүх албан хаагчдад хамааралтай.
8. Төрийн нууцын жагсаалт батлах тухай 2004-01-02	Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцсэн төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг зохицуулна.	-	УИХ болоод Тамгын газрын нууц хариуцсан ажилтнууд болон бүх албан хаагчдад хамааралтай.
9. Байгууллагын нууцын тухай хууль 1995-05-16	Энэ хуулиар байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.	-	УИХ болоод Тамгын газрын нууц хариуцсан ажилтнууд болон бүх албан хаагчдад хамааралтай.
10. Хувь хүний нууцын тухай хууль 1995-04-21	Энэ хуулиар хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.	-	УИХ болоод Тамгын газрын нууц хариуцсан ажилтнууд болон бүх албан хаагчдад хамааралтай.

11. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль 1995-04-17	Энэхүү хууль нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
12. Төрийн албан ёсны хэлний тухай хууль 2003-05-15	Энэ хуулиар төрийн албан ёсны хэл болох монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёог төрийн албан хэрэг хөтлөх, төрийн албан ёсны үйл ажиллагаанд хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах болон Монгол Улсын нэгдмэл байдлыг хангах харилцааг зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
13. Хөдөлмөрийн тухай хууль 1999-05-14	Энэ хуулиар хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангах харилцааг зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
14. Архивын тухай хууль 1998-01-02	Энэ хуулиар Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөг, түүний бүрэлдэхүүн, төрийн архивын үйл ажиллагааны зарчим, удирдлага, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулна.	Хуулийн 23.1-т зааснаар Улсын Их Хурал, түүний Тамгын газарт-20 жил хадгалсны дараа эрдэм шинжилгээ, судалгааны ач холбогдолтой хэсгийг нь төрийн архивт шилжүүлнэ.	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
15. Захиргааны хариуцлагын тухай хууль 1992-11-27	Энэхүү хуулиар захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.
16. Авлигын эсрэг хууль 2006-07-06	Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авилгалтай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулна.	-	Төрийн албанд нийтлэг хамааралтай.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

<p>17. Монгол улсын төрийн ордны тухай хууль 2001-02-01</p>	<p>Энэ хуулиар Монгол Улсын Төрийн ордны эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний хамгаалалт, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулна.</p>	<p>Хуулийн 4.1-д Төрийн ордонд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, тэдгээрийн Тамгын газар, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус тус байрлаж үйл ажиллагаагаа явуулна. Төрийн ордны дотоод зохион байгуулалт, өрөө, тасалгааны хуваарилалтыг УИХТГ-ын ЕНБД, УИХ-ын дэд дарга ажлын байрны жишиг шаардлагад нийцүүлэн тогтооно. Төрийн ордонд үйлчилгээ явуулах, засвар хийх журмыг Төрийн ордны хамгаалалтын албатай, Төрийн ордны өнгө төрх, засал чимэглэл, тавилга бусад зүйлийн хийц, загварын талаар баримтлах бодлогыг УИХТГ-ын ЕНБД-ын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.</p>	<p>Төрийн ордонд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтанд хамаарна.</p>
---	--	---	--



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**“ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ”
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ)**

А. Пагма, Г. Гэрэл, Б. Мөнхцэцэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 8 -д УИХ -ын “... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхийг хуульчилсан ба Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд¹³ туссан үндсэн 5 **зорилтын** 2 –т, “Парламентын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлнэ” гэж заажээ.

УИХ-ын стратеги төлөвлөгөөнд урт хугацааны уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон чухал **зорилго** дурдагдсаны дотор,

- Парламентын хянан шалгах үйл ажиллагааны өнөөгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, улмаар, эрх зүйн талаас нь тусгайлан зохицуулж шийдвэрлэх;
- Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй болгох; ... зэрэг тодорхой заалтууд орсон байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд УИХ-ын хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх зарчим, хэлбэрийг хуульчилжээ. УИХ нь хянан шалгах бүрэн эрхээ дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд,

- Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга тавих, түүний хариуг чуулганаар хэлэлцүүлэх;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулт тавьж хариулт авах;
- Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллага, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан шалгаж дүнг Байнгын хорооны, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас томилогдсон, түүнд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, гишүүнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж санал, дүгнэлт гаргах зэрэг болно.

Түүнчлэн УИХ-ын тухай хуулинд зааснаар Байнгын хороод нь УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор дагнасан болон холимог бүрэлдэхүүнтэй шалгалтын ажлын хэсэг байгуулж ажиллуулах бүрэн эрхтэй ба дэд хороод нь хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй юм.

Улсын Их Хурал өөрийн хянан шалгах чиг үүргийг хангалттай сайн биелүүлж чадахгүй явсаар олон жил боллоо гэсэн шүүмжлэл олон түмний зүгээс байнга гарсаар иржээ. Энэ нь оргүй хоосон үг биш юм. 2010 онд УИХ –ын Тамгын газрын Судалгааны төвөөс гаргасан “УИХ –ын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл

¹³ Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан

ажиллагааны талаархи статистик мэдээлэл” (1996 – 2009) –д, хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгүүдийн “үр дүнгээ хэлэлцсэн байдал” –ыг тоон үзүүлэлтээр харуулсан. Тэнд, өнгөрсөн 13 жилийн хугацаанд байгуулагдсан 244 ажлын хэсгийн 14 нь “ажиллаагүй”, 60 нь “ажилласан эсэх нь тодорхойгүй” гэж тэмдэглэгджээ. Тэгэхээр, байгуулагдсан 3 ажлын хэсэг тутмын бараг 1 нь буюу 30.3% нь “үр дүнгээ өгөөгүй” сул үзүүлэлттэй байна. Ийм байдалд хүргэсэн 7 шалтгаан байгаагийн нэг нь, тэнд дурдсанаар, “хяналт шалгалтын үр дүнг үнэлэх нэгдсэн хэмжүүр, шалгуур үзүүлэлт байхгүй” –д оршиж байгаа ажээ¹⁴.

Гадаадын улс орнууд парламентын хяналт шалгалт, ялангуяа, парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаанд/ parliamentary investigation, парламентское расследование/ онцгой ач холбогдол өгч, түүнийг олон оронд тусгай хуулиар зохицуулсан байдаг. Дэлхийн олон улс орны парламент иргэдийн анхааралд нэгэнт өртсөн, нийгмийн хурц маргаан дэгдээсэн “ноцтой халуун” асуудлыг “өөрөө шалган тодруулж, холбогдох арга хэмжээг авах” эрхээ өөр өөрийн үндсэн хуулиндаа тусгасан байдаг¹⁵.

Парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь түүний ажлын албаны зүгээс үзүүлэх үйлчилгээний хувьд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 73 дугаар захирамжаар батлагдсан Тамгын газрын хэлтэс, алба, төвийн чиг үүргийн дагуу Байнгын хороодын ажлын алба, Захиргаа боловсон хүчний хэлтэсийн чиг үүрэгт УИХ-ын хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх үүрэг тодорхойлогдсон байна.

Парламентын хяналт шалгалт гэдэг нь парламентаас засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт бөгөөд гадаадын парламентын практикт засгийн газрын үйл ажиллагаанд тавих бүхий л талын төлөвшсөн бүхэл бүтэн тогтолцоо ажиллаж засгийн газрын үйл ажиллагаа, төсвийн бодлого, түүний хэрэгжилт, төрийн үйл ажиллагааны бусад салбарт өөрийн бүрэн эрхийн хүрээнд хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлдэг байна.

Парламентын хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь засгийн газарт итгэл үзүүлэх эсэх талаар асуудал тавих, буруушаасан тогтоол батлах, парламентын гишүүний асуулга, засгийн газарт аман болон бичгээр асуулт тавих, парламентаас мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах зэрэг хэлбэртэй байдаг.

Гадаадын зарим улс орны туршлагаас үзэхэд парламентаас хяналт шалгалтын чиг үүргээ гүйцэтгэхэд нь ажлын албадын зүгээс үзүүлэх үйлчилгээ нь төрөл бүрийн хэлбэр, чиглэлтэй бөгөөд зарим орны парламент энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйлчилгээ тусламж үзүүлэх зорилго бүхий бие даасан нэгжтэй, зарим нь ийм тусгайлсан нэгжгүй боловч бусад бүтцээр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг байна.

Парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь парламентын ажлын албадын үзүүлдэг дэмжлэг, үйлчилгээг зарим улс орны жишээн дээр авч үзье.

Шинэ Зеланд

Тус улсын парламентын Тусгай хороод нь парламентын хууль тогтоох, санхүүгийн, хяналт шалгалтын болон мөрдөн шалгах үүрэгтэй холбоотой хамгийн шуурхай ажлыг гүйцэтгэдэг. Танхим дахь хэлэлцүүлэг зөвхөн парламентын гишүүдээр хязгаарлагддаг бол тусгай хороод өөрийн үйл ажиллагаандаа олон нийтийг татан оролцуулж болдог. Хууль

¹⁴ Бодлогын судалгаа шинжилгээ IV боть, УБ., 2010 он, 317 дах тал

¹⁵ Хавсралт 2-оос үзнэ үү

тогтоох процесст парламентын гишүүд ийнхүү олон нийттэй харилцан ажилладаг нь Шинэ Зеландын парламентын онцлог юм.

Тусгай асуудлаар байгуулагдсан эдгээр хороодын үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ үзүүлэх нь парламентын ажлын албаны **Тусгай хороодын офисийн /Select Committee Office/** үүрэг ба шаардлагатай тохиолдолд бусад байнгын хороодод үйлчилнэ. Офис нь мөн тусгай хороодод процедур, тайлан бичих, зохион байгуулах ажлаар туслана. Офисийн ажилтнуудын хувьд хорооны хуралдааны материал бэлтгэх, хуралдааны бичлэг үйлдэх, судалгаа, анализын мэдээлэл, хорооны тайлан бэлтгэх зэргээс гадна тусгай хороодын гишүүдэд дүрэм, журам, парламентын процедурын практикаар зөвлөгөө өгнө.

Тусгай хороодын офисоос тусгай хороо бүрт ажилтан томилон ажиллуулна. Энэ ажилтан Танхимын клеркийг төлөөлөн ажиллаж, хариуцлага хүлээхээс гадна тусгай хорооны удирдлагын доор хорооны ажлыг зохицуулна. Тусгай хороодын хамгийн гол ажлын нэг болох Танхимд гарган өгөх тайланг энэ ажилтны удирдлага доор бэлтгэдэг байна.

Түүнчлэн парламентаас хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг Парламентын офис ажилладаг ба энэ нь **Ерөнхий аудиторын офис, Омбудсмэний офис, Байгаль орчны парламентын комиссарын офис** гэсэн гурван парламентын офисоос бүрдэнэ. Эдгээр офис тус бүрийг Төлөөлөгчдийн танхимын зөвлөснөөр Мужын сайдын /Governor-General/ томилсон Парламентын албан тушаалтнаар удирддаг.

Ерөнхий аудиторын офис /Office of the Auditor-General/

Ерөнхий аудитор болон Ерөнхий хянагч /Controller/ нь бүх төрийн мэдлийн байгууллага, аж ахуйн нэгжийн төсвийн аудитор байна. Үүнд: Төрийн яамд, төв болон орон нутгийн төсвийн байгууллагууд хамрагдана.

Омбудсмэний офис /Office of the Ombudsmen/

Одоогоор хоёр Омбудсмэн томилогдон ажиллаж байгаа ба тэдгээрийн үүрэг нь Шинэ Зеландын төв болон орон нутгийн засгийн газрын байгууллагууд, агентлагуудаас гаргасан захиргааны шийдвэрүүдийн талаархи гомдлыг хянан шалгана.

Байгаль орчны парламентын комиссарын офис /Office of the Parliamentary Commissioner for the Environment/

Байгаль орчны парламентын комиссарын офис нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлсөн байж болох бүх асуудлыг мөрдөн шалгаж, илтгэл тайлан бэлтгэн парламентад танилцуулах өргөн хүрээний эрх мэдэлтэй болно. Мөн Байгаль орчны парламентын комиссарын офис нь парламентын Тусгай хороодод хүрээлэн буй орчны асуудлуудын талаар зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг.

Их Британи

Их Британи улсын парламентын Нийтийн танхим /House of Commons/ нь байнгын ба түр хороодтой ба байнгын хороод нь Нийтийн танхимын хороо, Тусгай хороо, Тусгай бус хороо гэж гурван төрөлд хуваагдана. Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг Тусгай хороод гүйцэтгэдэг ба эдгээр хороодын үүрэг нь гол яамдын үйл ажиллагааг хянах явдал учраас тэдгээр нь Батлан хамгаалах асуудлаархи тусгай хороо, Гадаад харилцааны тусгай хороо, Дотоод хэргийн тусгай хороо гэх мэт засгийн газрын бүтцийн дагуу байгуулагдсан нийт 14 тусгай хороо ажилладаг. Тусгай хороод нь хоёр танхимд хоёуланд нь үйлчилэх ба засгийн газрын яамны ажлаас эхлэн эдийн засгийн асуудал хүртэлх бүх хүрээнд хяналт шалгалт хийж тайлан гаргана.

Парламентын ажлын албаны **Танхим ба байнгын хороодын үйлчилгээний департаментын Хороодын газар нь /Committee Office/** Нийтлэг хууль тогтоомжын хороод болон Засгийн газрын байгууллагуудыг хянан шалгах үүрэгтэй Тусгай хороодын үйл ажиллагаанд туслана. Мөн Танхимын үйл ажиллагааны хяналт шалгалтыг чадавхижуулах зорилгоор Нийтийн танхимын Хороодын газрын бүрэлдэхүүнд **Хяналтын нэгжийг /Scrutiny unit/** байгуулсан байна.

Энэ нэгж нь Тусгай хороодод мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг ба ялангуяа санхүүгийн асуудал болон хуулийн төсөлд хийх хяналт, шалгалтад туслалцаа үзүүлдэг. Хяналтын нэгжид хуульч, нягтлан бодогч - санхүүч, эдийн засагч, статистикч зэрэг мэргэжилтэй нийт 14 албан хаагч ажилладаг.

Хяналтын нэгж нь гол төлөв хууль тогтоох болон санхүүгийн хяналт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд анхааран ажилладаг ба эдгээрийг доор авч үзье.

✓ **Хууль тогтоох үйл ажиллагааны хяналт шалгалт**

Хяналтын нэгжийн хууль тогтоох хяналт шалгалтын ажил нь хоёр төрөлд хуваагдана. Нэгд нь, энэхүү нэгж нь Тусгай хороодод хуулийн төслийг хянан шалгахад туслалцаа үзүүлнэ, хоёрт, хуулийн төслийг хэлэлцэхээр Лордын танхим болон Нийтийн танхимаас байгуулсан Онц яаралтай хамтарсан хороодод захиргааны туслалцаа үзүүлж, хуулийн болон процедурын талаар зөвлөгөө өгнө.

✓ **Санхүүгийн хяналт шалгалт**

Хяналтын нэгж нь Тусгай хороодод санхүүгийн өргөн хүрээний зөвлөгөө өгдөг талаар дээр дурьдсан. Санхүүгийн хяналтыг санхүү, төсвийн тооцоо хийх, яамдын санхүүгийн тайлан, тооцоог хянах, санхүүгийн нөөцийг урьдчилан тооцоолох, зарлагын хяналтыг гүйцэтгэх зэргээр системтэйгээр бүрэн дүүрэн хийж гүйцэтгэдэг байна.

Хяналтын нэгж нь мөн яамдаас гаргадаг санхүүгийн мэдээллийн чанарыг дээшлүүлэх, зааварчилгаа, танилцуулга бэлтгэх болон парламентын гишүүд, тэдгээрийн туслахуудад сургалт явуулах зэрэг ажилд Тусгай хороодтой хамтран ажиллах замаар санхүүгийн хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үүний зэрэгцээ Хяналтын нэгж нь Танхимын бусад нэгж албадуудтай мөн хамтран ажилладаг. Тухайлбал, Спикерийн хороонд, Сонгуулийн Комиссын хяналт хийх, Байнгын хороодод хуулийн хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийхэд нь туслалцаа үзүүлдэг.

Түүнээс гадна Их Британы парламентад Парламентын Захиргааны Комиссарын буюу Парламентын Омбудсманы /Parliamentary Commissioner for Administration (Parliamentary Ombudsman)/ офис ажилладаг ба 1967 оны “Парламентын Комиссарын тухай” /The Parliamentary Commissioner Act 1967/ хуулиар Парламентын Омбудсмэн нь төв засгийн газрын яамны болон орон нутгийн засаг захиргаа зэргийн захиргааны үйл ажиллагааг мөрдөн шалгах үүрэгтэй болохыг хуульчилсан байна. Офис нь засгийн газраас биеэ даасан, хараат бус, иргэний үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны талаархи иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хянан шалгадаг байна.

Түүнчлэн тус парламентад засгийн газар хөрөнгө мөнгийг хэрхэн зарцуулж байгаа

байдалд хяналт тавих үүрэг бүхий Ерөнхий хянагч ажилладаг. Тэрээр парламентын албан тушаалтан бөгөөд парламентын өмнө хариуцлага хүлээдэг.

ХБНГУ


ХБНГУ-д парламентын хяналт шалгалт нь Бундестагын чухал чиг үүргийн нэг юм. Тус улсад парламентын хяналт шалгалт нь хууль тогтоомж болон төсвийн хяналт шалгалт, бие даасан гишүүдийн хяналт шалгалт, төрөл бүрийн байгууллагуудын хяналт шалгалт гэм мэт олон хэлбэрээр хэрэгждэг байна¹⁶. Бундестагт парламентын төрийн нарийн бичгийн дарга гэсэн албан тушаалтан байдаг бөгөөд энэхүү албан тушаалтан нь парламентын гишүүн бөгөөд зарим голлох яамны төрийн нарийн бичгийн даргын албыг давхар хашдаг байна. Үндсэн чиг үүрэг нь парламент дахь засгийн газрын цагаар Засгийн газрыг төлөөлөн асуултанд хариулж, засгийн газар, парламентын бүлгүүд, хороодын харилцаа холбоог хангана.

Холбооны Засгийн газрын хяналтыг Парламентын **Өргөдлийн хороо** мөн хариуцан гүйцэтгэдэг. ХБНГУ-ын Үндсэн хуульд хүн бүр Парламентад санал хүсэлт эсвэл гомдлоо бичгээр илэрхийлэх эрхтэй хэмээн хуульчилсаны дагуу иргэд, хувь хүнээс болон хамт олноос парламентад гаргасан өргөдөл, гомдлыг тус хороо хүлээн авч засгийн газартай холбоотой өргөдөл, гомдлыг холбогдох засгийн газрын байгууллагад шилжүүлдэг ба хорооны хурлаар уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи мэдээллийг сонсдог байна.

Парламентын хяналтын нэг чухал чиглэл нь **Мөрдөн шалгах хороо** байгуулан ажиллаж мөрдөн шалгах ажиллагаа явуулан үр дүнг нь илтгэл хэлбэрээр дүгнэн бэлтгэж парламентын хэлэлцэх асуудалд оруулан хэлэлцдэг. Мөрдөн шалгах хороог холбооны засгийн газар, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гарсан хууль бус үйл ажиллагаа, дутагдалын талаар шүүмжлэл гарсан тохиолдолд ихэвчлэн сөрөг хүчний санаачлагаар байгуулан ажиллуулдаг байна.

Германы Бундестагийн дээр дурьдсан хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий 6 байгууллага бүтэц парламентад ажилладаг ба тэдгээрийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь парламентын ажлын албаны Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн дарга нарын газар, Өргөдөл, хүсэлт хариуцсан газар мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг.

Зураг



¹⁶ Мөн тэндээс үзнэ үү

Secretariat PD 5 буюу Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар нь Парламентын хяналтын хороо, G10 комисс, ZFdG комисс /Гаалийн мөрдөн шалгах Үйлчилгээний Актын дагуу байгуулагдсан/, Хамтарсан хороодоос /Үндсэн хуулийн 53т заасны дагуу/ бүрдэнэ.

Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар буюу Secretariat PD 5 нь Холбооны засгийн газрын оюуны үйлчилгээг хянан шалгах үүрэгтэй хэд хэдэн парламентын байгууллагуудад туслалцаа үзүүлнэ. Эдгээр байгууллагууд нь нууц хурлуудад товч мэдээлэл хийх ба дээрх гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаагаар Бундестагийн хяналт хийх чадварыг хангах зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг.

Өргөдөл, хүсэлт хариуцсан газар нь өргөдлийн байнгын хорооны нарийн бичгийн даргын газар болон хэд хэдэн яамдыг нэгтгэн хариуцдаг нийт 5 хэлтэстэй болно. Тус газар нь Өргөдлийн хорооны хүлээн авсан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх, Хорооны хурлыг зохион байгуулах, хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундестагийн чуулганд оруулж тайлагнасан Тайлангуудыг хэвлэж тараах, өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэх, тэдэнд зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэх зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг ба Бундестагт гаргасан хууль болон захиргааны шийдвэр нь алдаатай, орхигдуулсан, шударга бус байсныг илрүүлж, эрхзүйн орчныг сайжруулахад чухал үүрэгтэй Өргөдлийн хорооны үйл ажиллагаанд оролцдог ажээ.

* * *

Дүгнэлт

- Дээр авч үзсэн орнуудын туршлагаас үзэхэд парламентын хяналт шалгалтын, түүн дотроо мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй Байнгын хорооны статустай хороо, комисс, офис болон тусгай албан тушаалтан ажиллаж байгаа бол манайд УИХ-ын Байнгын хороод, дэд хороод хянан шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй, харин тусгайлан мөрдөн шалгалт явуулах эрх, үүрэгтэй бүтэц үгүй байна.
- Парламент хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх хэлбэрийн хувьд засгийн газрын цаг, асуулга, асуулт тавих, төсвийн хяналт, захиргааны зөрчлийг шалгаж санал дүгнэлт гаргах зэрэг ижил төстэй явагдаж байгаа боловч захиргааны зөрчлийн талаархи өргөдөл гомдлыг барагдуулах, шийдвэрлэх, төр, нийтийн эрх ашгийн үүднээс парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах тал дээр эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм, үр дүнг тооцоход ялгаатай анхаарвал зохих асуудал ажиглагдаж байна.
- Парламентын ажлын албадын зүгээс хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлдэг бие даасан нэгжтэй бөгөөд тэд парламентын хяналт шалгалт хийх чадварыг нь хангах, дээшлүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа явуулж байна.

Санал

- УИХ –ын Хянан шалгах **Ерөнхий чиг үүргийн** дагуу парламентын зохион байгуулалтын дотоод бүтцэд Хяналт шалгалтын хороог шинээр байгуулж, түүнд, Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг зохион байгуулах ажлыг хариуцуулах
- Парламентын хяналт шалгалтын нэг гол хэлбэр болсон мөрдөн шалгах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын талаар анхаарах

- УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийг сайжруулах зорилгоор Тамгын газрын бүтцэд хяналт шалгалтын бүтэц байгуулж, чиг үүргийг тодорхойлох зэрэг болно.

* * *

Хавсралт 1

Гадаадын зарим орны парламентын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжүүд, тэдгээрийн чиг үүрэг

Улс ба Парламентын танхимын нэр	Эрх зүйн зохицуулалт	Хяналтын чиг үүрэгтэй парламентын нэгжийн нэр	Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг хэлбэр	Парламентын Ажлын албанаас хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг бүтцийн нэгж, чиг үүрэг
Шинэ Зеланд Төлөөлөгчдийн танхим	Төлөөлөгчдийн танхимын Дэг, Омбудсмэний тухай хууль, 1975 он	- Тусгай хороод - Ерөнхий аудиторын офис - Омбудсмэний офис - Парламентын байгаль орчны комиссарын офис	Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавих, тайлан илтгэл хэлэлцэх, санхүүгийн шалгалт хийх, өргөдөл, гомдлыг хянан шалгах, тулгамдсан асуудлаар мөрдөн шалгалт хийх, захиргааны шийдвэрийн талаархи гомдлыг хянах, ЗГ-т итгэл үзүүлэх эсэх асуудал зэрэг болно.	Тусгай хороодын офис: хяналт шалгалтын болон мөрдөн шалгах үүрэгтэй холбоотой ажлыг хийж гүйцэтгэхэд зохион байгуулах үүрэгтэй оролцоно. Мөн тусгай хороодын гишүүдэд дүрэм, журам, парламентын процедурын практикаар зөвөлгөө өгнө.
Их Британи Нийтийн танхим	Нийтийн танхимын Дэг, Захиргааны комиссарын тухай хууль, 1967 он	- Нийт 14 Тусгай хороод ажилладаг - Парламентын Захиргааны комиссар - Ерөнхий хянагч	Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавих, Тусгай хороод засгийн газрын бодлогод салбар бүрээр хяналт шалгалт хийнэ. Захиргааны асуудлаар мөрдөн шалгалт явуулна. Санхүүгийн хяналт, шалгалт хийнэ.	Нийтийн танхимын хороодын газрын Хяналтын нэгж: Тусгай хороодод хуулийн төслийг хянан шалгахад туслах, санхүүгийн талаар зөвөлгөө өгөх, гишүүд, албан хаагчдад сургалт явуулах, Онц яаралтай хамтарсан хороодод захиргааны туслалцаа, хуулийн болон процедурын талаар зөвөлгөө өгөх,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХБНГУ	<p>Үндсэн хууль, Германы Бундестагийн Дэг,</p> <p>Зэвсэгт хүчин хариуцсан комиссарын тухай хууль,</p> <p>Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих парламентын хяналтын тухай хууль, 1978 он</p>	<p>-Тусгай статустай хороод</p> <p>-Өргөдлийн хороо</p> <p>-Парламентын хяналт шалгалтын комисс</p> <p>-G 10 комисс</p> <p>-ZFdG комисс</p> <p>-Хувийн орон сууцны дуу чимээний хяналтын хороо</p> <p>-Зэвсэгт хүчин хариуцсан комиссар</p> <p>-Хяналтын хороо</p>	<p>Засгийн газрын цаг, төсвийн хяналт, шалгалт, өргөдөл, гомдлыг хянан шалгах, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, засгийн газрын байгууллагуудаас мэдээлэл авах, тусгай албадын үйл ажиллагаанд хяналт тавих, тайлан, илтгэл хэлэлцэх</p>	<p>Secretariat PD 5 буюу Парламентын хяналтыг хэрэгжүүлэх хороодын нарийн бичгийн даргын газар, Өргөдөл, хүсэлт хариуцсан газар: Secretariat PD 5 нь Холбооны засгийн газрыг хянан шалгах үүрэгтэй хэд хэдэн парламентын байгууллагуудад туслалцаа үзүүлнэ. Эдгээр байгууллагууд нь нууц хурлуудад товч мэдээлэл хийх ба дээрх гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаагаар Бундестагийн хяналт хийх чадварыг хангах зорилго бүхий үйл ажиллагаа явуулдаг. Ө/Хгазар нь Өргөдлийн хорооны хүлээн авсан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэх, Хорооны хурлыг зохион байгуулах, хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундестагийн чуулганд оруулж тайлагнасан Тайлангуудыг хэвлэж тараах, өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэх, тэдэнд зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэх зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг.</p>
Монгол Улсын Их Хурал	<p>Үндсэн хууль, УИХ-ын тухай хууль, УИХ-ын Дэгийн тухай хууль</p>	<p>-УИХ-ын Байнгын хороод</p> <p>-Тусгай хяналтын дэд хороо</p> <p>-Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо</p> <p>-Өргөдөл гомдлын дэд хороо</p> <p>-Төсвийн зарлагын хяналтын дэд хороо</p> <p>-Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо</p>	<p>Засгийн газрын ба УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, тэдгээрт асуулга, асуулт тавих, түүний хариуг чуулганаар хэлэлцүүлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулж болно. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын дарга, гишүүнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж санал, дүгнэлт гаргах.</p>	<p>Байнгын хороодын ажлын алба:Хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах ажлыг төлөвлөх,гүйцэтгэлийг хянах, Хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай зохих журмын дагуу харилцах, хяналт тавих, асуулт, асуулга тавих ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хариуг сонсох асуудлыг зохион байгуулах, УИХ-аас тогтоолоор өгөгдсөн үүргийн биелэлтэнд хяналт тавих, ЗГ, холбогдох бусад байгууллагад өгөх чиглэл,санал дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулж албажуулах, Хорооны даргад ирсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж хариу бэлтгэн явуулах, Захиргаа боловсон хүчний хэлтэс:Байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, баримт материал, иргэдийн захидал,УИХ-ын веб хуудсаар ирүүлсэн болон амаар тавьсан санал хүсэлт, гомдол,мэдээллийг хүлээн авч бүртгэх, тэдгээрийг холбогдох албан тушаалтанд хүргэх ажлыг зохион байгуулах, хариутай бичиг, өргөдөл, санал, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих</p>

* * *

Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа
(Parliamentary investigation, парламентское расследование)

Энэхүү үйл ажиллагааг нь парламентын хянан шалгах чиг үүргийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа нь парламентын хяналтанд байдаг засгийн газрын байгууллагын нийтийн эрх ашгийн хохироосон, улс төрийн шинж чанартай хууль бус үйл ажиллагааг шалгах зорилгоор хийгддэг болно.

Парламентын мөрдөн шалгалтыг хэрэгжүүлэх эрх зүйн механизм нь, гадаадын туршлагаас харахад, бүхэлдээ үндсэн хууль ба хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны дэг процедурыг тогтоосон хууль, мөн түүнчлэн бие даасан тусгай хууль батлах гэх мэт олон аргаар тодорхойлогддог. Үүнд:

- Үндсэн хуулийн агуулгын тухайлсан тодорхой заалтаар парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны үндсийг тавьж эрхийг нээж өгсөн байх;
- Парламентын тухай хуулийн агуулгад парламентын шалгалтын эрхийг нээсэн заалт оруулаад зогсохгүй, тухайн шалгалтыг чухам яаж зохион байгуулж явуулах тухай дэлгэрүүлж тодруулсан байх;
- Төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр гаргах процесс (Дэг) –ийн тухай хуулийн агуулгад парламентын байцаан дүгнэх ажиллагааны талаар тусгаж хуульчилсан байх;
- Төрийн дээд байгууллагаас парламентын шалгалт хийх, мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах горимыг бүхэлд нь нэгтгэж зохицуулсан тусгай хуультай байх зэрэг болно.

Германы Үндсэн хуулинд парламентын мөрдөн шалгах комиссыг хэрхэн томилох, засаглалын бусад механизмтай комиссын үйл ажиллагааг холбох, комиссын ажлын дүнг ашиглах талаар заасан байна. Иймэрхүү утга санаа бүхий зүйл заалтууд Грек, Испани, Итали, Швейцарь, Япон, Португалийн болон бусад олон орны Үндсэн хуулинд суужээ¹⁷.

Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулдаг улс орнууд ч байна. Орос, Дани, Люксембург, Литва –д асуудал тусгай хуулиар, эсхүл тухайн орны үндэсний парламентын тухай хуулийн холбогдох бүлэг заалтаар зохицуулагддаг. Ер нь парламентын мөрдөн шалгах чиг үүргийг хуульчлан хэрэгжүүлдэг улс болгон парламентын явуулах процедур үйлдлийг зааж зохицуулсан Дэгийн тухай хуульдаа асуудлыг бас нарийвчлан тусгадаг ажээ. Парламентын бие даасан мөрдөн шалгах эрхийг Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн Беларусь, Гүрж, Молдав, Украин, Узбекистан, Армен зэрэг орнуудад баталгаажуулсан байна.

* * *

¹⁷ Хавсралтыг үзнэ үү

Европын Холбооны зарим улсууд болон АНУ, Японы парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны Үндсэн хуулийн зохицуулалтын талаархи лавлагаа

Улсын нэр	Улсын үндсэн баримт бичигт парламентын мөрдөн шалгах ү/а-г тусгасан байдал	Үндсэн баримт бичигт Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааг нарийвчлан тусгасан байдал	Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагааны нарийвчилсан дэг	Парламентын мөрдөн шалгах ү/а-ны субъект
Австри	Үндсэн хуулийн 53 дугаар зүйл	Байхгүй	Үндэсний зөвлөлийн дэгийн тухай Холбооны хууль	Мөрдөн шалгах хороо
Бельги	Үндсэн хуулийн 56 дугаар зүйл	Байхгүй	Үндсэн хуульд заагаагүй	Үндсэн хуульд заагаагүй
Их Британи	Заалт байхгүй		1967 оны хуулийн дагуу Захиргааны комиссар	Захиргааны комиссар
ХБНГУ	ХБНГУ –ын Үндсэн хуулийн 44, 45-а-2	Мөрдөн шалгах хороо байгуулах дараалал зарчим / ҮХ-ийн 44-1/ Төр засгийн байгууллагатай Хамтран ажиллах /ҮХ-ийн 44-3/ Парламентын мөрдөн шалгалтын үр дүнг ашиглах /ҮХ-ийн 44-4/	Мөрдөн шалгах үйл ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтын дагуу явуулах	Батлан хамгаалах асуудлаарх хороо / мөрдөн шалгах хорооны эрхтэй /
Грек	Үндсэн хуулийн 68 дугаар зүйл	Мөрдөн шалгах комисс байгуулах журам /ҮХ-ийн 68-2,3/	Мөрдөн шалгах комиссын ажиллах журам, бүтэц бүрэлдэхүүнийг Парламентын дүрмээр тодорхойлно	Мөрдөн шалгах комисс
Дани	Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл	Харилцан мэдээлэл солилцох харилцан /ҮХ –ийн 51 дүгээр зүйл/	ҮХ-нд заагаагүй	Онц чухал асуудлаар мөрдөн шалгах ү/а явуулах хороод
Испани	Үндсэн хуулийн 76 дугаар зүйл	Мөрдөн шалгах комисс байгуулах журам /ҮХ-ийн 76-1/ Парламентийн мөрдөн шалгах ү/а-ны үр дүнг ашиглах /ҮХ-ийн 76-1/ Парламентын шаардлагаар ирэх үүрэгтэй байх /ҮХ-ийн 76-2/	Үндсэн хуулинд заагаагүй	Мөрдөн шалгах комисс
Итали	Үндсэн хуулийн 82 дугаар зүйл	Парламентын мөрдөн шалгалт явуулах шалгуур / ҮХ-ийн 82-1/ Парламентын мөрдөн шалгалт явуулах комиссыг байгуулах журам /ҮХ-ийн 82-2 Парламентын мөрдөн шалгалт явуулах бүрэн эрх, хязгаарлалт/Шүүхийн бүрэн эрх ба хязгаарлалттай адил// ҮХ-ийн 82-2/	Үндсэн хуулинд заагаагүй	Төрийн эрх ашгийн үүднээс мөрдөн шалгалт явуулах комисс
Люксембург	Үндсэн хуулийн 64 дугаар зүйл	байхгүй	Хуулиар зохицуулсан	ҮХ-д заагаагүй

Португал	Үндсэн хуулийн 181 дүгээр зүйл	Парламентын мөрдөн шалгах түр комисс байгуулах журам /ҮХ –ийн 181 зүйлийн 2,4,6/ Парламентын мөрдөн шалгах ү/а-ны журам / ҮХ-ийн 181-3/ Парламентын мөрдөн шалгалтын явц хамтран ажиллах журам/ҮХ-ийн 181-3/ Парламентын мөрдөн шалгах комиссын бүрэн эрх / шүүхтэй адил эрх эдэлнэ// ҮХ-ийн 181-5/	Үндсэн хуульд заагаагүй	Парламентын мөрдөн шалгах түр комисс
Франц	Заалт үгүй		Тусгай хуультай	
Швед	Үндсэн хуулийн 4 дүгээр зүйл	Тусгай бүрэн эрхт Үндсэн хуулийн комиссын үйл ажиллагааны процесс/ҮХ-ийн 12 дугаар зүйл/ Сонгуулийн асуудлаар парламентын мөрдөн шалгалт явуулах асуудлын хүрээ, шалгалт хийх үндэслэл, үр дүн /ҮХ-ийн 4-7/	Риксдагийн тухай хууль	Сонгуулийн шалгалтын хороо, Үндсэн хуулийн комисс
АНУ	Заалт үгүй	1991.02.28 өдрийн Сенатын 62 дугаар тогтоол		Сенатын байнгын дэд хороо
Япон	Үндсэн хуулийн 62 дугаар зүйл	Парламентын мөрдөн шалгалт явуулах асуудлыг тодорхойлох шалгуурууд /ҮХ-ийн 62 дугаар зүйл/ Парламентын шаардлагаар тэмдэглэлээ ирүүлэх буюу хүрэлцэн ирэх үүрэгтэй		
Монгол	Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 8-д УИХ-ын “... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхийг хуульчилсан	Заалт үгүй	Тусгайлсан хууль үгүй	УИХ-ын Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсэг

* * *

Хавсралт 3

ХБНГУ-ын парламентын хяналт, шалгалт Хяналт шалгалтын хэлбэрүүд

Хууль тогтоомж болон төсвийн хяналт шалгалт

Засгийн газрын хяналт шалгалт нь Бундестагийн чухал үүрэг хариуцлагуудын нэг билээ. Энэ үүрэг нь хууль батлах үйл ажиллагаатай холбоотой. Засгийн газраас гаргасан хуулийн зүйл заалт бүрийг парламентаар хэлэлцэх ба олонхын саналыг авах шаардлагатай байдаг. Парламент нь мөн засгийн газрын төсвийн баримтлалыг хянан. Холбооны сангийн сайд

нь хуралдаанаар Бундестагд болон Засгийн газарт тайлангаа тавина.

Бие даасан гишүүдийн хяналт шалгалт

Парламентын гишүүд нь өөрийн ажил болон засгийн газрын төлөвлөгөө мөн чухал асуудлын талаар мэдээлэл авах боломжтой. Эдгээр арга хэмжээг заавал парламентын олонхоор дэмжих шаардлагагүй. Жишээлбэл бие даасан гишүүд засгийн газарт амаар болон бичгээр асуулт тавьж болно.

Төрөл бүрийн байгууллагуудын хяналт шалгалт

Бундестаг нь төрөл бүрийн байгууллагуудыг засгийн газрын ажлыг хянаж шалгуулахаар байгуулдаг. Эдгээр байгууллагуудын зарим нь байнгын байх ба үүнд байнгын хороод болон Парламентын хяналт шалгалтын хороо /Parliamentary Control Panel/ орно. Харин бусад байгууллагууд нь зөвхөн тулгамдсан чухал арга хэмжээнүүдэд хяналт шалгалт хийх зорилготойгоор байгуулагддаг. Зарим тохиолдолд энэ төрлийн байгууллагыг байгуулахад Германы Бундестагийн гишүүдийн 25 хувийн саналын дэмжлэг шаардагддаг. Эдгээр байгууллагуудад мөн улс төрийн болон хүнд суртал, албан тушаалын гэмт хэргийг шалгуулахаар байгуулдаг хяналтын хороод орно.

ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫГ ХЯНАН ШАЛГАХААР БАЙГУУЛАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

Хороод, комиссууд, комиссарууд

Германы Бундестагийн гишүүд засгийн газрын ажил, төлөвлөгөөний талаар мэдээлэл авах болон өөрсдийн саналаа хуралдаанд илэрхийлэх төрөл бүрийн боломжтой. Түүнчлэн Бундестагийн сонгуулийн жил бүр засгийн газрын хяналтыг хийх зөвшөөрөл бүхий байгууллагуудыг байгууна. Үүнд:

- Байнгын хороод
- Тусгай салбаруудыг хянан шалгах аар байгуулсан байгууллага
- Хяналтын хороод

○ Байнгын хороод

Бундестагийн байнгын хороод тус бүрдээ холбооны тодорхой яамыг хариуцсан байхаар зохион байгуулагдсан. Тиймээс тэдгээр нь бодлогын эсвэл үйл ажиллагааны тогтоосон тодорхой хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ. Хороод өөрийн хяналтын үйл ажиллагаагаа хууль тогтоох үйл ажиллагааны оролцоотойгоор шууд бусаар гүйцэтгэнэ. Гэхдээ мөн тэдэнд хяналт шалгалтын шууд эрхүүд байдаг. Жишээлбэл тэд холбогдох холбооны яамны төлөөлөгчдөөс тухайн хуулийн төслүүдэд тайлан гаргахыг шаардах эрхтэй.

○ Тусгай статустай байнгын хороод

Зарим байнгын хороод нь засгийн газрын холбогдох хяналтын үйл ажиллагааны тусгай статус эдэлнэ. Жишээлбэл Гадаад хэргийн хорооны үндсэн үүрэг нь засгийн газрын гадаад бодлогын хянан шалгалт байна.

Зэвсэгт хүчин хариуцсан парламентын комиссар, Батлан хамгаалах хороо, мөн Батлан хамгаалахын сайд нь зэвсэгт хүчний хяналтыг хангах зорилготой гэж Үндсэн хуульд заасан байдаг.

Төсвийн хороо нь төсвийн нөөцийн зөвшөөрлийн шийдвэр гаргахад чухал үүрэгтэй тул энэ нь хамгийн их эрх мэдэлтэй хороо байдаг.

○ **Өргөдлийн хороо /Petitions committee/**

Өөр нэг байнгын хороо нь Өргөдлийн хороо бөгөөд энэ нь мөн чухал байр суурь эзэлдэг. Иргэд нь засгийн газарт шууд нөлөөлөх боломжтой. Үндсэн хуульд зааснаар хүн бүр Парламентад санал хүсэлт эсвэл гомдлоо бичгээр илэрхийлэх эрхтэй. Тусгай эрх эдэлдэг өргөдлийн хороо нь иргэдээс ирүүлсэн захидлуудыг Германы Бундестагийн ерөнхийлөгчид дамжуулан хүргэнэ.

○ **Тусгай салбаруудад хяналт шалгалт хийхээр байгуулагдсан байгууллагууд**

Бундестагийн байнгын байгууллага нь мөн бодлогын тусгай салбаруудыг хянахаар байгуулагдсан байгууллагуудыг оруулна. Тэдгээр нь засгийн газрын тодорхой хүрээний ажлыг хянана. Парламентын хяналт шалгалтын хороо нь Холбооны оюуны үйлчилгээний үйл ажиллагааг хянана. Энэ хорооноос байгуулсан G10 Комисс нь захидал, шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалд хязгаарлалт хийх талаар шийдвэр гаргах үүрэгтэй.

Тусгай салбаруудад хяналт шалгалт хийхээр байгуулагдсан байгууллагууд нь засгийн газраас ерөнхий үйл ажиллагаануудын талаар мэдээлэл, түүнчлэн тодорхой чухал үйл ажиллагааны талаар мэдээлэл шаардах боломжтой. Хяналт хийх зорилготой эдгээр байгууллагуудад мэдээллээ өгөх болон ажилчдаас ярилцлага авах зөвшөөрлийг тэдэнд өгөх, агентууд руу зочлоход засгийн газраас зөвшөөрөл олгох ёстой.

➤ **Парламентын хяналт шалгалтын комисс /The Parliamentary Control Panel (PKGr)/**

Парламентын хяналт шалгалтын комисс нь Холбооны түвшинд оюуны үйлчилгээний ажлыг хянах үүрэгтэй. Энэхүү Комисс нь холбооны оюуны үйлчилгээний ерөнхий үйл ажиллагаа болон ялангуяа чухал үйл ажиллагааны талаар нарийвчилсан мэдээлэл өгөхийг Холбооны засгийн газраас шаардаж болно.

➤ **G 10 Комисс /G 10 Commission/**

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу G10 Комисс нь шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалд хязгаарлалт хийх шаардлагатай талаар шийдвэр гаргана.

➤ **ZFдG комисс /ZFдG Panel /**

ZFдG комисс нь Гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний актын / Customs Investigation Service Act/ дагуу байгуулагдсан. Герман улсын гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний төв офис нь Гадаад Худалдааны Төлбөрийн Акт /Foreign Trade and Payments Act/ болон Дайны зэвсгийн хяналтын актын /War Weapons Control Act/ дагуу гэмт хэргийг мөрдөн шалгана. Тиймээс энэ комисс нь шуудан холбоо, харилцаа холбооны хувийн нууцлалыг хязгаарлах эрхтэй. Дээр дурьдсан Үндсэн хуулийн заалтын дагуу үндсэн эрхүүдийг зөрчсөн эдгээр үйл ажиллагааг Гаалийн хяналт шалгалтын үйлчилгээний актын 23-р хэсгийн дагуу ZFдG Комиссоор шалгуулна.

➤ **Хувийн Орон Сууцан дахь Дуу Чимээний Хяналт Шалгалтын Хороо /Committee for the Scrutiny of Acoustic Surveillance of the Private Home/**

Үндсэн хуулийн өөрчлөлттэйгөөр зөвхөн ноцтой гэмт хэргийн тохиолдолд Хувийн орон сууцанд дуу чимээний хяналт шалгалтыг хийж болно. Энэхүү үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн 13-бд заасны дагуу парламентаар хяналт шалгалт хийлгэнэ.

○ **Хяналтын хороод** /Committees of inquiry/

Хяналтын хороо нь зөвхөн чухал тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр Германы Бундестагийн гишүүдийн 25 хувийн саналын дэмжлэгийг авсанаар байгуулагддаг. Хяналтын хороо нь Холбооны засгийн газар, Бундестаг, захиргааны улс төрийн болон хүнд суртал албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгаж хяналт хийнэ. Хяналтын хорооны гол ажил нь нотлох баримт цуглуулах ажил байна. Хяналтын хороо нь түүнд байгаа баримт материалыг шалгах, гэрчүүдийг шалгах, амлалт авах, ярилцлага авч болно. Түүнчлэн шүүх, захиргааны эрх мэдлээс гүйцэтгэх туслалцаа хүсч болно. Хяналт хийж дууссаны дараа тайланг хэвлэн гаргаж мөн Бундестагд хэлэлцүүлэг хийнэ.

БАТЛАН ХАМГААЛАХ ХОРОО /Defence Committee/

Батлан хамгаалах хороо нь Холбооны Батлан хамгаалах яам болон түүний харьяат агентлагууд болох Зэвсэгт хүчин болон Холбооны Батлан Хамгаалах Захиргаатай хамтран ажилладаг парламентын байгууллага юм. Тиймээс түүний эрх мэдлийн хүрээ нь Бундестагийн аль ч хорооноос илүү их хүрээг хамардаг. Энэ хороо нь мөн батлан хамгаалахын төсвийн гүйцэтгэл болон түүнийг хэлэлцэхэд чухал үүрэгтэй. Үндсэн хуулийн 45д зааснаар Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын Комиссарын байгууллагыг парламентын хянан шалгах үйл ажиллагаанд Бундестагд туслалцаа үзүүлэхээр байгуулсан. Парламентын комиссарын хийсэн цэргийн өнөөгийн байдлын үнэлгээг түүний жилийн тайланд оруулах ба энэ нь мэдээллийн чухал эх үүсвэр болно, тиймээс хэлэлцүүлэгт оруулна.

ЗЭВСЭГТ ХҮЧИН ХАРИУЦСАН ПАРЛАМЕНТЫН КОМИССАР /The Parliamentary Commissioner for the Armed Forces/

Бундестагийг төлөөлөн ажиллана. Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссарыг Бундестагийн гишүүд 5 жилийн хугацаатай сонгоно. Комиссар нь Бундестагийн гишүүн биш, төрийн албан хаагч ч биш ба, тэрээр тусгай байр суурьтай байна. Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссар нь Германы Үндсэн хуульд заасны дагуу үндсэн эрхийг хамгаалах, парламентын хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд Бундестагд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Комиссарын гүйцэтгэх эрх үүргүүд нь Зэвсэгт хүчин хариуцсан Парламентын комиссарын хуулинд заасан байдаг.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ПАРЛАМЕНТЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЖЛЫН АЛБАНААС
ҮЗҮҮЛЖ БУЙ МЭРГЭШСЭН ҮЙЛЧИЛГЭЭ** /Харьцуулсан судалгааны дүгнэлт/

Ц. Мягмарцэрэн, П. Амаржаргал, Г. Билгээ,
Б. Дуламсүрэн

Энэхүү илтгэлийн сэдэв нь “Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ” гэсэн тодорхой хүрээгээр хязгаарлагдаж байгаа тул Парламентын хууль тогтоохоос бусад эрх мэдлийн талаар авч үзээгүй болно. Тиймээс илтгэлд, судалгаанд хамрагдсан 50 орчим орны Парламентын ажлын албаны хууль эрх зүйн болон хуралдаан зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгжүүдийн зохион байгуулалт, чиг үүрэг нь УИХ-ын Тамгын газар дахь ижил чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдэд хэрхэн зохион байгуулагдсан талаар харьцуулан авч үзлээ.

ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Дэлхийн аль ч улс оронд хууль тогтоох эрх мэдэл нь тухайн улсынхаа Парламентад хадгалагддаг бөгөөд энэхүү эрх мэдэл нь хуулийн төсөл санаачлах, төслийг хэлэлцэн батлах гэсэн ерөнхий процессоор хэлбэржих тул Парламент нь нэг болон хоёр танхимтай байх эсэх, хуулийн төслийг эцсийн байдлаар Ерөнхийлөгч нь батладаг эсэхээс үл хамаарна. Харин Парламент энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд өндөр мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий мэргэшсэн албатай байх ёстой байдаг.

Тодруулбал, Парламентын Ажлын алба нь Парламентад бүхэлд нь болон Парламентын танхимууд, Байнгын болон бусад хороод /комисс/, Парламентын гишүүдэд хууль тогтоох болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх болон шинжлэх ухааны судалгаа, техник - зохион байгуулалтын өргөн хүрээтэй үйлчилгээ, туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн албан хаагчдын байгууллага юм.

Манай улс дэлхийн жишигт нийцсэн орчин цагийн Парламент бүхий улс болохын хувьд эдгээрийг хууль тогтоомждоо дараах байдлаар зохицуулсан байна. Монгол улсын Үндсэн хуулийн 20-р зүйлд “УИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална” хэмээн заасан байдаг. Тэгвэл Үндсэн хуулийн энэхүү заалт хэрхэн хэрэгжиж биелэлээ олдогийг УИХ-ын тухай хуулийн 32-р зүйлийн 1 -д “УИХ хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд Нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл, тодорхой бусад асуудал хэлэлцэх, санал хураах, батлах, шийдвэр гаргахдаа УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг баримтална” хэмээн тодорхой зааж өгчээ.

Хуулийн 38-р зүйлийн 2-т “УИХ нь гишүүд, Байнгын, дэд, түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна” гэж заасан нь УИХ хууль тогтоох бүрэн эрхээ эдэлж хэрэгжүүлэхэд УИХ-ын Тамгын газар гол үүрэгтэй болохыг нь тодруулж өгч байна.

Хэдийгээр ихэнх улс орнууд манай улсын адил Парламентад үйлчлэх үүрэг бүхий нэг ажлын албатай байдаг ч зарим улсын хувьд Парламентын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг туслалцааг сайжруулах, оновчтой зохион байгуулах үүднээс эрх зүйн байдлын хувьд Тамгын газартайгаа ижил түвшний, тухайлсан чиг үүрэг бүхий албыг зэрэгцүүлэн бий болгосон байдаг. Энд хоёр танхимтай Парламентад танхим бүрд зориулагдсан ажлын алба байдагтай хольж ойлгож болохгүй юм. Үүнийг тодруулах үүднээс Япон улсын Хуулийн

товчоо болон АНУ-ын Конгрессын Төсвийн газрыг жишээ болгон авлаа.

Хуулийн товчоо

Японы 1947 оны Үндсэн хуулийн дагуу одоогийн Хуулийн товчоо нь Ерөнхий нарийн бичгийн даргын газарт Хууль тогтоомжийн газар хэлбэрээр ажиллаж байжээ. Хожим нь 1948 онд Танхимуудын тухай хуулийн дагуу парламентын танхим тус бүр Ерөнхий нарийн бичгийн даргын газраас тусдаа, бие даасан Хуулийн товчоо ажиллуулах болсон байна. Хуулийн товчоо нь Ерөнхий болон Судалгааны хэлтсээс гадна 5 газартай бөгөөд тэдгээрээс салбарласан 10 хэлтсээс бүрдэнэ.

Конгрессийн төсвийн газар

Конгрессийн төсвийн газар (СВО) нь холбооны агентлаг бөгөөд 1974 оны Конгрессийн төсөв ба зарцуулалтыг хянах актын дагуу байгуулагдсан. Тус газар нь холбооны төсөвтэй холбоотой шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, шинжилгээ, суурь мэдээллээр хангах үүрэгтэй. Конгрессийн төсвийн хоёр хорооны саналыг үндэслэн Төлөөлөгчдийн танхимын дарга /Спикер/ болон Сенатын дэд ерөнхийлөгч нар зөвшилцөн уг газрын даргыг 4 жилийн хугацаатайгаар томилно. Газрын даргыг нь Парламентын Спикер томилдог энэхүү зарчим нь уг байгууллагыг Парламентын ажлын алба буюу Тамгын газрын статустай болохыг харуулж байгаа юм. Конгрессийн төсвийн газар нь дараахь 8 хэлтэст хуваагдана.

- Төсвийн анализийн хэлтэс
- Эдийн засгийн анализийн хэлтэс
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэлтэс
- Макро эдийн засгийн хэлтэс
- Менежмент, бизнес, мэдээллийн үйлчилгээний хэлтэс
- Микро эдийн засгийн судалгааны хэлтэс
- Үндэсний аюулгүй байдлын хэлтэс
- Татварын анализийн хэлтэс

ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

Энэ хэсэгт хууль тогтоох процесс дахь Парламентын ажлын албаны оролцооны хүрээг тодруулахыг зорьсон буюу уг албаны чухам аль бүтцийн нэгж нь хууль тогтоох процесст илүү үүрэг гүйцэтгэж байгааг тодорхойлов. Хэдийгээр УИХ-ын Тамгын газрын хэлтэс албадууд бүхэлдээ УИХ-аас хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тодорхой хэмжээгээр заавал оролцдог ч тэдгээрийн дундаас Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс, Байнгын хороодын ажлын алба, Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба, Судалгааны төвийн үндсэн чиг үүргүүд хууль тогтоох процесст илүү оролцоотой байна. Энд зөвхөн хууль боловсруулах тухай явцуу хүрээг хамруулж байгааг анхаарна уу.

Бусад улс орнуудын хувьд ч ерөнхийдөө мөн адил ийм байгаа боловч бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалт, чиг үүргийн зарим нэг онцлог хуваарилалтаас хамаарсан ялгаа харагдаж байна.

Нийтлэг бүтэц зохион байгуулалт бүхий:

УИХ-ын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, албадын чиг үүрэгтэй төстэй олон улс орнууд байгаа бөгөөд эдгээрээс цөөн хэдийг товч авч үзье.

1. Солонгос

Үндэсний хурлын Тамгын газарт **Хуулийн зөвлөхийн албанаас** гадна **Үндэсний хурлын**

судалгааны газар байх бөгөөд хууль тогтоох болон бодлогын үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох мэдээлэл хайх, боловсруулах үүрэгтэй. Судалгааны газар нь гишүүд, хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа, шинжилгээ хийнэ.

Үндэсний хурлын төсвийн газар нь төсвийн тухай хуулийн төслийг судлах, анализ хийх, төсвийн болон сангуудын хөрөнгийг зарцуулахтай холбоотой хуулиудын төслийн нэгдсэн дүнд анализ хийх, төрийн болон макро эдийн засгийн талаарх санхүүгийн чиг хандлага, мэдээ гаргах, задлан шинжилгээ хийх, томоохон хэмжээний нийтийн төслүүдэд үнэлгээ өгөх, төрийн урт болон дунд хугацааны санхүүгийн үнэлгээ хийх, Үндэсний хурлын гишүүд болон хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу дүн шинжилгээ хийнэ.

2. Турк

Ерөнхий нарийн бичгийн даргын газрын **Хуулийн зөвлөхүүдийн алба** болон **Хууль тогтоомжийн газар** нь Үндэсний Их Хурлын хуулийн төсөл бэлтгэх, боловсруулах, гишүүдээс гаргасан саналыг томъёолох, хороодын тайлан бэлтгэх зэрэг ажилд туслалцаа үзүүлэх, баримт бичгийг бүртгэх, хувилах, мэдээлэх үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

3. Аргентин

Тамгын газрын **Байнгын хороодын газар** нь хуралдааныг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, дотоод ажлын зохион байгуулалтыг хангах, Хорооны дарга, гишүүдэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх, ажлын алба, ажилтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, шуурхай удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4. Канад

Нарийн бичгийн даргын орлогч нь Нийтийн танхимын хоёр дахь үндсэн, байнгын ажилтан бөгөөд Клеркийн удирдлагын бүлгийн хүрээнд хийгдэж буй ажлын үр дүн, тэргүүн ээлжийн болон стратегийн чиглэлийг тодорхойлох үүрэгтэйгээс гадна Дэгийн албыг ерөнхий удирдлагаар хангаж, парламент хоорондын харилцааны асуудлыг хариуцна.

Хуулийн клерк бөгөөд парламентын Зөвлөх нь гишүүдийг хууль тогтоох болон хянан шалгах үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй. Нийтийн танхимд өргөн баригдсан баримт бичгийн төслийг хэвлэж, тараана.

Парламентын гүйцэтгэгчийн (Serjeant-at-Arms) гол үүрэг нь парламентын хуралдааны үед эмх журам сахиулах ба Дэгийн хуулийг мөрдүүлэхэд спикерт туслана. Ийм нийтлэг зохион байгуулалтын бүтэц байдаг бол одоо арай өөр онцлог бүхий улс орнуудын жишээг харуулая.

Ялгаатай бүтэц зохион байгуулалт бүхий:

Энд УИХ -ын Тамгын газрын хэлтэс албадад тус тусдаа хуваарилагдсан чиг үүргүүдийг нэгтгэх, тусгаарлах зэргээр өөр хэлбэрээр зохицуулсан буюу зохион байгуулалтын бүтцийн өөр нэгжид хариуцуулсан зэрэг туршлагауд байна.

1. Эстони

Эрх зүй, судалгааны хэлтэс нь хамтдаа байдаг бөгөөд Рийгикогу, түүний Тамгын газрын хэлтэс, албадад эрх зүй, парламентын хяналт, нийгэм, эдийн засгийн салбарууд болон Европын Холбоны асуудлаар зөвлөлгөө өгөх, харьцуулсан судалгаа, шинжилгээ хийх,

лавлагаа мэдээлэл өгөх, хууль, тогтоолын төсөлд дүн шинжилгээ хийж зөвлөмж, дүгнэлт гаргах, шинжилгээ судалгааны ажил захиалах, гадаад орнуудын парламентын судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэгтэй.

Албан хэрэг, баримт бичгийн хэлтэс нь Тамгын газрын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг хариуцах бөгөөд парламентаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан, хэлэлцүүлгийн шатанд байгаа болон батлан гаргасан хууль, шийдвэрийн бүртгэл хөтлөх, хэл зүй, найруулгын зөвлөлтөө өгөх, нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, соронзон хальсанд буулгах, баримт бичгийн орчуулга хийх зэрэг үүрэгтэй.

2. Энэтхэг

Парламентын хоёр танхимын Тамгын газрын **Хууль тогтоомжийн жигүүрийн** ажлын ихэнх хэсэг нь асуулт, асуулгын салбар, хууль тогтоомжийн салбар, Парламентын баримт бичгийн алба зэргээр Танхимын үйл ажиллагаатай уялдаатай байдаг. Харин **Парламентийн хорооны салбарын** ихэнх ажил нь Үнэлгээний хороо, Улсын төсвийн хороо, Улсын үйлдвэрийн газрын хороодын ажилтай уялдаатай байна.

Захиргаа, зохион байгуулалтын жигүүр нь гишүүдийн цалин, нэмэгдэл хөлс, гишүүдийн үйлчилгээ, төлбөр тооцооны алба, төсөв, данс бүртгэлийн салбар, нийтлэг ажил үйлчилгээ зэрэг ажил үйлчилгээг эрхэлнэ. **Хорооны салбарын** ажилтнууд нь парламентын байнгын болон бусад хороодод зөвлөн туслах үүрэгтэй.

Протоколын салбарын ажилтнууд нь Энэтхэгийн болон гадаад орны удирдлагуудын оролцсон айлчлал, хурал, цуглааныг зохион байгуулахтай холбоотой ажлыг гүйцэтгэнэ. Гэхдээ энд гол онцлог зохицуулалт нь **Захиргаа, санхүү, зохион байгуулалт, хууль тогтоомжийн үйлчилгээ хариуцсан ажилтнууд** парламентын захиргааны эрэлт хэрэгцээнд нийцүүлж **аль ч салбар хооронд шилжин** хариуцлагатай ажиллах үүрэгтэй.

3. Аргентин

Тус улсын Тамгын газарт хууль тогтоох процесст шууд оролцох чиг үүрэг бүхий хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж байхгүй байгаа нь онцлог болж байна. Үүнтэй адил зохион байгуулалт бүхий Сингапур, Чили зэрэг улсуудыг жишээ болгож авав. Тодруулах үүднээс энэ чиг үүргийг хариуцдаг нэгжүүдийн чиг үүргүүдийг товч дурдсан.

Парламентын мэдээллийн Захиргаа нь Тамгын газрын хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг, Депутатуудын танхимд мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй төв юм.

Мэдээллийн Захиргаанд бодлогын шинжээч, хуульч, мэдээллийн мэргэжилтэн, эдийн засагч, гадаад хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч, антропологич, сэтгэл судлаач, боловсролын мэргэжилтэн, байгаль орчин болон шинжлэх ухаан технологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, шинжээчид ажилладаг. Мэдээллийн Захиргаа нь тойм мэдээлэл, зөвлөгөө өгөх, батлагдан гарсан хуулийн асуудлаарх тайлан мэдээний хүрээнд мэдээлэл бэлтгэх Конгрессийн ажилтнуудад хууль тогтоох болон төсөв хэлэлцэх журмын талаар сургалт зохион байгуулах, хуульд дүн шинжилгээ, анализ, тайлбар хийх зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

4. Сингапур

Албан ёсны баримтын газар

Чуулган, хуралдааны үеэр гишүүд болон хуралдааны үйл ажиллагаанд оролцогчдын

хэлсэн үг бүрийг тэмдэглэл, албан ёсны бичлэгт буулгах бөгөөд хороодын хурлын тэмдэглэл, төлөөлөгчдийн уулзалт, парламентын гишүүдийн уулзалтын тэмдэглэлийг хөтөлнө.

Номын сан, судалгааны газар

Номын сангийн гол үйлчилгээ нь парламентын гишүүд, хуулийн төслийн туслахууд, Тамгын газрын ажилтнуудыг мэдээллээр хангах, лавлагааны материал боловсруулахад чиглэгдэнэ.

Аюулгүй байдлын газар

Аюулгүй байдлын газар нь захирал, журам сахиулагчдаас бүрдэнэ. Захирал нь танхимын аюулгүй байдлыг хариуцан ажиллана. Түүнчлэн ёслолын чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд эрх олгогдсон тохиолдолд парламентын онцгой эрхийг зөрчсөн этгээдийг зохицуулах үүрэгтэй.

5. Чили

Сенатын ажлын албаны **Мэдээллийн хэлтэс** Үндэсний Конгрессийг нийгэм, улс төр, эдийн засаг, эрүүл мэндийн зэрэг бүх салбарын мэдээллээр тогтмол хангаж ажиллана. Түүнчлэн төрийн хэвлэл болон улирал, жилийн тайланг боловсруулан хэвлэх үүрэгтэй.

Сурталчилгаа (PR) ба хэвлэлийн хэлтэс Конгрессийн албан ёсны мэдэгдэл, тайлан, гадаад, дотоод үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэх, хэвлэн нийтлэх, танилцуулах ажлыг хариуцахаас гадна Үндэсний Конгрессийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нээлттэй засаглалыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны **Комисс** нь улсын төсвийг хянан шалгаж, судлах, олон улсын гэрээ хэлэлцээр, гэрээний төслийг хэлэлцэн Төлөөлөгчдийн танхимд оруулах онцгой эрхтэй.

Мэдээллийн хэлтэс нь Үндэсний Конгрессийн хүсэлтээр хууль, эрх зүй, эдийн засаг, статистикийн тайлан мэдээг холбогдох эх үүсвэрээс бэлтгэн боловсруулж хүргүүлэх үүрэгтэй. Мөн хурлын онцгой мэдэгдлийг бэлтгэн гаргадаг.

6. Нидерланд

Бүртгэл, хууль зүйн товчоо нь Засгийн газар, иргэд, байгууллагуудаас ирүүлсэн баримт бичгийг бүртгэж, холбогдох газарт хүргэх асуудлыг хариуцна. Төлөөлөгчдийн танхим нь долоо хоног бүрийн пүрэв гаригт дараагийн долоо хоногт хэлэлцэх асуудлаа тодорхойлдог. Бүртгэл, хууль зүйн товчоо үүний дагуу өдөр бүрийн хэлэлцэх асуудлыг бэлтгэн, хуралдаанд оролцох сайд нарт мэдэгдэнэ. Мөн хэлэлцэх асуудлын урт хугацааны дарааллыг гаргаж, парламентын гишүүд ямар асуудлаар, хэдийд санал хураалтанд оролцох нь тодорхой байхаар санал хураалтын хуваарийг бэлтгэнэ.

Парламентын гишүүдийн санаачилсан хуулийн төсөл, нэмэлт оруулах санал бүрийн текст нь зөв дараалалтай эсэх, хууль зүйн стандартад нийцэж байгаа эсэхийг Бүртгэл, хууль зүйн товчоо хянаж, үнэлгээ дүгнэлт гаргана. Хуулийн төсөл Төлөөлөгчдийн танхимаар батлагдсаны дараа Ерөнхий нарийн бичгийн даргын оффис уг төслийг дээд танхим буюу Сенатад хүргүүлнэ.

Хууль тогтоох процесст парламентын ажлын албаны оролцооны хүрээ

Парламентын хууль тогтоох эрх мэдлийн хэрэгжилт нь:

- Хуулийн төсөл санаачлах
- Хуулийн төслийг хэлэлцэх
- Хуулийг батлан гаргах гэсэн үндсэн хэсгүүдээр илэрхийлэгддэг, тодорхой дараалал бүхий процесс юм.

Эдгээр үе шат бүрд Парламентын ажлын алба хэрхэн оролцдог талаар авч үзье.

Хуулийн төсөл санаачлах

Бусад улс орнуудын жишиг хандлагаас харахад хуулийн төсөл санаачлах эрх ихэнхдээ Парламентын гишүүд болон Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд зэрэг төрийн эрх барих дээд түвшний субъектуудад хамаардаг байна. Гэхдээ латин америкийн зарим улсуудад Дээд шүүх нь хуулийн төсөл санаачилж болдог онцлог туршлага байдаг бол Аргентин улсад иргэн хүн хуулийн төсөл санаачилж болдог байна. Гэвч хэн хуулийн төсөл санаачилснаас үл хамааран Парламентын ажлын алба төслийг хүлээн авч хэлэлцүүлэгт бэлтгэх байдлаар зохих журмын дагуу хэлбэржүүлэх үүргийг гүйцэтгэдэг нь аль ч улсын хувьд нийтлэг жишиг юм.

УИХ-ын тухай хуулийн 39-р зүйлд зааснаар хуулийн төсөл санаачлах үе шатанд Тамгын газар дараах үүргийг гүйцэтгэдэг байна.

1. УИХ, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
2. УИХ-д өргөн мэдүүлэх төслийг хянаж, зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах;

Дийлэнх улс орнуудын Парламентын ажлын албадын хувьд хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж нь хуулийн төслийг хүлээн авснаар энэхүү үйл ажиллагаануудыг гүйцэтгэдэг.

УИХ -ын Тамгын газрын хувьд энэхүү чиг үүргийг Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс гүйцэтгэж байдаг бол АНУ-д Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны Эрх зүйн хэлтэс дотор энэ талаар тусгайлсан чиг үүрэг бүхий **хуулийн төслийн Клерк** ажиллаж төсөв, тушаал, тогтоол, нэмэлт баримт, материалуудын төслийг хүлээн авч боловсруулан Төлөөлөгчдийн танхимын хуралд танилцуулдаг. Хуулийн төсөл санаачлах үе шатан дахь Парламентын ажлын албаны нэг онцлог оролцоо бол Парламентын гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөлгөө, туслалцаа үзүүлэх явдал байдаг. Энэ чиг үүрэг хуулийн төсөл хэлэлцэх үе шатанд хэрэглэгдэж болох ч үндсэндээ төсөл санаачлагч гишүүнд хуулийн төслөө боловсруулах үед нь илүү үүрэг ач холбогдолтой байдаг.

Тухайлбал, Шинэ Зеландын Клеркийн газрын **Хууль тогтоомжийн төслийн хэлтэс** нь парламентын гишүүд хуулийн төслөө боловсруулахад нь шаардлагатай хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд **Хууль зүйн үйлчилгээний оффисоос** хууль зүйн экспертиз, зөвлөлгөө тусламж авч болдог. Ийнхүү хууль тогтоомжид заасан шалгуур болон бүрдлийг хангасан төслийг Парламентын ажлын алба хүлээн авсны дараа төслийг хэлэлцүүлэхээр бэлтгэдэг.

Хуулийн төслийг хэлэлцэх

Хуулийн төслийг хэлэлцэх үйл явц нь Парламентын үндсэн үүрэг болохын хувьд энэ үе

шатанд Парламентын ажлын алба ихээхэн өргөн хүрээгээр оролцдог. Үүнд:

1. Хуралдааны бэлтгэл хангах,
2. Хуралдаан, хэлэлцүүлгийг зохион байгуулах,
3. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын зөрүүг арилгахад чиглэсэн зөвшилцөх үйл ажиллагаанд эрх зүй, дүн шинжилгээ, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Үүнд Парламентын ажлын албаны дараахь бүтцийн нэгжүүд гол үүрэг гүйцэтгэнэ.

- хууль эрх зүйн үйлчилгээний асуудал хариуцсан нэгж,
- судалгаа мэдээллийн асуудал хариуцсан нэгж,
- хуралдааны үйл ажиллагаа зохион байгуулах үүрэг бүхий нэгж,
- байнгын хороодын ажлын алба,

Гэхдээ өмнөх хэсэгт дурдсанчлан эдгээр нэгжүүдийн зохион байгуулалт улс бүрд адилгүй бөгөөд нэршил, харъяалал, дотоод зохион байгуулалт, эрхлэх асуудлын хүрээнээс хамаарч нийтлэг нэг хэлбэрээр тодорхойлох боломжгүй тул ерөнхий чиг үүргийн хувьд ийнхүү хуваан авч үзлээ. Ихэнх улс орнуудын хувьд төслийг хэлэлцэхдээ Парламент буюу гишүүдийг хэлэлцүүлэг эхлэхээс өмнө болон хэлэлцүүлгийн явцад судалгаа мэдээллийн асуудал хариуцсан нэгж шаардлагатай судалгаа, мэдээ, баримтаар хангах үүргийг хүлээдэг.

Харин хууль эрх зүйн үйлчилгээний асуудал хариуцсан нэгж нь хэлэлцүүлгийн явцад төслийг эрх зүй, хэл зүйн талаас нь хянах, бусад хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх, уялдуулах, шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргах, эрх зүйн тайлбар өгөх гэсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Төсөл хэлэлцэх үе шатанд гол үүрэгтэй бүтцийн нэгж бол хуралдааны үйл ажиллагаа зохион байгуулах үүрэг бүхий нэгж байдаг. Нэлээд олон улс орнуудын хувьд үүнийг хуралдааны дэгийн болон протоколын асуудал хариуцсан чиг үүрэг бүхий нэгж болон Байнгын хороодын үйл ажиллагаанд туслах, үйлчлэх чиг үүрэг бүхий ажлын алба гэсэн хоёр тусдаа чиг үүрэгтэй байгууллагуудыг байгуулсан байдаг. Манай улс ч энэ жишгээс гажаагүй. Гэхдээ ингэснээр Байнгын хорооны ажлын албадын чиг үүрэг зарим тохиолдолд бүрхэгдэн зохион байгуулалтын бүтэц дэх бусад нэгжийнхээ чиг үүрэгтэй давхцах, хийдэх нөхцлийг бүрдүүлдэг байна.

Доор дурдсан улсуудын жишээгээр төсөл хэлэлцэх явц буюу хуралдааны процесст дэг, зохион байгуулалт, эрх зүйн болон бусад аливаа хэлбэрийн туслалцаа үзүүлэх чиг үүргүүдийг хэрхэн зохицуулсныг тус тусд нь ялган авч үзүүлэв.

Чиг үүргүүдийг салангид хуваарилсан зохицуулалт:

1. Узбекистан

Байнгын хороодын ажлын алба нь Байнгын хороодоор хуулийн төсөл хэлэлцэх, санал, дүгнэлт гаргах, хянах зэрэг үйл ажиллагаанд зохион байгуулалт, арга зүй, мэдээллийн болон шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөлтөө өгнө. Түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, байнгын хороодоос зохион байгуулж буй арга хэмжээ болон ажлын хэсэг байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

2. Австри

Хуралдаан зохион байгуулах хэлтэс нь санал хураалтад бэлтгэх, Спикерийн үйл ажиллагааг Дэгийн тухай хуулийн дагуу явуулах, үг хэлэх хугацааг сахиулах, үг хэлэгчдийн жагсаалтыг асуулгын цагт бэлтгэх, Үг хэлэгчдийн жагсаалт гаргах, хуралдааны албан ёсны протокол хөтлөх, Холбооны зөвлөлийн тогтоолын хуулбарыг гаргах гэсэн чиг үүрэгтэй.

Хороодын ажлын алба нь Хорооны даргын үйл ажиллагааг Дэгийн хуулийн дагуу нарийн зохион байгуулалттай хэрэгжүүлэхэд туслах, хуралдаанд бэлтгэх болон холбогдох баримт бичгийг хариуцах, Хорооны шийдвэрүүд, тайлан болон бусад баримт бичгийн найруулга зэргийг хариуцах, Мэдээлэл, лавлагаагаар хангах гэсэн чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнээс гадна Эрх зүй, хууль тогтоомж, судалгааны албанд **Дэг процедурын хэлтэс** байдаг ч энэ нь зөвхөн Дэгийн журам, Дэг сахиулах журмыг л боловсруулах үүрэгтэй байна.

3. Орос

Зохион байгуулах газар нь нэгдсэн болон Хороодын хуралдааны бэлтгэл, техник, зохион байгуулалтыг хангах, хуралдааны ирцийг бүрдүүлэх, ОХУ-ын Засгийн газрын болон бусад зарим байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээр байгууллагад өгсөн үүргийн биелэлтэд хяналт тавих, Төрийн Дум, түүний Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдож гарсан шийдвэрийн биелэлтийг хангах чиг үүрэгтэй.

Баримт бичгийн газар нь албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, нэгдсэн болон Хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, соронзон хальсанд бичих, хэвлэн гаргах, хуралдааны тэмдэглэлийг дотоод сүлжээнд байрлуулах, албан бичиг, иргэдийн санал, өргөдөл, гомдлыг бүртгэн авч, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих чиг үүрэгтэй.

4. Серби

Үндэсний Ассамблейн Чуулган зохион байгуулах хэлтэс нь чуулганы хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах, хуралдаанд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг цуглуулах, бэлтгэх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, батлагдсан хууль тогтоомжуудыг “Бүгд Найрамдах Серби Улсын Төрийн сонин”-д хэвлүүлэхэд бэлтгэх, хуралдааны хөтөлбөр, цагийн хуваарийг боловсруулах, хуралдааны товын талаар гишүүдэд мэдээлэл өгөх, Үндэсний Ассамблейн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай албаны болон мэргэжлийн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Хуралдааны тэмдэглэл хөтлөх хэлтэс нь хуралдааны хэлэлцүүлгийн бүх тэмдэглэлийг “Хуралдааны тэмдэглэл” цуврал хэвлэлд хэвлэхээр хянах, Зөвшөөрөгдөөгүй тэмдэглэлүүдийн үг үсэг, найрлагыг дахин боловсруулж, зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулах, Парламентын асуулгын төсөлд хууль зүйн болон бичгийн томъёололын хяналт хийх, Хуралдааны тэмдэглэлүүдээр ном товхимол бэлдэж гаргах Удирдлагын хорооноос зөвшөөрсний дагуу хэвлэгдэн гарсан хуралдааны бичлэгийн товхимолыг хэрэглэгчдийн хаягийн бүртгэлийг гаргах, Хуралдааны тэмдэглэлийн архив, мэдээллийн санг үүсгэж хадгалах зэрэг үндсэн үүрэг болон холбогдох дүрэм, журамд заасан бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Байнгын хороодын асуудал хариуцсан сектор нь Байнгын хороодын хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах, Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэгдсэн асуудлуудтай холбоотой баримт бичиг, мэдээ бэлтгэх, тайлан бичих, Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж буй асуудлаар мэргэжлийн зөвлөлгөө өгөх, хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг томъёолон бэлтгэх, Байнгын хороодоос гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Иргэд, байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авах, Үндэсний Ассамблейгаас

баталсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын танилцуулга, тайлан бичих, Санаачилсан хууль тогтоомжийн төсөл Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргахад зориулан санал, тайлбар бэлтгэх, холбогдох мэдээллийг харьцуулах, Иргэд, байгууллагуудаас гаргасан өргөдөл, санал, хүсэлтэд хариу өгөхөд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, Хууль тогтоомж болон хуулийн төсөлд анализ хийх, Үндэсний Ассамблей, түүний байнгын хороод болон гишүүдэд шаардлагатай бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Чиг үүргүүдийг нэгтгэн хуваарилсан зохицуулалт:

1. Норвеги

Байнгын хороодын ажлын албаны бүтцэд Байнгын хороодын нарийн бичгийн дарга нарын газар ба Байнгын хороодын архив байна. **Байнгын хороодын нарийн бичгийн даргын газар** нь хороодын хурал, сонсгол зэргийг зохион байгуулах, хэвлэл, олон нийтэд зориулсан мэдээллийг бэлтгэх, хороодын өдөр тутмын ажилд бодитой туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

Хороодын ажлын алба нь Хороодоор хуулийн төсөл хэлэлцүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах ба үйл ажиллагаанд нь мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. **Ажлын хуваарь, баримт бичгийн алба** нь Стортингийн ажлын хуваарийг зохицуулна. Санал, асуулт, лавлагаа, Стортингийн хэлэлцэх асуудлуудын долоо хоногийн хуваарийг бэлтгэнэ. Мөн Стортингийн хуралдааны үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг бэлтгэнэ.

2. Румын

Техникийн нарийн бичгийн даргын газар нь Депутатын танхимын Товчоо (шаардлагатай үед хоёр танхимын Товчооны), парламентын бүлэг, байнгын хорооны үйл ажиллагааны бэлтгэлийг хангахаас гадна эдгээрээс гаргасан шийдвэр, парламентын гишүүд, албан тушаалтны гаргасан санал, хүсэлтийн биелэлтэд хяналт тавих, Депутатын танхимын мэдээллийн нууцыг хамгаалах арга хэмжээ авах, архивыг хариуцах зэрэг чиг үүрэг гүйцэтгэнэ.

3. Словени

Үндэсний Ассамблей, Байнгын хороодын хуралдаан зохион байгуулах алба нь Хуулийн төсөл боловсруулах, Европын холбоотой харилцахтай холбоотой асуудлыг хариуцах ба уг асуудлаар мэргэжлийн санал, зөвлөлгөө өгөх, тайлан, дүгнэлт, анализ, мэдээ мэдээлэл болон бусад материалыг бэлтгэх, Парламентаас батлан гаргасан хууль тогтоомж Үндсэн Хууль болон эрх зүйт ёсонд нийцсэн эсэх талаар Үндсэн Хуулийн шүүхийн өмнө гаргах тайлбарыг томъёолоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг тайлбарласан шийдвэрийн талаар Үндэсний Ассамблейд экспертийн санал гаргах, бодлого боловсруулалт, түүний хэрэгжилтийн талаар мэргэжлийн зөвлөлгөө өгөх, Үндэсний Ассамблейн дэгийн талаар тайлбар гаргах үүрэгтэй.

Дээрх үүргүүдийг холбогдох ажлын хэсгүүд буюу Зөвлөл, Хороодын албан хаагчид гүйцэтгэнэ. Эдгээр зөвлөл, хороод нь нарийн бичиг болон удирдлагын туслах ажилтантайгаас гадна ажлын цар хүрээнээс хамааран ажилтны тоо нэмэгдэнэ.

Мандат болон Сонгуулийн Хорооны ажилтнууд нь өөрийн хорооны үйл ажиллагаанаас гадна гишүүдийн статус болон боловсон хүчний асуудлуудыг хариуцаж, албан хаагчдын бүртгэлийг хөтлөн, гишүүдийг материаллаг баазаар хангаж ажиллана. Өргөдөл, санал хүсэлт, хүний эрх, тэгш эрхийн байнгын хорооны ажилтнууд нь өөрийн хорооны үйл ажиллагаанаас гадна Үндэсний Ассамблейд ирсэн өргөдөл, гомдол, танилцуулга зэрэгтэй

холбоотой техникийн үүргийг гүйцэтгэнэ.

4. *Украйн*

Зохион байгуулалтын газар нь Байнгын хороо, намын болон депутатын бүлэгтэй ажиллах газар болон Байнгын хороодын, Байнгын хороо, намын болон депутатын бүлгийн, Хуулийн төслийн төлөвлөлт, бүртгэлийн, Нэгдсэн хуралдааныг зохион байгуулах гэсэн хэлтсүүдтэй.

Тус газар нь нэгдсэн болон Байнгын хороод, нам эвсэл, депутатын бүлгийн хуралдааны бэлтгэл, техник, зохион байгуулалтыг хангах, хуралдааны ирцийг бүрдүүлэх, парламентад ажлаа тайлагнадаг байгууллагуудын тайлан, мэдээлийг сонсох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийн хөгжлийн чиг хандлага, хууль тогтоох үйл явцын тулгамдсан асуудлаар шинжилгээ, прогноз хийх зэрэг чиг үүрэгтэй.

5. *Швед*

Риксдагт 15 парламентын хороо байдаг. Хороод бүр өөрийн нарийн бичгийн даргын газартай бөгөөд эдгээр газрууд нь хорооны нэг ахлах нарийн бичгийн дарга болон таваас арван ажилтантай байдаг.

Хорооны нарийн бичгийн даргын газрууд нь гишүүдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд шаардлагатай материал бэлтгэх, Европын холбооны зарим материалд дүгнэлт бичих, үүний дагуу Риксдагийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй. Мөн судалгаа, төлөвлөлттэй холбоотой ажилд нь туслана.

Чиг үүргүүдийг давхцуулан хуваарилсан зохицуулалт:

1. *Австрали*

Процедурын газар нь Сенатын гишүүд ба департментын ажилтнуудад үйлчилгээ үзүүлдэг. Газрын дарга нь Сенатын Клеркийн процедур хариуцсан ассистент байх бөгөөд процедурын асуудлаар аман болон бичгийн хэлбэрээр зөвлөлтөө өгөхөөс гадна хууль тогтоомжийг хэлэлцэхэд процедурын тусламж үзүүлнэ. Мөн хууль тогтоомжийн төсөл хэлэлцэх байнгын хороод болох Хуулийн зохицуулалт, хууль тогтоомжийн болон Хуулийн төсөл нягтлах байнгын хорооны ажлын албаны үүрэг гүйцэтгэнэ.

Процедурын газрын Судалгааны хэсэг нь парламент, парламентын түүх болон Үндсэн хуулийн асуудлаар судалгаа хийх, сенатын талаарх мэдээллийг ном, товхимол болон электрон хэлбэрээр бэлтгэх, парламентын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар сенатын гишүүд, тэдний туслахууд болон парламент, гүйцэтгэх засаглалын албан хаагчдад зориулан семинар зохион байгуулах, процедурын мэдээллийн ресурсийн төвийг ажиллуулах, парламентын гишүүд ба парламентын албан тушаалтнуудын хамрагдах хөтөлбөр, парламентын асуудлаар нийтэд зориулсан лекц, үзэсгэлэн зэргийг зохион байгуулна.

Байнгын хороодын газар нь Парламентын Байнгын хороод, тусгай хороод болон хоёр танхимын хамтарсан хороодод зориулан судалгаа хийх, захиргааны болон нарийн бичгийн даргын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Газрын дарга нь Сенатын Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент байх бөгөөд мөн Баримт бичгийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэж, байнгын хороод болон хороодын ажлын албадад процедурын холбоотой зөвлөлтөө, удирдамж өгнө.

2. Намиби

Баримт бичгийн газар нь танхимын үйл ажиллагаанд шуурхай туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцна. Түүнээс гадна:

- Өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх
- Үйл ажиллагааны товыг тогтоох
- Танхимд баримт бичгийг хүлээн авах, тараах
- Гишүүдийн санал, засварыг бэлтгэх
- Баримт бичигт редакци хийх
- Танхимын даргад дэгийн холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлэх
- Танхимын дотоод аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэх

Эрх зүйн үйлчилгээний хэлтэс Үндэсний Ассамблейн дарга, дэд дарга, парламентын хоёр танхимын гишүүдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлнэ. Үндэсний зөвлөлийн гишүүдэд дэгийн болон эрх зүйн асуудлаар зөвлөнө. Хэлтэс нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Эрх зүйн судалгаа
- Эрх зүйн баримт бичгийн редакци
- Парламентын гишүүдэд эрх зүйн зөвлөлгөө өгөх
- Парламентын гишүүдийн оролцооны бүртгэл хөтлөх
- Хууль боловсруулах шатанд Үндсэн хуулийн болон бусад холбогдол бүхий асуудлаар эрх зүйн дүгнэлт гаргах

Байнгын хорооны ажлын алба нь байнгын болон чиглэлийн хороодын дарга, гишүүдэд удирдлага, дэгийн холбоотой асуудлаар үйлчилгээ үзүүлнэ. Мөн гишүүдээс иргэний болон бусад байгууллагуудтай харилцахад дэмжлэг үзүүлэх буюу гишүүдэд хандан тавьсан олон нийтийн санал хүсэлтийг шийдвэрлэхэд туслах үүрэгтэй байдаг.

3. Финланд

Хороодын ажлын алба /Committee Secretariat/ нь хорооны хурлын зохион байгуулалт, бэлтгэл ажлыг хариуцна. Хорооны ажлын алба нь Байнгын хороод болон Ерөнхий хорооны ажилтнуудаас бүрдэнэ.

15 Байнгын хорооны ажлын алба /15 special Committees/ нь Засгийн газраас санаачилсан хуулийн төсөл, санал, засгийн газрын тайлан мэдээ, хуралдааны бусад асуудлуудыг бэлтгэх ажлыг хариуцан хэрэгжүүлнэ. Хороод бүр холбогдох яамдтай тодорхой асуудлаар хамтран ажиллана.

Төв алба /Central Office/ нь парламентын чуулганы бэлтгэл, үйлчилгээний асуудлыг хариуцах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хадгалах, парламентын баримт бичгүүдийг хэвлэн нийтлэхэд бэлтгэх, бүртгэх, парламентын гол чухал баримт бичгүүдийг Швед хэл рүү орчуулах, баримт бичгүүдийг тараах, хадгалах ажлыг хариуцна. Төв алба нь мөн Даргын зөвлөлд зориулан нэгдсэн чуулганы төлөвлөгөөг бэлтгэх /хуралдаан удирдах дарааллыг/ болон чуулгантай холбоотой асуудлаар Засгийн газар, хороодтой хамтран ажиллана. Төв алба нь Нарийн бичгийн даргын газар болон Швед хэлний, Бүртгэлийн, Баримт бичгийн гэсэн албадтай.

4. Швейцари

Байнгын хороодын ажлын алба нь хууль тогтоох хороодын нарийн бичгийн даргын газраас бүрдэнэ. Парламентын гишүүдэд хуулийн төсөл, мөн нарийн төвөгтэй

хэлэлцээрүүд, тоо баримтыг нарийвчлан судлахад туслах үүрэгтэй. Хороо бүр өөрийн ажлын албатай. Ажлын албад хороодын үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, техник зохион байгуулалт, захиргааны туслалцаа үзүүлэх, парламентын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөгөө өгнө.

Баримт бичгийн алба нь парламентын гишүүдэд шаардлагатай баримт бичгээр хангах, Холбооны Хурлаас шийдвэр гаргахад хэрэгцээтэй бүх мэдээллээр хангана. Тус алба нь албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, парламентын гишүүдийг лавлагаа мэдээлэл, судалгаагаар хангах үүрэгтэй. Мөн парламентын номын сан энэ албанд харъяалагдана.

Монгол

Манай улсын хувьд УИХ-ын Тамгын газар дахь бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтаас харахад хуулийн төсөл хэлэлцэх шатны чиг үүргүүдийг төрөлжүүлэн салгаж тухайлсан нэгж тус бүрд оноож өгсөн гэж үзэж болохоор байна. Гэвч хэлтэс албадын чиг үүргээс харахад тийм ч оновчтой хуваарилаагүй гэж дүгнэж болох юм.

Байнгын хороодын ажлын алба

Байнгын хороодын ажлын алба нь УИХ-ын Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх, дотоод ажлын зохион байгуулалтыг хангаж, Хорооны дарга, гишүүдэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, ажлын алба, ажилтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, шуурхай удирдлагаар хангах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба

Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах алба нь УИХ-ын нэгдсэн болон Хорооны хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлж, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ.

Эрх зүй хууль тогтоомжийн хэлтэс

Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс нь Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль, тогтоолын төслийг Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэх, уялдуулах, энэ асуудлаар УИХ, Байнгын, дэд, түр хороо, УИХ-ын удирдлага, гишүүд, ажлын хэсгээс өгсөн үүрэг, тавьсан саналыг хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд төслийн хэлэлцүүлэгтэй холбогдсон асуудлаар тайлбар өгөх, баталсан шийдвэрийн эцсийн найруулгыг бэлтгэж УИХ-д танилцуулах, ёсчлуулах, хууль тогтоомжийг системчлэх, ангилах, эрх зүйн актын лавлагаа, мэдээллээр хангах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Судалгааны төв

Судалгааны төв нь УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд ирүүлсэн захиалга, чиглэлийн дагуу болон Төвийн санаачлагаар цаг үеийн тулгамдсан асуудлууд, бодлогын чанартай асуудлуудаар судалгаа хийх, бодлогын шинжилгээний дүгнэлт, зөвлөмж гаргах, цаг үеийн шуурхай мэдээлэл, судалгааны мэдээллээр хангах, хэлэлцүүлэг хийхтэй холбогдуулан олон нийттэй харилцах үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

Хуулийг батлан гаргах

Энэ хэсэгт Парламентаас хуулийн төслийг эцсийн байдлаар хэлэлцэн батласны дараа шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх үйл ажиллагаанд Парламентын ажлын албаны аль хэлтэс алба голлох үүрэгтэй байдгийг

тодруулан авч үзлээ.

Манай улсын хувьд энэ чиг үүргийг УИХ-ын Тамгын газрын **Эрх зүй хууль тогтоомжийн хэлтэс** хийж гүйцэтгэдэг байна. Тус хэлтсийн чиг үүрэгт заасны дагуу уг хэлтэс нь баталсан шийдвэрийн эцсийн найруулгыг бэлтгэж УИХ-д танилцуулах, ёсчлуулах, хууль тогтоомжийг системчлэх, ангилах, эрх зүйн актын лавлагаа, мэдээллээр хангах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Бусад улс орнуудын хувьд ч манай улсын нэг адил Парламентын ажлын албаны хууль эрх зүйн үйлчилгээний асуудал хариуцсан нэгж нь Парламентаас баталсан шийдвэрийг эцсийн байдлаар олон нийтэд хүргэх чиг үүргийг хариуцан гүйцэтгэдэг байна. Гэхдээ ийм зохицуулалт улс орон бүрд яг адил байна гэж үзэж болохгүй бөгөөд зарим улсын хувьд хууль тогтоомжийн хэлтэсээс гадна бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий нэгж хариуцан гүйцэтгэдэг байна.

1. Сингапур

Албан ёсны баримтын газар

Чуулган, хуралдааны үеэр гишүүд болон хуралдааны үйл ажиллагаанд оролцогчдын хэлсэн үг бүрийг тэмдэглэл, албан ёсны бичлэгт буулгах бөгөөд энэ нь Сингапурын парламентын албан ёсны хэвлэлд нийтлэгдэнэ. Парламентын хуралдааны түргэн бичлэгийн тэмдэглэлийг гишүүдэд е-мэйлээр явуулан шалгуулна. Тэмдэглэлд хийсэн засвараа гишүүд 72 цагийн дотор Ерөнхий редакторт буцаан илгээх үүрэгтэй. Үүний дараа албан ёсны хэвлэлд нийтэлнэ.

2. Чили

Сенатын ажлын албаны **Сурталчилгаа (PR) ба хэвлэлийн хэлтэс** нь Конгрессийн албан ёсны мэдэгдэл, тайлан, гадаад, дотоод үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэх, хэвлэн нийтлэх, танилцуулах ажлыг хариуцахаас гадна Үндэсний Конгрессийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нээлттэй засаглалыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны **Баримт бичгийн хэлтэс** нь Хуралдааны үйл явцыг баримтжуулан протокол хөтлөх, бичлэг хийх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд Үндэсний Конгрессийн хорооны хуралдааны протокол хөтлөх, бичлэг хийх, Засгийн газрын шаардлагаар хийсэн хяналт, шалгалтын үед хяналт тавих, гэрчлэх үүргийг гүйцэтгэнэ.

3. Кабо-Верде

Парламентын ажлын албаны **Редакцийн хэлтэс** нь Нэгдсэн хуралдааны протокол хөтлөх, Нэгдсэн хуралдаан дээр тавигдсан илтгэл, мэдэгдлийн нэгдсэн тайланг зохих техник хэрэгслийн тусламжтайгаар бэлтгэх, батласан шийдвэрийг шаардлагатай тохиолдолд найруулж боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хэвлэлтэд бэлтгэх, бүрдлийг хянах, нийтлүүлэхэд бэлэн болсон парламентын баримт бичгийг шалгаж зөвшөөрөл өгөх, Үндэсний Ассамблейн баримт бичгийг тогтоосон хугацаанд нийтлүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд түүний ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ нь ихэнх улс оронд нийтлэг байдлаар

зохицуулагдсан байна. Зарим тодорхой нэг улс орнуудын хувьд бусдаас арай өөр хэлбэрийн зохицуулалт, зохион байгуулалт байгаа ч үүнийг сайн туршлага, муу туршлага хэмээн хөндлөнгөөс шууд дүгнэх боломжгүй юм. Эдгээр нь тухайн орны эрх зүйн харилцаа, Парламентын хэлбэр болон уламжлалтай холбоотой онцлог юм гэдгийг харгалзах үзэх ёстой.

Тиймээс УИХ-ын Тамгын газар өөрийн үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах үүднээс судалгаанд хамрагдсан улс орнуудаас зохих туршлага авч нэвтрүүлэх тохиолдолд өөрийн улс орны нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцааны онцлогийг харгалзан үзэх нь чухал юм.

Ардчилсан засаглалтай орнуудын Парламентын ажлын албаны туршлагыг судалсны үндсэн дээр УИХ-ын Тамгын газар нь чадавхиа бэхжүүлэх, үйл ажиллагааны үр ашиг, үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс шат дараатайгаар олон арга хэмжээ авч байгаа бөгөөд тухайлбал, ажил үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, үйл ажиллагааны үр дүнг чанаржуулах үүднээс 1992 оноос өнөөг хүртэл 6 удаа бүтцийн өөрчлөлт хийж хэлтэс албадын үндсэн чиг үүргүүдийг шинэчлэн тодорхойлж өгсөн байна.

УИХ-ын 2002 оны 22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж буй *“УИХ-ын стратеги төлөвлөгөө”* -нд *“Парламентын ажлын мэргэшсэн алба болох УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах”* гэсэн стратеги зорилтыг дэвшүүлсэн бөгөөд үүний дагуу Тамгын газар нь чадавхиа бэхжүүлэхтэй холбогдсон асуудлыг УИХ-ын өөрийнх нь өөрчлөлт, шинэтгэл, хөгжлийн цаашдын чиг хандлагатай маш нарийн харилцан уялдаа холбоотой авч хэрэгжүүлж байна.

Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх талаар гаргасан хүчин чармайлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн нь эцсийн эцэст төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-ын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөгөөр дамжин илрэлээ олох бөгөөд энэ нь ардчилсан нийгмийн харилцааны төлөвшилт болон ард иргэдийн амжиргааны түвшингийн дээшлэлтийн гүйцэтгэлийн тодорхой шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх болно.

Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх тухай ойлголт нь өмнөх хэсэгт дурдсан үндсэн чиг үүргээ болон холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны чадавхийг буй болгох, түүнийг бэхжүүлэхтэй холбогдсон хүчин зүйлсийг агуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, аливаа байгууллагын чадавхи нь сайн бол чиг үүрэг нь сайн хэрэгжинэ, чадавхи нь хангалттай биш бол чиг үүрэг нь хангалттай бус хэрэгжинэ гэсэн үг. Гэвч тухайн байгууллагын өөрчлөлт, шинэтгэл, хөгжлийн түвшин болон тухайн байгууллагад ажиллаж байгаа боловсон хүчний мэдлэг чадварын түвшингээс хамаардаг **байгууллагын чадавхийн түвшин** нь хичнээн сайн байгаад бүтцийн нэгжүүд дэх чиг үүрэг зөв тодорхойлогдож чадаагүй бол уг өндөр түвшний чадавхиа бүрэн ашиглаж чадахгүйд хүрнэ.

Товчдоо, байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудал болон байгууллагын бүтцийн нэгжүүдийг чиг үүргийг зөв тодорхойлох тухай асуудал нь харилцан уялдаа холбоотой бөгөөд харилцан бие биенээсээ хамааралтай нэг медалийн хоёр тал болох юм.



**МОНГОЛЫН ПАРЛАМЕНТ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО,
ЦААШИД САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ***Ч. Базар (Ph.D)*

Барууны орнуудад сүүлийн үед хийгдэж байгаа судалгаагаар сонгуульд бүхнийг найдаж орхих нь ардчиллыг бэхжүүлэхэд учир дутагдалтай байна гэсэн шүүмжлэл өрнөж байна. Энэ шүүмжлэлийн нөгөө талд нь сонгуулиас бусад үед бодлого боловсруулах үйл явцад иргэдийн идэвхтэй оролцоог хөхүүлэн дэмжих төрийн үүрэг оршиж байна. Тийм ч учраас Монгол Улсад ардчилсан тогтолцооны суурь байгууламжийг бэхжүүлж, төр засаг, иргэдийн хооронд үр бүтээлтэй холбоо харилцааг бий болгох зорилт тавигдаж байна. Энэ нь төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн Үндсэн хуулийн эрхийг баталгаажуулах явдал юм. Энэ нь биднээс шинэ сэтгэлгээ, бүтээлч хандлага шаардаж байна.

- Нээлттэй, ил тод байх нь ардчилсан Парламентын үндсэн шинж
Нээлттэй ил тод байдал нь иргэдийн улс төрийн оролцоог идэвхжүүлж, хэлэлцэж буй асуудалд тэдний анхаарлыг хандуулж дэмжлэг авах буюу шүүмжлэл өрнүүлэх боломжтой болдог.
- Тайлагнах нь мөн ардчилсан Парламентын гол шинж
Тайлагнах нь парламентын өөрийнх нь хариуцлагыг дээшлүүлэхээс гадна иргэд, ИНБ-ийн үүрэг хариуцлагыг ч хамтдаа нэмэгдүүлж байдаг.
- Иргэдийн оролцоог алхам тутамдаа дэмжих ардчилсан Парламентын хамгийн гол шинж юм.
Парламентыг ард түмэн бий болгодог бөгөөд энэхүү процесс нь нэг сонгууль санал өгсөн дэмжлэгээр хязгаарлагдах бус тасралтгүй үргэлжлэх үйл явц байж чадах ёстой.

Өнөөдөр Монголын парламентад иргэдийн оролцоо ямар байна, ямар хэлбэрээр иргэд, иргэний нийгмийн байгууллага оролцож байна вэ?

1. Парламентад хаяглаж захидал бичих

Судалгаанаас үзэхэд иргэдийн Парламентад хандаж захидал бичих нь ихэсчээ. Үүнийг иргэдв олон нийтийн парламентад боловсруулж буй аливаа бодлогын үйл ажиллагаанд оролцох сонирхол, идэвх оролцоо нь нэмэгдэж байна гэж дүгнэж болно.

Иргэдээс УИХ-д хандаж ирүүлсэн захидлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулийн дагуу захидлыг өргөдөл, гомдол гэж хоёр ангилна. Улс нийгмийн ач холбогдолтой болон бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг өргөдөл гэнэ. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болдог.

2. Иргэний хөдөлгөөний эрчимжилт.

Сүүлийн 6 жилд иргэний хөдөлгөөн, эвсэл холбоо олноор байгуулагдах боллоо. Үүний үндсэн шалтгааныг бодлого боловсруулах үйл явцад иргэд, ИНБ оролцох боломжгүй байгаатай холбож үзжээ. Түүнчлэн намуудын дотоод хямрал, цаашилбал төр нь иргэнийхээ ашиг сонирхлыг төлөөлж чадахгүй байгаагийн илрэл гэж экспертүүд тайлбарладаг.

3. Олон түмний итгэл.

Парламентад үзүүлэх олон түмний итгэл өнгөрсөн хугацаанд дээшлэх бус жил тутам улам буурч байгааг олон нийтийн санал асуулгын дүнгээс харж болно. Шалтгааныг нь НҮБ-ын баримт бичигт УИХ-ын гишүүдэд ил тод байдал үгүй болж, үйл ажиллагаагаа олон нийтийн өмнө хариуцадггүй байдалтай холбоотой гэж үзсэн.

Ийнхүү олон түмний итгэл сулрах нь ардчилсан засаглалтай орнуудад байдаг үзэгдэл гэж тайвширч болохгүй бөгөөд системийн онолын үүднээс авч үзвэл төрийн институтад итгэдэг иргэдийн тоо 25 хувиас багассан тохиолдолд систем хэвийн оршин тогтнох боломжгүй болно гэж үздэг. НҮБ-ын судалгаанд оролцсон иргэдийн 41,3 хувь нь улсын төсөв боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж шалгахад оролцохыг хүсдэг гэдгийг харуулсан аж.

Эрсдэлтэй байдлууд:

- Бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог дээшлүүлэх нь засаглалын ил тод байдал, иргэний эрхийн хэрэгжилтээс шууд хамаардаг. Монгол улсад ажилгүйдэл, ядуурал, авилгын түвшин өндөр зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд цаашид бодлого боловсруулах иргэдийг оролцоог дээшлүүлэх асуудалд бэрхшээл авчрах магадлалтай.
- Парламент ил тод байдлыг хангах талаар хүсэл эрмэлзэл гаргахгүй бол дэвшил гаргахгүй. Энэ өвөл Парламентийн байнгын хорооны хурлыг хаалттай хийнэ, сэтгүүлчдийг оруулахгүй гэсэн хууль баталсан нь нийгмийн эсэргүүцэлтэй тулгарсан. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажил хаялт зэрэг эсэргүүцэл үзүүлж байж сурвалжлах боломжоо хангасан. Энэ бол өргөн утгаараа иргэдийн оролцоонд л саад болно.

Нааштай алхмууд:**Идэвхтэй оролцоог дэмжих.:**

- Энэ нь бодлого боловсруулах асуудлаар санал солилцоход иргэдийн өөрсдийн нь оруулж буй хувь оролцоо юм. Энэ утгаараа 2008-2012 оны УИХ-ын Тамгын газар хөдөө орон нутагт ажиллаж, хуулийн төслийн танилцуулга хийж, иргэдийн санал бодлыг сонсох ажлыг идэвхтэй хийж байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгал, халамжийн хууль, хөдөлмөр эрхлэлт гэх мэт олон хуулийн төслийг иргэдэд танилцуулж, ямар санал оруулахыг нь судалгаагаар авч байна.
- Бодлого боловсруулах явцад иргэнийг оролцуулна гэдэг бол түншлэлийн зарчимд тулгуурласан үйл явц. Энэ утгаараа УИХ-ын байнгын хороо, хуулийн төслийн ажлын хэсэг хот, дүүрэг, аймаг сумдад иргэдийг цуглуулан хуулийн төслийн талаар харилцан ярилцаж байна.
- Тамгын газрын бүтцэд “Судалгааны төв” байгуулан Байнгын хороо, гишүүдийн захиалгаар судалгаа, лавлагаа мэдээлэл бэлтгэж байна. Судалгаа хийж буй тухайн асуудлаар мэргэжилтнүүдийн дунд дугуй ширээний болон нүүр тулсан ярилцлага хийх, олон нийтээс социологийн судалгаа авах зэргээр оролцоог чухалчилж байна.

Цаашид оролцоог яаж илүү боловсронгуй болгох вэ?

УИХ-нь төрийн санхүү, зээл албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах, ард нийтийн санал асуулга явуулах зэрэг онцгой бүрэн эрхийг эдэлдэг байна. Гэхдээ ард түмнээс сонгогдож, нийгмийн төлөөллийн

өмнөөс ажилладаг. Энэ утгаараа парламентад иргэд, ИНБ-ийн оролцоог дээдэлж, түүний төлөө эрх зүйн таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байх учиртай. Үүний тулд:

- Иргэд, ИНБ хуулийн төсөл санаачлах асуудлаар хууль санаачлагчид хандах өөрийн саналыг уламжлах боломжийг нэмэгдүүлэх
 - Тамгын газар нь :Улсын Их Хуралд хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь иж бүрэн зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх чадавхитай бие даасан өндөр мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болон төлөвших эрхэм зорилготой. Энэ зорилгыг мэргэшсэн, чадварлаг, бас хүсэл эрмэлзлэлтэй боловсон хүчинд түшиглэж байж хийнэ: Тийм болохоор боловсон хүчнийг чадавхжуулах
 - Байнгын хороо нь Нээлттэй Засгийн газар, Нээлттэй сонсгол, Хорооны хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байх, хэлэлцэгдсэн бүх асуудлыг олон нийтэд нээлттэй мэдээлэх зарчмыг барьж ажиллах учиртай. Хороонд мэргэшсэн боловсон хүчинтэй байх нь чухал бөгөөд тулгамдсан асуудал. Тийм учраас боловсон хүчинг чадавхжуулах, тогтвортой ажиллуулах, Байнгын хороог улам бүр бэхжүүлэх
 - Иргэдийн санал хүсэлтийг бодлого боловсруулагч нарт шаардлагатай мэдээлэл, хэрэглэгдхүүн болгон боловсруулан хүргэх институт тун чухал. Зөвхөн иргэдээс ирүүлж байгаа төрөл бүрийн санал, захидлыг тодорхой аргачлалаар боловсруулан хууль боловсруулагчдад ашиглаж болохуйц хэрэглэгдхүүн болгон боловсруулах ажлыг хийдэг мэргэжлийн баг бий болгох
 - Орон нутагт дахь Парламентын сурталчилгааны төвийг бэхжүүлэх, УИХ-ын гишүүдийн туслах-бие төлөөлөгчид хамтарч ажиллах, олон нийттэй харилцах, хэвлэлийн алба ТББ, ХМБ-аар дамжуулан чуулганаар хэлэлцэх гэж байгаа хуулийн төслийн жагсаалтыг тогтмол олон нийтэд мэдээлж байх,
 - Институтчлалыг /institution/ төгс болгох. Энэхүү ойлголтыг нэлээд өргөнөөр авч үзэж байна. Иргэд бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл явцад оролцох нөхцөл бололцоог зохицуулсан хууль эрхийн акт, дүрэм, журам, бодлого, шийдвэр мөн хуулийг хэрэгжүүлэх институтын үйл ажиллагааг хэлнэ. Үүнд хуулийн хэрэгжилтийн асуудал ч орно. Үүнийг төгс болгож, оролцоог дэмжсэн, хэрэгжихүйц хууль, журмыг батлан гаргах, хэрэгжүүлэх шаардлагатай.
 - Хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөр ч өөрөө нээлттэй мэдээллийн, хамтын ажиллагааны болон оролцооны зарчимд түшиглэж явах учиртай.
1. Нээлттэй мэдээллийн зарчмын хүрээнд мэдээлэл авах иргэдийн эрхийг хангах үүднээс чадавхижуулах, ингэхдээ орон даяар засгийн газрын байгууллага бүр танин мэдэхүйн соёлыг бий болгохын төлөө ажиллах; Парламентын мэдээллийг иргэн бүрт хүртээмжтэй, ашиглаж болохоор зохион байгуулах, цахим мэдээллийн дэвшлийг ашиглах;
 2. Хамтын ажиллагааны зарчмын хүрээнд УИХ-ын гишүүд иргэдтэйгээ Үндэсний болон орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдэх талаар нээлттэй ярилцаж хамтран ажиллах; Ялангуяа Төсвийн үйл явц дахь оролцоог чухалчлах
 3. Оролцооны зарчмын хүрээнд хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг явуулах, санал бодлыг сонсох, захидал, өргөдөлд бүтээлчээр хандах зөвлөлдөх зэргээр оролцооны аргаар үйл ажиллагаагаа явуулдаг болгох зэрэг багтана. Оролцоог нэмэгдүүлэх нь ганцхан Парламентын чадавхийн асуудал биш бас Иргэний чадавхийн асуудал. Харин хөгжлийн төлөө оролцоог хүсдэггүй иргэн, ИНБ гэж байдаггүй.

**ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЭГЖҮҮД** (Харьцуулсан судалгааны дүгнэлт)

К. Пүрэвсүрэн, Т. Мягмаржав

- ❖ Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа
- ❖ Олон нийттэй харилцах үйл ажиллагаа
- ❖ Радио, телевиз /broadcasting/
- ❖ Парламентын боловсрол

Эдгээр нэгж нь парламент, түүний үйл ажиллагааны талаар олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай, үнэн зөв, бодитойгоор мэдээлэх, түүнчлэн парламент, парламентад ёсны түүх болон Үндсэн хуульт ёсны асуудлаарх мэдлэг, мэдээллийг түгээх, ойлгуулан таниулах нийтлэг чиг үүрэгтэй. Зохион байгуулалтын хувьд эдгээр нэгжүүд нь улс орнуудын парламентын ажлын албаны бүтцэд бие даасан нэгж хэлбэрээр, эсхүл аль нэг нэгж дотор хэсэг, албадын хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

Парламентын үйл ажиллагаа, түүний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, парламент болон иргэд, олон нийтийн дунд холбох үүргийг хэрэгжүүлэхдээ:

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх
- Сурталчлан таниулах (радио, ТВ-ийн суваг зэргийг ашиглан)
- Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч парламентад уламжлах
- Иргэд, олон нийтийн парламентын боловсролыг нэмэгдүүлэх талаар шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулах

зэрэг үйл ажиллагааны нийтлэг чиг үүрэгтэй байдаг байна.

Ихэнхи орны парламентад:

- Гишүүдийн ажлын алба
- Спикерын ажлын алба

гэсэн нэгж байдаг бөгөөд эдгээр нь парламентын болон парламентын гишүүдийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, сурталчлах үйл ажиллагааг мөн хэрэгжүүлдэг.

Энэ нь зарим талаараа манай тамгын газрын бүтэд байх УИХ-ын даргын ажлын алба болон УИХ-ын гишүүдийн туслах, бие төлөөлөгч - туслах, зөвлөхийн чиг үүрэгтэй төсөөтэй. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын ажлын албаны зохион байгуулалт болон хэрэгжүүлэх чиг үүргээс харахад ихэнхи улсын хувьд Хэвлэл мэдээллийн болон Олон нийттэй харилцах нэгж нь хамтдаа байх тул энэхүү нэгжийн талаарх мэдээллийг нэгтгэн бичив. Харин бусад нэгжийн хувьд тус тусад нь, нийтлэг болон онцлог байдлыг дүгнэн оруулсан ба зарим нэг онцлог зохион байгуулалттай улсуудыг жишээ болгон оруулав.

Хэвлэл мэдээлэл болон Олон нийттэй харилцах үйл ажиллагаа

Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд:

- олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр парламентын үйл ажиллагааг тогтмол мэдээлэх замаар парламент, түүний ажлын албадын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах,
- парламентын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан танилцуулах үйл

ажиллагаа зохион байгуулах

- дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах,
- парламентын гишүүд, төлөөлөгчдийн оролцсон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын хурал, чуулганы талаар мэдээлэх,
- иргэд, сонгогчдийн парламентын гишүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулах зэрэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Хэвлэл мэдээлэлтэй харилцах болон Олон нийттэй харилцах үйл ажиллагааг ерөнхийдөө зохион байгуулалтын хувьд дараах байдлаар хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн нэгж Олон нийттэй харилцах нэгжтэй хамтдаа (Марокко, Австри, Армян, Герман, Гүрж/дотроо тусдаа хэлтэстэй/, Нидерланд, Орос зэрэг улсууд)
- Олон нийттэй харилцах чиг үүргийг дангаараа бие даасан нэгж хэрэгжүүлдэг (Турк, Босни-Герцеговин зэрэг улсууд)
- Боловсрол болон Хэвлэлийн газар (Сингапур)
- Мэдээллийн үйлчилгээний департамент болон Мэдээллийн газар, төв зэрэг нэртэй Хэвлэлийн алба нь тусдаа бие даасан нэгж (Их Британи, Нидерланд, Норвег, Украин, Эстони зэрэг улсууд) байна.

Хэвлэл мэдээллийн нэгжүүдийн иргэд, олон нийтэд парламентын чиг үүрэг, үйл ажиллагааг хүргэх, ойлгуулан танилцуулах үйл ажиллагаа нь иргэдийн парламентын талаарх мэдлэгийг дээшлүүлж, парламент, түүний ажлын албадын үйл ажиллагааг сонирхох, олон нийтээс парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой байна.

Олон нийттэй харилцах чиг үүргийг бие даасан нэгж хэрэгжүүлдэг улсын хувьд парламентаас олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд, тухайлбал, Туркийн парламентын ажлын албаны Олон нийттэй харилцах газар нь:

- Баримт бичиг, архивын хэлтэс,
- Хэвлэл мэдээлэл-олон нийттэй харилцах хэлтэс,
- Парламентын үйлчилгээний хэлтэс,
- Турк Улсын Үндэсний Их Хурлын Телевизийн хэлтэс гэсэн бүтэцтэй байна.

Зарим улсын парламентын ажлын албаны бүтцэд иргэд, сонгогчдод парламентын түүх, чиг үүрэг, хууль тогтоох үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, тэдний асуултад телефон утас, факс, цахим шуудан болон бусад хэлбэрээр хариулт өгөх үүрэг бүхий мэдээллийн төв ажилладаг.

Мэдээллийн төвийн байранд иргэд зочилж, парламент болон төрийн бусад байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авах, телевизийн дотоод сүлжээгээр парламентын хуралдааныг сонирхох, парламентаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хууль тогтоомжын төсөл зэрэгтэй танилцах, хуулбарлаж авах, парламентаас хэвлэн гаргасан тогтмол хэвлэл, ном товхимол бусад материалыг уншиж, хуулбарлан авч болдог. Мөн парламентын ордон, парламентын үйл ажиллагаатай танилцахыг хүссэн иргэн Мэдээллийн төвд ханддаг байна. Тухайлбал, Украин улсын хувьд Мэдээллийн газар гэсэн нэгж байх ба энэ нь Төлөвлөлт, дүн шийжилгээний хэлтэс, Парламентын үйл ажиллагааг сурталчлан таниулах хэлтэс, Үнэлгээний хэлтэс, Мэдээлэл-номын сангийн үйлчилгээний хэлтэстэй бөгөөд парламентын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үндсэн чиг үүрэгтэй.

Энэ газар нь Дээд Радагийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж сурталчлах, нээлттэй хэлэлцүүлэг зохиох, олон нийтийн саналыг хуулийн төсөлд тусгах ажлыг зохион байгуулах, иргэдийг Дээд Радагийн үйл ажиллагаа, парламентын ордонтой

танилцуулах, парламентын үйл ажиллагааны тухай танилцуулга, сурталчилгааны бусад материал бэлтгэж хэвлүүлэх, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэдэг бол Хэвлэлийн алба нь Дээд Рада болон депутатууд, Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, хэвлэлийн мэдээ, мэдэгдэл бэлтгэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоотой ажиллах, хэвлэлийн бага хурал хийлгэх ажлыг зохион байгуулах, депутатуудыг хэвлэлийн мэдээллээр хангах, парламентын сэтгүүлчдэд сурвалжлах эрх олгох, мэдээллээр хангах, мэдээллийн хэрэгслүүдэд гарсан парламентын асуудлаарх нийтлэлүүдэд дүн шинжилгээ хийх зэрэг үүрэгтэй байна.

Түүнчлэн туснэгж нь парламентаас батлан гаргасан хууль тогтоомжоос гадна парламенттай холбоотой үйл ажиллагааны нь талаарх мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулж, парламентаас тогтмол эрхлэн гаргадаг хэвлэл (сонин, сэтгүүл, товхимол зэрэг)-д нийтлэн олон нийтэд хүргэдэг байна. Харин манай парламентын хувьд албан ёсны тогтмол хэвлэл болох ХМОНХХ-ийн дэргэдэх “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн редакциас эрхлэн гаргах “Төрийн мэдээлэл” сэтгүүл байдаг ба үүнд парламентаас батлан гаргасан хууль тогтоомжийг нийтэлдэг.

Дэлхийн олон оронд парламентын ордон нь түүх, соёлын үнэт дурсгал болдог. Энэ утгаараа олон оронд парламентын музей ажилладаг бөгөөд энэ нь парламентын зүгээс олон нийттэй харилцах үйл ажиллагааны нэг чухал хэсэг байдаг. (Энэтхэг, Аргентин г.м.)

Тиймээс иргэд, олон нийтэд парламентын түүх, үйл ажиллагаанаас гадна парламентын ордонг танилцуулдаг байна. Тухайлбал, Эстонийн Хэвлэл мэдээллийн хэлтэсийн үйл ажиллагаанд олон нийттэй харилцах чиг үүрэг багтах бөгөөд үүний хүрээнд парламентын үйл ажиллагааг иргэд олон нийтэд танилцуулах болон парламентын бүрэлдэхүүний тухай тоон мэдээлэл, гишүүдийн намын харьяаллыг нэгдсэн хуралдааны танхимын план зураг дээр гэрэл зургийнх нь хамт ялган харуулж, парламентын үйл ажиллагаа, түүхтэй холбоотой зарим чухал үйл явдлын тоймыг өгүүлсэн танилцуулгыг хэвлэн гаргах, парламентаас эрхлэн гаргадаг “А и Б Рийгикогу” товхимолд Эстонийн парламентын байрладаг “Тоомпеа” шилтгээний түүх, Рийгикогугийн үүсэл хөгжил, үйл ажиллагаа, хууль боловсруулах, хэлэлцэн батлах журам, парламент, Ерөнхийлөгч, Засгийн газар хоорондын ажлын уялдаа холбооны талаар нийтэлдэг байна.

Харин Рийгикогугийн Мэдээллийн төв нь Рийгикогугийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд албан ёсны мэдээ, мэдэгдэл нийтлүүлэх, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, иргэд, сонгогчдод Рийгикогугийн түүх, чиг үүрэг, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөхөөс гадна тэдний асуултад телефон утас, факс, цахим шуудан болон бусад хэлбэрээр хариулт өгөх, тус төвийн байранд иргэд зочилж Рийгикогугийн болон төрийн бусад байгууллагын цахим хуудаснаас мэдээлэл авах, телевизийн дотоод сүлжээгээр парламентын хуралдааныг сонирхох, тухайн 7 хоногт Рийгикогугаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хууль тогтоолын төсөл зэрэгтэй танилцаж, хуулбарлаж авах, парламентын тогтмол хэвлэл болох “Рийгикогугийн товчоон”, “Riigikogu Toimetised” сэтгүүл зэргийг уншиж, хуулбарлан авч болно.

Мөн Рийгикогугийн үйл ажиллагаа болон түүний байрладаг түүхийн дурсгалт “Тоомпеа” шилтгээнтэй танилцахыг хүссэн хэн ч гэсэн Мэдээллийн төвтэй урьдчилан холбогдож цаг товлон, бусад сонирхогч иргэдээс бүрдсэн 25-аас илүүгүй хүнтэй багийн бүрэлдэхүүнд орж танилцах аялал хийж болно. Энэхүү танилцах аялалыг ажлын өдрүүдэд 10-16 цагийн хооронд, нэг удаагийн аялалын үргэлжлэх хугацаа дунджаар 30 минут байхаар зохион байгуулна.

Хамт олноороо танилцах аялал хийх бол оролцох хүмүүсийн нэрсийг нэг хоногийн өмнө Мэдээллийн төвд хүргүүлэх бөгөөд танилцуулга эстони, англи, орос хэл дээр явагдана.

Түүнчлэн Рийгикогугийн хуралдааныг хувь хүн ганцаараа ч сонирхож болох бөгөөд ингэхдээ биеийн байцаалттай парламентын ордны баруун хаалганд очиж, хамгаалалтын албаны ажилтанд хүсэлтээ илэрхийлэхэд хангалттай.

Улс орнуудын эдгээр зохион байгуулалтаас харахад парламентын үйл ажиллагааг олон нийтэд ил тод байлгах, түүнчлэн парламентын үйл ажиллагаатай танилцах тал дээр иргэдэд илүү чөлөөтэй, нээлттэй байлгах талаар ихэд анхаарч буй явдал нь тэдний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх явц, шат дамжлагаас тодорхой харагдаж байна.

Broadcasting -ийн үйл ажиллагаа (Мэдээлэл дамжуулах радио, TV суваг)

Парламент нь өөрийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх хамгийн хялбар, түгээмэл хүртээмжтэй хэлбэр нь ТВ, радио юм. Дэлхийн парламентын ажлын албадын бүтцээс харахад дэргэдээ ТВ, радиотой ч байна, мөн манай Тамгын газрын Хууль сурталчлах албаны адилаар бусад ТВ, радиотой гэрээгээр ажилладаг орнууд ч байна. Эдгээр нэгж нь радио, ТВ-ийн тодорхой сувгуудтай хоёр янзаар хамтран ажилладаг.

- ❖ парламентын хуралдаан, үйл ажиллагааг тогтмол нэвтрүүлдэг
- ❖ парламентын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, хөтөлбөрүүдийг бэлтгэж хамтран ажилладаг радио, ТВ-ийн сувгуудаар дамжуулан олон нийтэд хүргэдэг.

Жишээлбэл, Германд парламентын түүх, үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээллийг дагнан нэвтрүүлдэг телевизийн суваг байдаг. Уг сувгаар нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааныг шууд дамжуулан олон нийтэд хүргэж байдаг. Харин Турк зэрэг улсад парламентын үйл ажиллагааг дагнан хүргэдэг парламентын телевиз байдаг ба энэ нь парламентын ажлын албаны бүтцэд багтдаг.

Манай улсын хувьд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” хэмээн заасан байдаг. Манайд парламентын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой мэдээллийг орон даяар радио, телевизийн сувгуудаар дамжуулан нэвтрүүлдэг боловч парламентын хуралдааныг орон даяар шууд дамжуулдаггүй.

Парламентын үйл ажиллагааг хүргэж буй радио, телевиз нь зарим талаар өөрийн нэвтрүүлгийн бодлогоос хамааран нэг талыг барьсан, бүрэн дүүрэн бус, өрөөсгөл ойлголтыг олон нийтэд хүргэх талтай. Иймд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн хүрээнд парламентын хуралдааныг ямар нэгэн нэмэлт тайлбаргүйгээр, орон даяар шууд дамжуулан үзэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Парламентын боловсрол

Парламентын боловсрол гэдэг нь парламент түүний үйл ажиллагаа, парламентат ёсны түүх, парламент судлал болон Үндсэн хуулийн асуудлаар судалгаа хийж, парламенттай холбоотой мэдлэгийг олон нийтэд өгөх, эргээд парламентын үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс эерэг дэмжлэг авах тухай асуудал юм. Энэ утгаараа Парламентын боловсрол олгох тухай асуудал нь парламентын ажлын албадын чухал үүргийн нэг юм.

Судалгаанд хамрагдсан улсуудаас Сингапур, АНУ, Их Британи, Румын, Канад зэрэг улсуудын парламентын ажлын алба нь Парламентын боловсрол олгох нэгжтэй байна. Энэхүү нэгж нь олон нийтэд ном, товхимол, электрон болон телевизийн нэвтрүүлэг зэрэг хэлбэрээр мэдээллийг хүргэдэг.

Энд жишээ болгон АНУ, Канад болон Австралийн Парламентын боловсролын талаар дурдъя.

- АНУ-ын Конгрессийн сургалтын агентлаг нь бие даасан, улс төрийн хараат бус агентлаг бөгөөд Конгрессийн гишүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд ёс зүйн харилцаа, эрүүл мэнд, аюулгүй байдал, дипломат ёс гэх мэт улс төр, олон улсын түвшинд Конгрессийн гишүүдэд тавигдах шаардлагын талаар сургалтыг зохион байгуулдаг байна. Мөн Конгрессийн гишүүд, албан хаагчдад тэдгээрийн эрх, үүргийн талаар тодорхой ойлголт өгөх сургалт явуулдаг.

Дараах үндсэн гурван чиглэлээр боловсролын үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- 1) Дунд сургуулийн сурагчдад парламентын үүрэг, ролийг ойлгуулах сургалт АНУ-ын конгрессын Пэйж хөтөлбөр нь дунд сургуулийн сурагчдад бүтэн жилийн хугацаанд эсхүл 1-2 улирлын туршид АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд туслах ажилтнаар ажиллах боломжийг олгодог. 180 жилийн түүхтэй уг хөтөлбөрт хамрагдахын тулд өндөр шалгуур хангасан байх ба уг хөтөлбөрт хамрагдах хугацаанд Төлөөлөгчдийн танхимын гишүүн уг суралцагчийн бүх зардлыг хариуцна. Сенатад ажиллаж буй бүх “пэйж” сурагчдад зориулсан тусгайлсан хөтөлбөр бас байна.
 - 2) Парламентын гишүүдэд зориулан парламентын үйл ажиллагаанд оролцогчийнх нь үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг бэлтгэн, тэдэнд хүргүүлэх, танхимын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олж авахад туслах үйлчилгээ байна. Парламентын процессын асуудлаар парламентын гишүүд, тэдний туслахууд болон парламент, гүйцэтгэх засаглалын албан хаагчдад зориулсан семинар зохион байгуулна. Төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийнхэн зэрэг бүлгүүдэд зориулсан парламентын үйл ажиллагааны талаар ойлголт өгөх семинар зохион байгуулж, танилцуулга хийнэ.
 - 3) Мөн насанд хүрэгчдэд зориулсан парламентын боловсролын үйлчилгээ үзүүлж, парламентын үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулан дэмжүүлэх зорилгоор боловсролын байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулах ба лекц унших, үзэсгэлэн зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулна.
- Канадын парламентын боловсрол олгох асуудал нэлээн нарийвчилсан, боловсронгуй гэж болохоор байна. Энэ талаар тусгайлсан иргэдийн нас, боловсрол зэргээр ангилсан сургалт, мэдээлэл болон гарын авлага, бусад хэвлэмэл материалыг бэлтгэн үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Парламентын боловсролын сургалтын хүрээнд өөрийн улсын болон парламент, парламентын гишүүдийн эрх үүрэг, үйл ажиллагаа, шийдвэр гаргах процессын талаарх сургалтын иж бүрдэл материал, парламентын нэр томьёоны тайлбар зэргийг сурагчдын насны ангилал болон багш нарт зориулан бэлтгэн гаргадаг.
Парламент, парламентын ажлын албад, тэдгээрийн үйл ажиллагааны талаар, тухайлбал, спикер, сенат гэж хэн бэ, тэдгээрийн парламент дахь үүрэг роль, парламент, түүний түүх, парламент хэрхэн бүрддэг, ажлын албад нь ямар үйл ажиллагаа эрхэлдэг зэрэг мэдээллийг иргэд, олон нийтийн нас, боловсролын онцлогт тохируулан мэдээллийг сонирхолтой, энгийн, ойлгомжтой байдлаар төрөл бүрийн хэлбэрээр хүргэдэг.
 - Австралийн парламентад Парламентын боловсролын бие даасан офис ажилладаг.

Парламентын боловсролын офис нь сургууль, багш нар, оюутнуудад зориулан тэдгээрийн нас, боловсролын онцлогт тохируулсан хөтөлбөрийн дагуу парламентын боловсролын үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- тодорхой сургалтын хөтөлбөрөөр парламент хэрхэн ажилладаг тухай мэдлэг олгох
- хичээлийн танхимд болон бие даан суралцахад зориулсан сургалтын

материалыг бэлтгэх

- насны болон мэдлэгийн төрөл бүрийн ангилалд зориулсан цахим мэдээллийн сан бүрдүүлэх.

Тус офист багш нар, төслийн менежерүүд, график дизайнерууд, веб сайт хариуцсан ажилтан болон захиргааны ажилтнуудаас бүрдсэн олон талын мэдлэгтэй баг ажилладаг ба жилд 90 000 гаруй суралцагчдад зориулан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Мөн парламентын гишүүдийг тойрогтоо ажиллахад нь зориулан парламентын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангадаг.

Эцэст нь аль ч улс ямар ч хэлбэрээр эдгээр мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэдэг ч энэ бүх үйл ажиллагааны үр дүнд олон нийт, нийгмийн бүлгүүд парламентын талаарх мэдлэгээ дээшлүүлж, Танхим, байнгын хороодын үйл ажиллагааг сонирхох, оролцох тэмүүлэлтэй болдог бөгөөд энэ нь парламентын үйл ажиллагаанд эерэг дэмжлэг үзүүлдэг байна.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ПАРЛАМЕНТАД АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ
СУДАЛГАА, АРХИВ, НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
(Харьцуулсан судалгааны дүгнэлт)

Ц. Болормаа, Б. Хатантуул

Энэхүү илтгэлд дэлхийн 40 гаруй орны парламентын ажлын албаны судалгаа, номын сан, архивын нэгжийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, чиг үүрэгтэй холбоотой асуудлуудыг харьцуулан судалсан бөгөөд сонгодог жишээ болохуйц зарим орнуудын тухайн нэгжийн мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох нэгжийн үйл ажиллагаатай харьцуулан дараахь асуудлуудын хүрээнд судлав. Үүнд:

- 1) Парламентын судалгаа, архив, номын сангийн нэгжүүдийн зохион байгуулалт
- 2) Судалгаа, архив, номын сангийн нэгжийн ерөнхий чиг үүрэг
- 3) Нэгжүүдийн орон тоо, хүний нөөц
- 4) Судалгааны албаны чиг үүрэг
- 5) Судалгааны захиалга авах, гүйцэтгэх журам

1. Парламентын судалгаа, архив, номын сангийн нэгжүүдийн зохион байгуулалт

Судалгаанд хамрагдсан нийт 47 орны парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалтаас үзэхэд судалгаа, архив, номын сангийн нэгжийн зохион байгуулалтыг парламентын ажлын албаны бүтцэд болон парламентынхаа харьяанд шууд /Ажлын албатайгаа ижил статустай/ гэсэн бүтцийн 2 шинж ажиглагдаж байна. Гэвч маш цөөн тооны улс, тухайлбал АНУ, Австрали, Вьетнам, Сингапур, БНСУ, Узбекистан, Япон, Канад, Египит, Эстони зэрэг 10 улсын Номын сан нь парламентын ажлын албаны бүтцэд биш шууд парламентдаа захирагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Өөрөөр хэлбэл, англо-саксоны эрх зүйн системтэй улс орнууд болон тэдгээрийн колони байсан улс орны хувьд номын сан, судалгааны албыг парламентын ажлын албатай ижил түвшинд бие даасан байдалтай зохион байгуулсан байна. Аргентины парламентын номын сан нь хэдийгээр ажлын албаны бүтцэд биш ч “Конгрессын харьяа байгууллагуудын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга”-ын харьяанд байдаг байна.

“Secretariat” буюу “Тамгын газар”-аас хараат бус байдлаар парламентын харьяанд үйл ажиллагаа явуулж буй “Судалгааны алба” болон “Номын сан” нь парламентын ажлын албатай эн тэнцүү мэргэшсэн ажил үйлчилгээ үзүүлдэг чухал нэгжүүдэд тооцогддог байна. Харин бусад 36 улсын номын сан, судалгаа, архивын нэгжийн хувьд парламентын ажлын албаны бүтэц дотор байхаар зохион байгуулсан байна. Судалгаанд хамрагдсан 46 орны хувьд дээрхи нэгжүүдийн харьяалалыг хувьчлан үзүүлбэл:



Мөн ажлын албаны бүтцэд болон ижил статустайгаас үл хамааран нэгж тус бүрийг дараахь байдлаар зохион байгуулжээ. Үүнд:

1. Судалгаа, архив, номын сангийн нэгж тус тусдаа байх
2. Судалгаа болон номын сангийн үйлчилгээ хамт нэгдсэн нэг удирдлагатай байх
3. Номын сан болон архивын үйлчилгээ нь хамтдаа судалгааны нэгж нь тусдаа
4. Судалгаа, номын сан, архивын нэгж хамтдаа нэг удирдлагатай байх зохион байгуулалтын хэлбэрүүд байна.

Судалгаа, номын сан, архивын нэгж тус тусдаа бие даасан алба боловч удирдлагын хувьд парламентын ажлын албаны “Хэлтэс” болон “Газар”-т харьяалагдан нэгдсэн удирдлагаар хангагдаж байгаа байдал зүүн болон төв европын орнуудад зонхилж байна. Бусад зохион байгуулалтын хувьд тус тусдаа бие даасан алба бололгүйгээр парламентын ажлын албаны бүтэц дэх холбогдох “Хэлтэс” болон “Газар”-т харьяалагдан нэгдсэн нэг чиг үүрэгтэйгээр ажиллаж байгаа байдал эх газрын эрх зүйн системтэй орнуудад ихэвчлэн ажиглагдаж байна.

Эдгээр зохион байгуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дэлгэрэнгүй харьцуулсан хүснэгтээр хавсаргасан болно. Харин Судалгааны албаны хувьд ихэвчлэн Номын сантайгаа хамтдаа үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, АНУ-ын “Конгрессын номын сан”, Австралийн “Парламентын номын сан” гэж нэрлэх боловч үндсэндээ судалгаа, мэдээллийн үйл ажиллагаа нь нэгдмэл байна. Эдгээр орнууд нь судалгаа, мэдээллийн мэргэшсэн албадын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны сонгодог жишээтэй орнуудад тооцогддог ба сүүлийн үед хөгжиж байгаа болон шинэ тутам парламентын засаглалыг хөгжүүлж байгаа орнуудын судалгаа, мэдээллийн албадууд эдгээр орнуудын туршлагаас суралцаж нэгдсэн стандарт тогтоохын төлөө ажиллаж байна.

Австралийн Парламентын номын сан

Парламентын Номын сан анх 1901 онд Мэлбурн хотноо Австралийн Парламенттай хамт байгуулагдсан түүхтэй. 1960 он хүртэл Парламентын номын сан Тамгын газар хоёр нэг удирдлага зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан ч 1962 оноос Австралийн Үндэсний номын сантай хамтарч үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Гэвч тун удалгүй бие даасан Парламентын номын сан болсон. 1999 онд Парламентын номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон “Парламентын үйлчилгээний тухай” хууль батлагдсан.

Австралийн парламентын судалгааны алба нь номын сантайгаа нэгдмэл бүтэцтэйгээр ажиллана. Парламентын номын сан хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Судалгаа, шинжилгээ
- Мэдээлэл

Парламентын Номын сангийн харилцагчид нь:

- Гишүүд, Сенатууд, Улс төрийн намууд
- Сенат болон Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын болон байнгын хорооны ажлын албаны ажилчид, албан хаагчид байна

Хуулийн дагуу парламентын номын сан дараах **зарчмын** дагуу гишүүдэд үйлчилнэ. Үүнд:

- Цаг хугацаанд нь, нууцлалын өндөр зэрэглэлтэйгээр үйлчилгээ үзүүлнэ.
- Бие даасан, гишүүд, сенатуудын хүсэлтийн дагуу мэдээлэл судалгааны үйлчилгээ үзүүлнэ

Судалгааны эмхтгэл, XII боть

- Өндөр хэмжээний стандарт мөрдөж ажиллана.
- Үйлчлүүлэгчидэд тэгш эрхийн зарчмаар үйлчилнэ.
- Сенатын гишүүд асуултанд /Question time/ оролцох үед түүний дагуу хөтөлбөр боловсруулна
- Гишүүдийн орон нутагт мэдээлэх мэдээллийг бэлдэж, дамжуулна.

Номын сан болон судалгааны албаны үйлчлүүлэгчид үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ:

- Шинжээчийн дүгнэлт
- Бичгэн болон аман зөвлөмж
- Баримт, тоон болон статистик мэдээлэл
- Судалгааны зөвлөмж болон хэвлэл
- Хуулийн төслийн тайлбар
- Дэмжлэг болон сургалтын чиг баримжаа
- Сэтгүүлийн нийтлэл өгүүлэл, ном, мэдээллийн бааз
- Хэвлэл мэдээллийн нөөц \сонин, радио, телевиз\
- Семинар болон Лекц

Номын сангийн гол чиг үүргийн нэг болох Мэдээллийн салбар нь 60-аад ажилтантай, үйлчилгээний 4 хэсэгтэй.

- Номын сангийн мэдээлэл (*Хоёр сая долларын өртөг бүхий 150иад мянган номтой*)
- Мэдээллийн бааз бүрдүүлэлт (*Мэдээллийн бааз бүрдүүлэх, индэксжүүлэх*)
- Хэвлэл (*хэвлэмэл болон цахим хэвлэл, вэбсайт болон интранэтэд эх болон анатаци бэлдэх, цахим хэвлэл мэдээллийн мониторинг хийх*)
- Төв лавалгааны цэг (*Судалгаа, шинжилгээний захиалга авах гол цэг*)

Номын сангийн мэдээллийн бааз бүрдүүлэлт болон вэбсайт нь маш нарийн зохион байгуулалттай бөгөөд үйл ажиллагаа нь жигдэрсэн байна. Номын сан мэдээллийн баазаа Парламентын вэбсайтад байршуулах бөгөөд цахим мэдээллийн баазыг дараах байдлаар төрөлжүүлэн байршуулсан байдаг байна. Үүнд: сонины хайчилбар, нийтлэл, гишүүдын илтгэл (судлаачдын бэлдсэн), Номын сангийн өөрийн хэвлэл, номны каталоги, хуулийн төслийн шинжилгээ, улс төрийн намуудын баримт бичиг, хэвлэлийн газар, радио телевизийн нэвтрүүлэг, Парламентын гарын авлага гэх мэт

Судалгааны алба

Австралийн Номын сангийн Судалгааны алба жилд ойролцоогоор 20000 гаруй шинжээчийн дүгнэлт болон судалгааны ажил гаргадаг. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа маш шахуу, ачаалал өндөртэй ажилладаг байна. Судалгааны салбарын бүтэц зохион байгуулалтанд дөрвөн жилийн өмнө өөрчлөлт орсон. Судалгааны салбар нь 80 гаруй судлаач болон туслах ажилчидтай 7 хэсэгтэй. Үүнд:

- Эдийн засгийн судалгааны хэсэг
- Гадаад хэрэг, аюулгүй байдалын судалгааны хэсэг
- Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг
- Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг
- Шинжлэх ухаан, технологи, Хүрээлэн буй орчин байгалийн баялгын судалгааны хэсэг

- Нийгмийн бодлогын судалгааны хэсэг
- Статистик дүрслэлийн судалгааны хэсэг

Судлаачдад тавих шаардлага:

1. Салбарын мэдлэг
2. Судалгааны болон бичгийн ур чадвар
3. Задлан шинжлэх болон зөвлөлдөх чадвар
4. Хөрвөх чадвар
5. Мэргэжлийн ур чадвар
6. Мэдээлэл зөв олж авах, хувийн зохион байгуулалт сайтай байх.

Номын сангийн судалгааны хэсгүүд нь судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхдээ удирдлагын гаргасан “Судалгааны захиалга хүлээн авах журам”, “Судалгааны ажил гүйцэтгэх заавар”, “Хуулийн төслийн шинжилгээ хийх журам” болон холбогдох бусад заавар журмын дагуу хийж гүйцэтгэнэ. Туршлага судлах явцад тус судалгааны салбарын судалгааны ажил гүйцэтгэх арга зүй, зохион байгуулалтын хэлбэр манай төвийн үйл ажиллагаатай тун ойролцоо байсан юм.

Хуулийн төслийн шинжилгээ

Австралийн парламентын Судалгааны албаны судалгаа шинжилгээний ажлын чухал хэсэг нь *Хуулийн төслийн шинжилгээ* (bill digest) юм. Судалгааны салбарын Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг нь 2008 оны 2-р сараас шинээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд нийт 267 хуулийн төсөлд шинжилгээ хийсэн байна. Хуулийн төслийн шинжилгээг дараах агуулгын хүрээнд хийдэг байна. Үүнд:

- Хуулийн төсөлд нийгмийн ямар харилцааг зохицуулах ямар зорилт дэвшүүлсэн талаар
- Хуулийн төслийг зохих шаардлагын дагуу боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргах
- Хуулийн төсөлд тухайн харилцааг хэрхэн зохицуулахаар тусгасан, бодлогын ямар хувилбарыг сонгосон, үүдэн гарах үр дагавар нь ямар байх талаар дүгнэлт гаргах
- Томоохон хэмжээний зүйл, заалтуудад дүн шинжилгээ хийх
- Дүгнэлт гаргах
- Зөвлөмж, тайлбар гаргах

Хуулийн төслийн шинжилгээний албан ёсны дүгнэлттэй бүх гишүүд заавал танилцах ба сард ойролцоогоор 80-100 мянган хүн эдгээр дүгнэлттэй танилцдаг гэсэн албан ёсны тоо байна. Ийм учраас шинжээчдийн гаргасан санал дүгнэлт, зөвлөмжийг хуулийн төсөлд тусгах магадлал өндөр байдаг байна. Хуулийн төслийн шинжилгээг зөвхөн Судалгааны албаны шинжээчид хийнэ. Учир нь Байнгын хороодын судлаачид улс төрийн өнгө аястай тайлан бичдэг гэж үздэг тул хараат бус бие, даасан, бодит судалгаа гаргах үүднээс хуулийн төслийн шинжилгээг судалгааны албаны үндсэн чиг үүрэгт хамааруулсан байдаг байна.

2. Судалгаа, архив, номын сангийн нэгжийн ерөнхий чиг үүрэг

Аливаа улс орны парламентын ажлын албаны судалгаа, номын сан, архивын нэгжийн үндсэн чиг үүрэг нь ерөнхийдөө ижил төстэй боловч тухайн орны өөрийн онцлог, парламентын ажлын албаны бодлого, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан дээрх

нэгжүүдийн чиг үүрэг тодорхой хэмжээнд ялгамжтай байгааг дэлгэрэнгүй судалгаагаар үзүүлэв. Үүнд:

1. Судалгааны нэгжүүдийн ерөнхий чиг үүрэг:

- Парламентаар хэлэлцэх хуулийн төслийн талаар харьцуулсан судалгаа, товч мэдээлэл, бодлогын судалгаа болон эрх зүй, эдийн засаг, төсөв, хүрээлэн буй байгаль орчны шинжилгээ судалгаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, эдийн засгийн тухайн төлөв байдал эдийн засаг, мөнгөний бодлого, хуулийн төслийн нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар мониторинг хийх,
- Хууль хэрэгжсэнээр гарч болох нийгмийн үр дагаварын талаар судлах,
- Парламентын гишүүд болон судалгаа захиалах эрх бүхий хэрэглэгчийн хүсэлтээр эрх зүйн акттай холбоотой мэдээлэл бэлтгэх,
- Танхим, байнгын хороодоор хэлэлцэгдэж буй хуулийн төслийн талаарх мэргэжлийн байгууллага болон олон нийтийн санаа бодлыг судлах,
- Парламент болон Байнгын хороод, хэлтэс, албадын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх;
- Шинээр сонгогдсон гишүүдэд зориулан лавлагаа, мэдээлэл бэлтгэх,
- Дотоодын болон олон улсын судалгааны институт, номын сангууд, их сургуулиудтай нягт уялдаа холбоотой ажиллах;
- Хуулийн төслийн шинжилгээ хийх
- Гадаад улс дахь тодорхой асуудлаар дагнасан судалгаагаар захиалагчийг хангах

2. Номын сангийн нэгжүүдийн ерөнхий чиг үүрэг:

Номын сангийн үйлчилгээний хувьд анхаарвал зохих нэг асуудал нь нээлттэй болон хаалттай үйлчилгээ үзүүлдэг онцлог улс орнуудад байна. Нээлттэй нь гишүүд болон парламентын ажлын албаны ажилчид болон бусад сурагч, судлаач, иргэдэд нээлттэй үйлчилдэг байна. Тухайлбал, Финлянд улсын парламентын номын сан нээлттэй үйлчилгээ үзүүлдэг байна. Дийлэнх парламентын номын сан гишүүд болон судлаач, ажлын албадын холбогдох албан хаагчдад үйлчилдэг байна.

- Номын сангийн үйлчилгээний нэгж нь хэрэглэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хурдан шуурхай үйлчилнэ.
- Уншлагын үйлчилгээ нь гар дээр ном олгох, хувилахаас гадна номын сангийн мэргэжилтнүүд нь гишүүдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл бэлтгэх,
- Ном сурвалж болон дэлхийн түүхэн баримт бичгүүдээс бүрдсэн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, хадгалалтын нөхцөл, зохион байгуулалт, ангилах,
- Ном худалдан авах, хадгалах, индексжүүлэх,
- Тогтоосон журмын дагуу номын сангаар үйлчлүүлэх ажлыг зохион байгуулах,

3. Архивын нэгжүүдийн үйлчилгээ:

- Хууль эрхийн актууд, Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэр, хуулийн тайлан, танхимын тайлан, мэдэгдэл, албан ёсны сонингуудын эмхтгэлийг баталгаажуулах;
- Парламент, түүний байгууллагуудаас гаргадаг баримт бичгийн хадгалалт, ашиглалт, үйлчилгээний талаар хариуцлага хүлээх;
- Номинал шинжилгээний хүснэгт, нийтийн болон Байнгын хороодын сэдэвчилсэн хэлэлцүүлгийн талаар бүртгэл хөтлөх, гишүүдийн намтрын баяжилт хийх;

- Парламентаас архивт шилжүүлсэн баримт бичиг, хуурцгуудыг хадгалах;
- Парламентын баримт бичгийн фондыг бүрдүүлэх, хөтлөх, тоолох, дахин боловсруулах, тэдгээрийг бичгийн, цахим, хэвлэмэл хэлбэрээр хадгалах,
- Парламентын үйл ажиллагааны талаарх материалыг бэлтгэх, редакторлах, өөрийн мэдээллийн баазыг бүрдүүлж, түүний үндсэн дээр хууль тогтоох үйл ажиллагааны талаар мэдээлэл, статистик болон дүн шинжилгээний эмхтгэл гаргах, харьцуулсан судалгаа, төлөвлөгөөний арга зүйг боловсруулах,
- Баримт бичгийн цахим архив бий болгох, бусад ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллаж засгийн газрын бүх шатны үйл ажиллагааны талаар мэдээлэл, баримт бичиг солилцох болон хуулиар тогтоосон бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.
- Парламентаар хэлэлцэгдсэн, батлагдсан хууль нэг бүрийн мэдээллийг үе шат бүрээр нь архивлана. Түүнчлэн индексжүүлсэн, ангилсан бусад материалыг хадгалж, лавлагааны материалыг хэвлүүлж гишүүдэд хүргэх ерөнхий чиг үүрэгтэй.

3. Нэгжүүдийн орон тоо

Судалгаанд хамруулсан улс оруудын хувьд парламентын ажлын албаны судалгаа, номын сан, архивын нэгжүүдийн орон тоо харилцан адилгүй байна. Парламентын танхим, гишүүдийн тоо, ажлын цар хүрээнээс хамаарч нэгж тус бүрийн орон тоо харилцан адилгүй байвч дийлэнх улс орон нь парламентын ажлын албаны бүтэц, албан хаагчдын тоо хангалттай байхыг эрхэмлэдэг байна. Үүнд маш олон орныг жишээ болгон дурьдаж болох юм. Тэр дундаа архив, номын сангийн нэгжээс судалгааны үйлчилгээ үзүүлдэг нэгж албан хаагчдын тоог хангалттай байхаар зохицуулсан байна.

Тухайлбал, Вьетнамын парламентын судалгааны албанд орон тооны 50 гаруй ажилтнаас гадна 250 гаруй мэргэжилтэн, эксперт, судлаач ажилладаг бол Австралийн судалгааны албанд 80 гаруй судлаачид, Номын санд нь 60 гаруй ажилтан, АНУ-ын Конгрессийн судалгааны алба нь нийт 700 гаруй ажилтантайгаас 450 гаруй нь бодлогын шинжээч, хуульч, мэдээллийн мэргэжилтэн, эдийн засагч, гадаад хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, цагаачлал, эрчим хүч, байгаль орчин болон шинжлэх ухаан, технологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, шинжээчид байна.

4. Судалгааны албадын чиг үүрэг

Судалгаанд хамрагдсан гадаадын 46 орноос АНУ-ын Конгрессын Судалгааны албыг сонгон чиг үүргийг дэлгэрүүлэн авч үзье. Учир нь дээр бусад орны судалгааны нэгжийн чиг үүргийг ерөнхийд нь авч үзсэн тул энд жишиг болохуйц үйлчилгээ үзүүлж буй оронг сонгон авлаа.

АНУ-ын Конгрессийн Судалгааны алба:

Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 1914 онд Конгрессийн номын сангийн бүтцэд Хууль зүйн лавлагааны албыг байгуулжээ. 1970 онд “Бүтэц, зохион байгуулалтын тухай хууль”-аар Хууль зүйн лавлагааны албаны нэрийг өөрчилж “Конгрессийн судалгааны алба” болгосон байна.

Конгрессийн судалгааны алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах дэлхийн хамгийн том судалгааны төв бөгөөд Конгрессийн гишүүд солигдож шинэчлэгдсэн ч энэ алба нь “Конгрессийн тархи” болж үе үеийн Конгрессийн гишүүд, Байнгын хороодод мэдээлэл, мэдлэг, судалгаагаар хангах үйлчилгээг үзүүлдэг байнгын цэнэглэгч хүч нь байсаар ирсэн. Шинжээчид нь хуулийн төслийг Байнгын хороодоор хэлэлцүүлэхээс эхлээд хууль батлагдах хүртэлх бүх шатанд мэдээлэл, судалгааг бэлтгэхдээ цаг үедээ нийцсэн, бодитой, аль нэг

улс төрийн хүчнээс хараат бус, төвийг сахисан, нууцлалыг чандлан хадгалах зарчмуудыг барьж ажилладаг.

Гүйцэтгэх засаглал ба хууль тогтоох байгууллагын судалгааны чадавхийг тэнцвэржүүлэх зорилгоор тус албыг 1970 -аад оны үед өргөтгөн бэхжүүлсэн байна. Эрх зүйн зохицуулалтын хувьд тус албаны үйл ажиллагааг АНУ-ын Конгрессийн хууль тогтоох үйл явцтай нягт уялдуулж өгсөн ба Конгресст бодлогын олон талт хувилбарууд ба тэдгээрээс гарах үр дагаварыг тооцсон санал боловсруулан танилцуулах үүрэгтэй бөгөөд гүйцэтгэх засаглалын байгууллага болон олон нийтийн судалгааны хэрэгцээг хангах үүрэг хүлээдэггүй.

Судалгааны албанаас тайлан, мэдээлэл, семинар, илтгэл, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд үзүүлдэг.

Судалгааны албаны бүтэц:

Захирлын ажлын алба:

- Захиргааны үйл ажиллагааны алба - *Office of Administrative Operations*
- Олон нийттэй харилцах алба - *Communications Office*
- Нягтлан шалгах /шүүмж/ газар - *Review Office*

Судалгааны алба нь 5 салбар, 1 хэсэгтэй. Үүнд:



а) Нэгдсэн Улсын хуулийн салбар

Энэ салбар нь хуулийн чиглэлийн бүхий л асуултуудад хариулт өгдөг. Ингэхдээ тухайн асуудал Үндсэн хуулийн зарчим, холбогдох хууль, холбооны улсын зарчим, худалдаа, иргэний эрхтэй нийцсэн эсэх талаас авч үзнэ. Түүнчлэн бизнес, гэмт хэрэг, байгаль орчин, иргэний эрх, олон улсын эрх зүйн зэрэг салбарын хууль, холбогдох асуудлуудад дүн шинжилгээ хийдэг.

Энэ салбар нь дотроо таван хэсэгтэй ба хэсэг тус бүр удирдагчтай байна. Үүнд:

- Захиргааны хууль
- Бизнес
- Конгресс
- Шүүх ба олон улсын харилцаа

- Үндэсний баялаг / Холбооны нөөц

б) Нийгмийн бодлого

Энэ салбар нь дотоодын нийгмийн бодлогын хөтөлбөрийн асуудлуудад дүн шинжилгээ хийдэг. Энэ салбарын хамрах асуудлын хүрээнд боловсрол, хөдөлмөрийн нөөц, түүний аюулгүй байдал, эрүүл мэндийн даатгал ба санхүүжилт, эрүүл мэндийн үйлчилгээ, насжилт, нийгмийн даатгал, тэтгэвэр, иргэдийн шилжилт хөдөлгөөн, эрүүгийн хэргийн шүүх, нийгмийн хангамж, хүнс ба орон сууцны хөтөлбөрүүд багтана.

Энэ салбар нь дотроо зургаан хэсэгтэй ба хэсэг тус бүр судалгааны удирдагчтай байна.

- *Хүүхэд ба гэр бүл* – жирэмслэлт, хүүхэд ба үрчлэлт, бага орлоготой иргэд, орон гэргүйчүүд болон орон гэрээсээ дайжсан өсвөр насныхан, орон сууцны хөтөлбөр,
- *Аюулгүй байдал ба шилжилт хөдөлгөөн* – Эрүүгийн гэмт хэрэг, мансууруулах бодисын хэрэглээ, архи, тамхи, галт зэвсгийн хяналт, хилийн аюулгүй байдал, шилжилт хөдөлгөөн,
- *Боловсрол ба ажиллах хүч* – анхан болон дунд боловсрол, мэргэжлийн сургалт, ажиллах хүчний асуудлууд,
- *Эрүүл мэндийн үйлчилгээ ба санхүүжилт* – эмнэлгийн үнэгүй тусламж, ядуу иргэдэд зориулсан эрүүл мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ ба хүүхдийн эрүүл мэндийн даатгалын асуудлууд,
- *Эрүүл мэндийн үйлчилгээ ба судалгаа* – эрүүл мэндийн судалгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд, ахмад дайчдын эрүүл мэндийн халамж,
- *Нийгмийн даатгал* – нийгмийн даатгал, ажилгүйдлийн нөхөн төлбөр, тэтгэвэр, тэтгэмж зэрэг асуудал тус тус хамаарна.

с) Гадаад хэрэг, батлан хамгаалах, худалдаа

Энэ салбарт дэлхийн улс төр, эдийн засгийн хөгжлийн асуудал, АНУ ба бусад улс хоорондын улс төр, эдийн засгийн харилцаа, улс хоорондын асуудал болох терроризм, цагаачлалын асуудлаар шинжээчид ажилладаг. Үндэсний аюулгүй байдлын судалгаанд зэвсэгт хүчний стратеги, АНУ-ын батлан хамгаалахын төсөв, зэвсгийн систем, зэвсэгт хүчний баазын нөхөн төлбөр зэрэг асуудлууд хамаарна. Худалдааны шинжээчид нь эдийн засгийн асуудлуудад дүгнэлт өгөх ба худалдааны тариф, экспорт, импортын асуудлуудыг авч үзнэ.

Тус салбар дотроо долоон хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

- Ази
- Батлан хамгаалах ба зэвсгийн хяналт
- Батлан хамгаалахын төсөв, удирдлага, зохион байгуулалт
- Европ ба Америк тив
- Гадаад бодлогын менежмент, олон улсын асуудал
- Олон улсын худалдаа ба санхүү
- Ойрхи дорнод ба Африк

д) Засгийн газар ба Санхүү

Тус салбар нь зургаан хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр удирдагчтай байна.

- Банк, даатгал, үнэт цаас ба макро эдийн засгийн бодлого
- Конгресс ба шүүх засаглал
- Гүйцэтгэх засаглалын салбарын үйл ажиллагаа – Ерөнхийлөгчийн алба ба эрх мэдэл, ерөнхийлөгчид нэр дэвшигчид, холбооны ажиллах хүч, Нэгдсэн улсын шуудан, дүрэм журмын удирдлага, спорт гэсэн асуудлуудыг хамаарна.
- Холбооны улсын зарчим, сонгууль ба онцгой байдлын удирдлага
- Засгийн газрын санхүү ба татвар
- Хууль тогтоох ба төсөв батлах үе шат

Санхүүгийн асуудлын хүрээнд банк, санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаас, татвар, төрийн санхүү, төсвийн болон мөнгөний бодлого, улсын зээл, эдийн засгийн зээлийн үзүүлэлтүүдийг судалдаг.

е) Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нөөц

Тус салбар нь байгалийн нөөц, шинжлэх ухааны дэвшил, технологийн хөгжил, бизнесийн гол салбаруудын зохицуулалтын судалгаа хийдэг. Нөөцийн асуудлын хүрээнд байгалийн баялаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, хүнс ба загас агнуур, эрчим хүч ба ашигт малтмал зэрэг хамаарна. Шинжлэх ухааны салбарын асуудалд иргэний болон зэвсэгт хүчний судалгаа хөгжлийн асуудлууд, мэдээллийн технологи, сансар судлал, бусад шинжлэх ухааны салбарууд хамаарна. Үйлдвэрлэлийн асуудалд тээврийн хяналт, тээврийн дэд бүтцийн асуудал, үйлдвэрлэлийн зах зээл ба зохицуулалтын талаархи шинжилгээ, судалгааны ажлууд багтдаг.

- Хөдөө аж ахуй ба хүнсний хангамж
- Эрчим хүч ба ашигт малтмал
- Байгаль орчны бодлого
- Байгалийн нөөц судлал
- Шинжлэх ухаан ба технологийн бодлого
- Тээвэр ба үйлдвэрлэлийн шинжилгээ

Мэдлэгийн мэдээллийн хэсэг

Энэ хэсэг нь дээр дурдагдсан судалгааны салбаруудын бодлогын судлаачдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, туслах хэлбэрээр хамтран ажилладаг. Конгрессийн судалгааны албанаас үзүүлэх үйлчилгээ болон бүтээгдэхүүнүүд:

- Бодлого, эрх зүй болон процедурын иж бүрэн дүн шинжилгээ хийлгэх
- Бодлогын олон талт хувилбаруудыг нээн илрүүлэх, үнэлэх, тэдгээр хувилбаруудын үр дүн, үр дагаварыг тооцох
- Хуулийн төсөл боловсруулахад анхан шатны дэмжлэг авах
- Сүүлийн үеийн судалгааны арга, аргачлалыг ашиглан тодорхой асуудлаар тоон мэдээллийн сан буй болгох, дүн шинжилгээ хийлгэх
- Судалгааны шинэ үр дүн, мэдээ ба мэдээллийн эх сурвалжыг олж авах, тодорхойлолт гаргуулах
- Конгрессийн байнгын хороодод шинжээчийн дүгнэлтийг сонсгох
- Хууль тогтоох байгууллагын анхаарлын төвд байгаа асуудлаар сургалт семинар хийх

КСА-ны Эрхэм зорилго:

- “Хууль тогтоох бүхий л үйл явцын туршид Конгрессийг иж бүрэн, үнэн зөв дүн шинжилгээ, судалгаагаар хангаж ажиллах, үйлчилгээ нь төвийг сахисан, цагаа олсон, нууцыг чандлан хадгалсан байх”

КСА-ны Үнэт зүйлс:

- “Нууцыг хадгалах, төвийг сахих, бодитой хандах” гэж тодорхойлжээ.
Дээрх эрхэм зорилго, үнэт зүйлсийн дагуу КСА-ны ажилтан бүр судалгааны бүх үе шатанд нууцыг чандлан хадгалах, төвийг сахиж нөлөөнд үл автсан, бие даасан байдлаар гишүүдэд дэмжлэг үзүүлэх, тэнцвэртэй, бодитой дүн шинжилгээ хийх, мэдлэг, мэдээллийг хадгалах, уламжлан дамжуулан ажилладаг.

КСА-ны чиг үүрэг:

- Конгресст Нэгдсэн улсын иргэдийн эрх ашигт нийцсэн, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай төвийг сахисан судалгаа, дүн шинжилгээ хийж, бодлогын альтернатив хувилбарууд ба эдгээрийн үр нөлөөг боловсруулан санал болгох мэдээллээр хангах үүрэгтэй.

КСА нь зөвхөн Конгрессийн байнгын хороод болон Конгрессийн гишүүдийн мэдээлэл, судалгааны хэрэгцээг хангах зорилгоор ажилладаг. КСА-ны үйлчилгээний хэлбэр:

- Зөвлөлгөө өгөх, мэдээлэл хийх
- Нууц танилцуулга бэлтгэх
- Шинжээчдийн мэдүүлэг хийх
- Цахим хуудасны үйлчилгээ
- Конгрессоор дамжуулж олон нийтэд дамжуулах мэдээ
- Сургалт семинар
- Ерөнхий мэдээлэл
- Уншлагын танхим ба судалгааны төвүүд

Конгресст хэлэлцэх хуулийн төслийн жагсаалттай уялдуулан Судалгааны албанаас бэлтгэн гаргаж буй судалгаа шинжилгээний бүтээлүүд нь зохиогчийн эрхээр хамгаалагдахгүй бөгөөд Конгрессийн зөвшөөрлөөр нийтэд чөлөөтэй ашиглагддаг. Энэхүү мэдээллийг КСА-ийн цахим хуудаснаас 7 хоногийн бүх өдөр 24 цагийн турш үзэх боломжтой. Мөн Конгрессийн гишүүд болон бүх байнгын хороодын хүсэлтээр мэдээлэл бэлтгэх бөгөөд энэ мэдээлэл нь бүх гишүүдэд нээлттэйгээр эсвэл зөвхөн нэг гишүүнд зориулагдсан нууц хэлбэрээр бэлтгэгдэнэ.

Зөвлөлгөө өгөх, мэдээлэл хийх хэлбэрүүд

- Гишүүний өрөөнд биечлэн эсвэл КСА-ны байранд зөвлөлгөө өгөх
- Утсаар, телехурал эсвэл онлайн ярилцлага хийх
- Бодлогын асуудлаар суурь мэдээ өгөх
- Хууль тогтоомжийн тойм бэлтгэх
- Ирээдүйн хууль тогтоомжийн хувилбаруудыг судлан мэдээлэх

Зуучлах үйлчилгээ

- Мэргэшсэн мэдээллийн ажилтнууд /Information Professionals/

- Мэдээллийн баазаас сэдэвчилсэн хайлт хийх
- Конгрессийн гишүүдийн өмнөөс бусад байгууллагуудтай холбоо барьж мэдээлэл авах

Сонсголын бэлтгэл

КСА-ны шинжээчид мэдээлэл өгөх боломжтой гэхдээ тухайн асуудлын нөлөөллийн бус аспектаар сонсголд оролцож мэдээлэл өгдөг бөгөөд мэдээлэл нь тухайн шинжээчийн мэдлэгийн цар хүрээгээр хязгаарлагдана.

- Сонсголд оролцох гэрчийн жагсаалтыг бэлтгэх
- Сонсголын асуултуудыг бэлтгэх
- Сонсголын нээлтийн үг, илтгэлийг бэлтгэхэд туслах
- Шаардлагатай үед нь газар дээр нь мэдээлэл өгөх зорилгоор сонсголд оролцох

Хуулиар хоригдосон үйлчилгээ

- Туйлширсан, төвийг үл сахисан үйлчилгээ үзүүлэх;
- Конгрессийн нэг гишүүний талаарх мэдээллийг нөгөө гишүүнд өгөх;
- Хуулийн төслийг бичих болон хуультай холбоотой албан ёсны төсөв тооцоо гаргах.

5. Судалгааны захиалга авах, гүйцэтгэх

Судалгаанд хамрагдсан 46 орны хувьд ихэнх нь судалгааны захиалга хүлээн авах, судалгааны ажлыг гүйцэтгэх журамтай байна. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн хувьд журамд дараах зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

- ✓ Судалгааны ажлыг парламентын гишүүд, парламентын Байнгын болон Дэд, Түр хороод, Тамгын газрын удирдлагын захиалгаар гүйцэтгэнэ.
- ✓ Цаг үеийн тулгамдсан асуудал, бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудлаар судлаач болон судалгааны төвийн санаачлагаар судалгааны ажлыг гүйцэтгэж болно.
- ✓ Судалгааны захиалгыг албан бичгээр авна. Лавлагаа, мэдээллийн шинжтэй болон хөдөө орон нутаг, гадаадад ажиллаж байгаа гишүүдийн захиалгыг утсаар буюу цахим шуудангаар авч болох бөгөөд Судалгааны төвийн бичиг хэрэг хариуцсан ажилтан захиалагчийн нэр, захиалга өгсөн утасны дугаар, цаг, огноо, цахим хаягийг бүртгэлд тэмдэглэнэ.
- ✓ "Нууц"-тай холбоотой захиалгыг энэ талаар гарсан хууль тогтоомж, холбогдох журам, зааврын дагуу шийдвэрлэнэ.

Түүнчлэн судлаачид гишүүдэд хувийн зөвлөгөө өгөх, сонгуулийн тойрогт нь ажиллах, хуулийн төсөл боловсруулах, боловсруулахад оролцох, улс төрийн үзэл бодлоо судалгааны бүтээлдээ илэрхийлэх, захиалагчын зөвшөөрөлгүйгээр судалгааны бүтээлийн талаар бусдад мэдээлэхийг хориглодог. Ажил үүрэгт нь хамааралгүй эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй болон хүний хувийн нууцад хамаарах захиалгыг гүйцэтгэхээс татгалзах эрхийг судлаачид эдэлдэг байна.

Улс орнуудын хувьд эрх зүйн аль системд хамаарч байгаагаас үл шалтгаалан судалгааны захиалга авах, гүйцэтгэх журам ерөнхийдөө ойролцоо зохицуулалтай байна. Австралийн хувьд судалгаа шинжилгээний ажил хийхдээ «Судалгааны захиалга хүлээн авах журам», «Судалгааны ажил гүйцэтгэх заавар», «Хуулийн төслийн шинжилгээ хийх журам» -уудыг баримталдаг бол зүүн болон төв Европын улс орнууд дотоод журмаараа зохицуулах нь их

байна. Энд жишиг болгон мөн л АНУ-ын КСА-ын судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй авч үзлээ. Үүнд:

Конгрессийн судалгааны албны судалгаа шинжилгээний ажлын процедур

2010 оны санхүүгийн жилд Конгрессийн судалгааны алба нь 78 276 судалгаа, дүн шинжилгээ болон мэдээллийн захиалга, хүсэлт хүлээн авч шийдвэрлэн, Конгрессийн гишүүд болон тэдгээрийн туслах, ажилтнуудад зориулсан 6 655 судалгаа гаргаж, 393 сургалт семинар зохион байгуулан, 8 223 хуулийн төслийн тойм бичсэн байна.

Конгрессийн гишүүд болон тэдгээрийн туслах, ажилтнууд судалгааны захиалга өгөх, хүсэлт гаргахдаа дараах хэлбэрүүдийн аль нэгийг сонгон хүсэлтээ гаргана. Үүнд :

- Конгрессийн номын сангийн Хүсэлт хүлээн авах хэсгийн утасны дугаар руу залгаж лавлагаа хариуцсан номын санчтай холбогдож захиалга өгөх, хүсэлт гаргах;
- КСА-ны цахим хуудсанд нэвтэрч онлайн захиалга өгөх, хүсэлт гаргах;
- Тодорхой нэг судлаач, шинжээч ажилтантай утсаар холбогдож захиалга өгөх, хүсэлт гаргах.

Онлайн захиалга өгөх, хүсэлт гаргахдаа КСА -ийн цахим хуудсанд дараах мэдээллийг бөглөдөг.

Place Request

Have a CRS.gov Account? [Sign In](#)
A CRS.gov account is not required in order to Place a CRS Request.

1 Enter Request Details 2 Review Your Request 3 Confirmation

Please Note
Same day deadlines: Call CRS 7-5700 (202-707-5700) and press 1, 5
Requests are read: Monday - Friday 8:00 a.m. - 6:00 p.m. (Eastern Time)
To change or follow up on a previously placed request, call CRS 7-5700 (202-707-5700) and press 1, 5, and indicate your request.

Contact Information
In order to complete your contact information, you must first choose your name from the staff directory by searching in the below. If you cannot find your name please call CRS at 7-5700 (202-707-5700).

Your Name: Begin typing to find your name in the staff directory.
Your Office:
Preferred Address:
*Address Line 1: *Phone:
Address Line 2: Fax:
*City: *Email:
*State: Please select a State
*Zip:

Not you? Clear the contact information and search the staff directory again.

CLEAR ALL CONTACT INFORMATION

About Your Request
Is this a Constituent Request? ☐ No ☐ Yes
*Subject:
*Request:

Судалгааны захиалга, хүсэлтийг боловсруулах:

Хүсэлт хүлээн авах хэсгийн үүрэг: Хүсэлт хүлээн авах хэсэгт лавлагаа хариуцсан номын санчид ажилладаг бөгөөд тэд хүсэлт гаргагчид асуултыг нь нарийвчлах, томъёолоход нь туслана. Жишээлбэл дараахь асуултуудыг тавьж болно. Үүнд:

- Та эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн талаар мэдээлэл байгаа эсэхийг асууж байна. Та яг ямар мэдээлэл хэрэгтэй байгаагаа илүү тодруулж өгнө үү. Танд зөвхөн дээрх асуудлаар хуулийн төслүүд хэрэгтэй байгаа юу эсвэл бусад баримт бичиг, мэдээллүүд хэрэгтэй юу?
- Дээрх мэдээллийг та ямар зорилгоор ашиглах вэ?
- Танд дээрх мэдээлэл хэзээ хэрэгтэй байна вэ?

Дээрх мэдээллийг авсны дараа хүсэлтийг хүлээн авч мэдээллийн мэргэжилтнүүд эсвэл шинжээчид хуваарилан хариуцуулна. КСА нь 100 орчим мэдээллийн мэргэжилтэнтэй (Information Professionals) бөгөөд тэдний гол үүрэг нь хэрэгцээтэй байгаа мэдээллийг богино хугацаанд олох явдал юм. Судалгааны алба мөн 350 орчим шинжээчтэй (Analyst). Шинжээч нар асуудлыг нарийвчлан судлах, тайлан бичих, мэдээлэл хийх үндсэн үүрэгтэй юм.

Мэдээллийн мэргэжилтнүүдийн бусад үүрэг:

- Конгрессийн ажилтнуудад конгрессийн бичиг баримтыг хэрхэн хайх ба ашиглах, судалгаа хийх арга чадварыг сурган эзэмшүүлэх;
- Шинжээчдэд шаардлагатай мэдээллийг олж өгөх;
- Шинжээчдэд цахим мэдээллийн санг ашиглах талаар сургалт явуулах, тэдэнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, зөвлөлгөө өгөх;
- Судалгааны ажлуудын товхимол, эмхтгэлийг хадгалах.

Хүсэлтийг цахим хэлбэрээр олох, хянах:

1. Хүсэлтийн дугаар
2. Хүлээн авсан огноо
3. Хүсэлт гаргасан нэгж
4. Сэдэв
5. Хүсэлтийн талаархи дэлгэрэнгүй мэдээ
6. Эцсийн хугацаа
7. Хариуцах шинжээч /мэдээллийн мэргэжилтэн/
8. Ямар хариу өгсөн гэсэн бүх мэдээллүүд тусгай хуудсанд хадгалаастай байдаг

Захиалагч өөрийн хүсэлтийн талаарх мэдээллийг хянахдаа дээрхээс аль нэг өгөгдлийг оруулан мэдээллийг харах боломжтой.

КСА -ны Хянан тохиолдуулах нэгж:

Дээрх нэгж нь КСА-ны бүх бүтээгдэхүүн бодитой, төвийг сахисан, бодит, цагаа олсон эсэхийг дараахь материалууд дээр үндэслэн дүгнэлт гаргаж хянан шалгана.

- Товч мэдээллийн хуудас ба тайлан;
- КСА-аас боловсруулсан боловч Конгрессийн байнгын хорооноос нийтлэх судалгаа, илтгэл;
- Конгрессийн гишүүд болон тэдгээрийн туслахуудад зориулагдсан тэднээс мэдээлэл хийхдээ ашиглах PowerPoint слайд;

- Шинжээчийн мэдүүлэг;
- Сургалт, семинарын төлөвлөгөө;
- Сургалт, семинарын видео материал;
- Цахим хуудас дээрх материал;
- Судалгааны ажлын агуулга бүхий и-мэйл.

КСА-ны вэб хуудас зөвхөн Конгрессийн гишүүд болон тэдгээрийн туслахуудад зориулсан байдаг байна.

УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн хувьд

Монгол Улсын Их Хурлын тамгын газрын Судалгааны төвийн хувьд “Судалгааны захиалга хүлээн авах, гүйцэтгэх журам”-ыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар баталсан юм. Тус журамд зааснаар судалгааны захиалгыг албан бичгээр авах бөгөөд лавлагаа мэдээллийн шинжтэй захиалгыг утсаар буюу цахим шуудангаар авч болохоор заасан. Судалгааны төвд захиалгын дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх ба захиалагчийн нэр, утасны дугаар, захиалга өгсөн цаг, огноо, захиалгын утга зэргийг тэмдэглэнэ. Түүнчлэн хүлээн авахыг хориглосон захиалгыг журамласан байна. Үүнд:

- ✓ Хувийн асуудлаарх - тухайн хувь улс төрчийн эрдэм шинжилгээний ажил, хувийн ярилцлага, хэлэх үг, илтгэл болон тойрогт сурталчилгаа хийх, рейтинг тодорхойлох, улс төрийн намын үйл ажиллагаа болон хувийн бизнесийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаар,
- ✓ Тамгын газрын бусад хэлтэс, албад болон УИХ -ын гишүүдийн зөвлөх, туслахуудын үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах асуудлаар,
- ✓ Улс төрийн зорилгоор өөрийн байр суурийг нотлох байдлаар гаргуулахыг хүссэн дүгнэлт, зөвлөмж,
- ✓ Орчуулгын ажил,
- ✓ Төрийн болон төрийн бус байгууллагуудаас УИХ-ын гишүүд өөрсдөө болон зөвлөх, туслахаараа дамжуулж шууд гаргуулан авах боломжтой баримт, мэдээллийг хүлээн авахыг хориглосон байна.

Судалгааны төвийн бүтээгдэхүүн нь бодлогын судалгаа, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ, тойм мэдээлэл, лавлагаа мэдээлэл, илтгэл, санал асуулгын хуудас зэрэг хэлбэртэй байх ба бүтээгдэхүүний төрөл тус бүрээр код олгох журам үйлчилж байна.

Судалгаанд хамрагдсан улс орны Парламентын ажлын албаны судалгаа, архив, номын сангийн нэгжийн талаарх харьцуулсан мэдээлэл

Хавсралт

(Тухайлсан улс орноор)			
Судалгаа	Архив	Номын сан	Тайлбар
(1)	(2)	(3)	(4)

(1)	(2)	(3)	(4)
Жибути			
Шинжээчдын алба	<p>Архивын хэлтэс</p> <p>Тус хэлтэс нь Жибути Улсын бусад нийтийн болон шинжлэх ухааны номын сангуудтай хамтран Үндэсний ассамблей болон депутатуудад шаардлагатай мэдээллийн үйлчилгээг үзүүлэх чиглэлээр дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none">-Жибути Улсын хууль эрхийн актууд, Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэр, хуулийн тайлан, Тооцооны танхимын тайлан, мэдэгдэл, албан ёсны сонингуудын эмхтгэлийг баталгаажуулах;-Ном худалдан авах, хадгалах, индексчлэх болон гишүүдэд ном, тогтмол хэвлэлээр үйлчлэх;-Товчооноос тогтоосон журмын дагуу номын сангаар үйлчлүүлэх ажлыг зохион байгуулах;-Үндэсний ассамблей, түүний байгууллагуудаас гаргадаг баримт бичгийн хадгалалт, ашиглалт, үйлчилгээний талаар хариуцлага хүлээх;-Номинал шинжилгээний хүснэгт, нийтийн болон Байнгын хороодын сэдэвчилсэн хэлэлцүүлгийн талаар бүртгэл хөтлөх, гишүүдийн намтрын баяжилт хийх;-Үндэсний ассамблейгаас архивт шилжүүлсэн баримт бичиг, хуурцгуудыг хадгалах;	Шинжээчдын алба, Архивын хэлтэс 2 тусдаа албаны статустай боловч “Баримт Бичиг, Мэдээллийн Газар”-т харъяалагдах ба дээд удирдлага нь нэг байна. Номын сан нь Архивын нэгж дотроо байна.	

Кабо-Верде		
Парламентын мэдээлэл, баримт бичгийн үйлчилгээний газар Тус газар нь Үндэсний ассамблейн баталсан болон үйл ажиллагааны мэдээлэл, баримт бичгүүдийг шуурхай тараах, хураан авах, хадгалах, системчлэх үүрэгтэй. Чиг үүрэг: - Үндэсний ассамблейн үйл ажиллагааг номын сангийн болон баримт бичгийн үйлчилгээгээр дэмжих; - Үндэсний ассамблейн түвшинд номын сан, баримт бичиг, дүрэм заавар, хууль эрх зүй, захиргаа, шинжлэх ухаан, техникийн мэдээллээр дэмжих, тэдгээрийг цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах; - Үндэсний болон олон улсын мэдээллийн шинэчилсэн файлуудыг бий болгох; - Үндэсний ассамблейн үйл ажиллагаанд холбогдох үндэсний болон гадаад улс орнуудын хууль тогтоох үйл ажиллагааны мэдээлүүдийг цуглуулах, шинжилгээ хийх, архивлахад тусалцаа үзүүлэх; - Номын санг удирдлагаар хангах; - Үндэсний ассамблейн баримт бичиг болон Үндэсний ассамблейд хамаарах баримт бичгүүдийг нийтлүүлэхэд оролцох; - Үндэсний түүхийн архивтай хамтран парламентын түүхийн сан үүсгэхэд оролцох; ■ Номын сан - Үндэсний ассамблей түүний байгууллагуудын чиг үүргээ биелүүлэхэд шаардлагатай шинжлэх ухаан, эдийн засаг, нийгэм, статистикийн мэдээллээр хангах, тэдгээрийг хадгалах, индексчлэх, каталогжуулах; - Шинэ ном, урсгал мэдээлэл, баримтат мэдээллийн санг баяжуулах; - Номын сангийн мэдээллийн эх үүсвэрийг бүхэлд нь каталогжуулах, индексчлэх ажиллагааг зохион байгуулах; - Олон нийтэд үйлчлэх; - Гар дээр өгөх үйлчилгээ үзүүлэх; - Сургалт явуулах; - Шинэ номын танилцуулгыг тогтмол нийтлүүлэх; - Үйл ажиллагааны дүрмээ боловсруулж, батлуулах; ■ Архив - Үндэсний ассамблейн түүхэн уламжлалыг агуулсан сан бүрдүүлэх; - Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг цуглуулж хадгалах, индексжүүлэх, каталогжуулах; - Соронзон хальсанд буулгасан бичлэгийн мэдээллийг хадгалах, боловсруулах, цуглуулах; - Үндэсний ассамблейн фото зургийн санг бүрдүүлж хадгалах; - Хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг ашиглуулах - Үндэсний болон гадаад улсуудын архивтай хамтран ажиллах;		Тусдаа боловч Ажлын албаны Парламентын “мэдээлэл баримт бичгийн үйлчилгээний Газар”-т харъяалагдана.

Марокко			
Судалгаа, баримт бичгийн хэлтэс нь Архив, бичиг хэрэг, номын сангийн үйлчилгээний алба болон Судалгаа, орчуулгын албатай.			“Судалгаа бичиг баримтын хэлтэс” нь дотроо Архив бичиг баримт Номын сан хамтдаа нэг алба, Судалгаа орчуулгын албатай
Намиби			
Судалгаа, мэдээлэл, нийтлэл, редакцийн хэлтэс Тус хэлтэс нь Үндэсний ассамблейг шинжлэх ухааны арга зүйн үндэслэлтэй судалгаа, мэдээллээр хангана. Хэлтэс нь дараах албадтай байна: <ul style="list-style-type: none"> Судалгааны алба Гишүүдэд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай судалгаа, мэдээллээр үйлчилнэ.		Номын сан, компьютерын үйлчилгээний хэлтэс Тус хэлтэс нь номын сангийн үйлчилгээг Үндэсний ассамблейн гишүүдэд хүргэнэ. Парламентын номын сангийн фондод: <ul style="list-style-type: none"> -Эрх зүй, улс төр судлал, төрийн удирдлага, төрийн бодлого, түүхийн чиглэлийн ном, бусад хэвлэл -Албан ёсны баримт бичиг, акт, мэдэгдэл, тогтоол -Уншлагад зориулсан тогтмол хэвлэл, сэтгүүл, жилийн тайлан, өдөр тумын сонин зэрэг материал байна. Мөн гишүүдийн уншлагын танхимд олшруулах үйлчилгээ үзүүлнэ. Гишүүдийг мэдээлэл хайх онлайн үйлчилгээгээр хангахаас гадна компьютерийн хэрэглээний програм ашиглахад туслана.	тусдаа
Австри			
Мэдээллийн хэлтэс (L3.6) -Үндэсний болон Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгчдөд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; -Парламентын бүлгүүд болон парламентын Тамгын газарт мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; -Тухайн цаг үеийн мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл, судалгаа шинжилгээнд анализ хийх;	Парламентын баримт бичиг, архив, статистикийн хэлтэс (L1.6) -Үндэсний Зөвлөл болон Холбооны Зөвлөлийн стенограф бичлэг болон стенограф бичлэгийн индексийг баримтжуулах, хуулийн төслүүд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг баримтжуулах; -Архив болон статистик мэдээллийг хөтлөх; -“Power point” дээрх илтгэл зэрэг техник мэдээллийг бэлтгэх; -Ардчилал, эрх зүйн салбарын мэдээллийн тойм	Номын сан (L3.5) -Тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээлийн (хэвлэмэл, электрон хэлбэр, CD-ROM болон сүлжээний мэдээллийн зэрэг) сан бүрдүүлэх, контент анализ хийх, түгээх; -Хууль, улс төрийн сэдэвтэй электрон номын сангийн систем бүрдүүлэх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; -Парламентын мэдээллийн солилцоо хийх;	Тусдаа

* * *

Судалгааны эмхтгэл, XII боть

Армян		
Судалгаа, шинжилгээний газар <ul style="list-style-type: none"> Нийгмийн судалгааны хэлтэс Эдийн засгийн судалгааны хэлтэс 	Мэдээллийн газар: <ul style="list-style-type: none"> Архив Номын сан Мэдээлэл хангамжийн хэлтэс <p>Үндэсний хурлын депутатууд, Ажлын албаны ажилтнуудыг мэдээллээр хангана. Мөн шаардлагатай үед судлаачид, эрдмийн зэрэг горилогчид, иргэдэд бусад номын санд байхгүй мэдээлэл, материалаар үйлчилдэг. Хэрэглэгчдэд уншлагын заалаар үйлчлэхээс гадна тэднийг мэдээллийн электрон хэлбэрээр хангана. Номын сангийн фондод 9000 гаруй нэгж төрөл бүрийн ном, зохиол, толь бичиг болон улс төр, хууль эрх зүй, дипломат харилцаа, эдийн засаг, түүх, хүний эрх, олон улсын харилцааны асуудлаар эмхтгэл зэрэг материал янз бүрийн хэл дээр байдаг. Мөн мэдээлэл, лавлагаа, шинжилгээ, судалгааны материал, тогтмол хэвлэлээр байнга үйлчилдэг. фондод байгаа номын каталог, тодорхой сэдвээр тогтмол хэвлэлийн материалын жагсаалт гарган ерөнхий сүлжээгээр хүргэнэ. Номын сан нь хууль эрх зүйн материалын үндэсний номын сангийн үүргийг гүйцэтгэдэг. Үндэсний хурлын номын сан нь хэрэглэгчдэд ерөнхий сүлжээ, олшруулагчаар үйлчилж, сүлжээнд материал хайх, олоход зөвлөгөө өгч, тусалцаа үзүүлнэ.</p>	Архив, Номын сан нь нэгдсэн нэг удирдлагатай, Судалгааны нэгж нь тусдаа

* * *

Босни Герцеговин			
Судалгааны газар <p>Парламентаар хэлэлцэх хуулийн төслийн талаар харьцуулсан судалгаа, товч мэдээлэл, бодлогын судалгаа болон эрх зүй, эдийн засаг, төсөв, хүрээлэн буй байгаль орчны шинжилгээ судалгаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, эдийн засгийн тухайн төлөв байдал эдийн засаг, мөнгөний бодлого, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар мониторинг хийх, хууль хэрэгжсэнээр гарч болох нийгмийн үр дагаварын талаар судлах үүрэгтэй. Түүнчлэн хэрэглэгчдийн хүсэлтээр Европын Холбооны баримт бичгийн эмхтгэл гаргах, хэлэлцэгдэж буй хуулийн төсөл бусад эрх зүйн акттай холбоотой асуудлаар техникийн материал бэлтгэх, удирдлага, хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бусад байгууллагатай хамтран ажиллах, Танхим, байнгын хороодоор хэлэлцэгдэж буй хуулийн төслийн талаарх төрийн ба төрийн бус байгууллагуудын саналыг тандан судлах, шинээр сонгогдсон гишүүдэд зориулан лавлагаа, мэдээлэл бэлтгэх, парламенттай хамтран ажилладаг олон улсын байгууллагуудын талаар мэдээлэл, судалгааны материал бэлтгэх, олон улсын байгууллагуудын захиалгаар парламентын үйл ажиллагаа, Босни-Герцеговиний хууль тогтоомж, улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаар шинжилгээ судалгаа, мэдээлэл бэлтгэх, гадаад улс орнуудын парламентын судалгааны албадтай холбоо тогтоон хамтран ажиллах, журмаар тогтоосон бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.</p>	Баримт бичиг, мэдээллийн хэлтэс <p>парламентын баримт бичгийн фондыг бүрдүүлэх, хөтлөх, тоолох, дахин боловсруулах, тэдгээрийг бичгийн, цахим, хэвлэмэл хэлбэрээр хадгалах, парламентын үйл ажиллагааны талаарх материалыг бэлтгэх, редакторлах, өөрийн мэдээллийн баазыг бүрдүүлж, түүний үндсэн дээр хууль тогтоох үйл ажиллагааны талаар мэдээлэл, статистик болон дүн шинжилгээний эмхтгэл гаргах, харьцуулсан судалгаа, төлөвлөгөөний арга зүйг боловсруулах, баримт бичгийн цахим архив бий болгох, бусад ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллаж засгийн газрын бүх шатны үйл ажиллагааны талаар мэдээлэл, баримт бичиг солилцох болон хуулиар тогтоосон бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.</p>	- Парламентын номын сан <p>Парламентын номын сан нь өнгөрсөн зууны дунд үед байгуулагдсан бөгөөд 1992-1995 оны дайны үед бараг бүхэлдээ устсан байна. Үндсэн хууль баталсаны дараа буюу 2002 онд дахин байгуулагдсан ба одоогоор 3000 нэгж бүрдүүлэлт бүхий фондтой. Үүнд, эрх зүй, улс төр, эдийн засаг, төрийн удирдлага, олон улсын харилцаа европын интеграци, социолог, түүх, газар зүй, болон бусад чиглэлээр ном, тогтмол хэвлэл, аудио, видео бичлэг, цахим мэдээллийн бааз зэрэг хамаарна. Парламентын номын сангаар эрдэмтэн, судлаачид, оюутан сурагчид болон иргэд бичгээр хүсэлт гарган түр хугацаагаар үйлчлүүлдэг байна. Номын сан нь Олон улсын номын сангийн холбооны гишүүн юм.</p> <p>Номын сан нь Танхимуудын чуулган, байнгын хороодын хуралдаан, парламентын ажлын албаны талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх, номын сангийн стандартыг хэрэгжүүлэх зэрэг бусад чиг үүргийг гүйцэтгэнэ.</p>	Баримт бичиг мэдээллийн хэлтэс нь 4 нэгжтэй бөгөөд түүний нэг нь Номын сан байх ба Баримт бичгийн мэдээллийн хэлтэсийн чиг үүрэгт архивын чиг үүрэг багтана. Архив болон Номын сан нь нэг "Газар"-т харьяалагдах бөгөөд Судалгааны нэгж нь тусдаа

ХБНГУ	
<p>Судалгаа, гадаад харилцааны ерөнхий захиргаа</p> <p>Тус захиргаа нь дараах 3 газартай.</p> <ul style="list-style-type: none"> Судалгааны газар Гадаад харилцааны газар Өргөдөл, хүсэлт хариуцсан газар тус тус байна. <p>Судалгааны газрын ерөнхий чиг үүрэг нь парламентын гишүүдийг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулсан мэдээллээр хангах, анализ шинжилгээ хийх, зөвлөмж гаргах юм.</p> <p>Судалгааны секторууд нь:</p> <ul style="list-style-type: none"> -Түүх, орчин үеийн түүх, улс төрийн судалгааны хэсэг -Гадаад харилцаа, ОУ-ын хууль, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил, Батлан хамгаалах, Хүний эрх, Хүмүүнлэгийн тусламжийн судалгааны хэсэг, -Үндсэн хуулийн эрх зүй, Төрийн захиргааны судалгааны хэсэг, -Төсөв, санхүүгийн судалгааны хэсэг, -Эдийн засаг, технологи, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Хүнс, ХАА, Аялал, жуулчлалын судалгааны хэсэг, -Хөдөлмөр, нийгмийн асуудлын судалгааны хэсэг, -Эрүү, иргэн болон иргэн, эрүүгийн байцаан шийтгэх хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Тээвэр, барилга, хот байгуулалтын хуулийн судалгааны төв, -Байгаль орчны хамгаалалт, цөмийн аюулгүй байдал, Боловсрол, шинжлэх ухааны судалгааны хэсэг, -Эрүүл мэнд, гэр бүл, өндөр настан, эмэгтэйчүүд, залуучуудын судалгааны хэсэг, -Соёл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, спортын судалгааны баг, -Европын асуудлын судалгааны хэсэг тус тус байна. 	<p>Мэдээлэл, баримт бичиг хариуцсан ерөнхий захиргаа</p> <p>Тус захиргаа нь дараах 3-н газартай.</p> <ul style="list-style-type: none"> Номын сан, баримт бичгийн газар Мэдээлэл, олон нийттэй харилцах газар Мэдээллийн технологийн газар тус тус байна <p>Номын сан, баримт бичгийн газрын гол чиг үүрэг нь Парламентын баримт бичгийн мэдээллийн систем / the Parliamentary Material Information System (DIP)-ийн үйлчилгээ байна. Энэхүү систем нь Бундестаг болон Бундестратын баримт бичгийг хайхад тусална. Баримт бичгүүдийг нэр болон төрлөөр нь индексжүүлсэн байдаг. Одоогоор 2 төрлийн систем үйлчилж байгаа.</p> <ol style="list-style-type: none"> 8-15 дахь ээлжит сонгууль (1976–2005 он) 16 дугаар ээлжит сонгуулийн дараах үе (2005 оноос хойш) <p>Үүнд хэлэлцүүлэг болон бусад хуралдааны бичлэг, хуулийн төслүүд, асуулт, тайлан, гишүүдийн үйл ажиллагааны тайлан зэрэг мэдээллийг багтаасан байдаг. Хайлтын үр дүнд тухайн мэдээлэл бүрэн хэмжээгээр, нэгдсэн чуулганы бичлэг цаг, минутаараа гарч ирдэг. Бундестагийн гишүүн бүрийн нэгдсэн чуулганд хэлсэн үгийг бичиж, олон нийтэд хүргэхээс өмнө хянах журмын дагуу тус газар хянах үүргийг хэрэгжүүлнэ. Хянасны дараа түүнийг PDF файл болгон онлайн системд оруулна. Тус газар нь дараах бүтэцтэй.</p> <ul style="list-style-type: none"> - Номын сан - Парламентын архив - Парламентын баримт бичиг - Хэвлэлийн баримт бичиг <p>Бундестагийн номын сан нь үндсэндээ парламентад үйлчилдэг. Зохион байгуулалтын хувьд номын санг дараах 4 хэсэгт хуваана.</p> <ul style="list-style-type: none"> - Цуглуулгын хэсэг -1 - Цуглуулгын хэсэг -2 - Индексжүүлэлт, баримт бичгийн хэсэг - Лавлагааны хэсэг <p>Цуглуулгын 1-р хэсэг нь номыг нийлүүлэх болон бусад газруудтай солилцох ажлыг зохион байгуулдаг бол, цуглуулгын 2-р хэсэг нь номын сангийн худалдаж авсан ном, хандивийн номын асуудлыг хариуцдаг. Индексжүүлэлт, баримт бичгийн хэсэг нь материалуудыг индексжүүлж, цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаан, олон нийтэд хүргэхэд бэлтгэнэ. Сүүлийн үед бүх материалуудыг электрон хэлбэрт оруулж интернетийн каталогийг хөгжүүлсэн. Лавлагааны хэсэг нь тухайн материалын талаарх мэдээллийг хэрэглэгчид гаргаж өгөх, хайх, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх үүрэгтэй.</p> <p>Бундестагийн номын сан нь дээрх 4 хэсэгтээ нийт 86 ажилтантай. Үүнээс бүх шатны боловсролтой 77 мэргэжлийн номын санч, ном засвар, техник ажиллагааны 9-н ажилтан тус тус ажиллана.</p> <p>Архив нь Бундестаг болон Бундесратаар хэлэлцэгдсэн, батлагдсан хууль нэг бүрийн мэдээллийг үе шат бүрээр нь архивлана. Түүнчлэн индексжүүлсэн, ангилсан бусад материалыг хадгалж, лавлагааны материалыг хэвлүүлж гишүүдэд хүргэх үүрэгтэй.</p> <p>Хэвлэлийн баримт бичгийн хэсэг нь Бундестагийн Kohlmeier студиэс эрхлэн гаргасан бүх сонинг индексжүүлж, архивладаг. Гол чиг үүрэг нь Бундестагтай холбоотой мэдээллийг цуглуулах, шаардлагатай мэдээлэлд хариу өгөхөд чиглэнэ. Хэдийгээр Парламентын архивыг зөвхөн дотооддоо ашигладаг ч Хэвлэлийн баримт бичгийн хэсэг нь илүү хязгаарлагдмал хүрээнд, тодорхой захиалгын дагуу материалаа гаргадаг.</p>

Гүрж		
Судалгааны газар <ul style="list-style-type: none"> Архив Хууль тогтоох үйл ажиллагааны мэдээлэл, хангамжийн хэлтэс Номын сан 		Гурван нэгж “Судалгааны газар” гэсэн нэг нэгжид харъяалагдана.
Их Британи		
Парламентын шинжлэх ухаан, технологийн офис Шинжлэх ухаан, технологийн бодлогын асуудлаар бие даасан, бусдаас хамааралгүй, хүртээмжтэй анализ хийх үүрэгтэй парламентын дотоод эх сурвалж болох байгууллага юм.	Парламентын архив Лордуудын танхим болон Нийтийн танхимын архивын материалтай холбоотой асуултад хариулах, баримт бичиг ашиглах нөхцөл бүрдүүлэх үүрэгтэй.	
Молдов		
Мэдээлэл-судалгааны алба -Парламент судлал, шинжилгээний хэлтэс -Мэдээллийн нөөцийн хэлтэс		
Монтенегро		
Судалгаа, баримт бичиг, мэдээллийн технологийн сектор <i>Инь дараах 4 салбар нэгжтэй байна/ Үүнд:</i> <ul style="list-style-type: none"> Судалгаа шинжилгээ, бичиг баримт, номын сан, архивын салбар Мэдээллийн технологийн салбар Парламентын чуулганы телевиз-радио нэвтрүүлэг, бичлэгийн салбар Аудио болон бичмэл протоколын салбар. Судалгаа шинжилгээ, номын сан, бичиг баримт, архивын салбар нь гишүүд, Байнгын хороод болон ажлын албаны ажилд шаардлагатай судалгаа, шинжилгээ (товч тайлан, олон улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ)-ний ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Түүнчлэн Парламентын ажлын албаны зохион байгуулалт, системчлэлийн дүрэмд зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Секторын судалгааны ажилд шаардлагатай номын сангууд, их, дээд сургуулиуд, төрийн болон бусад институтууд, дотоодын болон олон улсын институтуудтай нягт хамтран ажиллах; Парламентын гишүүд, мэргэшсэн албаны ажилтан, алба хаагчид болон бусад хараат бус судалгаа ашиглагчдад электрон мэдээллийн эх сурвалжид агуулагдаж буй мэдээлэл болон хайлтын стратегийг ашиглахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, дадлаажуулах; Монтэнegro Улсын парламентын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн талаар Парламентын Судалгаа баримт бичгийн Европын төв /European Centre for Parliamentary Research and Documentation/-ийн сүлжээний олон улсын байгууллагууд, үндэсний парламентууд болон институтуудаас гаргасан мэдээлэл, экспертний дүн шинжилгээг боловсруулах, танилцуулах; Номын сангийн тусгай цуглуулга болон мэдээллийн түүврийг танилцуулах, номын сангийн материалууд болон парламентын дотоод баримт бичгийг эзэмших, хадгалах, боловсруулах; Харилцаа холбоо бүхий гадаадын институтуудтай парламентын баримт бичгийг солилцох, мэдээллийн электрон эх сурвалжийг ашиглах; Баримтат болон бичгээр үйлдсэн материалуудыг ашиглахад зориулан цуглуулах, хадгалах, төрөлжүүлэх, боловсруулах болон бэлтгэх; Парламентын материалыг архивлахтай холбоотой үйл ажиллагааг хариуцах, Ерөнхий нарийн бичгийн дарга болон түүний орлогчийн даалгасан бусад үйл ажиллагааг гүйцэтгэнэ. 		Судалгаа, номын сан, архивын нэгж нь нэг салбарт харъяалагдах буюу нэгдсэн нэг зохион байгуулалттай

* * *

ОХУ	<p>Судалгааны газар нь хуулийн зохицуулалт шаардагдаж буй нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлаар болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар мэдээлэл, судалгааны материал бэлтгэж депутатуудад хүргэх чиг үүрэгтэй. Судалгааны газраас жил бүр “Мэдээлэл-судалгааны эмхтгэл” 10 дугаар, “Судалгааны мэдээлэл” сэтгүүл 20 гаруйг хэвлүүлж гаргахаас гадна депутатууд, тэдний туслахууд, Думын Тамгын газрын ажилтнууд, бусад байгууллагын захиалгаар 9 мянга гаруй лавлагаа, мэдээлэл бэлтгэдэг. Тус газрын үйл ажиллагааны нэг чухал чиглэл нь Думаар хэлэлцэж байгаа хуулийн төслийн талаар мэдээлэл, судалгаа бэлтгэх бөгөөд нэг жилд 100-аас доошгүй материал бэлтгэдэг. Судалгааны газрын мэдээллийн сан нь ОХУ-ын хэмжээнд хамгийн томд тооцогдох мэдээллийн сангуудын нэг бөгөөд Төрийн Дум төдийгүй тус улсын төрийн бусад байгууллагыг мэдээллээр хангадаг. Тус газрын ажилтнууд нь Төрийн Думаас зохион байгуулдаг парламентын сонсгол, нээлттэй хэлэлцүүлэг, онол-практикийн болон олон улсын бага хурал бусад арга хэмжээг зохион байгуулахад оролцдог. Мөн улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахад оролцох, хууль тогтоомжийн хөгжлийн чиг хандлага, хууль тогтоох үйл явцын тулгамдсан асуудлаар шинжилгээ, прогноз хийх зэрэг чиг үүрэгтэй.</p>	<p>Баримт бичгийн газар нь албан хэрэг хөтөлтийг зохион байгуулах, нэгдсэн болон Хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, соронзон хальсанд бичих, хэвлэн гаргах, хуралдааны тэмдэглэлийг дотоод сүлжээнд байрлуулах, албан бичиг, иргэдийн санал, өргөдөл, гомдлыг бүртгэн авч, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих чиг үүрэгтэй.</p>	<p>Номын фондын газар (Парламентын номын сан) Тус газар нь дараах хэлтсүүдтэй: -<i>Номын фондыг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах хэлтэс</i> -<i>Төрийн баримт бичгийн жагсаалт, мэдээллийн сангийн бүртгэл хөтлөлтийн хэлтэс</i> -<i>Номын сан, мэдээллийн үйлчилгээний хэлтэс</i> -<i>Цахим хэвлэлийн хэлтэс</i> Номын фондыг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах хэлтэс нь номын фондын баяжилт хийх, хадгалах, индексжүүлэх, тогтмол хэвлэл захиалах, нөөц болон албан хэрэгцээний номын фонд үүсгэх үүрэгтэй. Төрийн баримт бичгийн жагсаалт, мэдээллийн сангийн бүртгэл хөтлөлтийн хэлтэс нь түргэн бичлэгийн тайланг индексжүүлэх, төрийн ном зүй, баримт бичгийн бүртгэл хөтлөх, сонин, хэвлэлүүд дээр гарч буй нийтлэлүүдийг төрөлжүүлж хадгалах, хэвлэлд нийтлэгдээгүй судалгааны материалуудыг эмхтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Номын сан, мэдээллийн үйлчилгээний хэлтэс нь номын сан хоорондын захиалга, солилцоог хэрэгжүүлэх, тулгуур бичиг, эх сурвалжийг үйлчлүүлэгчдэд гаргаж өгөх, ном, хэвлэл, лавлагаагаар үйлчлэх үүрэгтэй. Цахим хэвлэлийн хэлтэс нь цахим хэвлэлийн хувилбар бэлтгэх, өөрийн цахим сан, Оросын номын сан-мэдээллийн Консорциумын цахим хуудас болон дотоод сүлжээнээс үйлчлүүлэгчдэд мэдээлэл олж өгөх, номын сангийн мэдээлэл, технологийн хангамж, үйлчилгээг хариуцах зэрэг үүрэгтэй. Төрийн Думын Номын сан нь анх 1906 онд Оросын анхны Төрийн Думын хуралдаанаас санаачилснаар үүссэн түүхтэй. Харин одоогийн Парламентын номын сан 1991 онд хэд хэдэн номын сангийн бааз суурин дээр үүсчээ. Тус номын сан нь Төрийн Думын депутатууд, Холбооны хурлын гишүүд, тэдгээрийн туслахууд, аппаратын ажилтнуудад номын сангийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэгтэй.</p>	<p>Тус тусад нь зохион байгуулсан</p>
-----	--	---	--	---------------------------------------

Румын	
<p>Парламент, хуулийн судалгааны газар нь дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Депутатын танхимын үйл ажиллагааны зорилго, чиг үүрэг, хөтөлбөр, арга хэмжээ, ялангуяа Европын Холбооны хэмжээнд шийдвэр гаргахад оролцсон оролцоотой холбоотой баримтат материалыг бэлтгэх - Депутатын танхимын улс төр, стратеги, шуурхай үйл ажиллагаанд мониторинг хийж, Танхимын холбогдох албадад мэдээлэх - Дотоодын болон олон улсын, европын парламентын талаар шинжилгээ, судалгаа хийх - Парламентын байгууллагуудад баримт бичгийг хүргэх, тэдгээрт шаардлагатай зөвлөгөөг өгөх - Үндэсний болон олон улсын хүрээнд ижил төрлийн байгууллагуудтай харилцаа тогтоож, мэдээлэл, арга туршлагаа солилцох зэрэг болно. <p>Энэ алба нь дараах хэлтэстэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> o Эрх зүйн судалгаа, баримт бичгийн хэлтэс o Нийтийн эрх зүйн хэлтэстэй байна. <p>Парламент, хуулийн судалгааны газрын <i>Эрх зүйн судалгаа, баримт бичгийн хэлтэс</i> нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ <i>Парламентын шинжилгээ, судалгааны хэсэг</i> ▪ <i>Баримт бичиг, хуулийн мэдээллийн хэсэг</i> ▪ <i>Номын сан</i> <p><i>Эрх зүйн судалгаа, баримт бичгийн хэлтэс</i> нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Депутатын танхимын Товчоо, намуудын бүлэг, байнгын хороодын дарга нарын захиалгын дагуу судалгаа хийх, харьцуулсан эрх зүйн судалгаа, материал бэлтгэх, - Өөрийн санаачлагаар Танхимын хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлаар судалгаа хийх, мэдээллийн хуудас, бусад материалыг боловсруулах - Олон улсын анхаарал татсан асуудлаар судалгаа хийж материал бэлтгэх - Захиалгын дагуу парламентын тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх - Румыны парламентын төлөөлөгчдийн албан ёсны гадаад айлчлалын талаар захиалгаар баримтат кино хийх - Гадаадын парламентын судалгаа, шинжилгээний байгууллага, Парламентын судалгааны Европын төв, бусад мэргэжлийн байгууллага, номын сантай хамтран ажиллах, харилцан баримт, мэдээлэл солилцох - Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн бусад байгууллага, хэлтсээс тодорхой мэдээлэл, эрх зүйн судалгаа, лавалгааны материал гаргуулах - Цахим мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл олж, ашиглах - Мэдээллийн сан бий болгох зорилгоор шаардлагатай судалгаа, мэдээллийг дотоод сүлжээнд байршуулах - Парламентын номын сангийн байнгын ажиллагааг хангах, бусад гадаад, дотоодын номын сантай мэдээлэл, баримт солилцох - Танхимын ажлын албадын шаардлагатай, цаг үеийн баримт бичгийн хэрэгцээг хангах зэрэг болно. 	<p>Техникийн нарийн бичгийн даргын газарт Архивын нэгж нь харъяалагдана. Харин судалгаа болон номын сангийн нэгж нь цугтаа байна.</p>
Серби	
<p>Мэдээлэл, судалгаа, номын сангийн хэлтэс нь “<i>Үндэсний ассамблейн дэмжлэг үйлчилгээний байгууллагын тухай шийдвэр</i>”-т зааснаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаатай холбогдуулан мэргэжлийн болон шинжээчийн судалгаа, мэдээллээр хангах; - Үндэсний ассамблейн хуралдаанаар хэлэлцэгдэж буй асуудлаар парламентын гишүүд болон байнгын хороодод мэргэжлийн харьцуулсан судалгааны үйлчилгээ үзүүлнэ. <p>Мэдээлэл судалгаа, номын сангийн хэлтэс нь дараах 2 албатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Мэдээлэл судалгааны алба</i> - <i>Номын сан</i> 	<p>Мэдээлэл судалгааны алба, Номын сан хамтдаа, Архивын нэгжийн талаар мэдээлэлгүй байна.</p>

Словени			
<p>Судалгааны алба Тус хэлтэс нь Үндсэн хууль, Үндэсний ассамблейн үйл ажиллагааны дэг болон холбогдох хууль, журмын дагуу төвийг сахисан мэдээ мэдээлэл боловсруулж, мэдээллийн сан бүрдүүлэх, Үндэсний ассамблей хууль тогтоох үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай судалгаа, мэдээллээр хангана. Ингэснээр Үндэсний ассамблейн хэвийн үйл ажиллагаа, ил тод, нээлттэй байдал, ажлын бүтээмж зэрэгт дэмжлэг туслалцаа үзүүлнэ.Судалгааны алба нь парламентаар хэлэлцэгдэж буй асуудлаар Үндэсний ассамблей болон ассамблейн Зөвлөл, Байнгын хороод, ажлын хэсгүүдэд шаардлагатай судалгаа, экспертний шинжилгээ хийх, хууль зүйн асуудал, Дэгийн хуулийн зохицуулалтууд, гишүүдийн статус, парламентын үйл ажиллагааны талаар харьцуулсан дүгнэлт, судалгаа хийнэ. Судалгааны газар нь Үндэсний ассамблейн үйл ажиллагааны талаар тогтмол тайлан гаргана.</p> <p>Номын сан, баримт бичгийн алба нь дотоод хэрэглэгчдэд (Үндэсний ассамблейн тэргүүлэх албан тушаалтнууд, гишүүд, гишүүдийн бүлэг зэрэг) хууль тогтоох болон бусад үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн номын сан, мэдээллийн төв хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Гадны хэрэглэгчдийг хууль тогтоох үйл явц болон Үндэсний ассамблейн бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангаж ажиллана. Түүнээс гадна Номын сан, баримт бичгийн алба нь Үндэсний ассамблейн хуралдааны тэмдэглэл, албан ёсны захидал харилцааг хэлзүйн үүднээс хянах, засах болон хэлзүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий нэгж юм.</p>		<p>Судалгааны алба Номын сан хамтдаа байх бөгөөд Архивын нэгж нь мэдээллийн хэлтэст харъяалагдан байдаг</p>	
Украин			
<p>Эрдэм шинжилгээ-судалгааны газар нь Төрийн байгуулалтын, Үндсэн хуулийн, Олон улс, хүний эрх, Европын Холбооны, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, Иргэний болон аж ахуйн харилцаа, жижиг үйлдвэрийн, Хөдөө аж ахуй, байгаль, экологийн, Төсөв, татварын, Макро эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн хэлтсүүдтэй. Энэ газар нь хуулийн зохицуулалт шаардагдаж байгаа нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлаар болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар мэдээлэл, судалгааны материал бэлтгэж депутатуудад хүргэх үндсэн чиг үүрэгтэй.</p> <p>Тус газрын ажилтнууд онол-практикийн болон эрдэм шинжилгээний бага хурал, бусад арга хэмжээг зохион байгуулах, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахад оролцох, хуулийн төслийн талаар мэдээлэл, судалгаа бэлтгэх, улс орны хөгжлийн чиг хандлага, хууль тогтоох үйл явцын тулгамдсан асуудлаар шинжилгээ, судалгаа хийх зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэнэ.</p>	<p>Албан хэрэг, баримт бичгийн газар нь Бичиг хэргийн газар болон Хуралдааны тэмдэглэл хөтлөх, Албан хэрэг хөтлөх, зохион байгуулах, Албан захидал харилцааны, Баримт бичгийн техник ажиллагааны, Техник зохион байгуулалтын, Буулган бичлэгийн (стенографирования), Редакцын гэсэн хэлтэсүүдтэй.</p> <p>Тус газар нь албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, нэгдсэн болон хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, соронзон хальсанд болон буулган бичих, хэвлэх, хуралдааны тэмдэглэлд редакц хийх, албан бичгийг бүртгэн авч, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих чиг үүрэгтэй.</p>	<p>Мэдээллийн газар нь Төлөвлөлт, дүн шижилгээний хэлтэс, Парламентын үйл ажиллагааг сурталчлан таниулах хэлтэс, Үнэлгээний хэлтэс, Мэдээлэл-номын сангийн үйлчилгээний хэлтэстэй ба парламентын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үндсэн чиг үүрэгтэй. Энэ газар нь Дээд Радагийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж сурталчлах, нээлттэй хэлэлцүүлэг зохиох, олон нийтийн саналыг хуулийн төсөлд тусгах ажлыг зохион байгуулах, иргэдийг Дээд Радагийн үйл ажиллагаа, парламентын ордонтой танилцуулах, парламентын үйл ажиллагааны тухай танилцуулга, сурталчилгааны бусад материал бэлтгэж хэвлүүлэх, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.</p>	<p>Тус тусдаа удирдлага зохион байгуулалттай буюу Номын сан нь “Мэдээллийн газар”-таа харъяалагдана.</p>

* * *

Финлянд			
<p>Судалгааны алба / <i>Research Service</i> / нь парламентаар хэлэлцэгдэж буй асуудал болон гишүүдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах болон хэвлэлийн материал зэргийг бэлтгэх үүрэгтэй. Мөн Европын холбооны тухай мэдээлэл, телевизэд зориулсан видео үйлчилгээ, онлайн үйлчилгээгээр хангах зэрэг чиг үүрэгтэй.</p>		<p>Парламентын номын сан /<i>Library of Parliament</i>/ нь парламентын гишүүд, туслахууд, парламентын ажилтнууд, сурагч, судлаач, иргэдэд үйлчилдэг олон нийтийн номын сан юм. Үүний зэрэгцээ парламентын төв архивын үйл ажиллагааг эрхэлнэ. Түүнчлэн парламентаас гаргасан шийдвэрүүдийн талаарх мэдээлэл, парламентын баримт бичгүүдээр үйлчилнэ. Мөн онлайн үйлчилгээг үзүүлдэг.</p>	<p>Номын сан болон судалгааны алба нь тусдаа бие даасан алба боловч ажлын албаны Ерөнхий Нарийн бичгийн даргад шууд захирагдах "Мэдээлэл, холбооны газар"-т харъяалагдана. Харин Архив нь Төв албандаа харъяалагдана.</p>
Швед			
<p>Судалгааны алба</p> <p>Судалгааны алба нь парламентын гишүүд, намын бүлгүүдийн нарийн бичгийн даргын газар, хороод болон парламентын бусад албадад зориулан судалгаа, мэдээллийн ажил гүйцэтгэнэ. Судлаачдын бэлтгэсэн мэдээлэл нь бодитой, улс төрийн хувьд аль нэг талыг бариагүй, контекстдээ багтсан байх ёстой.</p> <p>Судалгааны алба нь хороодтой хамтран парламентын гаргасан шийдвэрийн дагуух цаашдын үйл ажиллагааг явуулах, үнэлэхэд туслана.</p>	<p>Баримт бичгийн алба нь парламентын гишүүдэд шаардлагатай баримт бичгээр хангах, Холбооны Хурлаас шийдвэр гаргахад хэрэгцээтэй бүх мэдээллээр хангана.</p> <p>Тус алба нь албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, парламентын гишүүдийг лавлагаа мэдээлэл, судалгаагаар хангах үүрэгтэй. Мөн парламентын номын сан энэ албанд харъяалагдана.</p>	<p>Харилцаа холбооны газар</p> <p>Харилцаа холбооны газар нь парламентын мэдээллийг хүртээмжтэй, нээлттэй болгох, парламент, түүний үйл ажиллагааны тухай материал бэлтгэх үүрэгтэй. Дараах департментуудтай:</p> <ul style="list-style-type: none"> -Мэдээллийн департмент -Риксдагийн номын сан -Европын холбооны мэдээллийн төв -“Риксдаг ба яамдын мэдээлэл” сэтгүүл -Парламентын баримт бичгийн департмент. <p>Харилцаа холбооны газрын департментууд нь олон нийт, хэвлэл мэдээлэл, хувийн сектор болон байгууллагуудын хэрэгцээнд зориулсан мэдээллийн үйлчилгээ явуулна. Мөн парламентын гишүүд, ажилтнуудын хэрэгцээнд лавлагаа материал, орон нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээний үйл явдлын мониторинг хийнэ.</p>	<p>Тус тусдаа удирдлагатай зохион байгуулжээ</p>

УН.МН
СУДАЛГААНЫ САН

Швейцар			
	<p>Баримт бичгийн алба нь парламентын гишүүдэд шаардлагатай баримт бичгээр хангах, Холбооны Хурлаас шийдвэр гаргахад хэрэгцээтэй бүх мэдээллээр хангана.</p> <p>Тус алба нь албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, хороодын хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, уншиж нийлэх, архивт шилжүүлэх, парламентын гишүүдийг лавлагаа мэдээлэл, судалгаагаар хангах үүрэгтэй. Мөн парламентын номын сан энэ албанд харъяалагдана.</p> <p>Номын сан нь парламентын гишүүд болон тэдний туслахууд, Засгийн газар, парламентын Тамгын газарт үйлчилдэг.</p> <p>Номын сан нь парламент болон Засгийн газар, бусад байгууллагуудаас хэвлэн гаргасан болон ховор ном бүтээл, баримт бичгийн цуглуулгатай. Тэдгээрийг номын сангийн каталоогоос (pdf хэлбэрээр) авч болно. Парламентын номын сан 450 орчим тогтмол хэвлэл захиалдаг бөгөөд нийтлэгдсэн зарим материалыг сонгон авч номын сангийн каталогт оруулдаг. Үйлчлүүлэгчид төрөл бүрийн электрон хэвлэл болон өгөгдлийн санд чөлөөтэй нэвтэрч болно. Номын сангийн каталогт интернэтээр нэвтэрч болох бөгөөд жагсаалтыг сэдвээр нь ангилж байнга шинэчилдэг. Мөн аудио, видео материалуудыг интернэтээр болон номын санд хувиан авч болно. Номын сангийн уншлагын танхимд олшруулах болон скайнерын үйлчилгээ үзүүлнэ.</p>	Номын сан болон Архивын чиг үүрэг хэрэгжүүлэгч нэгж хамтдаа нэгдсэн удирдлагатай байна.	
Эстони			
<p>Эрх зүй, судалгааны хэлтэс нь бие даасан судалгаа, шинжилгээний байгууллага бөгөөд Рийгикогу, түүний Тамгын газрын хэлтэс, албадад эрх зүй, парламентын хяналт, нийгэм, эдийн засгийн салбарууд болон Европын Холбоны асуудлаар зөвлөгөө өгөх, харьцуулсан судалгаа, шинжилгээ хийх, лавлагаа мэдээлэл өгөх, хууль, тогтоолын төсөлд дүн шинжилгээ хийж зөвлөмж, дүгнэлт гаргах, шинжилгээ судалгааны ажил захиалах, гадаад орнуудын парламентын судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэгтэй.</p>			Парламентын ажлын албаны бүтэц дотор Номын сан болон Архивын нэгж байхгүй
Самоа			
<p>Номын сан</p> <p>Гишүүдийг судалгааны материал болон мэдээллээр хангахаас гадна Хууль тогтоох Ассамблейн үйл ажиллагааны бүх бичлэгийг хадгална. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Хууль тогтоомжийн төслүүдийн хэлэлцсэн хуулбарууд, парламентын актууд, парламентын хэлэлцүүлгийн бичлэг, сонгогчдын нэгдсэн болон санал өгсөн тухай бүртгэл, Үндсэн хуулийн Конвенцийн хэлэлцүүлгийн бичлэгийг тус тус бүрдүүлж Самоагийн Үндэсний Ассамблейн архивт хадгалах -Гадаад улс орнуудын улс төр, засгийн газар, эрх зүй, эдийн засгийн талаарх лавлагааны материалууд -Тогтмол хэвлэл, сэтгүүлүүд болон гол төлөв Хамтын нөхөрлөлийн орнууд, Хамтын нөхөрлөлийн орнуудын нарийн бичгийн дарга нарын газар, Парламентын Ассоциаци, Ази, Номхон далайн орнуудын Парламентын холбоо, Олон улсын Парламентын холбооны хэвлэлүүд Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхим болон Австралийн парламентын бичлэгүүд 		судалгааны нэгж болон архивын талаар мэдээллгүй байна.	

* * *

Судалгааны эмхтгэл, XII боть

Вьетнам	
<p>Вьетнамын хуулийн судалгааны институт-дотроо судалгааны болон мэдээллийн төв, ерөнхий үйл ажиллагааны зохицуулах газар гэсэн бүтэцтэй, Институт нь дараах үндсэн чиг үүрэгтэй.</p> <p>- <i>Судалгааны чиг үүрэг</i></p> <p>Үндэсний ассамблейн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, өөрчлөх зэрэг асуудлаар онолын болон практик судалгаа хийх</p> <p>Үндэсний ассамблейн бүтцийн нэгжүүд болон гишүүдээс ирүүлсэн захиалгын дагуу ассамблейн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлуудаар судалгаа хийх</p> <p>- <i>Мэдээллийн чиг үүрэг</i></p> <p>Үндэсний ассамблейн бүтцийн нэгжүүд болон гишүүдэд шаардагдах мэдээллийг бэлтгэх, зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд холбогдох мэдээллийн бааз бүрдүүлэх</p> <p>Үндэсний ассамблей, түүний бүтцийн нэгжүүд, гишүүдэд шаардлагатай судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэж харьцуулах, хүргүүлэх ажиллагааг зохион байгуулах</p> <p>Үндэсний ассамблейд зориулан гадаад, дотоодын судалгааны байгууллагуудын гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг захиалж авах, цуглуулах, ангилах, хүргүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>- <i>Бусад чиг үүрэг</i></p> <p>Үндэсний ассамблейн зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралтай судалгааны чиглэлээр гадаад, дотоодын судалгааны хүрээлэн, агентлагуудтай хамтран ажиллах</p> <p>Эрдэмтэн судлаачид, шинжээчид, салбарын мэргэжилтнүүдийг судалгаа, мэдээллийн үйл ажиллагаанд татан оролцуулах</p> <p>Үндэсний ассамблейн бүтцийн байгууллагууд, Байнгын хорооны нэгжүүд, Үндэсний ассамблейн Ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах судалгааны төлөвлөлт, менежментийг хариуцах</p> <p>Байнгын хорооноос өгсөн удирдамж чиглэлийн дагуу бусад үүргийг хэрэгжүүлэх зэрэг болно.</p>	<p>Номын сан болон архивын талаар мэдээлэлгүй байна.</p>

* * *

Саудын араб			
Судалгаа мэдээллийн ерөнхий хэлтэс		Архивын ажлыг Захиргааны харилцаа холбооны хэлтэс хариуцна	Судалгааны хэлтэс, архив нь тусдаа удирдлагатай. Номын сангийн талаар мэдээлэлгүй байна
Солонгос			
<p>Үндэсний Ассамблейн судалгааны алба- Парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор хууль тогтоох болон бодлогын үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох мэдээлэл хайх, боловсруулах үүрэгтэй. Судалгааны алба нь гишүүд, хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа, шинжилгээ хийнэ</p>	<p>Үндэсний Ассамблейн номын сан-ном, хэвлэл, байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны эх сурвалжуудыг цуглуулах, парламентын хууль тогтоох болон хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай тоо баримтуудыг гаргах, задлан шинжлэх, эмхтгэх, цуглуулах ажлыг гүйцэтгэхээс гадна эдгээр эх сурвалжыг олон нийтэд хүртээмжтэй байлгах үүрэгтэй.</p>	<p>Үндэсний Ассамблейн архив нь Үндэсний хурлын номын сандаа харяалагдана.</p>	<p>Номын сан, архив нь нэгдсэн нэг удирдлагатай, Судалгааны алба нь тусдаа</p>

* * *

Турк					
<p>Судалгааны төв болон Номын сан, баримт бичиг, орчуулгын хэлтэс нь Хууль тогтоомжийн газарт харяалагдана.</p> <p>Тус төвд эдийн засаг, олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухаан, төрийн захиргаа зэрэг мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүд ажиллана.</p> <p>Судалгааны тасгийн ажилтнууд гишүүдээс ирүүлсэн захиалгын дагуу судалгаа хийж хариуг амаар болон бичгээр өгч болно.</p> <p>Судалгааны тасгаас хийсэн судалгааны ажил, тайлангаар улирал тутам “Bilgi” сэтгүүл, ном зэргийг хэвлэн гаргана.</p> <p>-Номын сан, баримт бичгийн төвийн зорилго нь парламентын гишүүдэд хууль тогтоох, төлөөлөх зэрэг Үндсэн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээ, материалаар хангах явдал юм.</p> <p>Энэхүү төв нь номын санч, баримт бичгийн ажилтан, судлаач зэрэг 60 гаруй ажилтантай.</p> <ul style="list-style-type: none">Номын сангийн үйлчилгээ <p>Номын сангийн үйлчилгээний тасаг нь хэрэглэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хурдан шуурхай үйлчилнэ. Уншлагын үйлчилгээний тасаг нь гар дээр ном олгох, хувилахаас гадна номын сангийн мэргэжилтнүүд нь гишүүдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл бэлтгэх зэрэг үйлчилгээг тус тус үзүүлнэ.</p>		<p>Архив, бичиг хэргийн хэлтэс нь Олон нийттэй харилцах газарт</p>		Номын сан Судалгааны нэгж нь нэгдсэн нэг удирдлагатай архив нь тусдаа	
Энэтхэг					
<p>Парламентын Номын сан, судалгаа, лавлагаа, мэдээлэл, баримтжуулах болон мэдээлэх үйлчилгээ-Энэ үйлчилгээ нь 5 хэлтэст хуваагдана. Үүнд: <i>номын сан, судалгаа, лавлагаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, парламентийн музей.</i></p> <p>Бүх салбар чиглэлээр судалгаа, лавлагаа, мэдээлэл бэлтгэх, тэдгээрийг эмхтгэхээс гадна Тамгын газраас эрхлэн гаргадаг тогтмол хэвлэмэл материалыг бэлтгэн гаргах ажлыг хариуцна.</p> <p>Энэ үйлчилгээ нь парламентын гишүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, Энэтхэг болон гадаад орнуудын хөгжлийн талаарх өдөр тутмын мэдээлэл, номын сангийн эх сурвалжаас бэлтгэгдсэн сүүлийн үеийн, бодит мэдээ мэдээлэл, судалгаагаар хангахад чиглэнэ. Парламентын гишүүдэд чуулганаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, Танхимын өмнө тулгамдсан асуудлаар гарын авлага болохуйц судалгаа, лавлагааны материал бэлдэх, мөн Энэтхэгийн Парламентын холбооны их, бага хурлын төлөөлөгчдөд зориулан судалгаа, зөвлөмж, мэдээлэл, тоо баримтыг бэлтгэнэ. Мөн парламентат ёсны талаар ном болон бусад хэвлэлийн материалд гарсан сонирхолтой товчлол, тэмдэглэл, гадаад улс орнуудын талаарх цаг үеийн мэдээллээр хангана.</p>				Номын сан Судалгааны нэгж нь нэгдсэн нэг удирдлагатай. Архивын талаар мэдээлэлгүй байна.	
Япон					
<p>Парламентын судалгааны байгууллага болох Номын сангийн судалгаа, хуулийн лавлагааны товчоо нь нийт 190 орчим ажилтантай</p>		<p>Үндэсний хурлын номын сан нь парламентын гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд, олон нийтэд номын сангийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Үндэсний хурлын номын сан нь 900 ажилтантай.</p>		Тусдаа Архивын талаар мэдээлэлгүй байна.	

АНУ	
<p>Конгрессийн судалгааны алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах дэлхийн хамгийн том судалгааны төв юм. Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод мэдээлэл, судалгааны үйлчилгээ үзүүлнэ. Шинжээчид нь хуулийн төслийг Байнгын хороодоор хэлэлцүүлэхээс хууль батлагдах хүртэлх бүх шатанд мэдээлэл, судалгааг бэлтгэхдээ цаг үеийн, бодитой, нам бус, төвийг сахисан, нууцыг хадгалах зарчмаар ажиллана.</p> <p>Конгрессийн судалгааны алба нь гүйцэтгэх засаглалын байгууллага болон олон нийтийн судалгааны хэрэгцээг хангах үүрэг хүлээдэггүй.</p> <p>Конгрессийн судалгааны алба нь нийт 700 гаруй ажилтантайгаас 450 гаруй нь бодлогын шинжээч, хуульч, мэдээллийн мэргэжилтэн, эдийн засагч, гадаад хэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, цагаачлал, эрчим хүч, байгаль орчин болон шинжлэх ухаан, технологийн чиглэлээр мэргэшсэн судлаач, шинжээчид байна.</p> <p>Судалгааны албанаас тайлан, мэдээлэл, семинар, илтгэл, биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх үе шатанд үзүүлдэг.</p> <p>Конгрессийн судалгааны албанаас үзүүлэх үйлчилгээ болон бүтээгдэхүүнүүд:</p> <p>Тойм мэдээлэл, зөвлөгөө</p> <p>Тухайн үед хэлэлцэж буй хуулийн асуудлаарх тайлан, мэдээг цахим хуудсаар 7 хоногийн 24 цагийн турш мэдээлэх</p> <p>Хууль зүйн мэдээллийн систем (LIS)</p> <p>Семинар, уулзалт зохион байгуулах, Холбооны хуулийн шинэчлэлийн талаар жилд 2 удаа хэлэлцүүлэг хийх</p> <p>Конгрессийн ажилтнуудад хууль тогтоох болон төсөв хэлэлцэх журмын талаар сургалт зохион байгуулах</p> <p>Хуульд дүн шинжилгээ, анализ, тайлбар хийх</p> <p>Конгрессын номын сан-АНУ-ын хууль тогтоох дээд байгууллага болох Конгресст үйлчлэхээс гадна Засгийн газрын агентлаг, бусад номын сангууд, эрдэмтэд, судлаачдаас гадна олон нийтэд үйлчилдэг.</p> <p>-Конгрессийн номын сан нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна.</p> <p>Номын сангийн удирдах газар нь номын сангийн бодлогыг тодорхойлох, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг зохион байгуулах үүрэгтэй.</p> <p><i>Захиргаа, санхүүгийн алба</i></p> <p>Номын сангийн харъяа газруудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдгээр газруудын үйл ажиллагааг дэмжих зорилготой. Захиргааны газарт хүний нөөц, санхүү, аюулгүй байдлын албад харъяалагдана.</p> <p><i>Конгрессийн судалгааны алба</i></p> <p>Конгрессийн судалгааны алба нь Конгрессийн хууль тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, мэдээллээр хангана.</p> <p><i>Зохиогчийн эрхийн алба</i></p> <p>Үндэсний зохиогчийн эрхийн системийн дагуу зохиогчийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулна.</p> <p><i>Хуулийн номын сан</i></p> <p>Конгресс 1832 онд хуулийн номын санг байгуулсан бөгөөд одоогоор 3 сая гаруй хууль, эрх зүйн акт, баримт бичгүүдийг агуулсан дэлхийн хамгийн том хуулийн номын сан юм.</p> <p><i>Номын сангийн алба</i></p> <p>Энэ алба нь Америкийн ард түмний бүтээсэн түүхэн ном сурвалж болон дэлхийн түүхэн баримт бичгүүдээс бүрдсэн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, зохион байгуулах, кодчилох зэргийг асуудлыг хариуцна.</p> <p><i>Стратеги төлөвлөлтийн газар</i></p> <p>Энэ газар нь стратеги төлөвлөгөөний дагуу номын сангийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, үндэсний хэмжээнд удаан хугацааны дижитал хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.</p>	<p>Номын сан Судалгааны нэгж нь нэгдсэн нэг удирдлагатай.</p> <p>Архивын талаар мэдээлэлгүй байна.</p>

Аргентин			
<p>Парламентын Тамгын газрын Мэдээллийн Захиргаа нь дараах чиг үүрэгтэй:</p> <p>-Батлагдан гарсан хуулийн асуудлаарх тайлан мэдээний хүрээнд мэдээлэл бэлтгэх</p> <p>-Хууль зүйн мэдээлэл</p> <p>-Семинар, уулзалт зохион байгуулах, Холбооны хуулийн шинэчлэлийн талаар хэлэлцүүлэг хийх</p> <p>-Конгрессийн ажилтнуудад хууль тогтоох болон төсөв хэлэлцэх журмын талаар сургалт зохион байгуулах</p> <p>-Хуульд дүн шинжилгээ, анализ, тайлбар хийх</p> <p>Тогтмол хэвлэлээр түүвэр судалгаа бэлтгэх</p> <p>-Парламентын асуудлаар судалгааны сан бүрдүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>Мөн түүнчлэн тус захиргаанд Сургалт, судалгааны дэд хэсэг харьяалагддаг бөгөөд дараах үйл ажиллагааг явуулна.</p> <p>Үүнд: тайлан, мэдээлэл, семинар, илтгэл бэлтгэхээс гадна биечлэн болон утсаар зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээг гишүүд, Байнгын хороод, Конгрессийн дээд, доод танхимд хууль тогтоох үйл ажиллагааны бүх шатанд үзүүлнэ.</p> <p>Хууль тогтоох үйл ажиллагаа болон хуулийн техник аргачлалын талаар сургалт зохион байгуулна</p>	<p>Хэвлэл, мэдээлэл, архив, музейн газар</p> <p>Депутатуудын танхимын түүхэнд холбогдох баримт бичиг, түүхийн дурсгалт зүйлс, түүхийн судалгаа, Депутатуудын танхимын бүртгэл, тайланг хадгалдаг.</p>	<p>Конгрессын харьяа байгууллагуудын асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын дор Парламентын номын сантай</p>	<p>Тус тусад нь зохион байгуулсан</p>
Канад			
	<p>Парламентын номын сан</p> <p>Номын сангийн мэдээлэл, судалгааны материалуудыг парламентын гишүүд, ажилтнууд, парламентын хороод, холбогдох бусад байгууллага ашиглана. Номын санд голчлон Канадын улс төр, парламентын үйл ажиллагаа, Засгийн газар, эдийн засаг, хууль, парламентын түүх, дэг, улс төрийн шинжлэх ухаан, олон улсын байдалтай холбоотой материалууд байдаг. Тус номын сан нь 300 орчим ажилтантай.</p>		<p>Архив болон Судалгааны нэгжийн талаар мэдээлэлгүй байна.</p>

Мексик			
Баримт бичиг мэдээлэл болон анализ хариуцсан ерөнхий газар доторх Судалгаа, шинжилгээ, анализийн төв болон Номын сан, архивын газартай. Депутатуудын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, лавлагаа, бодлогын болон харьцуулсан судалгаа зэргийг мэргэжлийн өндөр түвшинд үнэн бодит мэдээлэлд тулгуурлан бэлтгэж үйлчилнэ.			Архив, Номын сан нэгдсэн нэг удирдлагатай, Судалгааны нэгж нь тусдаа боловч нэг газарт харьяалагдана
Тринидад ба тобаго			
		Парламентын номын сан нь парламентын гишүүд, ажилтнууд, судлаачдыг нэг талыг бариагүй, үнэн бодит мэдээллээр тогтмол хангаж ажиллана. Парламентын гишүүдэд дараах төрлийн мэдээллээр үйлчилнэ. Үүнд: Мэдээлэл, Судалгаа, шинжилгээ, Санхүү, Өрийн мэдээ, Техникийн мэдээлэл, Номын сангийн үйлчилгээ, Хэвлэл	Номын сан Судалгааны нэгж нь нэгдсэн нэг удирдлагатай. Архивын талаар мэдээлэлгүй байна.
Египет			
Парламентын номын сан Үндэсний ассамблейн үйл ажиллагааны чухал нэгж бөгөөд Африк тив, Арабын ертөнц төдийгүй дэлхийд томоохонд тооцогддог. Фондод нь нийтийнхээс гадна Үндэсний ассамблейн гишүүд, ажилтнуудын хэрэгцээнд зориулсан мэдээлэл агуулагдах бөгөөд орчин үеийн технологийн дагуу ашиглах боломжийг бүрдүүлсэн байдаг. Мэдээллийн төв нь Үндэсний ассамблейн хууль тогтоох, хяналт тавих үйл ажиллагаанд тусламж үзүүлэх үндсэн болон туслах чанарын үйлчилгээг бий болгожээ. Үүнд: Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх, Номын сангийн мэдээллийн фонд нь бүх салбарын мэдээллийг хамарсан байна. Тухайлбал, эрх зүй, нийгэм, эдийн засгийн г.м. Парламентын судалгаанд шаардлагатай мэдээллийг дотоод, гадаад эх сурвалжаас бүрдүүлэх, Тухайлсан мэдээлэлд бодит шинжилгээ хийх, Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгийн агуулгыг шинжлэх, Парламентын Байнгын хороод, Засгийн газрын байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг мөрдөж ажиллах, Парламентын нэгдсэн хуралдаан, бусад үйл ажиллагааны тайлан мэдээ гаргах, Ассамблейн гишүүд, ажилтнуудын санхүүжилтийн байдлыг судалж, шинжлэх			Номын сан Судалгааны нэгж нь нэгдсэн нэг удирдлагатай. Архивын талаар мэдээлэлгүй байна

* * *

Норвеги			
Судалгааны хэлтэс (Research Section) Гишүүд, байнгын хороод, намын ажлын албадад экспертийн туслалцаа үзүүлнэ.	Стортингийн архив (Archives of the Storting) Энэ нь Стортингийн гол архив бөгөөд парламентын үйл ажиллагаанд баримт бичгийн болон архивын үйлчилгээ үзүүлнэ. Мөн Стортингийн уран зураг, хөрөг зургийн галерейн ажлыг хариуцна. Байнгын хорооны архив нь хороодын үйл ажиллагааны тайлан мэдээг хадгалах, хороодын архивыг Стортингийн архив руу явуулахад бэлтгэх ажлыг хариуцна.	Стортингийн номын сан (Library of the Storting) Номын сангийн үйлчилгээнээс гадна ном, тайлан, тогтмол хэвлэл, сонинг фондод авах, гадны мэдээллийн сангуудаас хайлт хийх, радио, телевизийн бичлэг үзэх, хуулж авах зэрэг үйлчилгээний ажлыг хариуцна.	Энэ гурван нэгж тусдаа боловч нэг Газар-т буюу "Мэдээлэл баримт бичгийн газар"-т бусад 4 хэлтэсийн хамтаар харьяалагдана.

* * *

Монгол		
<p>Судалгааны төв</p> <p>Судалгааны төв нь Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд ирүүлсэн захиалга, чиглэлийн дагуу болон Төвийн санаачлагаар цаг үеийн тулгамдсан асуудлууд, бодлогын чанартай асуудлуудаар судалгаа хийх, бодлогын шинжилгээний дүгнэлт, зөвлөмж гаргах, цаг үеийн шуурхай мэдээлэл, судалгааны мэдээллээр хангах, судалгааны мэдээллийн бааз бүрдүүлэх, хууль, тогтоолын төсөл болон бодлого боловсруулах шатанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, экспертүүдийн саналыг авах, хэлэлцүүлэг хийхтэй холбогдуулан олон нийттэй харилцах үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1) Улсын Их Хурлын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын хүрээнд хийх судалгааны ажлын захиалгыг Байнгын хороодын ажлын албаар дамжуулан авах, Улсын Их Хурлын болон Тамгын газрын удирдлага, Байнгын хороодын удирдлагаас өгсөн захиалгын дагуу судалгааны ажлыг зохион байгуулах; 2) Цаг үеийн тулгамдсан асуудал болон бодлого, хууль, эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудлаар Төвийн санаачлагаар судалгааны сэдэв гаргаж, судалгааны ажлыг зохион байгуулах; 3) Судалгааны сэдвийн хүрээнд тухайн асуудлаар статистик мэдээлэл, судалгааны материал, зах зээлийн мэдээлэл, бусад орны туршлагыг судалж судалгааны мэдээллийн бааз бүрдүүлэх, мэдээллээр хангах; 4) Судалгааны сэдвийн хүрээнд тухайн салбарын хууль, эрх зүйн болон төрийн зохицуулалтын бодлого, чиглэл, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээллийн бааз бүрдүүлж мэдээллээр хангах; 5) Судалгааны сэдвийн хүрээнд бодлогын судалгаа хийж төлөв байдал, хандлагад дүн шинжилгээ хийх, нөлөөллийн хүчин зүйлийг тодорхойлох, бодлогын шинжилгээний дүгнэлт гаргаж, тухайн асуудлыг шийдвэрлэх бодлогын альтернатив хувилбаруудыг боловсруулах, санал, зөвлөмж гаргах; 6) Шаардлагатай хууль, тогтоолын төсөл болон бодлогын шийдвэрийн төсөлд олон нийтийн саналыг тусгах үүднээс санал авах, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдыг оролцуулан хэлэлцүүлэг, онол практикийн хурлыг Тамгын газрын бүтцийн холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах; 7) Засгийн газар, яам, агентлаг, судалгаа шинжилгээ, мэдээллийн болон бусад холбогдох байгууллага, Тамгын газрын бүтцийн нэгжүүдээс мэдээлэл авах, хамтран ажиллах; 8) Судалгааны явцад шаардлагатай асуудлаар мэргэжлийн эксперт, зөвлөхийг гэрээгээр ажиллуулах, судлаачдын түвшинд уулзалт, ярилцлага, төрөлжсөн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах; 9) Судалгааны чиглэлээр олон нийтийн хэлэлцүүлэг хийх, санал авах ажлыг зохион байгуулах; 10) Веб хуудсаар дамжуулан хуулийн төсөл болон бодлогын асуудлаар хэлэлцүүлэг хийх, олон нийтийн санал авах ажлыг тогтмол зохион байгуулах; 11) Дотоодын болон гадаад орнуудын парламент болон парламентын дэргэдэх бодлогын судалгаа, шинжилгээний байгууллагын талаар судалгаа хийх, парламентын түүхийн эмхтгэл гаргах; 12) Судалгааны материалыг эмхтгэн номын санд шилжүүлэх, Улсын Их Хурлын гишүүдийг судалгааны дэлгэрэнгүй тайлантай танилцах нөхцөлийг бүрдүүлэх; 13) Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын удирдлагыг улс орны дотоод мэдээлэл болон дэлхийн улс төр, эдийн засаг, санхүүгийн байдлын талаархи тойм мэдээллээр шуурхай хангах; 14) Судалгааны мэдээллийн нэгдсэн бааз бүрдүүлэх, мэдээллийг ангилан дэлгэрэнгүй болон хураангуй хэлбэрээр хадгалах, судалгааны лавлагаа, цахим мэдээллийн сан бүрдүүлэх; 15) Улсын Их Хурлын дотоод сүлжээнд судалгааны мэдээллийн материалыг байршуулах; 16) Судалгааны ажлын тайлан, судалгааны материалаар болон шаардлагатай зарим асуудлаар гарын авлага, ном товхимол эмхтгэн гаргах; 17) Төвийн болон Тамгын газрын хэмжээнд бусад хэлтэс, албатай хамтран сургалт зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх; 18) Улсын Их Хурлын номын санг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, олон нийтэд номын сангаар үйлчлэх. 	<p>Архив</p> <p>Улсын Их Хурал, түүний Тамгын газрын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагааг стандартын дагуу зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын бүтцийн нэгжүүдийг архивын лавлагаа, мэдээллээр хангах, архив, бичиг хэргийн ажлын мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;</p>	<p>Манай улсын хувьд Номын сан нь судалгааны төвдөө харъяалагдах бөгөөд архивын нэгж нь парламентын ажлын албаны “Захиргаа боловсон хүчний хэлтэс”-д харъяалагдан үйл ажиллагаагаа явуулна.</p>

**ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ ДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**
(Харьцуулсан судалгааны дүгнэлт)

Г. Алтан - Оч (Ph. D), С. Дорждагва

Орчин үед Парламентын Тамгын газарт тулгамдаж байгаа нэгэн чухал асуудал нь парламентын үйл ажиллагаанд мэдээллийн автоматжуулалтыг нэвтрүүлэх ажил болоод байна. Үүнтэй холбоотой дараах асуудлуудад анхаарал хандуулж ажиллах, түлхүү ашиглах, үйл ажиллагаандаа хэвшүүлэх шаардлагатай хэмээн мэргэжлийн байгууллага үзжээ¹⁸. Үүнд:

- Маш их хэмжээний мэдээллийг электрон хэлбэрт бэлтгэх, шилжүүлэх;
- Парламентын гишүүд санал хураалтанд электрон хэлбэрээр оролцох. Энэ чадварыг гишүүдэд бүрэн эзэмшүүлэх;
- Ажилтнуудад шинэ төрлийн техник хэрэгслийг эзэмшүүлэх;
- Парламентын бүх гишүүдэд орчин үеийн лаптоп, таблет компьютеруудыг ашиглах чадвар эзэмшүүлэх;
- Ажлын болон хуралдааны танхимд шинэ төрлийн менежментийг хэвшүүлэх;
- Шинэ технологид тулгуурласан оффисын тавилгаас эхлээд бүх төрлийн зүйлд электрон хэрэгслийн зохион байгуулалтыг нэвтрүүлэх;
- Парламентын түүх болон хуралдааны тэмдэглэл хөтлөх үйл ажиллагааны мэдээллийг бүрэн автоматжуулах;
- Парламентын барилгын дотор болон гадна зохион байгуулах арга хэмжээнүүд, тэдгээрийн харилцан шууд холбогдох боломжийг хангах.

Дэлхийн улс орнуудын Парламентын тамгын газрын бүтцээс харахад, парламентын үйл ажиллагаан дахь мэдээллийн автоматжуулалт дараах үндсэн 3 функциональ чиглэлээс бүрдэж байна. Үүнд:

1. Мэдээллийн технологи: Энэ нь парламентын вэб сайт, спикерийн вэб сайт, гишүүдийн вэб сайт, гишүүдийн дотоод сүлжээний вэб сайт, Тамгын газрын дотоод сүлжээний програм хангамж (мэдээлэл солилцох болон албан бичгийн чиглэлээр) гэх мэт ерөнхийдөө софтвер буюу програм хангамжийн асуудлыг хариуцан ажиллах үндсэн үүрэгтэй байна. Энэ чиглэлд хамаарах бас нэгэн үүрэг нь мэдээллийн технологийг ашиглах арга зүйн талаар парламентын гишүүд, ажлын албаны ажилтнуудад сургалт зохион байгуулах юм;
2. Техник хангамж: Энэ нь парламентын гишүүдийн болон Тамгын газрын компьютер, техник хэрэгсэл, дотоод болон Интернэтийн сүлжээ, хуралдаанд ашиглах техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хардвейр буюу техникийн үйлчилгээ үзүүлдэг үндсэн үүрэгтэй ажиллах хэсэг юм;
3. Парламентын мэдээллийг электрон хэлбэрээр түгээх: Энэ нь парламентаас гарч байгаа шийдвэрийг электрон хэлбэрээр нийгэмд хүргэх ажлыг хариуцдаг. Тухайлбал, үндсэн агуулга, хэлбэр, дизайн, цаг хугацааг тодорхойлох, мэдээллийг шинэчлэх, эдгээр мэдээлэлд ирүүлсэн саналыг нэгтгэн иргэдийн санал байдлаар холбогдох газар (судалгааны алба, байнгын хороодын ажлын алба)-т хүргэх гэх мэт чиг үүрэгтэй. Энэ чиг үүргийг хариуцсан бие даасан алба

¹⁸ Towards the modernization and computerization of services. Association of Secretaries General of Parliaments. Panama Session. April 2011

харьцангуй түгээмэл бус байгаа юм.

Тус судалгааны ажилд хамруулан авч үзсэн 50 орчим улс орнуудын парламентын ажлын албаны бүтцээс харахад, эдгээр гурван чиг үүрэг нэг хэлтэс, албанд нэгтгэгдсэн, эсвэл тус тусдаа бие даасан алба болгосон байдалтай байна. Гэхдээ, нэг ерөнхий чиг хандлага ажиглагдаж байгаа нь мэдээллийн технологийг гүнзгий нэвтрүүлж парламентын үйл ажиллагаан дахь автоматжуулалтын төвшин нэмэгдэхийн хэрээр эдгээр чиг үүргийг дагнан хариуцсан бие даасан хэлтэс байдалтай болж байна. Өөрөөр хэлбэл, хөгжиж байгаа орнуудад эдгээр чиг үүрэг нэг хэлтэст харъяалагдаж байгаа бол хөгжлийн төвшин нэмэгдэхийн хэрээр бие даасан хэлтэс болж хөгжиж байна. Үлгэр жишээ болохуйц зарим орны Тамгын газрын бүтцийг хавсаргав. Үүнд: Норвеги, Нидерланд, Герман (Хавсралт №1-№3).


Судалгаанаас харахад, мэдээллийн автоматжуулалтыг маш сайн иж бүрэн нэвтрүүлсэн орон бол Энэтхэг улс байна. Энэтхэгийн туршлагаас үзэхэд, софтверийг гадны мэргэжлийн байгууллагаар (NIC - Үндэсний информатикийн төв) хийлгэж, харин Тамгын газартаа өөрсдийн хүчээр үргэлжлүүлэн хөгжүүлж, сайжруулж нэвтрүүлдэг юм байна. Энэтхэгийн парламентын мэдээллийн автоматжуулсан системийн функциональ бүтцийг Хавсралт №4-д үзүүлэв.

Дүгнэлт, зөвлөмж


1. Тус тамгын газрын дотоод сүлжээний ашиглалтыг сайжруулж, мэдээллийн нууцлал, найдвартай ажиллагааг хангасны үндсэн дээр мэдээлэл шуурхай солилцох зориулалттай бие даасан, дотоод мэссэнжэрийн систем ашиглах, улмаар Lotus Notes зэрэг зах зээлд шалгарсан, баталгаатай, найдвартай мэдээллийн баазын удирдлагын програм хангамжийг нэвтрүүлэх, мэдээлэл солилцоог бүрэн автоматжуулсанаар цаасгүй технологид шилжих зорилт тавин ажиллах, холбогдох техникийн төсөл, техникийн даалгавар боловсруулах шаардлагатай байна.
2. Тус тамгын газарт иж бүрэн мэдээллийн автоматжуулсан систем нэвтрүүлэх зорилтын хүрээнд софтвер буюу програм хангамж боловсруулах, хөгжүүлэх чиг үүрэг бүхий албыг нэн даруй байгуулж ажиллуулах нь зүйтэй. Энэ чиглэлийн мэргэжлийн хүний нөөцийн чадавхийг бий болгох, Энэтхэг зэрэг улсад явуулж туршлага судлуулах.
3. Мэдээллийн автоматжуулсан систем боловсруулах ажлын хүрээнд мэргэжлийн өндөр чадамж, их хүн - хүч шаардагдах зарим дэд системийн софтверийг гадны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, холбогдох төсөв хөрөнгийг батлуулж бэлтгэх нь зүйтэй.

* * *


UIN.MN
СУДАЛГААНЫ САН

НОРВЕГИЙН ВАНТ УЛС (*Kingdom of the Norway*)

НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛС (Kingdom of the Netherlands)



ГЕРМАНЫ БУНДЕСТАГИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ



ЭНЭТХЭГ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Парламентын мэдээллийн автоматжуулалт

Анх 1985 оны 12 дугаар сард PARLIS буюу Парламентын номын сангийн мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлаар мэдээллийн автоматжуулалтын ажлыг эхэлсэн. Хожим Экспертийн зөвлөл 1991 онд Энэтхэгийн парламентын доод танхимын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт энэ ажлыг нэвтрүүлсэн. Экспертийн зөвлөлийн тайлангаас үзэхэд, автоматжуулалтын ажлыг Үндэсний мэдээлэл зүйн төв болон Компьютерийн техник үйлчилгээний корпорацийн туслалцаатай хийсэн байна.

Мэдээллийн автоматжуулалт нь хэдэн жилийн дараа гэхэд Парламентын Тамгын газрыг бүрэн хамарч чадсан. Энэ ажлын хүрээнд технологийн шинэчлэлтийн зэрэгцээ бусад чиг үүрэг, ажлын үйл явцыг шинэчлэн зохион байгуулсан. Улмаар тухайн цаг үе бүрд хамгийн сүүлийн үеийн техник хэрэгслийг нэвтрүүлэх ажил хийгдэж ирсэн тул програмчлалын ажил түүнтэй хамт байнга шинэчлэгдэн хөгжиж явж байна.

Энэтхэг улсын Парламентын үндсэн вэбсайт

Энэтхэгийн парламентын үндсэн вэбсайт анх 1996 оны 3 дугаар сард албан ёсоор нээгдсэн. Маш богино хугацаанд тус вэбсайт нь Энэтхэгийн парламентын дээд, доод танхимын үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичгүүд, парламентын түүх, гишүүдийн талаар хамгийн гол, үнэн бодитой мэдээллийг олж авахад тусладаг хэрэгсэл болж чадсан юм.

Тус сайтад одоогоор Энэтхэг улсын парламентын талаарх дараах үндсэн мэдээллийг агуулж байна. Үүнд:

- Энэтхэгийн үндсэн хууль
- Constituent Assembly Debates
- 1997 оноос хойших улсын нэгдсэн төсөв
- Энэтхэгийн парламент - Lok Sabha/Rajya Sabha (доод, дээд танхим)-ийн талаар танилцуулга
- Доод танхимын үйл ажиллагааны болон удирдлагын холбогдох дүрэм журмууд
- Даргын үйл ажиллагаа, шийдвэрүүд
- Байнгын хороод болон тэдгээрийн үйл ажиллагааны тайлан
- Хэн нь хэн бэ? (тухайн үеийн парламентын)
- Lok Sabha-ийн үе үеийн гишүүдийн нэрсийн жагсаалт
- Үйл ажиллагааны тайлан - 1999 оноос хойших онуудын
- Статистик мэдээллүүд он оноор
- Хэлэлцүүлгийн тайлан, тэмдэглэл - 1991 оноос хойш он оноор
- Хэлэлцүүлгийн хураангуй танилцуулга - 2000 оноос хойш он оноор
- Парламентын асуултууд (агуулга) – 1984-1999 он
- Парламентын асуулт, хариултын хамт – 2000 оноос хойш
- Гишүүдийн холбоо барих хаягууд
- Гишүүдэд зориулсан гарын авлага
- Гишүүдийн тойрог, түүний хөгжлийн асуудлууд

Парламентын дээд доод танхим телевиз ашиглан шууд холбогдож хамтарсан хурал хийдэг. Энэ хоёр танхимын хурлын үйл явцыг энэхүү сайтыг ашиглан дэлхийн өнцөг булан

бүрээс мэдэх, үзэх боломжтой. Тус вэб сайт нь мэдээж бусад төрийн байгууллагуудын мэдээллэлийн зарим хэсгийг агуулж, тэдгээртэй линкээр холбогдсон байдаг.

Парламентын номын сан

Парламентын номын санд одоогийн ашиглаж байгаа програм нь номын сангийн тусгайлсан LIBSYS програмд суурилж хөгжүүлж, тохируулга хийсний үндсэн дээр бий болсон. Тус програм нь вэб програмчлалд тулгуурласан номын сангийн бүхийл үйлчилгээний функцыг багтаасан иж бүрэн програмын цогц юм. Номын сангийн програмыг интернет болон дотоод сүлжээ ашиглан парламентын гишүүд ажлын албаны ажилтнууд, бусад хэрэглэгчид номын сангийн мэдээлэлд хандах боломжтой байдаг.

Парламентын номын санг UNIX системд үндэслэн 1989 оноос хойших сэтгүүл, тогтмол хэвлэл гэх мэт зүйлсийг олж авах ажлуудыг зохион байгуулж, мэдээллийн баазад оруулж байдаг. мэдээллийн системийг баяжуулах ажил 1989 онд автоматжуулалтыг нэвтрүүлсэн үеэс эхлэн Баримт бичгийн хэсэгт хамаарч байна. Цахим мэдээллийн баазад оруулах мэдээллийг Парламентын ажлын албаны холбогдох ажилтнууд, ажлын хэсгийн гишүүд загварчилна. Эдгээр баримт бичгүүдийг мэдээллийн сангийн ангилал болон жагсаалтад гишүүдийн заавраар оруулсанаар түүнийг богино хугацаанд шинэчлэх, хөгжүүлэх ашиг тустай байдаг.

Хэвлэлийн тойм бэлтгэх ажил STEX програмаар хийгддэг. Чухал гэж үзсэн мэдээллийг нийтлэгч, агуулга, тухайн цаг үеийн гэх мэт ангилалаар Хинди болон Англи хэл дээрх хэвлэлээс сканнердаж зурган файл хэлбэрээр оруулдаг. Хэвлэлийн тоймыг онлайн эх сурвалжаас татах бол зөвхөн интернет эх сурвалжийг нь оруулсан байдаг. Цахим номын санд хадгалагддаг мэдээллүүдийг DVD, CD гэх мэт хувилбараар бэлтгэж хэрэгцээтэй парламентын гишүүн, ажлын албаны ажилтнуудад хүргэх боломжтой байдаг.

Спикерийн вэбсайт

Спикерийн вэб сайт нь 2002 оны нэгдүгээр сард анх Lok Sabha-ийн вэб сайтын “The Office of the Speaker Lok Sabha” хэсэгт байгуулагдсан байна. Тус сайтад спикерийн улс төрийн болон хувийн ололт амжилтууд, танилцуулга, парламентад гүйцэтгэх үүрэг, ажлын үеийн зурагт мэдээлэл, хэвлэлийн мэдээлэл, хэлсэн үгүүд байдаг. Мөн өмнөх спикерүүдийн мэдээлэл бас байдаг.

Парламентын гишүүний вэбсайт

Гишүүн бүр өөрийн хувийн мэдээллийн талаар хэсэг түүний парламентын үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, асуулт хариулт, өөрийн сонгуулийн тойрогт хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлуудын талаар мэдээллийг оруулдаг. Гишүүдийн линк нь Парламентын үндсэн сайтад байрласан байдаг.

Дотоод сүлжээ

Парламент болон түүний ажлын алба нь Парламентын ордон, Парламентын номын сан, Парламентын ордны өргөтгөл гэсэн 3 үндсэн барилгад байрладаг. Эдгээр барилгад байдаг компьютерүүдийг холбосон мэдээлэл дамжуулах сүлжээг интернет болон өндөр хурдны дотоод сүлжээг ашиглан энгийнээр шийдсэн байдаг. Энэхүү дотоод сүлжээ нь CISCO 6513 Central Switch and CISCO Catalyst 3524 edge switches-үүдээс бүрддэг.

The switches have layer 3 routing capabilities. The central switch 6513 is ideally suited for high performance, high port density, fast ethernet and gigabit ethernet aggregation in all parts of the network including the access, distribution and backbone layers as well as the server farm and

data centre environments. The independent Local Area Network (LAN) of the three buildings and reception offices is connected with each other through Optical Fibre Cables for providing high speed connectivity. The computer connectivity to outside world including Internet is being provided through National Informatics Centre Network known as NICNET. The NICNET is connected to state capitals, important institutions and all the District Headquarters of the country. The LAN of all the three buildings of Parliament House Precinct are independently connected with NICNET through 2 mbps ISDN lines.

Touch Screen Computer -ийн хэсэг

Энэ хэсгийг байгуулсан нь Парламентын ордны мэдээллийн автоматжуулалтад шинэлэг ажил болсон. Энэ хэсэг нь парламентын хэлэлцүүлэг, асуулт, ажлын хэсэг, хуралдаан, гишүүндийн мэдээлэл, гүйцэтгэх ажлын жагсаалт танилцуулга, парламентын санхүү, төсвийн гэх мэт мэдээллээр тогтмол, шуурхай хангах үүрэгтэй.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4

БҮЛЭГ

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ҮНДСЭН ХУУЛИА ДЭЭДЛЭХҮЙ*Ц. Товуусүрэн*

Нуур амгалан бол нугас амгалан гэдгийн үлгэрээр төр нь тогтвортой бол түмэн олон нь амгалан гэдэг. Төр тогтвортой байхын үндсийн үндэс нь Үндсэн хуулиа тогтвортой мөрдөх явдал юм.

Үндсэн хуулийг тогтвортой мөрдөх талаар намайг юм бичихээр Үндсэн хуулийг боловсруулах, батлах явцад оролцсон учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж байна гэж бүү ойлгоосой гэж хичээнгүйлэн хүсэхийн ялдамд дэлхийн зарим улс орнуудад Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хэрхэн хангаж байгаа болон хангаж чадахгүй байгааг зэрэгцүүлэн судалсаны үндсэн дээр хийсэн дүгнэлтдээ тулгуурлаж энэхүү сэдвийг хөндсөн гэдгийг хэлэх байна

Үндсэн хууль нь аливаа улс орны ард нийтийн эрх, эрх чөлөөг дээдлэн тэдгээрийн сайн сайхан амьдралд үйлчилж байх учиртай бөгөөд Үндсэн хуулиас нийт ард түмэнд юу ашиг тустай хийгээд нийгмээрээ юу хүсч байгааг олж харах боломжийг олгож байвал Үндсэн хууль нь дэлгэрэнгүй эсвэл хураангуй байхаас үл шалтгаалан өөрийн үүргээ биелүүлэх чадвартай болохыг дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн түүхээс төвөггүйхэн харж болдог.

Улс орон бүр Үндсэн хуулиараа хаант эсвэл бүгд найрамдах, холбооны эсвэл нэгдмэл улсын аль нь байхаа тогтоохоос гадна хаант улсын хааны эрх хэмжээ хэмжээлшгүй эсвэл хэмжээ, хязгаартай байх, бүгд найрамдах улсын төрийн дээд эрхийг Ерөнхийлөгч эсвэл парламент нь барьдаг байхыг тогтоодог бол эдгээр тохиолдолд Хаан, Ерөнхийлөгч, Засгийн газар, парламент, шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх хэмжээг тогтоодог билээ. Парламентын бүтэц /нэг танхимтай, эсвэл хоёр танхимтай/ ямар байх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалах хэм хэмжээг ч нэгэн адил тогтоодог. Эдгээр нь Үндсэн хуулийн хамгийн тогтвортой үйлчилж байх ёстой амин чухал хэм хэмжээ гэж үздэг байна.

Үндсэн хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээс хойш түүнд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг санаачлах субъект, хэлэлцэн батлах журам, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэрийг дэлхийн нийгмэд улс орнуудад хатуухан шалгууртайгаар нарийвчлан тогтоож өгдгийг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн “Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын асуудлыг бусад орны Үндсэн хуульд зохицуулсан байдал” харьцуулсан судалгаагаар нотолж байгаа бөгөөд энэ судалгаанаас Үндсэн хууль бол тогтвортой үйлчилж байх ёстой эрх зүйн дээд баримт гэж нэг мөр ойлгож болохоор байгаа юм. Судалгаанд хамрагдсан 53 улсын Үндсэн хуулийн зохицуулалтаас харахад хүний эрх, эрх чөлөөг дордуулсан, төрийн хэлбэр, төрийн байгууламжийн хэлбэрийг өөрчилсөн төсөл оруулахыг хориглосон байх нь нэлээд нийтлэг бөгөөд, Үндсэн хуулийн байгуулалд хамаарах төрийн эрхийг барих дээд байгууллагуудын тогтолцоотой холбогдсон заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулахыг хязгаарласан эсвэл зөвхөн ард нийтийн санал асуулгаар батлах журам тогтоосон зэрэг нь мөн л Үндсэн хуулийн эдгээр хэсэгт тэр бүр халдаад байх бололцоо хязгаартай гэдгийг нотолсон хэрэг юм.

Ийм учраас л АНУ-ын Үндсэн хууль батлагдаад 223 жил болсон байхад 27 удаа нэмэлт өөрчлөлт оруулсаны олонхи нь хүний эрх чөлөөг улам өргөтгөх Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн сонгуулийн журмыг тодотгох, Конгрессын танхимуудын үйл ажиллагааны журмыг илүү тодорхой болгохтой холбоо бүхий харилцааг хамарч байснаас бус төрийн тогтолцоо, Үндсэн хуулийн байгууллыг хөндөж байсангүй ээ.

Австралийн Үндсэн хууль 1901 онд, Норвегийн Үндсэн хууль 1814 онд, Бельгийн Үндсэн хууль 1831 онд батлагдсан байгаа нь Үндсэн хуулиа тогтвортой мөрдөж, хэрэгжүүлж чадаж байгаагийн илрэл юм.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад хүргэдэг томоохон хүчин зүйлийн нэг нь хууль зөрчигдөх явдал газар авч, даамжирсантай холбоотой байдаг. Грек, Ромын нийгэм парламентат ёсны үндсэн шинж бол « хууль дээдлэх чанар », « хууль бүхэнд ноёрхох » зарчим бөгөөд төр хуулийн үндсэн дээр, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зарчимтай гэж үздэг байжээ. Платон « Хууль засаглахгүй байгаа газар төрийн мөхөл холгүй байгааг төвөггүй ажиглаж болно » гэсэн бол Аристотель « Хууль засаглахгүй байгаа газар төрийн байгууллын хэлбэр орших орон зай байхгүй, хууль бүхнийг засаглах ёстой » хэмээн тодорхойлж байжээ. Парламентат ёсны их сэтгэгчид Дж. Локк, Ш. Монтескье, Ж. Бентам нар ч хууль бүхнээс дээгүүр засаглах учиртай гэсэн байдаг.

Улс орнуудын Үндсэн хуулийн түүхээс харахад хаана хууль хэрэгжихгүй байна, тэнд Үндсэн хуулиа байн байн өөрчлөх хандлага давамгайлдаг байна.

Үндсэн хуулийн тогтвортой байдалд сөрөг муугаар нөлөөлдөг, Үндсэн хууль болохгүй байна гэсэн сэтгэгдлийг олон түмэнд төрүүлдэг өөр нэг хүчин зүйл бол төрийн нэрийн өмнөөс ажилладаг байгууллага, албан тушаалтнууд хээл хахууль, авилгатай байнга холбогдох явдал гэдгийг Африк тивийн асар их баялагтай мөртлөө хөгжиж чадахгүй байгаа, авилгын индексээр дэлхийд тэргүүлдэг улс орнуудын туулж ирсэн замналаас тодорхой харж болно.

Орчин үед дэлхийн тэр дундаа хөгжилтэй орнуудын зүгээс ядуу буурай орнуудын төрийн удирдлагад ажиллаж байгаа хүмүүсийг авилгад татан оруулж, улс орныхоо эдийн засгийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийг урьтал болгох хандлага байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч болгоомжлох цаг нь болсон байна.

Эдийн засгийн хөгжил сул дорой улс орнуудад Үндсэн хуулиар тогтоодог төрийн тогтолцоо, төрийн байгууллын хэлбэрүүдийг өөрчлөх хандлага давамгайлдаг нь тухайн улс орны тогтвортой хөгжилд улам сөрөг муу нөлөө үзүүлдэг байна. Үүнийг Африк тивийн цөөнгүй улс орны бодит түүх нотолж байна. Үндсэн хуулийн аливаа өөрчлөлт нь тухайн улс орны төрийн байгууллын хэлбэр, нийгэм, улс төрийн тодорхой бүлэглэл, үндэстний болон шашны төлөөллийн эрх ашгийг байнга хөнддөг учраас тэнд эсэргүүцэл, тэмцэл, үймээн самуун, иргэний дайн бүр хомроглон устгах явдал ч гардаг жишээ баримт цөөнгүй байна. /хавсрат 1-ийг харна уу/.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 1

- Африк тивийн зарим орнуудын Үндсэн хуулийн түүх, төрийн байгууллын талаархи харьцуулалт

№ Улсын нэр	Төрийн хэлбэр	Төрийн дээд эрхийг барих субъект	Парламентын танхимын тоо	Үндсэн хуулиа баталсан он	1 хүнд ногдох ДНБ \$/оор /2010/
1. Бурунди	-1962 оноос Хаант -1966-1981 онд цэргийн дэглэм, төрийн эргэлт -1981 онд 1 намын тогтолцоотой БНУ	-1962 оноос Хаан -1966 оноос цэргийн эрхтнүүд -1981 оноос Ерөнхийлөгч	2 танхимтай, Үндэсний ассамблей Сенат	-1962 анхны -1981 шинэчилсэн -1992 шинэчилсэн -2005 шинэчилсэн	410.0
2. Гвиней- Биссау	1974 оноос БНУ	-1974 оноос Ерөнхийлөгч -1999-2000 онд түр засгийн газар -2000 оноос Ерөнхийлөгч -2003 оноос түр засгийн газар -2005 оноос Ерөнхийлөгч -2009 онд ерөнхийлөгч буудуулан алагдсан	1 танхимтай	-1974 онд анхны Үндсэн хууль - 1984 онд нэг намын тогтолцоо -1991 онд олон намын тогтолцоог тусгасан шинэчлэл -1993 онд 2 удаа, 1996 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан	1081.0
3. Зимбабве	-1965 оноос БНУ Өмнөд Родези нэртэй -1980 оноос БНУ Зимбабве	1965 оноос Ерөнхийлөгч	2 танхимтай Сенат Үндэсний ассамблей	-1965 онд Өмнөд Родезийн БНУ-ын -1981 онд БНЗимБУ-ын Үндсэн хууль түүнд 1981- 2005 оны хооронд 17 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан	173.0
4. БНА Конго	-1960 оноос БНУ -1964 оноос БНАКонго	1960 оноос Ерөнхийлөгч 1965 оноос 1 намын Ерөнхийлөгч	-1960 оноос 2 танхимтай -1965 оноос 1 танхимтай -2005 оноос 2 танхимтай	-1960 онд анхны -1965 онд 1 намын системтэй -1974, 1978, 1990, 1994, 1998, 2002, 2005 онд ихэвчлэн нам, танхимын тоо, хууль тогтоох, Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оружээ.	342.0
5. Конго	1960 онд БНУ -1963 оноос социалист чиг баримжааг сонгосон -1977 оноос нэг хүний дарангуйлал тогтоосон улс гэж үздэг	-1960 оноос Ерөнхийлөгч -1977 оноос Денни Сассугийн дэглэм бүхий улс	1960 оноос 1 танхимтай 2005 оноос 2 танхимтай	1960 онд анхны -1963 онд социалист -1991 онд БНУ -1998 оноос шилжилтийн үеийн 2002 оноос Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг сунгах, парламент 2 танхимтай байх	4548.0

Судалгааны эмхтгэл, XII боть

6. Нигер	1960 оноос БНУ	-1960 оноос 1 намаас сонгогдсон Ерөнхийлөгч -1974 оноос Цэргийн дэглэм -1991 оноос Ерөнхийлөгч -1996 оноос цэргийн дэглэм, Үндэсний эвлэрлийн зөвлөл -1999 оноос Ерөнхийлөгч -2010 онд цэргийн дэглэм	1 танхимтай	-1960 онд анхны -1991 онд олон намын тогтолцоо бүхий -1999 онд Үндсэн хуулийн шинэчлэл - Одоогийн байдлаар Үндсэн хуулийн үйлчлэлийг зогсоож, цэргийн дэглэм тогтоосон	733.0
7. Нигерия	1960 оноос Холбооны БНУ	-1960 оноос Ерөнхийлөгч -1966 оноос Цэргийн зөвлөл -1983 оноос Ерөнхийлөгч -1989 оноос Цэргийн зөвлөл -1999 оноос Ерөнхийлөгч	-1966 онд хүртэл Британий загвар бүхий 2 танхимтай -1979 оноос Америкийн загвар бүхий 2 танхимтай	-1969 онд анхны -1979 онд шинэ Үндсэн хууль -1989 онд баталсан Үндсэн хуулийг мөрдөж чадаагүй -1999 онд шинэ Үндсэн хууль баталж, иргэний Ерөнхийлөгч парламентын сонгууль явуулсан	2358.0
8 Руанда	1961 оноос БНУ	-1961 оноос Ерөнхийлөгч /энэ хугацаанд төрийн эрх барих горимд хэд хэдэн удаа өөрчлөлт орж байсан/ -1973 оноос цэргийн дэглэм -1975 оноос Эрх баригчдыг дэмждэг хөгжлийн төлөө хувьсгалт нам -1978 оноос Ерөнхийлөгч	1961 оноос 2 танхимтай Сенат Депутатуутын Танхим Үндэстэн хоорондын зөрчлөөс хамаарч 1961 оноос хойш 6 удаа парламентын сонгууль болсон бөгөөд 1973- 1978 онд парламент ажиллаагүй байна.	-1961 онд анхны - 1978 онд нэг намын тогтолцоо бүхий -1991 онд олон намын тогтолцоо бүхий -1995 онд Үндсэн хуулиа шинэчилсэн - 2008 онд баталсан шинэ Үндсэн хуулийг мөрдөж байна.	1149.0
9. Этиопи	-1889 оноос хаант улс/1936- 1941оныг/ эс тооцвол африк тивийн колони болоогүй тусгаар тогтнолоо хадгалж үлдсэн цөөн улсын нэг юм. -1995 оноос холбооны БНУ	1950оноос эзэн хаан -1974 оноос Социалист зүүний хүчний холбоо 1995 оноос парламент	1994 оны Үндсэн хуулиар Холбооны ассамблей 2 танхимтай Ардын төлөөлөгч- дийн танхим Холбооны танхим	Хаант улсын Үндсэн хуулийг залгамжилж 1987 онд анхны холбооны БНУ-ын Үндсэн хууль батлагдсан -1994 онд дахин шинэ Үндсэн хууль баталсан	1004.0

10. Сомали	1960 оноос БНУ	-1961 оноос парламент -1969-1976 онд Хувьсгалт дээд зөвлөл -2010 оноос Ерөнхийлөгч	Холбооны парламент 1 танхимтай	-1961 оны анхны Парламентын засаглалтай улсын -1979 онд 1 намын тогтолцоотой улсын -2010 оны Үндсэн хуулиар Ерөнхий лөгчийн БНУ-ын	600.0
------------	-------------------	--	--------------------------------------	--	-------

* * *

Хавсралт 2

- Зарим улс орны төрийн хэлбэр, удирдлагын хэлбэрийг 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулбал :

№ Улсын нэр	Төрийн хэлбэр	Төрийн дээд эрхийг барих субъект	Парламентын танхимын тоо	Үндсэн хуулиа баталсан он	1 хүнд ногдох ДНБ \$/оор/2010/
1. Катар	Хаант	Султаан	1 танхимтай, хязгаарлагдмал эрх хэмжээтэй	1970, 2004	88232.0
2. Сингапур	БНУ	Ерөнхийлөгч	1 танхимтай	1959	57238.0
3. Бруней	Хаант	Султаан	1 танхимтай	1959	47200.0
4. БНХАУ	БНУ	КНам	1 танхимтай, байнгынбус ажиллагаатай, чуулганы чөлөөт цагаар Байнгын хороо ажиллана.	1954	7518.0
5. Дани	Хаант	Парламент	1 танхимтай	1849	36764.0
6. Норвеги	Хаант	Парламент	1 танхимтай, 2 хэсэгтэй	1814	52238.0
7. Швед	Хаант	Парламент	1 танхимтай	Нэгдсэн Үндсэн хуульгүй, Үндсэн хуулийн эрх бүхий актуудтай	37775.0
8. Чили	БНУ	Ерөнхийлөгч	2 танхимтай	1980	14982.0
9. Маврикий	БНУ	Парламент	1 танхимтай	1968	13214.0
10. Ботсван	БНУ	Ерөнхийлөгч	1 танхимтай	1966	15449.0

Жич :

Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг ОУВСангийн 2010 оны 12 дугаар сарын 15-ний мэдээнээс зэрэгцүүлсэн үнээр авсан болно.

* * *

Африк тивийн ардчилсан Конго Улс 68.7 сая хүн амтай, байгалийн баялаг ихтэй, 1960 онд тусгаар тогтносноосоо хойш Үндсэн хуулиа 9 удаа өөрчилсөн нь ихэвчлэн Үндсэн хуулийн байгуулал, сонгуульд оролцох намын тоо, парламентын танхимын тоо, хууль тогтоох эрх мэдлийн хэм хэмжээтэй холбоотой байснаас гадна үүнээсээ шалтгаалсан

цэргийн эргэлт, иргэний I, II дайны улмаас өнөөдөр дэлхийн хамгийн ядуу буурай орны тоонд хамрагдагдаж, нэг хүнд ногдох ДНБ нь 342 ам доллар байна. Эндээс хэн хождог вэ ?

Зөвхөн хөгжингүй баян улсууд, тэдгээрийн хөрөнгө оруулагчид л хождог нь бодит үнэн билээ. Улс орон төрийн тогтолцоогоо сольсноор хөгжил нь хурдасдаггүй, харин ч удааширдаг болохыг дээрх судалгаа нотолж байгаа юм. Тэгвэл улс орон өндөр хөгжилд хүрч болох нь баян, ядуу байхаас ч төдийлөн хамаардаггүй болохыг саяхан 1970-аад оны үед дэлхийн хамгийн ядуу улсын тоонд багтаж байсан Африк тивийн Ботсваны туршлага харуулж байна.

Ботсван Улс 1.9 сая хүн амтай, 600 мянган ам километр нутаг дэвсгэртэй, 1966 онд Их Британий колониос тусгаар тогтнож, Үндсэн хуулиа баталж, төр нь тогтвортой ажиллаж, эдийн засгаа авилгаас ангид хөгжүүлж чадсан учраас хөгжлийн хурдцаараа Азийн баруудаас түрүүлж, хөгжлийн түвшингээрээ Турк, Мексикийг гүйцэж түрүүлэн манай дэлхийн хамгийн өндөр хурдацтай хөгжиж байгаа улс гэж түүнийг Дэлхийн банкнаас үнэлсэн байна.

УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс « Дэлхийн улс орнуудын парламент » номыг бүтээж гаргасан судлаачид аливаа улс орон Үндсэн хууль, төрийн тогтолцоогоо тогтвортой хадгалж, эдийн засгийн хөгжлөө авилгаас ангид авч явж чадваас төрийн дээд эрх мэдлийг хэн барьдгаас үл хамааран хөгжил цэцэглэлд хүрч болдгийг хойт Европын парламент нь төрийн дээд эрхийг барьдаг хаант улсууд, Азийн Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг бар-орнууд, Арабын хэмжээгүй эрхт хаант засагтай орнуудын өндөр хөгжилд хүрсэн туршлага харуулж нотолж байна гэж дүгнэж байна.

Дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн байгуулал, парламентын талаархи судалгаанаас дүгнэлт хийхэд аливаа улс орны төрөөс хөгжил цэцэглэлд хүрэхийн тулд хийж гүйцэтгэж байгаа ажлын үр дүн нь ард иргэдийн бодит орлогын өсөлтийг хангаж, амьдралын түвшинг дээшлүүлж, эрх чөлөөтэй тайван амгалан амьдрах нөхцлийг бүрдүүлснээр л хэмжигддэгээс бус төрийн удирдлагын хэлбэр тогтолцоогоор хэмжигддэггүй бололтой.

БНХАУ эдийн засгийн нээлттэй бодлого явуулж, төрийн дээд эрхийг коммунист нам нь барьж байгаа бол Азийн Катар Брунейд төрийн дээд эрхийг Султан нь, Европын хаант улс болох Дани, Норвеги, Шведэд парламент нь, Сингапур, Ботсван, Чили зэрэг улсад Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьж байгаа ч эдгээр улс орнууд бүгд өндөр хөгжилд хүрч, ард иргэд нь амар амгалан амьдарч, төрөө дээдлэн хүндэтгэдэг байна.

Африк тивийн Маврикий 1.3 сая хүн амтай, байгалийн баялаг хомс, 250 гаруй жил Франц, Английн колони байгаад 1968 онд Их Британий хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүнд тусгаар тогтнолоо зарлаж, 1992 оноос Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, парламент нь төрийн дээд эрхийг барьдаг улс болж, эрүүл мэндийн аялал жуулчлал, мэдээллийн технологи, далайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт тулгуурлан улс орноо хөгжүүлсэний үр дүнд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ 13000 \$-т хүргэсэн байна.

Эдгээр нэр дурдсан улс орнууд төрийн хэлбэрийн хувьд өөр өөр, төрийн дээд эрхийг барьдаг субъект нь өөр өөр, хөгжлийн түүхийн хувьд ч өөр өөр хэрнээ дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй буюу өндөр хурдацтай хөгжиж буй орнууд мөн гэдгийг хүснэгт 2-оос төвөггүй харж болно.

Энэхүү харьцуулалтад тив, тивээс хамруулсан 10 улсын дотор нэгдсэн бичмэл Үндсэн хуульгүй 1, Коммунист нам нь төрийн дээд эрхийг барьдаг 1, хоёр танхим бүхий парламенттай 1 улс байна. Ерөнхийлөгч нь төрийн дээд эрхийг барьдаг 3, Парламент нь

төрийн дээд эрхийг барьдаг 4, Султаан нь барьдаг 2 улс хамрагдсан.

Улс орнуудад сонгож авсан тогтолцоогоо төрийн дээд байгууллагууд нь хэр зэрэг тогтвортой, зөв ажиллуулж чадаж байгаагаас тухайн улсын хөгжлийн хурдац хамаардаг болохыг энэхүү харьцуулалт нотлох бөгөөд ийм жишээ баримт өдий төдийг дурдаж болно. Ийм учраас Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиараа парламентын Бүгд Найрамдах Улс байхаа нэгэнт сонгож тогтоосон болохоор энэ тогтолцоог хэрхэн зөв сайн ажиллуулах вэ ? гэдэг дээрээ илүү төвлөрөн ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойшхи 18 жилийн хугацаанд Үндсэн хуульд Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн байж болох, Улсын Их Хурлын 76 гишүүний 39 нь хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор хүчингүй болгосон байтал 2000 оны 12 дугаар сарын 14 -ний өдрийн хуулиар Үндсэн хуульд энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулан мөрдөж байна.

Чухам энэхүү нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7,8-д заасан Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж, Үндсэн хуулийн төрийн эрх мэдэл хуваарилалтын тэнцвэрийг алдагдуулж, УИХ-ын шийдвэр гаргахад хүрэлцэхүйц 20 гишүүний үнэмлэхүй олонхийг Засгийн газрын гишүүд бүрдүүлж, Засгийн газрын дур зоригоор Улсын Их Хурлын шийдвэр гарах хүчин зүйл болж, Улсын Их Хурлын эзэлж байх ёстой орон зайг хомсдуулж, зарим хууль шийдвэр хөнгөн гоомой гарах нөхцлийг нээж өгсөн учраас Улсын Их Хурал, Засгийн газрын нэр хүнд олон түмний дунд унах шалтгаан болсоор байна.

Төрийн эрх барих дээд байгууллагуудын нэр хүнд унаад ирэхээр олон түмний дунд Үндсэн хуулиар тогтоосон төрийн тогтолцоо, төрийн байгуулал буруу байна гэсэн ойлголт гүнзгийрч, бүр парламентын гишүүдээсээ эхлээд сэтгүүлчид, энгийн иргэд ч Монгол улсад парламентын засаг тохирохгүй байна, Ерөнхийлөгчийн засагтай болмоор байна, парламентыг 2 танхимтай, эсвэл бүр хуучин 2 шатлалтай хэлбэрт оруулмаар байна гэсэн санал улам газар авсаар байна.

Зүй нь сонгуульд нэр дэвшигчдэд төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхийг ард түмэн өөрөө олгодог ухамсарлаж, алдаа оноогоо дүгнэж сонгуульд хариуцлагатай хандаж саналаа өгөх учиртай.

Төрийн эрх мэдлийн хуваарилалтад өөрчлөлт оруулан Ерөнхийлөгчийн засаглалтай боллоо гээд төсөөлье. Энэхүү дээд эрх мэдлийг хэн хэрэгжүүлэх вэ ? Мөн л намуудаас нэр дэвшүүлж, ард түмний сонгосон этгээд л хэрэгжүүлнэ. Цөөнгүй улс оронд энэхүү өөрчлөлтийг хийснээр нэг хүний дарангуйлал тогтсон жишгийг сүүлийн үед Арабын зарим орнуудад өрнөж байгаа улс төрийн үйл явц нотлон харуулж байна.

Саяхан МАН -ын даргаас парламент 2 танхимтай байх нь зүйтэй гэсэн мэдэгдэл хийснээр түүнийг тойрсон асуудал олон түмний дунд хэлэлцэгдэж эхлэв бололтой. Гэхдээ энэ бол зөвхөн л нэг мэдэгдэл, үүний цаана чухам ямар тогтолцоо юм бэ гэдэг нь тодорхой биш байна.

Хоёр шатлалтай (АИХ, УБХ маягийн) парламент юм уу, тийм бол хоёулаа байнгын ажиллагаатай юм уу, хуучны адил дээд шат нь байнгын бус ажиллагаатай юм уу эсвэл бүр сонгодог хоёр танхимтай парламент юм уу, энэ тохиолдолд хоёр танхим хоёулаа бүх нийтийн шууд сонгуулиар байгуулагдах юм уу, аль нэг нь шууд бус сонгуулиар байгуулагдах юм уу, дээд танхимын гишүүд бүхэлдээ буюу зарим хэсэг нь хуулиар заасан албан тушаал эрхэлж байсан (Ерөнхийлөгч, УИХ-ын дарга г.м.) хүмүүс байх юм уу гэх мэт олон олон

асуултын хариу тодорхой бус байна. Ийм байхад хэвлэл мэдээллийн хэрэгслээр хоёр танхимтай парламент гоё, мангуунууд нь цэцэн болно гээд шуугиулаад байгаа нь цагаа олоогүй мэт санагдана.

Төрийн хууль тогтоох эрх мэдэл нь иргэд, сонгогчдоос парламентын гишүүдэд шилжүүлж байгаа эрх мэдэл болох тул Үндсэн хуульд парламентын талаар оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, ард нийтийн дунд өргөн хэлэлцүүлэг, судалгаа явуулсаны дараа Улсын Их Хурал хэлэлцэх нь зүйд нийцэх мэт санагдана.

Хавсралт 1.2 -т авагдсан улс орнуудын бодит жишээ нь Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангах нь улс орны хөгжилд түлхэц болдог гэдгийг тодорхой хэмжээнд батлан харуулж байгаа бөгөөд Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллын талаархи хэм хэмжээг хэрхэн зөв хэрэгжүүлэх тал дээр сонгогчид, улс төрийн намууд, улс төрчид илүү ихээр төвлөрч, олон улсын байгууллагын судалгаагаар нотлогдож байгаа авилгын индексээ бууруулах дорвитой алхам хийж чадахгүй юм бол ямар ч төрийн тогтолцоо зөв үр дүнтэй ажиллах хөрс суурьгүй гэдгийг хавсралт 1-д заасан улс орнуудын туулж ирсэн замнал тодорхой нотолж байгаа билээ.

Энэхүү дүгнэлтийг хийхдээ одоо янз бүрийн байгууллага, хувь хүмүүсийн зүгээс төрийн тогтолцоогоо эргэн харах санал нэг бус удаа гарч, тэр ч бүү хэл зарим намаас Үндсэн хуулийн төсөл санаачлан нийтэлж, хэлэлцүүлж байгааг иш үндэс болгож байгаа юм.

Одоо тэгээд яах вэ?

1. 1992 оны Үндсэн хуулийн жинхэнэ эхийг сэргээж, Үндсэн хуулийнхаа дагуу улс орноо хөгжил цэцэглэлд хүргэхийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр хамтран зүтгэцгээе.
2. Төрийн өндөр албан тушаалтнууд авилга, хээл хахуулиас ангид байж, авилгаар биш ажил хэрэгч байдлаараа дараагийн шатныхандаа үлгэрлэе
3. Улс төрийн намууд улс орныхоо өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, сонгуульд нэр дэвшигчиддээ тавих шаардлагыг өндөржүүлж, хөрөнгө чинээгээр нь биш, төрийн холч ухаан, эрдэм чадал, ажлын туршлага зэргийг нь тэргүүн ээлжинд харгалзан шалгаруулдаг болъё .
4. Сонгогчид өнгөрсөн сонголтдоо дүн тавьж, өнөөгийн 5, 10 мянган төгрөгийг харгалзалгүйгээр саналаа хариуцлагатай өгдөг болъё.
5. Төрийн дээд байгууллагуудад сонгогдож, томилогдсон этгээд нь хувийн өчүүхэн эрх ашгаа хойш тавьж, улс орныхоо нийтлэг эрх ашгийг дээдэлж, Үндсэн хуулиа хэрэгжүүлэхийн тулд оюун бодлоо хөвчлөн чухамхүү чөмгөө дундартал зүтгее.

Үндсэн хууль өрчлөгдөшгүй мөнхийн хууль биш ч, өөрчлөлт нь сайн тал руугаа юу, осолтой тал руугаа юу гэдгийг нарийвчлан дэнслэх шаардлага юу юунаас чухал бөгөөд Үндсэн хуулийн аливаа өөрчлөлтийг зуун зуунаар дамжин хөгжсөн Үндсэн хуулийн онолын үндсэн дээр чухамдаа долоо хэмжиж, нэг огтлох зарчмыг иш үндэс болгон хийх нь зүйтэй байна. Бидэнд 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн балаг, түүнээс үүдсэн сургамж хангалттай байгаа шүү дээ. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

МЭДЭГТҮН, САХИГТҮН



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОРЬДУГААР ЗҮЙЛ, ЯПОН УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ҮНДСЭН ХУУЛИЙН
ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС ХАРЬЦУУЛАХ НЬ**

П. Амаржаргал (LL.M)

Энэ жил Монгол Улсад Ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ой тохиож байгаа билээ. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль нь манай улсын хувьд улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээний шилжилтийн эрх зүйн үндсийг тавьж, шинэ үеийн эхлэлийн суурь болсон гэдгийг хэн бүхэн мэдэх билээ. Харин Үндсэн хуулийн заалтуудыг ягштал мөрдөн биелүүлэхийн тулд түүний заалт бүрийн цаана байх үзэл баримтлал, түүхэн нөхцөл байдлыг ухаж ойлгох нь Үндсэн хуулиа нэг мөр зөв хэрэглэх, эрх зүйн тогтвортой байдалд чухал үүрэгтэй юм.

Иймд миний бие Үндсэн хуулийн гол үзэл баримтлалын нэг болсон эрх мэдэл хуваарилах онолын дагуу хууль тогтоох эрх мэдлийн үндэс болох Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийг Япон Улсын ижил төстэй заалттай харьцуулан авч үзэж, Монголын болон гадны эрдэмтдийн санаа бодол, судалгааны гаргалгааг харьцуулан тусгаж, өөрийн дүгнэлтийг хийхийг зорьсон болно.

Хууль тогтоох байгууллагын статус, бүрэн эрхийг улс төр, философи зэрэг нийгмийн шинжлэх ухааны олон салбарын хүрээнд судлан, шинжилдэг боловч миний энэхүү илтгэлд уг асуудлыг зөвхөн Үндсэн хуулийн эрх зүйн¹⁹ үүднээс авч үзсэн юм. Үндсэн хуулийн эрх зүйн судлах зүйлийн хүрээнд парламент, түүний бүрэн эрхийн асуудал голлох байр суурьтай байна.

Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн...” гэж заасан нь цаанаа ямар утга агуулга илэрхийлж байгаа, энэ нь эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэж байгаа эсэх асуудлаар эрдэмтэн, судлаачдын дунд маргаан дагуулсаар байна. Манай улсын хувьд Үндсэн хуулиа боловсруулахдаа гадаад улсуудын дэвшилтэт Үндсэн хуулиудыг өргөнөөр харьцуулан, хэрэглэх уламжлалтай билээ. Тухайлбал, 1924 оны анхны Үндсэн хуулийг боловсруулахад Япон Улсын 1884

¹⁹ Б. Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс 2006. 11 хуудас. Доктор, профессор Б.Чимид Үндсэн хуулийн эрх зүйг “1992 оноос хойш манай оронд Төрийн буюу Үндсэн хуулийн эрх зүйн ном зохиол элбэгшсэн нь талархан дэмжүүштэй үйлс мөн. Энэ хоёр ялгаатай ойлголт ч судлах зүйлийн хувьд нэлээд хэмжээгээр давхцдаг тул адилсах талаас нь авч үзэв” гэж тайлбарласан байна. Д.Солонго Төрийн эрх зүйн тайлбар толь, 2003, 133-134 хуудас, Доктор, профессор Д.Солонго уг ойлголтыг “Төрийн /Үндсэн хуулийн/ эрх зүйгээр нийгмийн суурь харилцааг зохицуулна. Төрийн /Үндсэн хуулийн/ эрх зүй нь гол эх сурвалж нь Үндсэн хууль бусад хуулиуд, Ерөнхийлөгчийн шийдвэр, Засгийн газрын акт, Үндсэн хуулийн шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ болоод нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын зарим эрх актууд мөн хамаарна” гэж тайлбарласан байна. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь. Улаанбаатар 2006, Нээлттэй нийгэм форум, НҮБХХ 130 хуудас,

Дараагийн нэг өөр хувилбар бол Үндсэн хуулийн эрх зүй гэж эрх зүйн салбарын тогтолцоонд гол байр эзэлдэг түүний нэг салбар шинжлэх ухаан юм. Үндсэн хуулийн эрх зүй нь тухайн иргэний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулах тогтолцоо, улс орны нийгэм эдийн засаг, улс төрийн байгуулал болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламж, төр иргэний нийгэм хоёрын харилцаа, түншлэл зэрэг асуудлын үндсэн зарчмыг тодорхойлж байдаг. Мөн эрх зүйн тогтолцооноос хамаарч өөр өөрөөр хэрэглэгдэж байхыг үгүйсгэхгүй юм. Тухайлбал Англи-Саксоны эрх зүйн тогтолцоонд “Constitutional Law” буюу “Үндсэн хуулийн эрх зүй”, Ром-Германы эрх зүйн тогтолцоонд “State Law” буюу “Төрийн эрх зүй” гэж нэрлэжээ. Энэ удаад би бээр Үндсэн хуулийн эрх зүйн нэр томьёогоор авч үзлээ. П.А.

оны Үндсэн хуулийн судалж байсныг судлаачид нотолсон байдаг²⁰. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 20 дугаар зүйлтэй төсөөтэй заалт Япон Улсын 1946 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд байдаг гэдгийг манай нэрт эрдэмтэд ч тэмдэглэж байгаа²¹. Иймд энэхүү хоёр заалтыг Үндсэн хуулийн эрх зүйн судлаачид хэрхэн ойлгон тайлбарлаж ирснийг дараахь байдлаар судалсан болно.

Юуны өмнө Парламентын талаар Үндсэн хуулийн эрх зүйн монгол эрдэмтэд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар²² -д Улсын Их Хурлын Тамгын газрын эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх Н.Тунгалаг нь хуулиар ард түмний хүсэл зоригийг илэрхийлж байгаа учраас төрийн эрх мэдлийн дээд байгууллага гэж тодорхойлсон байна. Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Солонгын Төрийн эрх зүйн тайлбар толь²³ Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэл, төрийн эрх барих дээд байгууллагыг ард түмнээс сонгогдсон төлөөллийн ардчилалтай холбон тодорхойлсон байна.

Энэхүү тайлбарууд 2003, 2009 онуудад хэвлэгдсэн бөгөөд одоог хүртэл ач холбогдлоо алдаагүй байна. Харин хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж²⁴ нь төрийн эрх мэдлийн хуваарилах онолын харилцан тэнцвэртэй, хяналт бүхий (checks and balances) зарчим нь зөрчилдөж байгааг одоогийн бодит байдлаар тодорхойлсон билээ. Ийнхүү уг асуудлыг эрдэмтэн, судлаачид өөр өөр өнцгөөс, олон талаас нь судлан дүгнэлт хийж буй нь харагдаж байна.

Япон Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлээр тогтоосон парламентын асуудлыг Үндсэн хуулийн эрх зүйн профессор Хироюүки Хата, Го Накагава, Япон Улсын Парламентын

²⁰ Японы Нагояагийн Их сургуулийн Олон улсын хөгжлийн сургуулийн докторант, Накамура Масаки. “Гадаад улсуудын Үндсэн хуулийн орчууллага ба Монгол Улсын анхны Үндсэн хуультай холбогдох баримт бичиг. Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” Хууль зүйн үндэсний хүрээлэн 2004. 71-74 хуудас

²¹ Б. Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс, 2006. 48 хуудас “Маргаад байдаг нэг заалт болох “УИХ нь төрийн эрх барих дээд байгууллага ... ” гэсэн томъёоллыг бичихдээ бид өөрийн уламжлалыг шууд тусгахын хамт Японы 1946 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд ийм заалт байдаг юм шүү гэдгийг ч хань татаж бодолцсон билээ. Ийм хандлага баримтласан нь засгийн нэгдмэл байдал (улс нэг засагтай байх)-ыг хангах, хүний эрхийг хангах үүднээс уг эрх мэдлийг тэрхүү нэг засгийн 3 салаа (“three branches of government”)-д Үндсэн хуулиар хуваах, хувиарилан тэнцвэржүүлэх хоёрыг ялгаж ойлгохыг хичээсэн ухаантай юм”

²² Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар хот 2011. 117 хуудас Эмхтгэн хэвлүүлсэн: Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, “Дэлхийн улс орнуудад төрийн эрх барих дээд байгууллага нь зарим тохиолдолд хоёр танхимтай, зарим оронд нэг танхимтай парламент хэлбэртэй байна. Олон улс орны ардчилсан хувьсгалын үеэр “хууль тогтоох бүтээх эрх”, “хууль тогтоох эрх”, “хууль хэвлэх эрх”, “хууль тогтоох бүрэн эрх” гэх мэт ойлголтыг буй болгосон юм. Эдгээрийг Үндсэн хуульдаа хуульчилан баталгаажуулжээ. Өөрөөр хэлбэл хууль гэдэг нь төрийн аливаа нэг зүтгэлтний хувийн хүсэл зоригийн илэрхийлэл болох ёсгүй билээ. Хууль бол иргэдийн нийтлэг хүсэл зоригийн илэрхийлэл билээ. Иймд ард нийтийн төлөөлөгчдийн байгууллагын институтыг төрийн эрх мэдлийн систем дэх улс төрийн дээд төлөөлөл хэмээн тодорхойлсон юм. Үүнээс төлөөллийн өөр институт байхгүй билээ. Манай Улсын хувьд парламент-Улсын Их Хурлыг нэг танхимтай, нийт хүн амын тоонд тохирсон, ард түмнээ төлөөлж эрх барих, хууль тогтоох байгууллага байхаар хуульчилсан юм”.

²³ Д.Солонго Төрийн эрх зүйн тайлбар толь 2003 139, 167 хуудас “...Ард түмнээс сонгогдсон, төрийн эрх барих, төлөөлөгчдийн дээд байгууллага”

²⁴ Н.Лүндэндорж Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал 2010 25-26 дугаар хуудас “Өдгөө Монгол Улсад төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарлан хэрэгжүүлэх бус, харин “төрийн эрх барих дээд байгууллага” төрийн дээд эрхээ дангаар эдэлж байна.” Дэлгэрэнгүйг энэхүү номноос уншина уу.

Төлөөлөгчдийн танхимын дарга Такехиро Ёокомичи болон Парламент судлаач, профессор Ханс Х. Байрвальд нарын тайлбарыг авч үзье.

Япон Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд Япон эх хэлээр:

第4章 国会

国会の地位 第41条国会は、国権の最高機関であつて、国の唯一の立法機関である

Англи хэлнээ хөрвүүлбэл:

Chapter IV. The Diet

Article 41. The Diet shall be the highest organ of state power, and shall be the sole law-making organ of the State.

Монгол хэлнээ хөрвүүлбэл:

Дөрөвдүгээр бүлэг. Парламент /The Diet/

41 дүгээр зүйл. Парламент бол улсын хуулийг дангаар тогтоодог, төрийн эрх мэдлийн дээд байгууллага юм.

Япон Улсын Үндсэн хуулийн эрх зүйн профессор Хироюки Хата, Го Накагава нарын тайлбар Хууль тогтоох байгууллага болон Төрийн эрх мэдлийн дээд байгууллага гэдэг ойлголтыг гарган тайлбарласан байна. Энэхүү тайлбартаа “хууль тогтоох цорын ганц байгууллага гэсэн үг ямар утга санааг илэрхийлж байна вэ? Тухайн үеийн Үндсэн хуулийн төсөл боловсруулагчид Эзэн хаанаас төрийн хууль тогтоох эрх мэдлийг салгаж, түүнийг Үндэсний засгийн газрын хүлээн зөвшөөрөгдсөн хууль тогтоох байгууллага болох парламентад шилжүүлэх “ухамсарлагдаагүй” төлөвлөгөөтэй байсан” гэжээ. Цааш нь “Төрийн эрх мэдлийн дээд байгууллага гэдэг нь мөн дээрхийн адилаар тайлбарлагдаж болох юм. Парламентын баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгох шүүхийн бүрэн эрхийн зүгээс авч үзвэл парламент нь заавал ч төрийн эрх мэдлийн дээд байгууллага биш болж байна.

Үндсэн хуулиар юуг дээд болгож байгаа нь парламентын хүсэл зориг бус Үндсэн хуулийн өөрийнх нь хүсэл зориг юм. Тэгвэл яагаад парламентыг төрийн эрх мэдлийн дээд байгууллага гэсэн бэ? Энэ нь өөрөө эрх мэдэл хуваарилах зарчмын эсрэг болж байна. Харин хуучин Үндсэн хуульд байсан Эзэн хааны бүрэн эрхт байдлын үзэл санааг хууль ёсоор үгүйсгэх гэсэн Үндсэн хуулийн төсөл боловсруулагчдын арга техник байсан байж болох юм.

Тэдний гол зорилго нь төрийн бүрэн эрхт байдлын аливаа эх сурвалжийг Эзэн хааныг үлдээлгүйгээр түүний дотор, хууль тогтоох эрх мэдлийн хувьд парламентыг хамгийн дээд бөгөөд хууль тогтоох цорын ганц байгууллага гэсэн түвшинд зэрэглэсэн явдал юм. Хэрвээ энэ үнэн бол төрийн эрх мэдлийн дээд байгууллагын эрх мэдлийг парламентад Үндсэн хуулиар өгөөгүй гэдэгт гайхах зүйл байхгүй” гэсэн байна. Үүнээс үзэхэд парламентын “төрийн эрх мэдлийн дээд байгууллага” гэсэн ойлголт нь “төрийн хуулийг тогтоох цорын ганц субъект” гэдэг талаас нь тайлбарласан байна.

Энэ заалтыг Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Такехиро Ёокомичи тайлбарлахдаа “Ард түмнээс сонгогдсон танхимын манай гишүүд нь улс төрийн хэлэлцүүлэг өрнүүлж, Диетийг “нээлттэй” бөгөөд ойлгоход “энгийн” болгож, манай ард түмний амьдралын алхам бүрт Япон орныг зөв чиглүүлэх хүнд хариуцлага үүрч байгаагаа байнга мэдэж байдаг” гэсэн байна. Ийнхүү төлөөллийн зарчимд үндэслэгдсэн бодлогын шийдвэр гаргах парламентын гишүүний үүрэг, хариуцлага талаас нь дээрх заалтыг тайлбарласан байна.

Парламентын гишүүдтэй ярилцлага хийх, парламентын үйл ажиллагаанд ажиглалт хийх

замаар Японы парламентын талаар судалгаа хийсэн, Япон Улсын улсын Парламент судлаач, профессор Ханс Х. Байрвальд нь энэ тухай судалгааны нэртэй өгүүлэлдээ “Парламент бол төрийн эрх мэдлийн дээд байгууллага” гэсэн Үндсэн хуулийн томъёолол нь Японы парламентын бодит бүрэн эрхийн тусгал биш юм гэж улс төр судлаачид төдийгүй Япон хүмүүсийн ихэнх нь үздэг” гэжээ²⁵.

Ийнхүү хоёр улсын Үндсэн хуулийн заалтын тайлбарыг харьцуулан авч үзэж дүгнэхэд:

Монгол Улсын төр, эрх зүйн түүх болон нийгэм, эдийн засгийн харилцаанд Үндсэн хуулийн эрх зүйн салбар чухал байр суурь эзэлдэг билээ. Аливаа улс орны Үндсэн хууль нь тухайн нийгмийн хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн байгууллын тогтолцоо, улсын эдийн засгийн үндсийг тогтоодог болно.

Аливаа төрийн эрх мэдлийн үндэс нь ард түмнээс эх үндэстэй билээ. Ард түмэн эрх мэдлээ өөрсдийн сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ. Энэ нь төлөөллийн ардчилал буюу ард түмнээс сонгуулийн аргаар эрх мэдлийг шилжүүлж авах хууль ёсны үйлдлийг ойлгоно. Энэ утгаараа эрх мэдлийн уг үндэс нь тэрхүү ард түмний төлөөллийн байгууллага Парламентад олгогдож болно. Гэхдээ нөгөө талаас үүнийг шууд утгаар нь Улсын Их Хурал бол эрх мэдэл хуваарилалтын 3 салаа мөчир дундаасаа дээд байгууллага нь гэж ойлгож болохгүй юм. Учир нь эрх мэдэл хуваарилалтын үүднээс хандвал “checks and balances”-ийн зарчмаар хандвал энэ нь тохирохгүй байна. Эрх мэдлийн гурван салаа мөчир хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд өөр хоорондоо харилцан хяналт, тэнцвэртэй байх зарчмыг алдагдуулах нэг үндэс болж болзошгүй юм.

Япон Улсын тухайд энэхүү Үндсэн хуулийн заалтыг тухайн үеийн түүхийн нөхцөл байдлаас хамаарах, мөнхүү Үндсэн хуульдаа заасан шууд утгаар ойлгох бус ард түмний хүсэл зоригоор ойлгон тайлбарлаж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл төлөөллийн ардчилал болон эрх мэдлийг субъектийн хооронд шилжүүлэх бодит шаардлага, түүхэн нөхцөл байдлын үүднээс тайлбарласан байна.

Монгол Улсын хувьд энэхүү Үндсэн хуулийн заалт нь шилжилтийн нийгмийн нөхцөл байдал болон шууд утга, өгүүлбэрээр нь ойлгох явдал түгээмэл байх бөгөөд “хууль тогтоох дээд байгууллага” байгууллага гэсэн утга агуулга байна уу, эсхүл төлөөллийн ардчиллын үүднээс тайлбарлах уу гэсэн хувилбарууд байна. Нөгөө талаас “төр хуулийг дээдлэх” үзэл баримтлалын үүднээс энэхүү “хууль”-ийг тогтоогч дээд байгууллага нь ард түмнээс хууль ёсоор эрх мэдэл шилжүүлэн авсан парламент болох гэсэн утгаар “төрийн эрх мэдлийн дээд байгууллага” гэдгийг ойлгон хэвшүүлэх нь зүйтэй болов уу.

2010 оны 12 дугаар сарын 23 -ны өдөр батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн”²⁶ 5.2.2-т заасны дагуу дээрх хорьдугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно” гэсэн байна. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын²⁷ 1.1.4. “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, *парламентын засаглалд суурилсан*, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн” гэж заажээ. Ийм тохиолдолд энэхүү Үндсэн хуулийн хорьдугаар зүйлийг зөв ойлгон тайлбарлаж, нэг мөр хэрэглэх зайлшгүй шаардлага байна. Хэрвээ энэхүү шаардлагыг үл ойшоох буюу

²⁵ Япон Улсын Үндсэн хууль. Орч. П.Амаржаргал. Ред. Н.Лүндэндорж, Ж.Оюунтунгалаг. Адмон хэвлэл 2011. 15 дахь тал.

²⁶ Hiroyuki Hata, Go Nakagawa, Constitutional Law of Japan, Kluwer Law International, (1997) 58-59 p

²⁷ http://www.shugiin.go.jp/index.nsf/html/index_e_message.htm. Япон Улсын Төлөөлөгчдийн танхимын албан ёсны цахим хуудас

хорьдугаар зүйлийг буруу ойлговол энэ нь Үндсэн хуулийн²⁸ 22, 25 дугаар зүйлүүдээр олгогдсон бүрэн эрхүүдээр улам лавширах боломжтой болно. Тухайлбал хорин тавдугаар зүйлд заасан төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх “онцгой бүрэн эрх” нь хэдийд ч шүүх эрх мэдэлд халдах, бидний өнгөрсөн туршлагаас үзэхэд хэн нэгэн таалагдаагүй байгууллага, албан тушаалтныг үзэмжээрээ авч хэлэлцэх боломж олгохыг үгүйсгэхгүй.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар баталгаажсан Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийг хэвээр хадгалж, харин 25 дугаар зүйлийн “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэсэн зүйлийг өөрчилснөөр Улсын Их Хурлын бүрэн эрхтэй холбоотой үүсч болох гажуудлыг засаж болно.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²⁸ Hans H. Baerwald, “Parliament and parliamentarians in Japan” Pacific Affairs, Vol. 37, No3., 1960 Autumn, 271-282 pp. University of British Columbia

**ҮНДСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ (1992) -ИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛСАН
БНМАУ -ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТАЛААРХИ ЗАРИМ ТЭМДЭГЛЭЛ²⁹**

(Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойд зориулав)

И. Ренчинханд, Г. Чулуун

- *Үндсэн хуульт ёсны үндсэн зарчим, үзэл санааны талаар Та бид тээр жил сүрхий ярилцаж билээ. Та санаж байна уу. Тэрнээс хойш уджээ. Хуучин танилтайгаа хуучин сэдвээрээ хэдэн үг сольвол ямар вэ. Зав боломж байна уу.*

Тийм, санаж байна. Тэрнээс хойш 10 гаран жил өнгөрчээ. Нээрээ, удсан байна. Бидний ярилцлагыг тэгэхэд гарчигласан зарим хүн, сүүлд, утасдаад юм хум яриад байж билээ. Надад хайчилбар нь байх ёстой. За, таныг сонсьё, та асуу. Би Үндсэн хууль батлах үйл явдалд оролцсон хүн биш, харин, түүнийг ойроос харсан хүнийхээ хувьд хир чинээгээрээ хариулахыг бодъё.

- *Үндсэн хуулийн 20 жилийн ойд өргөн тэмдэглэх төлөвтэй байна. Үндсэн хууль тогтоогчдын хөдөлмөрийг үнэлнэ сурталчилна гэж их ярьж бичиж байна. Сэтгүүлчдийн дунд бичлэгийн уралдаан хүртэл зарлажээ. Гэхдээн би уралдах гэж биш ярилцах гэж ирснээ хэлэх ёстой.*

Тэрийг харсан. Үндсэн хуулийн ололтыг товойлгоно гэж ирээд л бичсэн байна лээ. Ололтыг дөвийлгөх нь дутагдлыг хаацайлах санаа биш байгаа. (инээв). Миний бодоход, Үндсэн хуулийнхаа болж байгаа тал дээр нь бус, болохгүй байгаа хэсэг дээр нь хараагаа сайн тусгамаар санагддаг. Ингэлээ гээд, үндсэн хууль батлагчдын нэр сүр гутахгүй. Тэд гавъяагаан нэгэнт байгуулчихсан.

Зохиолч сэтгүүлч хүн захиалгаар ажиллаж таарахгүй. Дөчин хэдэн онд юм, маршалын 50 насны ой болж, эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэн (1908 - 1986), даалгавраар байж уу даа гэмээр, нэг ерөөл бичдэгийн. Тэрэндээ, “Таны насалсан тавин жил бол тайван цагийн мянган жилтэй тэнцүү” гэнгүүт л чойбалсангийн (төрийн) шан энгэр дээр нь под гээд унаад ирсэн гэдэг. Тэгэхэд нийгэм өөр байв. Дэлхийн дайн дуусаагүй шахуу, амны алдаа арван жилтэй, эрх чөлөө, элдэвийг ярилтгүй цаг байсан. Өнөөдөр тэгж болохгүй. Төсөөлиг хандлагын орших боломж өнөө хир байсаар байгаа бол, манайд, үндсэн хуульт дэг ёс сайн хөгжөөгүй, яагаачгүй байгаагийн шинж шүү дээ. Юун түүнийг товойлгох ...

- *УИХ –ын ажлын хэсгээс зохион байгуулж байгаа ажилд бид тал талдаа хүндэтгэлтэй хандах учиртай. Би яахав сэтгүүлч, та төрийн албан хаагч, аппаратад нь ажилладаг хүн. Хүний хэлснийг бид засахгүй.*

Үндсэн хуулийн өөрчлөлийн асуудал эхэлчихээд нилээн хүчээ авах маягтай байхад хуучныг нь магтаад гэх вий гэдгээс болгоомжлох нь бид зөв шүү. Парламентад конституцийг өөрчлөх чиглэлээр Ажлын хэсэг байгуулагдсан. Мөн, УИХ–ын Байнгын хорооноос энэ жил, Үндсэн хуулиа яах вэ гэдэг дээр олон нийтийн санаа бодлыг тандсан. Тэгэхэд, олны санаа Үндсэн хуулийг “өөрчилъё” гэж байгаа нь ил болно лээ. Саналын тоо 11000 дөхөөд байхад тоолсон дүнг харав. Тэнд, конституцийг хэвээр

²⁹ БНМАУ –ын Дэд ерөнхийлөгч бөгөөд УБХ –ын даргын дэргэд, туслах нь явсан, эдүгээ, УИХ –ын Тамгын газрын ахмад ажилтан, инженер Гончигдоржийн Чулуунтай Монгол Улсын Соёлын гавъяат зүтгэлтэн, “Өнөөдөр” сонины улстөрийн мэдээллийн албаны Ерөнхий редактор, сэтгүүлч - сурвалжлагч И. Ренчинханд ийн ярилцжээ. Ярилцлага тус сонинд “БУРХАНААН ШҮТЭЖ, ЗАРЧМААН ДЭЭДЛЭН ... ЗАСГААН ЗАЛЪЯ” гарчгаар нийтлэгдсэн. [Ред.]

байлгана; гэдгээр дөнгөж 2000 санал ирж байхад, “өөрчлөнө” гэдэг дээр нь, түүнээс олон дахин их, 9000 орчим санал бүртгэгджээ.

Төрийн албаны тухайд гэвэл энэ алба түмэнд үйлчлэх үүрэг зарчимтай, албан хаагч тангараг өргөдөг. Байгууллагынхаа санаачилсан ажилд идэвхтэй оролцохыг би үүргээн гэж үзнэ. Төр засгийн бодлогод биш, хэрэгжүүлэлтийн шатанд зүйл энд яригдаж байгааг хэлэх нь зөв биз ээ.

- **Үндсэн хуулийг хэлэлцэж батлах амаргүй даалгавар. Нийгэм цагийн байдал ч шуургатай байлаа. Тийм нөхцөлд хуулиа батлаад авсан нь амжилт юм, нэг бодлын. Ямар ч байсан хоёулаа түүнийг ололт талаас нь тунгааж харъя.**

Улстөрийн философи, үндсэн хуулийн эрх зүй өөрөө мэдлэг судалгаа шаардсан багтаамжлэг хүнд сэдэв. Малч, тариаланч, эмч, багш, хоньчин, барилгачин ... цоохор баг хүрч ирээд үндсэн хуулийг барьж аваад нухаж гардаг, бодож сэдээд зохиогоод унадаг тийм талбар биш. Гэхдээ тухайн үед өөр арга байгаагүй гэх үү дээ.

1990 онд монголын нийгмийн улстөрийн уур амьсгал лассалийн түймэрийн дараахь байдалд бараг орсон. Тун хүнд нөхцөлд конституцтай болж чадсан нь чиний хэлээд байгаа нэг ололт мөн байх. Яг агуулга руу нь өнгийгөөд үзэхээр дутагдал ихтэй ш дээ. Ой-мой гэж байхад тэрийг нь яриад байлтай биш ...

- **Лассаль гэж нэг их танил нэр байх чинь ... лассалийн түймэр гэж та юу хэлэв?!**

XIX зууны улстөрийн философч, Германы социал-демократ намыг үндэслэгч, Карл Маркстай ном хаялцаад байдаг Фердинанд Лассалийг, ялангуяа бидний үеийнхэн их төлөв мэднэ ээ. Нийгмийг эгшин зуур ямар ч хуулгүй болгож төсөөлсөн тэр суутны сэтгэмж, хялбаршуулсан тайлбар юм.

Аль нэгэн улс гүрэнд гэнэтхэн их түймэр дэгдээд бүх хууль дүрэм, түүн дотор Үндсэн хууль нь ч шатчихаж гэнэ. Баримтлах, хүн үзэх юм нэг ч үлдсэнгүй. Орон даяар нэг ч хуульгүй болсон ийм нөхцөл үүсвэл юу болхов. Бүхнийг тэгээс эхэлнэ. Юун түрүүнд, нийгмийн зохицуулалын үндсэн зарчмаа дахин шинээр тогтоох хэрэгтэй.

Парламент тал нь конституцийг бид хийнэ, бид хууль хийдэг байсан, цаашдаа хийнэ; гэж томров. Ерөнхийлэгчийн талаас, үгүй шүү, тэгэхгүй, тэгүүлэхгүй. Би төрийн тэргүүн, би зохион байгуулна; гэвэй. Засгийг газар - бид удирдаж байсан, бидэнд хүч нөөц цагдаа тагнуул ... бүгд байна, засгийн оролцоо - бололцоог хэн ч үгүйсгэх эрхгүй; хэмээв. Ерөнхийлэгч тэндээс, би бүх цэргийн ерөнхий командлагч, нөхцөл байдлыг би хянаж байна; гэж тодотгов. Гудамжид олон хүн бахиралдаж, хэн нь чухам хэнийгээ дэмжээд байгаа нь үл мэдэгдэнэ. Гадаахи тэд бие биедээ дайсагнасан нь илт ажаам. Ингээд зөвшилцөх ба байлдах гэсэн 2 -хон сонголтод талууд тулж ирмой.



К. Маркс & Ф. Лассаль

Үндсэн хууль тэгэхээр нийгэм дэх хүчний харьцааг тодорхойлсон баримт бичиг мөн байгаа биз. Энийг л хэлэх гэж их сэтгэгч ийм нөхцөл зохиомжилжээ. Талууд гар хоосонгүй

... энд тэндгүй зэр зэвсэг, буу шийдэм байгаа болохоор тэд эрхбиш зөвшилцөнө. Ингэх нь ашигтай. Нийгмээрээ бужигнаж байснаас нийлээд хэлцсэн нь дээр биз дээ. Эндээс, нийтийг төлөөлөх багийн хэрэгцээ үүсдэг.

Морин жилийн хувьсгал ... хувьсгал байсныг одоо дээр доргүй зөвшөөрөв. За, тэр яахав. Хамгийн гол нь, тэгэхэд, хуучин үндсэн хууль үндсэндээ үйлчлэх чадамжаа гээчихсэн, орлох юм алга байв. Одоо түүнийг бий болгох хэрэгтэй, заавал ... Ингээд хүчний тэнцвэржилийг хангах, лассалийн галыг унтраах бүрэлдэхүүн бий болгохын тулд, анхны ардчилсан сонгуулийг хийх хэрэгцээ арга буюу үүсч байгаам. Улмаар, жалга довны энэ тэр гэж хэлэн хэлүүлэн байж чухамхүү энэ л хэдийгээ (431 депутатыг хэлж байна) олоод, залаад аваад ирсэн.

Үндсэн хууль тогтоогчдын жинхэнэ гавъяа нь баталсан баримт бичигтээн биш, хэрэгтэй газар хэрэгтэй цагт байж өгсөнд л байгаа юм. Дандаа нэр хүндтэй сайхан хүмүүс. Эднийг хуралдаж байхад эх орон зүрхээ даран чагнаж байсан юм шүү.

- ***Хэрэгтэй газар хэрэгтэй цагт байх, гал сөнөөх ... гэв үү. Их сонин хэллэг юм. Энийг ялимгүй тодруулах уу?***

Ард түмэндээ “хэрэгтэй газар, хэрэгтэй цагт байж өгнө” гэдэг бол гарцаа байхгүй түүхэн гавъяа юм. Үндсэн хууль баталсан АИХ-ын депутатууд бол чухамхүү тэгсэн улс мөн. Энийг өөрөөр яаж тодруулхав. Лам Баасангаар жишээлье. Эцсийн дүндээ яв явсаар, шинэ үндсэн хуулийг та бидэнд гардуулж өгсөн [тэрхүү] ардчилсан хувьсгалын тэргүүн шугаман дээр, хэн байх нь хамаагүй, нэг лам тухайн үедээ үнэхээр хэрэгтэй байсан бөгөөд тэр нь бас эрүүлэлгүйгээр өөрөө олдсон байдаг юм, хөөрхий. Баатарлиг үйл. Бурхны “намын гишүүн” рүү буу шагайх ч амаргүй дээ. Ардчилсан хувьсгалд бурхны шашин [хүртэл] бусдын адил оролцсон юм, мөн чанар талаасаа бол ...

Гучин хэдэн онд, мянга мянган ламын эсрэг 1 нам дайрсныг яг таг сануулах гэсэн шиг, 90 онд, төмөр мэт сахилгатай төө улаан батлахтай бүхэл бүтэн намын сүлжээний эсрэг ганц 1 лам эрэлхэгээр “зогссон” нь ниймийн сэтгэлзүйд хүчтэй нөлөөлсөн. БааСан ламын гавъяа бааХан намын гавъяанаас нэг их дутахгүй дээ. Тэр хэрэгтэй цагт хэрэгтэй газар байсан хүн.

Тэмцэл бол урлаг юм даа, нэг бодлын. Тэгж тэгж, ойж бууж явсаар ... мандатгүй тэмцэгчийн халааг мандаттай тэмцэгчид залгаж авсан даа. Тоос манарсан тэмцлийн шинэ бөгөөд бүтээлч талбар нь засгийн газрын ордон дахь ардын хурлын чуулганы хуралдааны их танхим байлаа.

- ***Үндсэн хуулийг удаан хэлэлцсэн. Тэгэхэд та голцуу оройн цагаар, дээр лоожинд Улаанбаатар-Таймсын ерөнхий эрхлэгч, зохиолч, яруу найрагч Ү. Хүрэлбаатар нарын хавилцаа ганцаардангүй төрхтэй сууж харагддагсан. Үйл явцыг дэргэдээс нь, “дээрээс” ажигласан хүнийхээ хувьд тэнд байсан ажил хэргийн уур амьсгалыг нэг сайхан дурсаач. Үндсэн хууль батлагдахгүй сунжрах боломж байсан уу. Та юу хэлэхсэн бол энэ тал дээр?***

Уур амьсгал үнэхээр ажил хэрэгч байв. Өөрөөр байх боломжгүй байсан. Идэр гурван ес ид дундаа тачигнаж байхад, гадаа нэг үдэш, төв талбай пиг дүүрэн үймэлдэж, зарим хүнийг [нэр нь сонин биш] “огцор, огцор” гээл. Сүхбаатарын талбай өлсгөлөнтэй байв. Ардын Их Хурлын дарга гудамжинд явж байгаад хүн хард өшиглүүлсэн гэж [энэ тэр] дуулдаж л байсан. Үнэндээ, АИХ-ын дарга ч айхаар цаг байлаа. Улаанбаатарт, гадуур талх олдохгүй болчихсоныг санаж байна уу. Цагийн байдал тун эвгүй байв.

Гадна талаасаа энэ мэт дарамттайгаасаан болсон гэж хэлэхгүй. Депутатууд угаасаа аж амьдралын арвин туршлагатай, гүйлгээ сийрэг ухаантай, хамгийн гол нь, бүгд

тэмцэгч манлайлагч улсууд учраас, бүлэг фракцаа ном дүрмээр нь байгуулж авч байгаад, хонтоор дотроо хонзон санахгүй, их сайхан, тун нүсэр үзсэн дээ. Юм болгон дээр хүч хайргүй “нанчилдсаар” байгаад аажимдаа бүгд ядарчихсан юмдаг. Танхимд унтаж байгаа депутатыг олж харах энэ тэр бол сүүлдээ нэг их гайхаад байх үзэгдэл биш болж хувирсан.

Явсаар цагаан сар ч тулаад ирэв. Ар гэр, аав ээж, эхнэр хүүхэд, эгэл түмэндээ, “би ямар чадсангүй, бид барсангүй” гээд очилтой биш, нүүр халуун. Сүүлрүүгээ ч шударч өгсөндөө, хашрууд. Нээрээ, шинийн нэгэн шилэн дээр шилэн хундага аман дээр ирчихээд байхад “чиг зүггүй” мэтгэлцэж суух утгагүй. Ний нуугүй хэлэхэд, монголын үндэсний уламжлалт их баяр – цагаан сарынхаа ач буянаар бид чинь үндсэн хуультайгаа үлдэж чадсан юм шүү дээ. Тэгээгүй бол ч, ай мэдэхгүй ... надад тэгж санагдсан.



БНМАУ -ын Засгийн газрын ордон, Ардын Их Хурлын хуралдааны танхимд
Үндсэн хууль хэлэлцэж байгаа нь, 1991

1992 оны 1 сарын 13 –ны өдрийн бага үдэд монголын шинэ конституци батлагдсан. Цаашаа ердөө 4 –хөн хоноод байна уу даа, XVII жарны усан бичин жилийн хаврын тэргүүн сарын шинийн 1 тохиож, улс даяарын өргөн их золгуут эхэлсэн дээ. Ойр ойрхон бөх барилдаад, юм юм их сайхан таарсан.

- **“Чиг зүггүй мэтгэлцэх” ... та тэгээд АИХ –ын хуралдаан замбараа муутай, бүтээлч бус байсан гэв үү.**

Үгээр хүнийг ороох, үнэнийг мушгих муухай. Та арай тэгээгүй байх. “Учир начиргүй, чиг зүггүй ...” гэдгийн тухайд бяцхан талбар хийе. Депутатууд хэлэлцүүлгийн үед, заримдаа үнэнээс их хол байх шиг санагддагсан. Жишээ нь, улсын нэрийг оноох гэж бүтэн 2 өдөр “ноцолдоно” гэдэг бол асуудлын мөн чанарыг, мөнөөр нь зөв ухах чиг баримжаагаа тэд түрхэн зуурт бүрэн гэсний шинж юм.

Үнэнээс хол гэдгийн тухайд бол ... “БНМАУ”, “БНМУ”, “МУ” гэсэн гурван хувилбар дээр санал зөрөөд хурал гацсан байдаг. Гэтэл улсын нэрийн “яг зөв” гэмээр хувилбар нь, үндсэндээ хэлцүүлгийн хүрээний гадна үлдсэн байв. Таны алдар хэн бэ, гэхэд та Ренчинханд л гэж хариулна биз дээ. Түүн лугаа “улсын нэр” гэдэгт монголын иргэн бүр МОНГОЛ гэж товч тодорхой ганц үгээр хариулбал хичнээн сайхан байхав.

“Улс” гэдгийн тухайд бол бид түүнийг хэрэгтэй газар нь хэрэглээд, хэрэггүй газар нь гээгээд л явна шүү дээ. Алтан соёмбот монголын далбаа гэхэд бид “улс” гэхгүйгээр болж байна. Тэртэй тэргүй Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн нэгдүгээрт, монголыг ... бүгд найрамдах улс; гээд заачихсан байдаг юм.

Бүргэдийг бүргэд гэж нэрлэе, монголыгоо [зөвхөн] монгол гэж нэрлэе гэсэн уянгын халилтай алдарт үг, уг нь зааланд маш цоглог тод дуулдсан, харамсалтай нь, хэн ч түүнийг зохих ёсоор өлгөж аваагүй, гэх үү дээ. Олон хүн асуудал шийдэх хэцүү юм билээ.

Хоёр сар гаран хуралдаад сүүлрүүгээ 4 – 5 хүн тутмын 1 нь хуралдаа ямар нэг шалтгаанаар суухгүй байдал хавтгайрч, ирц хангах бас нэг айхтар зовлон нэмэгдэж, Уртнасан дарга үйлээ үзсэн. АНУ –ын конституцийг 29 хүн 18 хоногт баталсан бол, монголд түүнийг 430 гаран хүн 76 хоног хэлэлцжээ. Хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанарын асуудал их нарийн. Хууль тогтоомжийг олон хүн олон хоног бөмбөрүүлэхээр сайн болдог гэдэг худлаа, худлаа.

- **Нээрээ, хоорондоо өдөр шөнө шиг ялгаатай тоо байна. АИХ –ын хуралдааны хоног хугацаа нь хэтрээд, төсөв зардал нь багадаад, аль алийг нь байн байн нэмээд байсныг санаж байна. Ямар ч байсан төлөвлөсөнөөс нь их өөрөөр өрнөнө лээ.**

Үнэнийг харьцуулахгүйгээр мэдэх боломжгүй гэдэг билэв үү. Америкчууд хоёрын 2 төслийг хугас сар хэлэлцээд нэгийг нь амжилттай сонгосон байхад, бид ганц төслийг 3 сар шахам нухжээ. Хүн амын тоо эрс зөрөөтэй. Бид 15 дахин их хүчээр, 4 илүү дахин удаан ажиллаж, нэг хүнд ногдох ажлын бүтээмж багцаагаар 60 дахин бага гарч байна. Дээр нь, бүтээгдэхүүнийхээ чанарын асуудал нэмж яригдана.

Цаг үеэсээ хамаараад, америкчуудад харах юм бараг байгаагүй бол, бид, бөөн шипи [шпаргалка] -н дотор умбаж, онол номоор хангалттай зэвсэглэсэн байв. Тэдний хийсэн конституци бараг хэвээрээ гурав дахь зуунаа хэвнэг элээж байхад, манай хууль манийхаа үйлийг багагүй үзэж байна уу даа. Тэгээд, 10 жил ч тэссэнгүй, зарга маргаан ихтэй байна. Тэнд, америкчууд конституция баталчихаад, дараа нь, муж улсуудаараа нэгбүрчлэн “шалгуулж, зөвшөөрөл энэ-тэр гуйсан” бол, бид цагаан сардаа шахуулан барин хам хум амжуулсныгаа нийтэд ерөнхийдөө “тулгачихсан”.

Манай Үндсэн хуулийн зарим заалт жаран оныхоосоо ч дордсоныг би жишээлж хэлэхэд бэлэн байна. Ийм л байна даа, анд минь. За, чи сонс, тэд ба бидний хэн нь илүү чадсан, хэн нь дутуу чадсаныг хэлээд өг. Ил байгаа биз дээ.

- **Үндсэн хуулийн хүрээнд түгээмэл утгаараа хамаарахгүй асуудал гэж байх биш. Депутатууд “эвэр хошуут амьтан”, “сүүгүй шувуу”, “пиво онгойлгогч морь”, “хоёр эхнэр” ... гээд хожмын улс хальт сонсоод нүд нь орой дээрээ гармаар зүйлээр сүрхий маргадагсан. Зарим газар “гар зөрүүлсэн” ч удаатай. Та саяын хэлсэн тэр “2 эхнэрийн асуудал” –ыг уншигчдад бяцхаан тодруулж өгөөч. Би бол мэднэ.**

Хоёр эхнэртэй байж болох санаа хэнээс нь ч билээ, нэг эрээс гарсан. Бөөн маргаан. Хүмүүс ч хаа сайгүй инээлдэж, онигооны хэмжээний үгс чих дэлсдэгсэн. Ардын дунд зарим “сайхаан сайхан” гээд алгаа үрэх. Хурал тараад харьсан нэг депутатыг орой эхнэр нь байцааж гэнэ. Мэдээж, худал, сул үг байх. Эхнэр нь нөхрөөсөө “хоёр эхнэрийн санал батлагдсан бол чи тэгээд яах байв, тэрийгээ хэл” гэжүхүй. Залуухан депутат толгойгоо нэг илэмдэг болсноо “за даа, би ч хуулиа л дагана даа” гээд байсан гэдэг. Би хүртэл тэр агуу их хууль дээдлэгчийн талд байна аа. (Инээв)

- **Үндсэн хуулийг батлахад хамгийн их нөлөөлсөн төрийн зүтгэлтнийг нэрлэ гэвэл та хэнийг хэлэх вэ?**

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П. Очирбатыг нэрлэхгүй байхын аргагүй юм даа. Харамсалтай нь, Улсын ерөнхийлөгч Үндсэн хуулийг баталсан хүний тоонд ордоггүй. Депутатаар сонгогдож ирээд депутат биш болчихдог. Дэвшчихсэн. Хуулийг хууль тогтоох байгууллага баталдаг энэ тэр гээд ярихаар зэрэг чиг үүргийн зааг ялгаа гараад ирж байгаам. Нарийн учиртай.

Ерөнхийлөгч Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах Улсын Комиссыг ахалж байв. Үндсэн хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, удаа дараагийн шинэчлэгдсэн төслийн талаархи бараг бүх илтгэлийг БНМАУ –ын Ерөнхийлөгч П. Очирбат тавьж, ер нь, конституцитай холбоотой ихэнх ажил асуудал чухамхүү Ерөнхийлөгчийн тойронд эргэлдэж байсан даа.

Дашрамд хэлэхэд, депутат биш Улсын Бага Хурлын гишүүд ч үндсэн хуулийг, хэрэг дээрээ, баталсан улс. Болсон юмыг болсноор нь хэлэхгүй бол муухай. Энэн дээр одоо, хангалттай хугацаа өнгөрлөө, de jure явж de facto ирэх цаг болсон гэж бодож байна. Үнэнийг хэлэх хэлүүлэх хэрэгцээ үргэлж оршдог. Үндсэн хууль баталсан хүмүүсийн хичээл зүтгэлийг үнэлнэ энэ тэр гэж ярьж бичээд эхлэв. Тэгээсэй дээ.

Үйл явцад оролцсон хүмүүсийн нилээд нь өнгөтийн жамаар өөр ертөнцөд оджээ. Цаг хугацаа энэрэлгүй. Эгэж ирэхгүй эгнэгт одох томилолт эндээшигнээ улам ширүүснэ. Олон хүн байгаа биш, үүнийг, одоогийн, үгүйдээ дараагийн Их Хурал, нэг “тооцсугай” тогтоолоор шийдэх боломжийг авч үзэхэд болохгүй гэх газаргүй юм. Засаг талруугаа “өөрийн хүслээр биш” томилогдоод дэвшээд явчихсан зүтгэлтнүүд ч бий. Тэд өөрснөө энэ мэтийн жижиг сажиг юмыг тоож хэзээ ч сөхөхгүй шүү дээ.

• **Үндсэн хуулийн албан ёсны “эх баригч” гэж байсан гэдэг билэв үү?!**

Хүмүүс мэдэж байгаа даа. Үндсэн хуулийг зүйлчлэн хэлэлцэж эхлэхийн өмнө “Депутатын хороо” -г байгуулсан. УИХ ба УБХ гэсэн 2 байгууллага нийлээд ярихаар эрх ашгийн ч гэмээр юм уу, зөрчил, олон юман дээр үүсдэг бололтой харагдсан. УБХ –ын талаас, оруулсан “төслийнхөө эхийг барьж суух” хүнийг томилох санал оруулав. Уг нь, үндсэн хуулийн эцсийн хэлэлцүүлэгт орсон жинхэнэ төсөл Депутатын хороо (Ж.Гомбожав) -нд биш юм аа гэхэд, хуралдаан даргалагч БНМАУ–ын АИХ–ын дарга (Ж.Уртнасан) -ын гарт байсан байх учиртай.

Эх баригчийн асуудал яригдаж байх үед зарим депутат (жишээ нь: 287 дугаар тойргийн депутат Ч.Хурц) “Хурлыг, хурлын дарга өөрөө үймүүлээд байна. Депутатын хороонд УБХ–аас нилээн хэдэн хүн орсон. Тэд тэр эхийг бариад яваг л дээ, яагаад дэгэнд заагаагүй өөр юм гаргаж ирээд санал хураалгаад байна вэ. Замбараагүй байдал гаргахгүй байвал сайн байна” гэх зэргээр шүүмжилсэн.

Дашрамд тэмдэглэхэд, депутатуудын тэр хороо “санал бүрийг нягтлан үзэж, зохих өөрчлөлт оруулан Их цаазын төслийг эцэслэн боловсруулсан тухай илтгэл бэлдэх, шаардлагатай [бол] ажлын хэсэг байгуулж, холбогдох мэргэжлийн хүмүүсийг эл ажилд оролцуулах” тийм үүрэгтэй байсан. Эндээс ч харсан, депутатын хорооны тухайлсан чиг үүрэг өөр тийшээ салаад явчих ёсгүй мэт. Эхийг баригч ... эх баригч ... эрхзүйн талбарт эмнэлэгийн гэмээр хэллэг этгээд сонин сонсогддог.

• **Үндсэн хуулийг батлах бэлтгэл ажлын явцад манайхан гадны туршлагыг их судалсан. Энэ чиглэлээр хурал симпозиум бишгүйдээ л болж байв. Ингэхэд манай үндсэн хууль гадныхны баримт бичгийн орчуулга - хуулбар болсон гэх яриа хэр үндсэлэлтэй вэ?!**

Үндсэн хуулийн эрхзүй өөрөө онол номтой эд. Олон улсын түгээмэл эрх зүйн хэм хэмжээ ч гэж байна. Хүссэн хүсээгүй газар газрын ижил төрлийн хууль дүрэм, адаглаад

бүтцийн хувьд адил төстэй болох нь, эдүгээ, жам ёс шахуу юм. Гадны туршлага сэлтийг ч манайхан чамлахааргүй судалсан. Гэхдээ, яг аваасай анхаараасай гэхүйц тийм зүйлийг авдаггүй л юм даа. Яадаг юм бүү мэд. Авах юмаа авахгүй юм бол айлчлах ... судлахын хэрэг юун.

- **Авах юмыг авахгүй, авуулахгүй байж болно гэж үү. Үгүй байлгүй дээ. Депутатын амыг хэн ч үдээгүй ш дээ?**

Энд л “дундач депутат” –ын эрхзүйн мэдлэг мэргэшил “даруухан” байхын “хэрэг гарсан” ч байж болно ш дээ. Төрийн соёрхолт, жүжгийн зохиолч, нэрт найруулагч Л.Ванганы зөвлөгөө санаанд орчихлоо. Главлиттэй үеийн киночдын бүтээл ногоон гэрлээр батлагдах нь тун ховор. Зохиолыг нь танана хасна, авторыг нь зэмлэнэ донгодно, бүр цөлнө. Ийм хүнд нөхцөлд уран бүтээлчид юу эсийг бодох вэ! Зарим нь главлитыг “эвтэйхэн аргалах” санаатай, тэрийгээ ч бусадтайгаа хуваалцаж байсан болтой байдаг.

Яаж гэхээр, “найруулагч та бүтээлээ зоригтой хий, санаагаа айлгүй гарга, үгээн гүйцэд хэл, тэгээд хасагдах шүүмжлэлд өртөх тэр хэсгээ тайруулахгүй тануулахгүй авч үлдэхийн тулд зориуд хэд хэдэн газар илэрхий суртаалгүй загна, хормой хот үзүүл, тэгсэн цагт чиний кино чиний хийснээр үлдэнэ” гэсэн гэдэг. Худал газар чулуу хөөлгөх нохой үг.

Үндсэн хуулийн төслийн хоёр, гуравдугаар зэргийн асуудлаар хэт маргаж, депутатуудыг, хамаг тамираан барж байх тэр хооронд нийгмийн амьдралын амин чухал зохицуулалтыг хөндсөн том том асуудлууд хайнга буруу шийдэгдэх, огт хөндөгдөхгүй хаягдах явдал энэ тэр [бол] гарсан байхыг үгүйсгэхгүй. Авахгүй, авуулдаггүй; гэж хардахын үндэс энд байгаам.

Нийгэм өөрчлөгдсөн, марксизм ленинзмээсээ салж ядсан зурвас тэрхэн үед монголчуудын улстөрийн сэтгэлгээний “нийтлэг дундаж чадамж” ядмаг, эхлэлийн шатандаа байсан. Мэдлэг бол хуримтлагддаг эд. Хурааж хуримтлуулахад хугацаа хэрэгтэй. Өнөөдрийн өндөрлөгөөс өөрсдийхээ байсан байр байдал, хуучин оромыг эргэж хараад шоолоод шоглоод ичээд эмээгээд байх явдалгүй юм. Би тэр үеийн хурлын нэг депутатад нялзаж ногдох “эрхзүйн мэдлэгийн дундаж үзүүлэлт” -ийн талаар энд ярьж байна. Хүн яриагүй. Улс амьтан гомдох вий.

Шийдвэр гаргагчид маань тэр үед авах - оруулах тэр гадаадын туршлага юмаа, хөөрхий минь, зааж ч чадахгүй ш дээ, хуруугаараа. Мэдэхгүй юм чинь яахын. Энийг хэлэхэд надад сайхангүй байна. Шийдэж чаддаг нь [олонхийг хэлж байна] зааварчилж чаддаггүйн гачлант орчинд манай энэ үндсэн хууль бүтсэнийг би зориуд тэмдэглэн хэлмээр байна.

Тэрнээс хойш, цаг хугацаа хийдгээн хийж, нийгмийн сэтгэлгээ ... юм юм хувирч, байдал эрс өөр болов. Одоо Үндсэн хуулиа ахиад нэг сайн барьж авах цаг ирж байх шиг байна. Үүнийг эс анзаарвал алдана. Тэнгэр цэлмэг байхад, их сайхан арга зүйгээр ... тайван сайхан үзэх хэрэгтэй.

- **Юуг, жишээ нь, хаанаас авч болох байв. Тодорхой зүйл хэлж, хариултаа жаахан дэлгэрүүлнэ үү?**

Германд байдаг туршлага. Ард түмэн хууль санаачлах эрхтэй. Догь сонсогдож байна уу. Ийм мундаг эрхтэй түмэн олон тэр болгон жагсаал тэмцэл хийгээд байхгүй. Яагаад гэхээр, жагсахын оронд ажиллана биз дээ. Асуудлаа томъёолно, гарын үсэг цуглуулна. Энэ нь амар бөгөөд бүтээлч, бас найдвартай. Тэнд, ард түмний санаачилсан хууль

тогтоолын төслийг парламент нь оочергүй хэлэлцэх үүрэг хүлээнэ. Хэлэлцээд харин яаж шийдэх нь парламентын өөрийнх нь эрхийн асуудал байдаг. Энд, гайхамшиг нь юунд оршинов гэхээр, ард түмэн хүссэн асуудлаа парламентын хэлэлцүүлгийн сэдэв болгоод авч чадаж байна, тийм үү.

Өөр жишээ хэлье. Бас германых. Бослого гаргах эрхийн тухай юм. Ярихад жаахан тиймхэн байж магад, гэхдээ сонин шүү. Ийм эрхийг тэнд, үндсэн хуулийн эерэг заалтаар хангасан бөгөөд ерөнхийдөө, төрийн хууль тогтоомжийг үг дуугүй дагалгүй, бүр, түүнийг эсэргүүцэж болох тухай өгүүлдэг.

Германы үндсэн хуулийн 20 -р зүйлийн 4 дэх хэсэгт [тодорхой заасан] нөхцлүүдэд, хэрэв өөр арга хэмжээ авах боломжгүй болсон бол герман хүн бослого гаргах эрхтэй” гэж бий. Энэ заалтыг тэд 1968 онд үндсэн хуулиндаа оруулсан юм билээ.

Бослого гаргах эрх бол аливаа эрхзүйн зохицуулалтыг эрхчөлөөтэй харьцуулан хэмжих ёстой гэдэг; гаргалга - мэдлэгийн үр дагавар юм. Зарчим яваад байгаа хэрэг. Иймээс, Германы үндсэн хуулинд бослого гаргах эрхийг хүний эрхэд биш, харин, иргэний эрхэд хамааруулжээ. Бослого гаргах эрхийг бусад бүх арга хэмжээг авч болохгүй болсон нөхцөлд зөвхөн ultima ratio байдлаар, гадаад хүн биш зөвхөн герман хүн хэрэглэх боломжтой.

Бослогын хэлбэр янз бүр байж болно, хувь хүн эсвэл хамт олноор. Бослого хүчин төгөлдөр эрхзүйн зохицуулалтыг ч зөрчих боломжтой. Энэ үед гарсан гэмт хэрэг, эрхзүйн зөрчлүүд бослого гаргах [тэр] эрхээр хамгаалагдана. Үндсэн хуульт дэг ёс алдагдсаныг дахин сэргээх зорилгоор босогчид цохилт өгөх, [бүр] аллага үйлдэх [дарангуйлагчийг устгах] эрхтэй; гэх мэтээр бичсэнийг би уншиж байв.

- ***Хүний эрх, эрх чөлөөг дээдлэнэ гэдэг л энэ байх даа. Ёстой нөгөө киноны “аймаар чиг, бахархмаар чиг” гэдэг шиг ... тун жигтэй, нилээн сонсууштай ... сонжууштай юм яриад байна уу даа, та бид?!***

Тэгэлгүй яахав. Ухварлаваас, ингэхгүйгээр төрийг аажим аажмаар улам бүр харгис догшин авиртай болж хувирах тэр аюулаас урьдчилан сэргийлэх боломжгүй; ч байж мэднэ. Миний зохиосон дажгүй нэг үг байгаа. Тэрийг чамд хэлье. “Хүн хүнээсээ айх сэтгэхүй төрийг үүсгэжээ, хүн эргээд төрөөсөө айгаад ирэхээрээ үндсэн хуулийг сэдэжээ” гэж. Үндсэн хууль бол төрийн эрх мэдлийг хязгаарлах, түүнийг “айлгах” үүрэгтэй баримт бичиг шүү дээ. Дотроо “бослогын эрх” -тэй ямар ч үндсэн хууль, чанарын зэргээрээ “бусдын дор” орохгүй.

Конституци өгүүлэмжээрээ бослогыг зөвшөөрөх нь “босоод бай” гэсэн уриа дуудлага биш, харин, засаг төрийн [хэрээс хэтэрсэн] муу авир, мулгуу ажиллагаанд хязгаар тогтоож, хориг тавьж байгаа хэрэг юм. Нэг ёсондоо энэ нь, үүрэг хүлээсэн субъектийн зүгээс, нийгмийг бослого гартал ур-дүйгүй удирдах, харгис хэрцгий загнах боломжийг хаах нэг төрлийн албадлагын механизм ажээ.

Ингэснээрээ, тэдний конституци, талуудын эрэмбийг нэгмөр хөдөлгөөнгүй зааж өгөн, засаг төрийн орой дээр германы ард түмнийг гүн хүндэтгэлтэйгээр тавьж [залж] байгаагаа, зарчмын хувьд, төгс илэрхийлсэн гэж үзнэ.

- ***Ердийн ухамсрын төвшиндөө яриа маань нэг л хуулиас дээгүүр, хууль давсан тийм зүйл рүү ячих гээд байна. Уншигч будилах вий. Тэгэхээр, манайхны хуулийг дээдэлнэ гэдэг зарчим, тэнд, германд байдаггүй болж таараа уу?!***

Үндсэн хуулийн 17 -ийн 1-1 –д заасан ёсоор монголын иргэн хууль дээдлэх үүрэгтэй. Дээдлээд зогсохгүй бүр ёсчлон биелүүнэ; гэсэн. Мөн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд

хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны зарчим гэж бичсэн байгаа. Хуулийг иргэн зөрчвөл, асуудал ойлгомжтой, цагдаа ирээд ёсолно. Гэтэл, засаглал талаасаа, жишээ нь, хууль тогтоогчид Үндсэн хуулийг зөрчин гажуудуулбал, хэн хэзээ яах ёстой вэ. Үнэхээр зарчмын асуудал энд хөндөгдөж байна.

Германд үүнийг зохицуулсан [нилээн захын гэмээр] нэг хувилбарыг нь бид сая цухас хөндлөө. Төрийг бослогоор хүртэл “айлгаж” болдог байх нь. Юунаас ч айхгүй субъект их аюултай, амархан завхардаг. Б.Ренчиний “Мангаа Доо –гийн эцсийн зүүд” өгүүллэг хэлмэгдүүлэгч мангасын тухай юм. Төр нь мангас байв уу, түшмэл нь мангас байв уу гээд яривал дуусахгүй урт яриа болно.

Тухайн асуудал дээр, тэдний зарчим тодорхой байна, манай зарчим бүрхэг, байхгүйтэй адил байна. Ер нь бол тал талдаа бид хуулийг биш, зарчмыг дээдлэх учиртай юм аа. Зарчим, зарчим, бас дахин зарчим.

Үндсэн хууль бол үндсэндээ зарчим тодорхойлсон баримт бичиг мөн. Дээд зарчим. Зарчимд нийцээгүй хуулийг юун дээдлэх, харин ч эсрэгээр түүнийг “урж хаяад” үтэр түргэн өөрчлөх ёстой. Тэгэхгүй бол нийгэмд гай тарина. Хуулийг биш зарчмыг ... эрхзүйг дээдэлсэн тэр цагт монголд эрхзүйт нийгэм зохих ёсоор хөгжин төлөвшинө; гэж боддог. Энүүхэндээ гэж хэлэхэд, юм их хол байна аа.

- ***Таны дурдсан гадаадын туршлага жишээ тун догь юм, сонсоход. Өөр агууштай хаана юу байна?!***

Аль болгоныг энд дурдахав дээ. Араг савар нийлүүлж сураагүй хүнд бол бүх газар аргалгүй, харин, түүж чаддаг хүнд бол аргалгүй газар ч аргалтай; гэж ээж минь багад хэлдэгсэн. Хэрэгтэй юм хаа сайгүй зөндөөн бий. Бүр, бүдэрч унахаар элбэг байгаа.

Өөрийхөөнийг бий болгохгүй, бас хүнийхийг “тоохгүй” хоосон сууна; гэдэг их өрөвдөлтэй зан. Бид энд гадаадын туршлагыг авах тухай ярьж байна. Авах нь хүртэл учиртай. Шууд хуулж болохгүй, хоосон хэлбэрдэлт болно. Агуулга талаас нь харж, үзэл санааны үүднээс “ойлгож” авсан юм л монголын хөрсөн дээр бууж сая нутагшина ... үрэл жимсээ өгнө ш дээ.

Америкийн үндсэн хууль ~230 жилийн настай. Түүнийг дэлхийн анхны бичмэл конституц гэдэг. Бенжамин Франклин (1706-1790), Жеймс Медисон (1751-1836) ... зэрэг их сэтгэгчдийн гараар орсон тэр гайхамшигт баримт бичгийн үзэл санаа ер нь “төгс” талдаа шүү. Тэнд, “ард түмний эрх ашгийг хохироох чиглэлд үндсэн хуулийг тайлбарлаж болохгүй” гэж заасан нь хүртэл бий.

Ийм хязгаарлалт тавиад өгөхөөр зэрэг, конституцийг хэн тайлбарлах нь нэг их сонин биш болоод явчихаж байгаам. Манайд болохоор, чи би гэлцээд “наян юм болно”, хэн тайлбарлах нь тодорхойгүй, ил биш, ойлгомжгүй, эзнийг нь олох гэж таавар таах хэмжээний юм болно ш дээ. Гэх мэтээр, бид авмаар авмаар юмыг [арай ч зориуд биш байх] авахгүй байх шиг санагддаг. Би хуульч биш болохоор алдаж байж ч мэднэ.

- ***Манайд тэгээд, үндсэн хуулийг хэн талбарладаг болж таараав. Дээд шүүх үү?***

Дээд шүүхэд тийм эрх өгөөгүй. Өгөөгүйгээн хэлсэн. Дээд шүүх тайлбарлахгүй. Гаргасан хуулиа өөрөө тайлбарлах нь, зарчмын үүднээс, ёс бус. Тэгэхээр, парламент бас биш. Тэгээд хэн байж таарах вэ. Онъсого л нэг ийм байдаг даа. Ухварлаваас, манайд Үндсэн хуулийн цэц, хэрэг үүсгэн хянан шийдэх явцдаа, конституцийг [дам] тайлбарладаг; гэж хэлж болно.

Парламентаас баталсан хууль тогтоол конституцид нийцээгүй байна; гэсэн сэдэлтэй 70 гаран маргааныг Үндсэн хуулийн Цэц хянан хэлэлцсэн байдаг. 2008 оны бололтой тоо юм билээ. Одоо мэдээж нэмэгдсэн. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүд тусдаа эмхтгэл товхимол болоод гарсан байдаг.

Үндсэн хууль албан ёсоор тайлбарлагддаг байх нь өөрөө бас хөдөлгөөнгүй том зарчим шүү дээ. Үүнийг тодорхойгүй хаяж яаж болох вэ. Манайхан юу хаячихсаныгаа ч мэдээгүй болтой харагддаг. Аливаа конституцийн тайлбар уг хуулийнхаа салшгүй бүрдэл нь болдог. Тиймээс, тэрийг нь, “Үндсэн хуулийн хүчинтэй” гэж хэлдэг бичдэг болов уу.



Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат хэсэг депутатын хамт

Үндсэн хуулийн цэц өнгөрсөн хугацаанд олон асуудал эцэслэн шийдсэн. Тэгэхээр, батлагдаад яг 20 жил болж байгаа [хуучин] үндсэн маань агуулгын хувьд үлэмж баяжжээ. Түүний “үнэн бодот хэмжээ” –г үг үсэг талаас нь, бид өнөөдөр яг таг хэлж мэдэхгүй тийм байдалд хүрчихээд, бүр орчихоод байна. Байдал ийм байхад магтаал ярих дэндүү утгагүй.

- **Улсын Их Хуурал хууль батлан гаргах замаар үндсэн хуулийг талбарладаг гэж би дуулсан. Тэр таныхаар бол худал үг байх нь ээ дээ?**

Оргүй худал үгэнд бүү үнэмш. Тэгж болдоггүйн зарчмын үндсийг сая би хэллээ. Монголын бүх хууль, ухаандаа тэгээд, бүгд үндсэн хуулийн тайлбар байж таарах нь уу гэж танаас эргүүлж асуумаар байна. Тийм юм байхгүй. Нөгөө оньсогыг тааж чадахгүй будилж сандарч, үнэнийг хэлэхэд мухардаж байгаагийн нэг тод жишээ юм уу даа.

Монголын үндсэн хуулийг тайлбарлаж [үндсэндээ] болдоггүйг би хэлсэн. Тиймээс, манай энэ үндсэн хууль конституц мөн үү биш үү энэ-тэр гэж эргэлзэхэд хүрэх нь ч бий. Үндсэн хуулийн тайлбар конституцийн [тухайн нэг] бүрхэг заалтыг нэгмөр ойлгож болохоор тодруулж өгөх тусалдаг. Үндсэн хуулийн тайлбар чинь үндсэн хуультайгаа зөрчилдөх боломжгүй эд шүү дээ.

Харин, хууль, хуулийн агуулга үндсэн хуультай зөрчилдөх явдал элбэг. Хуулийн агуулгын конституцид харшилсан утга зөрчлийг илрүүлж, засч болно. Тусгай механизмтай. Тэгэхээр, үндсэн хуулийн тайлбар ба ердийн хууль хоёрын хооронд зарчмын ялгаа байна гэсэн үг. Энэ ялгааг олж харахгүй, харахыг ч хүсэхгүй, тэгээд муйхараар зүтгэнэ гэдэг бол, дарууханаар зүйрлэхэд, даншигийн алдарт бөх өрөөсөн нүдэндээ үүлтэй “бүрхэг дэндэв”-ийг бүрхэг талаас нь дайрах лугаа адил жудаггүй муу үйлдэл мөн биз ээ.

Энэ юу ч биш. Бидний ам дамжуулан хэлцдэг өөр нэг худал домог бол гараар барьж нүдээр үзэж болдоггүй “төрийн хар хайрцагны бодлого” юм. Хаана байна тэр будаг нь холцорсон модон хайрцаг, хайрцган дотор хэн хэний, хэдэн онд бичсэн, хичнээн дэвтэр юу байна, үзье - харъя, гэхээр, “байгаа” гээд хавьтуулахгүй. Байхгүй юм чинь өөр яахын. Ямар ч бодлоггүйгээн нуух нэг арга юм даа.

Домогт өөрөө бүрэн итгэчихсэн, тэгээд зогсохгүй бусдыг ухуулаад, уран цэцэн яриад, улс амьтныг төөрөгдүүлээд, тэр чинээгээрээ нийгмийг “хорлоод”, бас болоогүй ээ, тодроод явдаг хүмүүстэй тэмцэх бараг боломжгүй юм. Олон. “Бүх нийтийн дээд боловсрол” -оос улбаатай ч байж мэдэх, монголын өнөөгийн нийгмийн нэг гай гамшиг – энэ мөн. Ярих ч юм биш.

Монголчууд домгийн сэтгэлгээтэй ард түмэн. Худал юманд их итгэнэ. Байхгүй юмыг байгаа мэтээр, эсхүл эсрэгээр, гөрдөхдөөн үнэн дадамгай. Үндсэн хуульд, түүнийг, УИХ тайлбарлана гэсэн бичвэр хаана нь ч байхгүй ш дээ. Яаж тэгж мэлээж чадаж байна вэ. Алсдаа муу даа. Бүрхэг дэндэв бүрхэг талаасаа дайраад байгаа хүнийг хааяа байя гэтэл нь, их чанга хаядаг, бүр майхны гадсан дээр шидчихдэг байсан гэдэг, еэ базарваань.

- *Үгүй тэгээд таны энэ хэлээд байгаа англи америкийн жишиг чинь, хүнд юм бодуулахаар, чихэнд цаагуураа чимэгтэй юм гээч. Улстөрийн гүн сэтгэлгээний чиглэлд агууштай анхаарууштай өөр юм их байдаг байх даа. Философ талруугаа асуулт шүү. Гадаадын туршлага гэсэн утгаар асууж байна л даа?*

Миний хэлэх дуртай үг бий. Хуулийг биш зарчмыг дээлэх, төрийг биш бурханыг шүтэх учиртай; гэж. АНУ–ын Ерөнхийлөгч библийн сударт “залбирч” байгаад тангарагладаг. Манайх Үндсэн хууль дээрээ гараа тавьдаг бил үү. Энэний цаана маш том үзэл - ялгаа явж байдаг гэж хэлж болно.

Тэндэхийн төрийн тэргүүн бурханыг дээдэлж байгаа бол, манайд, шилжсэн утгаараа, төр өөрийгөө бараг бурхан гэж үзэх гээд байгаа мэт. Гарын доорхи юм гарын доорхи л юм байдгийм билээ. Үндсэн хуулийг өөрчлөх нь үдийн хойно өмнийн шахуу хялбархан ажил болохыг бид нэгтгээ харсан даа. Нөгөө 7 өөрчлөлтийг хэлж байна. Барьцгүй.

Монголын Үндсэн хуульд, төр шашныг хүндэтгэнэ, шашин төрийг дээдэлнэ, гэж (9.1) заасан. Шашин гэдгийн цаана бурханыг дээдлэх үзэл санаа оршин байдаг гэвээс монголын засаг төр хэт өндөрт үүлэн цаана байгаа хэрэг шүү дээ. Төрийн нэг институцийн дээр хөх тэнгэр байдаг мэтээр ярих нь, монголд [бол] их цэцэн мэргэн үгэнд тооцогддог юм даа.

Үндсэн хуульд, монголын төр өөрийгөө (хэн нэгнээр) дээдлүүлэх “эсийн төвшний” мөрөөдөлтэй байдгаан яг таг тас нууж бас чадаагүй, тэрийгээ, энд, 9 –ийн 1 –ээр ил гаргасан. Булавч бултайдгийн үлгэр юм уу даа.

- **Төрийн тухай ярьж байснаа шашны талруу хазайчихлаа. Ингэхэд шашны зорилго юу вэ, хүн яагаад шашин шүтдэг вэ?**

Асуултад би сүүлээс нь эхэлж хариулъя. Хүн гэдэг амьтан гарвалын хувьд цэвэр 100% энэ ертөнцийн бус, олдмол, хагас олдмол бололтой байж магад; гэсэн. Нэвтрүүлэг энэ тэр [бол зөндөө] байдаг. Хүн яагаад шашин шүтдэг вэ - Харь гарагийн шахуу амьтан чинь зөн совингоороо тэнгэрийн хамаатнаа янз бүрээр бодно биз дээ. Энд л сая бурхны хэрэгцээ урган гарч ирж байгаам, түүнд. Далд мэдрэхүйн асуудал.

Хүн энэ ертөнцийн бүх амьтанаас ганцаараа хэтэрхий ондоо. Айдас бодрол ихтэй. Төрөл арилжаад ч болов хаанаас ирсэн тийшээгээ буцна, харина, гэж мөрөөддөг болов уу. Тэгээд хойд насандаа очих тэр газраа бурхны орон гэж нэрийджээ. Иймээс шашны хэрэгцээ цаанаасаа хүнд [нэг тийм] заяамал шинжтэй. Төр дээдлэх үзэл бол, олдмол, хожуугийн, олон зуун жилийн турш үргэлжилсэн цэргийн дарангуйллын ул мөр байх аа, би тэгж боддог юм.

Харин, шашны зорилгын тухайд, за байз, юу гэж хэлье дээ. Равжай хутагтад нэг үг бий. Галавшанхай сургаалд нь байдаг юм. “Жан шамбалын оронд номын хүчээр учирна” гэж. Хэнтэй тэр вэ - бурхантай л болов уу. Номын хүчээр гэж юуг хэлнэв - гэрээрхийг хэлээ болов уу. Гэгээрнэ гэж юу вэ – хүн шуналгүй болох, бүх төрлийн шуналаас ангижрах ...

Шуналгүй хүнээс муу үйл гарахгүй, бага гарна. Муу үйл хийхгүй байгаа нь өөрөө сайн үйл мөн. Бас дээр нь нэмээд зориуд сайн үйл хийнэ, асарна тэтгэнэ, өгнө тараана, мөргөнө сүслэнэ. Эд бүгд нийлээд буян болно. Буян хийхээр хойд насандаа жаргана. Диваажинд очно. Диваажин бол бурханы орон. [мөн үү] Ингээд харахаар зэрэг таны эхний асуултад хариулчихаж болмоор санадаад эхэлж байна шүү.

Буян хийлгүй, нүгэл хийгээд байвал юун диваажин ... бүр өөр газар луу тууна. Шашны зорилго нь бүх хүнийг буяны ариун мөр хөөлгөж диваажинд очуулах, эцсийн эцэст, “гэрээд нь” нэг их төөрүүлэлгүйгээр эсэн мэнд буцаах явдал юм. Шашин бүх хүнийг диваажингийн зам руу хашиж өгдөг. Жаахан жаахан албадна, арваннайман тамын орноор айлгана. Аюуш тамын ероолд юу болдогийг харуулна, номлоно. Тэгэхээр, шашин номлол нь хатуу орчлонг зөөллөх, хүний хорвоог ариусгах цорын ганц зорилготой. Утгаан цаагуураа хүнийг хүнээс нь хамгаалах гээд байгаа юм.

Засаг гэдэг субъект нийгмийн шударга ёсны төлөө оршдог. Мөн л, хүнийг хүнээс нь хамгаална гэсэн үг ш дээ. Дээр нь нэмээд, Үндсэн хууль хүнийг төрөөс [өөрөөс нь бас] хамгаалдаг. Монголын засаг төр улам бүр гэгээлиг, шашинлиг, хүнлиг, иргэнлиг, нигүүлсэнгүй, сайн сайхан болоосой гэж хүсдэг хүндээ би. Товчоор үүнийг, БУРХАНАА ШҮТЭЖ, ЗАРЧМАА ДЭЭДЛЭН ... ЗАСГААН ЗАЛЪЯ гэмээр юм уу даа.

- **Та ингэхэд шашны философ сонирхдог хүн юм аа даа?**

Үгүй үгүй. Би зүгээр гарт таарсан ганц нэгэн юм уншиж байснаас цаашгүй. Молан тойн эхийн ачийг хариулсан судар, Эрдэнэчойжид дагинын намтар энэ-тэрээс хэтрээгүй, харанхуй хүн ш дээ. Гэхдээ муугүй уншигч байх аа. Чойжид дагинын тууж “мунхагийн харанхуйг гийгүүлэгч билгийн зул оршвой” гэж эхэлдэг гээд бод доо. Орон бүхний пурилтаараас олон хувь илүү, утга уянга төгөлдөр сайхан үг дээ. Сурвалж бичиг бүхэн агуу ...


- **За хоёулаа зарим зүйлийг зүгээр сайхан дурсъя. Үндсэн хуулийг батлах үед сонин содон учрал тохиол бишгүй таарч байсан байх. Хөгтэй хөгжөөнтэй, бодууштай санууштай болсон явдал ярих боломж байна уу.**

Эрхэм депутатууд заримдаа бие биенээ элдвээр хэлнэ. Хуралдааны явцад тэгж байсан нь хожмын өдөр тэднийг харин ч бүр ердийнхөөс нь илүү нягтруулж нөхөрлүүлдэг болов уу гэмээр харагдсан. Хэн нэгний үг хэлсний хойно, дараагийнх нь босч ирээд, саяын тэр галзуу хүний үгийг бүү тоо; гэж уриалах [энэ-тэр] бол наад захын ялигүй явдалд тооцогдоно. Манай энэ “иргэн Ла” [39 дүгээр тойргийн депутат Дондовын Ламжав] лав тэгж байсан болтой байна лээ. Би протокол харсан.

Баянаа [аварга] депутат “би суух дасгалгүй хүн юм байна, надад хөдөлгөөн дутаад тун берк байна, нааш цааш зөөх бичиг сачиг байвал тэрэнд би явъя” гэж хэлээд “таагүй байсан” заалны уур амьсгалыг эвлэгхээн гэгч инээдээр эмчлээд авч байв, нэг удаа. Аваргыг тэгэхэд би их “бүдүүн ширхэгтэй”, тун нарийн ухаантай, торгон мэдрэмжтэй мундаг сэтгэлзүйч юм; гэж харсан даа.

Баабарын үүтгэсэн “ярьдаг бөх” гэсэн ёж хэллэг саяханых. Тэр үед ийм үг гараагүй байсан. Энийг бодосхийж хэлэхэд, Баянаа депутат бол ярихдаа ч гаргуун, явахдаан ч тэмүүлэмтгий, үнэхээр зүүний магнай, зууны манлай бөх дөө. [Ярилцагч тэмдэглэлийн дэвтрээ сөхөж, өөрийнхөө 20 жил “хадгалсан” 2 шадыг уншиж сонирхуулав]

Үндсэн хууль тогтоогчдын нэг, улсын далай даян дархан дайчин, олныг баясуулагч их аварга, БНМАУ -ын АИХ –ын депутат Хорлоогийн Баянмөнх –д



Баян хангайн бараатай
Баянаа аварга сүрээтэй
Баадан зодгоо бүсэлчихээд
Байдал төрх нь бахдалтай

Хүнгэнэтэл урамдаад ирж яваа
Хүрэн улаан бух шиг
Хэнхэлдэг цээж нь түхийгээд
Цэнгэлдэх дэвжээндээ чимэгтэй
...

Ардын хурлын танхимдаа
Амны фигүүртэй “дэвдэгсэн”
Үндсэн хуулийн хурал дээр
Үгийн цэцэнээр “давдагсан” ...

...
Далай даян
Дархан дайчин
Их аварга мину зэ ...

(Нөхөрсөг шарж –д зориулав, Г. Ч.)

Хэзээ хойно, 1993 онд шиг санах юм. Тамгын газрын ажилтантай Тангадын Галсан ирж уулзав. Тэр ингэж ярьж билээ. «Үндсэн хууль хэлэлцэх явцад Улсын Ерөнхийлөгч П.Очирбат илтгэл тавьсан. Ерөнхийлөгчийн илтгэлд нэг 4 мөрт орсон байгаа. “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” гэж. Энийг та, хэний үг гэж бодож байна, айн ... гэснээ, илтгэгч тэрийг Моодун шаньюй хэлсэн гэж дурдана лээ. Би дотроо тун баяртай байгаа. Улсын Ерөнхийлөгч хүн, мөхөс найрагч монхор Галсанг тоож, бүр, түүхэн баатрын хэмжээнд өргөмжлөн мандуулж байхад ...» гэв. Тэгснээ ...

Яг үнэндээ бол Моодон хаан тэгж хэлэх байсан болов уу; гэдгээр би бичсэн, миний

бүтээл юм аа. Би заргалдах сэдлээр биш, залруулах санаагаар ирэв; гээд сахлаа имэрч маг маг инээж суусан нь цаанаа нэг баавартай, сэтгэлд тод үлджээ. Яриа хөөрөө нь егөө дэгээ ихтэй янзын хүн байгаам. Галсан тэгэхэд соёлын гавъяат, ардын зохиолч болоогүй, бас депутат биш байв.

Болсон явдал, гарсан алдааг би илтгэгчийн буруу биш, илтгэлийн төслийг бэлдсэн “дэргэдийн түшмэл” -ийн лясус [lapsus, лат.] гэж таамагласан. Бараг үнэн биз. Эрдэм оюуны талбарын ийм нэг хохиролгүй, хохирогчгүй, гэхдээн ямар байсан [бяцхан] өмчийн шинжтэй “хэрэг” үүсэн алдаж байв аа.

- **Үндсэн хуулийг баталсан АИХ –д өөрийнх нь ажлын алба гэхээр сүртэй том аппарат байгаагүй санагддаг. Ардын Эрх сонин Засгийн газрын ордонд байсан, сэтгүүлч бид анзааралгүй яахав. Дандаа хуралдаад, хурал дээрээ бүх юм нь жин тан баймаажин болоод явчдаг байж дээ, багцаа нь. Нээрээ өөр юу ч хийх билээ?**

Та арай буруу яриад байна. АИХ чинь бараг хагас мянган хүнтэй үнэмлэхүй эрхтэй нүсэр байгууллага. Байгууллагад учирдаг бүх асуудал их бага хэмжээгээр заавал тулгарна. Депутатын гэрт утас тавиулах, унаа хөсөг, хоол унд, дайллага цайллага, кино ший, бэлэг сэлт, гачигдал зовлон ... ер нь юу эс байхав дээ. Гар утас ч байгаагүй цаг гээд бодчих. Бүгдийг Ганбаатар, Лхагварэнцэн, Лантав, Барсүрэн ... нарын зэрэг цөөхөн хэдэн хүнээс бүрдсэн АИХ–ын өөрийнх нь ажлын алба диспетчирдсэн дээ. Мэдээж хэрэг, Засгийн газрын ХЭГ, ЯАГ, УБХ–ын Тамгын газраас чиг үүргийнхээ дагуу хангалттай дэмжлэг үзүүлсэн. Тэг гэсэн захирамж тогтоолтой.

Энээс гадна тухайн нэг тойргийн депутатад сонгогчоос нь ч байдаг юм уу, хэн нэг иргэн, байгууллагаас гомдол хүсэлт байнга ирнэ. Түүнийг магадлана шалгана, шийднэ шийдүүлнэ, уламжлана мэдэгдэнэ. Түрхэн зуурт умарсан их ажил цаг наргүй өрнөнө. Засгийн ажил ч тэгээд үйлчилгээ хангамж талдаа бол заавал бүтэх нь сайхан даа. Харин бодлого тал нь явж өгдөггүй хэцүү байдаг шиг байгаам. Жишээ нь, АИХ тэр үед нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлд хүртэл идэвхтэй ажиллаж байжээ. Энийг хар даа. (Баримт үзүүлэв, хуулбарыг өгөв)

БНМАУ–ын АИХ–ын Байгаль орчныг хамгаалах Байнгын комиссын дарга, 7 дугаар тойргийн депутат Цэрэндоржийн Балдорж (1953-2007) агсан “бүрэн шаталттай зуух, утаагүй түлш үйлдвэрлэх” асуудлыг дэмж; гэж Монгол Улсын Шинжлэх ухааны академи руу бичиг шийтгэн явуулж байж. Тэрнээс хойш чилийсэн хорин хэдэн жил өнгөрч байж, дөнгөж сая нэг-юм, утаагүй зуух түрүүчээсээ үзэгдэж эхэлж байна. Бодлогын хэрэгжилт нь тусдаа асуудал аа.

- **Үндсэн хуулийг батлахад гаргасан Улсын Бага Хурлын оролцоо зүтгэлийг энд дурдахгүй байхын аргагүй. Та тэгэхэд УБХ –ын ажилтан байсан бил үү?**

Үндсэн хуулийг батлахад Бага Хурлын үүрэг бага байгаагүй, эсрэгээрээ, ихийн их байсан. Асуугаагүй бол орхигдуулах нь. Хүч тамир шаардсан хамаг ажил чухамхүү Бага хурал дээр, бага хурлын танхимд болсон. Улсын Бага Хурлын эрхэм гишүүн [жишээ нь] эрдэмтэн зохиолч Орлой Мажигийн - Дүгэржавын Маам агсан “нэгэн зүйл” гэж босч ирээд л, долоовор хуруугаан гозойлгож байгаад сэнхрүүлж гардагсан, бусдыгаа. Гү. Лхагважав байна цэцэн цэлмэг гэж жигтэйхэн. Үндсэн хууль тогтоогчид, ер нь, бүгд амны фигур сайтай, үгийн гаргуун мастерууд байсан даа. Улсын Бага Хурлын урьдчилсан шүүлтүүр, Их цааз төслийн 4 удаагийн хэлэлцүүлэг нь үндсэн хуулийг батлахад шийдвэрлэх алхам болсон нь дамжиггүй.

Ажлын арга технологи нарийн, байнгын парламентын үүрэг хариуцлага өндөр, бүх юм дэс дараатай, дэг жаягтай. Улсын Бага Хурлаас 1991 оны наадмын өмнөхөн тогтоол гаргаж, Үндсэн хууль хэлэлцэж батлах [тэрхүү] АИХ –ын хуралдааны товыг зарласан.

Уг тогтоолоор, АИХ –ын хуралдааны бэлтгэлийг хангах комисс байгуулсан юмдаг. Тэр комиссыг БНМАУ -ын Дэд Ерөнхийлөгч бөгөөд Улсын Бага Хурлын дарга ахалсан.

Нийтэд хүрэх эл ярилцлага үүнийг өгүүлэгч мөхөс бээрт тэр болгон тохиохгүй сайхан боломж олгож байна. Маргааш – Үндсэн хууль баталсны 20 жилийн ойн баяр, монголын ард түмний өлзийт сайн их баярын өдөр өө!

Нэгэн цагт нэг байгууллагад, нэг дээвэр дор цуг ажиллаж, “үндсэн хуулийн үзэл санаагаар хамтдаа амьсгалж” явсан дарга цэрэг, ахас ихэс, анд олон нөхөддөөн би түүхэн тэмдэглэлт энэ ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлж, урт наslaарай, удаан жаргаарай, урьд эртийнх шигээ эрчим дүүрэн зүтгээрэй, эгэл түмэн эх орныхоо төлөө ихийн ихийг хийгээрэй; гэж хүсэн ерөөе.

• **Яриа хөөрөө явсаар дурсамж - шүүмж талдаа дажгүй болчихов уу даа. Танд баярлаа.**

Эртэдсэн дүгнэлт биш биз. Хүмүүс эхлээд уншиг. Дурсах уг нь, арай л эртдээд байна. Ардын хувьсгалын партизануудын дурсамжийг 40 гаран жилийн дараа 60 -аад онд бөөгнүүлж авсан байдаг. Оройтуулсан. Тус бүр нь 2 - 3 хуруу зузаан 3 том ном бий. Харин, өнөөдөр, ардчилсан хувьсгалын анхны биет ололтыг бий болгосон, өөрөөр хэлбэл, 1992 оны Үндсэн хуулийг шүүн хэлцсэн тэр шинэ түүхийг, өнөөдөр, 20 -хон жилийн дараа эргэн дурсах нь жаахан эрт юмуу даа. Яг нарийндаа түүх болж амжаагүй шахуу байна. Гэхдээ, зовлон бий. Их оройтохоор хүн худал залаад эхэлдэг, тэгэх нөхцөл нь бүрдчихдэг юм.

Бүх партизан гоймон [гоу мин, гоминдаан гэдгийн] баатрын морин жолооч болох гээд зүтгэвэл юу болох вэ. Элэг доог л болно шүү дээ. Жанжны хөөрөг хага үсэрсэн, махан биеийг нь сум даагаагүй гэж хээвнэг залах хүн захаас аван байхад, “Шор манхтайд манай талаас хүн үрэгдээгүй. Мампсай Дашийн бага хүү мархаан Доржпалам (нутгийн хүнээ нэр хочоор нь барим тавим хэлж буй болтой) -ын чүй манан хөөрөг, алсаас, орос мангадын онилсон суманд оногдон бяцарч даалин нь яз явсан байж билээ. Өөрөө хумсын чинээхэн ч шалбараагүй, хийморьтой эр, хожим улсын сайн малчин болсон; гэж ганцхан хүн хэлбэл хэлнэ, үгүй бол үгүй. Хууч дурсамж юм.

Арай илүү баримжаатай, арай илүү ханатай буудаа болов уу гэмээр тэр нэгэн эгэл эр - цэргийн энгүүн хар яриа, онцлог нь, өөрийгөө гэсэнгүй, даргыгаа, хамаатныгаа гэсэнгүй, бүр, өөлж болохоо болиод их удаж байсан орос монголын “найрамдал-дружба” -г ч тоосонгүй, зүгээр л, анд сайн нэг нөхрийнхөө азтайг бахдан шогширчээ. Үнэн үг үнэртэй, мэдэгдэнэ. Дурсамж бүхэн голтой байвал, тэр ч бас ололт мөн. Танд ажлын амжилт хүсье.

И. Р. Г. Ч., 2012.01.10;



ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

5

БҮЛЭГ

ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА

Н. Лүндэндорж (Sc.D), П. Амаржаргал

Аливаа үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлсон хүчин зүйл бодитой оршдог уу, оршдог бол тэрхүү хүчин зүйлд юу хамаарах вэ гэсэн асуулт зүй ёсоор үүснэ. Соёл иргэншлийн онолыг үндэс болговол аливаа үндэстний хэл, түүх, шашин, зан заншил, бүхий л төрлийн институт, сэтгэлгээ, хүмүүс хоорондын харилцааны хэв маягийг иргэншил, соёл нь тодорхойлдог³⁰ аж. Харин тэрхүү иргэншил соёлын онцлогийг байгаль, цаг агаар нь нөхцөлдүүлдэг гэж детерминист³¹ хандлага үздэг. Тухайлбал, монголчууд нүүдлийн иргэншлийг өөрсдөө сонгоогүй. Харин байгаль, цаг агаар, хөрсний үржил шим³² нь амьдралын энэ хэв маягийг тулгасан. Манай орны хөрсний бүтэц, үржил шим нь газар тариалангийн соёлыг зөвшөөрөөгүй.

Монголын нүүдлийн иргэншлийг нөхцөлдүүлсэн байгаль, цаг агаар, хөрсний хүчин зүйл монгол хүний антропологи, этнос, менталитет гэх зэрэг уугуул онцлогуудыг тодорхойлсон. Жишээ нь, өргөн уудам газар нутаг нь төрийн үйлдвэрлэлийн аргыг бий болгож, олон зууны турш газар дахь улсын өмчлөлийн харилцааг тогтоож, хувийн өмчид суурилсан индивидуалист үзэл санаа дэлгэрэх, хөгжих бололцоог хааж, төрийг хянах бус харин дээдлэх үзэл санааг бий болгосон байх жишээтэй. Нүүдлийн мал аж ахуй хөдөлмөрийн онцлог нь суурин иргэншлийн хүмүүс шиг нийгмийн тал бүрийн харилцаанд оролцох, харилцах бололцоог хязгаарлаж байсан учраас харилцан буулт хийх, тэвчихүйн мэдрэмж сул хөгжсөн. Эрс тэс уур амьсгал, цаг агаар монгол хүнийг зориг тэвчээртэй болгосны зэрэгцээ хэрцгий догшин араншинг заяасан гэх мэт монгол хүний сэтгэлгээний уугуул төрхийн талаар олон шинжийг нэрлэж болно.

Объектив хүчин зүйлээр нөхцөлдсөн монгол хүний сэтгэлгээний дээрх уугуул төрх түүхэн хөгжлийг дагаж хувьсан өөрчлөгдөж ирсэн хэдий ч бүр мөсөн төрөл арилжиж, бүрэн хувирдаггүй хадгалагдсаар байгааг бид эргэн тойрноосоо харсаар байгаа билээ. Байгаль, цаг агаарын онцлогоор нөхцөлдсөн нүүдлийн иргэншил, түүнээс шууд эх сурвалжтай амьдралын хэв шинж, нийгмийн зохион байгуулалт, харилцаа, зан заншил, шашин суртал зэрэг нь монголчуудын эрх зүйн сэтгэлгээний тулгуур уг сурвалж мөн³³ нь эргэлзээгүй юм.

Тэгэхлээр, үндэсний эрх зүйн сэтгэлгээ нь тухайн ард түмний иргэншил, соёлоор нөхцөлдсөн сэтгэлгээний уугуул төрхийг тусгасан хамтын амьдралын дэг журам, эрх, үүрэгт хандах хандлагын илрэл юм. Монголчуудын эрх зүйн сэтгэлгээний түүхэн хөгжлийг иргэншлийн онцлог, эрх зүйн эх сурвалжийн шинж чанарыг харгалзан (1) уламжлалт, (2) социалист, (3) либерал эрх зүйн сэтгэлгээний үед хуваан үзэж болно.

Уламжлалт эрх зүйн сэтгэлгээний үе нь цаг хугацааны хувьд 1206-1921 хүртэлх он хамрах бөгөөд дотроо заншлын, хууль цаазын, Манж-Чин улсын эрх зүйн нөлөөний, өрнийн эрх

³⁰ Хантингтон С. Столкновение цивилизации Полис, (1994) № 1

³¹ Black's Law Dictionary. Editor in chief Bryan A. Garner. Eighth edition (2004) p 481 Хүний зан байдал нь гэр бүл, орчны нөхцлийн бүрэн хяналтанд байдаг бөгөөд түүнд хүсэл зориг нөлөөлөдөггүй гэсэн философи юм.

³² А. Ж. Тойнби. Түүх судлал (2007) 141 дэх тал

³³ N.Lundendorj. Development of state and legal thoughts and its tendencies (General and Specific Study), Synopsis for the Degree of Doctor of Science in Law. Ulaanbaatar (2003) p 21-23

зүйн соёлын нөлөө нэвтэрч эхэлсэн үе гэж нарийвчлан хувааж болно. Эл үеийн эрх зүйн сэтгэлгээний гол эх сурвалж нь нүүдэлчдийн ёс заншил³⁴, хэв хууль, эзэн хаадын билэг сургаал, Хятадын уламжлалт эрх зүй³⁵, өрнийн эрх зүйн зарим институт байсан гэж үзэж болно. Энд авч үзсэн эрх зүйн сэтгэлгээний эх сурвалжуудаас Хятадын уламжлалт эрх зүй гэсэн эх сурвалж судлаачдын судалгаанд төдийлэн хөндөгдөөгүй шинэ эх сурвалж юм. Бид түүх, соёлоо хятадаас тусгаарлах гэсэн “хүйтэн” жилүүдэд Хятадын соёлын нөлөөг төдийлэн авч үзэхийг хүсдэггүй байв. Гэвч үнэнийг нууж болохгүйн зарчмаар сүүлийн жилүүдэд хандах болж буй нь сайшаалтай. Хятадын соёлын нөлөө монголчуудын бүх түүхэнд байсаар ирсэн. Одоо ч байна. Цаашид ч байх нь мэдээж. Хятадын уламжлалт эрх зүй Монголын эрх зүйн хөгжил, сэтгэлгээнд ямагт гол нөлөө үзүүлсээр иржээ.

Хятад улсын уламжлалт эрх зүйн мөн чанар эрүүгийн хэм хэмжээнд тулгуурлаж оршдог. Тийм учраас тус улсын уламжлалт эрх зүйг эрүүгийн эрх зүй ч гэж нэрлэдэг. Хятадын уламжлалт эрх зүйн онцлог, хууль цаазын тогтолцоонд эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ гол байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл, Нэгдүгээрт бусад эрх зүйн хэм хэмжээг төдийлөн өргөн хэмжээнд бий болгодоггүй онцлогтой. Хоёрдугаарт, газар дахь эзэн хааны өмчлөл, хуваарилалт нь төрийн хатуу хяналт тогтоох зорилгыг агуулдаг. Тэгвэл Хятад улсын уламжлалт эрх зүйн энэ онцлог Монголын эрх зүйн түүхэнд хэрхэн нөлөөлснийг харахад төвөггүй байна. Харин том иргэншил соёл нь бага иргэншил соёлоо ямагт дагуулж байдаг учраас Монголын уламжлалт эрх зүй хятадад нөлөөлсөн гэж бид баталж чадахгүй билээ. Тийм учраас монголын эрх зүйн сэтгэлгээнд Хятад улсын уламжлалт эрх зүй нэг гол эх сурвалж болж түүхэн нөлөө үзүүлснийг тэмдэглэж байна.

Тэгэхлээр, монголчуудын уламжлалт эрх зүйн сэтгэлгээний үеийн гол мөн чанар бол төр, эзнийг дээдлэх, ёс заншлыг дагах, үүргийг хүндэтгэн биелүүлэх, харин эрхийг дээдлэн хүндэтгэх ёс журам, соёл, мэдрэмж сул байсан онцлогтой байжээ гэж хэлж болмоор байна.

Социалист эрх зүйн сэтгэлгээний үед монголын эрх зүйн сэтгэлгээнд томоохон хувьсал болсон. Уламжлалт эрх зүйн соёлоос бүрэн тасарсан, ангич, намч, үзэл сурталжсан агуулгатай эрх зүйн соёл, сэтгэлгээг нэвтрүүлсэн хэдий ч орчин цагийн эрх зүйн тогтолцооны нэгэн өвөрмөц загварыг ЗХУ-ын нөлөөн дор бүрдүүлж чадсан билээ. Энэ үед эрх зүйн сонгодог үзэл санаа, зарчим нэвтрээгүй юм. Үүний улмаас хүний эрх хуулийн үндэс, төр тогтоодоггүй хүний салшгүй эрх оршдог, өмчлөх эрх - хүний бүх эрхийн үндэс суурь, хэрэгжих баталгаа гэсэн үзэл сэтгэлгээ, мэдрэмж хөгжөөгүй.

Харин хүний эрхийг хуулиар бий болгодог, төрөлх жам ёсны эрх гэж байдаггүй, энэ бол хөрөнгөтний суртал нэвтрүүлэг, хувийн өмч бол хүний эрх, эрх чөлөөний үндэс баталгаа биш, харин хүн хүнээ дарлан мөлжих хэрэгсэл, хүн мөн чанараа алдах, ангит нийгэм болон нийгэм орших суурь гэж үзэж байлаа. Энэхүү албан ёсны үзэл суртал, үнэлэмжийн хүрээнд монголчуудын эрх зүйн сэтгэлгээний бас нэгэн өвөрмөц хэв маяг бүрэлдсэн. Түүний гол онцлог бол зөвшөөрснийг хийх үйлдлийг эрх, даалгасныг биелүүлэх үйл ажиллагааг үүрэг гэж үзэж, нийгмийн дэг журамд хандах хандлагын үндсийг коммунист ёс суртахууны үнэлэмжээр авч үзэх явдал байлаа.

Социалист эрх зүйн сэтгэлгээний хүрээнд төлөвшсөн эрх зүйн марксист онол (1) хуулиар бий болж болзошгүй аюулыг зайлуулдаг³⁶ хуулийн чанд орших хуулийн тухай, (2) хууль тогтоох үйл ажиллагаа нийгмийн гэрээний зарчим, үл хөндөгдөх хууль зүйн техникийн

³⁴ Montesquieu The Spirit of the Laws Cambridge University press (1989) p 468

³⁵ Takehiro OHYA, Course Material: Japanese legal System, Nagoya University, Graduate School of Law. (2006) p.5

³⁶ Н.Лүндэндорж. Jurisprudence-Эрх зүй судлал, философи, онол. (2011) 144 дэх тал

дүрмүүдэд захирагддаг³⁷ тухай, (3) төрийн эрх мэдлүүдийг хяналт, тэнцвэрийн зарчмаар хуваарилж, хүний эрхийг төрийн дүр зоргоос хамгаалдаг тухай, (4) нийтийн эрх зүй болон процессийн эрх зүй нь эрх зүйн байх ёстой зарчимд³⁸ тулгуурласан байх тухай, (5) Үндсэн хуулийн хяналт зэрэг орчин үеийн ардчилсан улсын хуульт ёсны үндсэн дүрмүүдээс биднийг хүнийгсгэсэн байсан нь эрх зүйн тоталитар сэтгэлгээнд дасгаж, түүнийг зөв, үнэн, давуу гэж үзэх үнэлэмжийг бий болгосон байлаа.

Монгол улс дахь нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан шинэтгэл монголын эрх зүйн соёл, сэтгэлгээнд үндсэн эргэлт гаргалаа. Энэ эргэлтийн үр дүнд либерал эрх зүйн соёл, сэтгэлгээ төлөвшин хөгжин нутагшиж байна. Гэвч либерал эрх зүйн соёл, сэтгэлгээний хөгжлийн зам дардан шулуун биш байна. Зөвлөлт хэв маягийн социалист, социал-демократ, коммуитарист үзэл санаанд тулгаарласан эрх зүйн соёл, сэтгэлгээ ч бас зэрэгцэн оршсоор байна. Гэсэн хэдий ч либерал эрх зүйн соёл, сэтгэлгээ давамгайлж байна.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль либерал эрх зүйн дэг журам, соёл, сэтгэлгээ хөгжүүлэх гол чиг шугам, “тоглоомын дүрэм” болж байна. Ардчилсан гэх тодотголтой аливаа улсын Үндсэн хууль нь эрх зүйн “мод”-ны үндэс суурь болж байдаг. Тэрхүү модны үндсийг тэжээж байдаг хөрс, ус, бордооны үүргийг ямар нэг улс төрийн онол гүйцэтгэж байдаг. Манай улсын эрх зүйн модны суурь болсон Үндсэн хуулийг тэжээж байдаг тэрхүү хөрс, ус бордоо нь либерализм³⁹ юм.

Сонгодог либерализмын тулгын гурван чулуу бол: (1) хувь хүний эрх, эрх чөлөө, (2) чөлөөт зах зээл, (3) хязгаарлагдмал засаг төр⁴⁰. Эдгээрийг Монгол улсын Үндсэн хууль⁴¹ бараг бүрэн утгаар нь тусгасан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-д “Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн тунхаглаж, 16 дугаар зүйлд хүний суурь эрхүүдийг нийтлэг агуулгаар хуульчилж, 5 дугаар зүйлийн 2-д өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална хэмээн зааж хувь хүний эрх, эрх чөлөөг аливаа дүр зоргоос хамгаалсан байна. Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “... олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, мөн зүйлийн 2-д “Төр нь...хөгжлийг хангах зорилгоор эдийн засгийг хамгаална” хэмээн заасан нь зах зээлийн эдийн засгийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсны илрэл юм.

Үндсэн хуулийн оршил хэсэгт “...хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж зааснаар төрийг иргэний нийгмийн хяналт дор байлгах, төрийг хянах иргэдийн тогтолцоог хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Мөн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-д төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг зааж өгсөн нь төрд ажиллаж байгаа хүмүүсийн дүр зоргыг хязгаарласан хэрэг юм. Мөн Үндсэн хуульд төрийн эрх мэдлүүдийг хуваарилах оролдлого хийсэн нь либерал онолыг баримталсны илрэл мөн.

³⁷ L.Fuller. *Morality of Law* (1964) Chap 2

³⁸ Black's Law Dictionary. Editor in chief Bryan A.Garner. Eighth edition (2004) p 538-539. Уг хуулийн толь бичигт эрх зүйн байх ёстой зарчмыг /Due process of law/ тайлбарлахдаа “Хувийн эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн үйл ажиллагааг тогтоосон дүрэм журмын дагуу явуулахыг хэлнэ. Тухайлбал: хэргийг шийдвэрлэх эрхтэй шүүгчийн өмнө шудрагаар хэргийг шийдвэрлүүлэх эрх болон мэдэгдэл байна”.

³⁹ Black's Law Dictionary. Editor in chief Bryan A.Garner. Eighth edition (2004) p 936. Төр, үзэл бодлын хувьд- хязгаарлалтгүй, өргөжүүлсэн, олон ургалч үзлийг тэвчих гэсэн тэмдэг нэрийг илэрхийлнэ.

⁴⁰ Дэвид Боаз. Либертарианизм Орч. Б.Батчулуун (2005) 1-р бүлэг

⁴¹ Төрийн мэдээлэл эмхтгэл 1992 № 1

Эдгээрээс эргэцүүлэхэд Монгол улсын эрх зүйн тогтолцоо либерал онол дээр суурилсан болохыг Үндсэн хуулийн дээрх заалтууд нотолж байна. Тийм учраас өдгөө Монгол улсад эрх зүйн либерал сэтгэлгээ бүрэлдэн хөгжиж байна гэж хэлэх бүрэн үндэстэй юм. Эрх зүйн либерал сэтгэлгээний хүрээнд монголчууд хуулийн цаана хууль байдаг, түүгээр хуулийг шалгана, үнэлнэ гэж итгэж, тэр эх сурвалжийг хүн төрөлхтөний сэтгэлгээний болон хууль зүйн практикийн ололтод тулгуурлан эрж хайж, судалж, сурталчилж, зааж сургах болсноор эрх зүйн онолын сэтгэлгээний дэлхий нийтийн гэр бүлд нэгдэх процесийг эхлүүлжээ.

Засаг төрийн эрх мэдлийг хууль, шүүх, иргэний нийгмийн хяналтад оруулах, хууль тогтоох ажиллагааг аливаа дур зоргоос хязгаарлах институт болон институцийг бий болгож эхэлснээр “засаг төрийг ард түмэн хянах эрхтэй”, “засгийн эрх ард түмнээс эх сурвалжтай” гэсэн хуучин цагт ч байсан уриа лоозонд олон түмэн итгэх хандлага бий болж байна.

Хэдийгээр өдгөө эрх зүйн позитивизмын марксист хувилбар хадгалагдаж байгаа хэдий ч эрх зүйн олон ургальч үзлийн үр дүнд эрх зүйн янз бүрийн номлол, сургаал, онол, үзэл баримтлал академик хүрээнд түгэн дэлгэрч, эрх зүйн сэтгэлгээний глобальчлал, тэлэлтийг бий болгож байна. Үүний үр дүнд эрх зүйн монист сэтгэлгээнээс плюралист сэтгэлгээнд шилжиж байна.

Дэвид Боазын таамагласнаар XXI зууны улс төрийн сэтгэлгээний гол өрсөлдөөн либертари болон социал-демократ онолын хооронд өрнөх⁴² бөгөөд монголын нийгмийн улс төрийн сэтгэлгээ ч түүнийн нөлөөнд байх нь эргэлзээгүй бизээ. Тийм учраас монголын эрх зүйн соёл, сэтгэлгээнд либерал онол тодорхой байр суурьтай байх шинж төлөв ажиглагдаж байна.

Гэвч Монгол Улсад эрх зүйн либерал сэтгэлгээ цаашид хэрхэн нутагшин хөгжих нь дэлхийн улс төрийн уур амьсгал, нөөцийн хүрэлцээ зэрэг бодит хүчин зүйлээс хамаарахаас гадна Монгол улс дотооддоо иргэний нийгмийг төлөвшүүлэх, ардчиллыг тууштай хөгжүүлэх, төр засгийн үйл ажиллагааны үр нөлөө, бүтээмж, цэвэр тунгалаг байдлыг хэрхэн хангахаас ихээхэн хамаарна. Ялангуяа авилга хээл хахуул, ядуурлыг бууруулах талаар төр засгаас оновчтой арга хэмжээг авч чадахгүй бол “хөөрсөн түмний” өмнө либерализм хүчгүйдэхийг үгүйсгэхгүй.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁴² Дэвид Боаз. Либертарианизм. Орч. Б.Батчулуун (2005) 341 дэх тал

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЕКТОРЫН ШИНЭЧЛЭЛ БА ТҮҮНД ТАВИХ ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ

*“Ардчилсан нийгэм ба тагнуулын байгууллага” эрдэм
шинжилгээний хурал, Тагнуулын академи,*

Илтгэгч: Д-р Г. Алтан - Оч, ахлах референт, УИХ -ын
Судалгааны төв, altanoch@parliament.mn

2011.09.29

Домог

Аюулгүй байдлын бодлого нь зохих мэдлэгтэй, мөн түргэн гүйцэтгэх чадвартай тул гүйцэтгэх засаглалын ‘үндсэн’ үүрэг мөн гэсэн өргөн дэлгэр тархсан ойлголт байдаг. Аюулгүй байдлын талаарх засгийн газрын хамгийн чухал үүрэг хариуцлага болох дайнд оролцох, олон улсын энхийн үйл ажиллагаанд цэрэг илгээх, олон улсын гэрээ хэлэлцээр хийх, батлан хамгаалахын төсвийг нэмэгдүүлэх зэргийг гүйцэтгэх засаглал шийдвэрлэдэг.

Эдгээр шийдвэрийг гаргах нь парламентад огт хамааралгүй гэсэн мугуйд ойлголт байсаар байна. Парламентыг аюулгүй байдлын асуудалд тохиромж муутай байгууллага (институц) гэх үзэл их тархсан байдаг. Яагаад гэвэл, шийдвэр гаргах хугацаа ихэнхдээ урт, мөн хангалттай мэргэшлийн туршлага байхгүй, мэдээлэлд бүрэн дүүрэн хандах боломжгүй гэж үздэгтэй холбоотой. Гэсэн ч энэ нь буруу ойлголт юм³⁵.

Ардчилал хөгжсөн орнуудад дайны үе ч бай энхийн цагийн алинд ч парламент нь аюулгүй байдлын асуудалд голлох үүргийг гүйцэтгэсээр ирсэнийг түүх нотолно. Ромын бүгд найрамдах улс, XVI зууны үеийн Нидерландын БНУ, дэлхийн II дайны үеийн Их британи улсад, Персийн булангийн II дайны цөмрөлтийн үед, бүр байлдааны үйл ажиллагаа ид явагдаж байх үед ч бөмбөрцөг даяар улс орнуудын парламентад аюулгүй байдлын бодлого болон түүний шинэчлэлийн талаар мэтгэлцэж, шийдвэрт нөлөөлж, хяналт тавьж байсан.

Энэхүү бэсрэг судалгаанд, (а) яагаад парламент улстөр, эрхзүйн хэлэлцэх асуудлынхаа дараалалд аюулгүй байдлын секторын шинэчлэлийг дээгүүр байршуулах ёстой болон (б) яагаад парламентийн гишүүд аюулгүй байдлын секторын шинэчлэл, түүний бодлогод хяналт тавих ёстой талаарх гол үндэслэлийг тодорхойлохыг зорив. Ингээд аюулгүй байдлын сектор (АБС)-ын шинэ үзэл баримтлалд эхлээд анхаарлаа хандуулъя.

Аюулгүй байдлын секторын шинэчлэл гэж юу вэ?

‘Аюулгүй байдлын секторын шинэчлэл’ (АБСШ) гэдэг нь харьцангуй шинэ боловч тодорхой бус үзэл баримтлал юм. Аюулгүй байдал судлал дахь ‘батлан хамгаалахын шинэчлэл’ гэдгийг орлох болоод байгаа энэхүү ойлголт нь үүсээд буй аюулгүй байдлын шинэ орчинд асуудлыг авч үзэх бодлогын үзэл баримтлал юм.

Өнөөдрийн аюулгүй байдлын аюул занал нь батлан хамгаалахын хариу цохилт шаардахуйц зөвхөн цэргийн халдлагаас хальж терроризм, иргэний дайн, зохион байгуулалттай гэмт хэрэг, хил дамнуулан хууль бусаар хүн наймаалах, галт зэвсэг, цаашилбал үй олноор устгах зэвсэг түгээн дэлгэрүүлэх зэрэг цэргийн бус шинжтэй болсон. Эдгээр шинэ нөхцөл байдал нь бүх улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллагууд нэгдмэл саналтайгаар хамтран ажиллахыг шаардаж байна.

Аюулгүй байдлын секторт ‘хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхийг тушаах, хүч хэрэглэхээр

заналхийлэх хуулиар олгогдсон эрх бүхий аливаа төрийн байгууллагыг хамруулна⁴³. Эдгээрт цэрэг (арми, усан цэрэг, агаарын хүчин), тагнуул, хил хамгаалах болон хагас цэрэгжүүлсэн байгууллагууд бүгд багтана.

Аюулгүй байдлын секторын шинэчлэлийн зорилго нь 'дэвжин дээшилсэн, баттай тогтсон, системтэй байх угтвар нөхцөл хангагдсан ардчилсан хяналт шалгалтын үндсэн дээр системтэй хариуцлагын тогтолцоо (тайлагнах чанар), ил тод (тунгалаг) байдал бий болгоход' оршино⁴⁴. Хариуцлагын тогтолцоо, ил тод байдлыг илүүтэй тодотгосноор АБСШ-ийг хүний эрх, ардчилал болон хуулинд захирагдах ёсыг бат тууштай эрхэмлэсэн шинж бүхий сайн засаглалын хөтөлбөрийн хүрээнд хамруулах болно.

Нөгөөтээгүүр шинэчлэл явагдаагүй АБС-т доорх шинжүүд илэрдэг. Үүнд:

- Ил тод байдал дутмаг, ялангуяа, зэвсгийн наймааны секторт авлига цэцэглэсэн;
- Улсын эдийн засгийг эрсдэлд оруулахуйц нүсэр их төсөв бүхий хэтэрхий том зохион байгуулалт;
- Огт оргүй буюу сулхан хуулийн бааз суурийн улмаас хуулинд захирагдах ёс дутмаг;
- Мэргэжлийн чадавхи (профессионализм) дутмаг: бэлтгэл сургуулилт муутай анги нэгтгэл, сонирхогчийн байдал (аматеризм), гавьяа зүтгэлийн оронд хамаатан садны байдлаар тусгай ажилтныг сонгон шалгаруулах болон цол ахиулах явдал;
- Дотогшоогоо харсан хүнд суртал, эрсдлээс зайлсхийсэн, өөрчлөлтийг эсэргүүцэгч болон аюулгүй байдлын шинэ аюул, сорилтод нийцэхгүй зохион байгуулалтын бүтэц;
- Улстөрийн дайснаа мөрдөн мөшгих зэргээр тагнуулын байгууллагыг дотоодын тагнан турших зорилгоор ашиглаж аюулгүй байдлын байгууллагыг улстөржүүлэх, урвуулан ашиглах, мөн хагас цэрэгжүүлсэн байгууллагыг улстөрийн дайснаа айлган сүрдүүлэх буюу дарахад ашиглах;
- Мэргэжлийн чадавхи, цол хэргэм, албан тушаал ахих боломж дутмаг, цалин хөлс багатай буюу тэд нийгэмдээ нэр хүнд муутай зэргээс хамаарч хүсэл эрмэлзэлгүй (мотивацгүй) болж сэтгэлээр унасан (хөрсөн сэтгэлтэй) офицер, байлдагчид;
- Цэрэг татлагыг дэмий цаг нөгцөөсөн явдал болгосон, бие бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэхийн тулд цэрэг татлагыг буруугаар ашиглах, шинэ цэргүүдийг хуаранд 'мартах';

Шинэчлээгүй АБС-ыг 'муу засаглалтай' жишиж болох юм. Муу засаглалын шинж гэвэл: дур зоргоор шийдвэр гаргах, хариуцлагагүй хүнд суртал, дагаж мөрддөггүй эсвэл шударга бус эрхзүйн систем, гүйцэтгэх эрх мэдлийг буруугаар ашиглах, олон нийтийн амьдралд иргэний нийгэм оролцохгүй байх болон авлига өргөн дэлгэр тархсан байх явдал юм⁴⁵.

Аюулгүй байдлын секторын шинэчлэлийн зайлшгүй байдал

⁴³ Hans Born and Philipp Fluri, *Relevance of Parliamentary Oversight for Security Sector Reform*, DCAF, Geneva, 2003

⁴⁴ Hans Born, Philipp Fluri, Anders Johnsson, *Handbook for Parliamentarians No.5, Parliamentary Oversight of the Security Sector: Principles, Mechanisms and Practices*, IPU/DCAF, Geneva/Belgrade, 2003

⁴⁵ Үгсийн тайлбар толь дахь 'АБСШ'-ийн тодорхойлолт: Hans Born, Philipp Fluri, Simon Lunn, *NATO-PA Vademecum*, Geneva/Brussels, 2003

АБСШ-ийн мөн чанар, цар хүрээнээс хамаарч шинэчлэлийг ядаж дөрвөн учир шалтгааны улмаас явуулах шаардлагатай байна.

Сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, тогтвортой байдалд чиглэсэн дэвшил

Шинэчлэгдээгүй АБС нь сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх чадваргүй байдаг бөгөөд заримдаа зовлон шаналал, ядуурлыг улам нэмэгдүүлэх хүчирхийлсэн мөргөлдөөнд ч хүргэдэг⁴⁶. Сөргөлдөөний бүсэд ажилладаг ТББ (Төрийн бус байгууллага)-уудын тайлангаас үзэхэд, энх тайван орших болон тогтвортой байдалд саад тотгор учруулдаг гол хүчин зүйл бол АБС-ын буруутай үйл ажиллагаа байдаг:

Иргэдийн аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа аюулгүй байдлын ажилтан нь хуулийн дагуу, ардчилсан хариуцлагатай байх үүрэг хүлээж ажиллахгүй бол үүсээд байгаа зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх чадваргүй байдаг бөгөөд харин ч бүр хүчирхийллийн эх үүсвэр болдог⁴⁷.

Нөгөө талаар үр дүнтэй АБСШ нь ардчилсан хяналтын дор үр дүнтэй, үр ашигтай байдлаар аюулгүй байдлыг хангах утгаар дотоод болон гадаад тогтвортой байдлыг бий болгоход нөлөөлж чадна⁴⁸. АБСШ нь тогтворгүй байдалд хүргэдэг хүчин зүйлийг арилгаснаар дотоод тогтвортой байдлыг хангана, жишээлбэл, иргэн-цэргийн харилцаа. Ил тод байдалтай, ардчилсан хяналттай АБС-ийг бүс нутгийн хүрээнд итгэл найдвар оршихын хэмжүүр гэж үздэг тул гадаад тогтвортой байдлыг хангана. Иймээс АБСШ нь ардчилал, эдийн засгийн хөгжлийн суурь болох тогтвортой байдлыг бий болгоход дэмжлэг үзүүлдэг юм.

Эдийн засгийн тулхтай хөгжилд оруулах хувь нэмэр

Шинэчлэгдээгүй АБС нь тогтворгүй байдал, аюултай байдалд хүргэдэг учир хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгодоггүй. Нөгөөтээгүүр авлигад идэгдсэн АБС нь улсын эдийн засагт саад тотгор учруулах нь дамжиггүй. АБСШ нь шинээр тоног төхөөрөмжинд хөрөнгө оруулах, тусгай ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх, сургах, тэднийг дотоодын хөдөлмөрийн зах зээлтэй өрсөлдөхүйц цалин хөлсөөр хангах зэрэг олон үзүүлэлтээс шалтгаалан хямд хийгдэхгүй гэдэг нь ойлгомжтой. Гэвч эдийн засгийн тулхтай хөгжилд түлхэц өгсөнөөр урт удаан хугацааны туршид зардлаа нөхөж үр дүнгээ өгөх нь зайлшгүй.

Мэргэшүүлэх: Найдвартай, үнэнч тусгай ажилтнуудын корпус бий болгох

АБС-ын байгууллага нь ардчилсан сонгуулиар гарч ирсэн улстөрийн удирдагчдын нэрийн өмнөөс төрийн монополь хүчирхийллийг хэрэгжүүлдэг учир мэргэжлийн ажиллах хүчинтэй байх нь маш чухал юм. Хүчний байгууллага гэдгээрээ төрийн бусад байгууллагуудаас ялгаатай.

Мэргэжлийн чадавхи нь өөрт оногдсон үүрэг, дээрээс өгсөн даалгаврыг биелүүлэх чадвартай, динамиктай түргэн өөрчлөгдөж буй аюулгүй байдлын шинэ орчны нөхцөлд аюулгүй байдлыг хангах үйлсэд үнэнчээр өөрийгөө зориулан зүтгэхэд хөтөлнө. Мэргэжлийн чадавхи гэдэг нь офицерууд мөн урьдчилан таамаглахуйц, сахилга баттай байхыг хэлнэ. Мэргэжлийн чадавхи үгүй бол, сахилга бат, гүйцэтгэлийн чанар дутсанаас өгсөн үүрэг даалгавар нь хэрхэн биелэх талаар цэргийн улстөрийн удирдлагын баталгаа алдагдаж

⁴⁶ The World Bank, Governance: The WB's Experience, World Bank, Washington DC, 1994

⁴⁷ Department for International Development, *Understanding and Supporting Security Sector Reform*, Stairway Communications DFID, London, 2002

⁴⁸ Damian Lilly, Robin Luckham, Michael von Tangen Page, *A Goal Oriented Approach to Governance and Security Sector Reform*, International Alert, London, 2002

ардчилсан хяналт утга учраа алдахад хүрнэ. Тусгай ажилтнууд эрхэлсэн ажилдаа эзэн болж байна гэдэгт улстөрийн удирдагчид итгэлтэй байх явдлыг мэргэжлийн чадавхи дамаа илэрхийлдэг юм.

Аюулгүй байдлыг ардчилах

Эцэст нь, АБСШ нь түүнийг хуулийн дагуух улстөрийн байгууллагын харьяан дор оруулж, түүний эрх мэдлийн хүрээг тодорхойлох, мөн хязгаарлах замаар хууль эрхзүйн орчныг бүрдүүлж өгсөнөөрөө ардчиллыг улам сайжруулдаг юм. Засгийн дээд эрх ард түмний мэдэлд байх хууль эрхзүйн орчин бүрдүүлэхийг шилжиж буй орнуудад ардчилсан үйл явц амжилттай өрнөх гарааны цэг буюу босго-шугам гэж үзэхэд болно.

Зарчмын хувьд, хууль эрхзүйн орчин хоёр суурь багана дээр тулгуурлаж байдаг, нэг нь хариуцлагын тогтолцоо; нөгөө нь ил тод байдал. Улстөрийн удирдлага, аюулгүй байдлын байгууллагын хоорондын харилцааг аюулгүй байдлыг ардчилах эдгээр хоёр чухал хос үзэл баримтлалын дагуу зохицуулах нь зүйтэй.

Хяналтыг ардчилах: Парламентийг оролцуулах зайлшгүй байдал

АБС-ын байгууллагууд нь хоёр нүүртэй байгууллагын шинжтэй байдаг. Нэгтээгүүр, хууль, журам сахиулах, үндэсний эрх ашиг, иргэний эрхийг хамгаалах замаар функциональ хэрэгцээг хангах шаардлагатай. АБС-ын бүх байгууллагууд өөрт оногдсон үүрэг даалгаврыг биелүүлэхэд бэлтгэгдсэн, мөн бэлэн байгаагаа харуулах ёстой. Нөгөөтээгүүр, нийгмийн хэм хэмжээ, ардчилал, хууль эрхзүйн стандартыг хангах шаардлагатай. Бүх АБС-ын байгууллагууд хуулийн хүрээнд, ардчилсан хууль ёсны улстөрийн удирдагчдын өмнө хариуцлага хүлээж ажиллах ёстой.

Засгийн бүхэрх ард түмний мэдэлд байх ардчилсан засаглал бүхий нийгэмд парламент амин чухал үүрэг рольтой. Парламентыг татан оролцуулсанаар, парламентэд мэтгэлцсэнээр иргэний хяналт нь сая ардчилсан хяналт болдог юм. АБ-ын тухай мэтгэлцээн өрнүүлэх замаар ард түмний эрэлт хэрэгцээ, санаа зовоож буй асуудалд дуу хоолойгоо нийлүүлэх боломж бүрдэнэ. Үнэндээ парламентийн оролцоо нь ард түмний хяналт уу, ардчилсан хяналт уу, эсвэл сайн засаглал уу, ардчилсан засаглал уу гэдгийг ялгаж өгдөг. Ингэж ялгавартай авч үзэх нь чухал ач холбогдолтой.

Ард түмний хяналт нь урьдчилсан нөхцөл мөн боловч ардчилсан хяналт тавих нөхцөлд хангалттай биш юм. Үүнийг бид XX зууны авторитарь дэглэмүүдээс суралцаж болно.

Жишээ нь, Хитлер, Сталин нар цэргийн дээр ард түмний төгс хяналтыг бий болгож чадсан боловч тэдний хяналтын байдлыг ардчилсан нийгэмд яаж ч хэрэглэх боломжгүй юм. Ийм учраас АБС-ын хяналтын ардчилсан элементийг баттай оршиход парламент чухал үүрэгтэй билээ.

АБ-ын бодлого болон АБСШ-д парламентийг татан оролцуулах нь нэн чухал болохыг илтгэсэн ядаж таван шалтгаан байна⁴⁹.

Авторитарь дэглэмээс урьдчилан сэргийлэхэд ардчиллын түшиг тулгуур

Засгийн бүх эрх ард түмний төлөөлөгчдийн мэдэлд байх ардчилсан нийгэмд төрийн ямар ч сектор түүний хяналтаас гадуур байх ёсгүй юм. АБС-ыг, тэр тусмаа цэргээ хяналтандаа аваагүй парламент бүхий улсыг хамгийн сайнаар бодвол, ардчилал бүрэн

⁴⁹ Timothy Edmunds, Defining Security Sector Reform, Proceedings of the DCAF/IISS Conference, Geneva, 2001

тогтоогүй буюу ардчилах шатандаа яваа гэж үзнэ.

Америкийн нэр хүндтэй эрдэмтэн Роберт А. Даал 'улстөрд байнга тулгардаг хамгийн суурь асуудал бол авторитарь дэглэм тогтохоос зайлсхийх явдал' гэжээ. АБС нь аливаа улсад амин чухал үүрэг биелүүлдэг учир гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг сөрөн тэнцүүлэх хяналт шалгалт, тэнцвэржүүлэлтийн тогтолцоо шаардлагатай. Тиймээс гүйцэтгэх засаглал буюу ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах замаар АБС-т парламентын зүгээс хяналт тавих нь улсын хэмжээнд эрх мэдлийг хуваарилах маш чухал элемент юм.

Төлөөлөхгүй л бол татвар байхгүй

Орчин үед гүйцэтгэх засаглалыг хянах парламентын хамгийн чухал механизм бол төсөв юм. Баруун европт анхны чуулган хуралдаж эхэлсэн тэр л цагаас хойш бодлогын асуудлаар 'Төлөөлөхгүй л бол татвар байхгүй' гэсэн нэгэн хэллэг парламентад тогтсон юм. АБС-ын байгууллагууд нь улсын төсвийн томоохон хэсгийг зарцуулдаг учир парламентын зүгээс улсын хомсхон уг эх үүсвэрийг хэр үр дүнтэй болон үр ашигтай ашиглаж байгаа эсэхэд мониторинг хийх зайлшгүй шаардлагатай.

Аюулгүй байдлын асуудлаар эрхзүйн үзүүлэлт бий болгох

Практикт, гүйцэтгэх засаглал аюулгүй байдлын холбогдолтой хууль эрхзүйн актын төслийг боловсруулдаг. Гэсэн ч парламентын гишүүд нь дээрх хуулийн төслүүдийг шүүн хэлэлцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Шаардлагатай бол парламентын гишүүд төсөлд өөрчлөлт оруулах замаар аюулгүй байдлын шинэ үзэл санаа хуулинд тусгалаа сайн олох нөхцлийг хангадаг. Түүнчлэн хуулийн акт зүгээр цаасан дээр үлдэх биш, харин түүнийг бүрэн дүүрэн мөрдүүлэх нь парламентын үүрэг юм.

Ард түмэнтэй холбох гүүр

Гүйцэтгэх засаглал аюулгүй байдлын асуудлаар иргэд ямар ойлголттой явааг бүрэн мэдэхгүй байх талтай. Парламентын гишүүд нь олон нийттэй байнга холбоотой байдаг тул тэдний үзэл бодлыг маш сайн ойлгосон байдаг. Иймээс парламентын гишүүд нь иргэдийн үзэл бодлыг парламентад гаргаж тавих, улмаар аюулгүй байдлын талаарх хууль болон бодлогод тусгуулах чадвартай. Ард түмнийг төлөөлөх энэхүү үүргийнхээ ачаар парламентын гишүүд нь АБ-ын бодлого болон АБСШ-ын талаар засгийн газраар ардчилсан хууль ёсонд нийлцүүлэн аливаа шийдвэр гаргуулах цор ганц боломжийг бүрдүүлж өгдөг.

Аюулгүй байдал ба эрх чөлөөг тэнцвэржүүлэх

Хүйтэн дайн дуусгавар болсоноор аюулгүй байдлын байгууллагууд (АББ) аюулгүй байдлын шинэ орчинтой нүүр тулсан билээ. Задран унаж буй улс гүрнүүд, терроризм, үй олноор хөнөөх зэвсгийг хяналтгүйгээр дэлгэрүүлэх, улстөрийн заналхийлэл, зохион байгуулалттай гэмт хэрэг зэргээс өнөөдрийн аюулгүй байдлын аюул заналыг харж болно. Ялангуяа, 9-р сарын 11-ний дараагаар терроризмын эсрэг олон шинэ хууль эрхзүйн актууд гарч, холбогдох арга хэмжээнүүдийг авлаа.

Харин АББ-ууд ардчиллын зарчмаар харин зөв сонголт хийх нь чухал юм. Ийм учраас, нэгдүгээрт, 'өмнөх дайныг генералууд бэлдээгүй юм' гэдэг шиг шинээр үүсээд байгаа аюулгүй байдлын орчинд нийцсэн хэрэгцээ шаардлагыг АББ-ууд хангах баталгааг парламентууд гаргах ёстой. Хоёрдугаарт, АББ-ын шинээр гаргаж буй дүрэм журмууд, тэдний үйл ажиллагаа нь үндсэн хууль, олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хууль тогтоомжид баттай нийцэж буйд парламентууд ямагт хяналт тавьж ажиллах ёстой.

Аюулгүй байдлын секторт парламентын зүгээс хяналт тавихад тулгарах бэрхшээл

АБС-т тавих парламентын хяналт мэдээжийн хэрнээ, дээр дүрсэлсэнчлэн, олон оронд харилцан адилгүй хэрэгжиж байна. Ардчилал хөгжсөн болон ардчилах шатандаа байгаа олон оронд парламент нь ноцтой сорилтуудтай тулгараад байна:

- ✓ Нууцлалын тухай хууль нь АБС-ын ил тод байдалд саад тотгор учруулж болзошгүй. Ялангуяа, ардчилал дөнгөж хөгжиж буй орнууд болон байнгын дотоодын хямралтай орнуудад мэдээллийн эрх чөлөөний хууль байхгүйгээс нууцлалын хууль нь АБС-т тавих парламентын хяналтыг хязгаарлах буюу бүр үгүйсгэж болох юм.
- ✓ АБС нь маш нарийн салбар тул зэвсгийн наймаа, галт зэвсгийн хяналт, цэргийн анги, нэгтгэлийн бэлэн байдал/бэлтгэлтэй байдал зэрэг бүх ээдрээтэй зүйлд парламентийн зүгээс хяналт тавих шаардлагатай. Парламентын гишүүн бүр эдгээр асуудлаар хангалттай мэдлэг, туршлага байдаггүйгээс үр дүнтэй байж чаддаггүй. Парламентын гишүүд нь цаг зав муутайгаас гадна дотоод, гадаадын мэргэжлийн эх сурвалжид хандах боломж дутмаг байдаг тул дээрх бүх асуудлыг судлах, боловсруулах боломж тун бага байдаг.
- ✓ Олон улсын аюулгүй байдлын өргөн дэлгэр хамтын ажиллагаа нь тухайн нэг улсын аюулгүй байдлын бодлогын ил тод байдал, ардчилсан зүй тогтолд нөлөөлсөнөөр парламентыг процессын гадна орхиод хүргэх болно. Ийм учраас парламент нь олон улсын тавцны мэтгэлцээн болон шийдвэрт санал оруулах, оролцох, дүгнэх боломжоор хангагдсан байх нь маш чухал юм.

Парламентын хяналт нь ардчилал, аюулгүй байдлын аль алины ашиг сонирхолд нийцнэ гэдгийг цэргээс авахуулаад, иргэний нийгэм, гүйцэтгэх болон ардчилсан засаглал хүртэлх бүх оролцогч байгууллагуудад ойлгуулах явдал л харин хамгийн ноцтой сорилт байж магадгүй юм.

Практик

Ингээд АБС-ын нэг салбар болох тагнуулын албанд парламентын зүгээс хяналт тавьж эхэлсэн зарим орнуудын туршлагыг жишээ болгон авч үзье⁵⁰. АНУ-1974, Канад-1984, Их Британи-(1989) 1994, Аргентин-1992, Өмнөд Африк-1994, Өмнөд Солонгос-1994, Норвег-1995, Польш улсад 1995 онд тус тус хууль гарч, тагнуулын байгууллагад парламентын зүгээс хяналт тавьдаг болжээ.

Эдгээр найман оронд янз бүрийн улстөрийн системтэй (парламентын ба ерөнхийлөгчийн ардчилал), ардчилал янз бүрийн шатанд хөгжсөн (“шинэ” ба “хуучин” ардчилал), нэг хэт том гүрэн, газарзүйн хувьд бага ба дунд хэмжээний газар нутагтай, янз бүрийн тивд (хойд ба латин америк, европ, африк, болон ази) орших улсууд багтсан байна. Харин эдгээр улсуудыг нэгтгэж байгаа зүйл гэвэл, бүгд ардчилсан орон, тэдгээрийн парламент нь тагнуулын байгууллагын үйл ажиллагаандаа хяналт тавих хороотой, тагнуулын байгууллага нь өөрөө зохих хууль тогтоомжийн үндсэн дээр ажлаа явуулдаг болно.

Дээрхээс үзэхэд, тагнуулын байгууллагад хяналт тавих парламентын хороонууд ердөө сүүлийн 20 жилд л үндсэндээ байгуулагдсан байна. Энэ нь шинээр ардчилах замд орсон улс ч бай, хуучин ардчилалтай ч бай ялгаагүй тагнуулын байгууллагын хяналтыг саяхнаас л “парламентжуулсан” гэдгийг харуулж байна.

Олон оронд тагнуулын байгууллагатай холбогдох гутамшигт явдал илчлэгдэж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ихээр цацагдсаны дараагаас энэ процесс эхэлсэн байдаг.

⁵⁰ Hans Born, Between Efficiency and Legitimacy: Democratic Accountability of the Military in the US, France, Sweden and Switzerland, DCAF Working Papers No.102, Geneva

Баруун европын хэд хэдэн улсад Европын хүний эрхийн шүүхээс гаргасан “хувийн өмч болон хувийн амьдралд халдахад хүний эрхийг зөрчиж болзошгүй тул хуулиар олгогдсон эрхтэй байвал зохино” гэсэн шийдвэр нь тагнуулын байгууллагад парламентын хяналт тогтооход түлхэц болсон байдаг.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“УЛААН ТҮҮХ” -ИЙН БОСГОН ДЭЭРХ БОГДЫН ХҮРЭЭ

(Нийслэл Хүрээ – 100 жил“ сэдэвт Эрдэм шинжилгээний хуралд зориулав)

*Г. Чулуун***Оршил**

Улсын нийслэл - Улаанбаатар хот маань олон зуунаар хэмжигдэх арвин баялиг түүхтэй. Буурал их цадиг түүхийнхээ буман нугачаанд монголын “нийслэл” нүүж сууж, ойж бууж ... мөн, олонтаа нэр зүсээ сольж өөрчилж ирсэн нь судлаач түүхчдийн ач оролцоогоор эдүгээ нэгэнт ил тодорхой зүйл болжээ.

Үүссэн цагаасаа хойш, ямагт монголын нийгмийн шашин соёл, улстөр, эдийн засгийн гол төв байж ирсэн, монголчуудын эх оронч сэтгэлгээ, оюун санаа, үзэл төлөвшлийн “үүрдийн [энэ] гал голомт” маань “улсын нийслэл” тодотголоо албан ёсоор анх зүүсэн, тэр цаг, харьцангуй хожуу, Богд хаант Монгол Улсын үед тохиожээ.

Өнөөдөр, тэр түүхэн мөчийн 100 жилийн ой болж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас олон сайхан арга хэмжээг ёслол төгөлдөр хэрэгжүүлж байгаагийн нэгд, бид илтгэл тавин оролцож байгаадаа баяртай байна. Эрдэм шинжилгээний хурлын элч төлөөлөгч та бүхэндээ энэ их ойн баярын, элгэн халуун мэндчилгээг өргөн дэвшүүлэе.

Түүх бол, жишээ нь, эцэс төгсгөлгүй дайн тулаан, эртний мэргэдийн намтрын ойллого, он цагийн түүхэн хэлхээс ...зэрэг, жишээлсэн бачуу ойлголтоос ямагт давдаг ... бүр тэдгээрийг нийлүүлж багцалснаас ч илүү өргөн дэлгэр агуулгатай нь мэдээж юм. Түүх гэдэг эгэл жирийн хүн ардын эрхи маанийн явдлаас эхлүүлээд ... эзэн богдын лүндэн, засаг төрийн зарлиг, зарлагын элчийн осол, намрын отор, өвлийн зуд, өнийн мөрөөдөл ... эд бүгдийг цөмийг багтаасан, товчдоо, тухайн нийгмийн гадаад дотоод харилцаа, үйл - үрийн харилцан шүтэлцээ, хүн зоны аж амьдралын утга учир тухайн цагийн орчилдоо ямаршуухан байж вэ; гэдгийг тодруулдаг.

Бид эл бяцхан илтгэлдээ, олноо өргөгдсөний он жилүүдэд Нийслэл хүрээний захиргааны хэргийг хэн эрхэлж байв [хотын дарга хэн байв], Хүрээний цэрэг цуух ямар байв ... гэхчилэнгийн жижиг сажиг асуудлыг цухасхан сөхөж хөндөхийн зэрэгцээ, гадаадын түүхэн зарим сурвалжийг ашиглан, тэр үеийн Нийслэл хүрээний аж амьдралын судлагдаагүй зарим аспектыг өнгөцхөн хөндөхийг хичээсэн болно.

Нийслэл хүрээний аж байдлыг тод томруунаар бичиглэн үлдээсэн бичгийн цогц өв монгол хэл дээр санасан хэмжээнд хадгалагдан үлдэж чадаагүйг тэмдэглэхийн сацуу, тухайн цаг үе нь өөрөө, бас ч гэж XX зууны эх юм болохоороо, үгүй дээ л, гадаадын хүмүүсийн дурдатгал дурсамжид Богдын хүрээний болсон явдлууд оочин цоочин, дажгүй сайн тэмдэглэгдэн үлдэж чаджээ.

Хэрэв бид, тууштайхан ... бодлоготойхон байж, тэдгээрийг нэгмөр нэгтгэн судалж дүгнэж гэмээнэ, хожмын “улаан түүх” –ийн босгон дээрх Богдын хүрээ (улсын нийслэл) –ний бодит дүрийг “байснаар нь зураад” гаргаад ирж чадах юм. Мөн, энэ чиглэлийн багц ажлыг Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар цаг алдалгүй санаачлан эртнээс эхлүүлж, түүнийгээ эдүгээ зүйл бүрээр улам лавшруулан эрчимжүүлж байгааг ч, энд дурдан хэлэх нь зөв болов уу.

* * *

1. Улстөрийн “мад” –наас улс орноо аварсан Богдын хүрээний “уран нүүдэл”

Хутагтын өргөө Их хүрээ болтлоо их олон нүүсэн. Хүрээний олон нүүдлийг бид дан ганц механик шилжилтээр төсөөлж бас болохгүй нь ээ. Өөр нүүдэл бас байж. Улстөрийг урлахад шатар ухаан хэрэгтэй; гэж нэг их мэргэн хүн хэлсэн байдаг. Тэрэн шиг, монгол эх орны маань гал голомт болсон Их хүрээний эзэн ноёдууд, чухамдаа, улстөрийн шатар нүүж, их гүрнүүдийн геополитикийн далан түмэн нугачаан завсарт нэгэн “уран гайхамшигт нүүдэл” хийснийг эхлээд товчхон дурдсу.

Монголчууд, XV дугаар жарны цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 (1911.12.29) -ний өлзий дэмбэрэлт, өнийн барилдлагат энэ сайн өдөр, өөрийн, төр - улсын бүх бодлого ба үйлийг Манж Чин гүрнээс тусгаарлаж, эцэг өвгөдийн эртний нандин өв болсон - улс гэрийнхээ тусгаар тогтнолыг ахинтаа сэргээн мандуулж байгаагаа дэлхий даяар зарлан тунхагласан юм.

Тэгш дүүрэн, билигт сайн, гайхамшигт төдийгүй баясгалант эл мэдээг сонссон эсгий туургатны их бүлийн эгэл түмэн, чухамхүү “тэнгэрийн цаг ирлээ” хэмээн сэтгэж, “цаглашгүй баярын нулимс унаган, цай сүүнийхээ дээжийг өөд өөд нь өргөн, ... мөргөн сүслэн залбирч амуй” –г тухайн үеийн түүхэн гэрчүүд тэмдэглэн үлдээсэн нь бий бөлгөө.

Тэрхүү гэгээн баярт явдлыг нүдээр үзсэн, дамаар сонссон ... басхүү түүнд, хир чинээгээрээ оролцсон гадаадын цөөнгүй орны элч төлөөлөгч, хэвлэл мэдээллийнхэн түүхэн тэр үйл явдлаас төрсөн зерэг сэтгэгдлээ түмэн олонд түгээн дэлгэрүүлсэн мэдээ сэлт зөндөө байдаг. Тухайлбал, Английн “Times” сонин “Богд хаант Монгол Улс [дахин] сэргэн мандсан нь бодит явдал мөн болой” хэмээн 1911 оны шувтаргын сүүлийн дугаартаа онцлон тэмдэглэж байжээ.

XIX зууны сүүлч, XX зууны эхэн үе нь, цаг түүхийн хувьд, тив дэлхийн улс гүрний нийгэм - улстөрийн дотоод гадаад харилцаанд онцгой бөгөөд огцом их өөрчлөлтийг авчирснаараа үнэхээр онцлог. Тухайн үеийн дэлхий дахинаа, тодорхой бүс нутгийг өмчилсөн [шинжтэй] эзэнт их гүрнүүдийн ... түүний дотор, Чин династи [хятад] –ийн цагийн аясыг сөрөх гэсэн жам ёсны үйл явцыг бодлогогүйгээр эсэргүүцэх ухвар мөчид ажил оролдлогууд ээлж дараалан бүтэлгүйтэв. Улмаар хятадын өөрийнх нь дотоодын байдал ч хямарсан.

Хорвоогийн бүх юмс үзэгдэл харилцан холбоотой. Энэнд, бие даан өсч өндийх замаар ... өөрийн хүчинд тулгуурлан улс гэрээ засах ... хөгжин дэвжих гэсэн бидний монголчуудын туйлын хүсэл тэмүүлэл ч багагүйгээр нөлөөлсөн нь дамжиггүй.

Сүүлдээ Манж Чин гүрний төрийн бодлого улам бүр хахиржиж, тэр нь, монголчуудад болон монголын бусадтай харилцах харилцаанд үл итгэсэн байдлаар байнга илэрч, улмаар “хар үйл хэрэг” болон хувирч байв. Манжууд, монголын хил хязгаар нутагт, мөн Их хүрээнд цэрэг харуул суулгахаас өгсүүлээд ... яван явсаар тэдгээр нь, монголчуудын уламжлалт аж ахуй, газар нутгийн бие даасан байдлыг шууд хөндсөн их гүрний эзлэн түрэмгийлэх явуулга болж хувирсан юм. Үүнийгээ манжууд “шинэ засгийг” бодлого гэж тодорхойлж байлаа.

Чин династийн төрийн бодлогод гарсан чанарын энэ таагүй өөрчлөлт, нөгөө “сул тал” –даа буюу вассаль хөршдөө хэзээ ч нөхөшгүй гай барцад дагуулж тусах нь улам бүр илэрхий болж байгааг монголчууд зөвхөн амьдрал ахуйгаараа биш, бүр, зөн совингоороо, зүрх сэтгэлээрээ “үржүүлэн” мэдэрч байлаа. 1910 он гэхэд, монголын гадаад дотоод улстөрийн байдал нэн хүндэрч, эх орны гал голомт болсон Их хүрээнээ, монголын ноёдууд, хэрэг дээрээ, бэрсэндээ ацтай нээнтэгт орсон, бэлэн эзлэн мадын заналд нэгэнт өртсөн байв. Байдал бараг авралгүй талдаа ...

Тэгтэл биднийг тэнгэр ивээжээ. 1911.10.10 –нд хятадад улстөрийн бослого хөдөлгөөн өрнөж, хувьсгал дэгдэн, иргэний дайн эхлэв. Хэсэгхэн хугацаа өнгөрөхөд, хөрш хятадад зэрэгцээ гурван Засгийн газар бий болж, тэд өвөр зуураа хэмлэлдэн, монголыг тэд хэсэгхэн зуур мартахаас өөр аргагүй байдал үүслээ.

Энэ сиймхийг монголын ноёд удирдагчид ухаалигаар, тун уран чадварлаг ашигласан юм. Тэд Манжийн хаантай итгэмжит холбоотны харилцаагаа нэн даруй зогсоож, улс үндэстнийхээ тусгаар тогтнолыг зарлан тунхагласан нь, эцсийн дүндээ, бараг хожигдоод байсан [нөгөө] “эргийг аврах”, “ничээ салгах” уран цэцэн нүүдэл болов.

Түмэн зүйлийн тэмцэл зовлонг туучин байж монголын ...11 оны үндэсний их хувьсгал амжилтыг олсон ерөнхий дүр ийм бөлгөө. Монгол түмний үндэсний их хувьсгалын өлгий болсон Халхын хүрээ, Их хүрээнээс ... эгэл түмнээ “ирж байсан гамшгаас” эгнэгт аварсан эрэлхэг түүх ингэж эхэлдэг.

2. Халхын хүрээ Нийслэл хүрээ болж нэрээ өөрчилсөн үү, аль эсхүл ...?

Энэ их сонин асуулт юм. Улаанбаатар хотын урьд эртийн нүүдэл суудал ... тэдгээрээс улбаалж хувирч өөрчлөгдсөөр ирсэн [оноосон] олон нэрийн дотор, “Халхын хүрээний газар” гэх нэр хэллэг харьцангуй цөөн таардаг.

Их Хүрээ, Да Хүрээ, Богдын хүрээ ... гэх мэт өргөн түгээмэл нэрийн сүр бараанд дарагдаад, тэгж, нийтийн дунд хэрэглээ багатай үлдсэн болов уу гэмээр, энэ, “Халхын хүрээний газар” нь, яг нарийн дээрээ, 1912.02.07 -нд албан ёсоор шинээр үүсгэсэн “Нийслэл хүрээ” нэрийн “зулай дээр завсаргүй оршин буй”, өөрчлөлтийн өмнөх хуучин нэр нь юм. Товчдоо, Их хүрээ ч Нийслэл хүрээ болсон, Халхын хүрээний газар ч Нийслэл хүрээ болсон; гэлтэй.

“Их хүрээ” нэртэй өрсөлдөх маягтай хэлэгдэж байгаа “Халхын хүрээний газар” гэсэн энэ нэр, уншигч танд, “тэгээд аль нь юм бэ” гэх эргэлзээг төрүүлэх нь лавтай. Эл асуултад шуудхан хариулахад бас амаргүй байна. Юутай ч, эх баримтад түшиглэсэн нь [хэл найруулгаасаа хүртэл илэрхий байгаа] ШУА –ийн Түүхийн хүрээлэнгийн холбогдох зарим мэдээ сэлтийг сөхье.

Баримт_1

Довтолгон яаран сонсон явуулах учир: “... [Улсын тусгаар тогтнолыг сэргээн зарлахын өмнө] энэ жил зун цаг манай халхын дөрвөн аймгийн хан, ван, гүн, олон засгууд шарын шашныг өрнөн дэлгэрүүлэх ба улс-төр баттаж, амар цэнгэлээр жаргах учир бүгдээр санаа нийлж зөвлөлдсөн явдлыг нэгэнт тогтсоны тулд, одоо монголчуудыг яахин амаржуулбаас зохихыг эвхмэл бичиж, Очирдара Богд гэгээнтнээ айлтгаад, буулгасан лүндэн зарлигийг ёсоор сийрүүлж хичээнгүйлэн дагаж, нийтээр олон газраа довтолгон ... [гээд], Халхын хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх Да түшээ гүн Ча “явуул”, хамаарсан да жүн ван Го “явуул”, Халхын хүрээний газрын бүгд хэргийг түр зөвлөн шийтгэх жанжин чин ван Ха, хамаарсан жанжин бэйс Го “үзэв”, ван Цэ, гүн На “үзэв”, да лам Цэ “үзэв”, гэжүхүй.

Дээрх бичигт гарч байгаа “Халхын хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газар” гэдэг нь, энгийнээр хэлбэл, “хуучин засаг” –аа хэлж байгаа хэрэг. Тэгэхээр хуучин засаг “Халхын хүрээний газар” –т оршин бүхүй; гэсэн санаа гарч ирээд байна.

Баримт_2

Мөн, “... Шашин төрийг хослон барьсан эзэн хааны зарлигаар төрийн таван яамнаас бүрдсэн Монгол Улсын байнгын Засгийн Газрыг байгуулнаар, Халхын хүрээний газрын Бүгд хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газрын үйл ажиллагааг үргэлжлүүлэн авсан болмуй. Цагаагчин гахай жилийн өвлийн тэргүүн сарын 10 [хэмээгээд], үүнийг басхүү их Орос улсын генерал консул сайдтанд сонсон явуулаад, зохих газраа

уламжлан гүйцэтгэх ажааму. Үүний тул өргөн илгээв” гэсэн байна.

“Халхын хүрээний газар” гэдэг ухагдахууныг анхаарахуйд, тэрэн дотор “халх даяарын нутаг газар”⁵¹ санаа байна; гэж хэлэх үндэс үгүй мэт санагддаг. Жишээлж дурдсантай төсөөтэй бусад олон түүхэн бичвэрээс үзэхүл, Халхын хүрээний газар гэдэг нь Хүрээ, Их Хүрээг хэлээд байх шиг байгаа юм. Сайтар нягтлах хэрэгтэй.

Дашрамд тэмдэглэхэд, их сэтгэгч Н. Бердяев “өнгөрсөн түүхээ хайхардаггүй, түүнийг, оргүй хоосноос цоо шинээр эхлэх гэж зүтгэдэг ард түмэн - золгүй ард түмэн” гэсэн гэдэг. Бид золгүй ард түмэн биш ажээ. Эзэн хааны зарлигаар байгуулагдсан “олноо өргөгдсөн” Монгол Улсын Засгийн Газар нь Халхын хүрээний газрын Бүгд хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газрын үйл ажиллагааг “үргэлжлүүлэн авсан” –ыг ч, эндээс бас харж болж байна.

Баримт_3

Нэгэн баримтаас эшлэхүйд, “Хүрээний Намба номун хан, Дуйнхор хутагт, хамаарсан шанзудба нарт довтолгон явуулаад, уламжлан өөр өөрийн харьяат аймаг шавийн хан, ван, гүн, олон засгууд, хутагт хувилгаан лам нарт, [хааныг] нийтээр эрдэнийн сууринд залж суулгахын наана эрхгүй нэгэн дэсээр Их Хүрээний газраа хуралдан ирж, улсын их ёслолыг хичээнгүйлэн гүйцэтгэхээс гадна төрийн монгол орд байгуулах ба бат оршил өргөх зэрэг зүйлийг дараа өөр зарлан тушаасугай. Өргөн илгээв” гэжээ.

Энд, “Хүрээний хамба”, “Их Хүрээний газар” гэсэн анхаарууштай 2 хэллэг гарч ирж байна. Их хүрээний газар гэдэг нь Халхын хүрээний газар гэдэгтэй утга ижил бол, чухамхүү, сүүлчийнх нь нэр л Нийслэл хүрээ болж хувирсан болж таарахаар байгаа юм. Энэ тал дээр цаашид түүхчид үгээ хэлэх биз ээ. Мөн, [хожмын Ерөнхий сайд] Догсомын Бодоо “Үйлийн чанарыг үлгэрлэсэн үзэмжит [нэгэн] үгүүлэл” –дээ Их Хүрээг [бас] Халхын Түшээт хан аймгийн хүрээ гэж нэрлэсэн нь бий. Хүрээний хувирч өөрчлөгдсөөр ирсэн олон нэрийн жагсаалтад энэ ч бас орно; гэж үзэж байна.

Баримт_4

Дашрамд өгүүлэхэд, манай анхдугаар Үндсэн хуульд их оросын нөлөө их туссан. Улсын анхдугаар их хурлаар Нийслэл хүрээний нэрийг өөрчлөх асуудал яригдав. Улсын анхдугаар их хурлын ... тэмдэглэлд өгүүлснээр, 26 дахь өдрийн хуралдаан дээр **Нийслэл хүрээний нэрийг өөрчлөх** талаар асуудлыг хэлэлцэж, олон хүн санал гаргажээ. Тухайлбал: Баатарвангийн хошууны мэрин Дамдинсүрэн “Монголын Бээжин” гэе гэхэд, Богдхан уулын аймгийн Бавуу “Ар Бээжин гэвэл зохилтой” хэмээв. Мөн, Хан-Хөгшин уулын хошууны Дуламдорж “**Их хүрээ**”, Хүрээ маралын уулын хошууны занги Гиваа “Баатар хот” гэе ... гэх зэргээр олон санал гарсан байдаг. Тэдгээрийн дотор Коминтерны төлөөлөгч Рыскулов ... нар монголчууд олон баатартай, тэднүүс улаан намын баатрууд байх ёстой. Иймд, **Улаанбаатар** гэдэг нэр өгье, гэж зөвлөсөн тухай баримт байдаг болтой юм. Удтал, зөвлөлдсөний эцэст Улаанбаатар гэдэг дээр санал нэгдэж ... батлан, төлөөлөгчид босч алга ташсан түүхтэй юм байна.

⁵¹ 1691 оны 5 сард Долоннуурт Манжийн хаан Энх–Амгалан халх монголыг Манж улсын бүрэлдэхүүнд багтаах ёслолыг үйлдэж, уг чуулганаар халхын засаг захиргааны зохион байгуулалтанд өөрчлөлт оруулав. Тэр өөрчлөлтөөр, Түшээт хан 9, Сэцэн хан 11, Засагт хан, Сайн ноён хан тус бүр 7 хошуутай болж ... ийнхүү, халхыг бүгд 34 хошуу болгон жижиглэжээ. Улмаар манжийн засгийн бодлогоор хошууд улам улмаар жижгэрч олширсоор XX зуны эхэн болоход, монголд 86 хошуу, 13 тамгатай хутагтын шавь, богд Жавзандамба хутагтын Их шавийн 17 их отог, 93 бага отог, тусгай 30 баг болон хуваагдсан бөгөөд энэ нь онцын өөрчлөлтгүйгээр байсаар 1923 онтой золгосон. Манжийн ёс халагдахад, тэдгээрийг тухайн нутаг орны уулын нэрээр нэрлэсэн. Энэ нь удалгүй, засаг захиргааны бүтэц зохион байгуулалт үндсээрээ эрс өөрчлөгдөхийн эхлэл болж өгчээ.

3. Халхын хүрээний газар Нийслэл хүрээ болж өөрчлөгдөх угтвар нөхцөл

Халхын хүрээ - Нийслэл хүрээ болж өөрчлөгдсөн нь, “улс гэрийн тусгаар тогтнол” гэсэн ухагдахуун дор зангидагдаж, төрийн чигч тууштай бодлогын дагуу зэрэгцээ болон дараалан өрнөсөн олон чухал түүхэн үйл явдлуудаас ангид салангид зүйл биш байв.

Үндэснийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолыг сэргээн тогтоох, улсаа мандуулахын төлөө зуун зууныг дамнуулан хийсэн урт тэмцлийн, нэг ёсны “барилцар зурхай” болж өгсөн 1910 – 1911 онуудад, монголчууд бид, улс үндсээрээ, гэр хотлоороо [ёстой л] гар газар, хөл хөсөр тавихыг умартан зүтгэжээ. Шийдвэрлэх ач холбогдол бүхий гол үйл явдлууд, мэдээж хэрэг, Богдын хүрээнд өрнөсөн. Тэдгээрээс цөөн хэдийг [дараалалд нь төдийлэн ач холбогдол өгөлгүйгээр] жагсаан дурья. Үүнд:

- Чин династийн “шинэ засгийн бодлого” монголын нийгэмд хүндээр тусав;
- 1910 онд, Их хүрээнд гарсан “улстөрийн сэдэлтэй” лам нарын үймээн [зодоон] болов. Энэ мэт нь ... ижил төстэй олон хэрэг явдлуудын нэг л жишээ юм.
- Овоо Дунжингараво –ийн ойд хэсэг монголын дээд лам - ноёдын нууц хуйвалдаан болов;
- 1911.4.21 –нд Халхын дөрвөн аймгийн хан, чуулган дарга, жанжин тэргүүтэй ноёд, хамба, шанзудба ... нарын зэрэг эрх мэдэлтэн Их Хүрээнд цугларч, Жибзундамба хутагтад бат оршил өргөхөөр [мөн], Эрдэнэ Шанзудбын яаманд нууц зөвлөлгөөн хийж, Чин улсын “шинэ засгийн бодлого” –ыг [хэрхэх талаар] зөвлөлдөжээ.
- Орос улсад явсан төлөөлөгчид уван цуван эгж ирсний дараа Их Хүрээнд монголын тусгаар тогтнолыг тунхаглах чиглэлд бэлтгэл ажил эрчимжив.
- Халхын хүрээний газрын дээд лам, ноёд язгууртнууд “дахин давтан хянан бодолхийлж, боловсортол шүүмжлэн хэлэлцэж, зөвлөлдөн төлөвлөөд” ... “улс гэрээ манжаас тусгаарлана” гэдэг дээр нэгдмэл шийдэлд хүрэв.
- 1911.11.28 –нд “Эдүгээ Хүрээнд сууж бүхий Халхын ван, гүн, засаг нар хамба, шанзудба, да лам нарын [албан] бичиг” үйлдэгдэж, улмаар түүнийг Богд гэгээнтнээ өргөн барив. Уг бичигт, “...Одоо өмнө газар их самуун дэгдэж олон шинэ төр байгуулан улс болон тогтож буй чимээ машид олон болсон ба Манжийн хаан аймагтны эрх мэдэл тун ч өчүүхэн болжээ. Иймд шавь нар бид бүхэн яахин хүмүүжвээс сайн болохыг тодорхойгоор айлдахыг хүснэ” гэжүүхүй
- Богдын Хүрээнд төрийн эргэлт (1911.11.28) болов.⁵² [Өмнө дурдсан бичгийн хариу болгож, мөн өдөр], Богд гэгээнтнээс үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийг эрс шийдэмгий явуулах лүндэн буулгав. Богдын лүндэн дотор “... Ийнхүү асуусан нь маш сайн. Ер нь аливаа юманд цаг хэмжээгүй нь огт үгүй. Манж, хятадын энэ байдал мөн цаг болсны тулд болой. Одоо монгол овогтон бүгдээр нийлж, өөртөө улс болон тогтнож, шашнаа мандуулан бусдын эрх мэдэлд дарлагдах зовлон зүдгүүрийг үзэхгүй болох цаг болсон. Гэвч бүгдээрээ нэгэн сэтгэл хамт хүчин гаргаж чармайн зүтгэхийг харгалзана. Бас лам би олон монгол шавь нараа цөмийг нэгэн адил авралдаа авсаар бөлгөө. Миний энэ үгийг улам улмаар лам надад мөргөхөөр ирдэг олон монгол шавь нарт нийтээр нэгэн адил сонсговол зохино” гэжээ. Ингэснээр “үндэсний хувьсгал” –ын зам шулуудан, төрийн эргэлтийн дараахь дагавар үйл явдлууд “эргэлт буцалтгүй төлөвлөгөөт зорилт” болон хувирав.
- 1911.11.30 –нд Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар [Түр Засгийн Газар] –ыг байгуулав. Түр Засгийн Газрын⁵³ үндсэн зорилго нь монгол даяар өрнөж байгаа үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ашиглан, нэн тэргүүнд, Их Хүрээнд дэх Манж Чин улсын захиргааг түлхэн унагаж, Монголын төр улсыг сэргээх явдал байв.
- Халхын хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газар

⁵² 1911.11.18 –нд, Өргөөд төрийн эргэлт гарсан; гэж орос хэл дээрх олон эх сурвал зэрэг зэрэг нэгэн дуугаар нотолдог. Яагаад энд сар өдрийн зөрөө гараад байна гэдгийг хэд хэдэн янзаар ухварлаж тайлбарлаж болохоор байгаа юм. Өдрийн учрыг түүхчид амархан олчихно. Хамгийн гол нь, энд, болсон үйл явдлыг тэр үеийн Хүрээнд байсан оросууд, чухамхүү “төрийн эргэлт” мөн гэж үзсэн нь ихээхэн анхаарал татаж байгаа юм.

байгуулагдмагц, Богдын лүндэнг Өвөр Монголын засаг ноёд, Барга, Алашаа, Хөх нуурын монголчуудад яаралтай дамжуулав. Энэ ялдараа, Жибзундамба хутагтыг Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөх гэж байгааг ч давхар мэдэгдэв.

- Монгол Улсаа “бүрэн тусгаар тогтнов” хэмээн тунхаглан (1911.12.29) зарлав;
- Халхын хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлэн захиран шийтгэх газар мөн өдрийн оройн 7 цагт Их Хүрээн дэх Чин улсын сүүлчийн сайдыг 3 хоногийн дотор монголын хилээс гадагш гарах шаардлага талбив.
- Улс орноо хамгаалах, тавьсан зорилгоо гүйцэлдүүлэх баталгааг хангах зорилгоор Их Хүрээнээ цэрэг зэвсэг хуримтлуулж, зэвсэгт бослогод бэлтгэв. [Энэ тухай зарим тодруулж, Хүрээний цэрэг дэд гарчиг өгүүлэх болно]
- Монгол Улс бие даасан, бүрэн эрхт, тусгаар улс болсноо дэлхий нийтэд тунхаглахын ялдараа, гадаадын олон улс гүрэнд энэ тухай “сонордуулсан захидал бичиг” илгээв. Мөнхүү тунхаг бичгийг Хүрээний газрын гудамж талбай, зах зээлийн газраар нааж түмэнд түгээв.
- Бурханы шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт, Очирдара Богд гэгээнтэнийг Монгол Улсын эзэн хаанд өргөмжилж, эрдэнийн сууринд залав эзэн хаанд өргөмжлөв;
- Чин улсын сайдын яамыг устгаж, харъяат яам ба сайд түшмэдийн гэр, хашаа юмсыг тусад нь гарган данслуулаад, сэргэн мандах яамдын суурь болгохоор бэлтгэв.
- Манжийн сайд дэргэдийн түшмэдээ дагуулан Оросын консулын газар хоргодохоор явмагц Хүрээн дэх бүх хятад цэргийн зэвсгийг хураан авч, улмаар, харь консулын газар түр хоргодсон мөнөөх сайд түшмэдийг XII сарын 4 -нд монгол түшмэд цэргүүдээр харгалзуулан, Хиагт хүртэл өртөөгөөр явуулж, Монгол нутгаас үлдэн зайлуулав.
- Монгол Улсын Засгийн газрыг хааны зарлигаар эмхлэн ... яамдыг байгуулж, “төр үүтгэн төвхнүүлэх хэрэгт онц хүчин зүтгэсэн” нэр бүхий лам, ван, бэйс, гүн, тайжийг төрийн анхны 5 яамны тэргүүн сайдаар тохоон томилов;
- Богд эзэн хааны зарлигаар ахмад буурлуудад хишиг хүртээж, алдсан эндсэн ард иргэд [ялтан, хоригдол] -ээ өршөөв.
- 1912.12.03 —нд, Манж Чин улсын Хэвт ёс [Сюаньтун] -ны он тооллыг халж, монголын 12 жилийн цаг тоог баримтлан, тухайн оныг [хуучин тооллоор, цагаан сар болоогүй байв] “цагаагчин гахай” жил гэж нэрлэхээр шийдвэрлэж, мөрдүүлэв.
- 1912.02.07 —нд **Халхын хүрээний газарыг улсын нийслэл болгон зарлаж, Их хүрээ Нийслэл хүрээ** хэмээн нэрийдэв.
- Улс гэрээ сэргээн байгуулах, засан зайлшгүй бэлтгэлийг төв орон нутагт яаравчлан хийв.

* * *

Халхын хүрээний газрын нэр албан ёсоор солигдож Нийслэл хүрээ болж өөрчлөгдсөн нь туурга тусгаар Богд хаант Монгол улсын засаг төрөөс, нэгдсэн чиг бодлогын дагуу төлөвлөн хэрэгжүүлсэн цогц ... хоорондоо салшгүй хэлхээст олон ажлын эхний ээлжийн нэгэн чухал бүрдэл хэсэг, хийхгүй орхиж болохгүй “зайлшгүй арга хэмжээ” байсан нь, дээрх үйл явдлуудаас ил тод харагдаж байна.

Нийслэл хүрээ; гэдэг нэр нь [аль нэгэн] хот - хүрээ газрын статусыг өргөхөөс хол давсан, улсын тусгаар тогтнолыг бататгах, хамгаалах, улсаа мандуулах алс хэтийн гүн агуулгатай “бодлогот арга ажиллагаа” юм. Тэр түүхэн мөчид, Богдын хүрээнд “Нийслэл хүрээ” нэрийг өгөхгүй - авахгүй боломж байгаагүй [буюу], ингэх нь, цаанаасаа логикийн дагуу нэхэгдсэн “жам ёсны үйлдэл” байсан байна.

Дээрх бүрэн бус, хураангуйлсан жагсаалтаас үзэхэд, хожим Нийслэл хүрээ болж нэрээ өөрчилсөн Халхын хүрээний газар нь Монголын үндэсний хувьсгалын өлгий газар мөн гэдэг нь маргаангүй байна. 1911 оны Үндэсний хувьсгалыг монголчууд [үндсэндээ гадны гүрний оролцоогүйгээр] “олон монголчуудынхаа хүчээр” өөрсдөө хийсэн байна.

Зарим талаараа дүгнэлтийн чанартай байж болох энэ санаа, “улаан түүх” —ийн “Хувьсгалын өлгий [бол] Алтанбулаг” гэсэн хуучин ойлголтыг нэгмөр цэгцлээд зогсохгүй,

1921 онд монгол дахин хувьсгал мандсан уу, үгүй юу гэдэг асуудлыг ч эрс эргэлзээнд оруулж байгааг эрхэм уншигч абугай хэдийнэ анхаарсан биз ээ.

* * *

4. Нийслэл хүрээний он жилүүд (Он цагийн зааг - хүрээ)

Монгол Улсын шашин төрийг хослон баригч, оройн дээд чандмань, очирдара –ийн хувилгаан, шашныг мандуулагч, амьтныг жаргуулагч, итгэл бишрэлт, хамгийг айлдагч, бүгдийн багш, нарангэрэлт түмэннаст, наймдугаар Богд Жэбзундамба хутагт, Богд эзэн хааны бошго зарлигаар XV жарны гахай жил (1911) -ийн өвлийн сүүл сарын 22 (1912.02.07) –нд⁵⁴ Их хүрээг Нийслэл хүрээ болгож нэрийг нь өөрчилснийг, түүхчид эдүгээ баримтаар сайхан нотолжээ.

Ийнхүү Нийслэл хүрээний он жилүүд эхэлжээ. “Нийслэл хүрээний он жил” гэдэг нь, угтаа бол, “олноо өргөгдсөн” –ний он жилүүд юм. Түүнээс нэг их өөр юм биш (зарим бяцхан өргөтгөлийг эс тооцвол). Бид, энд Нийслэл хүрээний түүхийг, болж өгвөл, улсын түүхээс ялгаж харах санаа агуулж байгаа болно. Тиймээс энэ удаадаа “нийслэл хүрээний он жил” гэдгээр түр явъя.

Баримт ба эргэцүүлэл_5

Гэвч “Хутагтын өргөөт газар” –ын нэр солигдсон, ч дүр нь мэдээж хэвээрээ байсан. Түмэн олон, эгэл ардын бодлын хүрээний хуучин [тэр] Богдын хүрээ, тухайн цаг үеийн гадна дотно хүмүүсийн ой тойнд, шинэ нэрээрээ тэр дороо төдийлэн сайн хэвшиж - эвшиж өгөхгүй байсан бололтой байдаг. Би бяцхан жишээ дурдъя.

- [Их Оросын] эзэн хааны дипломат агент, Монгол дахь Ерөнхий консул А. Миллерийн 1915.8.20 –ны өдрийн “Заавал биелүүлэх тогтоол” –оор, автономит монголд суугаа оросын харъяат нарт [тодорхой] үүрэг ногдуулж, түүнийг үл биелүүлсэн этгээдэд, дайны цагийн хуулиар хариуцлага тооцно ... [гарын үсэг А.Миллер, Өргөө хот, огноо] гэсэн байдаг.
- Нийслэл хүрээ нэр бий болоод 4 дэх жилийн нүүрийг үзэж байхад оросын консул монголын нийслэлийг Их хүрээ ... Хүрээ ч гэсэнгүй, харин Өргөө гэжээ. Оросууд ер нь бүр хожуу [1921 онд] ч гэсэн Нийслэл хүрээг аанай л мөн Өргөө гэсээр байв. Монголчууд ч бас Нийслэл хүрээ гэхээсээ илүү, их төлөв Хүрээ, Богдын хүрээ гэдэг байлаа.

Их хүрээ “хууль зарлиг ёсоор” ингэж “нийслэл хүрээ” болсон нь монгол төрийн уламжлалт бодлогын далайцыг тодотгон харуулсан, цаанаа улстөрийн ил цагаан, гүн гүнзгий учир шалтгаантай ... эх орны голомтын ариун галд ... шар тос өргөж ... цучил нэмж бадраасан, цаг алдаагүй, эх оронч, жам ёсны зөв зүйтэй шийдвэр байсан нь маргаангүй юм.

Улсын нийслэл бол тусгаар тогтнолын илэрхийлэл, түүний нэгэн баталгаа болдог. Түшмэг, автономит, вассаль, өөртөө засан тохинох эрх бүхий [бусдаас] хараат орших тийм нөхцөлд “улсын нийслэл” гэж учиргүй чанга хашгиръя ч гэсэн, дуу хоолой цахиртаад ... нэг л сайн гарч өгөхгүй байх нь ойлгомжтой зүйл ээ.

Богд хаант Монгол Улсын тусгаар тогтнол [хууль эрхзүйн талаасаа] нэг их удаан тэсээгүйг түүх нотолж байна. Гэхдээ янз бүрээр өгүүлдэг. 1915 оны Хиагтын гэрээгээр Богд Хаант Монгол Улс нь Дундад Иргэн Улсын “автономит” эрхтэй муж болсон тул 1915.6.09 –нөөс

⁵⁴ Хэдийгээр, Түр Засгийн Газрын нэр нь “Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар” боловч Нэгдсэн [их] Монгол Улс байгуулах зорилготой нь холбогдож, үйл ажиллагааных нь цар хүрээ Халхын дөрвөн аймгаар хязгаарласангүй, нийт монгол аймаг, хошуудын нутгийг хамрах шинжтэй болсон.

эхлэн, он тооллын “олноо өргөгдсөн” цолыг хэрэглэхийг хорьсон байв. Үүнтэй лүгээ нэг шалтгаанаар, мөн өдрөөс Нийслэл хүрээ нэр ч “хүчингүйдэх” үндэс бүхий болсон; гэж үзнэ.

Үүнийг эш болговол, Нийслэл хүрээний он жилүүд нь 1912.02.07 – 1915.6.09 –ний хооронд багтана гэсэн үг. Гэтэл цаг хугацааны энэ интервалыг бүр илүү багасгах нигууртай өөр түүхэн явдлын талаар ч гадаад эх сурвалжид тэмдэглэсэн зүйл нилээн бий.

Тэр юув гэхээр, цэргийн түүхч, хурандаа М. Г. Торновскийн⁵⁵ өгүүлж байгаагаар 1912.11.03 –нд Орос – Монгол хоёр талаас гэрээ байгуулав. Уг нь, манайхан, оросоор тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх хамгаалуулах санаа агуулсан бололтой байгаа юм. Гэрээн дээр, монголын талаас Бүх яамны сайд, оросын талаас хаант оросын Өргөөд суугаа Ерөнхий консул [элчин сайд] И. В. Коростовец (1862 - 1933) нар гарын үсэг зуржээ. Энэ гэрээгээр, хэрэг дээрээ хаана ч харъяалалгүй шахуу байсан манай Урианхайн хязгаарыг оросууд “булаагаад” авчихсан. Оронд нь тэд монголын “бие даасан байдал” [тусгаар тогтнол биш] –ыг хүлээн зөвшөөрч, манайхыг шаардлагатай үед хятадуудаас хамгаалах үүрэг хүлээнэ [бас яг ч “хамгаална” гээгүй болтой] ... гэх мэт олон зүйл дээр тохиролцсан байдаг.

Монголчууд ингэж өөрийн тусгаар тогтнолыг хамгаалах [зөвшөөрүүлэх] гээд, хэрэг дээрээ, өөрийгөө “тусгаар тогтноогүй улс” болгон “хүний аманд орж” тас гэдрэгээ савж унасан байв. Хүчгүйн зовлон их.

Баримт_6

[Энэ тухай “номч мэргэн” дипломатч Д. Баярхүү ийн бичжээ] 1912.11.03 –нд, Хаант Орос Монголын тусгаар тогтнолыг биш, Монголын өөртөө засах автономит эрхийг хүлээн зөвшөөрсөн хэлэлцээр Монголтой байгуулав. “ДИУ-ын Гадаад Монгол, тэгэхдээ өөртөө засах бүрэн эрхтэй” гэсэн утгаар. Үүнийгээ яг 1 жилийн дараа Дундад Иргэн Улс (ДИУ) -аар зөвшөөрүүлж Орос - Хятадын тунхаглалыг 1913.11.05 -нд гаргажээ. [Асуудал, хэрэг дээрээ, Хиагтын гэрээнээс ч өмнө шийдэгдээд дуусчихсан байж шүү дээ]

Эдгээр [анхдагч] гэрээ хэлэлцээрийн үзэл санаа ... явсаар 1915 оны 3 улсын гэрээний ул суурь болсон юм. Тусгаар биш улсын гол хот ... хичнээн ч том сайхан байлаа гээд, түүнд “нийслэл” тодотгол, үнэндээ бол хэрэггүй. Тэгэхээр, Нийслэл хүрээний он жилүүд гэхээр юм бидэнд бараг үлдсэнгүй. Нийслэл хүрээний ... нийслэл “байсан” цаг хугацаа ердөө 1 жил [1912.02.07 – 1912.11.03] ч хүрэхгүй нэн өчүүхэн ажгуу.

Хэдий ийм ч, “Нийслэл хүрээ” нэр албан бусаар “монголын автономит” –ыг устгачихаад байхад хүртэл хэрэглэгдсээр ирсэн төдийгүй, бүр улаан түүхтэй лавхан золгож байж, хожим Улаанбаатар болсон байдаг. Тиймээс энд бид, Нийслэл хүрээний он жилүүдийг, өмнө гаргасан үндэслэлээр, урагш хойш нь ялимгүй сунган [1911.11.28 – 1924.11.26] –ны хооронд байхаар авч үзлээ.

5. Нийслэл хүрээ “хот” байсан уу ... (Орчин үеийн ойлголтоор)

Чин гүрний удирдлага өөрийн харъяа [нэг] муж улсынхаа [буюу] монгол дахь засаг захиргааны төвийг анхнаасаа Улиастайд төвлөрүүлэн байршуулж, тэндээс удирдан зохицуулж эхэлсэн байдаг. Хаант оросууд ч, хожим мөн, Улиастайг монголын гол төв цэг-газар мөн гэж харж, тийшээгээ алсын хараатай “хөрөнгө оруулалт” хийж, Эрхүүгээс утсан

⁵⁵ М. Г. Торновский тэр үед Хүрээнд, консулын дэнж дээр амьдарч байсан, сүмийн ажилтан хүн. Хожим цагаантан болсон. Байлдаж явахдаа түүх тэмдэглээд байдаг эр, тайван цагт бүр ч илүү үнэн бодитой тэмдэглэсэн байж таарна. Энэ хүний заасан он сар өдөр тун баримжаатай санагддаг. Гэхдээ он цагийн “хөрвүүлэг” хэрэгтэй.

харилцаа татан “төмөр утасны хороо” -гоо байгуулаад амжсан байв. Газар зүйн байршлын “геометр төв” –ийн ойлголт ч эдгээрт мэдээж нөлөөлсөн байх. Гэвч, Их Хүрээ, Богдын хүрээ “амьд бурхан” Жэбзундамба хутагтынхаа ач буянаар, мөн, Хиагт – Хаалганы дөт замын хаялгаар, аажимхан ягуухан монголын нийгмийн улстөр, эдийн засаг, нийгэм соёлын үндсэн гол төв, монголын нөмөр нэг хот болж хувирсан ... бүр, Улиастайг гүйцэж түрүүлсэн түүхтэй. Ийнхүү, Халхын бурхан шашны төв бэхжин хөгжсөөр Халх даяарын төрийн хэргийг эрхлэх төв болжээ. \

Одоо Нийслэл хүрээний он цаг руугаа орьё. Тухайн цагийн эрх баригчид Нийслэл хүрээг, чухамхүү орчин цагийн ойлголтоор “хот мөн” гэж үзэж байв уу гэдгийг бид бас сонирхож үзсэн. Тийм ээ, Нийслэл хүрээ [өөрөө] – хот мөн байж. Мөн; гэсэн баримттай юм байна.

Баримт_7

Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамнаас ... өвлийн сүүл сарын 20 –нд Богд хаанд өргөн айлтгасан нэгэн бичигт “... олон улсын хаадын суугаа хотыг цөм “нийслэл” нэр өргөмжлөх ёсон бүхий. Их хүрээ болбоос манай Монгол Улсын эзэн Богд хааны гэгээн залран суугаа бүгдээр бараалхан ирэх чухамхүү үндэс охь, манлай газар мөн. [Тиймийн учир] үүнээс чинагш элдэв албаны бичиг хэрэгт Нийслэл хүрээ хэмээн бичиж явбаас нийцэх явдлыг хичээнгүйлэн айлтгав” гэжээ. Богд хаан уг бичгийг хүлээж аваад “Зарлигт гуйсан ёсоор бологтун” гэж цохжээ; гэж буй.

Уг бичигт “... хааны суугаа хотыг” гэж бичсэн нь бэлээхэн дурайж байна. Яагаад ийм асуулт гарав гэхээр... Монголчууд хэзээнээсээ “хот айл”, “хот саахалт” гэж ярихдаа “хот” гэдэг ухагдахууныг нэг тийм “хөдөөний ... өргөн айлсалтын” утгаар ярьж ойлгож явж иржээ. Жишээ нь, “хот хороо” –ны “хот” бол, орчин цагийг хотжилтын “хот” –оос өөр, бараг “хашаа хороо” гэсэн шахуу үг. “Хот айл” –ын “хот” ч “хотол олны шавсан газар” –ыг хэлээгүй нь мэдээж юм. Хот айл, хот суурингийн ялгаа нь, угтаа бол хөдөө ба хотыг хооронд нь зааглаж өгүүлсэн, саланги тусдаа, бүр эсрэгцсэн ойлголт байдаг. Энд, үг давхцлын цаана утгын тэрс ялгаа оршин байна.

Харин, хааны зарлиг, холбогдох яам газрын бичигт “монголын нийслэл бол хот мөн”, улмаар “Хүрээ бол хот юм” гэсэн давхар санааг, өдгөөгийн бидний яриад байгаа “хөгжлийн төв, нийгмийн хөгжлийн охь манлай, улсын [гүрний] гал голомт” гэдэг талаас нь “ойлгуулж” зааж тодруулж өгсөн байна. Болд-илд (Догсомын Бодоо) –ийн үлдээсэн уранзохиолын өв дотор ч Их хүрээг “хот” хэмээсэн нь бий бөлгөө. Энэ бүхнээс үзэхүл, Нийслэл хүрээ нь тухайн цагийнхаа хэмжүүрээр, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, үнэхээр [том] хот байжүхүй.

6. Нийслэл хүрээний шүтээн

Цаг түүхийн араншин өөр өөр. Үүнийг үл өгүүлэн өгүүлэхэд, ийм том, тэр үеийн “хот гэдэг их айл” уламжлалын үүднээсээ, [заавал] шүтээнтэй байх ёстой. Үнэхээр тийм байжээ. Монгол ардын аман зохиолд,

Аман түүх_1

Далай сэцэн Шанзавтай юм
Зургаан их яамтай юм ... **яам болгон шүтээнтэй**
...

Наян тохой майдартай юм
Майдраа тойрсон хүрдтэй юм
Манай Богдын хүрээ нь болбоос
Ванданлхамын шүтээнтэй ... гэж бий.

Тухайн үед, Их Хүрээний яам болгон өөр өөрсдийн бурхныг шүтдэг байсан юм байна лээ. Дотоод хэргийн яам “Далха” бурхан шүтдэг бол Гадаадын хэргийг эрхлэх яам “Аюуш”

УИИ.МН
СУДАЛГААНЫ САН

бурханыг, Цэргийн хэргийг захиран шийтгэгч яам “Улаан сахиуст Жамсран” бурханыг, Сангийн хамаг хэргийг захиран шийтгэгч яам “Намсрай” бурханыг тус тус шүтэн зална. Харин, Нийслэл хүрээний шүтээн ванданлам нь Балданлхам бурхан байсан ажгуу. Балданлхам бурханы нэрийг товчоор, Лхам бурхан гэдэг. Лхам бурханыг Балданлхам буюу Төгс цогт охин тэнгэр гэж нэрээр нь шууд дууддаггүй, машид хүндлэн, ванданлхам гэж залбирдаг заншилтай байсан аж.

Хууч үг_2

Нийслэл хүрээний нэг монгол эр, манж амбаны луусыг хулгайлаад тууж явтал агтчин нь мэдээд араас нь нэхэж ирэв гэнэ. Нөгөө эр хариугүй гүйцэгдэхийн даваан дээр, сандрахдаа “ээ, ванданлхам минь” гэж уулга алдтал ... араас нь хөөж явсан агтчин хятадын морь бүдрээд ... тэгээд, баригдалгүй зайлж амжсан гэх домог хүртэл байдаг. Эндээс ч харсан ... Нийслэл хүрээнд хятадуудыг үзэн ядах үзэл сэтгэлгээ нэн хүчтэй байсан нь ил харагдана.

Бид эдүгээ, Богдын Засгийн газрын бүтцэд үндэслэж, Нийслэл хүрээнд анх сан, шүүх, гадаад, дотоод ... [анхны] 5 яам байсан гээд байгаа. Гэтэл, тэр үеийн хүрээний хүмүүс 6 яамтай байсан гэж хэлдэг хэлцдэг байсан нь, дээрх “... магтаалын” хэсгээс ил байна. Эрдэнэ шанзодбын яамаа оруулж тоолоод тэгсэн байх нь.

7. Нийслэл хүрээний дарга - удирдлага (Орчин цагийн ойлголтоор)

Дундад зууны шувтарга цагийн, нилээн дээхнэ үеийн монголын түүхэнд ч “хүрээний дарга” маягийн ойлголт ухагдахуун бишгүй таардаг. Жишээ нь, 1707 онд Хүрээний хэргийг эрхлэх хамба, мөн Да ламыг бий болгож, 1723 онд Хүрээний хэргийг шийтгэх, лам, хар, шавь ... бүгдийг захирах Эрдэнэ шанзодба –д тамга олгож, түүний эрхийг өргөтгөжээ; ... г. м. –ээр өгүүлсэн байдаг.

Бүр (Өргөөг энд байнга суурьшихаас ч өмнө) 1758 онд Хүрээг харгалзах, мөн их шавь, басхүү оросын хэргийг эрхлүүлэхээр Улиастайн манж сайдын [газрын] төлөөний монгол сайд-амбаныг Хүрээнд суулгадаг болсон байна. Энэ магадтайяа, Хүрээний анхны дарга байсан байж таарах нь шиг байна. Удалгүй бас дээр нь манж сайд нэмэгдэж, яван явсаар, 1786 онд [түүний] эрхийг өргөтгөн, анхнаасаа Улиастайн сайдад хамаарагдаж байсан Халхын түшээт хан, Цэцэн хан аймгийн хэргийг [эндээс] шууд эрхлэх болгов.

Энэ үеэс Хүрээнд Халхын зүүн хоёр аймгийн жасаа сууж эхэлжээ. Хутагтын өргөөнд шанзодба гэж байсан боловч “халхын хүрээний газрын” шавийн хэргийг Түшээт хан тэргүүлэн, Халхын зүүн аймгийн ноёд тус тус [өөрөө] мэдэж байсан байна. Хүрээний “засаг захиргааны” үүх түүхийн эхлэл ерөнхийдөө нэг иймэрхүү.

Нийслэл хүрээний дарга; гэсэн энэхүү дэд бүлэгт, дурдаж буй албан тушаалтныг [орчин үеийн, өнөөдрийн] хотын захирагчийн ажил-агуулгаар авч үзэхийг хичээв. Харин хотын дарга; гэдэг ухагдахууныг нийслэл хүрээний “он цагийн явцуу хязгаар” дотор авч үзэх нь ихээхэн учир дутагдалтай. Энд хүссэн хүсээгүй түүх уламжлалыг сөхөж ярих ярих хэрэгцээ арга буюу тулгарч байгааг хэлэх нь зөв болов уу.

Хүрээнд, сүүлд, хутагтын өргөөний шанзодбын эрхийг өргөтгөж, улмаар “Шанзавын яам”-ыг бий болгов. Энэ нь, зөвхөн хүрээний лам нараар хязгаарлагдахгүй, хутагтын улам бүр олширч байсан шавь нарын хэргийг “хот хөдөөгүй” [өргөн хүрээнд] эрхлэх “нэгдсэн төв захиргаа” үүсч байгаа хэрэг байлаа.

Нийслэл хүрээний дарга-удирдлага нь [нийслэл хүрээний он жилүүдийн ихэнх хэсэгт] урьд эртийн уламжлалаа дагаад, шашны талаасаа Богд эзэн, Эрдэнэ шанзавын яам, [засаг төр талаасаа] Манж талаасаа амбан сайдын яам хэвээр байсан. Эд бол бодлого

талыг барьсан ерөнхий дээд удирдага юм. Хот хүрээ өргөжин тэлж, хүн зон нийгэмшихийн хэрээр, сүүлрүүгээ, цэрэг цагдаа, гааль, засаг захиргааны харъяа нэгж хэсэг ... нэмэн салбарлан өөрчлөгдсөөр байж.

Доорхи зураг дээр тухайн цаг үеийн монголын нийгмийн, бас Нийслэл хүрээний хамгийн том даргын дүр сүүдэрлэгдэн үлджээ. Саяхан илэрч мэдэгдсэн эл [шинэ] фотог (бусад хэд хэдэн түүхэн зургийн хамт) уншигч танаа толилуулсу.



Гүжир хамба, чин зоригт, эрдэнэ шанзодба [шанзавын яамны сайд] жүн ван [алдарт их уяач]
Гончигжанцангийн Бадамдорж [сүүлд, 1919 онд] Автономит монголын Ерөнхий сайд байв. Le shanzav
Badamdorj aux environs du Palais jaune, Ourga, Mongolie indépendante. Stéphane Passet, 24 juillet 1913, inv. A 3967
S, © Albert-Kahn, musée et jardins – Département des Hauts-de-Seine.

Нийслэл хүрээний он жилүүдэд Гандангийн хүр дээр, мөн-чанарын хувьд, “төр эргэсэн” нь тоймгүй олон. Тэр тоолонгоор Хүрээний засаг захиргаа [нутгийн удирдлага] –ны эрх мэдэл, төрийн эргэлтийн дийлсэн талын [гадаадын эзэрхэгчдийн] эрхшээлд орж байсныг түүхэн сурвалжууд тод харуулдаг. Үүнтэй холбогдуулж, дурдсан он цагийн хязгаар дотор хялбаршуулсан жагсаалт үйлдье. (Хүснэгт 1.)

Халхын хүрээний газарт гарсан төрийн эргэлтүүд & Нийслэл хүрээний дарга - удирдлага

(Хүснэгт 1.)

“Хүрээний газар” –т гарсан “төрийн эргэлт”- үүд	Засаг солигдох завсаруудад Их Хүрээний газрын “нутгийн” удирдлага	Тайлбар
---	--	---------

<p>■ 1911.11.28; Богд Жэбзундамба хутагт лүндэн буулгаж "... одоо монголчууд өрх тусгаар улсаа мандуулж бусдын эрхшээлээс ангижрах цаг болсон. Тиймээс, үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийг эрс шийдэмгий явуул" гэвэй.</p>	<p>Монгол дахь манжийн захиргааг Их Хүрээнээ Сань До-вень¹ (амбан сайдын яам) төлөөлж байв. Автономит монголын үед шанзодба Г. Бадамдорж Ерөнхий сайд байсан. Их Хүрээний "засаг захиргааны" чиг үүрэг доорхи мяндагтнуудаар дамжин хэрэгжиж байсан болов уу. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ■ Пунцаг - Хүрээний хамба номун хан, тунгалаг билэгт хутагт; ■ Содномдаржаа - Хүрээний дэд хамба (Дуйнхорын аймагт суудаг), номч билэгт, эрдэнэ мэргэн, чин бишрэлт хутагт; <p>... нар тус тус ажиллаж байв. Улмаар, хэсэгхэн хугацааны дараа эмхлэн байгуулагдсан Богдын засгийн газраас, дээрх тушаалтнуудыг, дээд үнэмлэхүй түвшиндээ,</p> <ul style="list-style-type: none"> ■ Гончигжанцангийн Бадамдорж – Гүжир хамба, эрдэнэ шанзодба (Шанзавын яамны сайд), чин зоригт, жүн ван; ■ Гомбын Цэрэнчимэд - [Засгийн газрын тэргүүн], Дотоод хэргийн бүгд захиран шийтгэх яамны сайд, Да лам, чин сүжигт,чин ван; <p>... тус тус ерөнхий удирдлагаар чиглүүлж байсан болов уу, гэмээр байдаг. [Судлах шаардлагатай]</p>	<p>Богд гэгээн үйл явдалд оролцох байр сууриа нэгмөр ил болгож, улсын тусгаар тогтнолын тэмцлийн манлайлагчийн сууринд албан ёсоор ийнхүү шилжсэн нь, мөн чанартаа, төрийн эргэлт мөн байв. (Хутагтын үгийг утгачилж авав)</p>
<p>Нийслэл хүрээний он жилүүдэд, Богд хаант Монголын улсын "Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм" үйлчилж байв. Хууль дүрмийн хэрэгжилттэд шууд хамаатай захиргааны зохион байгуулалтын ерөнхий бүтэц нь,</p> <ul style="list-style-type: none"> ■ Бүгд Ерөнхийлөн захирах зэрэг зургаан яам, Шашин төрд туслах сайдууд, Нийслэл Хүрээний Хамба Номун хан, Эрдэнэ Шанзудба, Зүүн хоёр аймгийн чуулганы дарга, Баруун хоёр аймгийн суурин жасааны гүн, түшмэд, Нийслэл Хүрээ, Маймаа хотын Монгол ба Иргэд (хятадууд) -ийн хэргийг захиран шийтгэх түшмэл Лувсанцэрэн ... нараар дамжих [маягийн] тойм төрхтэй байсныг ... жишээлж энд дурдлаа. 		
<p>■ 1912.11.03; Хаант Орос Монголын тусгаар тогтнолыг биш, Монголын автономит [хятадын гадаад монгол] –ийг зөвшөөрсөн [тийм] хэлэлцээрийг монголтой байгуулав. Гэрээнд Богдхаант Монгол Улсын 5 яамны сайд гарын үсэг зурсан.</p>	<ul style="list-style-type: none"> ■ Нийслэл хүрээний нутгийн удирдлагад зарчмын өөрчлөлт ороогүй, ерөнхийдээ засаглалын механизм хуучин маягаараа явж байсан бололтой. ■ Хятадаас ангижрах гэсэн монголчуудын туйлын хүсэл дээр оросууд байнга "тоглож" өөрийн байр сууриа, ялангуяа Нийслэл хүрээнд байнга бэхжүүлэхийг эрмэлзэж байв. ■ Энэ хугацаанд, Нийслэл хүрээний "нутгийн удирдлагад хамаарах" албан тушаалтнууд өөрчлөгдсөн солигдсон байх боломжтой. Хэрэв тэгсэн бол тэр нь, "төрийн чанарт гарсан өөрчлөлт" –тэй төдийлэн холбоогүй байх магадлалтай юм. 	<p>Монголын тусгаар тогтнол, хэрэг дээрээ, үгүй болж, урианхайн хязгаарыг орост алдав. Тусгаар тогтнолоо хамгаалах гээд тусгаар тогтнолоо алдаж байна. Тэгээд зогсохгүй Урианхайн хязгаарыг орост өгсөн. Үйл явдал төрийн эргэлтийн шинжтэй.</p>
<p>Богд хаант Монгол улсын үед манжийн хуулийн агуулгыг өөрчлөхгүйгээр хэрэглэж байсан. Мөн, шинэ дэг журмууд бий болсоор байв. Хүрээний дотроо Жибзундамба хутагтад мөргөх, жил бүр цагаан сарын арван дөрөвний Их Дүйцэнд Хүрээ сүмд хүж шатааж, эрхэм цаг жич, өргөл хүндлэл үйлдэж орон сүмд мөргөхөөр бол Эрдэнэ Шанзудбагийн яаманд мэдүүлж, Хүрээний өмнөх чөлөөгөөр арван тавны газрын цагдаа, Шавь яамны хиа нарын хяналтын дор уг мөргөлүүдийг үйлдэж, мөргөл дууссаны дараа Хүрээнээс гаргаж байхаар хуульчилсан байв. (Үүнийг, Нийслэл хүрээний газар дахь засаг захиргааны шийдвэр, хууль дүрмийн хэрэгжилийн механизмыг харуулах үүднээс оруулав)</p>		
<p>■ 1913.11.05 Орос - Хятадын тунхаглалыг гаргасан. Их орос манайд ашиггүй дээрх гэрээг ДИУ –тай далдуур үгсэн улам лавшруулан баталгаажуулж авсан. (Монголыг оролцуулалгүйгээр)</p>	<ul style="list-style-type: none"> ■ Үйл явдал монголын гадна болсон. Монголд, ялангуяа Нийслэл хүрээний захиргааны шинжтэй ажил хэргийн зохион байгуулалтад шууд нөлөөгүй байсан. 	<p>Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлыг, монгол улсыг [өөрийг нь] оролцуулалгүйгээр шийднэ гэдэг бол эзлэн түрэмгийлэхтэй эн тэнцүү үйлдэл. Товчдоо, үйл явдал төрийн эргэлтийн шинжтэй.</p>

Халх дөрвөн аймгийн чуулганы дарга, жанжин, **Нийслэл Хүрээний Эрдэнэ Шанзудба**, Нийслэл Хүрээ, Маймай хот, Хиагтын худалдааны монгол, **иргэдийг захирах хэлтсийн түшмэл** нар, зүүн, баруун өмнө хязгаарын сайдуудаар ... дамжин засаг захиргааны чиг үүрэг хэрэгжиж байжээ.

<p>■ 1915.05.25;</p> <p>Гурван улсын гэрээгээр, Богд хаант Монгол Улсын туурга тусгаар байдал үгүй болов.</p> <p>Их хөршүүд Монгол улсын тусгаар тогтнол, бие даасан байдалыг хязгаарлаж, автономит Монголын хилийг зөвхөн Халх дөрвөн аймаг, Ховдын хязгаараар зааглаж, монголчууд нэгдмэл нэг улс болох үйл хэргийг хэрэгжих “боломжгүй зүйл” болгосон.</p> <p>Хэлэлцээрээр, Барга болон Өмнөд Монгол нь автономитын гадна үлдэж, монголчууд газар нутгаа “алдсан”, алдах эрх зүйн үндэс бүрдсэн. [Хоёр хөрш монголын газар нутгийг, яг муушиг тоглож байгаа юм шиг “хэрчин идсээр” ...]</p>	<p>■ Энд тоочсон үр дүн, тайлбар сэлтээс харахад, Хиагтын гэрээний дараа Монголын автономитид de facto талаасаа “бие даасан улсын шинжтэй орших боломж бас ч гэж үлдсэн байсан. Тийм болохоор, Нийслэл хүрээний “захиргаа” хэрэгжүүлэх зохион байгуулалтын шинэ арга хэмжээ шаардагдаагүй. Өмнөх удирдлагын бүтэц ерөнхийдөө хэвээр үргэжилсэн;</p> <p>■ Хиагтын хэлэлцээрээр, монгол дахь оросуудын байдал бэхжив. Энэ үед, Нийслэл хүрээнд суугаа оросууд нилээн [тийм] “өөртөө засах локаль эрхтэй” аж төрөх болсон байв. Жишээ нь, 1917 онд орост гарсан хувьгалыг Нийслэл хүрээний оросууд дэмжиж, Консулын байрны дэргэд жагсаал хийснийг Ерөнхий консул “өөрийн хүчээр” түүгээрээ хөөн тарааж байжээ.</p> <p>■ Дашрамд тэмдэглэхэд, монголын нийгмийн улстөрийн дээд ерөнхий эрх мэдэл нь гадаадынхны гарт ээлжлэн ороод байсан ч, орон нутагт, тухайлбал, Их хүрээнд “орос захиргаа, манж – хятад захиргаа, монгол захиргаа” бие биенийхээ дотоод хэрэгт аль болохоор оролцохгүй байхыг хичээж, “зэрэгцээ олон засаг” –ууд ийнхүү параллель оршоод ирсэн Нийслэл хүрээний түүхэн “туршлага” –ыг улам бүр лавшруулан судлах хэрэгтэй байна.</p>	<p>Гурван улсын Хиагтын хэлэлцээр 1914.08.26-наас эхэлж он дамнан, 9 сар үр-гэлжилсэн, монголын талд хүнд хэцүү хэлэлцээр байсан.</p> <p>Тусгаар улс хятадын автономит болж хувирч байгаагаараа үйл явдал төрийн эргэлтийн шинжтэй.</p> <p>Хэдий тийм ч гэрээнд бас зарим ололт байсан. Автонимт Монголын дотоод хэрэгт Хятад, Оросын зүгээс оролцохгүй байхаар тогтсон, бас, төдийгүй эзэн хаан, засгийн газар, нутаг дэвсгэр, хил хязгаар, цэрэг зэргийг хэвээр байлгах болжээ. Мөн Хятад иргэдийг олноор суурьшуулахгүй байх, байх, олон улстай худалдаа үйлдвэрийн хэргээр харилцах бүрэн эрхтэй байв.</p>
---	--	---

Нийслэл хүрээний засаг захиргааны удирдлагын тогтолцоо (зохион байгуулалтын бүтэц) -г зарим талаар тодруулах [нэгэн жагсаалт]

- Сайдууд таны яаман ... \
- Живзундамба хутагтын сан
- Эрдэм итгэмжит сүмийн газар
- Эрдэнэ Шанзудбын яам
- Хамба Номун хан (газар)
- Дэд лам (газар)
- Эрдэнэ Шанзудба (газар)
- Дүйнхэр хутагт (газар)
- Цорж (газар)
- Да лам (газар)
- Хүрээнд суух Ялгуусан хутагт Номун хан
- Гучин аймгийн гэсгүй нарын газар
- Хүрээн бүхий Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн суурин жасааны газар
- Баруун хоёр аймгийн хэрмэлийг захирах жасааны газар
- Хүрээнд суух ван Цэрэнбаавайн дэргэдэх ... [тодорхойгүй]
- Вангай аймгийн газар ... гэх мэт.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

<p>■ 1919.11.22; Хятадын генерал Сю Шв-жан Монголын автономит засгийг устгасныг албан ёсоор зарлав.</p>	<ul style="list-style-type: none"> ■ ДИУ –ын төрийн бодлого монголын нутаг дээр бүрэн утгаараа хэрэгжиж, ялангуяа Нийслэл хүрээний “захиргаа” хятадуудын мэдэлд шилжив. [Орос, Хятадын цэргийн монголд оруулахгүй; гэсэн 3 улсын гэрээний “өндөр үнэ төлж” оруулсан заалт “хууран мэхлэлт” байсан нь ил болов] ■ Нийслэл хүрээний байдал монголчуудын хувьд нэн хөөрхийлэлтэй болж, ... бүр Хүрээг “монголчуудаас эгнэгт цэвэрлэх”, “цагаан сарыг нь улаан сар болгож” хүн зоныг нь хядах “Хүрээний их аллага” хэрэгжих магадлалтай болж ирсэн “аман түүх” бий. Юун нийслэл хүрээний [монгол] дарга ...?! гэмээр цаг ирсэн. ■ Хэдий тийм ч Нийслэл хүрээний “уламжлалт засаг, удирдлага” –ууд өдөр тутмын ажил чиг үүргээ [өөрийн дотоодод] хэрэгжүүлсээр байжээ. 	<p>Энэ нь, орос оронд “октябрийн” гэх хувьсгал, иргэний дайн гарч, “гадаад монголыг 2 талаас булаацалдах хвч” –ний харьцаанд “өөрт нь ашигтай” өөрчлөлт гарсныг хятадын тал шийдэмгий ашиглаж “санасандаа хүрсэн” хэрэг байлаа. Монголын “ор нэрийн төдий” тусгаар тогтнол үгүй болов. [Үйл явдал, монголын талд, төрийн эргэлтээс ч хол давсан хүнд уршигтай байв]</p>
<p>■ 1921.02.03 Нийслэл хүрээнд оросын цагаан цэрэг зөвшөөрөлгүй орж ирэв. Азийн морин дивизийн командлагч, генерал барон Унгерн Штернберг Нийслэл Хүрээг хятадын цэргээс чөлөөлөв.</p>	<ul style="list-style-type: none"> ■ Л. Сипайло - Нийслэл хүрээний комендант (зартай харгис этгээд) ■ Да лам Дашжав - Нийслэл хүрээний Эрдэнэ шанзодба (шавийн шанзодба) ■ Нийслэл хүрээн дэх оросуудын “нэгэнт үүсч бий болчихоод байсан улаан талыг талархагч дотоод бичил засаг” бас [давхар] унасан. 1919 он гэхэд, Нийслэл хүрээнд оросын худалдааны томоохон пүүс 50 гаруй, мөн 3 мянган орос иргэн амьдарч байжээ. 	<p>Улмаар Богдыг хааныг эрдэнийн сууринд нь дахин залж, түүний Засгийн газрыг “хуучин ёсоор” нь байгуулж ... хаант Монгол Улсыг мандуулав. Монгол дахь хятадын засаг бүрэн унав. Энэ монголын түүхийн санамсаргүй том үйл явдал, чухамдаа төрийн эргэлтээс ч давсан түүхэн эргэлт байлаа.</p>
<p>■ 1921.7.06 Нийслэл хүрээнд оросын улаан цэрэг “цагантиг хөөх халхавч нэрээр” орж ирэв. “Монголд одоо ямар ч цагаантан байхгүй, тэд бүрэн арилсан. Та нар наашаагаа Нийслэл хүрээ рүү битгий ир, цаашаа даруй буц” гэж Богд хаан хил давсан улаантнуудын өөдөөс уургын улаагаар удаа дараа элч илгээсэн, “нэмэр болоогүй” ... тэгээд “толгойтын даваан дээр” арга буюу албаны хүнээр “угтуулсан” байна.</p>	<ul style="list-style-type: none"> ■ Нийслэл хүрээний комендантаар Харти Хануков - (Догшин ноён, номун хутагт Дамбийжанцанг устгасан, нэрээ нуусан зартай чекист), өөрчилсөн нэр нь – Итрах Вокунаев) ажиллав. ■ Ардын засгийн газар 1922 оноос нутгийн захиргаадыг өөрчлөн шинэчлэх ажлыг эхэлж 1923.3.23 –нд “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм” –ийг баталжээ. Ийнхүү, “Нийслэл хүрээний захиргаа” бий болов. 1921-1924 онд Нийслэлийн хүрээний бүхий л хэргийг Дотоод явдлын яам эрхэлж байсан ба Нийслэл хүрээг хөгжлийн бодлогыг Ардын засгийн газраас тодорхойлж байжээ. 	<p>Монголыг булаацалдсан орос хятадын он удаан жилийн тэмцлийн сүүлчийн шийдвэрлэх шатанд “хойд хөрш” ийнхүү ялав. Монголд төр эргэж, засаг шилжив ... “улаан түүх” эхэллээ.</p>

Баримт_11

1922.5.12, [Нийслэл хүрээнд ... дараагийн **төрийн эргэлт** ойрхон байсан тухай]

Манжуурыг эрхшээсэн хятадын генерал, “монголыг тохинуулах дээд комиссар” Жан Зо-лин дорнод хятадын төмөр замаас оросуудыг хөөх бодлого барьж байлаа. “Хаант засгийн төлөө үзэлтэн” тэрбээр, монголыг, хятадын салшгүй хэсэг байх ёстой гэж үзэж ... ийм нэгэн захиаг төв засгийн газартаа илгээж байжээ. Үүнд:

- Оросын засгийн газар монголд цэрэг оруулахдаа, цагаантныг хөөж тэнд дэг журам тогтоогоод, хот [Их хүрээ] –ыг хятадын талд буцааж өгнө гэсэн ... одоо янз

бүрийн шалтгаан дурдаад буцааж өгөхгүй байна. Энэ бол шударга бус явдал. Тагнуудын мэдээнээс үзэхэд, оросууд цэргээ гаргахын оронд улам бүр шинэ анги нэгтгэлүүдийг нэмж Өргөө рүү илгээсээр байна. Тэднийг монголоос сайн дураар явна гэж найдах хэрэггүй боллоо. Тиймээс, би оросын түрэмгийлэгчдийг цэргийн хүчээр монголоос хөөн гаргахаар шийдээд байна. Монгол руу цэрэг илгээхэд 5 сая долл. хэрэгтэй ... 3 –ыг нь би өөрөө гаргана, үлдэх хэсгийг Засгийн газар ирүүлэх ёстой. Хэрвээ, төв засгийн газар эс хөдөлбөл, монголыг алдсан хариуцлагыг би хүлээхгүй шүү ... гэжээ.

- Дээрх мэдэгдэл хэрэгжих бүрэн бололцоотой байсан бөгөөд энийг сайтар ойлгож байсан оросууд “дипломат аргаар байлдаж”, 1924.5.31 –нд “гадаад монгол нь хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн, ДИУ нь Гадаад Монголыг эзэн мэдэх бүрэн эрхтэй “ гэсэн заалт бүхий хэлэлцээрийг хятадын талтай “монголд хэлэлцүүлгээр” байгуулж байв. Гэвч ... эцсийн дүндээ асуудал оросын талд ашигтайгаар шийдэгдэж, “монголыг орос эзэлсэн” хэвээр үлдсэн юм.

* * *

Нэмэлт тайлбар:

- [Хүрээнд төдийгүй монгол даяар үнэмлэхүй эрхтэй] Хүрээний манж [амбан] сайд [Сан До-вень, Чен-И, Сюй Шу-жан, (дахиад Чен-И), тэгээд, Богд хаант Монгол Улсын зарлигаар тохоогдсон сайд, “улсыг мандуулагч их баатар жанжин”, “ханы зэрэгт үе улирах дархан хошой чин ван”, Азийн морин дивизийн Ерөнхий командлагч, дэслэгч генерал, **барон** Роман Феодорович **Унгерн** – Штернберг фрейхер фон Пильхен – Пильхау] ч [дамаар] Их хүрээ, **Нийслэл хүрээний дарга** эрхлэгч мөн байх бололцоотой. Барон Унгерний дараа энэ буухиаг **Харти Хануков** авдаг. Удалгүй **Яков Блюмкин** Нийслэл хүрээнд ирээд Х. Хануковыг Улиастайн комендантаар хөөж зайлуулаад өөрөө Нийслэл хүрээний комендант⁵⁶ болсон байна. Энд бид, зэрэг тушаалыг харж явцууралгүй, үйл ажиллагааны тогтсон ерөнхий ойлголт жишгээр, зөв арга зүйгээр хандах хэрэгтэй мэт. 1921 оны хавар Нийслэл хүрээнд дэг журам тогтоож, “өндөр хог” –ийг ... өөр бусад газрын хог новшыг ч өөрөө хянан цэвэрлүүлж, хүрээний золбин нохдыг устгасан [устгуулсан] хүн бол, чухамхүү энэ, генерал Барон Унгерн билээ.
- Хүрээний комендантаар ажилласан Харти Хануковыг зарим түүхчид хотын дарга байсан гэдэг. Тийм ээ, хотын комендант гэдэг бол зөвхөн гагц цагдаагийн дарга байгаагүй, их хотын чухам хаана юу байгуулах байрлуулахаа, бүр, хэнийг алах аврахаа бүгдийг өөрөө мэдэж шийддэг, үнэмлэхүй эрхтэй албан тушаалтан. Харин улаан комендантаг хотын даргаар тооцсон атлаа цагаан комендантаг “авч хэлцэлгүй орхисон” нь [жаахан] ойлгомжгүй явдал юм.
- Нийслэл хүрээ 2 үндсэн хэсэгтэй байсан. “Хүрээний шанзодба” –ийн алба тушаалаас гадна, өмнө дурдсан “**Нийслэл Хүрээ, Маймаа хотын Монгол ба Иргэд** (хятадууд) -ийн хэргийг захиран шийтгэх түшмэл” бол монгол талаасаа [одоогийнхоор] хотын дарга; -тай “ойртохоор хэмжээний” албан тушаал байсан байж мэдэхээр санагддаг. Энэ алба тушаал дээр ажиллаж байсан хүмүүсийн нэрийг тодруулах хэрэгтэй болов уу.

8. Нийслэл хүрээний цэрэг (Хүрээ цэрэг)

Монголын үндэсний эрх чөлөөний төлөө хөдөлгөөний амжилтыг батжуулсан гахай жил [1910] –ийн үндэсний хувьсгал нь он удаан жилийн тэмцлийн эцсийн үр дүн юм. Аливаа

⁵⁶ http://www.beljews.info/ru/article_ungern.php

хувьсгал тэмцэл зэр зэвсэггүйгээр, цэрэг цуухгүйгээр бүтдэггүй билээ. Их Хүрээний Богдын ордонд, бүр 1907 онд зэвсэг нууж нөөцөлж байсан баримт хүртэл бий аж. Манж Дай Чин улсаас салахын тулд монголчуудад юун түрүүн “байлдах” цэрэг хэрэгтэй ... тэрхүү цэргийг ч Их Хүрээнээ яаж ийгээд “босгосон” байдаг.

Цэрэг босгох гэдэг хэллэг энд “арми бүрдүүлэх” гэсэн утгатайг уншигч абугай анхаарах биз ээ. Манжийн хууль үйлчилж байгаа эрхзүйн орчинд, Их Хүрээнд, манжийн төрийн эсрэг тэмцэх цэргийг байгуулна гэдэг бол нэн хүнд, амаргүй даалгавар. Эл асуудлыг Их хүрээнээ хэн хэрхэн яаж шийдсэнийг харъя.

Хятадад дотоодын самуун дэгдсэнийг [хэдүйнэ] сонссон монголын удирдагчид, Нийслэл Хүрээнээ Чин династийн захиргааг түлхэн унагаах “далд нууц” сэдлээр ... цэрэг босгохоор шийдэв. Тэгээд, манжийн амбан Сан До-вөн сайдад мэдэгдэл хүргүүлжээ. Тэнд дурдахдаа,

- “Манай Халхын монголчууд Чин улсын хишиг буяныг 200 гаруй жил бишгүйдээ хүртэв. Манжийн хаандаа туслах цаг ирлээ. Бид зүгээр хараад сууж төвдөхгүй. Иймийн учир, манай Богд Жибзундамба хутагт халх 4 аймгаасаа тус бүр 1000, нийт 4000 мянган морьт цэрэг татаж ... улмаар Бээжин орж, Дай Чин улсын эзэн хааныг хамгаалахаар шийдсэн тул [бидэнд] цалин, хэрэглэл, буу зэвсгийг [хүний] тоо ёсоор олгоно уу” гэжээ.

Цэрэг татлага нэгэнт эхэлсэн огноо нь [1911.11.28] бөгөөд [хожмын] “их цэрэг” –ийн цөм нь Түшээт хан аймгийн жанжин, Эрдэнэ дайчин хошой чин ван, хан Мижиддоржийн Ханддоржийн шууд мэдэлд байгаа хошуудын цэрэг байв.

Нийслэл хүрээний нэрийн тухай өгүүлсэн өмнөх [нэг] дэд гарчигт бид, Их Хүрээг бас Халхын Түшээт хан аймгийн хүрээ; гэдэг байсан тухай дурдсан. Их Хүрээ нь [давхар] Түшээт хан аймгийн хүрээ байсан учраас л энд, чин ван М. Хандоржийн мэдлийн “хуучин [манжийн] цэрэг” бас байсан болтой байгаа юм.

Манжийн амбаныг хөөхөд ашиглах [тэр] зэр зэвсгийг, манжийн амбанаас өөрөөс нь нэхээд шаардаад зогсож байна гэдэг бол монголчууд бидний “эрх чөлөөний төлөөх тэмцлийн тэмүүлэл, сэтгэл зүй тэр үед ямар их агуу” байсныг харуулах гайхамшигт нотолгоо юм. Энэ бол бахархал.

Зэвсэг шаардсан мэдэгдлийн хариуд Их Хүрээний манж амбан “Их Хүрээний монгол сайдтай уулзъя гэжээ. Гэтэл монгол сайд элдэв шалтаг хэлээд уулзсангүй. Сан До амбан учраа сайн олохгүй сандарч байв. Тэгтэл, хэдэн монгол лам, ноёд “Бид, Богд Жибзундамба хутагтын зарлигаар ирлээ” хэмээн, Сан До-вөн сайдад очиж, “... зэр зэвсэг мэдүүлсэн манай өргөдлийн хариуг одоо болтол тушаасангүйг үзвээс [танай тал] “зөвшөөрөхөд бэрх” гэж татгалзжээ. Тэгэхээр, Чин гүрний явдал бидэнд хамаагүй болсон байна. [Тиймээс] монголчууд бид бүх газар орноо өөрсдөө хамгаалж, бүрэн эрхт ИХ МОНГОЛ улсаан байгуулж, Богд Жибзундамба хутагтыг улсын эзэн хаанаар өргөмжлөхөөр тогтов” гэсэн байна. Тэгээд түүнд ультиматум тулгав. “Манж - амбан сайд Сан До та өөрийн албаны харъяат хүмүүсээ авч, манай монголын өртөө улааг хэрэглэн, маргааш өглөө гэхэд эндээс зайл, 3 хоногийн дотор Монгол Улсын дархан хил дотроос гадагш гарч арилсан байх ёстой” гэж эрс шийдэмгий анхааруулсан байна. Энэ бүрэн ёсоор болсоныг бид мэднэ.

Их Хүрээн дэх Чин улсын захиргааны эсрэг зэвсэгт бослого [ямар нэг хэмжээгээр] боломжтой байсан хэдий ч, эрх чөлөөний тэмцлийг удирдан зохион байгуулагчид ... шууд зэвсэг хэрэглэхийг урьтал болгоогүй аж. Энэний дараа 1-2 хоног өнгөрөхөд Их Хүрээний ойрхи хошуудаас мөн 500 гаран цэрэг нэмж цугларчээ. Цахаргүйгээр цэрэг босдоггүй, цаазгүйгээр улс босдоггүй; гэсэн үг хүртэл байдаг. Хүрээний цэрэг, харин ч амархан босчээ.



Хүрээ цэрэг буюу Хүрээний цэрэг. Тэд бүгд “товь” малгай өмсчээ.



Хатагтай Гуулийн 1910 онд авсан “Богдын цэрэг” гэдэг зураг. Гэхдээ, эд бол “цэрэг” биш “тусгайгийнхан”, өөрөөр хэлбэл, “хааны хамгаалалтын албаныхан”, түвдүүд байх магадлалтай

Богд хаант Монгол улсыг өвөрмонголчууд маань баатарлагаар хамгаалж дэмжсэн. “Хоёр хөнгөн их буунаас өөр гавьтай зэвсэггүй, 32 шилдэг баатраар удирдуулсан морин цэргийн түмт хятад цэргийг байнга давамгайлж, Цахар, Шилийн голыг бүрэн чөлөөлж, монголд нэгдээгүй байсныг нь нэгтгэж, зарим газраар Цагаан хэрэм хүрч, 58 удаа тулалдаж ... Хөх хотын төлөөх байлдаанд ялаагүй ч, ахин дайрч авах санаатай байсан ч их гүрнүүд дипломат аргаар элдвээр саад хийж ... амжилтын буухиаг зогсоосон байдаг” гэж түүхч Чулуундоржийн Мөнхбаяр тэмдэглэсэн байна.



Хүрээ цэрэг -ийн [нэг] дарга, Богд Жибзундамба хутагт хааны торгон цэргийн захирагч, ван **Энхбилэгийн Тогтох** (1863 - 1921)

Өвөрмонголын Горлосын хошууны дайчин “цэрэг”, тайж Энхбилэгийн Тогтохыг Нийслэл Хүрээнд тэмцэн ирэхэд нь, түүнийг үндэстний баатрын ёсоор угтаж, Богд хаант Монгол Улсын зоригт баатар цол олгож, цэргийн яамны албан тушаал, хашаа байшин өгөн, ар гэрийг нь авчруулж, гүн хүндэтгэж байв. (Энэ хүнтэй холбоотой мэдээ хойно дахин гарах тул зориуд энд сонгон жишээ татсан болно)

Монголыг хятадаас салах үед анх татсан цэргийг Хүрээ цэрэг, Хүрээний цэрэг гэдэг байж. Тэдэнд улсын сангаас сард 9 янчааны цалин өгнө. Сүүлд нэмж дайчлагдсан цэргийг “хөдөөний цэрэг” гэж ялган нэрлэдэг байв. Хүрээ цэргийг өвөрмонголд очихоор нь “Богдын цэрэг” хэмээн ихэд хүндэтгэн үзнэ. 1912 оны 2 сард Хүрээний цэрэг Шар хад ... зэрэг газарт хот хөдөөгөөрөө ялгаран хуарагнана. Удалгүй Хужирбуланд [Хүрээний] цэргийн [орос багштай] сургууль нээгдэв. Монгол Оросын хэлэлцээр (1912.11.03) -ийн дагуу оросын 17 офицер, 42 бага дарга нар монголын 2000 цэргийг сургаж эхэлсэн. Богд хааны шадар цэргийн хороо байгуулагдсан.

Хүрээний цэрэг сахилга муу, боловсролгүй боловч, түүний дотоод дэг, зохион байгуулалтын бүтэц нь Чингэсийн морин цэргийн аравтын системтэй нийцэж байсан. Арван цэргийг нэг нь даргална, дарга биш 9 –ийг нь хуягласан цэрэг гэнэ. Эр бүр 2 морьтой. Тавин цэрэг нь нэг анги, 100-200 цэрэг нь нэг хороо болно. Хэрэглэх зэвсэг нь оросуудаас өгсөн винтов буу, бярдаан байв. Цэргийн насны хязгаар бараг манжийн үеийнхээрээ байсан. Манжийн

үед, цэргийн албанд албанд 16 – 60 насны эрчүүлийг шаардлагатай бол татдаг байсан, гэдэг. Цэргүүд их оргоно. Цэргийн хоол муу, захын хамгийн хямд махыг тэдэнд зориулж авдаг байв.

1919 оны намар автономитыг устгах гамин цэргүүд жинчдийн дүрээр Их Хүрээнд ирж Хужирбуланд байрлан, монгол цэргүүд Цагаан хуаран руу шилжжээ. 1913 онд монгол цэргийн дагаж мөрдөх 23 зүйл бүхий дүрэм гарав. Монголын цэрэг барих сайн зэвсэггүй, байлдах сайн мэргэжилгүй боловч эх орноо тусгаар тогтноулах их үйлсэд гавъяатай зүтгэн, хил хязгаарт ямар ч дайсантай тулалдавч ямагт дийлж ирдэг байсан; гэдэг.

Богд хаант Монгол Улсын үед монгол эх орныхоо газар нутгийг харийннаас хамгаалах өргөтгөх, эх нутгаа батлан хамгаалах үйлсэд хүрээ цэрэг хүчин зүтгэж олон гавъяа байгуулсан нь түүх домог болон одоо ч яригдсаар байна.

Хүрээлээд ирсэн Жодовоо амбан
Хүрээний цэрэгт баригдаад одов оо хө
Хүнээр баярхсан гамингийн ноёдууд
“Хүрд нь буруудаад” цохигдоод буцав аа хө ...

... гэж дариганга ардын дуунд гардаг. Даригангын төлөө байлдаж гавъяа байгуулж явсан гүн Бавуужав бол Богд хаант Монгол Улсын “101 улсын баатрын” нэг, “жинхэнэ” хүрээ цэрэг байсан. Хамгийн эмгэнэлтэй нь, сүүлдээ, оросын хятадын нөлөө дарамт, монголчууд бие биенийхээ ач тус аврал энэрэлийг мэддэггүйн харгайгаар, хамгийн гол нь [мөнөөх] 3 улсын гэрээний дагалдах уршигаар, хүрээ цэрэг энэхүү Бавуужав баатартайгаа [хүрээ цэрэгтэйгээ] байлдаж шившиг болсон. Иргэний дайн.

Богд хаант Монгол Улсын үе улиран улсад туслагч, харчин гүн, шударга баатар Бавуужав нь Хубилай сэцэн хааны удам бөгөөд Өвөрмонголын Зостын чуулганы түмэд зүүн гарын монголжин хошууны хүн байв. Удалгүй, Улсын Зүүн өмнөд хязгаарын монголчуудыг төвшитгөн тохинуулах түшмэл [бөгөөд] цэргийг ерөнхийлэн захирах сайд болсон, түшээ гүн Бавуужав 1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээхэд хамгийн түрүүнд 200 цэргээ дагуулж ирэн хүчээ өгч, өмнөд хилээр болсон олон байлдаанд оройлон тулалдаж гавъяа байгуулсан чин шударгуу дайчин эр юм.

Өвөрмонголоос монгол эх орныхоо гал голомтыг зорин хүчээ өгөхөөр зориг шулуудан тэмцэн тэмүүлж ирсэн цэрэг болгоныг, цөмийг нь энэхүү Бавуужав баатарт хураан захируулж байв. Ингэсээр удалгүй, зөвхөн гүн Бавуужавын цэргийн тоо 2000 хол давж, туурга тусгаар монголын батлан хамгаалахын нэгэн том цохилтын хүч болон өсч бэхэжсэн байдаг. Гэвч тэднийгээ бид “та нар одоо хэрэггүй” гэж нэг л өдөр хөөв. Хиагтын гэрээний үр дагавар юм. Хятадын дайсан болж хэдийнээ амжсан хөөрхий тэдэнд буцах газар үнэндээ байгаагүй. Монгол авна гээд авсангүй, хятад хэзээ ч авахгүй. Түшээ гүн Бавуужавын цэрэг “бид гэрээсээ хаашаа ч явахгүй” гэж уллав. Зөв шүү дээ. Нижгээд хүн бүрт 100 цөлхөөв өгч аргадан хууран ... хүйтэн сэтгэлээр түлхэн хөөхөд ихэд гомдсон тэд хорсон хилэгнэж, замдаа таарсан зарим газрыг заналхийлж ... уурсан дээрэмдэв, улмаар, дотоодын дайсан болов. Монголд иргэний дайн ингэж эхэлсэн юм. Монголчууд шударга баатартаан дэндүү муухай шударга бус хандсан байгаа биз. Ёстой л эмгэнэн гашуудмаар, уучлалт гуймаар ...

Монголын хүрээ цэрэг, ялангуяа хятадыг айлгасан цохилтын их том хүч болоод байсныг харийнхан ийнхүү “бодлогын хүчээр” бутарган сарниулжээ. Их гүрнүүд ингэж, бидний газар нутгийг нь хуйвалдан булаагаад зогсохгүй, ахан дүүсийг хооронд нь алалцуулж хүртэл амжсан байна. 1912, 1915, 1921 онд монголд удаа дараа төр эргэсэний хорт үр дагавар, дам нотолгоо ийм маягаар илэрсэн жишээ түүхэнд, даанч дэндүү олоон. “Засаг төрийн хэргийг амьд хүмүүн хөдөлгөдөг [бол түүний удамшиж] тогтсон уг суурь нь нэгэн

биеийг үл огоорон зүтгэсээр үхэж үрэгдэж ... “эрэлхэгээр дууссан” үндэсний баатруудын яс чөмгөн дээр тогтдог” —оос хойш одоо яаяан гэхэв дээ.

9. Нийслэл хүрээний шорон

Нийслэл хүрээнд гадна дотны нийлсэн олон шорон байв. Барон Унгерн Нийслэл хүрээг хятадуудаас чөлөөлмөгцөө хятадын шоронд хоригдож байсан Дүйнхорын да лам Пунцагдорж, гүн Жамьян, гүн Гомбо-Идшин ... нарын 11 хүнийг суллаав. Мөн, Шүүх яамны их гянданд хоригдсон орос, буриад, монгол олон хүнийг суллахад тэд цөм “ура” гэж хашгиралдсан, харин тэдэнтэй хамт хоригдож байсан Богд хаант Монгол Улсын манлай баатар [баатруудын баатар] ван Ж. Дамдинсүрэн тэр газраа бие барсан байв; гэж Магсар хурц тэмдэглэн үлдээжээ.

Дээрхээс болон мөн бусад⁵⁷ сурвалжаас үзэхэд, Нийслэл хүрээнд тэр үед 1) хятадын шоронд, 2) шүүх яамны их гяндад, 3) хятадын цэргийн [цагаан] хуаран дахь шоронд ... гээд өөр бусад газруудад ч хэрэгтнийг олноор хорьдог байцаадаг байсан байна.

Хятадын шоронд тэр үед орсуудыг олноор нь хорьж байж. Хорих байр нь [өвөл] галгүй хүйтэн амбаар маягийн юм байсныг харсан хүмүүс хожим дурсан бичсэн байдаг. Хятадуудад өөр “дулаан” галлагаатай шорон ч байсан нь бас тодорхой байгаа. Яагаад гэхээр, “хоригдлуудыг дулаан шорон руу шилжүүлэх хүсэлт талаар болсон тухай” болон, мөн монголын шоронд мөглөнд сэгсийсэн үстэй унтарсан харцтай эмэгтэй хүн дуугүйхэн гөлрөн байхыг үзэж харсан хүний бичиж үлдээсэн дурсамж сэлт бас нэг газар таарч байсан юм.

Нийслэл хүрээг гамингаас чөлөөлсний дараа Хүрээний “комендантын [орос] газар” бий болсон. Тэр байгууллага тухан үеийн хэмжүүрээр нилээн том байшинд орсон. Хоёр давхар байшин байсан гэж цагаантнуудын дурдатгалд өгүүлжээ. Тэрхүү тэрхүү комендантын газрын байшингийн подваль ч мөн л шоронгийн үүрэгтэй хүн байцаадаг цээрлүүлдэг газар байв.



Их Хүрээний [нэг] шорон. Бат гүн ... хатуу дэглэмтэй дотроо ийм мөнлөнтэй байсан гэдэг. Зургийг мөн Гулл 1910 онд авчээ. Тэрээр авсан энэ зурагтаа “Хөөрхий энэ хүмүүс үхэн үхтлээ эндээс гарахгүй ...” гэсэн тайлбар зүүсэн байв.

⁵⁷ К. И. Лаврентьев, “Өргөөг эзэлсэн тухай”, Харбин, 1925;

Цагаантан явсан К. И. Лаврентьевийн дурсамжид “... 1921 оны өвөл юмсан. Хятадын шорон цагаан хуаранд байсан. [Нэг өдөр] шоронгоос суллагдсан бөөн оросууд бидэн дээр хүрч ирлээ. Тэднийг харахад нүд хальтирмаар. Эцэж тураад яс арьс болсон тэдний өмссөн хувцас нь, ёстой л, нэг муу навтас төдийхөн, дүр төрх нь хүн аймаар, булш бунханаас ухаад гаргаад ирсэн мэт байв. Тэд бүтэн хэдэн сар нарны гэрэл огт үзээгүй ажээ. Суллагдсан хоригдлуудыг харсан цэргийн дарга И. И. Никитин ухаан балартаж унасан” гэж бичжээ.

Нийслэл хүрээн дэх хятадын гэлтгүй олон шоронд монголчуудыг эрүүдэн байцаасаар алж үхүүлэх явдал элбэг тохиодог байж. Хятадууд эрүү шүүлтийн доорхи аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

- Хумсны завсраар хулс шаах;
- Хооронд нь 10 орчим хормын завсарлага авч ... нийтдээ 300 удаа банздах;
- Жижиг лаазанд хулгана барьж хийгээд хүний гэдсэн дээр амсарыг нь доош харуулж тавина. Тэгээд саваа дээрээс нь халаахад амь тэмцсэн олби оготно аврагдах зөнгөөрөө арьс хүний махыг урж тасдана;
- Хүний шээсний сүв рүү адууны дэл сүүлний хялгас шургуулна;

Монгол харгалзагчтай монгол шоронгийн талаар орос эх сурвалжид ийн бичсэн нь бий: “... Харгалзагч “хорин хоёр” гэж хашгирсаар хаалгыг хагас онгойлгон модон хөнөгтэй ус, жижиг ууттай хуурсан гурил авч орж ирэв. Тэр гурлыг усаар зуурч иднэ. Шингэхээн жонхуу болно. Бид өдөр бүр ийм л хоол иддэг байсан” гэжүхүй.

10. Нийслэл Хүрээ – “Нийлсэн түүх” –ийн зангилаа газар мөн.

Эл бяцхан бичвэрээ бид “Улаан түүх” –ийн босгон дээрх Богдын хүрээ (Нийслэл хүрээ нь нийлсэн түүхийн зангилаат газар мөн) гэж нэрлэсэн нь учиртай. Олноо өргөгдсөн он жилүүдийн Нийслэл Хүрээ өөрөө самуунт цагийн хөл үймээний газар төдийгүй, монголын 2 талаас ирж нийлсэн, орос хятадыг холбосон их замын уулзвар цэг байв. Нэг үгээр хэлбэл, тухайн цагийн, ялангуяа гадаад монгол нь геополитикийн үүнээсээ дэлхийн бодлогын анхааралд өртөхгүй байхын аргагүй [нэг] түшиц газар байжээ. Тиймээс, энд, монголд, чухамдаа Нийслэл хүрээнд, тухайн бүс нутагт оршин байгаа бүх талуудын эрх ашиг мөргөлдсөн юм. Товчхоноор хэлэхэд, Нийслэл хүрээнд, “дэлгэсэн тэрлэг шиг ... дээдсийн минь үлдээсэн нутаг” –ийг орос хятад хэмээх хоёр айхтар улс ... олз–ашиг хэмээн үзэж, олхиогүй муухайгаар булаацалдсан байдаг юм. Онцлог нь бид тэсээд үлдсэн. Тэгэхээр ...

Нийслэл хүрээ нь, монголын түүхийн гээд зогсохгүй ... оросын түүхийн, хятадын түүхийн, цагаантны хөдөлгөөний түүхийн, коминтерны улаан түүхийн ... гээд олон олон түүхийн их давхцлын цэг мөн юм. Эдгээр түүхийн дотор түүх гэж үзэхийн аргагүй болтлоо гуйвж гажуудсан нь гагц “улаан түүх” бөлгөө. Нийслэл хүрээний он жилүүд нь, олноо өргөгдсөний анхдугаар оноос манай анхдугаар үндсэн хууль батлагдсан – 1924 оны шувтаргыг хүртэл үргэлжилсэн гэж үзвэл, нийт хугацааны бараг $\frac{1}{3}$ нь буюу 1920–1924 он хүртэлх сүүл хэсэг нь улаан түүхэд хамаараад явчихдаг.


Нийслэл хүрээний аж амьдралын “үнэн гуйвсан байх өндөр магадлалтай” энэ хэсгийг бид төдийлэн сонирхоогүй орхисоноо хэлэх нь зөв болов уу. Манай зарим түүхчид ч, ялангуяа манай шинэ үеийнхэн улаан түүхийг чухамхүү тэгж үздэг. Эрдэмтэн Ч. Дашдаваагийн “Улаан түүх” гэдэг ном хүртэл бий билээ. Тийм учраас, бид нийтлэлийнхээ гарчгийг “улаан түүхийн босгон дээр ...” гэж тодотгосон болно.

Улаан түүх яахаараа [тийм] худал байдаг вэ гэхээр – үзэл сурталжсан учраас. Үгүй дээ л, улаан түүхэнд түүхэн нэг хүний нэр түмэн янзаар өөрчлөгдөөд байдаг ... эзнийг нь нууж байгаа ухаантай юм. Жишээ нь, бидний өмнө нэрийг нь нэгтгээ дурдаад өнгөрсөн,

улаан цэргийн дарга, хүрээний комендант Харти Хануковын нэр гэнэтхэн Итрах Вокунаев болоод хувирчихна. Итрах –ыг тонгоруулахаар Харти болдог, Вокунаевыг тонгоруулахаар [бараг] Хануков гардаг. Түүнд өөр х нэр бий; хэмээмой. Мөн, жишээ нь, Д. Сүхбаатарын 1921 оны [дугаар - №2] тушаалыг аваад үзье. Тэнд, нэгдүгээр гарын үсгийг Эрдэнэдорж гэдэг хүн зурсан байдаг. Хаанаас юун огт дуулдаагүй хүн гэнэт гараад ирэв гэхээр монгол нэр зүүсэн орос хүн болж таардаг юм ... гэх мэт. Улаан түүхээс авах тун ховор доо.

Тэгэхэд хаа очиж, “муу нэртэй луу данстай” цагаантны хөдөлгөөний түүх бол байгааг байгаагаар нь өгүүлнэ. Үүгээрээ тэр илүү үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн юм. Нийслэл хүрээний комендант, “янгиа толгойт” Леонид Сипайло бол яриа байхгүй муу хүн, янзын муухай амьтан ... гэхдээ, тэр [өөрийн] цагаан түүхэн [Белое дело] -дээ ч цагаанаар үлдэж чадаагүй юм. Түүх бол ийм л байх ёстой мэт.

Бид, Нийслэл хүрээний он жилүүдийн Нийслэл хүрээг “түүхэн сурвалжийн дурангаар”, цагийн байдал дотроос нь “реал-таймаар” харах гэж оролдов. Ер нь, дурдсан он цагийн Хүрээний түүхийг, Хүрээнд оршин амьдарч байсан, ирсэн ... буцсан гадаадын хүмүүс л илүү бодитойгоор бичиглэж үлдээсэн мэт санагддаг. Ядаж л тэд, биднээс илүү гярхай байдаг юм.



Орос Самсон хөтөчийн хамт, 1910
(Ус гаталсны дараа бололтой)

Бидний бичвэртээ оруулсан дээрх хэдэн фото зураг л гэхэд, Богдын хүрээгээр дайрч өнгөрсөн англи эхнэрийн татаж үлдээсэн зураг юм. Хатагтай Гулл одоогоос 100 гаран жилийн тэртээ монголоор дайран аялж, Нийслэл хүрээний нийгмийн байдал, хүн ардыг гэрэл зургийн хальснаа түүхлэн буулгаж, улмаар “Монголоор аялсан нь” гэдэг уншууртай сайхан ном бичжээ. Энийг манайхан монгол хэлнээ хараахан орчуулж буулгаж амжаагүй байна. Тэрээр, бидний олон монголчуудыг “энгийн номхон, аз жаргалтай, сайхан сэтгэлтэй, гадаад ертөнцтэй өрсөлдөх сэтгэлгээ өчүүхэн ч суугаагүй, дээд зэргийн ... маш их залхуу хүмүүс” гэж бичиж тодорхойлжээ.

Мөн, XX зууны эхээр Алберт Кан гэж баян франц эр өөрийн хөрөнгөөр тал тал тийшээгээ

олон экспедици зохион байгуулж, тухайн үеийн улс орнууд руу хүмүүс [томилон] илгээж фото болон видео хийлгүүлж авсан байдаг аж. Парисын Алберт Каны музейд “Нийслэл хүрээний он жилүүдийн Нийслэл хүрээ” –г дурандаж харуулсан олон сайхан дүрс зураг байдаг. Өмнө үзүүлсэн гүжир хамба, эрдэнэ шанзав Г. Бадамдоржийн өнгөт зураг бол тэдгээрийн нэг юм.

Түүхийн зарим нь ийм үнэн бөгөөд бодитой байхад, зарим нь яагаад, авах юмгүй худал байна вэ. Муу хүний ... өөдгүй амьтасын худал хэлэх нь хүртэл элбэг бөгөөд хорлонтой гэдэг дээ. Бид, бас нэгэн, гэхдээ **маш ноцтой** худал түүхийг товчхоон үгүүлсү. Нийслэлийн ажил үйлстэй холбож бодож үзээсэй, цаашид засаж залруулаасай; гэж. Улаан түүхэнд итгэж, бид жил бүрийн 7 сарын 11 –нд улсын наадмаа хийсээр ...

Ингэхэд, тэртээх 1921.7.11 –нд, монголд, Нийслэл хүрээнд юу болсон бэ гэхээр – юу ч болоогүй, “зүгээр л нартай сайхан өдөр байсан” гэж олон түүхчид зэрэг зэрэг нотолдог. Гэтэл, хөөе, юм болсон байна ... бүр “их баривчилгаа албан ёсоор эхэлсэн” байна. Бид бодохдоо, Бодоо сайдын бодийг хөтөлсөнөөр их хэлмэгдүүлэлт гараагаа, анх, 1922 онд эхэлсэн гэж боддог байсан чинь ... үгүй юм байна. Эх сурвалжийг [дам] сөхье.

1921.7.11 –ний өглөө үүрээр, эх орныхоо төлөө бие сэтгэлээн огоорч зүтгэсэн [өмнө нэрийг нь товчхон дурдаад өнгөрсөн] Богд хаант Монгол Улсын зоригт баатар, тайж Энхбилэгийн Тогтох, түүний эхнэр Өлзий, охин Дулмаа, ач хүү Эрхэмбаяр, ач охин Хаснавч, бэр Бадамгарав ... нарын болон бусад, нийтдээ 110 хүнийг буудан хороохоор баривчилжээ. Хэн тэрэв – Мэдээж, цаана нь оросууд байсан, тэд ингэхийг шахсан. Монголд, Нийслэл Хүрээнд Я. Блюмкин, В. Блюхер гээд улаан оросын шалгарсан чекистүүд ирсэн байхад хүн барихгүй, алахгүй талахгүй байна гэж бол байхгүй!



Богдын хүрээний наадам, 1910. Энэ зураг дээр, монгол бөхийн шуудаг дажгүй соёлтой харагдаж байна. Түвдэн ... аваргын үед ихэнх бөхийн шуудагны ар-амсар ацнаас нилээн доогуур жаахан эвгүй загвартай байсансан. Харин энд тиймгүй огт ажаам. Тэгэхээр, тэр лавтайяа хожуугийн моод бололтой ...

Улаан орос Нийслэл хүрээг чөлөөлөөгүй, тэд зүгээр л чөлөөтэй байсан газар луу явган маршаар [бас Кубанийн V морьт дивиз байсан] яваад ирсэн улс. Битгий наашаагаа ир

гэж Богд хаан олонтаа хэлээд дийлээгүй, бид чинь эзлэгдсэн улс юм ш дээ, үнэндээ бол тэдэнд. Ирсэн тэд [улаан оросыг хэлж байна] амарч дуусаад наадам үзэхдээн ... зүгээр үзэхгүй ... “буудчихаад” үзэхийг хүссэн мэт ээ. Эзэн мэдсэн их орос, энд ирээд, хэзээ юу хийхээ хэн хүнээр заалгахгүй нь ойлгомжтой.

Баримт_12

Эх сурвалжаас ... **[Их Оросын улаан намын цэрэг “урилгагүй зочин” мөнөөс мөн]**

- a. 27 июня 1921 г. по направлению на Ургу выступили [хил давсан] части Красной Армии под командованием В.Блюхера и 500 цириков Сухе-батора (последние носили громкое название «Монгольской Народно-Революционной Армии». Пройдя за 10 дней более 350 верст, их передовые отряды 6 июля вошли в столицу Монголии.
- b. Монголын хилийг нэвтрэн зөвшөөрөлгүй ирж яваа улаан цэргийн өөдөөс амдан хүргүүлсэн Богд хааны **анхны зарлиг**: «Төв засгийн түвширсэн ба цагаан цэргийн буцсаныг мэдэхгүй [хий дэмий] байлдаан үүсгэн буй нь улс үндэстэнд хортой, шашныг мандуулах, амьтныг жаргуулах зорилгод үл нийцэлдэх тул зэвсэгээ тавин [наанаасаа буцаад] төр, шашин суртахуунаа тэтгэхэд туслан зүтгэсүгэй» ...
- c. Нийслэл хүрээг чиглэн зөвшөөрөлгүй ирж яваа их оросын улаан цэрэгт Богд хаанаас амдан хүргүүлсэн **удаах зарлиг**: «Хүрээнд цаг тайван болсон, бид цагаан цэргийн зэвсэгийг хурааж бий. Та бүхэн зэвсэг хөдөлгөх хэрэггүй. Наашаа [Нийслэл хүрээ рүү] битгий ир» гэжээ.

Энэ өнцгөөс харвал, монголчууд бид өнөөдөр баяр наадмаа тун базаахгүй түүхтэй өдөр хийгээд байна бус уу. Тусгаар тогтнолоо олж авснаа биш, түүнийг бусдад алдсанаа тэмдэглэдэг улс орон энэ дэлхий дээр хаана ч байхгүй. Улсын баяр наадмын комисс энэ чиглэлд хууль санаачлагчтай цаг алдалгүй хамтарч ажиллах шаардлагатай гэж үзнэ.

Эцсийн дүндээ, муу үйлээс ч сайн үр дүн гарах [эсхүл, эсрэгээр байх] явдал байдаг. Хүчтэйн өмнө хүчгүй нь буруутай. Тайж язгууртай ... цайрч гэгээрсэн мянга түмэн хүн зон, олон шилдэг сэхээтнээ зольж байж, газар нутгаа тасдан өгч “хахуульдаж” байж тэсч үлдсэн монголынхоо нийгмийн тэр үеийн гашуун түүхийг одоо нэг их дэвслээд яах вэ. Гэхдээ энэ нь, түүхэн үнэнийг түмнээс нуух үндэслэл болох ёсгүй.

Нийслэл хүрээнээ, олноо өргөгдсөний анхдугаар он [1911] -ы бат оршил өргөх их наадам хэдийд болж вэ ... тэр өдөр л, өнөөдөр бид наадахдаан болоод явчих юм байгаам, уг нь. Тодруулах хэрэгтэй. Аягүй бол, мөн 7 сарын эхээр [сайхан таарч] байж мэдэх л юм. Тийм байх магадлалтай. Энд, огноо нэг их чухал биш, үйл явдал нь, тэмдэглэж байгаа “юм” нь “үнэн бөгөөд маш гэгээн-гоё” байх нь л нэн чухал. Түүхээс тодруулах юм их байна аа.

11. Дүгнэлт, зарим санал

- a) Нийслэл хүрээний түүх ... нийт түүхтэйгээ нийлчихээд, юу ч гэмээр юмб дээ ... “улсын түүхийн сүрд дарагдаад” тусдаан сайн товойж тодорч өгөхгүй их төвөгтэй байдаг юм байна. Арга ч үгүй байх, он цаг дараалсан түүхэн үйл явдлыг, нэгийг нь нөгөөгөөс нь ангид салангид авч үзэх санаархал өөрөө их маргаантай хэцүү зүйл. Хэдий тийм ч бид, Нийслэл хүрээний “дотоод хэрэг явдлыг” нийслэл хүрээнийх нь тэр он цагийн хүрээн дотор ... [их түүхээс] сэдэвчлэн ялгах бяцхан оролдлого хийв.

Цаашид Нийслэл хүрээний түүхийг олон сэжмээр нарийвчлан судлах хэрэгцээ шаардлагыг тооцож, чиглэл төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх боломжтой юм. Жишээ

нь, Хотын захиргаа, нутгийн удирдлагын чиглэлээр дээд ба ахисан төвшний мэргэжилтэн бэлтгэдэг “Соёмбо” ... зэрэг зарим сургуулийн магистрантурт суралцагчдад Нийслэл хүрээний үүх түүхийг гүнзгийрүүлэхэд хэрэг болох судалгааны ажлын тезис, дипломын сэдэв гаргаж [захиалах] замаар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь боловсролын салбарын зарим байгууллагатай хамтарч ажиллах боломжтой гэж үзнэ.

- b) Улсын нийслэлийн үүх түүхийг үнэн мөнөөр нь мэдэж авах нь Улаанбаатар хотын засаг захиргааны өнөөгийн ажил үйлсэд ч зөв чиг бодлого болж өгөх учиртай мэт ээ. Бас жишээлье. Нийслэлийн төвд улаан хувьсгалч Богумир Шмераль (1880-1941) -ийн гудамж [гэж] бийг их хотынхон бид бүгд мэднэ.

Коминтерний төлөөлөгч энэ чех эр «монголын энэ хүнгүй шахуу зах хязгааргүй уудам дэлгэр газар нутаг, мал ... байгаль, баялагийг бушуухан өөрийн болгож авах хэрэгтэй, хүн зон нь чухал биш ... түүнийг “арчин арилгах” амархан» гэсэн цаад далд санаа бүхий, бидэнд ашиггүй бөгөөд аймшигтай “хорон муухай” мэдээллийг төвдөө [Москва руу] илгээж, монголчуудын “эсрэг” ... монголыг “устгах” бодол чиглэлд ажиллаж байсан их “чөтгөр” юм билээ. Ийм хүнийг бид юуных нь төлөө тэгж өргөмжлөн мандуулж, нийслэлийнхээн төв хэсгийн нэг сайхан гудамжийг [очиж очиж, хүн мундсан биш] түүний нэрээр нэрлэнэ вэ!?

Мэдэхгүйгээсээн болсон нь бол нийслэлийнхээ түүхийг сайн судалж ... алдаагаа бид засч залруулах ёстой. Хэлсээр байтал, [эсхүл] мэдсээр байж сүхбаатарын хөшөөг алтдана гэдэг бол байж болшгүй зүйл ... мөн чанартаа гэмт шахуу үйлдэлд тооцогдох нигууртай. Алдаа гажуудал болгон засагдахын тулд оршиж байдаг гэдэг.

- c) Нийслэл Хүрээний түүхийг гүнзгийрүүлэн судлах явцад улсын түүхийн зарим асуудал ч товойж тодрох боломжтой. Бид эл бичвэрээрээ, жишээ нь, “XV дугаар жарны цагаагчин гахай жил [1911] -ийн үндэсний хувьсгалын үргэлжлэл нь ардын [гэх] хувьсгал мөн” гэсэн өнөөг хүртэл баримталж байгаа хуучин уламжлалт дүгнэлтийг “буруу, эргэж харах зайлшгүй шаардлагатай” гэж үзэж байна.
- d) Монгол Улс тусгаар тогтнолоо дахин сэргээсний ойг 12 сарын 29 –нд тэмдэглэж байгаа нь ялимгүй эргэлзээтэй мэт санагдав. Эзэн хааныг эрдэнийг сууринд нь залах ёслол бол төр эргэсэний дүнд ... дагалдан гарч ирж байгаа олон үйл явцын нэг л жишээ юм. Хамгийн анхны гэмээр, хамгийн гол, хамгийн чухал, хамгийн баатарлиг үйл явдал нь Нийслэл хүрээнд 1911.11.28 –ны өдөр болсон. Богд хаан лүндэн буулгасан. Тэр өдөр монголын төр эргэсэн юм. Тиймээс, цаашид, Монгол улсын Тусгаар тогтнолын өдрийг жил бүрийн 11.28 –нд тэмдэглэж байвал илүү зөв, илүү утга төгөлдөр [шинэ жилийн баярын давхцал ч арилна] болохоор байна.

Утга чанарын талаас нь л бид өөлж гоочлоод “болохгүй байна, зөв бус байна” гээд байгаа болохоос биш, ардын [гэх] хувьсгалын гол үйл явдал нь “1921.7.06” –нд орос цэрэг Нийслэл хүрээнд орж ирж, улмаар 7.09 –нд, монголын засаг төр нэг гараас нөгөө гарт шилжин, “төр [онцгүйгээр] эргэсэн” –ийг нь бол ер үгүйсгээгүй.

Бас, энэ “... ээлжит нэгэн эргэлт” нь монголын нийгэмд алс хожмоо ... аллага геноцит дагуулсан аймшигтай бөгөөд гутамшигт үр дагаварт хүргэсэн, анхнаасаа тэр “нэг их сайн үйл явдал биш” байсан гэдгийг ч мэдэж байгаа. Тийм байлаа ч гэсэн монголын баатарлиг ард түмэн, энэ бүхнийг тэсээд тэвчээд, туулаад туучаад, эцсийн дүндээ бас ... хожоод хөгжөөд гараад ирсэн. Бид азтай. Монголын заяа их гэдэг үнэн ажээ.

Энийг бүхнийг бид тэр болгон тогтож сайн ярихгүй л байна. “Төр эргэсэн” агуулгаар нь улс хувьсгалын ойгоо тэмдэглэж, наадмаа бид хийдэг. Монголын төрийг, сайн зүгт жам ёсоороо нь залж чиглүүлж, шууд 180° эсрэг эргүүлсэн “цагаагчин гахай жил (1911) -ийн хувьсгал” бол эрин зууны түүхт [өнөөдрийн] энэ нийгмийн ИХ ЭРГЭЛТ –ийн эхлэлийн цэг, гарааны зурхай мөн буюу.

Нэмэлт тодруулга:

- 1921 оны “төрийн эргэлтийг” Нийслэл хүрээнийхэн гэлтгүй ер нь монгол даяар ... [нэг их] “ардын хувьсгал” гэж үзээгүй нь гадаад дотоодын олон эх сурвалжаас ил байдаг. Эгэл ардууд болсон явдлыг илүү энгийнээр нэрийдэн, зүгээр л, “**чандрууны жил**” гэх жишээний. Халх даяар гамин барон сүлжилдсэн ... орос хятад нанчилдсан, үнэхээр гамин чандрууны хөл хөдөлгөөнд дарагдсан амаргүй он цаг байсан юм даг уу даа.
- Бас, тусгаарт тогтнолоо тунхаглан зарласан эсгий туургат Их Монгол улсын гуравдугаар он (1913) –д монголчууд хилийн дээсээ чандлан хамгаалж, зах зайдуу алс хязгаартаа хятадуудтай тун ч гарамгай, үнэхээр “мундаг үзэлцсэн” байдаг. Дайн тулаан ихтэй тэрхүү үхэр жилийг бидний дээдэс мөн л, хачир чимэггүй, яг байснаар нь, зөв нэрлэсэн нь юм. **Үхэр жилийн үймээн** гэж. Ардын аман яриа андуугүй байдагт би итгэдэг. Нийслэл хүрээний гуравдугаар он (1913) -ыг монголчууд, “аман түүхэндээ”, “үхэр жилийн үймээн” гэж гоё, зөв тодорхойлжээ.
- Энүүхэндээ гэж хэлэхэд, “1921 оны ардын хувьсгал” чинь [ард нийтийн дунд] анхнаасаа товойж тодорч шууд ил харагдахаар нэрлэгдэхээр тийм сүртэй эд “байгаагүй” бололтой; юм. Яагаад гэхээр, олон сурвалж үүнийг “тийм” гэж нотлохгүй байна. Коминтернийхэн монголд явуулсан цогц ажилбарынхаа явц болоод үр дүнг бүүр сүүлд л “хувьсгал”, “улаан хувьсгал”, “ардын хувьсгал” хэмээн өргөн мандуулж зориудаар магтан дуулсан бололтой байна.

Олон монголчуудын нэгдмэл хүсэл зоригийг биелүүж бадраасан, XV жарны цагаагчин гахай жил (1911) –ийн үндэсний их хувьсгалын тухайд бол ... түүний, гол гогцоо үйл явдал нь буюу “төр **эрхэм сайнаар** эргэсэн” тэр өлзий билэгт өдөр нь 1912.XII.29 биш, харин **1911.11.28** байжүхүй. Энэ өдөр судрын “баттай зөв” гэдэг дээр бид бүхэн санал нэгдэхээр [зэрэг] бүх юм зөв байрандаа өөрөө очих мэт болой.

* * *

Түүхийг “зохиодог” зовлонт эмгэг эртний ужиг эд. Тэр одоо ч оршин байсаар. Нэгэнт буруу бичсэнийг засч залруулах нь зуу зуун он-жилийг дамнан их бага, санаатай санамсаргүй мянга мянган эсэргүүцэлтэлтэй түмэнтээ тулгармой.

“Нийслэлийн Хүрээний сонин бичиг” –ийн Ерөнхий эрхлэгч, лам – чойжин, хожим, улаан засагт зүтгээд уулын мухарт өчиггүй буудуулсан, Богд хаант Монгол Улсын эрдэм билэгт их бичгийн хүн, “ардын засаг” –ын Бодоо сайдыг “асман банди, алан хядагч” гэж гутаадаг [нөгөө нэг] балай кино өнөө орой зурагтаар гарвал та ч гайхахгүй, хэн ч гайхахгүй. Энэ бол байнгын эсэргүүцлийн ердөө нэг бяцхан жишээ төдий зүйл юм.

Нийгмийн шилжилт олон чиглэлтэй, тэр салбар талбар болгоноор зэрэг зэрэг явагддаг “эд” шиг байгаам. Нийгмийн оюун санааны шилжилт [зарим талаар дээрх жишээнд өгүүлсэнчлэн] өнөөг хүртэл, бараг эхэлж өгөлгүй ормондоо “дэвхцсээр” байтал, бусад юм бүгд “хувьчлагдаад” өөрчлөгдөөд өмчлөгдөөд “бүрэн шилжээд” дуусчихав уу даа.

Нийслэл хүрээний түүх эхэлсэн тэр цагаас инагш даруй 100 жил өнгөрч амуй ч ... түүн

доторхи худал хуурмагаас, бид одоохондоо юу ч бараг засч залруулж амжаагүй шахуу явна. Амжих цаг ирэх биз ээ. Тэр цагийг ямхаар ч болов наашлуултугай ...



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Footnotes)

- ¹ Манайхан энэ нэрийг янз янзаар бичдэг. Заримдаа Сан До амбан, Сандова сайд ... гэх мэт. Манжийн амбан Сан До – вень нь өвөрмонгол гарвалтай, монгол хүн байсан гэдэг.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ч. Базар (Ph.D)

Өнөөгийн эрчимтэй цахимжиж буй болон даяарчлагдаж байгаа дэлхийд улс орнууд мэдээллийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах нь маш өргөн хүрээний асуудал болж байна. Учир нь мэдээллийн аюулгүй байдал Үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг мөн.

Энэхүү илтгэлийн хүрээ нь Йоханнесбургийн зарчим, Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууцийн зохицуулалт, хувийн мэдээллийн нууцлалт, мэдээллийн аюулгүй байдал-нууц эх сурвалжийг хамгаалах зэрэг асуудлыг зарим улс орнууд ялангуяа пост коммунист орнууд хэрхэн зохицуулсан байдлыг товч танилцуулан, дүгнэлт гаргаснаар хязгаарлагдана. ,

Үндэсний аюулгүй байдал ба Мэдээллийн эрх чөлөө

Мэдээлэл нь хүн төрөлхтний өнөөгийн хөгжил (хувь хүн, хамт олон, улс гүрэн, төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгийн амьдралд)-д шийдвэрлэх хүчин зүйл болж байна. Нөгөө талд, мэдээллийг хувь хүн, нийгэм, төрийн ашиг сонирхолд харшаар ашиглах тохиолдолд улс төр, нийгэм, эдийн засаг, олон улсын харилцааны хүрээнд маш их хор уршиг учруулах үр дагавартай. Үүнээс үүдэн иргэн, байгууллага, төр өөрөө мэдээлэл чөлөөтэй олж авах, түгээх, ашиглах эрхийг хамгаалахаас гадна учирч болох аюул занал, бусад хүчин зүйлийг зөв мэдэрсэн, мэдээллийн улсын нөөцийг хамгаалах, түүнийг ариг гамтай зарцуулах зэргийг тодорхойлон томъёолсон мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг цогцоор бий болгох нь цаг үеийн тулгамдсан, зүй ёсны асуудал юм.

Өнөөдөр Монгол Улсад Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай багц хуулиуд (1995), Улсын нууцын жагсаалт батлах тухай хууль (2004), Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал зэргээс өөр мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт алга байна. Тийм учраас юуны өмнө мэдээлэл бий болгох, цуглуулах, боловсруулах, хуримтлуулах, хадгалах, хайх, түгээх, түүнчлэн мэдээлэл болон мэдээлэлжүүлэлтийг хамгаалах асуудлыг зохицуулсан хууль /хэд хэдэн хууль байж болно/ гаргах шаардлага байна.

Гол томъёолол нь нэгд, Үндэсний аюулгүй байдал алдагдах нь улс оршин тогтнох, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал алдагдах ноцтой үр дагавартай тул нууцыг чанд хамгаалах учиртай, Хоёрт, Үндэсний аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал нь мэдээллийн эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн чөлөөт урсгалд хязгаарлалт болох ёсгүй гэдэгт тулгуурлавал зохино. Анхаарах зүйл нь мэдээллийн эрх чөлөө нь үндэсний аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалснаас бусад мэдээлэлд хамаардаг ойлголт.

Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууц

Мэдээллийн салбар дахь техник, технологийн асар хурдацтай хөгжил нь төрийн хүслээс үл хамааран иргэдийн мэдээлэл хүлээн авах чадавхид маш хүчтэй, хурдтай нөлөөлж байна. Энэ тохиолдолд төр мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд:

Нэгдүгээрт, Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрх, эрх чөлөө чөлөөтэй хэрэгжих орчинг бүрдүүлэх,

Хоёрдугаарт, Мэдээллийн технологийн хөгжлийг даган төрийн нууцад хамаарах

мэдээлэл алдагдах магадлал өндөр байгааг харгалзан төрийн нууцын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх механизмыг улам боловсронгуй болгох, төрийн нууцын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, чангатгахад чиглэсэн зохион байгуулалтын, техникийн шинжтэй цогц арга хэмжээг иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хохироохгүйгээр авч хэрэгжүүлэх,

Гуравдугаарт, Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үндсэн зарчмууд болох хууль ёсны болон ил тод байх зарчмыг төрийн бүх шатны байгууллагад жинхэнэ ажил хэрэг болгох,

Дөрөвдүгээрт, Төрийн нууцыг хамгаалах нь төрийн хүлээсэн шууд үүрэг хэдий ч энэ асуудал аливаа улс, үндэстний үндэсний аюулгүй байдлыг хангахтай шууд хамааралтай учраас төрийн нууцад хандах иргэдийн нийгмийн ухамсар, ёс зүйн хандлагыг эрс өөрчлөхөд илүүтэй анхаарал хандуулах болсон байна.

Мэдээллийн аюулгүй байдал ба гадаад улс орнуудын зохицуулалт

Мэдээллийн аюулгүй байдал ба хүний эрхийг хангах хоёрыг зөв зохицуулах үүднээс олон орон энэ чиглэлийн хуулиндаа ихээхэн анхаарч иржээ. Зарим орны эрх зүйн тэдгээр зохицуулалт нь манай орны эрх зүйн шинэчлэлтэд ч гэсэн санаа оноо нэмэрлэж болох юм.

Йоханнесбургийн зарчмууд:

Энэ баримт бичиг нь мэдээлэл хайх, олж авах, хэлэх эрхийг цаг хугацаанд нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай шалтгаанаар хязгаарлагдаж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэвч, үндэсний аюулгүй байдал нь мэдээлэл олж авахыг хязгаарлаж чадахгүй. Йоханнесбургийн олон зарчим дараахи нууцлалын хуулийн асуудалтай холбоотой байна. Үүнд,

Зарчим 2: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхол

А/ Хязгаарлалт нь цэргийн дайралт зэрэг гадаад эх сурвалжаас, эсвэл Засгийн газрыг унагах зөрчлийг өдөөн хатгах зэрэг дотоод эх сурвалжаас, хүч хэрэглэхэд хариу үзүүлэх хүчин чадал, аюул заналын эсрэг улсын оршин тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үр дүн, бодит зорилгогүй бол үндэсний аюулгүй байдлын шалтгаан нь хууль ёсны болж зөвтгөгдөхгүй.

Б/ Ялангуяа, бэрхшээл, саад, буруу үйлдлээс Засгийн газрыг хамгаалах, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээллийг нууцлах, үйлдвэрлэлийн үймээн самууныг нууцлан дарах зэргээр үндэсний аюулгүй байдалтай холбоогүй ашиг сонирхлыг хамгаалах үр дүн, бодит зорилго байвал үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар уг хязгаарлалтыг хууль ёсны гэж үзэж зөвтгөж болохгүй.

Зарчим 15: Нууц мэдээллийг задруулах талаарх нийтлэг журам

Хэрэв нэгд, Мэдээллийг задруулах нь бодитоор хохирол учруулаагүй, үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулаагүй бол, хоёрт, мэдээллийг мэдэх нийтийн ашиг сонирхол задруулснаас үүсэх хор хохирлоос илүү бол хэн ч мэдээллийг задруулсныхаа төлөө үндэсний аюулгүй байдлын шалтгааны дор шийтгэгдэх ёсгүй

Зарчим 16: Төрийн албаны хүрээнд олж авсан мэдээлэл

Мэдээлэл олж авах гэсэн нийтийн ашиг сонирхол нь илчилснээс гарах хохирлоос илүү байвал төрийн албаны шугамаар олсон мэдээллийг илчилбэл үндэсний аюулгүй

байдлын шалтгаанаар ямар нэг хохирол учруулсан гэж хэнийг ч авч хэлэлцэхгүй.

Эдгээр зарчмийг дэлхийн улс орнууд нууцын хууль тогтоомжийн шинэтгэл хийхдээ гол төлөв удирдлага болгодог байна.

Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууцийн зохицуулалт пост коммунист орнуудын жишээн дээр

ОХУ, Киргизийн БНУ, Таджикстан, Туркменстан, Украин, Гүрж, Казакстан, зэрэг улсын хуулиудад төрийн нууц (Улсын нууц)-ын тодорхойлолт, нууцын хамрах хүрээ, нууцлах хугацаа, нууцлалыг хэрхэн ил болгох, нууцыг тогтоох субъект зэргийг маш тодорхой тусгасан байдаг аж. Тухайлбал, Туркменстан, Украин, Киргиз, Гүрж, Казакстан зэрэг улс нь төрийн нууцыг тодорхойлсон гол томъёолол нь зөвхөн мэдээлэл гэжээ. Үүгээрээ манай хуулиас ялгаатай байна. Туркменстан, Киргиз, Казакстаны хуульд “төрийн нууцын жагсаалтад орсон мэдээлэл нь нууц” гэсэн бол Украин, Гүржийн хуульд “Задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах мэдээлэл” гэж нарийвчилсан байна.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 3-р зүйлд “Төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологии, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийн томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон. Үүнд мэдээлэл төдийгүй баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хүртэл төрийн нууцад хамаарах бөгөөд дээрх хүрээ нь бусад орны хуулийн хамрах хүрээнээс өргөн байгаа нь харагдаж байна.

ОХУ, Украин, Туркменстан, Таджикстаны хуулийг харьцуулахад үзэхэд бүтцийн хувьд ижил төстэй байсан бөгөөд харин агуулгын хувьд ОХУ, Украин, Тажикстаны хуульд нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг шууд тогтоож өгсөн байна. Украин, Гүржийн хууль нь илүү их дэлгэрэнгүй нэр томъёоны тайлбарыг нарийвчлан гаргасан, нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах гэх мэт технологийн үе шатны зохицуулалтын журмыг тодорхой тусгаж оруулжээ.

Төрийн нууцын хамрах хүрээг ОХУ, Украин, Гүрж улсад батлан хамгаалах /цэргийн/ салбар, шинжлэх ухаан, техник, эдийн засгийн салбар, эдийн засаг, улс төрийн гадаад харилцаанд тагнуул, сөрөг тагнуул, эрэн сурвалжлах үйл ажиллагаа гэж заасан байна. Энэ нь Монгол улсын төрийн нууцын хүрээг томъёолсонтой нэлээд төсөөтэй боловч Украин, Монгол улсын хуулинд “Үндэсний аюулгүй байдал” гэж тусгайлан оруулжээ.

Манай хуулиар масштабаас хамаараад газрын зураг бүгд нууцад хамаарахаар байхад, Казахстан, Тажикстан болон Украины хууль тогтоомжинд газрын зургийн нууцлалтай холбоотой заалтууд орсон ч энэ нь зөвхөн цэрэг, дайны зориулалтаар ашиглах тохиолдол буюу эсвэл эдийн засгийн мэдээлэл агуулсан үед (Казахстан, Тажикстан) газрын зургийн өгөгдлүүдийг нууцалсан байдаг. Харин ч Төрийн нууцын тухай Гүржийн хуулинд “цэргийн зориулалттай тусгай газрын зургаас бусад” газрын зургийг нууцад ангилахыг хориглосон зүйл байна.

Нууцалж болохгүй мэдээллийн хүрээнд юуг нууцалж болохгүйг Монгол улсын хуулинд тодорхой заагаагүй байдаг. Төрийн нууцын тухай Оросын Холбооны Улсын хуулинд алт болон бэлэн мөнгөний нөөц, төрийн өндөр, дээд тушаалын албан хаагчдын эрүүл мэндийн байдлыг төрийн нууц гэж үзэх ёсгүй гэж заажээ. Түүнчлэн ОХУ-ын Төрийн нууцын тухай хуульд:

- Онц байдал, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулах үйл явдлууд, байгалийн гамшиг, тэдгээрийн талаархи урьдчилсан мэдээлэл;
- Хүрээлэн байгаа орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, боловсрол, соёл, хөдөө аж ахуйн байдал, түүнчлэн гэмт хэргийн нөхцөл байдал;
- Онцгой эрх, төрөөс иргэд, албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжид олгож буй хөнгөлөлт, нөхөн төлбөр;
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тухай баримт;
- ОХУ-ын валютын нөөц, алтны нөөцийн хэмжээ;
- Төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдал;
- Төрийн байгууллага, түүний албан тушаалтны хууль бус үйлдлийн тухай мэдээллийг нууцалж болохгүй гэжээ.

Туркменстанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн хувь хүний аюулгүй байдал, эрүүл мэндэд нь аюул учруулж болох мэдээллийг нууцад хамааруулж болохгүй гэж хуульчилсан байна. Орос, Туркменстаны хуулиар иймэрхүү төрлийн мэдээллийг төрийн нууц гэж үзсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр тусгасан байгаа нь хуулийн хэрэгжилтийг нэлээд өндөрсгөж байгааг харуулж байна.

Гүржид олон улсын гэрээ хэлэлцээр, мөн байлдааны зориулалттай тусгай газрын зургаас бусад газрын зураг, төрийн өндөр дээд албан тушаалтны эрүүл мэндийн байдал, авлига, албан тушаалтнуудын хууль бус үйлдэл, гэмт хэргийн нөхцөл байдлын талаархи мэдээллийг нууцалж болохгүй гэжээ. ОХУ, Туркменстан, Киргиз, Гүрж, Казахстаны хуулиудад нууцалж болохгүй мэдээллийн хүрээг тодорхойлсон нь, Украин, Казахстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь манайд жишиг болохоор байна.

Нууцлах хугацааны хувьд ОХУ, Туркменстан, Казахстан улсын хуулийн дэвшилттэй заалт нь 5 жил тутамд нууцад хамаарах эсэхийг шалгаж, зэрэглэлийг хянаж, шаардлагагүй гэж үзвэл ил болгодог байна. Харин нууцлах хугацааг зэрэглэлээс хамааруулан Украинд 30 жилээс хэтрэхгүйгээр, Гүржид 20 жилээс ихгүй, Казахстанд 30 жилээс хэтрэхгүй байхаар хуульчилсан байхад Монгол Улсад 60 хүртэл жилийн хугацаагаар зарим категорийг байнгын нууц байхаар зохицуулжээ. 30 жил, (маш нууц) 10 жил, (нууц) 5 жил хүртэл байна.

Ихэнх орны тухайлбал, Казахстан, Туркменстан зэрэг улсын хууль тогтоомжийн давуу тал нь ангиллын хугацааг албан ёсоор тавихаас зайлсхийж, “Төр болон ард түмний ашиг сонирхол” эсвэл “Онцгой нөхцөлд” л байнга нууцлахыг зөвшөөрсөн байх бөгөөд харин бусад орны хууль тогтоомж нь нууцын ангиллын хугацаа дууссаны дараа нээлттэй болгох зарчим баримталдаг аж. Гүрж, ОХУ-д төрийн нууцыг ил болгох үндэслэлээ олон улсын нөхцөл байдлын улмаас тухайн мэдээллийг ил болгохоор үүрэг хүлээсэн, тухайн мэдээллийг нууцлах шаардлагагүй болсон, тогтоосон хугацаа дуусгавар болсон зэргээр хязгаарласан байна. Манайд нууцын ангилалд хамаарах мэдээллийг ил болгох талаар Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулинд цаашид нууцлах шаардлагагүй гэж үзэх нөхцөл байдал шинээр үүсэх, ангиллын нууцлах хугацаа дууссах, бусад үндэслэл гэж тодорхойлжээ.

Нууцын зэрэглэлд хамааруулсан мэдээллийг ил болгох ажиллагааг Засгийн газрын эрх мэдэлтнүүдэд хариуцуулбал (ялангуяа Улсыг аюулаас хамгаалах байгууллага) ямар ч баримт бичгийг нийтэд дэлгэдэггүй гэдгийг бусад орны туршлага харуулж байна. Улсыг аюулаас хамгаалах байгууллага нь угаасаа нууцыг хамгаалах нэрийн дор хүнд суртал гарган байнга нууцлахыг боддог аж.

Монгол Улсад Төрийн нууцын хуулиар нууцад хамаарах мэдээллийг хайж олох нь

хариуцлага хүлээх үйлдэл байдаг бол Украин, Казакстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь эх сурвалжтай холбоотой аливаа хэрэг маргаан дээр шүүх хуралдаан дээр үр дүнтэй ашиглагдаж болох ач холбогдол бүхий зохицуулалт гэж үзэж байна.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зохицуулалт

Англи улсад Төрийн нууцын талаархи 1989 оны акт голлох үүрэгтэй үйлчилдэг. Энэхүү акт нь төрийн мэдээллийн тодорхой хэлбэрүүдийг хууль бусаар олж авах явдлаас урьдчилан сэргийлэх үндсэн зорилгын хүрээнд, мөн 1911 оны актын нэгэн хэсэг болсон арга хэрэгслээс бусад аргаар албан тушаалтан бусад этгээдүүд мэдээллийг эрх мэдэлгүйгээр задруулахаас урьдчилан сэргийлэх үндсэн агуулгыг багтаадаг. Төрийн нууцыг илүү сайн хамгаалахын тулд энэхүү акт нь эрх мэдэлгүйгээр бичиг баримтыг задруулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах, төрийн албан хаагч болон Хатан хааны албан хаагчид үүргээ үл биелүүлэх, хууль бусаар бичиг баримтад хориг тавих нь гэмт үйлдлийн шинжийг бий болгох явдлыг бүрдүүлжээ.

Төрийн нууцын актаар хамгаалагдсан мэдээлэл нь аюулгүй байдал, тагнуултай холбоотой, Батлан хамгаалахтай холбоотой, олон улсын харилцаа, гадаад улс орон, олон улсын байгууллагаас ирсэн нууц, итгэмжит, гэмт хэрэг, тусгай мөрдлөгийн бүрэн эрхтэй холбоотой мэдээлэл гэсэн 4 ангилалд багтана. Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэл гэдэгт юу багтахыг авч үзвэл аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа, түүний нэг хэсэг, түүнд дэмжлэг үзүүлж буй ажил зэрэг нь хамаарна. Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэлд эдгээр ажиллагаагаар болон дэмжлэг үзүүлж буй хүмүүс, бусад этгээдийн шилжүүлсэн болон тэдгээрт байгаа мэдээлэл хамаарна. 1989 оны Акт нь аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа гэж юу болохыг тайлбарлаагүй байдаг ч бичигдмэл хуулиар дараахи ажиллагааг оруулж болохоор заажээ. Үүнд: Аюулгүй байдлын ажиллагаа, Нууц тагнуулын ажиллагаа, Төв штабын Ерөнхий нийгэмлэгийн ажиллагаа багтана.

Гэмт хэрэг, тусгай мөрдлөгтэй холбоотой мэдээлэл гэдэгт эрх мэдэлгүйгээр задруулсан доорхи мэдээлэл хамаарна: Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэний үр дагавар
- Хууль ёсны үйлдлээс гадуур өнгөрөхөд дэмжлэг үзүүлж буй арга хэрэгсэл
- Хууль ёсны хамгаалалтад буй хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх бусад үйлдэл, ажиллагаа
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сэжигтэй этгээдийг яллах, цагаатгахтай харшлах үйлдэл зэрэг болно.

ХБНГУ-ын зохицуулалт:

Тус улс нь Мэдээллийн эрх чөлөөний хуулиар гол зохицуулалтаа хийгээд “хариуцлага”-ын талаар Эрүүгийн хуулиндаа тусгасан нь дэвшилттэй буюу аль болох нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй болсныг судлаачид тэмдэглэдэг. ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар “Бие даасан, ардчилсан Үндсэн хуулийн журам болон олон улсын зэвсэгт хяналт тавих гэрээг зөрчсөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай гэрээ хэлэлцээр байгуулсан талуудаас нуун дарагдуулсан баримтуудыг төрийн нууцад хамааруулахгүй” гэж хуульчилжээ. Германы “Мэдээллийн эрх чөлөөний хууль”-д задалж болохгүй мэдээллийн хүрээг заасан байдаг. Үүнд:

- Хэрэв мэдээллийг задалсан нөхцөлд олон улсын харилцаа, Германы Зэвсэгт хүчний цэргийн аюулгүй байдал, дотоодын болон гадаадын аюулгүй байдлын сонирхол, санхүүгийн монополийн эсрэг болон журамлах эрх бүхий газрын хяналт тавих үүрэг, гадаад санхүүгийн хяналтын асуудал, хууль бус гадаад

худалдаанаас урьдчилан сэргийлэх гэсэн арга хэмжээ, одоо явагдаж буй хууль эрх зүйн үйл явц, хүн бүр шударга хуулийн үйлчилгээ авах эрх, ба эрүүгийн, засаг захиргааны болон сахилга батын холбогдолтой мөрдөн байцаалтын үйл ажиллагаа зэрэгт хохирол учрахаар байвал;

- Хэрэв мэдээллийг бусдад задруулснаар олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах бол;
- Хэрэв Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нууцлах шаардлага тавьсан бол эсвэл Агентлагт итгэх итгэл буурах бол;
- Хэрэв тухайн мэдээлэл нь хуулийн зохицуулалтын эсвэл ангилсан мэдээллийн талаархи Материалын болон Байгууллагын Хамгаалалтын Ерөнхий Захиргааны Зохицуулалтын дагуу нууцад хамаарах эсвэл мэргэжлийн холбогдолтой болон тусгай албан ёсны нууцад хамаарах;
- Өөр төрийн байгууллагаас нэг удаа өөрсдийн үйл ажиллагаанаас гадуур мэдээлэл өгөхийг шаардах;
- Хэрэв мэдээллийг задалснаар нийгмийн даатгалын институтын эдийн засгийн сонирхол болон эдийн засгийн ажил хэрэгт холбогдох Холбооны засгийн газрын санхүүгийн сонирхлыг хөндөх бол;
- Нууц мэдээлэл авах, хүртэх гэсэн санал тавьж цуглуулсан үед гуравдагч талын нууцлалыг хадгалах сонирхол нь хүчин төгөлдөр байсан тохиолдолд;
- Холбооны Засгийн Газрын Тагнуулын газар, агентлагууд болон бусад төрийн агентлагууд Германы Аюулгүй Байдлын Актын 10 (3)–р зүйлд заасны дагуу гүйцэтгэж байгаа бол зэрэг болно. Харин дээр дурьдсанаас бусад бүх мэдээлэл нээлттэй, ил тод байдаг байна.

Хувийн мэдээллийн нууцлалт

Нилээд жишиг болохуйц зохицуулалт гэж үзэн Канад улсын “Хувийн мэдээллийн хамгаалалт ба Электрон баримт бичгийн хуулийг илтгэлд оруулж байна. Уг хууль нь хувийн нууц мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулдаг. Уг хуулиар хувийн хэвшлийн байгууллагууд бизнесийн үйл ажиллагааны туршид хувь хүний /ажиллагсдынхаа/ мэдээллийг хэрхэн цуглуулах, хэрэглэх болон дэлгэх /задлах/ талаарх бүхий л харилцааг зохицуулдаг байна. Түүнчлэн энэхүү актаар электрон баримт бичгийг хэрэглэхэд тус дөхөм үзүүлэх харилцааг ч зохицуулдаг.

Европын холбоо нь “Канадын хувийн мэдээллийг хамгаалах хууль нь Европын иргэдийн хувийн мэдээллийг хамгаалахад ч шаардлага хангасан зүйн баримт бичиг” гэдгийг батлан хэлдэг. Уг хуулинд “Хувийн мэдээлэл” гэж чухам юу болохыг тодорхой заасан бөгөөд үүнд тухайн бие хүнийг таньж мэдэж болох бүхий л мэдээлэл багтана гэж томъёолжээ. Харин тухайн хүний нэр, эрхлэх ажил болон тухайн ажил олгогч байгууллагын бизнесийн хаяг, утасны дугаар тэрхүү мэдээлэлд хамрагдахгүй аж.

Хуулиар тухайн хүнд дараахи эрхийг олгосон байна. Үүнд:

- Яагаад байгууллага нь тухайн хүний талаарх мэдээллийг цуглуулах, хэрэглэх, ямар тохиолдолд дэлгэх /задлах/ ёстойг мэдэх эрхтэй;
- Тухайн байгууллагаас хувь хүний талаархи мэдээлэл цуглуулах, хэрэглэх, дэлгэх /задлах/ үйл ажиллагаа нь үндэслэлтэй, зүй ёсны байхыг шаардах болон тэрхүү мэдээллийг ямар нэгэн зорилгоор ашиглахгүй байх, тухайн хүний зөвшөөрсний үндсэн дээр хэрэглэх ёстойг шаардах эрхтэй;
- Тухайн байгууллагаас хэн гэдэг этгээд хувь хүний мэдээллийг хамгаалах үүрэг хүлээсэн болохыг мэдэх эрхтэй;
- Тухайн байгууллага нь хувь хүний мэдээллийг хамгаалахдаа нягт нямбай, иж

бүрэн, орчин үеийн шаардлагад нийцсэн байдлаар зохион байгуулж буй эсэхийг шаардах эрхтэй;

- Шаардлагатай үед хувь хүний мэдээлэлд нэвтрэхдээ тухайн хүнээс зөвшөөрөл авах болон анхааруулга өгсөн эсэхийг асуух эрхтэй;
- Тухайн байгууллага хувийн нууцлалын эрхэд үл хүндэтгэсэн байр сууринаас хандсан тохиолдолд тэдний мэдээллийг хамгаалах талаар хяналт тогтоосон эсэх асуудлаар гомдол гаргах эрхтэй зэрэг болно.

Хуулиар тухайн байгууллагад дараахи шаардлагыг тавьдаг. Үүнд:

- Хувь хүний мэдээллийг цуглуулах, хэрэглэх, дэлгэх /задлах/-дээ харилцан зөвшилцөх;
- Тухайн хүний хувийн мэдээллийг цуглуулах, хэрэглэх, түүнчлэн дэлгэх /задлах/-ээс гадна тухайн мэдээлэл ажил хэргийн салшгүй хэсэг учраас
 - Мэдээллийг хууль ёсны дагуу шударгаар цуглуулах
 - Хувь хүний мэдээллийн чиг шугам нь тодорхой, ойлгомжтой, хялбар байх зэрэг болно.

Канадын Стандартын Холбооны гаргасан “Хувь хүний мэдээллийг хамгаалах” загвар кодын үндсэн дээр цуглуулсан, хэрэглэсэн, ил болгох мэдээлэл нь хувь хүний зөвшөөрөлгүйгээр, хууран мэхлэх замаар ашиглагдахыг энэхүү хуулиар хамгаалдаг. Тухайлбал, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор мөрдөн шалгахтай болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудалд ч энэ нь хамаатай аж.

Мэдээллийн аюулгүй байдал-нууц эх сурвалжийг хамгаалах тухайд

Энэхүү асуудал нь өнгөц харахад Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн асуудал мэт байвч цаанаа олон нийтийн эрх ашигт нийцсэн, бүр цаашлаад Үндэсний аюулгүй байдал, тэр дундаа мэдээллийн аюулгүй байдалтай холбогдоно.

Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргасан эх сурвалжийг нууц эх сурвалж гэдэг. Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргасан эх сурвалжийн ажил, аюулгүй байдал, гэр бүлийг эрсдлээс сэргийлж сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага тухайн эх сурвалжтай холбоотой нэр, ажил, албан тушаал зэрэг мэдээллийг зориудаар нууцалдаг.

Энэ бол эх сурвалжаа эрсдлээс сэргийлсэн хамгаалалт юм. Гүржийн “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль”, Мексик, Францын “Эрүүгийн хууль”, Индонез, Мозамбик, Туркийн “Хэвлэлийн хууль”-иудад “Мэргэжлийн нууцын эх сурвалж үнэмлэхүй байдлаар хамгаалагдсан байх бөгөөд түүнийг задруулахыг хэн ч шаардах эрхгүй. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон шүүх хурлын явцад нууц мэдээллийн эх сурвалжийг задруулахыг хэнээс ч болов шаардах ёсгүй” гэсэн байдлаар хуульчилдаг. Хязгаарлалт тавих, эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэрийг зөвхөн хуульд нарийвчлан томьёолж заасан үндэслэлээр зөвхөн ардчилсан нийгмийн ашиг сонирхлын үүднээс шүүхээс гаргахыг хүлээн зөвшөөрдөг.

Гэхдээ эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэр гаргах эрхийг шүүх хязгаарлалтгүйгээр эдлэх нь бас ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилгод нийцэхгүй. Шүүхийн эрх мэдлийг хатуу тогтоогоогүй тохиолдолд эх сурвалжаа нэрлэхгүй байх үндэслэлээ тайлбарлах дарамт сэтгүүлчдэд ирсээр байх болно. Бельги, Герман, Филиппин, Армени, Финляндад эх сурвалжийн нууцыг задруулахаас татгалзах эрхийг сэтгүүлчдэд олгосон байдаг боловч тухайн тохиолдлоос хамаарч тодорхой шалгуур, дэг журмын дагуу эх сурвалжийг задруулах шийдвэр гаргах шаардлагыг хуульд тусгайлан заасан байдаг байна.

Дүгнэлт:

Манай улсын хувьд Мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг цогцоор нь авч үзэн, эрх зүйн орчныг төгс бүрдүүлэх нь тулгамдсан асуудлуудын нэг болжээ. Мэдээллийн аюулгүй байдлын талаархи эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ уг илтгэлд дурьдсан олон улсад баримталж буй хэм хэмжээ, зарчмыг мөрдлөг болгох нь чухал юм. Тэдгээр зарчим нь мэдээллийг нууцлахдаа иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг боогдуулах замаар хийж болохгүй гэсэн гол агуулга дээр үндэслэгддэг.

Мэдээллийн аюулгүй байдал нь хувь хүн, иргэн, байгууллага, хамт олон, төрийн нэгдмэл цогц үйл ажиллагааны үндсэн дээр тогтдог гэдэг чухал зарчмыг мөн хадгалах нь чухал юм. Мэдээллийн аюулгүй байдал нь дан ганц улс орны хэрэг биш нийт дэлхийн улс орнуудын хамтын идэвхтэй үйл ажиллагааны үндсэн дээр оршино гэдэг нь өнөөгийн эрх зүйн орчны бүрдэл, түүний хэрэгжилтийн бас нэг чухал хүчин зүйл нь болох учиртай.

Мэдээлэл технологийн өндөр хурдацтай хөгжлийн энэ үед хувь хүний мэдээллийг нууцлах, түүний хадгалалт хамгаалалт, олон нийтийн эрх ашгийн үүднээс ил болгох зэрэг асуудлыг цогцоор нь шийдэх нь бас нэг чухал асуудал юм.

Нийтэд нь дүгнэхэд, мэдээллийн аюулгүй байдал гэдэг дан ганц нууцлах гэсэн зарчим дээр тогтвол хүний язгуур эрх, эрх ашиг зөрчигддөг учраас нууцлал, нууцалсан мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлах хязгаар, цаг хугацаа зэргийг төгс зохицуулж, олон нийтийн мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах, хүртэх, тараах, түгээх эрх, эрх чөлөөнд ямагт хүндэтгэлтэй хандах учиртайг илтгэлд дурьдсан улс орнуудын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалт харуулж байна.

* * *

Ашигласан эх сурвалж:

- “Хувийн мэдээллийн хамгаалалт ба Электрон баримт бичгийн хууль”. Канад, 2002
- “Датаг хамгаалах тухай хууль” Англи, 1998
- “Хэвлэлийн хууль”. ХБНГУ
- “Мэдээлэл, мэдээжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль”. ОХУ
- “Йоханнесбургийн зарчим: Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай”. Лондон, 1995
- “Төрийн нууц ба Мэдээллийн эрх чөлөө”. “Глоб интернэйшнл” ТББ, УБ, 2006
- “Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах нь”, Ронан Бради. 2004
- “Төрөөс мэдээлэл хэрхэн олж авах вэ”, “Глоб Интернэйшнл” ТББ, “ННФ”, 2007



ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Бодлогын судалгаа, шинжилгээ”
эмхтгэл (XII боть) -ийн хавсралт

УИХ -ын 2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж
гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа


(XI ботид орсон бусад судалгааны жагсаалт)

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДЛААР		
1	• УИХ –д өргөн баригдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн тогтоолын төсөлд хийсэн шинжилгээ	Ц. Норовдондог (Ph.D), Б. Дуламсүрэн, Ц. Элбэгзаяа
2	• Монгол Улсын 2012 оны төсвийн төслийн шинжилгээ	Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Г. Билгээ
3	• Монгол Улсын төсвийн харилцаан дахь төсвийн төвлөрөлийн асуудал, төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн дүн шинжилгээ	Ц.Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Батдорж, Г. Билгээ, Б. Дуламсүрэн , Ч. Онончимэг
4	• Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн үйл ажиллагаа, түүнийг эрхлэх байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал	Ц. Норовдондог (Ph.D), Г. Гэрэл, Ц. Болормаа, Б. Тамир
5	• Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулж буй тэмдэгтийн хураамжийн үйлчилгээний нэр төрөл болон хувь хэмжээний харьцуулалт	Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа
6	• Тавантолгойн ордыг ашиглах талаар төрөөс баримталж буй бодлого ба хэрэгжилтийн явц, олон нийтийн санал шүүмж	Д.Мягмарцэрэн, Ч. Базар (Ph.D), Ц. Батдорж, С. Дорждагва, Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг, Ч. Онончимэг, Н.Түвшинтөгс, Ц. Элбэгзаяа
7	• Нидерландын вант улсын албан татварын зарим төрөл	Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ
8	• Мөнгөний бодлогын алтернатив хэлбэрүүд, тэдгээрийн давуу болон сул талууд	Ц. Норовдондог (Ph.D) , Ж. Элбэгзаяа, Б. Болортуяа
9	• Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн тулгамдсан асуудал: Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж болон кастодиан үйлчилгээ	Ц. Норовдондог (Ph.D)
10	• Монгол Улсын нийгэм, эдийн засаг дахь төрийн бодогын уялдаа холбоо, иргэдийн оролцоо	Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа, Ц. Болормаа, Г. Билгээ

Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДЛААР		
11	<ul style="list-style-type: none"> Энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмжийн талаархи харьцуулсан судалгаа 	Ц. Товуусүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг, А. Пагма, Б. Хатантуул
12	<ul style="list-style-type: none"> Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн стандарт, эрх зүйн орчны талаархи олон улсын туршлага, харьцуулсан судалгаа 	Г. Алтан - Оч (Ph.D), С. Дорждагва, Ө. Мөнхтунгалаа, Б. Мөнхцэцэг
13	<ul style="list-style-type: none"> Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, бодлого эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ 	Ц. Товуусүрэн, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа
14	<ul style="list-style-type: none"> Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА, 2011) -ийн товч танилцуулга 	УИХ -ын Тамгын газрын Эрх зүй хууль тогтоомжийн хэлтэс, Судалгааны төв
15	<ul style="list-style-type: none"> Ясли цэцэрлэгийн тоо болон барилга байгууламж, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн бус өмчит их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудын төлбөрийн талаахи судалгаа 	Т. Мягмаржав
Гурав. ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ ... бусад		
16	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн өсөлт ба хөрөнгийн зах зээлийн хөгжлийн харилцан хамаарлын асуудал 	Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ж. Элбэгзаяа
17	<ul style="list-style-type: none"> Байгалийн баялгийн зохистой ашиглах нь: Иргэдийн оролцоог хангах болон эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодитой хэрэгжүүлэх талаар 	Ч. Базар (Ph.D)



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Уншигчийн тэмдэглэл

UIH.MN
СҮДАЛГААНЫСАН



УИХ-МН
СҮДАЛГААНЫСАН

ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»
(Судалгааны эмхтгэл, XII боть)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэд шилжүүлсэн 2012.3.09
Тираж 400, Хэвлэлийн хуудас 20
Цаасны хэмжээ 176 * 250 $\frac{1}{10}$
(Анхны хэвлэл)

УБ, 2012

